



# ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2025 он



ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮР ДҮНД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨ, АХИЦ ДЭВШИЛ



ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС  
АНХААРУУЛЖ БУЙ АСУУДАЛ

# АГУУЛГА

<b>ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА</b> .....	6
<b>УДИРТГАЛ</b> .....	7

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

<i>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа-2024, хүрсэн түвшин, хүлээгдэж буй гүйцэтгэл</i> .....	13
--	----

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

<i>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ</i> .....	45
2.1.Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	47
2.2.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	105
2.3.Цагдаагийн байгууллагад хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	122
2.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	196
2.5.Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	302
2.6.Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах 032 дугаар ангийн Сахилгын тусгаарлан саатуулах байранд хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ.....	317

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

<i>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа</i> .....	329
3.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт.....	331
3.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа .....	376

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

<i>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа</i> .....	405
4.1.Олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа.....	407
4.2.Иргэний нийгмийн болон ашгийн төлөө бус төрийн бус байгууллагатай хамтран ажилласан талаар.....	443

## ТАВДУГААР БҮЛЭГ

Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол,  
мэдээллийн шийдвэрлэлт..... 455

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022-2024 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн, ахиц дэвшил ..... 467

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ ..... 477

САНАЛ..... 535

ХАВСРАЛТ ..... 539

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэхтэй холбоотой үндэсний эрх зүйн баримт бичиг

**Хавсралт 1** - Монгол Улсын иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай монгол улсын засгийн газарт хүргүүлэх уриалга .... 541

**Хавсралт 2** - Улсын их хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол..... 544

**Хавсралт 3** - Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол..... 545

**Хавсралт 4** - Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай “ 114 дүгээр тогтоол..... 546

**Хавсралт 5** - Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон Монгол Улсын Их Хурлын Хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоол..... 547

**Хавсралт 6** - Улсын их хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлах тухай” 21 дүгээр тогтоол ..... 550

**Хавсралт 7** - Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгавар..... 552



**Хавсралт 8** - Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө.... 553

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэхтэй холбоотой олон улсын эрх зүйн баримт бичиг

**Хавсралт 9** - НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн тухай Монгол Улсын III илтгэлийг хэлэлцээд Засгийн газарт ирүүлсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны тайлан, зөвлөмж (англи хэлээр)..... 555

**Хавсралт 10** - НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн тухай Монгол Улсын III илтгэлийг хэлэлцээд Засгийн газарт ирүүлсэн НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг хорооны тайлан, зөвлөмж (албан бус орчуулга, монгол хэлээр) ..... 571

**Хавсралт 11** - НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалын мөрөөр Монгол Улсад ирүүлсэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд хамаарах ажиглалт, зөвлөмжүүд” (албан бус орчуулга, монгол хэлээр)..... 588

**Хавсралт 12** - НҮБ-ын Хүний эрхийн комиссын Эрүүдэн шүүхийн асуудлаарх тусгай илтгэгч Манфред Новакийн 2005 оны 06 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалын талаарх мэдээлэл (англи хэлээр)..... 591

**Хавсралт 13** - НҮБ-ын Хүний эрхийн комиссын Эрүүдэн шүүхийн асуудлаарх тусгай илтгэгч Манфред Новакийн 2005 оны 06 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалын талаарх мэдээлэл (албан бус орчуулга, монгол хэлээр)..... 593

**Хавсралт 14** - НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс нь “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн чиг хандлагын тоймыг 2024 оны нөхцөл байдлаар дүгнэжээ (англи хэлээр) ..... 595

**Хавсралт 15** - НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс нь “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн чиг хандлагын тоймыг 2024 оны нөхцөл байдлаар дүгнэжээ (албан бус орчуулга, монгол хэлээр)..... 602

**Хавсралт 16** - Швейцарын холбооны улсын Женев хотноо төвтэй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын цахим хуудаснаа нийтлэгдсэн нийтлэл (англи хэлээр)..... 616

**Хавсралт 17** - Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (англи хэлээр)..... 618

**Хавсралт 18** - Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (албан бус орчуулга, монгол хэлээр)..... 655

Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох криминологийн судалгаа /Монголын Криминологчдын холбоо/ ..... 683

Товчилсон үгийн жагсаалт..... 773

# ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Долдугаар бүлэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”-ын эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.” гэж заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2024 оны тайланг боловсруулан хүргүүлж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга”-ын хэрэгжилт, дүгнэлт зөвлөмжид дурдагдсан асуудлыг анхаарч, хүний эрхийг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан саналыг хүндэтгэн, хэрэгжүүлж ажиллалаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2024 оны 4 дүгээр сараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа, хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны мэдээлэл, олон улсын байгууллагын дүгнэлтэд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа-2024, хүрсэн түвшин, хүлээгдэж буй гүйцэтгэл”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт”, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022-2024 онд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн, ахиц дэвшил” гэсэн 6 бүлэгтэйгээр, дүгнэлт, саналын хамт боловсрууллаа.

# УДИРТГАЛ

Хүний эрх, эрх чөлөөг бүх түвшиндээ хүндэтгэж, хангаж, хамгаалснаар эцсийн дүндээ “нийгмийн найрсал”<sup>1</sup> бүрдүүлэх нь бидний зорилго байх ёстой. Шударга ёс тогтоохын төлөө хүн засагладаггүй, хууль засагладаг тогтолцоог бэхжүүлэхэд төр, иргэн, хуулийн этгээдийн хүний эрхийн ойлголт нэг шугаман дээр зэрэгцэн ирэх шаардлагатай байна.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсад хүн бүрийн эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрхийг баталгаажуулах, түүнийг хангах, хамгаалдаг байх төрийн хуулийн шүхэр<sup>2</sup>-ийг бүрдүүлж, эрх зүйн таатай орчныг улам бэхжүүлэх нь зүйтэй. Монгол хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах нь ардчилсан Монгол Улс оршин тогтнохын нэг үндсэн баталгаа юм.

Хүний эрх, эрх чөлөө бол хүн төрөлхтөн туулсан зам мөрийн сургамж, амар амгалан амьдрах, эрх ашгаа хамгаалан баталгаажуулах талаар бүх нийтээрээ хамтран тогтоосон үнэлэмж. Нөгөө талаас хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс эрх чөлөөтэй түүнчлэн айх аюулгүй, эрүүдэн шүүгддэггүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн<sup>3</sup>.

Хүний төрөлх мөн чанараас урган гарсан, амьдралдаа заавал эдлэх ёстой боломж, байх ёстой суурь стандартууд, хүний хувьд зүй ёсоор шаардах шаардлага, тэдгээрийг хүлээн зөвшөөрч, зарчим, хэм хэмжээ, ёс журам, үнэт зүйл болгон тогтоож, хүний төрөлхийн нэр төр, алдар хүндээ хамгаалуулах үүднээс төрд хандаж, хуулийн хүрээнд хамгаалагдах эрхтэй. Энэ нь эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүгдэхээс урьдчилан сэргийлүүлж, хамгаалагдах, зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээлгэх, хохирлоо нөхөн барагдуулдаг цогц эрхийн

<sup>1</sup> Social Harmony - Нийгмийн Найрсал гэдэг нь ард түмэн эв найрамдалтай, хүндэтгэлтэй, зөрчилдөөнгүй, хамтын ажиллагаа, ойлголцол, нийгэм дэх эв нэгдлийн мэдрэмжээр тодорхойлогддог төрийг хэлдэг. Нийгмийн Найрсал гэж хувь хүн, хэсэг бүлгүүд харилцан хүндэтгэл, ойлголцол, шударга ёсыг эрхэмлэн эв найрамдал, хамтын ажиллагаатай хамтран амьдрах нийгмийн төлөв байдлыг хэлнэ.

<sup>2</sup> ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ХУУЛЬ ТОГТООМЖ, НРМ-МЕХАНИЗМ

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай 1975 оны Тунхаглал, НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг 1984 оны конвенц, түүний Нэмэлт протокол зэрэг НҮБ-ын хүний эрхийн суурь баримт бичгүүдэд бусдыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг хориглож эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан. Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан.

2. НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганаар баталсан. Монгол Улс 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсон.

3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, эрх зүйн зохицуулалтыг 2020 онд нэмэлт, өөрчлөлт орсноор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдах үндэс суурь тавигдсан.

4. УИХ-ын чуулганаар 2022 оны 06 дугаар сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилсноор Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаа хэрэгжиж эхэлсэн. D-Parliament.mn

<sup>3</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Удиртгал хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

бүрдүүлбэрийн тухай асуудал юм<sup>4</sup>.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий доромж хандлагаас ангид байх эрх бол абсолют эрх. Олон улсын хүний эрхийн эрх зүйд туйлын эрх маш цөөн байдаг. Эрүү шүүлт нь хүний нэр төр, эрхэм чанарыг ноцтой үгүйсгэдэг тул эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүний эрхийн эрх зүйд туйлын эрх хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл *ямар нэгэн зүй ёсны зорилго, шалтгаан, өөр юу ч байхыг үл харгалзан төрөөс энэ эрхэд халдахыг хатуу хориглоно*<sup>5</sup>.

Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталснаар **“эрүүдэн шүүх”**<sup>6</sup> болон **“хүний нэр төрийг доромжлон харьцах”**<sup>7</sup>, **“хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрх”**<sup>8</sup>-ийг олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулах суурийг тавьсан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг<sup>9</sup>, түүнчлэн 2002 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг<sup>10</sup> тус тус баталсан.

4 НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцод нэгдэн орсон улс орнууд эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцахыг туйлын хориглох, эрүү шүүлт тулгасан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүдэн шүүх болон түүнтэй адилтгах зүй бус харьцсан гэх гомдлыг шалгах, эрүүдэн шүүсэн этгээдийг яллах, хохирогчдын хохирлыг барагдуулах үүрэг хүлээсэн байдаг. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

5 Хүний нэр төрийг доромжлох нь хэрцгий, хүнлэг бусаар харьцах, шийтгэх гэсэн ойлголтоос ялгаатай. Энэ үйлдэл нь хүчтэй шаналал үүсгэх биш, харин хүнийг доромжлох, гутаах зорилгын үүднээс үйлдэгддэг. Тухайлбал, бусдын өмнө хувь хүнийг бүдүүлгээр доромжлох, хоригдсон, саатуулагдсан этгээдийг хиртэй, бохир хувцастай нь удаан хугацаанд байлгах, бие эрхтний доголдол, халдварт өвчнийх нь талаар бусдад дэлгэх, нойргүйдүүлэх, «стресс, дарамт шахалт» учруулах, бэлгийн болон нийгмийн «цөөнх» бүлэгт хамаардаг этгээдийн эмзэг мэдээллийг бусдад задруулах, хүний нүцгэн зургийг авч бэлгийн доромжлолд оруулах, бусдын дэргэд нүцгэлэх, эмзэг эрхтэнд халдах, бусдын өмнө гутаан доромжлох үйлдлүүдийг багтаан ойлгож болно. Эдгээр төрлийн арга нь хэдийгээр бие махбодод шарх сорви үлдээдэггүй ч удаан үргэлжилдэг, хэзээ ч бүрэн эдгэдэггүй сэтгэцийн гэмтэл учруулдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Монгол Улсын Үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

6 “Эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.” гэж томъёолсон. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

7 “Хүний нэр төрийг доромжлон харьцах” үйлдэл нь хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй үйлдэл, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоодог чанартай. Европын Хүний эрхийн комиссоос “хохирогчийг бусдын өмнө бүдүүлгээр доромжлох, баривчлагдсан этгээдийг хүсэл зориг, ухамсрынх нь эсрэг үйлдэл хийхэд түлхэц өгөх”-д чиглэсэн харьцаа, шийтгэлийн хэлбэр гэж тодорхойлсон байдаг. Torture and other forms of ill-treatment: The definitions used by the ICRC | International Committee of the Red Cross

8 “Хэрцгий, хүнлэг бусаар харьцаж, шийтгэх” үйлдэл нь бие махбодын болон сэтгэл санааны хувьд ноцтой өвдөлт, зовлон зүдүүрийг үүсгэдэг, эсвэл хувь хүний нэр төрд ноцтойгоор халдсан үйлдлээс бүрдэнэ. Эрүүдэн шүүхээс ялгаатай нь эдгээр үйлдлийг тодорхой зорилгоор хийх шаардлагагүй. Хэрцгий буюу хүнлэг бус харьцах арга хэлбэрийг гэр бүлийн гишүүдэд нь сэтгэл санааны зовлон шаналал учруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсвэл эмчилгээг буруугаар ашиглах, зохисгүй нөхцөлд цагдан хорих, саатуулах зэрэг үйлдлээр жишээ болгон тайлбарлаж болно. Torture and other forms of ill-treatment: The definitions used by the ICRC | International Committee of the Red Cross

9 НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 дугаар тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг баталж, 2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр тус конвенцыг Улсын Их Хурал соёрхон баталсан. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

10 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн Тавин долдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг баталж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

Энэхүү конвенцод нэгдэн орсон гишүүн орнуудад олон улсын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бие даасан байгууллага байгуулж, хараат бусаар ажиллах боломжийг олгохыг үүрэг болгосон<sup>11</sup>. Энэ нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бий болгоход оршино.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод одоогоор 174 улс нэгдэн орсон хэдий ч дэлхийн улс орнуудын дөрөвний гуравт нь эрүүдэн шүүх явдал үйлдэгдсээр, хүн төрөлхтний хамгийн эмзэг асуудал байсаар байна<sup>12</sup>. Женев хотноо 2024 оны 11 дүгээр сард болсон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар дэлхийн улс орнуудын эрүүдэн шүүлттэй холбоотой нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцлээ.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТЭД: **“Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) байгуулагдаад удаагүй ч, стратеги төлөвлөгөөгөө батлан, богино хугацаанд чадавхижж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ахиц гаргасан”** хэмээн онцлон дүгнэж, НҮБ-ын тусгай тайланд тэмдэглэсэн<sup>13</sup>.

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх Тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс нь “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн чиг хандлагын тоймыг 2024 оны нөхцөл байдлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганд дүгнэж танилцуулсан<sup>14</sup>.

11 НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 19 дүгээр зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

12 Seventeenth Annual report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment\*\* НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Арван долоо дахь тайлан. [file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20\(1\).pdf](file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20(1).pdf) [file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20\(1\).pdf](file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20(1).pdf)

13 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаар Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. [https://www.ohchr.org/en/ohchr\\_homepage](https://www.ohchr.org/en/ohchr_homepage)

14 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаас гаргасан олон улсын “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн 2024 оны нөхцөл байдлын тойм дүгнэлт.

2024 онд зэвсэгт мөргөлдөөний үеэр хүний нэр төрийг гутаан доромжилж, эрүүдэн шүүх үйлдлүүд гамшгийн хэмжээнд хүрлээ. Үүнд:

- ОХУ болон Украин Улс хоёрын зэвсэгт мөргөлдөөний үеэр олзлогдогсдоос мэдээлэл, мэдүүлэг авах зорилгоор үйлдэж буй айлган сүрдүүлэх, айдас автуулах, шийтгэх үйлдлүүд нь “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг харгислалыг батлан харуулж байна.
- Судан улсад дайтаж буй талууд дур зоргоороо саатуулах, баривчлах, энгийн иргэдийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах зэрэг системтэй кампанит ажил явуулж байна.
- 2023 оны 10 дугаар сарын 07-нд Израильд болсон халдлагын нотлох баримтууд нь аллага үйлдэх, барьцаалах, бие махбодын болон бэлгийн эрүү шүүлт тулгах зэрэг олон улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн болохыг баттай харуулж байна.
- 2023 оны 11 дүгээр сард Олон улсын шүүхээс Сирийн асуудлаарх нааштай, заавал биелүүлэх ёстой зарим арга хэмжээг яаралтай авсан хэдий ч тус улсад эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсан талаарх мэдээллүүд Тусгай илтгэгчид ирсэн хэвээр байна.

НҮБ-ын Тусгай илтгэгч зэвсэгт мөргөлдөөний үеэрх бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээлэл зонхилж байгаад онцгойлон санаа зовж байгаагаа илэрхийлжээ. 202410-unsrt-sexualtorture-q-a.pdf

Иймд НҮБ-ын гэрээний байгууллагууд эрүүдэн шүүх явдалтай хийж буй тэмцлээ хоёр дахин нэмэгдүүлэхийг Оролцогч улсуудын Засгийн газар, Үндэсний урьдчилан сэргийлэх болон хяналт, тайлагналын механизмууд, бусад оролцогч талуудад уриалсаар байгаа.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш хуучин нийгмийн тогтолцоог өөрчлөн хүмүүнлэг, иргэний, ардчилсан төрт улсын тогтолцоонд шилжихээр 1993 оноос эрх зүйн шинэчлэл эхлүүлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил үргэлжилсээр байна. Энэхүү шинэчлэлийн зорилт бол хүний эрхэд нийцсэн шударга процесс бүхий эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бэхжүүлэх явдал юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэвчиж үл болох хамгийн ноцтой зөрчил бол эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн зөрчил юм. Тиймээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх (ЭШУС) үндэсний механизм шинэ тутам байгуулагдсантай холбогдуулан төрийн бодлогын хүрээнд анхаарах асуудлууд байсаар байна.

Түүхийн явцад гэмт хэрэг илрүүлэх, ял эдлүүлэх зэрэг тодорхой зорилгод хүрэхийн тулд төрийн байгууллага, тэдгээрийн төлөөлөгчдөөс хүний бие махбод, эсвэл сэтгэл санаанд хүчтэй шаналал зовлон учруулах явдал байсан. Тухайлбал, тодорхой зорилгод хүрэхийн тулд хүнийг үндэслэлгүйгээр олон хорих ангиудад жил тойруулан дамжуулан хорьдог, олон хоног уурын зууханд хорьсон, тамхины цогоор түлсэн, эмэгтэй хэрэгт шалгагдагчийн харуул хамгаалалттай цоожтой өрөөний хаалгыг онгойлгоод онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн, чанга дэглэмтэй хорих ангид ялаа эдэлж байх ёстой эрэгтэй хоригдол орж ирж цохиж зодох, доромжлон харьцах, хэрэг хүлээхийг тулгах, хурц гэрэлтэй өндөр сандалд удаан хугацаагаар суулгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хэт удаашруулах, олон сар жилээр дуудан байцаалт авах нэрээр гаднаа хүлээлгээд ажил тарсан, маргааш ир гэх зэргээр олон удаа явуулж залхаадаг... гэх мэт хэрэг гарсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлж байсан<sup>15</sup>.

Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын ЭШУС асуудлыг хариуцсан Тусгай илтгэгч Манфред Новак 2005 онд Монголд ажилласан тайландаа “Монголд эрүү шүүлт хавтгайрсан байна”<sup>16</sup> гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Энэ нөхцөл байдал эргэн давтагдах ёсгүй.

Энэ бүх байдлыг таслан зогсоох, эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийг сайжруулахад анхаарч, Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна. Нэмэлт протоколын үзэл санаа, зохицуулалтыг хоёрдмол утга, өөр өөр байдлаар тайлбарлахгүйгээр нэг мөр хэрэгжилтийг хангах нь чухал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан<sup>17</sup> тул эрүү шүүлт тулгах, хэрцгий,

<sup>15</sup> Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос (2024.11.20) хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголыг зохион байгууллаа. <https://www.parliament.mn/nn/63400/>

<sup>16</sup> НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх асуудлаар тусгай илтгэгч хатагтай Манфред Новак Засгийн газрын урилгаар 2005 оны 6 дугаар сарын 4-10-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан. <http://www.ohchr.org/english/issues/torture/rapporteur/index.htm>

<sup>17</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1156>



хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн эрх зүйн зохицуулалт дотоодын холбогдох хууль тогтоомж болон нэгдэн орсон энэхүү конвенцын дагуу зохицуулагдана<sup>18</sup>.

Монгол Улсын хувьд конвенц, дотоодын хууль тогтоомжид заасны дагуу<sup>19</sup> Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнийг томилж, албан хаагчид томилогдсоноор ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Одоогоор бүрэн эрхээ хэрэгжүүлээд үйл ажиллагааны тайлант гурав дахь жилтэйгээ золгожээ.

ЭШУС үндэсний ажиллагаа нь аливаа хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан, өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт нэвтэрч, гэнэтийн, тогтмол хяналт шинжилгээ хийх, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг сурталчлах, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах гол чиг үүрэгтэй<sup>20</sup>.

Ихэнх хүмүүс эрүү шүүлтийг хорих газар, эсхүл цагдан хорих, саатуулах байранд л үйлдэгддэг хэмээн төсөөлдөг. Гэтэл конвенц болон хуульд заасан “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмад настнуудын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр зэрэг их өргөн хүрээтэй олон объект үүнд хамаардаг. Өөрөөр хэлбэл богино, дунд, урт хугацаанд эрх нь хязгаарлагдаж байгаа олон хүний зүй ёсны эрхийг хамгаалдаг.<sup>21</sup>

Тиймээс энэ механизмын хяналт шинжилгээ хийх газар нь 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт оршин байх тул маш өргөн цар хүрээтэй ажиллахыг шаардана. Ажиллах бүрэлдэхүүний хувьд одоогоор зургаан албан хаагчтай. Цаг хугацааны хувьд ч ажлын 8 цагаар хязгаарлагдахгүйгээр ажиллах нэн хүнд нөхцөлтэй. Төсөв, санхүү, техник хэрэгсэл хангалтгүй.<sup>22</sup>

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас авч хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагааг бүх талаар дэмжин, холбогдох тогтоол шийдвэрүүд гарган хэрэгжилтийг хангахад Улсын Их Хурлын дарга, Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд, Хууль зүйн байнгын хорооны

18 НҮБ-ын Хүний эрхийн гэрээний бусад Нэмэлт протоколуудаас ялгаатай нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол нь стандарт тогтоох хэрэгсэл биш харин үйл ажиллагааны гэрээ юм. Өөрөөр хэлбэл, энэ нь шинэ үүрэг хариуцлага үүсгэдэггүй, харин Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлд заасан эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үүрэг хэрэгжүүлэх боломжийг Оролцогч улсуудад олгодог.

19 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, түүнд туслах нэгжийн зохицуулалтыг хуульчилсан.

20 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

21 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг. Тайлбар: Энэ хуульд заасан «бүх газарт» гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

22 Нээлттэй Нийгэм Форумгаас хийсэн “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийсэн дүн шинжилгээ”. Б.Хишигсайхан нар. Энэ чиглэлээр уг механизмын үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй судалсан. Улаанбаатар, 2022.12.10.

ахлах зөвлөх Г.Золжаргал, УИХ-ын Тамгын газраас бодлогын дэмжлэг үзүүлж, жилээс жилд төсөв, санхүүг нэмэгдүүлэхийг эрмэлзэж ирсэн нь өмнөө тавьсан зорилт, төлөвлөсөн ажлууддаа амжилттай хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлснийг онцлон дурдаж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (ХЭҮКтХ) болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийж байна. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөлтэй нийт 843 газарт, давтагдсан тоогоор жилд 144,942 иргэн богино, дунд, урт хугацаагаар байрлаж байна. Нэн тэргүүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн 37,000 гаруй хүнд тогтмол хүрэлцэн очиж хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хууль, олон улсын гэрээнд зааснаар ажилладаг.

ЭШУС үндэсний ажиллагаанаас дээр дурдсан хаалттай, маш хол зайд тархан байрласан объектуудад ямар ч цаг хугацаанд хүрэлцэн очиж, дотогш нэвтрэн, түүн доторх эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг гэнэтийн хийдэг тэр онцлог бүрэн эрхийг нутагшуулахаар зорьж ажиллаж байна. ЭШУС механизм нь эрүү шүүлт гарсны дараа шалгадаг биш, харин гарч болзошгүй нөхцөл байдлуудыг урьдчилан харж, тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах замаар болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлдэг механизм юм. Нөгөө талаасаа мөн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхийн зэрэгцээ тогтолцооны хувьд өөрчлөх шаардлагатай нөхцөл байдлыг тогтоон, засаж сайжруулах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, санал хүргүүлж, хэрэгжилтийг хангууллаа.

Товчхондоо “хэдийд ч урьдчилан сэргийлэх механизм ороод ирж магадгүй” гэсэн болгоомжлолыг хуульд заасан тухайн байгууллагуудын удирдлага, албан хаагчдад төрүүлж, хүний эрхийн зөрчил гаргахгүй байх орчин нөхцөл бий болгож ажиллах хандлагыг төлөвшүүлэх, эрүүдэн шүүх гэмт явдлыг дахин гаргуулахгүй байх бүхий л нөхцөлийг бүрдүүлэх үзэл санаанд тулгуурлан урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүллээ.

Төр, иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааны үр дүнд эрүү шүүлтийн хор уршгийн талаар нийтээрээ танин мэдэж, түүнээс урьдчилан сэргийлэхийн ач холбогдлыг ойлгож, эрүү шүүлтгүй нийгэм, эрх зүйн орчин бүтээхээр бүхий л түвшинд эрмэлзэж байгааг НҮБ-ын гэрээний хороодоос өндрөөр үнэлсэн явдалд үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны хамт олон талархал илэрхийлье.

Тайлант хугацаанд ЭШУС үндэсний ажиллагааны талаар буруу ташаа мэдээллийг эрх мэдэл, албан тушаалын байдлын ашиглан бусдад түгээх, Монгол Улсын Олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор баталгаажсан бүрэн эрхийг үл хүндэтгэх, үйлдэл, эс үйлдлээр саад учруулах зэрэг харамсалтай оролдлогууд гарсныг энэхүү тайлангийн бүрдэл хэсгүүдэд тодорхой баримттайгаар орууллаа. Цаашид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно.” гэж заасныг төрийн байгууллагын бүхий л албан тушаалтнууд анхаарч, мөрдөх, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.





**N P M**  
**MONGOLIA**

ᠨᠡᠭᠳᠦᠭᠡᠷ ᠪᠦᠯᠡᠭ  
ᠡᠷᠦᠭᠦ ᠰᠢᠭᠦᠯᠲᠡᠭᠦ ᠤᠷᠦᠳᠴᠢᠯᠠᠨ ᠰᠡᠷᠭᠢᠶᠢᠯᠡᠬᠡ  
ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠶ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠭᠠ-2024, ХҮРСЭН ТҮВШИН,  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА-2024, ХҮРСЭН ТҮВШИН,  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ГҮЙЦЭТГЭЛ**



# ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА-2024, ХҮРСЭН ТҮВШИН, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

## Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль эрх зүйн орчны шинэтгэл, өнөөгийн байдал:

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (ХЭҮКТХ)-ийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх (ЭШУС) асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, баталгаа болон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах чиг үүрэг бүхий үндэсний ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилсан.

Үйлчлэх хүрээний хувьд аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийж, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, олон нийтэд сурталчлах, судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй хамтран ажиллах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.” гэж заасан.

Үүний дагуу ЭШУС үндэсний ажиллагаанаас хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил, гадаад, дотоод хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны статистик мэдээлэл, судалгаа, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, шийдвэрлэлт болон бусад эх сурвалжид үндэслэн ЭШУС үндэсний ажиллагааны тайланг хуульд заасан тайлант жилээр боловсруулж, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргад өргөн барьж, жил тутам УИХ-ын гишүүдэд хүргүүлж, хэвлэн нийтэлж олон нийтэд танилцуулж ирлээ. Энэ удаагийн тайланг боловсруулахдаа 2022 он, 2023 он, 2024 оны тайлант хугацааны үйл ажиллагааны хүрсэн түвшнийг харьцуулан дүгнэх, үр дүн, цаашид хүлээгдэж буй гүйцэтгэлийг танилцуулахыг зорьсон болно.



ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны тайланг УИХ-аас D-Parliament.mn-д байршуулан олон нийтэд танилцуулах арга хэмжээг 2024 онд авч ажилласан.



Түүнчлэн Хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл ЭШУС зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, ЭШУС чиглэлээр холбогдох судалгаа, санал дүгнэлт боловсруулан УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, улмаар ХЗБХ-оос УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн тодорхой асуудлуудаар шийдвэр гаргуулсан.



### НЭГ. УИХ-ын гишүүдээс санаачлан УИХ-д өргөн барьж хэлэлцсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсруулсан хуулийн төсөл<sup>23</sup>


Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт: Монгол Улсын ХЭҮКХ-ийн ЭШУС үндэсний

<sup>23</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлэв. 2024-04-26 <https://www.parliament.mn/nn/62341/>

ажиллагааг зохицуулсан заалтуудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийлгэхийг Улсын Их Хурлын ХЗБХ-нд даалгасан.

УИХ-ын ХЗБХ-ны захиалгаар хийсэн ЭШУС үндэсний ажиллагааны талаар хараат бус судлаачдын багийн “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа”-аар одоогийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй, ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэж байна гэж дүгнэгдсэн.

Түүнчлэн ЭШУС үндэсний үйл ажиллагаа нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод заасан хяналт шинжилгээ хийх газрыг хязгаарласан, хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг олгохгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь тогтоогдсон гэж дүгнэсэн.



Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр Монгол Улсын ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулсан 22 заалтын зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна<sup>24</sup>.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 2024 оны 5 сард хараат бус шинжээчдийн багийн гүйцэтгэсэн судалгааны дүн болон УИХ-ын 2023 оны №114, 2024 оны №37 дугаар тогтоолуудад заасны дагуу УИХ-ын удирдлагуудаас өгсөн чиглэлийн хүрээнд Монгол Улсын ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор “Монгол Улсын ХЭҮКтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, чуулганаар хэлэлцүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Д.Ганбат,

<sup>24</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ”. Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан хараат бус судлаачдын баг. 5 хууль зүйн докторууд багт ажилласан. ХЭҮК, 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>

Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нар Монгол Улсын ХЭҮКтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан боловсруулж, (2024.04.26) Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлж, Хаврын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэж, эхний хэлэлцүүлэгт шилжүүлж шийдвэрлэсэн<sup>25</sup>.

Монгол Улсын ХЭҮКтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нийцүүлэн нэмэлт оруулах, зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль болон зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тооцож байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.<sup>26</sup>

### **ХОЁР. Улсын Их Хурал, Засгийн газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан тогтоол, шийдвэр**

Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн байнгын хорооны гишүүд ЭШУС үндэсний ажиллагааны тайлан, бусад үйл ажиллагаатай танилцан, өндөр ач холбогдол өгч, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Засгийн газрын хуралдаан, ХЗБХ-ны хуралдаануудаар авч хэлэлцээд:

1. **Улсын Их Хурлын** 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” **35 дугаар тогтоол;**
2. **Улсын Их Хурлын** 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” **37 дугаар тогтоол;**
3. **Улсын Их Хурлын** 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” **114 дүгээр тогтоол;**
4. **Улсын Их Хурлын** Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” **09 дүгээр тогтоол.**
5. **Улсын Их Хурлын** 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлах тухай” **21 дүгээр тогтоол** (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн)

<sup>25</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэлээ. <https://www.parliament.mn/nn/62341/>

<sup>26</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл <https://d.parliament.mn>



6. **Улсын Их Хурлын** 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө»-г батлах тухай” **42 дугаар тогтоол** (Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилтын 5.3-т: “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан.)
7. **Монгол Улсын Ерөнхий сайдын** 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” **02 дугаар Албан даалгавар**. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгийг хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр тогтоол, шийдвэрүүд батлагдсан нь төр, засгаас ЭШУС үндэсний үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлсэн томоохон арга хэмжээ болсон.

**I. УИХ-ын 2023 оны 35 дугаар тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх;
- Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

**II. УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний

ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох"-ыг Засгийн газарт даалгасан.

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

- Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно." гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

### **III. Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийх чиглэлээр:

- Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын ХЗБХ болон Хүний эрхийн дэд хороонд даалгасан<sup>27</sup>.

### **IV. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар:

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу

<sup>27</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу хийсэн "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ" хийлгэсэн. Судалгаагаар ХЭҮКтХ-ийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, үл ойлгогдох байдал үүсгэхүйц байгаа нь тогтоогдсон. Хараат бус судлаачдын багийн тайлан. 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>



хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

**V. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.1.10 дугаар заалтад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа аливаа хязгаарлалтгүйгээр, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдах чухал баталгаа болсон.

**VI. Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө»-г батлах тухай” 42 дугаар тогтоол**

Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлэх чиглэлээр:

(Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилтын 5.3-т: “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор байгуулагдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм (NPM)-ыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалахад УИХ-аас дэмжиж ажиллах чухал баримт бичиг болсон.

**VII. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар.**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус

хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр тогтоол нь Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан ЭШУС үйл ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн томоохон бодлогын арга хэмжээ болсон. Онцлон тэмдэглэхэд тус тогтоолууд хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, замын зургийг тодорхойлоход чухал түлхэц үзүүлсэн.

Түүнчлэн ЭШУС үндэсний ажиллагаа хуульд заасан чиг үүргээ богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж байгааг дүгнэсэн байна<sup>28</sup>.


Үүнээс дүгнэхэд иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүүдэн шүүлтийг таслан зогсоох чиглэлд бодитой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн. Үндсэн хууль, төрөлжсөн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр иргэдийн эрүү шүүлт болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрхийг баталгаажуулсан, түүнийг хангах, хамгаалах үйл ажиллагааг дэмжих бэхжүүлэхэд тодорхой ахиц гарсан байна<sup>29</sup>.

Улсын Их Хурлын “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 75 жилийн ойд зориулсан 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Хүндэтгэлийн хуралдаан, УИХ-ын 2024 оны Хаврын чуулганы нээлт, 2025 оны Хаврын чуулганы хаалтын хуралдаанд Улсын Их Хурлын дарга чуулганы хуралдааны индрээс үг хэлэхдээ: “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд тодорхой ахиц дэвшил гарч байгааг Улсын Их Хурлын удирдлагын зүгээс үнэлж, байр сууриа илэрхийлэхийн сацуу Монгол Улс Хүний эрхийн конвенц, гэрээ, пактуудаар хүлээсэн үүргээ биелүүлж, Хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын Хүний эрхийн хороо, бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизм бүрдүүлж, парламентаас манлайлж ажиллах, Гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээний заалтыг шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын гэрээний үүрэг, зөвлөмжийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд тогтмол тайлагнадаг журамд шилжиж, эрүүдэн шүүлтийн нөхцөл байдалтай холбогдуулан нээлттэй сонсголоор хянан хэлэлцэх үүрэг чиглэл өгсөн<sup>30</sup>.

28 Монгол Улсын Их Хурлаас “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын дэлгэрэнгүй тэмдэглэл. 2024.11.20. “Их-Эзэн Чингис хаан” танхимд. <https://www.parliament.mn/nc/646/>

29 Г.Занданшатар: Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, Эрүүдэн шүүлтийг таслан зогсоох чиглэлд бодитой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн. Хаврын чуулганаар эрх зүй, эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн реформуудаа эцэслэн дуусгах нь Та бидний эрхэм чухал зорилт байх болно. <https://www.parliament.mn/nn/52006/>

30 Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нар (2023.12.12) Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нартай уулзлаа. <https://www.parliament.mn/nn/51503/>



Энэ үүргийн дагуу ЭШУС үндэсний ажиллагаанаас Улсын Их Хурлын ХЗБХ-ны хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголыг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан.

Харин Монгол Улсын Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн 02 дугаар Албан даалгавраар өгөгдсөн үүрэг даалгавар, ЭШУС болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр авах арга хэмжээний талаарх тогтоолуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхийг ХЗДХЯ-наас анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна.

### **ГУРАВ. Нэгдсэн Үндэстний Байгууллага, Хүний эрхийн гэрээний хороодоос ирүүлсэн зөвлөмж, тогтоол, дүгнэлт**

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Оролцогч улс нь энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээний тухай илтгэлээ конвенцод нэгдэн орсноос хойш нэг жилийн дотор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлдэг.

Түүнээс хойш Оролцогч улс нь шинээр авсан арга хэмжээний талаарх нэмэлт илтгэлийг дөрвөн жилд нэг удаа НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлэх тайлагналын тогтолцоотой.

Уг тайлагналын тогтолцооны дагуу Монгол Улсын Засгийн газар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх гурван удаагийн илтгэлийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тайлагнаж, дагаж мөрдөх гурван удаагийн зөвлөмжийг хорооны зүгээс хүлээн авч, хэрэгжилтийг хангаж байна. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодоос<sup>31</sup> Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмж, тогтоол, дүгнэлт ирүүлдэг.

<sup>31</sup> НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо (CAT), НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо (SPT). <https://www.ohchr.org/en/treaty-bodies/spt> Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хороо (SPT) нь НҮБ-ын Хүний эрхийн тогтолцооны шинэ төрлийн гэрээний байгууллага юм. Энэ нь эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх идэвхтэй арга барилд чиглэгдсэн урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын (OPCAT) Нэмэлт протоколыг соёрхон баталсан улсууд цагдан хорих газартаа очиж, тэнд хоригдож буй хүмүүст хэрхэн хандаж байгааг шалгах эрхийг SPT-д олгодог. Протоколд мөн хоригдож байгаа хүмүүсийн хэрхэн харьцаж буйг шалгах, эрүүдэн шүүхээс хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэх талаар улс орнуудын Засгийн газарт зөвлөмж өгөх, биелэлтийг шалгах, одоо байгаа болон санал болгож буй хууль тогтоомжийн талаар санал дүгнэлт гаргах зорилгоор бие даасан Үндэсний урьдчилан сэргийлэх механизм (NPM) байгуулахыг улс орнуудад үүрэг болгосон. UN SPT нь NPM-д үйл ажиллагаанд нь тусалж, зөвлөгөө өгдөг чиг үүрэгтэй.



1. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 50 дугаар чуулганы хуралдаан болон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны хуралдааны 54 дүгээр хуралдаанаас “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу Монгол Улс ЭШУС үндэсний механизмыг бие даасан, хараат бус байдлаар бий болгох арга хэмжээ авах” НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан удаа дараагийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах талаар Монгол Улсад өгөх зөвлөмж”-үүдийг баталсан.

- a. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хорооны 2016 оны 08 дугаар сарын 2,3-ны өдрийн 1443, 1445 дахь хуралдаанаар Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэлийг CAT/C/MNG/2 хэлэлцээд, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 1453 дахь хуралдаанаар баталсан зөвлөмж (2016),



- b. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн CAT/OP/MNG/1 «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017),
- c. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 54 дэх хуралдаанаар хэлэлцэн баталсан A/HRC/54/51/Add.2 Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг хэлэлцэн баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бие даасан, хараат бусаар байгуулах талаарх зөвлөмж.

Энэ талаар Монгол Улсын Их Хурал болон Олон улсын парламентын холбооны хамтран (2025.03.20) зохион байгуулсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан, хэлэлцүүлэг (UPR-Universal Periodic Review)-ийн үйл явц дахь Монгол Улсын Их Хурлын оролцоо, гишүүн орнуудаас хүлээн авсан зөвлөмжүүдийн хэрэгжилт, тэдгээрийг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог

хангах талаарх асуудлын талаарх уулзалт-хэлэлцүүлгийн үеэр тусгайлан хөндөгдсөн<sup>32</sup>.

2. НҮБ-ын Гэрээний хороодын тайлагналын механизмын дагуу Монгол Улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн гурав дахь илтгэлийг Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар хэлэлцлээ.

Хуралдаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх төв, Дэлхийн худалдааны байгууллага болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа, Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс болон ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ болон иргэний нийгмийн төлөөлөгчид биечлэн оролцов.

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Оролцогч улсын илтгэлийн хэлэлцүүлгийн явцад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор байгуулагдсан үндэсний урьдчилан сэргийлэх механизм буюу Монгол Улсын тухайд ЭШУС үндэсний ажиллагаа болон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хаалттай уулзалт хийж, ажиглалт зөвлөмж гаргах явцад өөрсдийн санал, дүгнэлтийг хороодын гишүүдэд танилцуулах эрхийг олгодог.

Энэ хүрээнд Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны дарга, гишүүд, Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид, НҮБ-ын ЭШУС Дэд хорооны дарга, гишүүдтэй албан ёсны уулзалт хийж, Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй хүчин чармайлтын талаар хоёр талын уулзалтууд хийв.

Мөн энэ үеэр **НҮБ-ын Тусгай сангаас Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх талаар хүргүүлсэн төсөл шалгарч, санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн**<sup>33</sup>.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын **Эрүүдэн шүүхийн эсрэг хороо** нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд 2157, 2160 дугаар хуралдаанаараа Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа **CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг** баталсан.

<sup>32</sup> Хүний эрхийн төлөв байдлын үнэлгээний талаарх цахим уулзалт-хэлэлцүүлэг эхэллээ  
<https://www.parliament.mn/nn/74289/>

<sup>33</sup> "Strengthening the NPM of Mongolia, improving public education on the right to be free from torture and human rights". Granted by the Special Fund of the Optional Protocol to the UN Convention against Torture to be implemented in 2025.05.01 – 2026.04.01.





Optional Protocol to the  
Convention against Torture  
and Other Cruel, Inhuman  
or Degrading Treatment  
or Punishment

Distr.: Restricted

Original: English

English, French and Spanish only

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтэд: **“Монгол Улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголын УИХ, Засгийн газарт уриалж, Зөвлөмж ирүүлсэн** болно<sup>34</sup>.

- a. Түүнчлэн Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгохыг удаа дараа сануулсаар ирсэн бөгөөд энэ удаад ч дахин сануулж байгаагаа уламжлав.
- b. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь **Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026 он) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан байна.**

34 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх. [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en).

4. НҮБ-ын **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос** Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн **CAT/OT/MNG/RPNPM/R-I зөвлөмж** гаргасан.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12-ны 2157дугаар хуралдаанд Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаар НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос танилцуулсан.

Улмаар НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн **CAT/OT/MNG/RPNPM/R-I дүгнэлт** гаргаж, ирүүлсэн.

5. Монгол Улсын илтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулан уг хуралдаанд оролцсон **“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) - Олон улсын байгууллагын дарга, төлөөлөгчид “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсийн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын бүс нутгийн бусад Оролцогч улсууддаа “үлгэр жишээ” болж буйг онцолж, мандатынхаа дагуу олон улсын түвшинд энэ тухай мэдээлсэн байна<sup>35</sup>.**

Тухайлбал, Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдан ажиллаж байгаа богино хугацаанд үр дүнтэй ажиллаж, Ази-Номхон далайн бүс нутагтаа тэргүүлэх байр суурьтай ажиллаж байна гэж дүгнэжээ.

АРТ-“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”, АРФ-Ази-Номхон далайн форум байгууллагууд хамтран санхүүжилтийг шийдвэрлэн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд 2025 онд техникийн туслалцаа үзүүлэх хүрээнд



Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллагатай Улаанбаатар хотноо дотоо янзгийн турш гайтлын ажиллагааг үргэлжлүүлжээ.

Энэ үеэр Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нийцэт шийтгэлтний арга барилд анхаарах асуудлыг олон талтай зорилгоор эмгэгтэйчүүдийн хариу ашиг хамтарсан хийцэт шийтгэлтэй хийж хэрэгжүүлжээ ирэх онд хамтаран ажиллахаар болжээ.

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсэд байгуулагдаж цэцэг энэрхий ажиллагаанд нэг болжээ. Бүс нутгийн ЭШУС үндэсний ажиллагааны бүрэн хөгжилд хамрагчид ЭШУС-уудын дэм болжээ. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг зарчлаар соёрхон батлахгүй бус нутгийн бусад Оролцогч улсуудад угтар хамтар болжээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”-ээс тодорлоо.



35 Mongolia's NPM is one of only a small number in the Asia Pacific but it is already benefiting from the experiences of other NHRIs in the region with an NPM mandate, as well as acting as an example for those states in the region who are yet to ratify the Optional Protocol to the Convention against Torture. <https://www.apt.ch/news/mongolia-new-monitoring-body-focuses-risky-practices-and-women-detention>

Монгол Улсад 3 удаа ирж, үндэсний ажиллагааны алба хаагчид болон монголын хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын сургагч багшаар бэлтгэх хамтарсан урт хугацааны төсөл хэрэгжиж эхлэв.**<sup>36</sup>

## **ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 34.1.11-д заасан бүрэн эрхийн дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны Стратеги төлөвлөгөөг батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна<sup>37</sup>.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Монгол Улсын ХЭҮКтХ-д заасан зарчимд нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагааны Алсын харааг “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” гэж тодорхойлон, эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судалж, ЭШУС үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч нь байх эрхэм зорилгыг баримтлан ажиллаж байна.

## **ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГЖИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1. ЭШУС нэгж нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, А/02 дугаар тушаалаар “ЭШУС хэлтсийн дүрэм”, 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх “Аргачлал батлах тухай” А/03 дугаар тушаалыг хуульд заасны дагуу тус тус батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь тайлант хугацаанд 6 албан хаагчтайгаар ажилласан.

3. Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд энэ 2024 оны тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлууд нь өмнөх 2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон мэдээлэлтэй харьцуулахад зарим үзүүлэлтүүд нэмэгдсэн.

4. ЭШУС үйл ажиллагааны хүрээнд олон улсын болон төрийн холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах, хамтарсан төлөвлөгөө батлан, дэвшүүлсэн зорилтын хүрээнд үр дүнтэй хамтран ажилласан нь бодит үр дүнд хүрсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлын удирдлага, Улсын Их Хурлын ХЗБХ-ны дарга, гишүүд, Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд, Хууль зүйн

36 “Strengthening the NPM of Mongolia, localizing the Mendez Principles in the law enforcement”. Granted by the Asia Pacific Forum (APF) and Association for the Prevention of Torture (APT), to be implemented in 2025.

37 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026 он) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан байна. [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolNo=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolNo=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en).



байнгын хорооны ахлах зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газар, УЕПГ, АТГ, ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ЦЕГ, ШШГЕГ, ГБХНХЯ, ЭМЯ, Боловсролын яам, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо (САТ), НҮБ-ын ЭШУС Дэд хороо (SPT), НҮБ-ын Тусгай сан, ЭШУС нийгэмлэг (АРТ), Ази-Номхон далайн форум (АФ) зэрэг гадаад, дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, анхлан бойжиж буй ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, бодлогын дэмжлэг тусалцаа авах, өмнөө тавьсан зорилт, төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлэх нөхцөл боллоцоог бүрдүүлсэн.

## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОЙМ

Тайлант хугацаанд ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүргийн хүрээнд хийсэн ажлуудаас товч хураангуйлан танилцуулъя.

### Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ<sup>38</sup>

- ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 10,172 километр замыг туулж, 57 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.
- ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжсэнээс хойших хугацаанд 38,596 километр замыг туулж нийт 128 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.
- Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар, СЭМҮТ-д НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсик, Мартин Зинклер, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Армен Авестисиан, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтран аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зарим газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцах, орчин нөхцөлд

38 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 2 дугаар бүлгээс үзнэ үү.

ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар асуумжийн аргаар судалгаа авч, ганцаарчлан ярилцсан.

- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 2022-2025 онд 6,076 иргэн, 1,465 төрийн албан хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар олон улсын жишиг стандарт, өөрийн улсын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж судалгаа авсан бол, тайлант хугацаанд 1,623 иргэн, 311 төрийн албан хаагчаас асуумж авсан.
- ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан 1,531 иргэнтэй, ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 291 хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад хэлбэрээр эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдтэй, 117 төрийн албан хаагчтай ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж зөвлөгөө өгсөн. ЭШУС хэлтсийн албан өрөөнд 7 иргэн өөрийн биеэр ирж ганцаарчлан ярилцаж, зөвлөгөө авсан нь Уулзалтын бүртгэлд тэмдэглэгджээ.

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ	23	48	57	128
2	Туулсан зам (километрээр)	10,614	17,810	10,172	38,596
3	Асуумж (эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдээс)	1,650	2,803	1,623	6,076
4	Асуумж (төрийн албан хаагчдаас)	304	850	311	1,465
5	Ганцаарчилсан уулзалт ярилцлага	459	675	415	1,549

### Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж<sup>39</sup>

- ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 14 зөвлөмж, ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нийт 50 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, зөвлөмж тус бүрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшлийг тооцон ажиллав.
- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлт тайлант хугацаанд 80.0 хувь, ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас 2024 он, 2025 оны нэгдүгээр улиралд мөн 80.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн.
- Улсын Их Хурлын Тамгын газраас ЭШУС үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулгад зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж ажиллах талаар зөвлөсөн. Энэ хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний

39 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

2024 оны А/03 дугаар тушаалаар “Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх Аргачлал батлах тухай” тушаал баталсан.<sup>40</sup>

- Тус аргачлалаар зөвлөмжийн хэрэгжилтийг заалт бүрээр хувиан үнэлж, дүн шинжилгээ хийж ажилласан ба шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилтийн үнэлгээтэй танилцуулж “Үнэлгээг хүлээн зөвшөөрсөн” тэмдэглэлд гарын үсэг зуруулан, биелэлтийг хангуулан тухайн байгууллагад нь архив үүсгэж хэвшсэн. Ингэснээр зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлээгүй ирүүлсэн зөвлөмжийн заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсож тус заалтын хүрээнд өгсөн арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх ойлголт, арга замыг дахин зөвлөж хэрэгжилтийг нэмэлтээр авч үнэлж ажиллав. Зарим тохиолдолд тухайн байгууллага дээр зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр сургалт хийх, газар дээр нь очиж хэрэгжилтийг хангуулахад зөвлөн туслах зэргээр үр дүнд суурилсан, нарийвчилсан дүн шинжилгээг тухай бүр хийж ажиллав<sup>41</sup>.
- Гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлага алдсан албан тушаалтныг хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах саналаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулж ажиллав.<sup>42</sup>
- ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийн сайн туршлагыг хуваалцах, өмнөх хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил, дутагдал давтан гарах шалтгаан нөхцөлийг арилгахад онцгой анхаарч ажиллалаа.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2

№		2022	2023	2024	2025 I улирал	Нийт
1	<b>Зөвлөмжийн хэрэгжилт хувь</b>	74.0%	80.0%	84.0%	-	80.0%
2		10 зөвлөмж	20 зөвлөмж	15 зөвлөмж	6 зөвлөмж	51 зөвлөмж
3		70 заалт	224 заалт	154 заалт	46 заалт	494 заалт

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн жил бүрийн хэрэгжилтийн хувь өссөн дүнтэй байна.

40 “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаал.

41 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

42 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

Гишүүний зөвлөмжийг хэрэгжилтийг хангуулах санал	Хариуцлага тооцуулсан байдал
Гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлага алдсан албан тушаалтныг хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулахаар санал хүргүүлж, хариуцлага тооцуулсан байдал <sup>43</sup>	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах, хариуцлага тооцох тухай гишүүний зөвлөмж болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийн хүрээнд хууль сахиулах байгууллагын болон холбогдох төрийн албан хаагч нийт 10 хүнд сахилгын арга хэмжээ тооцсон байна.

ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4-т ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана гэж заасан. Хуулиар олгосон энэхүү зохицуулалтыг баримтлан саналаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулж ажиллав.<sup>44</sup>

**Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэлт<sup>45</sup>**

ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж ирүүлсэн гомдол, мэдээллээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллахын зэрэгцээ түүний дагуу ямар арга хэмжээ авсан талаар эргэж мэдээллийг авах, эргэж мэдэгдээгүй албан газруудад дахин албан бичиг хүргүүлэн шийдвэрлэлтийн мэдээллийг авч, үр дүнг тооцож ажиллав.

ЭШУС үндэсний ажиллагаа гомдол шалгадаггүй, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.<sup>46</sup>

№	Албан байгууллага	Шилжүүлсэн гомдлын тоо	Хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлсэн гомдлын тоо	Шийдвэрлэлтийн хувь
<b>2022 онд</b>				
1	АТГ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
2	УЕПГ, харьяа прокурорын газар	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%

43 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

44 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

45 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 6 дугаар бүлгээс үзнэ үү.

46 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны чиг үүрэг. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

2023 онд				
1	АТГ	10	Албан бичгээр хариу ирүүлээгүй 3	70%
2	УЕПГ, харьяа прокурорын газар	7	Хариу ирүүлээгүй 3	57%
3	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	6	Албан бичгээр хариу ирүүлээгүй 4	30.0%
4	Цагдаагийн байгууллага	3	Албан бичгээр хариу ирүүлээгүй	0%
5	ХЗДХЯ	3	Хариу ирүүлээгүй 3	0%
6	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
7	ШЕЗ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
2024 онд				
5	АТГ	19	Албан бичгээр хариу ирүүлсэн 19	100%
6	УЕПГ, харьяа прокурорын газар	15	Албан бичгээр хариу ирүүлсэн 15	100%
7	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	17	Албан бичгээр хариу ирүүлсэн 17,	100%
8	Цагдаагийн байгууллага	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
9	ХЗДХЯ	3	Хариу ирүүлээгүй 3	0%
10	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
11	Ерөнхийлөгчийн Тамгын газар	1	Уучлалт үзүүлж шийдвэрлэсэн	100%
12	ШЕЗ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
<b>Нийт</b>				<b>96.0%</b>

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2024, 2025 оны нэгдүгээр улиралд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар нийт 169, үүнээс тайлант хугацаанд нийт 92 өргөдөл, гомдол мэдээлэл ирүүлсэн байна.

### Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт<sup>47</sup>

- ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш **нийт 223 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 41,081 хүнийг хамруулсан.**

47 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 3 дугаар бүлгээс үзнэ үү.

- ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд **155 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг** зохион байгуулж, **32,640 төрийн албан хаагч нар**, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, ЕБС-ийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн оюутан, суралцагч, сонсогч нар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн 73 сургагч багшийг 2023 онд бэлтгэн гэрчилгээ олгосон бол ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг ОУБ-тай хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тус тус зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд **нийт 2,632 хүнийг хамруулж**, танхимын сургалтаар **151 сургагч багшийг** бэлтгэн гэрчилгээ гардуулснаар ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд **нийт 224 сургагч багшийг** бэлтгэсэн.
- Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт **13 байгууллагын сургалтын хөтөлбөрт** Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд **дүн шинжилгээ хийсэн**.
- Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний

эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулсан.

Хүснэгт 5

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Зохион байгуулсан ЭШУС сургалт, хэлэлцүүлэг	31	37	155	223
2	Бэлтгэгдсэн сургагч багш	-	73	151	224
3	ЭШУС сургалтад оролцсон хүний тоо	3,357	4,858	32,414	41,081

### Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа<sup>48</sup>

- “ЭШУС үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийг батлан, таван үндсэн чиглэлийг тодорхойлж ажиллалаа.
- Энэ хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар дамжуулан 211 удаагийн хүний эрхийн талаар мэдлэг ойлголт, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон бусад арга хэмжээний талаар контент (бичлэг, reels, story, poster хэлбэрээр) нийт мэдээ мэдээлэл, **321 удаагийн** телевиз, сайт, сонины ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжууллаа. Цахим орчинд давхардсан тоогоор урт, богино хугацаагаар 628.5 мянган хүнд шууд хүрч, хандалтын хувь 2023 оны мөн үеэс 67.2 хувиар өссөн байна.
- ЭШУС үндэсний ажиллагаанаас төлөвлөн хэрэгжүүлсэн 5 үндсэн ажлын хүрээнд олон нийтэд мэдээлсэн нийт мэдээллийн тоон үзүүлэлтийг 2023 оны тайлант хугацааны үзүүлэлттэй харьцуулахад 45 хувиар, хандалт 91.7 хувиар тус тус өссөн бөгөөд ЭШУС статистик тоон мэдээллээс харахад хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 10 ажлын үзүүлэлт бүгд өссөн үзүүлэлтэй байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг таниулах ажлын хүрээнд Монголын үндэсний радио, телевиз, Монголын Үнэн сонин, Сайтын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонины булан, 10 удаагийн подкаст, ЭШУС мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж ажилласан нь сурталчилгаа, нөлөөллийн ажлыг нэгдсэн арга зүй, системтэйгээр зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.
- Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах хүрээнд цуврал анимейшн, нугалбар хуудас, мэдээллийн самбар, зурагт хуудас, цаглавар зэрэг олон төрлийн сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг бүтээв.
- Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийн доромжлон харьцаж шийтгэх тухай ойлголтыг агуулсан хүүхдэд зориулсан анимейшныг бүтээж хүүхдийн асрамж халамжийн байгууллагад байгаа хүүхдүүдэд эрүү шүүлтийн хор аюулыг ойлгуулах боломжтой болсон.

48 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 3 дугаар бүлгээс үзнэ үү.

- Нугалбар хуудас, мэдээллийн самбарын загварыг боловсруулж ШШГ байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байруудын эргэлт уулзалтын танхим, хүлээлгийн өрөө, хоригдлын амьдралын бүс, СЭМҮТ-д байршууллаа.
- ЭШУС үндэсний ажиллагааны 2022, 2023 оны төсөвт эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлах хүрээнд тодорхой төсөв хуваарилагдаагүй бол 2024 оны төсөвт сурталчилгааны зардал хуваарилагдсан нь тайлант хугацаанд эрүү шүүлтээс ангид байх хүний эрх, эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлан таниулах, сурталчилгааны хэрэглэгдэхүүн бүтээх үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргахад эерэг нөлөө үзүүлсэн.

Хүснэгт 6

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2023 он	2024 он
1	Олон нийтэд цахим сүлжээгээр түгээсэн мэдээлэл	90 мэдээ, мэдээлэл	211 мэдээ, мэдээлэл
2	“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” цахим хуудасны дагагч	51 мянга	53 мянга
3	Контентын хандалт (онлайн хамгийн их хандалтаар)	Постер 18 мянга, Бичлэг 45.8 мянга	Постер 36 мянга Бичлэг 51.2 мянга
4	Телевиз, сайт, сонины мэдээ, ярилцлага	136 удаа	321 удаа
5	15 минутаас богино бичлэг	36 удаа	77 удаа
6	Reels		20
7	15 минутаас урт бичлэг	5 удаа	20 удаа
8	Сурталчилгааны Нугалбар хуудас	2,000 ш	5,000 ш
9	Сурталчилгааны хэрэглэгдэхүүн (судалгаа, гарын авлага)	2	6
10	ЭШУС үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг	37	155
11	Мэдээллийн самбар		22

### Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх олон талт хамтын ажиллагаа<sup>49</sup>

- НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь Монгол Улсад хоёр дахь албан ёсны айлчлалаа 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд хийлээ. Айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн, Дэд хорооны гишүүн Элина Штайнерт “Долоон жилийн өмнөх Дэд хорооны айлчлалаас хойш Монгол Улсын Засгийн газар нь ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулсан нь ЭШУС чухал алхам болжээ. Энэ удаагийн айлчлалаар Монгол Улсын Засгийн газар Дэд хорооны өмнөх айлчлалаас гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх, шинэхэн байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд түлхүү анхаарах болно” хэмээн энэхүү айлчлалын зорилгыг тодорхойлсон.

49 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 4 дүгээр бүлгээс үзнэ үү.



- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Монгол Улсын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн талаарх гурав дахь илтгэлийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 2024 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд 81 дүгээр чуулганаараа хэлэлцэв. Уг чуулганд Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Я.Цэлмэн, ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор Б.Энхболд, ХЭҮК-ын ЭШУС хэлтсийн дарга хууль зүйн ухааны доктор Ш.Үнэнтөгс нар оролцсон.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл боловсруулан, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр илгээсэн нь дэмжигдэж, санхүүжилт 2025 оны 5 дугаар сараас олгогдохоор шийдвэрлэгдсэн. Уг төсөл нь 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 31-ний хугацаанд хэрэгжинэ.
- Швейцарын Холбооны Улсын Женев хотноо төвтэй, ЭШУС сургалт, нөлөөллийн ажлаараа олон улсад тэргүүлэх түвшинд үнэлэгддэг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны ажлын арга барилыг Ази-Номхон далайн бүс нутгийн УСҮБ-ууд дундаа “үлгэр жишээ” болохуйц хэмжээнд хүрч чадавхажсан болохыг цахим хуудсаараа дамжуулан олон улсад мэдээлсэн.
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-тай хамтран Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэхэд сургалт, нөлөөллийн ажлыг 2024 оноос үе шаттайгаар хамтран хэрэгжүүлж эхлээд байна. “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”-тэй хамтран хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн арга хэмжээний хоёр дахь үе шат 2025 оны 03 дугаар сард зохион байгуулагдав.
- Тайланд улсын Бангкок хотноо 2024 оны 06 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази-Номхон далайн ХЭҮБ болон УСҮБ-ын уулзалт хэлэлцүүлэгт ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс оролцож, Ази-Номхон далайн бүс нутгийн ЭШУС үндэсний ажиллагааны сүлжээ байгуулахад идэвхийлэн оролцож, “Эрүү шүүлтгүй дэлхийн хамтын ажиллагаа” уриа дор нэгдэн үр дүнтэй хамтран ажиллах баримт бичиг бий болгох санаачилгыг дэвшүүлсэн нь дэмжигдэн хэрэгжээд байна.
- ХЭҮБ-уудын Дэлхийн Холбоо болон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-аас хамтран 2024-2025 оны турш зохион байгуулж байгаа “Эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, Нэмэлт протоколыг хэрэгжүүлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх нь” сэдэвт 6 цуврал олон улсын цахим хурал”-д оролцов.

<b>ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх олон талт хамтын ажиллагааны тойм</b>	
<b>2024.01.31</b>	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх нь” төслийн саналыг хүргүүлэв
<b>2024.03.04-07</b>	Хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Словени Улсын ЭШУС үндэсний ажиллагааны Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй амжилт, ололтоос туршлага судлав
<b>2024.05.05-16</b>	НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь Монгол Улсад хоёр дахь албан ёсны айлчлалаа 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд хийлээ. “Байгуулагдаад удаагүй ч үндэсний ажиллагааны албан хаагчдын ур чадвар олон улсын хүний эрхийн стандартад нийцэж чадавхажсан байгааг хамтран ажилласан эдгээр өдрүүдэд олж харлаа” хэмээ айлчлалын тэргүүн, Дэд хорооны гишүүн Элина Штайнерт онцлов
<b>2024.05.20</b>	НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь Монгол Улсад хийсэн айлчлалын талаарх мэдээллийг цахим хуудастаа нийтлэв
<b>2024.06.18-20</b>	Ази-Номхон далайн бүс нутгийн ЭШУС үндэсний ажиллагааны сүлжээ байгуулагдав. Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны санаачилгаар “Эрүү шүүлтгүй дэлхийн хамтын ажиллагаа” уриа дор нэгдэн үр дүнтэй хамтран ажиллах баримт бичиг үзэглэгдэв
<b>2024.09.10-13</b>	“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-тай хамтран Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх сургалт, нөлөөллийн 3 үе шатлалт ажлыг хамтран хэрэгжүүлж эхлэв
<b>2024.10.02</b>	“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн арга хэмжээний эхний үе шатын хэрэгжилтийн талаарх мэдээллээ цахим хуудастаа нийтэлж, Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааг Ази-Номхон далайн бүс нутгийн үндэсний ажиллагаануудын дунд “үлгэр жишээ” болохуйц хэмжээнд хүрч чадавхажсан болохыг олон улсад мэдээлэв
<b>2024.11.11-13</b>	Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн талаарх гурав дахь илтгэлийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо 81 дүгээр чуулганаар хэлэлцэв
<b>2024.11.20</b>	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн талаарх гурав дахь илтгэлийн ажиглалт, дүгнэлтээ хэлэлцэн баталж, Монгол Улсын Засгийн газарт ирүүлэв. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь ЭШУС үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдав.

<p><b>2025.03.07</b></p>	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай сангийн ажлын албанаас ЭШУС үндэсний ажиллагааны “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх нь” төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн тухай албан тоотыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлэв.</p>
<p><b>2025.03.31-04.04</b></p>	<p>“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”-тэй хамтран хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн арга хэмжээний хоёр дахь үе шат 2025 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд “ЭШУС үндэсний ажиллагааны цагдаагийн албадан саатуулах ажиллагаанд хяналт тавихтай холбоотой чадавхыг бэхжүүлэх, ЭШУС үндэсний ажиллагаа болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, Үндэсний оролцогч талуудтай “Меңдезийн зарчмууд”-ыг хэрэгжүүлэх Үндэсний зураглалын төслийг боловсруулах” зорилгын хүрээнд зохион байгуулагдана.</p>
<p><b>2025.05.01</b></p>	<p>“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх нь” төслийн хэрэгжилт эхэлнэ. Уг төсөл нь 2026 оны 04 дүгээр сарын 31-нийг хүртэл хэрэгжих болно.</p>

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа**<sup>50</sup>

- ЭШУС үндэсний ажиллагаа нь иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагууд, тухайлбал “Монголын ЛГБТ Төв”, “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” зэрэг ТББ-ын удирдлагуудтай 2024 оны турш зохион байгуулав.
- Эдгээр уулзалтын дүнд ХЭҮКТХ-ийн 33.1.3, 34.1.7-д заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-уудын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хамтран хэрэгжүүлэх ажлын саналуудыг тусган “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг боловсруулан баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж эхэллээ.
- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт – хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа.

50 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 4 дүгээр бүлгээс үзнэ үү.

- Уг уулзалтаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн бүрэн эрхийн хүрээнд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дүгнэлт, зөвлөмж”-ийг Иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулав.
- Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцээд, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол, УИХ-ын ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн байдалд Иргэний нийгмийн өгч буй дүгнэлт, саналыг нэгтгэн, Монгол Улсын Засгийн газарт хандан Уриалга<sup>51</sup> хүргүүлэх ажлын эхлэлийг тавилаа.
- ЭШУС үндэсний ажиллагаа болон “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ хамтран “Хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах нь” төслийг боловсруулж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүргүүллээ.

Хүснэгт 8

<b>Иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны тойм</b>	
<b>2024.04.01-2025.01.17</b>	Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагуудтай зохион байгуулав.
<b>2025.02.05-07</b>	“Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-ын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны саналуудыг үндэслэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ын төслийг хамтран боловсруулан батлав.

51 Хавсралт 1

<p><b>2025-02.13</b></p>	<p>Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт – хэлэлцүүлэг зохион байгуулав</p> <p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн бүрэн эрхийн хүрээнд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дүгнэлт, зөвлөмж"-ийг Иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулав</p> <p>Монгол Улсын Засгийн газарт иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай УРИАЛГА хүргүүлэх ажлыг Иргэний нийгмийн байгууллагууд, ЭШУС үндэсний ажиллагаа хамтран санаачилж, Уриалгын төслийг хэлэлцэн, батлав.</p>
<p><b>2025.02.28</b></p>	<p>Хамтын ажиллагааны хүрээнд ЭШУС үндэсний ажиллагаа болон “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ хамтран хэрэгжүүлэхээр боловсруулсан “Хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах нь” төслийг саналыг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүргүүлэв.</p>

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн судалгаа**

ЭШУС үндэсний ажиллагаа нь ХЭҮКтХ-ийн 33.1.3-т заасан “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийн хүрээнд 2024 онд 1 судалгаа, дүн шинжилгээний ажил, 1 сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлыг 1 судлаачдын баг, ашгийн бус 1 хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлсэн бол 2025 онд 2 судалгааны ажлыг хараат бус 2 шинжээчдийн багаар гүйцэтгүүлж байна. Тухайлбал:

**2022 онд:**

- Нээлттэй Нийгэм Форумын судлаач Б.Хишигсайхан нарын хийсэн “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгаа. ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны тайланд тусгаж УИХ-ын ХЗБХ-нд танилцуулсан.

**2023 онд:**

- “ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ”-г Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан судлаачдын багтай ХЭҮК(2024)12

дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан гүйцэтгүүлсэн. Уг судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ, хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, мөрөг байдлыг илрүүлэн, цаашид ЭШУС үндэсний ажиллагааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж гаргаж, төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

### 2024 онд:

- Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.  
Улмаар эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн. Хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах ажлыг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-тай хамтран ажиллаж тус байгууллагаас олон улсын зөвлөх ажиллуулах талаар хэлэлцэн тохиролцсон.
- Хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах хүрээнд Монгол Улсын ТАЗ-тэй төрийн албан хаагчдын нийт хэдэн албан тушаалын тодорхойлолт байдаг, тэдгээрээс хэдэн төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод “Эрх зүйч” мэргэжилтэй байх шаардлага тавигддаг талаар судалгаа хийж хамтран ажилласан бөгөөд өссөн дүнгээр нийт 27,166 албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон ба “Эрх зүй” мэргэжил нь удирдах албан тушаалын 241 албан тушаалын тодорхойлолтод, гүйцэтгэх албан тушаалын 1,050 албан тушаалын тодорхойлолтод тус тус тусгагдсан байна;
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, судалгаа хийж танилцуулсан;
- ЭШУС сэдвээр сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, НҮБ-ын хараат бус шинжээчдийн зөвлөмжийн биелэлтийг хангах, ЭШУС үндэсний

ажиллагааг бэхжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн доктор, профессор, Монгол Улсын Гавьяат хуульч П.Оюунчимэгтэй ХЭҮК/2024/21 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага боловсруулах ажлуудыг гүйцэтгүүлсэн. Уг сургалтын хөтөлбөр, гарын авлага нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудын нэг болох НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын тухай ойлголт, уг конвенцын дагуу Монгол Улсын дотоодын хууль тогтоомжуудад оруулсан хууль эрх зүйн зохицуулалтын талаар болон олон улсын түвшинд эрүү шүүлттэй тэмцэж буй туршлага, хохирогч хамгаалал, ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүрэг, бүрэн эрхийн талаар хууль сахиулах байгууллагын ажилтнуудад нэгдсэн мэдлэг, мэдээлэл өгөхөд чиглэгдсэн.

**2025 онд:**

- Монголын Криминологийн холбооны судлаачдын багтай ХЭҮК/2025/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологийн (суурь судалгаа) судалгаа хийх” ажлыг гүйцэтгүүллээ. Гэрээний дагуу “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” дэд сэдвийн хүрээнд судалгаа хийв.
- ЭШУС үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн «Эрүү шүүлт тулгах, нотлох баримт хуурамчаар үйлдэх гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох» болон «Авлига хүний эрхийн зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах» зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, улмаар хэрэгжилтийг хангахаар АТГ-ын санхүүжилтээр хамтран “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн криминологи шинж” сэдэвт судалгааны ажлыг хараат бус судлаачдыг багаар хийж гүйцэтгүүлэхээр шийдвэрлэв.

**ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД 2022, 2023, 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ**

Хүснэгт 8

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022 он	2023 он	2024 он, 2025 оны 1 дүгээр улирал
1	Хяналт шинжилгээгээр туулсан зам	10.614 км	17,810 км	10.172 км
2	Хяналт шинжилгээ хийсэн газар	23	48	57



3	Ганцаарчлан уулзаж, ярилцсан, зөвлөгөө өгсөн хүний тоо	459	675	415
4	Асуумжид оролцсон эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн тоо	1,650	2,803	1,623
5	Асуумжид оролцсон ШШГ байгууллага, хууль сахиулах байгууллагын алба хаагч нар, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын ажилтнууд, төрийн албан хаагч нар	304	850	311
6	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмж	11	25 /1-22 заалттай/	14 /1-19 заалттай/
7	Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээр зохион байгуулсан нийт сургалтын тоо	31	37	155
8	Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн хүний тоо	-	73	151
9	Сургалтад хамрагдсан хүний тоо	1662	4,858	32.640
10	ЭШУС үндэсний ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн мэдээ, мэдээлэл	53	90	321
11	Зурагт хуудас, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын танилцуулгын цуврал	17	76	77
12	Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсэн талаарх гомдол, мэдээлэл	6	66	114
<p><b>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах, хариуцлага тооцох тухай гишүүний зөвлөмж болон зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийн хүрээнд хууль сахиулах байгууллагын болон холбогдох төрийн албан хаагч нийт 10 хүнд сахилгын арга хэмжээ тооцсон байна.</b></p>				





## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ


### 2.1. ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын хэмжээнд нийт 20 байгууллагын 29 хүүхдийн асрамж, халамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 24, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 1, Орхон аймагт 1, Өвөрхангай аймагт 1 төв тус тус ажиллаж байна. Эдгээр байгууллагаас Өнөр бүл хүүхдийн төв, Хүүхдийн төв сувилал, Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор улсын төсвийн санхүүжилтээр, бусад нь олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.



#### 2024 оны байдлаар

Эх сурвалж: Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам




Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээнд 2024 оны байдлаар нийт 893 хүүхэд хамрагдаж байгаагийн 0-5 настай 92 хүүхэд (10 хувь), 6-10 настай 274 хүүхэд (30,6 хувь), 11-14 настай 246 хүүхэд (27,5 хувь), 15-18 настай 197 хүүхэд

(22 хувь), 18-аас дээш насны 84 залуучууд (9,4) байна.

### 2024 оны байдлаар


Эх сурвалж: Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам




Тэдгээр хүүхдүүдийн 234 буюу нийт хүүхдийн 26,2 хувь нь бүтэн өнчин, 309 буюу 34,6 хувь нь хагас өнчин, 15 хүүхдийн эцэг, эх байдаг эсэх нь тодорхойгүй, 335 хүүхэд буюу нийт хүүхдийн 37,5 нь хувь нь гэр бүлтэй.

### 2024 оны байдлаар

Эх сурвалж: Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



Сургуулийн өмнөх боловсролд 62 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 645 хүүхэд, насан туршийн боловсролын төвд 10 хүүхэд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 60 хүүхэд, дотоодын их, дээд сургуульд 28 хүүхэд, гадаадын их, дээд сургуульд 9 хүүхэд, залуус тус тус суралцдаг.



Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, залуучуудын 55 буюу 6,1 хувь нь хөгжлийн хоцрогдолтой, 84 буюу 9,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 19, хөнгөн хэлбэрийн 53, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 18 хүүхэд, залуус байна. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг насны ангиллаар нь авч үзвэл 0-18 насны 67, 18-аас дээш насны 17 залуус байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагддаг нийт 778 хүүхэд, 18 хүртэлх насны хагас, бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэр авдаг 56 хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэр авдаг 7 хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэнд улирал тутамд олгодог тэтгэвэр авдаг 5 хүүхэд, залуус, байнгын асаргаа шаардлагатай 18 ба түүнээс дээш насны иргэнд тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг өөрөө авч, 30 хувийг асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад өгдөг 6 иргэн байна.<sup>52</sup>

<sup>52</sup> Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Мэдээлэл хүргүүлэх тухай” 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/193 дугаартай албан бичиг

## “ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВ”-Д ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт

шинжилгээ хийх” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын “Өнөр бүл хүүхдийн төв” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, “ЭШУС үндэсний ажиллагаа”, “НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенц”, “Төрийн алба хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт хийж 2024 оны 04 дүгээр сарын 10-12, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрүүдэд тус тус ажилласан.<sup>53</sup>

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний аргачлал



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, хүүхдүүд болон багш, ажилтнуудын эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон амьдарч, сурч боловсорч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, тус төвд амьдарч буй 35 хүүхдээс асуумж авч, 18 хүүхэдтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн бол тус төвийн 30 багш, ажилтнаас асуумж авч, 16 багш, ажилтантай ганцаарчилсан ярилцлага хийсэн.

<sup>53</sup> Өнөр бүл хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх №24/04 дугаартай удирдамж



## “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн түүхэн замнал

Өнөр бүл хүүхдийн төв нь Хүүхдийн төлөө фондын даргын шийдвэрээр 1972 онд “Асрамжийн 58 дугаар тусгай цэцэрлэг” нэртэйгээр анхлан байгуулагдаж, 27 хүүхдэд өдрийн үйлчилгээ үзүүлж байсан бөгөөд мөн Хүүхдийн төлөө фондын даргын шийдвэрээр 1974 онд 24 цагаар ажилладаг асрамжийн үйлчилгээтэй цэцэрлэг болон үйл ажиллагаагаа эхлүүлж байсан улсын хүүхдийн ууган асрамж, халамжийн төв юм.



БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1979 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 333 дугаар тогтоолоор “Хүүхэд асрах байр”-ыг мөн бий болгосон бол 1991 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор “58 дугаар тусгай цэцэрлэг” болон “Хүүхэд асрах байр”-ыг нэгтгэж “Хүүхэд асран хүмүүжүүлэх төв”-ийг байгуулсан байна.

Монгол Улсын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн “Өнөр бүл төв” нэртэйгээр 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 112 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын төв”-ийг тус төвтэй нэгтгэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/130 дугаар тушаалаар “Өнөр бүл хүүхдийн төв” болгосон бөгөөд хүүхдэд асрамж, халамж, хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлэн гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээг үзүүлж байна.

## Зорилтот бүлэг

“Өнөр бүл хүүхдийн төв” нь 200 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 2-20 насны бүтэн болон хагас өнчин хүүхдүүд, эцэг, эх байх эрх нь хуулиар хязгаарлагдсан, эцэг, эх нь хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, эцэг, эх нь хорих ангид ял эдэлж байгаа, мөн эцэг, эх нь сэтгэцийн өвчтэй нь эмчийн дүгнэлтээр батлагдсан нийт 144 хүүхдэд асрамж, халамж, хөгжил, хамгаалал, гэр бүлд түшиглэсэн хувилбарт үйлчилгээг үзүүлж байна.



Төвд амьдарч буй хүүхдүүдийн 77 нь эрэгтэй, 67 нь эмэгтэй хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдийн 68 нь бүтэн өнчин, 63 нь хагас өнчин, 13 нь эцэг, эхтэй хүүхэд байгаа бол 21 нь хөгжлийн бэрхшээлтэй.

Төв нь Монгол Улсын бүх аймаг, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн хүүхдийг хүлээн авдаг бөгөөд төвд амьдарч байгаа хүүхдүүдийн

44 нь Баянзүрх дүүрэг, 24 нь Чингэлтэй, 18 нь Баянгол, 4 нь Сүхбаатар, 20 нь Сонгинохайрхан, 11 нь Хан-Уул дүүргээс, 7 нь Орхон аймгаас, Булган, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий аймгаас тус тус нэг хүүхэд, Ховд, Дорноговь, Төв, Өвөрхангай аймгаас тус тус 2 хүүхэд ирсэн бол 3 хүүхэд Дорноговь аймгаас иржээ.

### **Бүтэц, орон тоо:**



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/162 дугаар тушаалаар тус төвийн зохион байгуулалтын бүтцийг ерөнхий захирал 1, Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс 27 ажилтантай, Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний хэлтэс 64 ажилтантайгаар буюу нийт 103 ажилтантай байхаар баталсан.

### **Төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:**



Бүтэн өнчин, эцэг, эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд гэр бүлийн орчинд дүйцэхүйц ээлтэй орчинд эсэн мэнд амьдрах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, хамгаалуулах үндсэн эрхийг ханган, өсгөн хүмүүжүүлж, амьдрах ухааны чадвартай, эерэг хандлагатай, бие хүн болгон төлөвшүүлэх зорилго тавин дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилладаг. Үүнд:

1. Хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх (Хүүхдийг тав тухтай, эрүүл аюулгүй, гэр бүлд дүйцэхүйц орчинд амьдруулах, хоол унд, хувцас, хичээлийн хэрэгсэл зэрэг хүүхдийн суурь хэрэгцээг хангах, өөрөө өөртөө үйлчлэх хөдөлмөрт сургах, амьдрах ухааны дадал, чадвар эзэмшүүлэх);
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх (Нийгмийн ажлын үйлчилгээ, Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ);
3. Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих үйлчилгээ үзүүлэх (Боловсролын үйлчилгээ, хөгжлийн үйлчилгээ);
4. Хүүхдийг амьдрах арга ухаанд сургах (Амьдрах ухааны дадал олгох, амьжиргааны чадвар эзэмшүүлэх, эдийн засаг, эрүүл мэнд, гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны 12 чадварыг эзэмшүүлэх);
5. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх (Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас туршлага судлах);

6. Ажилтнуудын чадавх бэхжүүлэх (Хүүхэд, гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, эрх зүйн актууд, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн нас сэтгэхүй хөгжлийн онцлог хэрэгцээ, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд, харилцаа, ёс зүй, хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтуудыг тогтмол зохион байгуулах, уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах, ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас туршлага судлах).

Өнөр бүл хүүхдийн төв нь номын сан, компьютерын өрөө, эмчийн өрөө, сэргээн засах өрөө, шүдний кабинет болон саунтай. Шүдний кабинетад шүдний их эмч ажилладаг бөгөөд эмчилгээний төсвийг Шүд, эрүү нүүрний төвөөс хандивын журмаар шийдвэрлэдэг.

“Өнөр” дэвжээ, спорт заалыг НҮБ-ын болон бусад байгууллага, хувь хүний тусламжтайгаар тохижуулсан бөгөөд хүүхдүүдийг спортоор хичээллүүлэн олон улсын чанартай тэмцээнд оролцуулдаг. Дуу хөгжмийн танхимыг төвийн багш, ажилтнуудын дэмжлэгээр тохижуулсан. Үлээвэр хөгжмийн хамтлагтай. Мөн хүүхдийн төвийн дэргэд “Хөгжлийн ордон”-той бөгөөд тус ордонд гар урлал зэрэг чиглэлээр дугуйлан хичээллүүлдэг.

Бага насны хүүхдийн төвд багш, ажилчдын хүүхдийн цэцэрлэг ажиллуулж байна.

### **Хууль тогтоомж, ахуй нөхцөл:**

Өнөр бүл хүүхдийн төв нь ГБТХ, ХЭТХ, Хүүхэд хамгааллын тухай хууль (ХХТХ), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТТХ), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (ХБХЭТХ), Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт, төвийн захирлын баталсан Хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

Төв нь нийслэл хотод байрлалтай нийт гурван барилга, байгууламжтай бөгөөд 3-6 настай хүүхдүүд, 7 наснаас дээш насны хүүхдүүдийг тус тусын байранд байрлуулан асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн өсвөр насны тодорхой тооны хүүхдүүдийг Нийгмийн ажилтан (Ээж багш)-аар харгалзуулан орон сууцанд амьдруулж асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Зуны улиралд нийт хүүхдүүдийг тус төвийн “Хараацай” зусланд байрлуулан асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 112 дугаар тогтоолоор бүтэн болон хагас өнчин хүүхдүүдийн уг асрамж, халамжийн төвийг хараа, хяналтгүй хүүхдүүдийн “Хүүхдийн хөгжил, хамгааллын төв”-тэй нэгтгэснээр эдгээр зорилтот бүлгийн хүүхдүүд нэг төвд хамт амьдарч, асрамж, халамж, хөгжил, хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байна.

## Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрх чөлөөг зөрчсөн байж болзошгүй дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:



Бүтэн болон хагас өнчин хүүхдүүдийн асрамж, халамжийн төвийг хараа, хяналтгүй хүүхдүүдийн төвтэй нэгтгэснээр эдгээр зорилтот бүлгийн хүүхдүүд нэг төвд хамт амьдарч, сурч боловсорч, хөгжих шаардлагатай болсон нь зарим хүүхдийн холбогдох эрхүүдийг зөрчиж байна. Тухайлбал, эцэг, эхтэй хүүхдүүд бүтэн болон хагас өнчин хүүхдүүдийг зарим тохиолдолд “чи бол аавгүй, ээжгүй, надад аав, ээж байгаа, би нэг л өдөр энэ асрамжийн газраас яваад гэртээ очно, чамд бол очих газар байхгүй, чамд хэн ч байхгүй” гэх зэргээр хэл амаар доромжилдог төдийгүй тэдгээр хүүхдүүд асрамжийн төвийг “миний гэр орон биш, би энд түр зуур амьдарч байгаа” гэсэн хүнийрхүү сэтгэлээр ханддаг талаар тус төвийн багш, ажилтнууд ажлын хэсэгт танилцуулсан;



- Мөн өсвөр насандаа төвд ирсэн хүүхдүүдтэй, ялангуяа сэтгэл зүйн асуудалтай, зан төрхийн өөрчлөлттэй хүүхдүүдтэй ажиллах, мөн цалин хөлс бага байгаагаас багш нар олон дахин солигдож, хүний нөөц хомсдох эрсдэл үүссэн. Сэтгэл зүйч, хуульч, эмчийн ажлын байрыг сонирхсон мэргэжилтнүүд цалингийн хэмжээг сонсоод ажиллахаас татгалздаг. Багш нар олон дахин солигдох нь хүүхдүүдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг. Мөн Нийгмийн ажилтан (Ээж багш)-аар ажиллах хүн нь мэргэжлийн нийгмийн ажилтан, эсхүл хүүхэдтэй ажиллахуйц мэргэжилтэй байх шаардлагатай байдаг;



- Шөнийн ээлжид 40 гаруй эрэгтэй хүүхдийг хариуцан нэг багш ажилладаг бөгөөд бүх хүүхдийн аюулгүй байдлыг ханган хараа хяналт тавихад хүрэлцдэггүй. Шөнийн ээлжийн багшийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай;

- Тус төвийн байруудад уулзалтын өрөөнүүдийг тохижуулсан бөгөөд эцэг, эхчүүд хүүхдүүдтэйгээ ирж уулзах үеэр өнчин хүүхдүүд сэтгэл зүйн хувьд “дутуу, дулимгийн мэдрэмж” ихээр авдаг нь ажиглагддаг аж. Тиймээс асрамж, халамжийн үйлчилгээг зорилтот бүлгээр нь төрөлжүүлэн зохион байгуулах нь чухал байна;
- Тус төвд амьдарч буй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй зарим

хүүхдийн холбогдох эрхүүд хэрэгжихгүй байна. Тухайлбал тус төвд мэргэжлийн сэргээн засахын эмч ажилладаггүй бөгөөд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай сэргээн засахын эмчилгээ, үйлчилгээг тус төвийн сувилагч, багш, нийгмийн ажилтан (Асралт багш) нар өөрсдийн түвшинд хийж гүйцэтгэж байна. Мөн тухайн хүүхдүүд байнгын хэвтэрт байдаг, хоол хүнсээ залгиж чаддаггүй, өөртөө үйлчлэх ямар нэгэн чадваргүй тул бүлгийн багш нар болон туслах багш нар нөхцөл боломжоо шавхан тухайн хүүхдүүдийг байнга асарч байна;



- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг Баянзүрх дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын хуралдаанаар оруулан, уг хуралдаанаар тэдгээр хүүхдүүдэд байнгын асаргаа шаардлагатайг тогтоон, нийгмийн халамжийн тэтгэмжид хамрагдах эрх үүссэн боловч тодорхойгүй шалтгаанаар уг тэтгэмжид хамрагдахгүй байна;
- Төвд амьдарч буй сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах төсөвгүй тул хүүхдийн харьяалах дүүргийн Засаг даргад хандаж шийдвэрлүүлдэг;
- Төв нь 2-18 насны хүүхдийг хүлээн авч асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх эрх хэмжээтэй боловч хүлээлгэж өгөх байгууллага байхгүйгээс тус төвд одоогийн байдлаар 20 настай хоёр хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байна;
- Сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй 2-3 хүүхэд тус төвд амьдардаг бөгөөд тэдгээр хүүхдүүдийн нэг нь СЭМҮТ-ийн байнгын хяналтад байж сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагддаг. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түр завсарлуулах 7 хоногийн хугацаанд асрамж, халамжийн төвд байрлахдаа бусдад аюултай үйлдэл хийх өндөр эрсдэлтэй.



### Анхаарах тохиолдол

*...Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй аутизмын хүрээний эмгэгтэй (ухрах хэлбэрийн аутизмтай) 10 настай хүүхэд нэг гарын эрхий хурууг байнга амандаа хөхдөг, нэг гараа байнга өмд дотроо хийдэг, хамт амьдардаг хүүхдийг бэлгийн сэдэлтэйгээр оролдох, татаж чангаах тохиолдол гарсан...*

*...Мөн тус төвд амьдардаг 13 настай нэг хүүхдийн оюун ухааны түвшин хэвийн гэж мэргэжлийн эмч тодорхойлсон боловч огт суралцах чадваргүй, хэт хөдөлгөөнтэй, үргэлж бусдыг буруутгадаг, түрэмгий зэрэг байдал нь тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй бусад хүүхдүүдэд сөргөөр нөлөөлөх байдал сүүлийн үед улам ихсэж байгаа... Тухайн хүүхэд саяхан хамт амьдардаг хүүхдийн нүдийг цохисон (бэртэл, гэмтэл учраагүй)...*

(Өнөр бүл хүүхдийн төвийн удирдлагатай хийсэн ярилцлагаас)

Сүүлийн 2 жилд тус байгууллагын үйлчилгээнд хамрагдахаар ирж буй хүүхдүүдийн дийлэнх олонх нь төрх үйлийн эмгэгтэй байна. Эдгээр хүүхдүүдийн цаашдын эмчилгээ, үйлчилгээний талаар СЭМҮТ-ийн эмч нартай уулзаж ярилцахад их удаан хугацааны эмчилгээ шаардлагатай, удаан хугацаанд ажиллаж байж үр дүн гарах тул одоогоор эм өгөх нь зүйтэй гэсэн бөгөөд эдгээр хүүхдүүдэд эм өгч байна. Сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдийн биед халдах, тав тухыг алдагдуулан орилж хашхирах, өөрийгөө болон бусдыг бэртэж гэмтээх эрсдэлтэй байдаг бөгөөд эдгээр хүүхдүүдтэй ажиллах мэргэжил арга зүйн дэмжлэг, мэргэшсэн боловсон хүчин нэн шаардлагатай байна. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээнд хамрагдаж буй сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд холбогдох тусламж, эмчилгээ, үйлчилгээг зохих орчинд, мэргэжлийн түвшинд үзүүлэх бодит шаардлага бий болсон;

Нийгмийн халамжийн тухай хууль (НХТХ)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “бүтэн өнчин хүүхэд гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх (эцэг) нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ” гэж заасан. Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй 84 хүүхэд хуулийн заалтаар бүтэн өнчинд тооцогдож байгаа бөгөөд үүнээс эцэг, эх нь нас барсан 11 хүүхэд байна. Бүтэн өнчин 73 хүүхдийг нийгмийн халамжийн холбогдох тэтгэвэр, тэтгэмжүүд, тодруулбал НХТХ-ийн 12.1.3, 12.1.4, 13.1.1, 13.2.1, 13.5.2, 13.5.3, 13.5.6, 13.6-д заасан тэтгэмжүүд, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид хамруулахад Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмын 3.1.6, 3.2.3-т заасан бүрдүүлэх материалд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, эцэг, эхийн нас барсны гэрчилгээ, лавлагаа шаардагддаг бөгөөд эдгээр баримт бичгийг бүрдүүлэхэд туйлын хүндрэлтэй байдаг. Тухайлбал:

- Хүүхдийн эцэг, эх тодорхойгүй /төрсний гэрчилгээнд эцэг, эхийн хэн нэгний нэр байдаггүй/;
- Төрсний гэрчилгээнд байгаа эцэг, эх нь харилцаа холбоогүй 5-10 жил болсон байдаг. Цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлах ажиллагаа явуулсан ч олддоггүй;

- Зарим тохиолдолд нас барсан гэх боловч улсын бүртгэлээс нас барсны бүртгэл гардаггүй;
- Материал бүрдүүлэхэд хугацаа их шаардагддаг тул тэжээгчээ алдсаны тэтгэвэр нөхөн олгогдох эсэх нь тодорхойгүй;
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2-т заасан 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн нэг удаа авах мөнгөн тэтгэмж буюу онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийг мөн төвөөс гарч байгаа залуусын 50 хувь нь дээр дурдсан шалтгаанаар авч чадахгүй байсаар байна;

Эцэг, эх байх эрхийг шүүхийн шийдвэрээр хязгаарлаж, хассанаар хүүхэд тодорхой хугацаанд "бүтэн өнчин"-д тооцогдож байгаа нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд хүндээр нөлөөлдөг. Иймд НХТХ-ийн 3.1.7-д заасан бүтэн өнчин хүүхдийн тодорхойлолтод байгаа эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд хүүхдийг бүтэн өнчинд тооцох зохицуулалтыг эргэж харах шаардлагатай талаар удирдлагууд танилцуулсан;

Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэн өгөхөд хүүхдийн эд хөрөнгийн өмчлөлийн асуудлыг орхигдуулдаг бөгөөд хүүхэд асрамж, халамжийн байгууллагад амьдарч байх хооронд хашаа, байшин, гэр зэрэг гэр бүлийнх нь өмч хөрөнгийг төрөл, садан нь өөрийн хэрэгцээнд ашигладаг. Хүүхдийн эцэг, эх нас барсан тохиолдолд өмчийг төрөл, садан захиран зарцуулдаг. Харьяа орон нутгийн Засаг дарга болон Хамтарсан баг хүүхдийн өмчлөлийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргадаггүй. Хүүхдийг насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарахын өмнө цаашид амьдрах орон байр, газрын асуудлыг харьяа орон нутгийн Засаг дарга шийдвэрлэдэг байх, мөн хүүхэд насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарахад нь төрөөс урьдчилгаа, барьцаа хөрөнгөгүйгээр түрээслээд өмчлөх орон сууц, байрны асуудлыг шийдвэрлэх, оюутны байрны төлбөрийг хөнгөлөлттэй нөхцөлд хамруулах, эсхүл бүрэн чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарсан;

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS5852:2017 стандартын "Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагаас 18 насанд хүрээд гарсан тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх буюу 1 жил хүртэлх хугацаанд харилцаа холбоотой байж, дэмжин ажиллана" заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүүхдүүдийг боловсролд хамруулахад дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Эрсдэлт нөхцөлөөс ирж байгаа хүүхдүүдийн хувьд сургууль завсардсан, хичээлийн хоцрогдол ихтэй байдаг бөгөөд сурагчийн хувийн хэрэгт тухайн ангийг суралцаж төгссөнөөр тэмдэглэж бүртгэсэн байдаг. Жишээлбэл БЗД-ийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/453 тоот захирамжаар тус байгууллагад ирсэн хүүхдийн хувийн хэрэгт ЕБС-ийн 7 дугаар ангид суралцдаг, сургууль завсардаагүй гэж бичсэн ч тухайн хүүхэд үсэг мэдэхгүй, уншиж бичих чадваргүй, хичээлийн хоцрогдол ихтэй байсан. Тухайн хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулахад сурагчийн хувийн хэргийг үндэслэн хэддүгээр ангид



суралцахыг нь тогтоодог бөгөөд хувийн хэрэгт тэмдэглэснийг үндэслээд тухайн хүүхдийг сургууль завсардаагүй гэж үзээд Насан туршийн боловсролын төв хүлээн авдаггүй. Иймд хүүхдийн асрамж, халамжийн байгууллага хүүхдийн хичээлийн хоцрогдлыг арилгах чиглэлээр ажиллах шаардлага тулгардаг. Үүнд хугацаа, хөдөлмөр шаардагддаг бөгөөд хүүхэд сургалтын хөтөлбөрийг гүйцэхгүйгээс улбаалж үе тэнгийнхнээсээ ичих, сургуульдаа явах, сурах сонирхолгүй болох зэрэг хүндрэл учирч байна;

- СЭМҮТ-ийн эмгэг сэтгэц судлалын шинжилгээ, оюун ухааны түвшин тодорхойлох оношилгоогоор хэвийн гэж оношлогддог боловч төрх үйлийн эмгэгтэй, сэтгэцийн тулгамдсан асуудалтай, нийгэмших чадваргүй, суралцах чадамж сул, ойлгоц удаан, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй, анхаарал төвлөрөлт сул ЕБС-ийн программыг гүйцэхгүй, анги хамт олны хэвийн суралцах үйл ажиллагааг алдагдуулж, бусад хүүхдийн эрх ашиг зөрчигдөж байна гэх асуудал сургуулийн болон ангийн хүүхдүүд, эцэг эхчүүдийн зүгээс гомдол, санал их ирдэг.

Хүүхдүүд эмнэлэгт хэвтэж, мэс засал эмчилгээнд ороход хариуцсан багш нь 5-7 хоног сахиж хамт байх шаардлага тулгардаг, мөн багш нар хариуцсан хүүхдүүдийн эцэг, эхийн хуралд суудаг ч илүү цагийн мөнгийг тэр болгон олгодоггүй, нөхөн амарч чаддаггүй. Ажлын ачаалал их, ажлын цагийг уртасгаж ажилладаг, амралтын өдрүүдэд илүү цагаар ажилладаг;

#### Анхаарах тохиолдол

*...ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт Финлянд Улсын "Eduten", Англи Улсын "Person" платформыг тус тус ашиглан сургалт явуулж байгаатай холбоотойгоор хүүхдүүдэд ухаалаг утас, холбогдох бусад төхөөрөмж хэрэглэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага тулгарч байгаа ч асрамж, халамжийн төвөөс энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна...*

(Өнөр бүл хүүхдийн төвийн удирдлагатай хийсэн ярилцлагаас)

- Харьяалах дээд шатны байгууллагуудаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж асрамжийн төвд гэр бүлд дүйцэх орчныг бүрдүүлэх шаардлага тавьдаг боловч холбогдох санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэдэггүй. Дотоод, гадаадын байгууллагуудын хандив, тусламжаар тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэдэг;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал тус бүрээр батлуулан, биелэлтийг тайлагнадаг боловч удирдлагын зүгээс ажил тарсны дараа ажлын бус цагаар тухайн өдөр хийсэн ажлаа байгууллагын дотоод групп (цахим орчин дахь бүлгээр харилцах групп)-т заавал оруулах шаардлага тавьдаг нь дарамттай байдаг талаар төвийн багш, ажилтнууд хэлсэн;
- Хүүхэд 18 нас хүрмэгц төвөөс гарч, дараагийн шатны боловсролд хамрагдахын зэрэгцээ шууд амьдралд хөл тавьж, их хямардаг. Зарим хүүхэд сургалтын төлбөрөө өөрөө төлөх шаардлагатай болдог тул ажил хөдөлмөр эрхлэн, сургуулиа орхих, мөн зарим хүүхдэд орон байрны асуудал тулгардаг. Эдгээр нөхцөл байдлаас хамаарч хүнтэй гэрлэхгүй байх, гэмт хэрэг зөрчилд холбогдох зэрэг олон асуудал тулгардаг

нь тухайн хүүхдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Хүүхдийг асрамжийн төвөөс гарахад төрөөс тодорхой хугацааны өмнөөс бэлтгэдэг байх зохицуулалт шаардлагатай байна;

- Эцэг, эх нь шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ тодорхой хугацаанд хасуулсан хүүхдүүд тус төвд ирж амьдардаг бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон ч эцэг, эх байх эрхийг сэргээлгэх хүсэлт гаргадаггүй, асрамжийн төвөөс хүүхдээ авахгүй байх тохиолдол гардаг;
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хүлээж авах дараагийн байгууллага байхгүй байна. Тус төвд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 20 нас хүрсэн хоёр хүн амьдарч байна;
- Бага насны хүүхдийн асрамжийн төвийн хоёрдугаар давхрын 1 өрөөнд хяналтын камергүй, дээврээс нь ус гоождог бөгөөд үүнээс үүдэн цахилгааны гэмтэл үүсэх магадлалтай, номын санг баяжуулах шаардлагатай талаар ажлын хэсэгт танилцуулсан;
- Өсвөр насны тодорхой тооны хүүхдүүдийн амьдарч буй орон сууцуудын ерөнхий тохижилт муу, тагтнууд нь хаалтгүй байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд тус төвд амьдардаг 35 хүүхдээс асуумж авахад дараах хариултууд харьцангуй өндөр хувьтай байна. Үүнд:

- “Асрамжийн төвийн ажилтнууд “бусад хүүхэдтэй харьцдагаас өөрөөр ялгаварлаж харьцдаг” гэж асуумжид оролцсон нийт хүүхдийн 50 хувь, “зоддог, бусдаар зодуулдаг” гэж 35 хувь, “шалтгаангүйгээр загнадаг, доромжилдог, гүтгэдэг”, “хүсээгүй зүйлийг хэт их тулгадаг” гэж 5 хувь нь тус тус хариулсан бол “Хэн тантай дээрх байдлаар харьцсан бэ” гэсэн асуултад “багш” гэж 35 хувь, “бусад дарга, нийгмийн ажилтан, асрамжийн төвд хамт амьдардаг хүүхэд” гэж 15 хувь, “жижүүр, захирал” гэж 10 хувь нь хариулжээ.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд тус төвийн 30 багш, ажилтнаас авсан асуумжид дараах хариултууд харьцангуй өндөр хувьтай байна. Үүнд:

- “Ажил үүрэгтэй холбоотой ямар хүндрэл, бэрхшээл гардаг вэ?” гэсэн асуултад “хэт ачаалалтай, олон цагаар ажилладаг” гэж багш, ажилтнуудын 68,2 хувь, “мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвддөг” гэж 40,9 хувь, “удирдлага, хамт ажиллагсад, хүүхэд, тэдгээрийн гэр бүлээс дарамт, шахалт, хэл амаар доромжлох, заналхийлдэг” гэж 31,8 хувь, “ямар нэгэн халдлагад өртдөг, эрүүл мэндээрээ хохирдог” гэж 13,6 хувь нь тус тус хариулсан.

## ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйл болон Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэг нарт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн.<sup>54 55</sup>



## ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлт

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэгт хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг тус тус албан бичгээр ирүүлсэн<sup>56 57</sup> бөгөөд Гишүүний “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлэхэд дараах үзүүлэлттэй байна.



54 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд хүргүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/12 дугаартай зөвлөмж

55 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэгт хүргүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/11 дугаартай зөвлөмж

56 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалангийн “Хариу хүргүүлэх тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/1776 дугаартай албан бичиг

57 Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэгийн 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 05 дугаартай албан бичиг

Хүснэгт 9

№	Зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан	Огноо, дугаар	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
1	ГБХНХ-ын сайд	2024.11, 27, 08/12	8	73 %
2	Өнөр бүл хүүхдийн төвийн захирал	2024.11.27, 08/11	12	91 %
<b>Биелэлтийн ерөнхий хувь</b>				<b>82 %</b>

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. “Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажсан хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, хүүхдийн аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхийг хангаж бүтэн болон хагас өнчин хүүхдүүд, хараа хяналтгүй хүүхдүүд, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тус бүрийн онцлог байдал, сэтгэл зүй, хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэж хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хүүхэд хамгааллын тухай хууль (ХХтХ)-ийн шинэчилсэн найруулгад Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний “Асралт гэр бүл”-ийн хувилбарыг нэмж тусгасан. Гэр бүлийн орчинд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үр дүнд хүрээгүй, эсхүл уг үйлчилгээг гэр бүлийн орчинд үзүүлэх нь хүүхдийн эрхийг зөрчиж болзошгүй тохиолдолд гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ. Гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ нэн тэргүүнд хүүхдийг төрөл, садны гэр бүлд асруулах, төрөл садны гэр бүл байхгүй бол хүүхдийг асралт гэр бүлд асруулах, эхний 2 үйлчилгээнд хамруулах боломжгүй бол асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах хувилбарыг хуульчилсан;
- Оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нийт 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй асрамж халамжийн газар 2025-2027 онд шинээр барихаар төлөвлөж, хэрэгжих төсөл арга хэмжээнд 2025 онд 5,980.6 тэрбум төсөвлөсөн;

2. “Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн үйл ажиллагааны хүний нөөцийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн, хүний нөөцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж буй үндэслэл, шалтгааныг тогтоож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хүний нөөцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа үндэслэл, шалтгааныг тогтоосон бөгөөд цаашид хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа шалтгааныг илүү нарийвчлан судалж, бодлогын түвшинд сайжруулах арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр ажиллаж байна;

3. “Тус асрамж, халамжийн төвд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүүхдэд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан сэтгэцийн эмч, сэргээн засахын эмч, мэргэжилтнийг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх. Төвд амьдарч буй сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг эрүүл мэндийн холбогдох тусламж, үйлчилгээнд хамруулахад шаардлагатай төсвийг шийдвэрлэх; Төвд амьдарч буй байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартын 7.3.2-т заасны дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа авахад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн нийгмийн халамжийн холбогдох тэтгэвэр, тэтгэмжид хамруулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын төслийг шинэчлэн боловсруулахдаа хүний нөөцөд тавигдах шаардлага хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд тутамд 1 багш /нийгмийн ажилтан байна.” гэсэн заалтыг шинээр тусгасан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/162 дугаартай тушаалаар төвийн дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн батлагдсан. Тус төвийн дүрэм, бүтэц орон тоог дахин шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулсан ажиллаж байна;
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.6-д заасан тэтгэмжид хамрагдах шаардлагатай 3 хүүхдийн баримт бичгийг бүрдүүлэн харьяа дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн;

4. “Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт Финлянд Улсын “Eduten”, Англи Улсын “Person” платформыг тус тус ашиглан сургалт явуулж байгаатай холбоотой Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй хүүхдүүд, ялангуяа онцгой анхаарал, халамж, үйлчилгээ шаардлагатай бүтэн болон хагас өнчин хүүхдүүд, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, сурч боловсрох эрхийг хангахад анхаарч, суралцах боломжийг бүрдүүлж хүүхдүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, түүнчлэн тус төвд амьдарч буй хүүхдүүдийн сурах бичгийн багц худалдаж авах төсвийн асуудлыг судлан шийдвэрлэх” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хуваарь батлах тухай” 2024 оны А/134 дүгээр тушаалаар ХГБХХЕГ-т албан хэрэгцээнд зориулан хуваарилсан таблетаас хэмнэлт үүсгэж, Өнөр бүл хүүхдийн төвд амьдардаг Eduten цахим хичээл хийх суралцагчид болон МСҮТ, коллежид суралцаж байгаа оюутнуудад 30 ширхэг таблет, А3, А6 загварын 31 ширхэг ухаалаг утсыг хүлээлгэн өгсөн бөгөөд хүүхдүүд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хичээлийн хэрэгцээнд ашиглаж байна;

5. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү төсвийн асуудлыг шийдвэрлэх” зөвлөмжийн мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- ХХТХ-ийг шинэчлэн баталсантай холбоотой 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тэдгээрт нийцүүлэн 35 дүрэм, журам, стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, баталж байна. Энэ хүрээнд 2017 оноос хэрэгжсэн “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017” стандартыг шинэчлэн боловсруулж байна. Өнөр бүл хүүхдийн төвийн төсөв 2024 онд 5,198.5 төгрөг байсныг 2025 онд 5,549.5 төгрөг болгож нэмэгдүүлсэн;

6. “Хяналт шинжилгээгээр Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй хүүхдүүдийн болон төвийн багш, ажилтнуудын Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хөдөлмөрийн шударга, аятай, таатай нөхцөлөөр хангагдах хүний эрх зөрчигдөж байж болзошгүй байна. Иймд энэ асуудалд онцгой анхаарал хандуулан, тус төвд амьдарч буй хүүхдүүд болон төвийн багш, ажилтнуудын эрхийн хэрэгжилт, хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль, тогтоомжоор хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт тус бүрд холбогдох хяналт шалгалт хийн бодит байдлыг нарийвчлан тогтоож, шалгалтын үр дүн болон түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар эргэн мэдэгдэх; Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй хүүхдүүд өөр хоорондоо бие биеэ ялгаварлан гадуурхахгүй байх, төвийн багш, ажилтнуудын зүгээс төвд амьдарч буй хүүхдүүдтэй хүнлэг бус харьцаж ялгаварлан гадуурхахгүй байх болон удирдлагын зүгээс төрийн албан хаагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, ажлын байрны дарамт үзүүлэхгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтгүй орчин бүрдүүлэхийг удирдлагад үүрэгжүүлэх” зөвлөмжийн мөрөөр:

- Хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүүхдийн эрхийг хангах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ, аяныг холбогдох байгууллагуудтай хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал, 2024 онд “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд ЦЕГ, БЕГ-тай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” нөлөөллийн аян, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээ, ДЗМ ОУБ-тай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Найз байя” аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна;

7. “Төвөөс 18 насанд хүрч бие даан амьдарч аж төрөхөөр гарч буй хүүхдүүд мэргэжил эзэмших, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд эзлэх байр суурьтай иргэн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тусгайлан хэрэгжүүлэх, холбогдох албан тушаалтан, байгууллага, хуулийн этгээд, салбар хоорондын уялдаа холбоо, оролцоог хангасан тогтолцоо бий болгох бодлогын шийдвэр гаргах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхэд, залууст амьдрах ухааны боловсрол олгож, чадавхжуулах зорилгоор 2019 оноос “Бие даан амьдрах



хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/212 дугаар тушаалаар хөтөлбөрийг шинэчлэн баталсан. 14-с дээш насны 269 хүүхдэд харилцааны болон амьдрах ухааны ур чадвар эзэмшүүлэх, эрүүл дадал хэвшилд суралцаж бие даасан иргэн болон төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны сургалтуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Асрамж, халамжийн төвд үйлчилгээ авч байгаа хүүхдээс дотоодын их, дээд сургуульд 28 хүүхэд, гадаадын их дээд сургуульд 9 хүүхэд, Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежид 60 хүүхэд тус тус суралцаж байна. Их дээд сургуульд суралцаж байгаа 37 хүүхдийн сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг асрамж, халамжийн төвөөс хариуцаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд асрамжийн төвд амьдарч байгаа бүтэн өнчин хүүхдийн сургалтын зардлыг шийдвэрлүүлж байна. Өнөр бүл хүүхдийн төвөөс 2022 онд 15, 2023 онд 8, 2024 онд 10 хүүхэд нийт 33 хүүхэд 18 насанд хүрч халамжийн дараах үйлчилгээнд хамрагдсан. Эдгээр хүүхдүүдээс 14 хүүхдийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын Залуусын төвд, 6 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, 13 хүүхдийг төрөл саданд хүлээлгэн өгсөн. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын Залуусын төвд амьдарч байгаа 12 хүүхэд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа бөгөөд 2 хүүхэд коллеж төгссөн. Коллеж төгссөн 2 хүүхдийг нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажлын байранд зуучилсан. Төрөл садан болон гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 19 хүүхэд их дээд сургуульд элсэн суралцаж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар асрамжийн төвөөс гарсан 3 хүүхдийг ажилтан, албан хаагчдын дэмжлэгээр орон гэртэй болгосон байна. Асрамж халамжийн төвөөс гарч, бие даан амьдарч байгаа залуучуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хуулиар үүрэг хүлээсэн, холбогдох байгууллагатай хамтран ажиллахаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгасан;

8. "Хараацай" зусланг хэвийн ажиллах, хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд амрах нөхцөл боломжийг бүрдүүлэх" зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- "Бөхөг", "Хараацай" зусланг засварлах хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар зөвшөөрөл авах хүсэлт хүргүүлж, Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2024/00-635 тоот Архитектур төлөвлөлтийн даалгаврыг хүлээж авсан. Мөн "Ленд тест" ХХК-тай гэрээ байгуулан ХББОСЯ-ны харьяа БХТ-ийн баталгаажуулсан барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтийг хийж гүйцэтгүүлсэн. Мөн "Функцион форм арч" ХХК-тай гэрээ байгуулан хүүхдийн зуслангийн хуучин барилгыг буулгах ажлын зураг төсвийг боловсруулж, зураг төслийн ажлыг хүлээлцэх, экспертээр батлуулах шатанд ажиллаж байна. "Жаргалант хийц" ХХК-тай гэрээ байгуулан барилгын ажлын зураг төсөв, эскиз зураг гүйцэтгүүлэхээр ажиллаж байна;



- УБЦТС ТӨХК-аас зөвлөгөө авч цахилгаан шугам сүлжээний техникийн нөхцөлийг өөрчлүүлэх болон хэрэглээг нэмэгдүүлэхээр баримт бичгийн бүрдлийг боловсруулсан. Цаашид ХГБХХЕГ-аас энэ асуудалд анхаарч, холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв хийгдэх шаардлагатай төслийн жагсаалтад “Хараацай” зуслангийн зураг төсвийн ажлыг тусгуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01/473 дугаар албан бичгийн хавсралтад тусган Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт хүргүүлсэн боловч хараахан шийдвэрлэгдээгүй байна. Иймд 2025 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар, Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуулийн саналд “Хараацай” зусланг шинэчлэх зураг, төсөв боловсруулах саналыг тусган Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлнэ. Зураг төсөв батлагдан ирснээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусган, шийдвэрлүүлэх боломж бүрдэх юм;

9. Хөдөлмөрийн тухай хууль (ХтХ)-ийн 7 дугаар зүйл, Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХтХ)-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нарийвчлан тусгаж дарамт, хүчирхийлэл, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Өнөр бүл хүүхдийн төвийн Ерөнхий захирлын тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, мөрдөж байна. Дотоод журамд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх тухай зохицуулалтыг тусгасан<sup>58</sup>;

10. “Хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн талаар, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар болон өсвөр насны хүүхэдтэй ажиллах чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулан, асрамж, халамжийн төвд амьдарч буй хүүхдүүд болон төвийн удирдлага, нийт багш, ажилтнуудын дунд зохион байгуулах. Хүний эрхийн талаар сургалт, бусад арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох мэргэжилтнүүдээс мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч, хамтарч ажиллах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Байгууллагын сургалтын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, “Хүний эрх, хүүхэд хамгаалал”, “Хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дүрэм, журам стандартын хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах”, “Мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх”, “Хувь хүний хөгжил, манлайлал” гэсэн 4 чиглэлийн хүрээнд 23 багц сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна;

<sup>58</sup> Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирлын “Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/8 дугаар тушаал

11. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (ИТБАТГӨГШТХ)-иар хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлж Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй хүүхдүүд болон төвийн багш, ажилтнуудын хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, хөдөлмөрлөх эрх, бусад эрх зөрчигдсөн талаар өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангах. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгч хэвших” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хүүхдүүдийн амьдарч буй давхарт санал, хүсэлтийн хайрцаг байрлуулсан. Багш, ажилтнуудын санал, хүсэлтийн хайрцгийг төвийн нэгдүгээр давхарт байрлуулсан бөгөөд бичиг хэргийн ажилтан хайрцгийг сар тутамд нээж, санал, хүсэлтүүдийг эрэмбэлэн холбогдох ажилтанд уламжилж, асуудлыг шийдвэрлүүлсэн;
- Мэдээллийн самбар дахь хүүхдийн эрхийн чиглэлийн мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, баяжуулж хүүхэд, багш, ажилтнуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна;
- Хүүхдийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага, үзэл бодлыг хүндэтгэн үзэж, тэдний дуу хоолойг сонсох зорилгоор хүүхдийн оролцоонд тулгуурлан төвийн Хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэмжин ажиллаж хэвшсэн;

12. Хөдөлмөрийн тухай хууль (ХтХ)-ийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан болон бусад эрх нь зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзсэн багш, ажилтан, ажилтны төлөөлөгчийн гомдол болон хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх болон бусад хүний эрх нь зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзсэн төвд амьдарч буй хүүхдүүдийн гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг төвд амьдарч буй хүүхдүүд, нийт ажилтанд харагдахуйц хүртээмжтэй газарт байршуулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Багш, ажилтнуудын хөдөлмөрийн харилцаан дахь санал, гомдол, өргөдлийг Хүний нөөцийн ахлах ажилтан Р.У 70151500 утсаар болон [unurbul22@gmail.com](mailto:unurbul22@gmail.com), [Unurbul@cfga.gov.mn](mailto:Unurbul@cfga.gov.mn) цахим хаягаар хүлээн авч, бүртгэл хөтлөн, холбогдох ажилтанд уламжлахаар дотоод зохион байгуулалтыг хийсэн;

13. “ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдад болон тус төвийн удирдлагад хандан төвд амьдарч буй хүүхдүүд болон багш, ажилтнуудаас санал, хүсэлт өгч, мэдээлэл, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлж санал, хүсэлтийн хайрцаг бэлтгэн хүртээмжтэй газарт тус тус байршуулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хүүхдийн эрхийн конвенцыг төв байрны давхар бүрд, бага насны хүүхдийн байрны бүлэг бүрд байршуулсан. Мэдээлэл байршуулах самбарыг төв байрны 1, 2, 3 дугаар давхарт болон сургалтын өрөөнд тус тус байршуулсан;

14. “Төвд байгууллагын сэтгэл зүйчийн орон тоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх, эсхүл төвийн багш, ажилтнуудад сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг

тогтмол давтамжтай үзүүлэх асуудлыг шийдвэрлэх” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Тус төвийн гурван сэтгэл зүйч багш, ажилтнуудад зориулан стресс менежментийн чиглэлээр сургалт, бусад арга хэмжээг тогтмол давтамжтай зохион байгуулж байна;

15. “Төвд амьдарч байгаа хүүхдүүд ижилхэн хувцас өмсөж байгаадаа эмзэглэдэг талаар асуумжид дурдсаныг анхаарч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх” зөвлөмжийн мөрөөр:

- Жил бүрийн эхэнд хүүхдүүдээс хувцасны өнгө, загвар, размерын судалгаа авч, тендерийн баримт бичгийн техникийн шаардлагад оруулж, түүнд нийцсэн хувцсыг нийлүүлэгч компаниас захиалан авдаг бөгөөд нэг өнгө, загварын хувцаснаас дээд тал нь 3-ыг захиалдаг;

16. “Бие даан амьдрах төв”-д амьдарч буй хүүхдүүдийн амьдралын бүс дэх аюулгүй байдал, тохижилт болон бага насны хүүхдийн асрамжийн төвийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэх” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- “Бие даан амьдрах төв”-д амьдарч буй хүүхдүүдийн амьдралын бүс дэх аюулгүй байдал, тохижилтыг сайжруулж орон сууцуудын тагтанд хаалт хийсэн.

### ДОРНОД АЙМАГ ДАХЬ “ANNA HOME” ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



“Бүхнийг хүүхдийн төлөө” төрийн бус байгууллагын “Anna home” хүүхдийн асрамж, халамжийн төв нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрладаг.

“Бүхнийг хүүхдийн төлөө” төрийн бус байгууллага нь 2006 оны 09 дүгээр сард байгуулагдаж,

хүүхдүүдэд туслах зорилгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2007 онд Голланд улсын иргэн сайн дурын ажилтан Мартин Стофилстэй хамтран “Anna home” хүүхдийн асрамж, халамжийн төвийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

“Бүхнийг хүүхдийн төлөө” төрийн бус байгууллага нь улмаар хүүхдийн асрамжийн газрын зориулалтаар 288 м<sup>2</sup> талбайтай, 12мХ12м хэмжээтэй, нийт 25 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, 2 давхар барилгыг барьж 2020 онд ашиглалтад оруулан уг байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Уг асрамж, халамжийн төв нь төвийн захирал, 3 багш, туслах багш, тогооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хагас өнчин болон амьжиргааны түвшнээс доогуур нэн ядуу, орон гэргүй өрхийн 1-18 насны нийт 19 хүүхдэд хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Тус асрамж, халамжийн төвөөр үйлчлүүлж буй хүүхдүүдийн 11 нь эмэгтэй, 8 нь эрэгтэй ба 1-6 насны 6 хүүхэд, 7-18 насны 13 хүүхэд байна.

Хүүхдийн асрамж, халамжийн төвийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л зардлыг дээр дурдсан Голланд улсын иргэн сайн дурын ажилтан Мартин Стофилс санхүүжүүлдэг. Хүүхдийн хоолны нэг сарын хувьсах зардал болох 3 сая төгрөгийг орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2022 оны 09 дүгээр сараас 12 дугаар сарыг дуустал олгосон гэж тус асрамж, халамжийн байгууллагын захирал П.Болдсайхан танилцуулсан.

Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй 5 хүүхэд, 3 багш, ажилтантай ганцаарчилсан ярилцлага хийсэн.

### Хууль тогтоомж, ахуй нөхцөл:



“Anna home” хүүхдийн асрамж, халамжийн төв нь Хүүхдийн эрхийн тухай хууль (ХЭТХ), ХХТХ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/209 дүгээр тушаалаар баталсан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт болон тус

төвийн даргын баталсан “Anna home хүүхдийн асрамж, халамжийн төвийн дотоод журам”, “Anna home хүүхдийн асрамж, халамжийн төвийн ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ”, “Anna home хүүхдийн асрамж, халамжийн төвийн хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах зааварчилгаа”, “Anna home хүүхдийн асрамж, халамжийн төвд хүүхэд хүлээж авах журам”, “Anna home хүүхдийн асрамж, халамжийн төвөөс хүүхдийг гэр бүлд нь буцаах журам”, “Дотоод хяналт шалгалтын журам”, “Төвийн олон нийттэй харилцах төлөвлөгөө” зэрэг баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын бодлого танилцуулаагүй.

Тус асрамж, халамжийн байгууллага нь төвийн захирал, 3 багш, туслах багш, тогооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан тушаалтан, ажилтнууд ажлын байрны тодорхойлолтгүй байна. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 11.2, 11.5-д тус тус заасан нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрүүл ахуйчийг ажиллуулахгүй байна. Мөн орон тооны цэвэрлэгч үйлчлэгчийг ажиллуулахгүй байна. Төвийн ажилтнуудын орон тоонд захирагдан цөөхөн бүрэлдэхүүнтэй ажилладаг тухай тус төвийн удирдлага хэлж байв.

Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ, нийтлэг шаардлага MNS5852:2017 стандартын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, уг үйл ажиллагааны үр дүнд үндэслэн мөрөөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаартай албан шаардлагыг тус байгууллагад хүргүүлсэн байна.

Албан шаардлагад дурдагдсан асуудлуудаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 11.5 дахь заалт буюу “10 хүртэлх хүүхдэд мэргэжлийн нийгмийн ажилтан 1 байна” гэснийг биелүүлээгүй байна.

Тус асрамж, халамжийн төвийн байрны эрүүл ахуйн нөхцөл, чийгшил, агааржуулалтын систем, нэг хүнд ногдох талбайн хэмжээ, зохион байгуулалт, ерөөний дулаан, гэрэлтүүлэг хэвийн.

Галын аюул гарах үед ашиглах аврах гарцын зураглалыг гал гарсан үед авах арга хэмжээг тодорхойлон самбарт байршуулсан.

Номын сан, телевизор, компьютер, хичээл давтах ширээ, сандал бүхий чөлөөт цагийн өрөө болон хүүхдийн тоглоомын өрөөтэй.

Байрны гадна орчинд цэцэрлэгжүүлэлт, сүүдрэвч, сандал зэрэг тохижуулалт хангалттай биш, “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандарт”-ын 12.11, 12.12, 12.13-д заасан шаардлагыг хангахгүй байна.

Төвийн хоолны танхим нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалттай тохилог, саруулхан, цэвэрхэн байх бөгөөд асуумж, ярилцлагад оролцсон хүүхдүүд 100 хувь “асрамж, халамжийн төвийн нөхцөл сайн” гэж хариулсан.

Өглөөний цай, өдрийн 2 хоолтой бөгөөд асуумж, ярилцлагад оролцсон хүүхдүүд 100 хувь “хоолны амт, чанар сайн” гэж хариулж байв.

Төв нь эмэгтэй, эрэгтэй хүүхдүүдэд зориулсан тус бүр нэг нэг ариун цэврийн өрөө болон усанд ордог өрөөтэй.

“Anna home” хүүхдийн асрамж, халамжийн төвийн хүүхдүүд бүгд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролд хамрагддаг. Хүүхэд тус бүрд хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажилладаг. Мөн “Дезерет” олон улсын энэрлийн байгууллагатай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж, тус төвийн хүүхдүүдийн англи хэлний чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг. Мөн сонирхсон хүүхдүүдийг таеквондогоор хичээллэх, дугуйланд хамрагдахад дэмжлэг үзүүлдэг.

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



Хүүхэд хамгааллын бодлого батлан, хэрэгжүүлдэггүй.

Албан шаардлагад дурдагдсан асуудлуудаас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 11.5 дахь заалт буюу “10 хүртэлх хүүхдэд мэргэжлийн нийгмийн ажилтан 1 байна” гэснийг биелүүлээгүй байсан.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийн хүрээнд

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 7.1.2, 7.1.4, 7.1.8, 7.1.11-д заасан шаардлага хангалтгүй байна.

Төв нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 11 дүгээр багийн өрхийн эмчтэй Хамтран ажиллах гэрээ байгуулан, хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг боловч уг гэрээнд Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 7.1.2 буюу “Хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт жилд 2-оос доошгүй удаа хамруулна” гэсэн заалтыг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 7.2.10, 11.2, 11.5, 11.6 дахь шаардлагуудыг хангахгүй байна. Тодруулбал тус төвд орон тооны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрүүл ахуйч ажиллахгүй, 12 наснаас эхлэн хүүхэд тус бүрд чиглэсэн бие даан амьдрах ур чадвар олгох тусгайлсан төлөвлөгөө гаргаж ажилладаггүй.

Тус асрамж, халамжийн байгууллага нь төвийн захирал, 3 багш, туслах багш, тогооч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан тушаалтан, ажилтнууд ажлын байрны тодорхойлолтгүй байна. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 11.2, 11.5-д тус тус заасан нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрүүл ахуйчийг ажиллуулахгүй байна. Мөн орон тооны цэвэрлэгч үйлчлэгчийг ажиллуулахгүй байна.

Төвд амьдарч байгаа хүүхдүүд “асрамж, халамжийн төв”-д амьдарч буй байдалдаа эмзэглэлтэй хандаж, найз нөхөд, үе тэнгийнхнээсээ ичих, санаа зовох, улмаар өөрийгөө тусгаарлан харилцаа холбоо тогтоохоос татгалзах хандлага ажиглагддаг тухай тус төвийн захирал хэлж байв.

Тиймээс захиргааны хэм хэмжээний актад тусгагдсан холбогдох нэр томъёоноос үүдэлтэй асрамж, халамжийн төвд амьдардаг хүүхдүүдийг сургуулийн орчинд үе тэнгийн хүүхдүүд ялгаварлан гадуурхаж, нэр хоч өгдөг байж болзошгүй гэж дүгнэгдсэн.

Мөн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тус хүүхдийн асрамж, халамжийн төвийн ариун цэврийн өрөө тохижилтгүй, хүүхдүүдийн усанд ордог өрөөний хаалга цоожлогддоггүй нь тогтоогдсон. Усанд ордог өрөөний хаалга цоожлогддоггүй тул хүүхдүүд усанд орохдоо хамт амьдардаг хүүхэд, найз нөхдөөсөө тусламж гуйн усны өрөөний гадна зогсоож байгаа нь хүүхдийн аюул, айдас, түгшүүргүй амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх орчныг бүрдүүлээгүй байна. Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн бүрэн эрхийн дагуу хууль ёсны шаардлага тавьж дээр дурдсан зөрчлүүдийг арилгуулсан.



## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНААС БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАРТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасныг үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүний

эрхийн хэрэгжилт, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах “03” дугаартай удирдамж<sup>59</sup>, Гишүүний баталсан “04” дугаартай удирдамжийн<sup>60</sup> дагуу нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хүүхдийн асрамж, халамжийн бүх байгууллага буюу Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд-залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын “Хүүхдийн төв”, “Залуучуудын төв”, “Монголын СОС хүүхдийн хотхон”, “Дон Боско”, “Бадамлянхуа”, “Цөлийн сарнай”, “Мишээл” хүүхдийн төвийн 1 салбар, “Гэрэл” хүүхдийн төв, нийт 9 байгууллагад 10 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тус тус явуулж хүүхэд, залуучуудын эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоосон.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, орчин, ахуй нөхцөлтэй танилцах, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээнд хамрагдаж буй 54 хүүхэд, залуус болон 33 төрийн албан хаагчаас асуумж авч, 39 хүүхэд, залуус, 17 төрийн албан хаагчтай ганцаарчлан ярилцаж, 4 хүүхэдтэй “Дуусаагүй өгүүлбэрийн арга” сэтгэл зүйн тестээр ажилласан.

59 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүний эрхийн хэрэгжилт, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах” “03” дугаартай 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн удирдамж

60 Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх “04” дугаартай удирдамж



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОРЫН “ХҮҮХДИЙН ТӨВ”, “ЗАЛУУЧУУДЫН ТӨВ”

### Хууль тогтоомж, ахуй нөхцөл:



Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор нь 33 жилийн түүхтэй байгууллага бөгөөд гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийг түлхүү авдгаараа хүүхдийн бусад асрамж, халамжийн байгууллагаас ялгаатай. Хүүхдүүд бага наснаасаа төрөл бүрийн хүчирхийлэлд өртсөн, сэтгэл зүйн гэмтэлтэй байх нь түгээмэл бөгөөд тус байгууллагаас “100 ноцтой кейс”

гарах магадлалтай талаар тус төвийн дарга танилцуулгадаа дурдсан. Сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй зарим хүүхдийн зүгээс байнга хэл амаар доромжилж, дарамт үзүүлдэг бөгөөд эдгээр хүүхдүүдтэй уулзахдаа заавал гэрч байлгадаг, камерын хяналттай орчинд уулзаж, байнга тэмдэглэл хөтөлдөг. Төвд амьдарч буй нэг хүүхдэд СЭМҮТ-ийн сэтгэцийн эмч “нийгэмд аюултай” гэсэн тодорхойлолт өгсөн. Тус байгууллагад бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэж, шалгагдан шийдвэрлэгдэж байсан бөгөөд хүүхэд, залуусыг бүлгийн зохион байгуулалтад оруулж, бүлэг тус бүрийг багштай болгосноор ийм төрлийн гэмт хэрэг дахин үйлдэгдээгүй талаар танилцуулсан.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжууд болон Нийслэлийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/141 дүгээр захирамжаар батлагдсан Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын дүрэм, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын дотоод журам, Хүүхдийн төвийн дотоод журам, Залуучуудын төвийн дотоод журам, Хүүхэд хамгааллын бодлого, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн гэрээ, Нууц хадгалах гэрээ, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт амьдарч сурч хүмүүжиж байгаа хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нартай хийх хариуцлагын гэрээ зэргийг мөрдөж байна.

Тус байгууллагын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 48 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн бөгөөд 88.7 хувьтай биелүүлжээ.

Хүүхдийн төв нь 80 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай бөгөөд одоогоор 70 хүүхэд байрлан асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна. Тэдгээр хүүхдүүдийн 40 нь эрэгтэй, 30 нь эмэгтэй хүүхэд байна, бүтэн өнчин 16, хагас өнчин 17, эцэг, эхтэй 16, эцэг, эх нь салсан 23 хүүхэд байна. Нийт 8 хүүхдийг 2024 онд гэр бүлд нь эргэн нэгтгэж, 10 хүүхдийг холбогдох журмын дагуу шинээр хүлээн авч үйлчилгээ үзүүлж байна.

Нэг жилд 3,1 тэрбум төгрөгийн төсөвтэй бөгөөд гуравны нэг нь цэвэр үйл ажиллагааны зардалд хуваарилагддаг.



Хүүхдийн төв нь хүүхэд амьдрах өрөөг бүлгүүдэд хуваасан бөгөөд нийт 9 бүлэгтэй, нэг бүлэгт 8 хүүхэд байна. Үүнээс эрэгтэй хүүхдийн 5, эмэгтэй хүүхдүүдийн 4 бүлэг байна. Бүлэг болгон өөр өөрийн оноосон нэр, унтлагын өрөө, гал тогоотой ба тухайн бүлгийг 1 багш-нийгмийн ажилтан хариуцаж ажилладаг. Бүлэг дотор хоёр насны зөрүүтэй байдлаар нас насаар нь ангилан нэг бүлэг болгож зохион байгуулсан, өөрөөр хэлбэл бага нас (4-7 нас), дунд нас (8-10, 10-12), ахлах насны бүлэг (12-14, 14-16, 16-18 нас) гэсэн насны ангиллаар хуваадаг. Гэр бүлтэй дүйцсэн орчин бүрдүүлэх, амьдрах арга ухаанд сургах үүднээс хүүхдүүд өөрсдөө хоолоо хийдэг, 4-7 насны бага бүлгийнхний хоолыг туслах багш хийж өгдөг.

Бүлгийн багш 08:00-17:00 цагт ажилладаг, ээлжийн нийгмийн ажилтан 16:00-08:00 цагт ажиллаж хүүхдүүдтэй хамт хонодог.

Нийт 64 багш, ажилтан ажиллаж байгаагаас 43 нь эмэгтэй, 21 нь эрэгтэй, байгууллагын хэмжээнд 1 эмч, 1 эрүүл ахуйч эмч тус тус ажлын 8 цагаар ажилладаг. Ажлын бус цагаар шаардлагатай тохиолдолд тухайн эмчийг дуудах, эсхүл яаралтай тусламжийн 103 дугаарт дуудлага өгч, хүүхэд, залууст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. Хүүхдийн төвд 2, Залуучуудын төвд 1, нийт гурван сэтгэл зүйч ажилладаг.

Тус байгууллагын багш, нийгмийн ажилтнууд онцгой нөхцөлийн 30 хувийн нэмэгдэл авдаг.



Хүүхдийн төвийн сургуулийн насны хүүхдүүд “Ерөнхий боловсролын Амгалан цогцолбор” болон ерөнхий боловсролын 52 дугаар сургуульд, цэцэрлэгийн насны хүүхдүүд 32 дугаар цэцэрлэгт хамрагддаг ба 7-8 хүүхэд албан бус сургалтад хамрагддаг. Хөгжлийн хоцрогдолтой нэг хүүхэд хараахан боловсролд хамрагддаггүй бөгөөд ойрын хугацаанд 10 дугаар цэцэрлэгт хамруулахаар ажиллаж байна.

Тус байгууллагын “Залуучуудын төв” нь 40 хүнийг байрлуулах хүчин чадалтай бөгөөд одоогоор 28 залуу (13 нь эмэгтэй, 15 нь эрэгтэй) байрлан асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна. Тэдгээр залуучуудын 5 нь хөгжлийн бэрхшээлтэй. Залуучууд дотоод, гадаадын боловсролын үйлчилгээнд хамрагддаг, 5 хөгжлийн бэрхшээлтэй залуугийн 3 нь төвдөө гар урлалын сургалтад хамрагдаж байна. Нийт 18 залууг 2024 онд журмын дагуу хүлээн авсан бол 11 залуу бие даан амьдрахаар төвөөс гарсан.



НХТХ-ийн 12.1.4-т заасан тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хагас, бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэр авдаг нийт 9 хүүхэд байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.2-т заасан 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд 18 нас хүрмэгц нь 1 удаа олгох мөнгөн тэтгэмжид 3 хүүхэд хамрагдсан. НХТХ-ийн 12.1.3 Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн (16-18 нас)-ий тэтгэврийг 5 хүүхэд авч байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны 1 хүүхэд нийгмийн халамжийн сангаас сар бүр олгодог тэтгэвэрт хамрагддаг.



Тус байгууллагын түүхэнд Залуучуудын төвд номын сан байгаагүй учир шинээр бий болгож, номоор хангаж байгаа тухай танилцуулсан.

Залуучуудыг гадаадын улсад суралцаж боловсрол эзэмших гарцыг нь нээж холбогдох харилцаа холбоог нээн, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж өгснөөр Өвөр Монголын Хөх хотын Аж үйлдвэрийн Их сургуульд 1, Бугат хотын Багшийн Их сургуулийн боловсролын тэтгэлэгт хөтөлбөрт 1 оюутныг хамруулж, “City” Их сургуульд сурдаг 2 оюутны Япон улсад шилжин суралцахад шаардлагатай санхүүгийн асуудлыг “Цэцэглэх Ирээдүй” ТББ-ын тусламжтайгаар “2+2” хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэсэн байна.

Байгууллагын захирал С.Амгалан тус ажлын байранд томилогдсоноос хойш хүүхэд, залуус байгууллага дотроо сургалт, бусад үйл ажиллагаанд хамрагддаг байсныг өөрчилж хүүхэд, залуучуудыг аль болох төвөөс гадагш гарч ойролцоо байршилтай холбогдох бусад байгууллагын сургалт, хөтөлбөрт хамруулдаг болсноор тэдний нийгмийн амьдралд оролцох, нийгэмших явцад ахиц гарч, хамрагдаж байгаа сургалтын үр өгөөж ч дээшилсэн тухай танилцуулсан. Тухайлбал БЗД-ийн усан спортын сургалтын төв, Гэрэл гэгээ Отелло, Алдар спорт хороо, Жанжин клуб, сагсан бөмбөгийн төв зэрэгт хүүхэд, залуучууд хамрагдаж спорт, урлагийн чиглэлээр хичээллэдэг.

Бага насны хүүхдүүдэд зориулсан “Би мундаг байна уу” хөгжлийн хөтөлбөр, дунд насны хүүхдүүдэд зориулсан “Үндэс” хөгжлийн хөтөлбөр, ахлах насныханд зориулсан “Оролцье, хөгжье” хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд орой бүр “Үлгэрийн цаг” арга хэмжээг зохион байгуулдаг. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 98 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1,568 хүүхэд, залуусыг хамруулсан.



Дэлхийн банкны “Цэвэр агаар” төслийн хүрээнд “Залуучуудын төв”-ийн барилгын гадна фасад, цонх, хаалгыг бүрэн засварлаж дулаан алдагдалгүй болгожээ. Мөн “Хүүхдийн төв”-ийн барилгын гадна фасадыг засварлаж, цонхыг дулаалан, төвийн багш нар өөрсдөө санаачлан “Залуучуудын төв”-ийн дотоод засварын ажлыг хийж нийт 7 өрөөг тохижуулсан байна. Түүнчлэн НЗДТГ-аас тус цогцолборын арын талбайд олон улсын стандартад нийцсэн 3x3 сагсан бөмбөгийн талбайг барьж байгуулж, “Жавзандамба хутагт” сан, “Дойче Велле” ХХК-ийн санхүүжилтээр Хүүхдийн төвд “Сэтгэл зүйн зөвлөгөөний өрөө”, “Тоглоомын заслын өрөө”, “Иог бясалгал”-ын өрөөний иж бүрэн засвар хийжээ. Мөн Залуучуудын төвийн сангийн холболт, системийг бүрэн шинэчилж, эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн усанд орох өрөөг тус тусдаа байхаар засварлаж байна.

Хүүхэд, залуучуудыг өөрийгөө болоод бусдыг хайрлан энэрч, нийгмийн харилцаанд оролцохдоо сэтгэл хөдлөлөө удирдан ёс зүйтэйгээр харилцаж сургах зорилго бүхий “SEE” хөтөлбөрийг анхлан асрамж, халамжийн байгууллагад нэвтрүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйн чиглэлийн 24 цагийн сургалтад төвийн сэтгэл зүйч, багш, нийгмийн ажилтан, албан хаагчид хамрагдаж сертификат гардан, “Энэрэнгүй анги танхим бүрдүүлэх”, “Сэтгэлийн хат суулгах”, “Анхаарах, өөрчлөх, ойлгож мэдрэх чадварыг бэхжүүлэх”, “Сэтгэл хөдлөлөө жолоодох”, “Бие биеэ таньж, харилцан суралцах”, “Өөрийгөө болон бусдыг хэрхэн хайрлах”, “Хамтын оролцоо”, “Илүү сайн сайхан дэлхий ертөнцийг цогцлоох нь” гэсэн сэдвүүдийн хүрээнд хүүхдүүдтэй ажиллах, харилцах арга барилыг сургахад чиглэсэн гарын авлагаар хангагджээ.



"Холт интернэшнл" ТББ-аас тус цогцолборт 2023 оны 10 дугаар сараас эхлэн хоол тэжээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хоол амтлагчаас татгалзаж, давс сахрын хэрэглээг эрс багасгаж, цагаан хоолны өдөртэй болсон. Тогтмол дасгал хөдөлгөөн хийж өглөөний гүйлт, өглөөний дасгал хийж хэвшсэн тухай ажлын хэсэгт танилцуулсан.

Цэцэгжүүлэх аян өрнүүлж төвдөө 1000 цэцэгтэй болох зорилго тавин төрөл бүрийн цэцэг үрслүүлэн ургуулж байна.

"Од" хүүхдийн зуслангийн нэг байшинг жишиг байшин болгон засварласан, цахилгааны шугам, тулгуур шон, цахилгааны кабелиг иж бүрэн шинэчлэн, хүлэмжид хүнсний ногоо тариалж, гахайн аж ахуй эрхэлдэг.

Насанд хүрч (21 насанд) Залуучуудын төвөөс гарахын өмнө шилжин очих дүүрэг, хорооны Нийгмийн ажилтанд албан бичиг хүргүүлэн тухайн хүний эргэн нэгдэх гэр бүл, амьдрах хаягийг мэдэгдэж, хяналт, ажиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангадаг ба төвөөс гарснаас хойш 6 сарын хугацаанд Хамтарсан баг ажиглалт, хяналт тавьж ажилладаг.

Мөн төвийн зүгээс гарч байгаа залуучуудыг ажлын байранд зуучлах асуудлыг бүрэн хариуцаж, 100 хувь ажлын байраар хангадаг, байр, гэрийн түрээсээ залуучууд нь төвд амьдрах хугацаандаа эрхэлж буй ажлын цалингаасаа хуримтлал үүсгэхэд нь чиглүүлэн залж өгдөг талаар Нийгмийн ажилтнууд танилцуулсан.

### **Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**

Хүүхэд, залуучуудын эрх зөрчигдөж байж болзошгүй дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТТХ)-ийн 5.1.4-т заасан "хамтарсан баг"-т хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын төлөөлөл оролцох зайлшгүй шаардлагатай байдаг ч ГБХТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд "20.1.Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны нийгмийн ажилтан, сургуулийн, нийгмийн халамжийн болон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, баг, хорооны Засаг дарга ахална." гэж заасан тул оролцох боломж хязгаарлагдмал байна;
2. Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах шийдвэрт ямар хугацаанд асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах тодорхой хугацаа заадаггүйгээс хүүхэд гэр бүлээ мартаж үндэс суурь болж байж болзошгүй;
3. Дүүргүүдийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтсүүд нь Засаг даргын захирамжийн дагуу хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлээд орхидог, эргэх холбоотой ажилладаггүй талаар танилцуулсан;
4. Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт хамрагдвал зохих шаардлага хангасан нийт 31 хүүхэд байгаагийн 9 нь уг тэтгэвэрт хамрагддаг, 22 нь хамрагдахгүй байна;

5. "Smile" бүлгийн гал тогооны өрөөн дэх бичгийн ширээн дээр ил байрлуулсан олон залгуураас принтер, компьютер, будаа агшаагч зэргийн цахилгааны үүсвэрийг авдаг, гал тогоонд цэвэрлэгээ хийгдээгүй удсан, жижиг ялаа үүрлэсэн байдалтай, хоолны хэрэгслүүд бохир байна. Мөн том хэмжээтэй хутга, заазуурыг ямар нэгэн хамгаалалт, хязгаарлалтгүй (уяагүй) ил задгай байрлуулсан;
6. Дуусаагүй өгүүлбэрийн арга сэтгэл зүйн тестээр зарим хүүхэдтэй ажиллахад тус асрамж, халамжийн төвд хамт амьдардаг хүүхдүүд бага насны хүүхдүүдийг зоддог, цохидог, дарамталдаг болох нь илэрсэн;



7. Тус төвд хүүхдүүдийн хэрэгцээнд зориулагдсан нэг ч компьютер байдаггүй бөгөөд компьютер ашиглаж гэрийн даалгавар хийх шаардлагатай үед бүлгийн нийгмийн ажилтныг гуйж, эсхүл ангийнхаа хүүхдүүдээс мөнгө цуглуулж байгаад компьютер тоглоомын газар орж даалгавраа хийдэг тухай танилцуулсан. Хүүхдүүд компьютерын өрөөтэй болох хүсэлтээ ажлын хэсэгт илэрхийлсэн;
8. Хүүхэд асрамж, халамжийн байгууллагаас оргох, хэл сураггүй алга болох явдал цөөнгүй тохиолддог. Сураггүй алга болсноос хойш 24 цагийн дотор харьяалах цагдаагийн байгууллагад ханддаг боловч цагдаагийн байгууллага энэ тал дээр хайхрамжгүй, удаашралтай хандаж шуурхай эрэн хайх ажиллагааг хэрэгжүүлдэггүй. Иймэрхүү байдлаар оргож, зугтаж алга болсон хүүхдүүдийн 80-90 хувийг төвийн багш, албан хаагчид өөрсдөө эрж хайж олдог байна. Мөн хүүхдийн байгаа байршлыг олж тогтоон цагдаагийн байгууллагад мэдээллийг өгсөн ч алба хаагчид дорвитой арга хэмжээ авч ажилладаггүй талаар онцлон танилцуулсан;
9. Сэтгэц, зан төрхийн өөрчлөлттэй хүүхэд, залуучуудыг СЭМҮТ-ийн тусламж, үйлчилгээнд тогтмол хамруулах шаардлагатай тулгардаг бөгөөд цагийн дараалал хүлээх нь туйлын бэрхшээлтэй байдаг тухай танилцуулсан;
10. Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байгаад гарсан хүүхэд, залуус мансууруулах төрлийн бодис хэрэглэх, худалдаалах чиглэлээр сүлжээ үүсгэн, улмаар гэмт хэрэгт холбогдож байж болзошгүй талаар танилцуулсан;
11. Том үений хөдөлгөөн алдагдал, тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй, 60 хувиар хөдөлмөрийн чадвар алдсан 26 насанд хүрсэн нэг эмэгтэй, Өвчний олон улсын 10 дугаар ангиллаар "F71" буюу оюун ухааны хүндэвтэр хомсдол оноштой, 79 хувиар хөдөлмөрийн чадвар алдсан 21 настай нэг эрэгтэй тус төвд амьдарч байна. Эдгээр 2 хүн нь бие даан амьдрах чадвар муу, цаашид амьдрах газар байхгүй талаар танилцуулсан;



12. Хоол хүнсний материалыг 14 хоногт нэг удаа олгодог боловч 7 хоноод дуусдаг, ялангуяа мах 14 хоногт огт хүрэлцдэггүй, зарим тохиолдолд удаан хадгалсан, муудсан байж болзошгүй хүнсний бүтээгдэхүүн өгдөг талаар хүүхэд, залуучууд танилцуулсан. Энэ танилцуулгын мөрөөр "Smile" бүлэгт амьдардаг ЕБС-ийн дунд ангид суралцдаг 5 хүүхдэд 14 хоногт олгосон 8 кг махны нэг хүүхдэд ноогдох хэмжээг тооцож үзэхэд 1 өдөрт нэг хүүхдэд 114 грамм мах ноогдож байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар баталсан "Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-д нэг хүний хоногт хэрэглэх малын махны хэмжээг 120 грамм байхаар тогтоосон байгаатай дүйцэж байна. Хүүхдүүдийн өрөөний хөргөгчид өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн, буурцагт ургамал, жимс жимсгэнэ бараг байхгүй, ерөнхийдөө мах, төмс, лууван, сонгино, саримс, ургамлын тос, гурил, будаа, гоймон гэсэн хүнсний зүйлүүд байна;
13. Хүүхэд, залуучуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдлийн талаар ярилцахад өмнөх даргын үед хүүхдүүдийн ирээдүйдээ итгэх итгэлд чиглэсэн, бие хүн болж төлөвшихөд чиглэсэн сургалт, арга хэмжээ ихээр зохион байгуулагддаг байсан бол сүүлийн жилүүдэд энэ төрлийн арга хэмжээ зогссон, үгүйлэгдэж байгааг дурдан, ер нь л ирээдүйнхээ талаар боддоггүй, "архичин л болчихгүй юм сан" гэж боддог тухай ярьсан;
14. Хүүхдийн төвийн зарим давхарт бүлгүүдийн гал тогоо, амьдрах өрөөний цонхнууд цантсан, чийгтэй, бүгчим байдалтай, агааржуулалтын хоолойнууд ажиллагаагүй. Хойд зүгт харсан цонхтой бүлгүүдийн өрөө сэрүүхэн, ялангуяа "Цоморлог" бүлгийн цонхоор дулаан нэлээн алдагдаж байх бөгөөд өрөөнүүдэд шөнийн цагаар цахилгаан халаагч ажиллуулдаг. Охидын унтлагын өрөөний тавилга, ор, шүүгээний эдэлгээ нэлээд муудсан, хаалганы хүрээ хагарсан, эдгээр эд зүйлс нь дор хаяж 10 жил эдлэгдсэн. Нэгэн багшийн өгсөн мэдээллээр 2 дугаар давхарт сүүлийн 5 жилийн хугацаанд урсгал засвар хийгдээгүй байна;





15. Залуучуудын төвийн нэгдүгээр давхарт байрлах эрэгтэйчүүд амьдардаг 106, 108, хоёрдугаар давхрын эмэгтэйчүүд амьдардаг 205 тоот өрөөнүүдийн үүдний өрөөнд байрлах гал тогооны тавилгууд хуучирч муудсан, агааржуулалт ажилладаггүй, бүгчим байлаа. Зориулалтын хэмжигч багажаар хэмжихэд 29 хувийн чийгшилтэй, 27,5 хэмийн дулаантай байна;
16. Байгууллагын удирдлага тулгамдаж буй дараах асуудлуудыг танилцуулсан. Үүнд:
- Авьяас, чадвартай хүүхдүүдийг олон улсын болон улс, дүүргийн уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх;
  - Хүүхдийг гадагш хөгжлийн үйлчилгээнд хамруулахад тээвэрлэх бага оврын машинтай болох;
  - Боловсон хүчний нийгмийн баталгаа, тогтвортой байдал (залуу гэр бүлийг дэмжих, түрээслээд өмчлөх орон сууцны хөнгөлөлтөд хамруулах, сурч боловсрох мэргэжил дээшлүүлэхэд нь гадагшаа явуулж дэмжих гэх мэт);
  - Эрсдэл өндөртэй, хүүхдийн амь нас хариуцдаг, амралтын өдрүүдэд дуудагдаж ажилладаг, хүүхдийг эрэн хайж өдөр шөнөгүй явдаг, эцэг эхийнх нь халдлагад өртдөг, гүтгэлэг заналхийлэлд өртдөг байдал;
  - Сэтгэлзүйн хувьд маш их стресст өртдөг.
17. Байгууллагын удирдлага цаашид хийж хэрэгжүүлэх шаардлагатай, хийж хэрэгжүүлэхээр зорьж буй дараах арга хэмжээнүүдийг ажлын хэсэгт танилцуулсан. Үүнд:
- Албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан хүүхэд харах үйлчилгээг бий болгох;
  - Хүүхэд залуусын амьдрах орчин нөхцөлийг илүү сайжруулах, засвар үйлчилгээ тохижилт хийх;
  - Гадаад харилцааг идэвхжүүлэх;
  - Гадагш чиглэсэн дугуйлан секц, хөгжүүлэх үйлчилгээнд хүүхэд, залуусыг түлхүү хамруулах;
  - Урлаг, спортоор хичээллэж байгаа шилдэг хүүхдүүдийг олон улс, улс, дүүргийн чанартай уралдаан тэмцээнүүдэд идэвхтэй оролцуулах;
  - Төрийн болон ТББ-аас зохион байгуулж байгаа сайн үйлсийн аянд идэвхтэй оролцох;
  - Бага бүлгүүдийг аав, ээжийг орлох туслах багштай болгох;
  - Хяналтын камерыг нэмэгдүүлэх, сайжруулах;
  - Нийгмийн ажилтан нарын гадагш чиглэсэн холбон зуучлах ажлыг эрчимжүүлж сайжруулах.

## “МОНГОЛЫН СОС ХҮҮХДИЙН ХОТХОН” ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

### Хууль тогтоомж, ахуй нөхцөл:

“Монголын СОС хүүхдийн хотхон” нь СОС Киндердорф Олон улсын байгууллага (СОС КДИ) олон улсын байгууллагын 100 хувийн санхүүжилттэй. Улаанбаатар хотод болон Дархан-Уул аймагт тус тус нэг салбартай бөгөөд 0-18 насны нийт 139 хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.



СОС КДИ нь дэлхийн 138 оронд салбартай бөгөөд 76 жилийн турш хүүхэд хамгааллын чиглэлээр хүмүүнлэгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн, НҮБ-ын Нийгэм-эдийн засгийн зөвлөлд зөвлөх эрхтэй байгууллага юм.



Монголын СОС Хүүхдийн хотход нь Монгол Улсын Засгийн газар болон СОС Киндердорф интернэшнл байгууллагын хооронд байгуулсан гэрээгээр 1998 онд байгуулагдсан бөгөөд 2001 онд Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан Хамтран ажиллах гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж, төсөл хөтөлбөр, үйлчилгээгээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон СОС КДИ Олон улсын байгууллагын бодлого, олон улсын стандартын дагуу явуулж байна.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөхөөс гадна холбогдох олон улсын байгууллагын бодлогын баримт бичгийн жишиг загварыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох баримт бичгүүдэд нийцүүлэн дотоод үйл ажиллагаандаа мөрдөх баримт бичгүүдийг боловсруулан баталж, мөрддөг.

Монголын СОС Хүүхдийн хотход нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш төсөл хөтөлбөрөөрөө дамжуулан давхардсан тоогоор нийт 7,000 орчим хүүхэд, залуус,



800 орчим гэр бүлд хүрч ажиллан, эцэг, эхийн хайр халамжийг алдсан болон алдах эрсдэлд байгаа хүүхэд багачуудын эрхийг хамгаалсан хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулж, олон зуун хүүхдийг зөв, боловсон, эрдэм мэдлэгтэй хувь хүн болон төлөвшихөд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Байгууллагын ёс зүйн дүрэмтэй бөгөөд энэхүү ёс зүйн дүрмийг байгууллагын удирдлага, үндсэн болон гэрээт ажилтнууд, тус байгууллагад түр хугацаагаар ажиллах хэн бүхэн бүхий л үйл ажиллагаандаа энэхүү ёс зүйн дүрмийг хамгийн нэгдүгээрт баримтлах зарчимтай. Тус байгууллагад шинээр ажиллахаар ирсэн хүмүүс хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан өдөр уг ёс зүйн дүрэмтэй танилцаж, гарын үсэг зурдаг.

### **Байгууллагын бүтэц, зохион байгуулалт:**

Монголын СОС хүүхдийн хотходын нийгэмлэгийг Удирдах зөвлөл удирддаг бөгөөд Нийгэмлэгийн Ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийг тэргүүлдэг.

Монголын СОС хүүхдийн хотходын үндэсний захиргаа нь Монголын СОС хүүхдийн хотход, СОС залуус өсвөр үеийн төв, СОС Нийгмийн халамжийн төв, СОС эмнэлэг, СОС Херманн Гмайнерын сургууль, цэцэрлэг, СОС мэргэжил сургалтын төв зэрэг үндэсний хэмжээний салбар нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирддаг бөгөөд Үндэсний захиргааг үндэсний захирал тэргүүлдэг.



Монголын СОС хүүхдийн хотходын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын СОС КДИ-тэй байгуулсан Хамтран ажиллах тухай гэрээ, Хамтран ажиллах гэрээг соёрхон баталсан тухай УИХ-ын тогтоол, Нийгэмлэгийн дүрэм, НҮБ-ийн Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын

тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Авлигын эсрэг журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021 Монгол Улсын стандарт зэрэг 50 орчим дүрэм, журам, баримт бичгийг мөрддөг.

Төсөл, хөтөлбөрийн чиглэлээр СОС халамжийн амлалт, Залуусын хөгжлийн гарын авлага, Залуусын оролцоог хангах гарын авлага, Үр дүнд суурилсан менежментийн журам, СОС Үйлчилгээний бодлогын бичиг баримт, Зүй бус үйлдлийн удирдлагын журам, Зүй бус үйлдлийг шалгах журам, Хөтөлбөрийн үйлчилгээний журам, Хөтөлбөрийн үйлчилгээний гарын авлага, Хүүхэд, залуучуудын аюулгүй байдлын бодлого, Хүүхэд, залуусын аюулгүй байдлын журам, хүний нөөцийн чиглэлээр Хүний нөөцийн гарын авлага, Ажлын гүйцэтгэл ба удирдлага журам, СОС ээжийн хөгжлийн арга хэрэгсэл гарын авлага, Хүйсийн тэгш байдлын бодлого, Томилолтын журам, Бэлгийн зүй бус үйлдлийн журам, Ажилд авах аюулгүй байдлын журам, СОС ээж, эгч нарын тэтгэврийн бодлого зэрэг баримт бичгийг мөрдөж ажилладаг.

Санхүүгийн чиглэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн үйл ажиллагааны журам, Худалдан авах ажиллагааны журам, Нягтлан бодох бүртгэлийн стандарт, Дотоод хяналтын систем гарын авлага, Сайн менежмент болон Хариуцлагын чанарын стандарт, СОС Нөөцийн тухай журам, Олон улсын дансны график, Гишүүн нийгэмлэгийн жилийн төлөвлөлт, төсөв боловсруулах гарын авлага, Мөнгөн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн журам, Өрхийн төсөв гарын авлага, Үндсэн хөрөнгийн тооллогын журам, Үндсэн хөрөнгө актлах журам зэргийг мөрддөг бол хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд Хөрөнгө босголтын бодлогын баримт бичиг, Чанартай ивээн тэтгэх үйлчилгээгээр хангах гарын авлага, Ивээн тэтгэх үйлчилгээний журам, Гишүүн нийгэмлэг олон улсын ивээн тэтгэгчдэд үйлчлэх хэрэглэгчийн гарын авлага, Түүх өгүүлэх гарын авлага, Хүүхдийн мөнгөн бэлгийг олгох журам зэргийг мөрдлөг болгон ажилладаг.



Тус байгууллага 100 гаруй ажилтны орон тоотой боловч одоогоор 65 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Ажилтнууд доод тал нь 6-8 жил ажилласан, дээд тал нь 20 гаруй жил ажиллаж байгаа тухай танилцуулсан. Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд бүлгийн буюу өрхийн зохион байгуулалттай, гэр бүлд дүйцсэн орчинд амьдардаг бөгөөд бүлэг тус бүрд “Ээж” багш нар 24 цагаар хамт амьдардаг. Ээж багш нар нь долоо хоногт нэг удаа 24 цагийн амралт эдэлдэг бөгөөд энэ хугацаанд “Эгч” багш хүүхдүүдтэй хамт байдаг. “Ээж” багш нар ийнхүү тус байгууллагад байнга байрлан ажиллах тул тэднийг сонгон шалгаруулахдаа 35-45 насны, хүүхдүүд нь том болсон, ар гэртээ



татлаагүй зэрэг шалгууруудаар сонгон шалгаруулдаг. ГБХНХЯ-ны харьяа ХГБХХЕГ-аас зохион байгуулдаг сургалт, бусад арга хэмжээнд тасралтгүй оролцдог. Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд нийгмийн халамжийн холбогдох тэтгэвэр, тэтгэмжид 100 хувь хамрагддаг. Байгууллагад нэг эмч, нэг сэтгэл зүйч ажлын цагаар ажилладаг бол дуу хөгжмийн багш амралтын өдрүүдэд ирж ажилладаг.



Төвд амьдарч буй хүүхдүүдийг огт үрчлүүлдэггүй бөгөөд насанд хүрч тус төвөөс гарсан хүүхдүүд 100 хувь хөдөлмөр эрхэлж байгаа талаар танилцуулсан.

Олон улсын байгууллагаас сар бүр зөвлөхүүд ирж тус байгууллагад ажилладаг.

Улаанбаатар дахь төв нь 13 өрх, 4 жижиг гэр бүлэгтэй, Дархан-Уул аймаг дахь төв нь 7 өрх, 2 жижиг гэр бүлэгтэйгээр хүүхэд, багачуудад гэр бүлтэй дүйцэхүйц орчинд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

ЕБС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар хүүхдүүд 100 хувь боловсролд хамрагдаж байгаа ба сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт 3 хүүхэд, ЕБС-д 119 хүүхэд, МСҮТ-д 13 хүүхэд, их дээд сургуульд 4 хүүхэд тус тус боловсрол эзэмшиж байна.

Хүүхдүүдийн хөгжлийг дэмжих болон сурлагын чанар, үзүүлэлтийг сайжруулах зорилгоор сургалт, дугуйланд хамруулдаг ба 2024 оны жилийн эцсийн байдлаар хотхонд 12 төрлийн сургалт, дугуйланд давхардсан тоогоор 374 хүүхэд, хотхоноос гадуурх 6 төрлийн сургалт, дугуйланд 66 хүүхэд тус тус хамрагдаж байна.

Нийт хүүхэд, залуусын 97.8 хувь буюу цэцэрлэгийн насны 3 хүүхдээс бусад нь нэг болон түүнээс дээш сургалт, дугуйланд хамрагдаж байна.

Монголын СОС Хүүхдийн хотхондын асрамж, халамжийн үйлчилгээнд нийт 325 хүүхэд, залуус хамрагдаж, амьдралд хөл тавьсан бөгөөд 239 хүүхэд буюу 51.5 хувь нь ар гэртээ эргэн нэгтгэгдсэн байна. Эдгээр залуус бүгд мэргэжлийн боловсрол эзэмшсэн бөгөөд маркетинг, архитектор, эмч, хүнсний технологич, инженер, цахилгаанчин, нягтлан бодогч, оёдолчин, тогооч, үсчин зэрэг мэргэжил эзэмшин хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 13 залуу гадаад улсад сурч, амьдарч байна. Бие даан гарсан хүүхдүүд 100 хувь хөдөлмөр эрхлэн ажиллаж, амьдарч байна.

Тус байгууллага нь 2007 оноос эхлэн Баянзүрх дүүргийн 21, 27, 29 дүгээр хороонд гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа явуулж байна. Гэр бүлийг дэмжих үйлчилгээ нь “Шууд гэр бүлийг чадавхжуулах буюу гэр бүлээ алдах эрсдэлд байгаа

хүүхдийг гэр бүлтэйгээ байж эрүүл аюулгүй орчинд сурч боловсрохыг дэмжих”, “Олон нийтийг чадавхжуулах буюу орон нутгийн оролцогч талуудын хамт олон нийтийг чадавхжуулж, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих” гэсэн үндсэн 2 чиглэлээр явагддаг.

Өрхүүд, гэр бүлгүүдийн байрны агаарын чийгшил 41.9-42 буюу хэвийн үзүүлэлттэй байна.

### **Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг зөрчиж байж болзошгүй дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

1. Тус байгууллагын үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүдийн гаргасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг байгууллагын албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг шийдвэрлэн хаасан нөхцөл байдал тогтоогдсон.

#### **Анхаарах тохиолдол**

*2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр өрхүүдэд халаалт ирэх үед ус алдаж байгаа эсэх талаар мэдээлэл авах зорилгоор харьцангуй том болсон хүүхдүүдийг тодорхой цэгүүдэд байлгасан бөгөөд энэ үеэр хотхоны аж ахуйн эрхлэгч Б.Д нь тус хотхонд амьдардаг Н.Э-гийн гар утас руу залгахад утсаа аваагүй шалтгаанаар Н.Э-гийн толгойн ар хэсэгт хоёр удаа цохисныг Н.Э 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр өөрөө ирж байгууллагын албан хаагчдад мэдээлсэн. Тухайн үед Н.Э-тэй хоёр хүүхэд хамт байсан. Уг байгууллагад хуульч ажилладаггүй. Уг хэргийг шалгах ажлын хэсгийг тус байгууллагын захирлын тушаалаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүд дотор эрх зүйч байхгүй. Хэргийг 3 хуудас бүхий “Мэдээлэх маягт”-д бүртгэж бичсэн бөгөөд “хүүхдийн биед шарх сорви байхгүй, сэтгэл санаа тогтворгүй, уурласан байдалтай” гэж тэмдэглэсэн. Тэмдэглэлийн төгсгөлд нь “өөрөөр батлах хүртэл сэжигтнийг гэм буруугүй гэж үзнэ” гэж бичээд хаасан.*

*(Монголын СОС хүүхдийн хотхоны хөтөлдөг баримт бичиг, тэмдэглэлээс)*

Энэ мэтчилэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжтэй таван зөрчлийг илрүүлэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газраас харьяаллын дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газарт, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газарт тус тус шилжүүлсэн;

2. Хотхоны өрх, гэр бүлгүүдийн гадна орчин, тоглоомын талбайг бүрэн камержуулсан боловч хүүхдүүдийн амьдралын бүсийн хуулиар хориглогдоогүй хэсэг камерын хяналтгүй. Мөн урлагийн танхимын арын өрөө камерын хяналтгүй байна;
3. Өрхүүд, гэр бүлгүүдийн байр мөөгөнцөртэй;
4. Хоолны дээжийг тогтмол шинжлүүлдэггүй. Өрх, гэр бүлгүүдийн хоолны агуулах зориулалтын бус, бохир;
5. Тус хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад 2023 оны 09 дүгээр сараас өнөөг хүртэлх хугацаанд 16-17 удаагийн хяналт, шалгалтын баг ирж ажилласан бөгөөд зарим тохиолдолд хяналт, шалгалтыг ямар байгууллагаас, ямар зорилгоор явуулж байгааг танилцуулдаггүй. Энэхүү олон давтамжтай хяналт, шалгалтууд нь тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд болон багш, ажилтнуудад дарамт үүсгэдэг.

Тухайлбал хамгийн сүүлд гэхэд 10-аад хоногийн өмнө өөрсдийгөө танилцуулахгүйгээр 10 орчим эрэгтэй хүн тус асрамж, халамжийн байгууллагын охидын байранд нэвтрэн орж, охидын цүнхэнд нэгжлэг хийсэн тухай байгууллагын удирдлага танилцуулсан.

## **“ДОН БОСКО” ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**



“Дон Боско шинэ үе” нийгэмд үйлчлэх ТББ-ын Дон Боско хүүхдийн төв нь 2002 онд үүсгэн байгуулагдсан, нийт 25 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай бөгөөд одоогоор 8 багш, ажилтантайгаар 06-19 насны 22 эрэгтэй хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үүсгэн байгуулагдсан цагаас хойш нийт 475 хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлсэн. Гадаадын болон

дотоодын хандивлагчдын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй ба уг төвд хүүхдүүдийг сурган, ажил хөдөлмөрт зуучилсны дараа төвөөс гаргадаг. Хүүхдүүд бүлгийн зохион байгуулалттайгаар амьдардаг бөгөөд оройны 18:00 цагаас өглөөний 09:00 цаг хүртэл ээлжийн багш нар ажилладаг. Хүүхдүүд боловсролд 100 хувь хамрагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхэдтэй, тэдгээрийн 3 нь насанд хүрсэн бөгөөд нэг багшийн хамт Улаанбаатарт орон сууцанд амьдардаг, “Солонго” төвийн боловсролын хөтөлбөр, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэрт хамрагддаг.



### **Хууль тогтоомж, ахуй нөхцөл:**

Үйл ажиллагаандаа хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын нэгэн адил Гэр бүлийн тухай хууль (ГБТХ), ХЭТХ, ХХТХ, ГБХТТХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (ХБХЭТХ), Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт, холбогдох бусад дүрэм, журмууд болон Хүүхэд хамгаалах бодлого, Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Багш ажилтны ажлын үр дүнг тооцох журам, Багш ажилтны ёс зүйн дүрэм, Ариутгал цэвэрлэгээ хийх тухай журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл



ахуйн журам, Хүүхэд хамгааллын журмыг мөрдөж ажилладаг бөгөөд Хүүхэд хамгааллын журмын хавсралтаар Хүүхэд хамгааллын зөрчлийн талаар мэдээлэх хуудас, Зан байдлын тодорхойлолт гаргуулах болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэхээ шалгуулах тухай, Хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээлэх процесс, Хувийн нууцыг хадгалах, хүндэтгэх журмыг тус тус батлан хэрэгжүүлж байна.



Тус байгууллагын орчин ерөнхийдөө цэвэрхэн, цэгцтэй, дулаан, чийгшил, гэрэлтүүлэг хэвийн, хяналтын камерыг зохих бүхий л байршлуудад зөв тусгалаар байрлуулсан, агааржуулалтын систем сайн төлөвлөгдсөн, хоёрдугаар давхарт байрлах хүүхдүүдийн сургалтын өрөө эргономик ширээ, сандалтай, сургалтын хажуугийн өрөөг бялдаржуулах өрөөгөөр ашигладаг ба хүүхдүүд биеэ хөгжүүлэх 3 төхөөрөмжтэй, ариун цэврийн өрөөнүүд чийгийн үнэргүй, гарын угаалтуурууд цэвэрхэн, усанд орох 5 өрөөтэй бөгөөд уг өрөөнүүдийг хэрэглэх хүүхдүүдийн нэрийг бичиж хаалганд байрлуулсан, ариун цэврийн өрөөнүүдийн доторх орчин цэвэрхэн байна.

Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хуримтлалын талаарх мэдээллийг тухай бүр танилцуулдаг.

Хүүхдүүд төвд оройны 18:00 цагаас өмнө ирсэн байх зохицуулалттай, хэрэв байгууллагын дотоод дүрэм, журмыг зөрчвөл нэмэлт цэвэрлэгээ хийх зэргээр шийтгүүлдэг талаар танилцуулсан.

Хүүхдүүд бүгд гар утас ашигладаг бөгөөд өдөрт 2-3 цаг ашигладаг, гар утсыг оройны ээлжийн багш хураан авч, өглөө буцааж өгдөг. Хүүхдүүдийн гар утсанд Pin-go гэх хяналтын аппликейшн суулгаж хүүхэд тус бүрийн нэрээр үүсгэсэн хяналтын аккаунтаар хүүхдүүдийн байршил болон интернэт орчин дахь хэрэглээг хянаж, шаардлагатай бол хэрэглээг зайнаас хязгаарладаг. Энэхүү зайны хяналтаас гадна гар утсыг шалгаж гэрэл зураг, захидал харилцааг мөн шалгадаг талаар ажлын хэсэгт танилцуулсан.

### **Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**



Хүүхдийн эрх зөрчигдөж байж болзошгүй дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

1. Pingo аппликейшнээр дамжуулж хүүхдүүдийн интернэт орчны хэрэглээ, аюулгүй байдлыг хянаж байгаа ч хүүхдүүдийн гар утсандаа хадгалж буй зураг, захидал харилцааг шалгаж байгаа нь хүүхдийн хувийн мэдээлэл, нууцтай байх эрхэд халдаж байж болзошгүй;

### Анхаарах тохиолдол

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад багш, ажилтнууд тус байгууллагын дэргэд байх Христийн сүмийг асрамж, халамжийн байгууллагатай ямар нэгэн холбоо хамааралгүй талаар мэдээлж байсан хэдий ч тус төвд амьдардаг хүүхдүүдтэй хийсэн ярилцлагын үеэр бүх хүүхэд уг Христийн сүмд амралтын өдөр очдог бөгөөд сүмийн номлогч нар хүүхдүүдийн амьдрал ахуй, хичээл сурлагын талаар нээлттэй дэлгэрэнгүй ярилцдаг тухай мэдээллийг өгсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 15, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 10.3-т заасныг тус тус зөрчиж байж болзошгүй...

Хүүхдүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

## “БАДАМЛЯНХУА” ХҮҮХДИЙН ТӨВД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

“Бадамлянхуа” хүүхдийн төвийг Австралийн иргэн Диди Ананда Калика 1995 онд үүсгэн байгуулсан бөгөөд хараа хяналтгүй хүүхдүүд, амьжиргааны түвшин доогуур, өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хүүхдүүдийг асран халамжилдаг ашгийн төлөө бус төрийн бус байгууллага юм. Төв нь Австрали дахь олон улсын байгууллагын үндсэн санхүүжилтээр болон гадаад, дотоодын хандивлагчдын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.

### Хууль тогтоомж, ахуй нөхцөл:



Үйл ажиллагаандаа хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын нэгэн адил ГБТХ, ХЭТХ, ХХТХ, ГБХТТХ, ХБХЭТХ, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт, холбогдох бусад дүрэм, журмууд болон Хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад дүрэм, журмыг мөрддөг.

Бага насны хүүхдүүдийн байрны тоглоомын хэсгийн дулаан 18.5 хэм, өрөөний агаарын чийгшил 47.5 хувь, дунд насны хүүхдүүдийн байрны өрөөний дулаан 20.7

хэм, чийгшил 45 хувь, Залуусын байрны өрөөний дулаан 17.7 хэм, чийгшил 62 хувьтай байна.

Бага насны хүүхдийн байрны амрах өрөө хүүхдийн 6 ортой, өрөөний нийт талбайн хэмжээ 10.5 метр квадрат бөгөөд нэг хүнд ноогдох талбайн хэмжээ 1.8 метр квадрат, дунд насны хүүхдийн амрах өрөө мөн 6 ортой, нийт талбайн хэмжээ 18.4 метр квадрат бөгөөд нэг хүнд ноогдох талбайн хэмжээ 2.8 метр квадрат байна.

Залуучуудын байранд 4 ортой ба нийт талбайн хэмжээ 18.4 метр квадрат, нэг хүнд ноогдох талбайн хэмжээ 4.8 метр квадрат хэмжээтэй.

Төвийн гадна орчинд камерын хяналттай боловч хүүхдүүд амьдардаг байруудад хяналтын камергүй. Тус хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын гадна хашаа, хамгаалалт сул, харуул хамгаалалтын ажилтангүй байгаа нь ажиглагдсан.

Хүүхдүүд бүлгийн зохион байгуулалттайгаар амьдардаг бөгөөд “гэр багш” нар гурван хоногоор буюу 72 цагаар ээлжлэн хүүхдүүдтэй байнга хамт амьдардаг. Хүүхдүүдийн хоолыг ажлын өдрүүдэд тогооч бэлтгэдэг бол амралтын өдрүүдэд “гэр багш” нар бэлтгэдэг.

Хүүхдүүд боловсролд 100 хувь хамрагддаг.

Хүүхдүүдийг амьдрах ухаанд сургах, хэрэгцээт хүнсний ногоог өөрсдөө тариалах зорилгоор хүлэмжид 5-6 төрлийн хүнсний ногоо тариалдаг, мөн мэргэжлийн сайн дурын сургагч багш нарыг урьж ирүүлэн хүүхдүүдэд хоол, нарийн боов зэрэг хүнс үйлдвэрлэлийн ур чадвар олгох сургалт явуулдаг.

Мөн тэмдэглэлт болон баярын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлдэг, аялал зугаалга, зураг зуруулах, музей, кино үзэх зэргээр чөлөөт цагийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Тус байгууллагын үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүдийн талаарх мэдээллийг зөвхөн сургуулийн нийгмийн ажилтан, ангийн багшид л өгдөг бөгөөд сургуулиас зохион байгуулдаг эцэг, эхийн хурал зэрэг арга хэмжээнд бүлгийн багш, нийгмийн ажилтнууд оролцож, өөрсдийгөө асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүдийн “эгч нь” гэж танилцуулдаг. Хүүхдүүдийн асрамж, халамжийн байгууллагад амьдардаг талаарх мэдээллийг чандлан нууцалснаар ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдын зүгээс хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах хандлага урд жилүүдтэй харьцуулахад багассан талаар бүлгийн багш н.Нямсүрэн танилцуулсан. Энэ нь тус хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын бусад асрамж, халамжийн байгууллагуудаас ялгарах нэгэн онцлог гэж үзэж байна. Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу хүүхдийн цэцэрлэгүүдэд хүүхдүүдэд ялгавартай хандах хандлага ажиглагддаг гэлээ.



Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, дүүргийн Цагдаагийн хэлтсээс хүүхэдтэй харилцах арга зүй, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулж, тус байгууллагын багш, ажилтнуудыг хамруулдаг боловч хүний эрхийн чиглэлээр сургалт, мэдээлэлд хамрагддаггүй талаар танилцуулсан.

Тус хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын багш нар сард 1,200,000 төгрөгийн цалин авдаг хэдий ч асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдийг нялх байхаас нь өсгөж, өндийлгөж, байнга хамт амьдарсан учраас орхиод явж чаддаггүй, түүнчлэн ямар нэгэн дарамтгүй ажилладаг тул энэ байгууллагадаа тогтвор суурьшилтайгаар 7-10 жил ажиллаж байгаа аж.

Байгууллагын зүгээс нийгмийн халамжийн сангаас хүүхдүүдэд олгодог мөнгөн тэтгэмжийг хүүхдийн дансанд хадгалж байгаад насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарахад нь гурван хүүхдийн дунд нэг хашаа, байшин, эсхүл 1-2 өрөөтэй орон сууц худалдан авч өгдөг талаар багш нартай хийсэн ярилцлагад дурдагдсан.

### Анхаарах тохиолдол

*Насанд хүрч асрамжийн төвөөс гарсан нэг хүүхдийн хадгаламжид хуримтлуулсан мөнгө 7 сая төгрөг болсныг мэдээд ар гэрийнхэн нь эргэн нэгтгэж гэртээ авна хэмээн ойрхон давтамжтай ирж уулзаж, хүүхдийг ятгаж хадгаламж дахь мөнгийг бүгдийг нь өөрсдөдөө шилжүүлэн авсан тохиолдол гарсан талаар танилцуулсан.*

Энэ мэтээр ар гэрээс нь хүүхдийг эргэж тойрохгүй, анхаарал халамж хандуулдаггүй боловч хуримтлуулсан мөнгийг авахыг завддаг, бүрмөсөн авдаг тохиолдол гарч байгааг анхаарч холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг зөрчиж байж болзошгүй дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

1. Хүүхдүүдийн амьдардаг байруудын хаалганы хэсэгт их хэмжээний мөс тогтсон, амьдрах орчинд чийгшил ихтэй, эхүүн үнэртэй, таазны хэсэгт ус алдсан, мөөгөнцөртсөн, цонхнууд их хэмжээгээр цантсан, хүрээн дээр нь мөн мөөгөнцөр үүссэн, өрөөнүүдийн хананы шавардлага ховхорч хөндийрсөн, зарим цонх цууралттай. Ариун цэврийн өрөөнүүдийн ерөнхий байдал бохир, эмх замбараагүй бөгөөд агааржуулалт ажилладаггүй,

бохирын шугамын хурц үнэртэй, суултуурын таглаа хагарснаас хүүхдүүд гараа зүсэх болон бусад байдлаар гэмтэх эрсдэлт нөхцөл байдал үүссэн. Бага насны хүүхдүүдийн унтлагын өрөөний халаалтын систем ажилладаггүй, цонхнууд цантсан, шалан дээр дэвссэн хивснүүд ариун цэврийн шаардлагыг илтэд хангахгүй, бохир, хувцасны шүүгээнүүдийн хаалга эвдэрхий. Гал тогооны эд зүйлс, тавилгуудыг удаан хугацаанд цэвэрлээгүйгээс дагтаршсан бохирдолтой. Тус төвд амьдарч буй хүүхдүүдтэй ганцаарчлан болон бүлгээр ярилцаж, ажиглалт хийхэд ерөнхийдөө сэтгэл санаа тайван, байгаа орчиндоо нэгэнт дассан байдалтай байна;

2. Нэг өрөөнд 8 хүүхэд амьдарч байгаа нь Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартын 10.4-ийг зөрчиж байна;
3. Монгол Улсын Засгийн газрын "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2024 оны 121 дүгээр тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд өөрчлөлт оруулж төрөлжсөн асрамжийн газарт амьдарч буй хүүхэд бүрд данс нээлгэн, 14 ба түүнээс дээш насны хүүхдүүдийн хүүхдийн мөнгөний 80 хувийг банкны хадгаламжид хуримтлуулж, 20 хувийг тухайн хүүхэд өөрөө захиран зарцуулахад зориулж цахим карт бүхий дансанд хийж байгаа. Тус хүүхдийн төвд хүүхдийн мөнгөний 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах үйл ажиллагаа хэрэгжихгүй байна;
4. Хүүхдүүд амьдардаг байруудын хуулиар хориглогдоогүй хэсэгт хяналтын камергүй. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын гадна хашаа, хамгаалалт сул, харуул хамгаалалтын ажилтангүй;
5. Зарим байрны дулааны үзүүлэлт зохих шаардлага хангаагүй;
6. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн бусад асрамж, халамжийн байгууллагуудад тогтоогдсон архины хамааралтай эцэг, эхийн хүүхдүүдийг Засаг даргын захирамжаар 10-15 жил хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулаад ар гэрт нь эргэн нэгтгэхэд эцэг, эх архины хамааралтай хэвээрээ, ар гэрийн ахуй нөхцөл өмнөхөөс дордсон байдалтай байдаг асуудал, эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой асуудал зэрэг асуудал, эцэг, эх нь тогтоогдоогүй, сураггүй алга болсон Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан "бүтэн өнчин хүүхэд"-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлууд мөн хөндөгдөж байна;
7. Нэгэн бүлгийн багш тухайн асрамжийн байгууллагад 6 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд хүүхэд асрах чөлөөтэй байсан боловч багш хомсдолтойн улмаас 4 сартай нялх хүүхэдтэйгээ хамт хүүхдүүдийн өрөөнд байрлан ажиллаж, амьдарч байна. Нялх хүүхэдтэйгээ хамт байж хүүхдээ харангаа ажлаа хийх боломж олгож байгаа нь өөрт нь тус дэмтэй байдаг гэж танилцуулсан. Харин тухайн багшийн нялх хүүхдийг тухайн бүлэгт амьдарч буй хүүхдүүд ээлжлэн тэврэх, саатуулах зэргээр хүүхдийг өсгөх үүрэгт бүгд гар бие оролцож байгаа нь харагдсан. Хүүхдийг унтах цаг хугацаанд сэрээхгүйн тулд хүүхдүүд чимээгүй болж орчин бүрдүүлж дуу чимээ, хөдөлгөөн нь хориглогддог байж болзошгүй.



## “ЦӨЛИЙН САРНАЙ” ХҮҮХДИЙН ТӨВД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

### “Цөлийн сарнай” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын тухай:



Тус байгууллагыг АНУ-ын иргэн, англи хэлний багш, сайн дурын ажилтан нэгэн эмэгтэй үүсгэн байгуулсан. Монгол Улсад амьдарч байсан байрны орцны хаалгыг нь даран, хүйтэн шалан дээр унтаж буй өсвөр насны охидыг хараад тэдэнд туслан хоол унд, хувцас хунар өгч тусалдаг болсон ч энэ нь тийм ч хүртээмжтэй биш байгааг хараад хэсэг монгол залуучуудад өөрийн санааг танилцуулан хамтран ажиллаж 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Цөлийн сарнай” түр хамгаалах байрыг нээжээ.

Ийнхүү 2007 оноос хүүхдийн эсрэг хүчирхийллийн, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон охид, хараа хяналтгүй орхигдсон охид, орон гэргүй, хагас болон бүтэн өнчин охидод хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан бол 2009 оноос эхлэн асрамж, халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байна.

Бага наснаасаа хүнд амьдрал туулж, хүчирхийлэл дарамт мэдэрч өссөн охидод итгэл найдвар, гэрэлт ирээдүй бэлэглэснээр сарнай цэцэг шиг дэлгэрч ургах болно хэмээн билэгдэж “Цөлийн сарнай” нэр өгсөн байна.

Хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын нэгэн адил ГБТХ, ХЭТХ, ХХТХ, ГБХТТХ, ХБХЭТХ, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт, Хүүхэд хамгааллын бодлого, холбогдох бусад дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.



Хүүхдийг гэр бүлийн аюулгүй орчинд амьдруулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, нийгэмд бие даасан иргэдийг бэлтгэх зорилго дэвшүүлэн ажилладаг.

Удирдах зөвлөлийн тэргүүн, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх алба гэсэн бүтэцтэй бөгөөд Удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй. Гүйцэтгэх захирал, эрх зүйч, сэтгэл зүйч, хоёр нийгмийн ажилтан, хоёр туслах багштай бөгөөд жолооч, нягтлан бодогч, гадаад харилцааны ажилтан нь цагаар ажилладаг.

Тус байгууллагын үйлчилгээнд 2-18 насны нийт 22 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд тэдгээрийн 50 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 50 хувь нь архины хамааралтай эцэг, эхтэй болон хаягдсан охид байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хоёр насанд хүрсэн хүн тус төвд амьдарч байна.

Хүүхдийг аль болох бага насанд нь гэр бүлд нь эргэн нэгтгэх хэрэгтэй байдаг, учир нь хүүхэд бага насандаа ар гэр, аав, ээжээ санаж маш их бэтгэрдэг бол өсвөр насанд хүрэхээрээ эсрэгээрээ эцэг, эхийгээ үзэн ядаж эхэлдэг, ялангуяа эцэг, эх согтуу ирж хүүхэдтэйгээ уулзвал ахиж хэзээ ч эргэж очихгүй хэмээн шийдчихдэг тухай танилцуулсан. Мөн бага насны хүүхэд ээжийгээ санаж бэтгэрэхээрээ өвөрмөц үнэр ялгаруулдаг, үс нь бөөстдөг аж. Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэхээр очиход ар гэр нь маш бохир, ахуй амьдралын наад захын боловсролгүй байх нь элбэг байдаг тул асрамж, халамжийн байгууллагын ажилтнууд сэтгэл зүйн хувьд хүнд байдаг. Сүүлийн үед хүүхдээ гэр бүлдээ эргэн нэгтгэж авах хүсэлтэй хүн цөөрсөн бөгөөд эцэг, эхчүүдтэй ажиллах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх төлөвлөгөө, хамтарсан багаас үзүүлэх мэргэжлийн үйлчилгээг сайжруулах бодит хэрэгцээ, шаардлага тулгарсан талаар ажлын хэсэгт танилцуулсан.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тэр бүр гэр бүлд нь эргэн нэгтгэдэггүй байна.

Хүүхдүүдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тус төвийн сэтгэл зүйч “Энэрлийн түүчээ” ТББ-тай хамтран ажилладаг.

Тус төвд амьдарч буй хүүхдүүд хэдийд ч утсаар ярих боломж нээлттэй.

Тус төвийн байрыг өдөр нь зуухаар галлаж, шөнө нь цахилгаанаар халаадаг.

Сүүлийн үед харьяа агентлагаас сургалтад хамруулах нь эрс цөөрсөн талаар танилцуулсан.

Байгууллагын захирал Ц.Амаржаргал ажлын хэсэгт хандаж дараах асуудалд дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Үүнд:

1. Насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарч буй хүүхэд, залууст орон байрны асуудал тулгардаг. Иймд тэдгээр хүүхдүүдийг орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлдэг болох, мөн тодорхой хэмжээний хувьсах зардлыг олгох асуудал;
2. Их, дээд сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төрөөс төлөх асуудлыг шийдвэрлэх;
3. Асрамж, халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн эцэг, эхтэй ажиллах төрийн үйлчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах асуудал.



## Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



1. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар авсан асуумжид оролцсон хүүхдүүд “энэ хавьд архичид их байдаг”, “багш нар нэр хоч өгдөг”, “багш нар заримдаа биднийг дүү нарын ээж нь болгох гээд байдаг”, “интернэт орчинд 1-2 цаг ажилламаар байдаг” гэх нөхцөл байдал, санал, хүсэлтийг бичсэн;

### Анхаарах тохиолдол

...тус төвийн үйлчилгээнд хамрагддаг бэлгийн хүчирхийллийн хохирогч нэгэн охины ээж уг охины аавтай гэр бүлээ цуцлуулан, өөр хүнтэй гэр болоод дахин охин төрүүлсэн байна. Уг ээж архины хамааралтай... сүүлд төрүүлсэн охиноо дахин бэлгийн хүчирхийллийн хохирогч болгоод тус төвд өгсөн... энэ мэтээр төрүүлсэн 3 охин, 2 хүү нийт 5 хүүхдийн 4 нь бэлгийн хүчирхийлэлд өртөж, нэг охин “оролдуулсан” байна... Одоо 3 охин тус төвд, 2 хүү нь өөр нэгэн асрамж, халамжийн төвд амьдарч байгаа бөгөөд 2 хүүг төрсөн эцэг нь хүчирхийлсэн...

Эдгээр хүүхдүүдийн ээж “би улсдаа 5 хүүхэд гаргаж өгсөн, хүүхдийн мөнгийг нь би авах ёстой” хэмээн байн байн утсаар ярьдаг, хэл амаар доромжилдог...

“Цэлийн сарнай” хүүхдийн төвийн захиралтай хийсэн ярилцлагаас

## “АЛЬФА КОММЮНИТИЗ” ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

### “Альфа Коммюнитиз” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын тухай:

Тус байгууллагыг хагас, бүтэн өнчин, амьдралын боломжгүй, харах асрах хүнгүй, хүмүүжлийн доголдолтой, сургууль завсардсан, эцэг эхийн анхаарал халамжаас гадуур байгаа, эмзэг бүлгийн хүүхдүүдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 1994 онд Герман улсын иргэн үүсгэн байгуулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж эхэлснээс өнөөг хүртэлх хугацаанд нийт 134 хүүхдийг асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулжээ.

Одоогийн байдлаар тус байгууллагын “Мишээл”, “Өнөр”, “Найдвар” гэсэн гурван салбарт хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны нийт 30 хүүхэд гэр бүлтэй дүйцүүлсэн орчинд амьдран, цэцэрлэг, сургуульд хамрагдаж байна. Төвд амьдарч байгаад насанд хүрсэн залууст их, дээд сургуульд суралцан өөрсдийн сонгосон чиглэлээр мэргэжил эзэмших нөхцөл бололцоог нь ханган дэмждэг.



“Альфа Коммюнитиз” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын захирлаар Голланд улсын иргэн Т.Хелен гэх эмэгтэй ажилладаг бөгөөд Герман улсын ард түмний цуглуулсан хандивын мөнгөөр төсвөө бүрдүүлэн ажилладаг тухай танилцуулсан.

Тус хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын 3 салбарыг хариуцсан 4 нийгмийн ажилтан, 2 багш, 1 сэтгэл зүйч, 1 жолооч, 1 нягтлан бодогч, 1 үйлчлэгч, 1 захирал, 5 туслах багш нийт 15 ажилтантай. Нийгмийн ажилтан, багш нар 2-3 хоногоор ээлжлэн хүүхдүүдтэй хамт амьдардаг. Эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулан хүүхдүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулдаг.

Тус байгууллагын Баянзүрх дүүрэг дэх “Мишээл” салбар төвд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

“Мишээл” төвд 6-18 насны нийт 9 хүүхэд амьдардаг. Оюун ухааны бэрхшээлтэй, хурц ширүүн зантай нэг хүүхэд амьдардаг бөгөөд шөнө бүр босож явдаг, бусад хүүхдэд аюултай үйлдэл хийх эрсдэлтэй байдаг тул шөнийн ээлжийн багш нь тухайн хүүхэдтэй ойрхон газар унтдаг тухай танилцуулсан.

Хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын нэгэн адил ГБТХ, ХЭТХ, ХХТХ, ГБХТТХ, ХБХЭТХ болон тэдгээрт нийцүүлэн баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Хүүхэд хамгааллын бодлого батлан, хэрэгжүүлдэг.

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



1. Хүүхдүүдийн амьдрах өрөөнүүд, гал тогоо, ариун цэврийн өрөө зэрэг бүхий л орчин эрүүл ахуйн шаардлагыг илтэд хангахгүй бохир, эмх цэгцгүй байна. Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн бүрэн эрхийн дагуу хууль ёсны шаардлага тавьж тухайн цаг мөчөөс эхлэн зохих байршлуудыг камерын

хяналттай болгох ажлыг эхлүүлэх, мөн хүүхдүүдийн амьдралын орчинд их цэвэрлэгээг эхлүүлэхээ ажлын хэсэгт илэрхийлсэн бөгөөд энэхүү ажлын явцын нотлох баримтыг цахим шуудангаар ирүүлсэн;

2. Тус төвд амьдардаг 12 настай охиноос асуумж авч, ганцаарчлан ярилцахад уг охины сэтгэл зүй тогтворгүй, сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай, тэрхүү байдал нь цаашид хүндэрч болзошгүй нөхцөл байдал ажиглагдсаныг нийгмийн ажилтанд уламжилсан бөгөөд холбогдох мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг даруй хэрэгжүүлсэн талаар эргэн мэдэгдсэн;
3. Эмийн санд байгаа зарим эм, бэлдмэлийн хугацаа дууссан;
4. Хоолны дээжийг шинжлүүлдэггүй.

## **“ГЭРЭЛ” ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

### **“Гэрэл” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын тухай:**



“Монголиан Азиа Рийч” олон улсын байгууллагын “Гэрэл” хүүхдийн асрамж, халамжийн байгууллагыг Монгол Улсад сайн дураараа ажиллаж байсан АНУ-ын иргэн, христийн шашинтай Рита, Маргарет нар 0-5 насны олдмол, хаягдсан хүүхдүүдэд асрамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2003 онд үүсгэн байгуулсан. Уг байгууллага нь хүүхдийн асрамж, халамж, сэргээн засах үйлчилгээ, хүүхдийн өдөр өнжүүлэхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь архины хамааралтай гэр бүлийн хүүхдүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд, эцэг, эх байх эрхээ хасуулсан эцэг, эх, гэр бүлийн хүүхдүүд, хорих ял эдэлж буй эцэг, эхийн хүүхдүүдэд асрамж, халамжийн үйлчилгээг 20 жилийн турш үзүүлсэн. Нийт 154 хүүхдийг үйлчилгээнд хамруулснаас 59 хүүхдийг ар гэрт нь эргэн нэгтгэсэн бол бүтэн өнчин 33 хүүхдийг гадаадын гэр бүлд, 31 хүүхдийг Монгол гэр бүлд үрчлүүлсэн.

Тус байгууллагын үйлчилгээнд 9-18 насны нийт 8 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд гурван хүүхэд их, дээд сургуульд суралцаж байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй буюу аутизмтай, бүрэн хараагүй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй тус тус нэг хүүхэдтэй бөгөөд сэтгэцийн эмгэгтэй хүүхэд өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийсэн тул мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн тухай танилцуулсан.

Төвийг үүсгэн байгуулсан АНУ-ын хоёр иргэн тус төвийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг бөгөөд байгууллагын бүтцийг мөн шийдвэрлэдэг. Энэ хүрээнд тус төвд 1 захирал, нэг нийгмийн ажилтан, нэг тогооч, нэг багш, хоёр оройны ажилтантай. Шаардлагатай үед мэргэжлийн сэтгэл зүйчтэй гэрээ байгуулан ажилладаг. Мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асардаг нэг багштай.



Захирал С.Чулуунхишигт өөрийгөө болон төвийн үйл ажиллагааны талаар танилцуулсан. Энэхүү албан тушаалд 5 жил ажиллаж байгаа бөгөөд хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй одоогийн тогтолцоог 3 жилийн турш ажиглаж, тэмдэглэл бичсэн талаар танилцуулан, хүүхдийн бусад асрамжийн газрын удирдлагуудын танилцуулсны нэгэн адилаар хүүхдүүдээ асрамжийн байгууллагад өгсөн эцэг, эхчүүд хэтэрхий хариуцлагагүй байгааг хэлж, цаашид бага насны хүүхэдтэй боловч хүүхдээ түр асруулаад ажил хөдөлмөр эрхлэх, эсхүл суралцах хэрэгцээ шаардлагатай ээжүүд, гэр бүлүүдийн хүүхдийг гэрээ байгуулан асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх хүсэл сонирхол, үндэслэлийг танилцуулсан. Дэлхийн зөн, Гүүд нейборс байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж уг асуудлыг хэлэлцсэн аж.

Одоогийн ажиллаж буй тогтолцооны үр дүнг тооцож, тогтолцоо, бодлогын шинэчлэлт хийх шаардлага тулгарч байна гэж дүгнэж байгаа талаар танилцуулсан.

Тус байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд гэр бүлийн зохион байгуулалтаар амьдардаг бөгөөд 3 жилийн өмнөөс нэгэн гэр бүлийн эхнэр, нөхөртэй зөвшилцсөний үндсэн дээр хүүхдүүдийг зохиомол аав, ээжтэй амьдруулсан байна. Ингэснээр хүүхдүүдийн зан төлөв зэрэгт эрс эерэг өөрчлөлт гарсан талаар танилцуулсан. Харамсалтай нь “зохиомол аав” хүндээр өвдсөн тул 2024 оны 12 дугаар сараас тус төвд ажиллах гэрээг цуцалсан байна.


Тус байгууллага нь хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын нэгэн адил ГБтХ, ХЭтХ, ХХтХ, ГБХТтХ, ХБХЭтХ, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандарт, Хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.



## Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



1. Хүүхдүүдийн амьдрах өрөө (тус амьдрах өрөө нь унтлагын өрөөтэйгөө хамт)-нүүдэд камерын хяналттай байсныг тогтоож, хууль ёсны шаардлага тавьснаар уг камеруудыг буулган, байршлыг өөрчлөх үйл ажиллагааг тэр даруй эхлүүлсэн бөгөөд камерын байршлыг өөрчилсөн талаарх нотлох баримт (зураг)-ыг ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн;



2. Тус төвд амьдарч буй хүүхдүүдэд христийн шашны талаар мэдээлэл танилцуулга хийдэг, "сайн мэдээ" ярьж өгдөг, дагалдагч бэлтгэх сургалтад хамруулдаг, бүх хүүхэд библийн судартай бөгөөд байгууллагад аливаа хяналт шинжилгээ, шалгалт ирэхийн өмнө хүүхдүүдээс библийн судруудыг хураан авч, нуудаг, ЭШУС хяналт шинжилгээний өмнө мөн хураан авсан, түүнчлэн тус төвд амьдарч буй хүүхдүүдийг 2025 оны 01 дүгээр сард галт тэргээр Эрдэнэт хот руу 14 хоногийн хугацаатай авч яван христийн шашны арга хэмжээнд хамруулсан, тухайн арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийг дуулуулсан, бүжиглүүлсэн талаар ганцаарчилсан ярилцлагад танилцуулагдсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 15, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 10.3-т заасныг тус тус зөрчиж байж болзошгүй;
3. Тус төвд амьдарч буй хүүхдүүдэд гар утас хэрэглэхийг огт зөвшөөрдөггүй;
4. Засгийн газрын тогтоолын дагуу 14-өөс дээш насны хүүхдүүдэд хүүхдийн мөнгөний 20 хувь олгогдохгүй байна;
5. Хүүхдүүд оройны 18:00 цагаас өмнө байрандаа ирсэн байх шаардлага тавьдаг ба 20:00 цагт төвийн гадна хаалгыг түгждэг. Садан төрөл, найз нөхөдтэйгөө хааяа уулзахдаа энэ байдлаас болоод маш түгшүүртэй байдаг бөгөөд хаалга түгжихээс өмнө байр луугаа явах гэж үргэлж яардаг талаар ганцаарчилсан ярилцлагад танилцуулагдсан;

6. Асуумжийн “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, залуучуудын ямар эрхийг хамгаалах зайлшгүй хамгаалах шаардлагатай гэж та үзэж байна вэ?” асуултад багш, ажилтнууд “хүүхэд 18 наснаас өмнө асрамжийн төвөөс явах тохиолдолд насанд хүрээгүй хүүхдийг явуулж болох эрх зүйн орчны зохицуулалт”, “сургуулийн орчинд үл гадуурхагдахаас сэргийлж сургуулийн нийгмийн ажилтнууд анхаарал хандуулах” гэж хариулжээ. “Хүүхэд, залуучуудтай харьцахад Танд тулгардаг бэрхшээл?” асуултад “хорт зуршилд амархан автдаг”, “гадуур тэнэдэг, шөнө хайдаг”, “өсвөр насны хүүхдүүдтэй тулж ажиллах хэрэгцээ, шаардлага их тул хүн хүч хэрэгтэй байдаг” гэж хариулжээ.
7. Монгол Улсын Засгийн газрын “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 121 дүгээр тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд өөрчлөлт оруулж төрөлжсөн асрамжийн газарт амьдарч буй хүүхэд бүрд данс нээлгэн, 14 ба түүнээс дээш насны хүүхдүүдийн хүүхдийн мөнгөний 80 хувийг банкны хадгаламжид хуримтлуулж, 20 хувийг тухайн хүүхэд өөрөө захиран зарцуулахад зориулж цахим карт бүхий дансанд хийж байгаа. Тус хүүхдийн төвд хүүхдийн мөнгөний 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах үйл ажиллагаа хэрэгжихгүй байна;
8. Хүүхдүүд амьдардаг байруудад хяналтын камергүй. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын гадна хашаа, хамгаалалт сул, харуул хамгаалалтын ажилтангүй;
9. Зарим байрны дулааны үзүүлэлт зохих шаардлага хангаагүй;
10. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр хүүхдийн бусад асрамж, халамжийн байгууллагуудад тогтоогдсон архины хамааралтай эцэг, эхийн хүүхдүүдийг Засаг даргын захирамжаар 10-15 жил хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулаад ар гэрт нь эргэн нэгтгэхэд эцэг, эх архины хамааралтай хэвээрээ, ар гэрийн ахуй нөхцөл өмнөхөөс дордсон байдалтай байдаг. Эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой асуудал зэрэг асуудал, эцэг, эх нь тогтоогдоогүй, сураггүй алга болсон НХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “бүтэн өнчин хүүхэд”-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлууд мөн хөндөгдөж байна.

## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд хүүхдийн асрамж, халамжийн нийт 9 байгууллагад 10 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “...Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас

гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана.” заалтыг удирдлага болгон хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах зорилгоор зарим хяналт шинжилгээг Прокурорын байгууллагатай хамтран явуулсан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, баримт бичигтэй танилцах, шаардлагатай бол хуулбарлан авах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, залуучууд, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагч нараас асуумж авах, уулзалт, ярилцлага хийх болон Олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглоогүй бусад арга, аргачлалаар явуулж нийт 89 хүүхэд, залуус болон 63 төрийн албан хаагчдаас асуумж авч, 57 хүүхэд, залуус, 33 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийж, 4 хүүхэдтэй “Дуусаагүй өгүүлбэрийн арга” сэтгэл зүйн тестээр ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлууд, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, цаашид эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/11 дугаар зөвлөмжийг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэгт, 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/12 дугаар зөвлөмжийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд тус тус хүргүүлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 82.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

1. Оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3-18 насны 100 хүүхэд, 18-34 насны 200 залуусыг хүлээн авах хүчин чадалтай 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй асрамж, халамжийн газрын барилгыг Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт барьж байгуулахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны багцын хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсан. Барилгын ажлыг 2025 онд эхлүүлэх бөгөөд энэ хүрээнд шаардлагатай 5,980.6 тэрбум төгрөгийг төсөвт суулгасан.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр



төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл боломжийг сайжруулахад оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төрөлжсөн асрамж, халамжийн газрын барилгыг яаралтай барьж байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатай.

2. Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцан, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах ажлыг Прокурорын байгууллагатай хамтран хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжтэй таван зөрчлийг илрүүлэн, харьяаллын дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газар болон Баянзүрх дүүргийн Цагдаагийн газарт тус тус шилжүүлсэн.

3. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017” стандартыг шинэчлэн батлахаар төслийг боловсруулсан бөгөөд төсөлд “Хөгжлийн бэрхшээлтэй гурван хүүхэд тутамд нэг багш/нийгмийн ажилтан байна.” заалт болон холбогдох бусад заалтыг тусгасан. Өнөр бүл хүүхдийн төвийн төсөв 2024 онд 5,198.5 төгрөг байсныг 2025 онд 5,549.5 төгрөг болгож нэмэгдүүлсэн.

4. Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт Финлянд Улсын “Eduten”, Англи Улсын “Person” платформыг тус тус ашиглан сургалт явуулж байгаатай холбоотойгоор хүүхдүүдийг ухаалаг утсаар хангах хэрэгцээ, шаардлага тулгардаг бөгөөд асрамж, халамжийн байгууллагад амьдардаг хүүхдүүд ухаалаг утасгүйгээс дээр дурдсан хөтөлбөрүүдэд зарим үед хамрагдах боломжгүй болох, гэрийн даалгавраа хийж чадахгүй байх зэрэг асуудал тулгамдаж, хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх, цаашлаад үе тэнгийнхний дунд ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хуваарь батлах тухай” 2024 оны А/134 дүгээр тушаалаар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт албан хэрэгцээнд зориулан хуваарилсан таблетаас хэмнэлт үүсгэж, Өнөр бүл хүүхдийн төвд амьдардаг Eduten цахим хичээл хийх суралцагчид болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид суралцаж байгаа оюутнуудад Doogee брэндийн T20 ultra загварын 30 ширхэг таблет, 31 ширхэг гар утсыг хүлээлгэн өгсөн бөгөөд хүүхдүүд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хичээлийн хэрэгцээнд ашиглаж байна.

Хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд сурч боловсрох эрх дээр дурдсан шалтгааны улмаас зөрчигдөх, үе тэнгийнхний дунд ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлж холбогдох арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

5. Зөвлөмжийн мөрөөр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хүний нөөцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа үндэслэл, шалтгааныг тогтоосон бөгөөд цаашид хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын багш, ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа шалтгааныг илүү нарийвчлан судалж, бодлогын түвшинд сайжруулах арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.6-д заасан тэтгэмжид хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн баримт, бичгийг бүрдүүлэн харьяа дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна.

7. “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газартай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” нөлөөллийн аян, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээ, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Найз байя” аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулсан.

8. Асрамж, халамжийн байгууллагад хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын эрхийг хангах, хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах ажлыг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, салбарын нийт ажилтан, албан хаагчдын дунд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна.

9. Өнөр бүл хүүдийн төвийн дэргэдэх “Бөхөг”, “Хараацай” зусланг засварлах хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар зөвшөөрөл авах хүсэлт хүргүүлж, Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2024/00-635 тоот Архитектур төлөвлөлтийн даалгаврыг хүлээж авсан. Мөн “Ленд тест” ХХК-тай гэрээ байгуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвийн баталгаажуулсан барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтийг хийж гүйцэтгүүлсэн. “Функцион форм арч” ХХК-тай гэрээ байгуулан хүүхдийн зуслангийн хуучин барилгыг буулгах ажлын зураг төсвийг боловсруулж, зураг төслийн ажлыг хүлээлцэх, экспертээр батлуулах шатанд ажиллаж байна. “Жаргалант хийц” ХХК-тай гэрээ байгуулан барилгын ажлын зураг төсөв, эскиз зураг гүйцэтгүүлэхээр ажиллаж байна. Зуслангийн цахилгаан шугам сүлжээний техникийн нөхцөлийг өөрчлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэхээр баримт бичгийн бүрдлийг боловсруулсан бөгөөд 2025 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн саналд “Хараацай” зусланг шинэчлэх зураг, төсөв боловсруулах саналыг тусган Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж буйг мэдэгдсэн.

10. Хөдөлмөрийн дотоод журамд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээг Өнөр бүл хүүхдийн төвийн хөдөлмөрийн дотоод журамд нарийвчлан тусгаж батлан, мөрдөж байна.

11. Өнөр бүл хүүдийн төвийн “Бие даан амьдрах төв”-д амьдарч буй хүүхдүүдийн амьдралын бүс дэх аюулгүй байдал, тохижилтыг сайжруулж орон сууцнуудын тагтанд хаалт хийсэн.

Хүүхдийн эрхийн чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал болон Олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоо, үйлчилгээг шинэчлэн сайжруулах ажлыг эрчимжүүлснээр ахиц дэвшил гарч байгаа ч хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээний чанар, нөхцөл байдал өөр хоорондоо харилцан адилгүй байгаад цаашид анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал, хүүхдийн асрамж, халамжийн зарим байгууллагад хүүхдийн амьдрах өрөө, гал тогоо, ариун цэврийн өрөө зэрэг бүхий л орчин стандартын шаардлагыг илтэд хангахгүй бохир, эмх цэгцгүй, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдалт харилцан адилгүй, мөн Монгол Улсын Засгийн газрын “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 121 дүгээр тогтоолын хэрэгжилт зарим төвд хангалтгүй, зарим байгууллагын гадна болон дотоод орчин, тоглоомын талбай огт камерын хяналтгүй байгаа бол зарим байгууллагад хүүхдийн унтлагын өрөөнд камерын хяналттай, хүүхдүүдэд гар утас хэрэглэхийг огт зөвшөөрдөггүй, зарим байгууллага хоолны дээжийг шинжлүүлдэггүй зэргийг дурдаж болно.

Мөн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтөд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын барилга, байгууламж, орчинд тавих шаардлагад дулаан, чийгшил, гэрэлтүүлгийн стандартыг тусгаж өгөх шаардлагатай.

Хүүхдийн асрамж, халамжийн зарим байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд христийн шашны талаар мэдээлэл танилцуулга хийдэг, дагалдагч бэлтгэх сургалтад хүчээр хамруулдаг байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон. Түүнчлэн зарим төвд “Pingo” гэх аппликейшнийг ашиглаж хүүхдүүдийн интернэт орчны хэрэглээ, аюулгүй байдлыг хянаж байгаа ч хүүхдүүдийн гар утсандаа хадгалж буй зураг, захидал харилцааг шалгаж байгаа нь хүүхдийн хувийн мэдээлэл, нууцтай байх эрхэд халдаж байж болзошгүй байна.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдээс гаргасан хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалттай холбоотой хүний эрхийн зөрчлийн гомдол, мэдээллийн бүртгэлийг байгууллага бүр хөтөлдөггүй, хүний эрхийн зөрчлийн гомдол, мэдээллийг тухай бүр зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулдаггүй.

Бүтэн өнчин хүүхдүүдийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.3, 12.1.4, 13.1.1, 13.2.1, 13.5.2, 13.5.3, 13.5.6, 13.6-д заасан тэтгэмжүүд, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид хамруулахад Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ын 3.1.6, 3.2.3-т заасан бүрдүүлэх материалд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, эцэг, эхийн нас барсны гэрчилгээ, лавлагаа шаардагддаг бөгөөд эдгээр баримт бичгийг бүрдүүлэхэд туйлын хүндрэлтэй байдгаас Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2-т заасан 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн нэг удаа авах мөнгөн тэтгэмж буюу онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжид хүүхэд, залуус хамрагдаж чадахгүй байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “бүтэн өнчин хүүхэд”-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой

зохицуулалтыг боловсронгуй болгон тусгасан, мөн эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яаралтай батлах шаардлагатай.

Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэн өгөхөд хүүхдийн эд хөрөнгө өмчлөлийн асуудал орхигддог бөгөөд хүүхэд асрамж, халамжийн байгууллагад амьдарч байх хугацаанд хашаа, байшин, гэр зэрэг гэр бүлийнх нь өмч хөрөнгийг төрөл, садан нь өөрийн хэрэгцээнд ашигладаг. Хүүхдийн эцэг, эх нас барсан тохиолдолд өмчийг мөн л төрөл, садан захиран зарцуулдаг. Харьяа орон нутгийн Засаг дарга болон Хамтарсан баг хүүхдийн өмчлөлийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргадаггүй. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан "бүтэн өнчин хүүхэд"-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, мөн эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Эрсдэлт нөхцөлөөс хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад ирж байгаа хүүхдүүдийн хувийн хэрэгт тухайн хүүхдийн боловсролд хамрагдалтын талаар үнэн зөв, бодитой мэдээллийг тэмдэглэдэггүйгээс үүдэн хүүхдийг үргэлжлүүлэн боловсролд хамруулахад бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, хувийн хэрэгт тэмдэглэгдсэн тухайн хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан, сургууль завсардаагүй гэх мэдээлэлд үндэслэн Насан туршийн боловсролын төв хүүхдийг хүлээж авдаггүй бөгөөд ерөнхий боловсролын сургуульд анги дэвшүүлэн суралцуулахаар шийдвэрлэдэг боловч хүүхэд сургалтын хөтөлбөрийг гүйцэхгүйгээс улбаалж үе тэнгийнхнээсээ ичих, сургуульд явах, сурах сонирхолгүй болох зэрэг хүндрэл учирдаг байна. Иймд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын зүгээс тухайн хүүхдийн хичээлийн хоцрогдлыг арилгах чиглэлээр ажиллах шаардлага тулгардаг бөгөөд үүнд ихээхэн хугацаа, хүч хөдөлмөр шаардагдаж байна.

Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэхээр очиход ар гэрийн орчин, нөхцөл эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангахгүй, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлтэй, хүүхдэд ээлгүй байх нь элбэг тохиолдож байна. Сүүлийн үед хүүхдээ гэр бүлдээ эргэн нэгтгэж авах хүсэлтэй хүн цөөрсөн бөгөөд эцэг, эхчүүдтэй ажиллах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх төлөвлөгөө, хамтарсан багаас үзүүлэх мэргэжлийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай.

Түүнчлэн насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарч буй хүүхэд, залууст нийтлэгээр тулгардаг орон байрны асуудалд анхаарч тэдгээр хүүхдүүдийг орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагддаг, их, дээд сургуульд суралцаж байгаа болон мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс төлөх эсэх асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага тулгамджээ.

Хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн үйл ажиллагааны бодлого, тогтолцоо нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (18 дугаар зүйл)-д нийцэж байгаа эсэхэд болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг гэр бүлээс нь тусгаарлан байрлуулж асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээний уламжлалт арга, өнөөгийн тогтолцооны үр дүн, хөгжил дэвшилд дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

## САНАЛ

Хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн үйл ажиллагааны бодлого, тогтолцоо нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (18 дугаар зүйл)-д нийцэж байгаа эсэхэд болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг гэр бүлээс нь тусгаарлан байрлуулж асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээний уламжлалт арга, өнөөгийн тогтолцооны үр дүн, хөгжил дэвшилд дүн шинжилгээ хийх, бүрэлдэхүүн хэсгүүдэд тулгамдаж буй асуудал болон үйлчилгээний үр нөлөөг тодорхойлох;

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл боломжийг сайжруулахад оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төрөлжсөн асрамж, халамжийн газрын барилгыг яаралтай барьж байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэх;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан "бүтэн өнчин хүүхэд"-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгон тусгасан, мөн эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яаралтай батлах;

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтөд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын барилга, байгууламж, орчинд тавих шаардлагад дулаан, чийгшил, гэрэлтүүлгийн стандартыг тусгаж өгөх;

Насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарч буй хүүхэд, залууст нийтлэгээр тулгардаг орон байрны асуудалд анхаарч тэдгээр хүүхдүүдийг орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх;

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагддаг, их, дээд сургуульд суралцаж байгаа болон мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс төлөх асуудлыг шийдвэрлэх;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4-т заасан "хамтарсан баг"-ийн бүрэлдэхүүнд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын төлөөлөл оролцох боломжийг бий болгон холбогдох хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах;

Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамруулах тухай зохицуулалтыг холбогдох журамд тусгах.

## 2.2 АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН АСРАМЖИЙН ГАЗРУУДАД ХИЙСЭН ЭЭЛЖИТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн ирүүлсэн тайлан, зөвлөмж<sup>61</sup> болон ХЭҮКХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор ТОГТМОЛ хяналт шинжилгээ хийх” заалтын дагуу ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг нийт 8 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт давхардсан тоогоор 11 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлэн, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож ажилласан.

Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн<sup>62</sup> дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын ХЭҮКХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсик, Мартин Зинклер, ХЭДКГ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Армен Авестинан, ХЭДКГ-ын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтран 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хяналт шинжилгээ хийн ажилласан.

“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт ЭШУС үндэсний ажиллагааны ажлын хэсэг 2024 оны 06 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийн ажилласан.

Төв аймгийн Батсүмбэр суман дахь АНҮТ-д хоёр удаа урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн бөгөөд нэг удаад нь ХЭҮК-ын гишүүн Х.Мөнхзултай хамтран ажилласан<sup>63 64</sup> бөгөөд тус урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, иргэд болон төрийн албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж ажиллах зорилгоор “Монголын үнэн” сонинтой байгуулсан Хамтран ажиллах гэрээний<sup>65</sup> дагуу тус сонины төлөөлөл болох сэтгүүлчтэй хамтран ажилласан. Монголын үнэн сонинд “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” буланг

61 НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын урьдчилсан тайланг Ерөнхий ассамблейн Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн, батлаад Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Зөвлөмж.

62 НҮБ-ын ЭШУС Дэд хорооны төлөөлөгчидтэй хамтран “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх 24/07 дугаартай удирдамж.

63 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан Ахмад настны үндэсний төвд ажиллах 24/10 дугаартай удирдамж.

64 Ахмад настны үндэсний төвд эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх 25/05 дугаартай удирдамж.

65 “Монголын үнэн” сонинтой байгуулсан 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭҮК/2025/10 дугаартай Хамтран ажиллах гэрээ.



тогтмол ажиллуулж байгаа бөгөөд энэ хүрээнд “Асрамжийн газрыг ахмад настны амьдран суух диваажин болгох хүсэл” нийтлэл тус сонины 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 009 дугаарт нийтлэгдсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын “Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээ”-гээр зөвлөмж болгосны дагуу урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцахын зэрэгцээ өмнө нь хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшилтэй танилцсан.

### **Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний аргачлал:**

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнүүдийг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, тус асрамжийн газруудад амьдарч буй 22 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнээс асуумж авч ганцаарчилсан ярилцлага хийн, 14 эмч, ажилтнаас асуумж авч, 15 эмч, ажилтантай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн.

### **Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газруудад хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхарт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/04, Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/03, Төв аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Алтанхуягт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/01, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/05, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/06, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн 08/17 дугаартай зөвлөмж тус бүрийн хэрэгжилтийн хувь болон хэрэгжилтийн ерөнхий хувийг хүснэгтээр харууллаа.

№	Зөвлөмж хүргүүлсэн байгууллага	Огноо, дугаар	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
<b>2022 онд</b>				
1	ХНХ-ын дэд сайд	2022.10.13, 08/04	9	100 %
2	АНУТ-ийн дарга	2022.10.13, 08/03	6	50.0 %
3	Төв аймгийн ЦГ-ын дарга	2022.10.13, 08/01	4	100 %
4	ЭМ-ийн сайд	2022.10.13, 08/05	5	100 %
5	ЗТХ-ийн сайд	2022.10.13, 08/06	1	80.0 %
6	<b>Нийт</b>	<b>86.0 %</b>		
<b>2023 онд</b>				
7	ХНХ-ын сайд	2023.10.23, 08/17	7	100 %
8	<b>Нийт</b>	<b>100 %</b>		
9	<b>Ерөнхий хувь</b>	<b>93.0 %</b>		

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний онцлох үр дүн, ахиц дэвшил

- Ахмад настны тухай хууль (АНТХ)-д 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулж ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөгжих, эрүүл, идэвхтэй амьдрах, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжтой байх, үл ялгаварлах зарчмыг хуульчлан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зохицуулалтыг тусган баталсан. Үүнд:
  - АНТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг төрийн байгууллага иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан, эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ”;
  - АНТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2.10-т “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон сум, тосгон, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх”;
  - Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.13-т “ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн

техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах”.

2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд дагаж мөрдөгддөг нийт таван журмыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж байна. Үүнд:
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаал;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/191 дүгээр тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам”.
3. Төв аймгийн Батсүмбэр сумаас АНҮТ хүртэлх 7,7 километр замыг хатуу хучилттай болгох ажлыг улсын төсвийн нийт 13,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2026 онд багтаан гүйцэтгэхээр шийдвэрлэгдсэн бөгөөд засмал зам тавих нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Будаан толгой” хэмээх газарт зохион байгуулагдсан. Түүнчлэн 2025 оны төсөвт 4,6 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд замын шороон далан барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

## **“МС” ТЕРЕЗА ЭХ, “АЧЛАЛТ ХҮҮХДҮҮД” АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСРАМЖИЙН ГАЗАРТ ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

### **Хууль, эрх зүйн орчин:**



Тус асрамжийн газрууд нь НХТХ, АНТХ, ХТХ, ХБХЭТХ, Нийгмийн даатгалын ерөнхий хууль (НДЕХ), Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавигдах нийтлэг

шаардлага MNS 5823:2016” стандарт, “Ачлалт хүүхдүүд” төрийн бус байгууллагын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын тухайд тус байгууллагын захирал Б.Саранбаатарын баталсан 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Төвийн дотоод журам”, 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Ачлалт хүүхдүүд төвийн төсөв бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Ачлалт хүүхдүүд асрамжийн төвд зайлшгүй байх тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журам”, “Ачлалт хүүхдүүд төвд хөгжлийн ажиллагаа зохион байгуулах журам”, “Ачлалт хүүхдүүд төвд зайлшгүй байх эмийн жагсаалт”, 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Ачлалт хүүхдүүд асрамжийн төвд асаргаа, сувилгаа нөхөн сэргээх үйлчилгээ явуулах журам” болон холбогдох бусад баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 2023 онд хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр шинэчлэгдэн батлагдсан эрх зүйн холбогдох баримт, бичгүүд болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/130 дугаар тушаал “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эмийн зардлын норм, норматив”, А/188 дугаар тушаал “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”, А/191 дүгээр тушаал “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам”, А/190 дүгээр тушаал “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”, “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх журам”, “Үнэлгээ хийх жишиг үнэ” зэрэг эрх зүйн баримт, бичгийг харьяалах дээд шатны байгууллагаас зарим асрамжийн газарт цаг тухайд нь хүргүүлж, мэдээллээр хангаж, холбогдох чиглэлийг өгөөгүй байна.

Түүнчлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга “Ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ сунгах тухай” 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/174 дүгээр тушаал гарган “МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээг сунгахдаа хүчин төгөлдөр бус эрх зүйн баримт бичгийг үндэслэн гаргажээ.

ГБХНХЯ-ны харьяа ХХҮЕГ-тай жил бүр Хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг.

### [“Ачлалт хүүхдүүд”, “МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын түүхэн замнал, үйл ажиллагаа:](#)



“Ачлалт хүүхдүүд” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар нь 2015 онд байгуулагдсанаас хойш 9 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрөөс хэсэгчлэн санхүүждэг (хоолны зардал, эм, зөөлөн эдлэл) хувийн хэвшлийн байгууллага юм. Газар тариалангийн ажил, худалдаа эрхэлж, олсон орлогоор тус асрамжийн төвийн ажилтнуудын цалин хөлс, ус, дулаан, цахилгааны зардлаа шийдвэрлэдэг тухай ажлын хэсэгт танилцуулсан. Асрамжийн газрын барилгыг 2015 онд Худалдаа, хөгжлийн банкнаас тус байгууллагад бэлэглэсэн боловч хэсэг хугацааны дараа зээлийн гэрээ байгуулан, гэрээнд тусгасны дагуу төлбөр төлж байгаа, мөн төлбөрийн асуудлаар хэрэг нээгдэн шүүхэд хянагдаж байгаа талаар танилцуулсан.

Тус асрамжийн газарт 53 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байгаа ба дийлэнх нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хэвтрийн хүмүүс байна.

Төвд ажилладаг хүний нөөцийн тухайд захирал 1, нийгмийн ажилтан 1, эмч 1, асаргааны ажилтан 6, нийт 9 ажилтантай.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”-д заасны дагуу тус төвд амьдарч төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг үйлчлүүлэгчид, 30 хувийг асрамжийн төв авч захиран зарцуулж байна.

Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан ажилладаг бөгөөд тус Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд тодорхой давтамжтай хүрэлцэн ирж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэн, шинжилгээнд хамрагдах шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг урьдчилан бүртгэж, холбогдох тусламж, үйлчилгээнд хамруулдаг.

“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар нь Монгол Улсад Ватиканы төлөөлөгчийн газраар дамжин уригдан орж ирсэн “Missionaries of charity” нэртэй байгууллагаас санхүүждэг.

“Missionaries of charity” байгууллагын дэлхий дээрх нийт 148 улс оронд үйл ажиллагаа явуулж буй 758 салбарт 5,150 гэлэнмаа нар ажиллаж, буяны болон хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээг үзүүлэн, нийгмийн хөгжлийн чиглэлээр төрөл бүрийн төслүүдийг санаачлан хэрэгжүүлдэг байна.

Монгол Улсад “МС” Тереза эх нэртэй асрамжийн газрын үйл ажиллагааг 1996 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлүүлэн 2011 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр албан ёсоор магадлан итгэмжлэгдсэн бөгөөд зорилтот бүлгийн хүмүүст зориулсан сайн дурын, үнэ төлбөргүй, олон талт тусламжийн үйлчилгээг нийгмийн гарал байдал, эрдэм боловсролоор нь үл ялгаварлан үзүүлж, 28 дахь жилдээ ажиллаж байна.

Нийт гурван салбартай бөгөөд 12 гэлэнмаагаар ахлуулсан үндсэн 31, сайн дурын 10 гаруй, нийт 40 орчим ажилтантай.

Сүхбаатар дүүргийн Бэлхийн 16 дугаар хороонд байршилтай нэгдүгээр салбарт эмэгтэй хүмүүсийг байрлуулдаг бол Хан-Уул дүүргийн 06 дугаар хороонд байршилтай хоёрдугаар салбарт эрэгтэй хүмүүсийг байрлуулдаг. Асрамжийн газрын байрны багтаамжаас шалтгаалж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тусад нь байрлуулдаг тухай танилцуулсан. Мөн Дархан-Уул аймагт хүүхэд, насанд хүрэгчдийн түр хоноглох байр ажиллуулдаг.

Нийслэл Улаанбаатар хот дахь хоёр салбарт нийт 60 хүнийг хүлээн авч тусламж, үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай.

“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар нь нийгмийн эмзэг бүлэгт хамрагддаг өрх толгойлсон болон орон гэргүй, тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй, мөн цус харвалтын дараах асаргаа, сувилгаа шаардлагатай, бичиг баримтгүй хүмүүсийг хүлээн авч, байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэн, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг явуулдаг.

Дээр дурдсан “Missionaries of charity” байгууллага нь дор дурдсан 14 чиглэлээр хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Эмзэг бүлгийн нэн ядуу иргэдэд зориулсан хүнсний тусламж /сар бүр гурил, будаа, ургамлын тос г.м хүнсний зүйл түгээдэг/ үзүүлэх;
2. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй иргэдийн гэрт очиж тусламж үзүүлэх;
3. Төлбөрийн чадваргүй иргэдийн эмчилгээний зардал төлөх /эм, тариа, ор хоног, мэс засал эмчилгээний төлбөр г.м/
4. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, орлого багатай айл өрхийн хүүхдүүдийг хичээлийн хэрэглэлээр хангах;
5. Нэн ядуу иргэдийг хувцас болон ариун цэврийн хэрэгслээр хангах;
6. Төлбөрийн чадваргүй иргэдийн орон байрны түрээс, засвар, цахилгааны төлбөр зэрэгт дэмжлэг үзүүлэх /гэр, гэрийн дулаалга, зуух/;
7. Нэн ядуу иргэдийг нийгэмшүүлэх, бичиг баримтай болгох үйлчилгээ /иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй болгох г.м./;
8. Сургууль завсардсан хүүхдүүдэд суурь боловсролыг нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх /сургуульд шинээр бүртгүүлэх, хичээлийн хоцрогдол арилгах, ном сурах бичгээр хангах/;
9. Боловсрол эзэмших хүсэл, сонирхолтой, оюуны чадавх сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад дэмжлэг үзүүлэх
10. Улаанбаатар хотын болон Дархан-Уул аймгийн хогийн цэгт болон траншейнд амьдардаг хүмүүст хүрч очиж тусламж, дэмжлэг үзүүлэх;
11. Нэн ядуу иргэдийн хүүхдүүдэд зусланд амрах боломж олгох;



12. Орон гэргүй боловч амьдралын төлөө тэмцэж байгаа иргэдэд газар, хашаа, гэр худалдан авч өгч, хяналт тавих;
13. Дүүрэг, хороо, багууд болон харьяалах эрүүл мэндийн байгууллагуудын зарим хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллах;
14. Хорих ангиудад хорих ял эдэлж буй иргэдэд шаардлагатай зарим эд, зүйлсээр хангаж дэмжлэг үзүүлэх.

Долоо хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт орон гэргүй, тэнэмэл хүмүүст халуун хоол, цай өгч, усанд оруулдаг. Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс энэхүү үйл ажиллагаанд болон бичиг баримтгүй иргэдийг бүртгэлжүүлэх, бичиг баримттай болгоход хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Хан-Уул дүүргийн 06 дугаар хороо, Ноосны үйлдвэрийн 31-83, 84 тоот хаягт байрлах салбарын нүүрс түлдэг зуухыг буулгаж, 500 орчим сая төгрөг зарцуулан төвийн дулаан болон цэвэр усны системд холбогдсон.



“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын нийслэл дэх хоёр салбарт 2024 оны 06 дугаар сарын 17, 18-ны өдрийн өдрийн байдлаар 28-83 насны 26 эмэгтэй, 44-85 насны 28 эрэгтэй нийт 54 иргэн амьдарч байна. Эдгээр иргэдийн ихэнх нь “Энэрэл” эмнэлгээс ирсэн. Үйлчлүүлэгчдийг асрамжийн газарт хүлээж авахдаа гэрээ байгуулдаг.

Сүхбаатар дүүрэг дэх салбарт монгол хүнтэй гэр бүл болсон казах эмэгтэй 1 нас 6 сартай хүүхдийн хамт амьдарч байна. Казак эмэгтэйн нөхөр цэргийн албанд явсны дараа хадмууд нь казах эмэгтэйд хүүхдийн хамт гэрээсээ явуулсан тул тус асрамжийн газарт амьдарч байгаа бөгөөд казах эмэгтэй асрамжийн газрын ойролцоох хүнсний дэлгүүрт ажиллаж байгаа бол 1 нас 6 сартай хүүхдийг асрамжийн газрын ойролцоох хувийн хэвшлийн цэцэрлэгт хамруулж байна.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн 6, 9 дүгээр ангийн хоёр сурагч тус асрамжийн газарт амьдарч байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоёр сурагчийн эцэг, эх нь архины хамааралтай бөгөөд “Missionaries of charity” байгууллагын хүмүүнлэгийн үйл ажиллагаанд байнга хамрагддаг. “Missionaries of charity” байгууллагын гэлэнмаа нар тухайн гэр бүлд тусламж үзүүлэхээр очихдоо болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж хоёр хүүхдийг тус асрамжийн газарт авчирсан талаар танилцуулсан.

“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газрын менежер Ш.Урантөгс нь 14 жил тус байгууллагад ажиллахад хүний эрхийн байгууллагаас анх удаа ирж ажиллаж байгааг хэлж, цаашид хамтран ажиллахад таатай байгаагаа илэрхийлж байв.

### **Бүтэц, орон тоо:**

“МС” Тереза эх асрамжийн газарт 1 захирал, 1 нийгмийн ажилтан, 1 эмч ажилладаг бол хоёр салбар тус бүрд 2 тогооч, 4 асрагч, 2 гэлэнмаа, 1 үйлчлэгч ажилладаг. Өвлийн улиралд 6 галч ажилладаг бол зуны улиралд 2 галч тус тус ээлжлэн ажилладаг.

Ажилтнууд “МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газрын даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилладаг бөгөөд асрагч нар 24/72 цагаар ажилладаг бол бусад ажилтнууд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын цагийг баримталж ажилладаг.

### **“Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХАТХ)-д заасны дагуу тендер шалгаруулалт зохион байгуулах, үнэлгээний хороо байгуулах зэрэг үйл ажиллагаанд их хугацаа зарцуулдгаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эмийн зардлын норм, норматив батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаалаар баталсан холбогдох зардлыг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад жилийн эхэн үеэр олгох боломжгүй байна. Энэхүү нөхцөл байдал нь асрамжийн үйлчилгээ үзүүлдэг зарим байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдахад хүндрэл бэрхшээл үүсгэдэг;

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газруудад аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон олон улсын байгууллагаас өгдөг аливаа хандив, тусламжийн талаар ил тод мэдээлэх, хандив, тусламжийн зарцуулалтад хяналт тавихтай холбоотой бодлого, зохицуулалт хангалтгүй;

### **“МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**

- Тус асрамжийн газар нь ихэвчлэн цус харвалтын дараах асаргаа, сувилгаа шаардлагатай, бичиг баримтгүй хүмүүсийг хүлээн авч, асрамжийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бичиг баримтгүй иргэдийг бичиг

баримттай болгон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээж авах боломжтой орон нутагт байршилтай асрамжийн газруудад шилжүүлэн, тусламж шаардлагатай дараагийн иргэдийг хүлээн авч холбогдох тусламж, үйлчилгээг үзүүлэх хэрэгцээ, шаардлага тулгамддаг;

- “Оронд шээдэг” гэх шалтгаанаар сувиллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж, үйлчилгээ үзүүлэхээс цааргалдаг, рашаан сувилалд хамруулахад бэрхшээлтэй байдаг;
- Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараалалгүй үзүүлэх зорилгоор үнэмлэх олгодог тул асрамжийн газраар үйлчлүүлж буй эрүүл мэндийн салбарт ажиллаж байсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад дараалал хүлээхтэй холбоотой бэрхшээл тулгардаггүй байна. Харин асрамжийн газраар үйлчлүүлж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад урт дараалал хүлээж хүндрэл бэрхшээл тулгардаг;
- Тус асрамжийн газрын ажилтнуудын цалингийн хэмжээг санхүүжүүлэгч байгууллагаас тогтоодог бөгөөд нэг сарын үндсэн цалин хөлсний хэмжээ 850,000-1,500,000 төгрөг тул амьдралд хүрэлцдэггүй. Цалин хөлс нэмэгдүүлэх хүсэлтийг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлдэг ч байгууллагаас “...энэхүү үйл ажиллагааг бусад улс орнуудад сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг, Монгол Улсад энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа хүмүүст тодорхой хэмжээний цалин хөлс өгдөг, цалин хөлсний хэмжээ шаардлагад нийцэхгүй байгаа бол энэ үйл ажиллагааг зогсооход ч хүрч магадгүй...” гэх утгатай тайлбар хэлж дорвитой арга хэмжээ авдаггүй талаар ажлын хэсэгт танилцуулсан;
- Асрамжийн газарт амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асрамжийн газрын ажилтнуудын эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар сургалтад тогтмол хамрагдах шаардлагатай;
- Асрамжийн газрын ажилтнууд болон үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн;
- Асрамжийн газрын зарим эм, тариа болон хүнсний бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа дууссан;
- Хан-Уул дүүргийн 6 дугаар хороонд байрлах хоёрдугаар салбарын барилгын агааржуулалтын системийг өдөрт зөвхөн 2 орчим цаг ажиллуулдаг үйлчлүүлэгчдийн амьдрах орчин бүгчим халуун, эхүүн үнэртэй;
- Барилгын зоорины давхар буюу хуурай хүнс хадгалах хэсэг агааржуулалтгүй;
- Барилгын хоёрдугаар давхар луу гарах шатны хэсэгт байх цонхны наагуур хамгаалалтын хаалт байхгүйгээс хүн унаж гэмтэх эрсдэл ажиглагдсан;

- Мөн хоёрдугаар давхар луу гарах шатны эхний гишгүүр хавьд хүн бүдэрч унах эрсдэл үүссэн;
- Үйлчлүүлэгч нар зөвхөн 18:00-21:00 цагт телевиз үзэх боломжтой;
- Асрамжийн газарт амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдийн орны чанх дээд талд тод гэрэлтдэг лед гэрэл байрлуулсан.

## АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВД ХИЙСЭН ЭЭЛЖИТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/107 дугаар тушаалаар тус байгууллага 127 ажилтантай байхаар баталсан бөгөөд Захиргаа нийгмийн оролцооны алба 14, Дэмжих үйлчилгээ, хангамжийн алба 49, Сувилахуйн төв 63, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний алба 27, Асаргаа сувилгаа, сэргээн засах

тусламж үйлчилгээ 36 батлагдсан орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Төвийн 1 болон 2 дугаар байрыг холбосон цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудад зориулсан спорт заал, тэргэнцэртэй хүмүүст зориулсан усан бассейн байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлуудын зарим зураг төслүүдийг гарган ажиллаж, хөрөнгө мөнгө, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудтай хэлцэл хийж байгаа талаар ажлын хэсэгт танилцуулсан.


### Ахмад настны үндэсний төвд хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:



1. АНҮТ нь зэргэлдээ байрлалтай нийт гурван барилга байгууламжтай бөгөөд асрамжийн төв байр 1982 онд, асрамжийн төвийн өргөтгөл 2015 онд, асрамжийн хоёрдугаар байр 2016 онд тус тус ашиглалтад орсон. Асрамжийн төв байр буюу нэгдүгээр байр нь 1982 онд ашиглалтад орсноос хойш бүрэн засварын ажил хийгдээгүй. Хүчтэй салхи салхилах, шуурах үед барилгын дээвэр хуулагдан унах зэрэгт өөрсдийн нөөц бололцоогоор засварладаг. Сүүлийн жилүүдэд хур бороо элбэгшиж нэлээд эрсдэлтэй нөхцөл байдал тулгарч, барилгын дээврийг бүрэн солих

хэрэгцээ шаардлага тулгарч буй талаар холбогдох яаманд хүсэлтээ гаргасаар ирсэн боловч төсөв шийдвэрлэгдээгүй;

2. Зарим үйлчлүүлэгчдийн амьдрах өрөөнд агааржуулалтын хоолойгүй, агааржуулалтын хоолойтой боловч ажилладаггүй, асрамжийн 1 дүгээр байрны С корпусын 1 давхраас 2 давхар руу гардаг хэсгийн цонхны ойр орчмын шавардлага их хэмжээгээр чийгтэж, хууларсан, 2 дугаар байрны үйлчлүүлэгчдийн 101-109 дүгээр өрөөнүүдийн коридор хэсгийн хананы шавардлага чийгшил, мөөгөнцрөөс болж их хэмжээгээр нурсан байдалтай, нийтийн коридорын болон үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөөнүүдэд байдаг агааржуулалтын хоолой ажиллахгүй байна;
3. Ахмад настнуудад чиглэсэн хөгжлийн, соёл чөлөөт цагийн үйл ажиллагааны хүрээнд үзвэр үзүүлэх, байгалийн дурсгалт газруудад аялуулах зэрэгт 24 хүний суудалтай автобус шаардлагатай байгааг удирдлагын зүгээс танилцуулсан;
4. Хөдөө орон нутагт өвлийн цагт удаан хугацаагаар цахилгаан тасрах эрсдэл их байдаг тул зайлшгүй цахилгаан үүсгүүр байх шаардлага тулгардаг. Цахилгаан тасрахад уурын зуухны ажиллагаа зогсож, халаалт тасрах, байнгын асаргаа шаардлагатай ахмадуудыг хуурайлах, даавуу угаах, хоол унд бэлтгэх үйл ажиллагаанд хүндрэл учирдаг талаар танилцуулсан;
5. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ганцаарчилсан ярилцлага





болон асуумжид оролцсон эмч, ажилтнууд болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд дараах нөхцөл байдлыг нийтлэгээр дурдсан байна. Үүнд:

- Төвд сэтгэцийн эмгэгтэй, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан сэтгэцийн эмч, хэл засалч ажиллуулах нэн шаардлагатай. Тухайлбал, төвд орон тооны сэтгэцийн эмч ажилладаггүй, сэтгэцийн эмч, сэтгэл зүйчийг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай;

- Архины хамааралтай болон сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүс ихээр ирж асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагддаг бөгөөд бусад үйлчлүүлэгчдийг хэл амаар доромжлох, цохих гэж дайрах, худлаа ярьж гүтгэх зэрэг асуудал үүсгэдэг. Сэтгэцийн хувьд өөрчлөлттэй үйлчлүүлэгч байгаа нь ажилтан албан хаагч болон бусад үйлчлүүлэгчдийн

сэтгэл санаа, эрүүл мэнд, аюулгүй байдалд хүндрэл учруулдаг. Сэтгэцийн хувьд их хурц зан араншинтай, огцом уурладаг, өөрийгөө болон бусдыг гэмтээх магадлалтай хүмүүс байдаг. Мөн сүүлийн үед байнгын асаргаа шаардлагатай хэвтрийн болон саажилттай хүмүүс ихээр ирж байна. Иймд хүний нөөцийн асуудалд анхаарч асрагчийн орон тоог нэмэгдүүлж, удирдлага, зохион байгуулалтын талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай;

- Тэтгэвэрт гарсан хүн албаны дарга хийж байгаа. Залуу боловсон хүчнээ дэмжиж, албаны даргыг залуу эмчээр соливол зүгээр байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны дарга нь ажилтнаа ялгаварладаг. Хүний бие муудахад албаны даргаас асууж байж эмчилгээ хийж байгаа харагддаг. Сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийг хэвийн хүмүүстэй хамт байлганааргүй байна. Эдгээр улсууд бидэнд ч ажилтнуудад ч ажиллахад, амьдрахад хүндрэл учруулдаг;
- Сэтгэцийн өвчтэй болон зөнөгрөлтэй үйлчлүүлэгчтэй харилцах болон ажиллахад бэрхшээлтэй байдаг учир тэдгээр хүмүүстэй холбоотой асуудлыг шийдвэрлэх шат шатны байгууллагуудад тавьж анхаарч





ажиллах. Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгч догширсон үед авах арга хэмжээг сайжруулах /эмийн болон эмийн бус/, бэлэн байдлыг хангах, сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийг тусад нь нэг давхарт байрлуулах, гэрээт харуул хамгаалалттай болох. Хоолны амт чанарыг сайжруулах, ахмад настууд хол явахад бэрхшээлтэй байдаг тул төв дээр хүнсний мухлаг, эмийн сантай байвал зүгээр байна;

- Үйлчлүүлэгчдээс ямар нэг зүйлийн хандив байнга авдаг. Төвийн нэр дурдсан зарим ажилтнууд дарамт үзүүлж хандив нэрээр мөнгө татдаг асуудлыг таслан зогсоох хэрэгтэй. Үйлчлүүлэгчдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг сумын банкны АТМ-ээс төвийн ажилтнууд авчирч өгдөг асуудалд хяналт тавих, ахмад настуудад мөнгийг нь бүрэн бүтэн өгүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай;
- Ахмад настуудыг лавлагаа шатлалын эмнэлэгт нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд тодорхой хугацаанд хамруулдаг болох, лабораторитой болох. Дотрын нарийн мэргэжлийн их эмч, сэргээн засахын эмч зэрэг нарийн мэргэжлийн эмч нар шаардлагатай;
- Үйлчлүүлэгчдийн ихэнх нь сэтгэцийн өөрчлөлттэй, сэтгэл санааны гүн хямралд орсон байдаг ба эдгээр хүмүүс нь ямар нэгэн эрсдэл гаргах өндөр магадлалтай байдаг тул Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилтийн тухайн жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг батлуулах шаардлагатай байна. Жил бүр төсөвт суулгаж явуулдаг боловч батлагддаггүй. Үйлчлүүлэгч нарын харилцаа хандлага, үйлдлээс болж эмнэлгийн тусламжийн албанд эмч, сувилагч, асрагч нар дутагдалтай байдаг асуудлыг шийдвэрлэх.

АНҮТ-д хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн тус төвийн захирал Л.Эрдэнэхүүд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08/04 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн.<sup>66</sup>

## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд, холбогдох албан тушаалтнуудтай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны ажлын хэсэг “МС” Тереза эх ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.

<sup>66</sup> ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08/04 дугаартай зөвлөмж

Хүний эрхийн Үндэсний Комиссын хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор ТОГТМОЛ хяналт шинжилгээ хийх” чиг үүргийн дагуу Ахмад настны үндэсний төвд хоёр удаа ажиллан ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнүүдийг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, тус асрамжийн газруудад амьдарч буй 22 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнээс асуумж авч ганцаарчилсан ярилцлага хийн, 14 эмч, ажилтнаас асуумж авч, 15 эмч, ажилтантай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын “Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээ”-гээр зөвлөмж болгосны дагуу урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон тэдний амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцахын зэрэгцээ өмнө нь хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өмнө хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшилтэй танилцсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхарт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/04, Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/03, Төв аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Алтанхуягт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/01, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/05, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/06, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн 08/17 дугаартай зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлэхэд 93.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах онцлох үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

1. Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулж ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөгжих, эрүүл, идэвхтэй амьдрах, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжтой байх, үл ялгаварлах зарчмыг хуульчлан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зохицуулалтыг тусган баталсан. Үүнд:
  - Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг төрийн байгууллага иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан, эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ”;
  - Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.10-т “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон сум, тосгон, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх”;
  - Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.13-т “ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах”.
2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд дагаж мөрдөгддөг нийт таван журмыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж байна. Үүнд:
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаал;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх журам”;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/191 дүгээр тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам”.

3. Төв аймгийн Батсүмбэр сумаас Ахмад настны үндэсний төв хүртэлх 7,7 километр замыг хатуу хучилттай болгох ажлыг улсын төсвийн нийт 13,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2026 онд багтаан гүйцэтгэхээр шийдвэрлэгдсэн бөгөөд засмал зам тавих нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Будаан толгой” хэмээх газарт зохион байгуулагдсан. Түүнчлэн 2025 оны төсөвт 4,6 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд замын шороон далан барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

### САНАЛ

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер шалгаруулалт зохион байгуулах, үнэлгээний хороо байгуулах зэрэг үйл ажиллагаанд их хугацаа зарцуулдагас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эмийн зардлын норм, норматив батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаалаар баталсан холбогдох зардлыг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад жилийн эхэн үеэр олгох боломжгүй байна. Энэхүү нөхцөл байдал нь асрамжийн үйлчилгээ үзүүлдэг зарим байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдахад хүндрэл бэрхшээл үүсгэдэг тул холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газруудад аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон олон улсын байгууллагаас өгдөг аливаа хандив, тусламжийн талаар ил тод мэдээлэх, хандив, тусламжийн зарцуулалтад хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг бий болгох.

## 2.3 ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН ЭЭЛЖИТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний аргачлал

ЭШУС үндэсний ажиллагаа 2024 оны 4 дүгээр сараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байруудад 16 удаагийн хяналт шинжилгээ хийсэн. Хяналт шинжилгээний хүрээнд хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, албадан эрүүлжүүлэгдсэн, түр саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан 609 иргэн болон 131 цагдаагийн алба хаагчаас асуумжийн аргаар эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар судалгаа авч, 43 иргэн, цагдаагийн 27 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийлээ.

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу, нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоохдоо Цагдаагийн байгууллагын тухайн байршлын материаллаг нөхцөл, дүрэм журам, бодлого, байгууллагын соёл, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй хэрхэн харьцаж буй эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг дараах аргуудыг ашиглан явуулсан:

- Орчны нөхцөлд ажиглалт хийх буюу тухайн байршлын барилга, байгууламжийн нөхцөл, тэр дундаа эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэх, нэг хүнд ногдох талбайн хэмжээ, зохион байгуулалт, өрөөний дулаан, гэрэлтүүлэг, чийгшил, агааржуулалт, дуу-дүрсний бичлэгийн камерын ажиллагаа зэрэг үзүүлэлтийн хэмжилт, баримтжуулалтыг хийх;
- Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байрны үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журамтай танилцах;
- Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байранд үйлчлүүлж байгаа хүнд олгогдож буй хоол, хүнсний орц, илчлэгийг хянах;
- Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байранд үйлчлүүлж байгаа хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт;
- Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байранд үйлчлүүлж байгаа хүнээс цагдаагийн газар, хэлтсийн удирдлага, эрх бүхий байгууллагад хандан гаргасан өргөдөл, гомдол, саналын бүртгэлд дүн шинжилгээ хийх;
- Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох баримт бичигтэй танилцах;
- Цагдаагийн газрын удирдлага, алба хаагчдад эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл хийх;
- Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байранд үйлчлүүлж байгаа иргэдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг тайлбарлан, танилцуулах;

- Цагдаагийн газрын алба хаагчидтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага явуулах, цагдан хоригдогсдын эрүү шүүлтээс ангид байх эрхийг хэрхэн хангаж буй эсэх, алба хаагчдын хөдөлмөрлөх эрх хэрхэн хангагддаг эсэхийг тодруулах асуумж авах;
- Цагдан хоригдсон, баривчлагдсан хүнтэй ганцаарчлан уулзах, хэзээд үл хязгаарлагдах эрхийн хэрэгжилт болон цагдан хоригдсон нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой асуумж авах.

## НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБА

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”<sup>67</sup> гэж заагаад, 38 дугаар зүйлд “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”<sup>68</sup> үүргийг Засгийн газарт хүлээлгэсэн.

Монгол Улсын ЦЕГ нь гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах чиг үүрэг бүхий засгийн газрын тохируулагч агентлаг юм.

Монгол Улсын Цагдаагийн алба үүсэж хөгжөөд даруй 103 жилийн түүхийг бичээд байна. 1921 онд Богд Жавзандамба хутагтын лүндэнгээр Нийслэл Хүрээг 15 бүрэлдэхүүнд хувааж, захын эргүүлийн цагдааг “морьтой”, дотор эргүүлийн цагдааг “явган” гэж ангилан тогтоосноор “арван тавны цагдаа” хэмээн олноороо нэрлэх болж, хожим “Амгаланг сахиулах цагдаа” гэх нэршилтэй болсон нь эдүгээ цагийн Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үүслийг тавьсан түүхтэй<sup>69</sup>.

Хүний эрх чөлөөг хязгаарласан эсхүл өөрийн хүслээр орхин гарч явах боломжгүй газрууд<sup>70</sup> гэх НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын тодорхойлолтын дагуу Монгол Улсын ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиг үүрэгт хамаарах Эрүүлжүүлэх, саатуулах төв, байр, баривчлах байрууд нь эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх хүний эрхийн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ явуулах зорилтот байршилд тооцогддог.

Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын Нийслэлийн цагдан сэргийлэх газрын сэргийлэн хамгаалах хэлтэс 1960 онд байгуулагдаж хот, хөдөөгийн хэмжээнд хэв журам хамгаалах ажлыг хариуцан, нийслэлийн 13 хороо, аймгийн сэргийлэн хамгаалах байцаагч нарыг харьяалж байжээ. Улмаар 1960 онд эрүүлжүүлэх байр байгуулагдсан байна. Сайд нарын зөвлөлийн 1968 оны 34

67 <https://legalinfo.mn/> Монгол Улсын Үндсэн хууль, Арван нэгдүгээр дүгээр зүйл, 1 дэх хэсэг

68 <https://legalinfo.mn/> Монгол Улсын Үндсэн хууль, ГУРАВ.Монгол Улсын Засгийн газар, Гучин наймдугаар зүйл, 7 дахь хэсэг

69 <https://police.gov.mn/100year>

70 Хүний эрхийн олон улсын билл, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл, 416 дугаар тал



дүгээр тогтоолоор Улаанбаатар, Дархан хотод баривчлах байр, Дархан, Дорнод, Сэлэнгэ, Зүүн хараа, Дорноговьд эрүүлжүүлэх байр байгуулагджээ<sup>71</sup>.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 76 дугаар тогтоолоор цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцэд “Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба”-ыг шинээр байгуулан баталж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/262 дугаар тушаалаар зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлсон.

Цагдаагийн албаны тухай хууль (ЦАТХ)-ийн шинэчилсэн найруулгын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулах болон ЦЕГ-ын үйл ажиллагааны стратеги загварыг үндэслэн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албыг цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцэд шинээр бий болгож, ЦЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 26-ны А/197 дугаар тушаалаар 31 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Улмаар ЦЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс, мөн даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/116 дугаар тушаалаар Хүрээлэн буй орчны хяналтын хэлтсийг 58 алба хаагчийн орон тоотойгоор тус тус байгуулсан байна.

ЦЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А/13 дугаар тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны бүтэц, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, Захиргааны удирдлагын газар, Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийг шинээр байгуулж, нийт 591 алба хаагчийн орон тоотойгоор зохион байгуулсан.

Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын албаны төв, орон нутгийн нийт 35 байранд ЦАТХ-ийн 11,12 дугаар зүйл, 13,14 дүгээр зүйлийн хамаарах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн гүйцэтгэж байна. Эдгээрээс 13 нь 40-өөс дээш жилийн насжилттай бол 4 нь 2020 оноос хойш баригдсан барилгад үйл ажиллагаа явуулж байна. (Хүснэгт 1)

Нэг удаад нийт 402 үйлчлүүлэгчийг хүлээн авч эрүүлжүүлэх 103, нэг удаад нийт 212 хүнийг 48 цаг хүртэл саатуулах 52, 26 хүнийг 6 цаг хүртэлх хугацаагаар түр саатуулах 8 болон 284 хүний багтаамжтай 64 баривчлах шийтгэл эдлүүлэх өрөө улсын хэмжээнд ажиллаж байна. (Хүснэгт 2)

71 <https://police.gov.mn/100year>

Д/д	Газар, хэлтэс	Байршил				Байр ашиглалтад орсон он	Байрны нийт өрөөний тоо	Нийт талбай м <sup>2</sup>
		Газар, хэлтсийн байранд	Байрны 1 дүгээр давхарт байрладаг	Барилгын доод давхарт байрладаг	Тусдаа байртай / өргөтгөлд/			
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1		1		1986	11	150
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс				1	2016	14	190
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс			1		1985	12	180
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв				1	1987	48	4600
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс				1	2021	12	50
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1			2020	5	48,5
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс		1			1985	8	144
8	Архангай аймгийн Цагдаагийн газар	1		1		1987	8	108
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	1		1		1984	16	600
10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар		1		1	2007	16	203,1
11	Булган аймгийн Цагдаагийн газар			1		1965	8	42,34
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар				1	2017	12	171
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар				1	1978	3	32
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар				1	1984	20	312,4
15	Шарын гол	1				1993	6	54
16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар				1	2013	14	252
17	Замын-Үүд					1998	8	96
18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар					1985	15	214,53
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар				1	2001	8	89

20	Завхан аймгийн Цагдаагийн газар				1	2006	16	275
21	Тосонцэнгэл	1	1			2019	9	146
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	1	1			2011	10	240
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар				1	1982	16	280
24	Хархорин	1	1			2015	6	53,8
25	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар				1	1990	13	139,5
26	Цогтцэций	Үйл ажиллагаа явуулахгүй байгаа						
27	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар				1	1991	8	129,4
28	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар			1		1984	14	332
29	Мандал				1	1981	10	168
30	Сайхан				1	1981	10	151
31	Төв аймгийн Цагдаагийн газар				1	1974	20	348
32	Увс аймгийн Цагдаагийн газар		1			2002	10	182
33	Ховд аймгийн Цагдаагийн газар				1	1993	14	108
34	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар				1	2020	20	348
35	Хэнтий аймгийн Цагдаагийн газар				1	2002	9	220,7
	Нийт	8	8	6	18		429	10657

Д/д	Газар, хэлтэс	Эрүүлжүүлэх ерөөний тоо	Багтаамж /Хүний тоо/	Саатуулах ерөөний тоо	Багтаамж /Хүний тоо/	Тур саатуулах ерөөний тоо	Багтаамж /Хүний тоо/	Баривчлах шийтгэл эдлүүлэх ерөөний тоо	Багтаамж /Хүний тоо/
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс	2	28			2	10		
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс	4	30						
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс	4	32						
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв	2	99	9	122	4	47		
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	20	2	12	1	5		
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	4	1	3				
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс	3	12						
8	Архангай аймгийн Цагдаагийн газар	2	7	1	5			3	13
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	3	4	3	6			3	24
10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	1	4	2	6			6	22
11	Булган аймгийн Цагдаагийн газар	2	8	2	8				
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	3	5					3	6
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар	1	3	1	1	1	3	3	7
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	3	14	1	2			3	9
15	Шарын гол	2	6	1	2				
16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	1	4	2	8			4	13
17	Замын-Үүд	1	4	1	4	1	4		

18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар	2	13	3	23	1	9		
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар	2	7	2	10	1	5		
20	Завхан аймгийн Цагдаагийн газар	2	4	3	7	1	1	2	11
21	Тосонцэнгэл	1	2	1	2			2	19
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	2	4	2	17				
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар	2	4	1	4	1	4	9	4
24	Хархорин	1	1	1	2			2	12
25	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	3	16	1	6			3	16
26	Цогтцэций	<i>Үйл ажиллагаа явуулахгүй байгаа</i>							
27	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар	2	16					2	12
28	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	1	7	1	4			2	8
29	Мандал	1	2	2	8			2	8
30	Сайхан	1	4	1	4	1	4	2	15
31	Төв аймгийн Цагдаагийн газар	3	5	1	4			2	22
32	Увс аймгийн Цагдаагийн газар	3	9	2	13				
33	Ховд аймгийн Цагдаагийн газар	3	4	3	6			3	12
34	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	3	7	4	16			4	13
35	Хэнтий аймгийн Цагдаагийн газар	2	5	2	7			2	19
	Нийт	70	402	56	312	14	93	62	265

Д/д	Газар, хэлтэс	Эмчийн үзлэгийн өрөө	Эд зүйлс хадгалах өрөө	Бие засах өрөө /алба хаагчид/	Бие засах өрөө /эрэгтэй/	Бие засах өрөө /эмэгтэй/	Сургалтын өрөө	Гал тогооны өрөө	Тусгай төлбөрт өрөөтэй эсэх	Усанд оруулах өрөөтэй эсэх	Угаалга халдваргүйжилтийн өрөөтэй эсэх
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1		1	1			1		2	
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1	1	1	1	1	1			1	1
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1		1	1	1					1
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв	2	2	1	1	1	1			2	1
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1	2	1	1	1	1	1	1	1
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1	1	1	1	1			1	1
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1	1	1	1					
8	Архангай аймгийн Цагдаагийн газар				1					1	
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	1					1	1			



10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1		1		1	
11	Булган аймгийн Цагдаагийн газар	1	1		1		1			1	
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	1		1	1		1				
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар	1		1	1			1		1	
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	1	1	2	1	1	1	1		1	1
15	Шарын гол	1	1		1	1					
16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	1			1	1		1		1	1
17	Замын-Үүд	1		1	1	1					
18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1		1	
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар	1	1		1					1	
20	Завхан аймгийн Цагдаагийн газар	1			1	1	1	1		1	
21	Тосонцэнгэл	1	1	1	1	1		1		1	
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1				1	
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1		1	1
24	Хархорин	1	1	1	1	1	1	1		1	

<b>25</b>	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1	1	1		1	
<b>26</b>	Цогтцэций	<i>Үйл ажиллагаа явуулахгүй байгаа</i>									
<b>27</b>	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар	1			1			1		1	1
<b>28</b>	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1		1	1
<b>29</b>	Мандал	1	1	1	1	1	1	1		1	1
<b>30</b>	Сайхан	1	1		1	1	1	1		1	
<b>31</b>	Төв аймгийн Цагдаагийн газар	1	1	1						1	
<b>32</b>	Увс аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1		1	1		1	
<b>33</b>	Ховд аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1	1	1		1	1
<b>34</b>	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	1	2		1	1	1	1		1	1
<b>35</b>	Хэнтий аймгийн Цагдаагийн газар	1						1		1	
<b>Нийт</b>		<b>36</b>	<b>25</b>	<b>21</b>	<b>31</b>	<b>22</b>	<b>18</b>	<b>21</b>	<b>1</b>	<b>30</b>	<b>14</b>

Д/д	Газар, хэлтэс	Нөхцөл /MNS: 5527 2019/							
		Агааржуулалтын системтэй эсэх	Өрөөний дулаан стандартад нийцсэн эсэх	Өрөөний чийгшил стандартад нийцсэн эсэх	Нян устгах, ариутгах төхөөрөмжтэй эсэх	Агаар цэвэршүүлэгч байгаа эсэх	Үнэт эдлэл, бичиг баримт хадгалах шүүгээтэй эсэх	Хувцас хадгалах шүүгээтэй эсэх	Согтолтын зэрэг шалгах төхөөрөмжтэй эсэх
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1	1	1	1	1	1	1	1
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс		1	1			1	1	1
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1	1	1	1	1	1	1	1
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв	1	1	1	1	1	1	1	3
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1	1	1		1	1	1
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	1	1	1	1	1	1	1	1
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс					1	1	1	1
8	Архангай аймгийн Цагдаагийн газар		1			1		3	1
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	1	1		1		1		1
10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	1	1	1			1	1	1
11	Булган аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1	1	1	1
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
15	Шарын гол	1	1	1		1	1	1	1
16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	1			1	1		1	1

17	Замын-Үүд		1	1			1	1	1
18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1	1	1	1
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар	1		1	1	1	1	1	1
20	Завхан аймгийн Цагдаагийн газар	1				1	1	1	1
21	Тосонцэнгэл	1	1	1	1	1	1	1	
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1		1
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1			1	1
24	Хархорин	1	1	1	1	1	1	1	1
25	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1		1	1	1
26	Цогтцэций	<i>Үйл ажиллагаа явуулахгүй байгаа</i>							
27	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар	1	1		1	1	1	1	1
28	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
29	Мандал	1	1	1	1	1	1	1	1
30	Сайхан	1	1	1		1	1	1	1
31	Төв аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1		1	1	1
32	Увс аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
33	Ховд аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1	1	1	1
34	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1		1	1	1
35	Хэнтий аймгийн Цагдаагийн газар		1	1	1	1	1	1	1
	<b>Нийт</b>	<b>28</b>	<b>30</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>27</b>	<b>34</b>	<b>36</b>

Д/д	Газар, хэлтэс	Нөхцөл /MNS: 5527 2019/						
		Теле хяналт			Цэвэр, бохир ус		Угаалгын машин	Номхотгох цамц
		Дуу хоолой бичдэг эсэх	Бичлэг хадгалах төхөөрөмжийн багтаамж /тб/	Бичлэг хадгалах хугацаа	Төвийн нэгдсэн холболттой эсэх	Бойлууртай эсэх		
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс	11	4т/б	30	1		1	
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1	4т/б	19	1	1	1	1
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс	1	4т/б	60	1		1	
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв	6	4т/б	60		1	1	1
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	13	4т/б	20	1		1	
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс	7	4т/б	30	1		1	1
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс	2	4т/б	30	1		1	
8	Архангай аймгийн Цагдаагийн газар	1	4т/б	30	1	1	1	3
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	1	16т/б	37	1	1	1	
10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	23	8т/б	30	1	1	2	1
11	Булган аймгийн Цагдаагийн газар	1	10т/б	30	1	1	1	1
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	11	6т/б	30	1	1	1	1
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар		4т/б б	30	1	1	1	1
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	1	8т/б	30	1		1	1
15	Шарын гол	1	8т/б	30	1		1	

16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	1	16т/б	14	1	1	1	1
17	Замын-Үүд		10т/б	30	1		1	
18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар	1	4т/б	21	1	1	1	3
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар	1	4т/б	30	1	1	1	
20	Завхан аймгийн Цагдаагийн газар	16	1т/б	30	1	1	1	1
21	Тосонцэнгэл		1т/б	30	1	1		1
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	6	1т/б	30	1		1	
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар		10т/б	30	1	1	1	1
24	Хархорин	1	2т/б	30	1	1	1	1
25	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	1	10т/б	14	1	1	1	
26	Цогтцэций	<i>Үйл ажиллагаа явуулахгүй байгаа</i>						
27	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар	1	10т/б	30	1	1	1	1
28	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	1	8т/б	30	1	1	1	1
29	Мандал	1	4т/б	21	1	1	1	
30	Сайхан	1	4т/б	60	1	1	1	1
31	Төв аймгийн Цагдаагийн газар	1	4т/б	30	1	1	1	1
32	Увс аймгийн Цагдаагийн газар		5т/б	30	1		1	
33	Ховд аймгийн Цагдаагийн газар	1	12т/б	30	1	1	1	1
34	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	1	4т/б	30	1	1	1	3
35	Хэнтий аймгийн Цагдаагийн газар	15	1т/б	30			1	1
	<b>Нийт</b>	<b>129</b>			<b>32</b>	<b>23</b>	<b>34</b>	<b>27</b>



д/д	Газар, хэлтэс	Өрөөний тоо	Эрэгтэй өрөө	Эмэгтэй өрөө	Насанд хүрээгүй хүнийг тусгаарлах өрөө	Гал тогоо
1	Баянзүрх дүүргийн Цагдаагийн I хэлтэс					
2	Сонгино-Хайрхан дүүргийн Цагдаагийн I хэлтэс					
3	Хан-Уул дүүргийн Цагдаагийн I хэлтэс					
4	Эрүүлжүүлэх, саатуулах төв	6	4	1	1	1
5	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс					
6	Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс					
7	Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс					
8	Архангай аймгийн Цагдаагийн газар	1	1			
9	Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар	3	1	1	1	1
10	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	2	1	1		
11	Булган аймгийн Цагдаагийн газар	2	1	1		1
12	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар					
13	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар	1	1			1
14	Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар	1				1
15	Шарын гол	1				
16	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	2	1	1		
17	Замын-Үүд	2	1	1		
18	Дорнод аймгийн аймгийн Цагдаагийн газар	2	1	1	1	
19	Дундговь аймгийн Цагдаагийн газар	2	1	1		
20	Завхан аймгийн Цагдаагийн газар	5	1	1	1	1
21	Тосонцэнгэл	1	1			1
22	Орхон аймгийн Цагдаагийн газар	4	1	1	1	
23	Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар	1	1	1	1	1

24	Хархорин	1	1			
25	Өмнөговь аймгийн Цагдаагийн газар	1	1			1
26	Цогтцэций					
27	Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар					
28	Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар	1	1			
29	Мандал	2	2			
30	Сайхан					
31	Төв аймгийн Цагдаагийн газар	2	1	1		
32	Увс аймгийн Цагдаагийн газар	2	1	1	1	1
33	Ховд аймгийн Цагдаагийн газар	2	1	1		1
34	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	4	1	1	1	1
35	Хэнтий аймгийн Цагдаагийн газар	1		1		1
	<b>Нийт</b>	<b>52</b>	<b>28</b>	<b>16</b>	<b>8</b>	<b>13</b>

### Хууль эрх зүйн орчин

ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба нь ЦАТХ-ийн 11,12 дугаар зүйл, 13,14 дүгээр зүйлийн хамаарах чиг үүргүүдийг хэрэгжүүлэхдээ:

### Эрүүлжүүлэх байранд:

- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (ЗШШТХ);
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль (СУХХЭАЭТХ);
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албадан эрүүлжүүлэх” /код-629/ журам;
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартыг;

### Саатуулах байранд:

- ЦАТХ;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/192 дугаар тушаалаар баталсан “Саатуулах байрны дэглэм, журам”;
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албадан саатуулах” журам /код-622/-ыг тус тус баримтлан үйл ажиллагаа явуулдаг;


## СТАТИСТИК, ДҮН МЭДЭЭ<sup>72</sup>

Улсын хэмжээнд 2024 онд 7,710 хүн эрүүлжүүлж, 37,354 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 6446 буюу 45,5 хувиар, саатуулсан хүн 705 буюу 1,9 хувиар тус тус буурчээ. Эрүүлжүүлэгдсэн хүний 5,014 буюу 65 хувь нь Улаанбаатар хотод, 2,696 буюу 35 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн бол саатуулсан хүний 30,434 буюу 81,2 хувь нь Улаанбаатар хотод, 7,011 буюу 18,8 хувь нь орон нутагт байна.

Өмнөх онуудын статистик мэдээ нь тогтмол бууралттай байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд 2023 онд 12,880 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2022 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 54,901 этгээдэд эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлснээс даруй 78,5 хувиар буурчээ.

Харин 2021 онд 70,479 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2020 оны мөн үеэс 23,384 буюу 24,9 хувиар буурсан байна. Тодруулбал 2020 онд 93,863 хүн эрүүлжүүлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар  
улсын хэмжээнд эрүүлжүүлэгдсэн  
хүний тоон харьцуулалт



Улаанбаатар хотод эрүүлжүүлэгдсэн хүний тоо хөдөө орон нутгийнхтай харьцуулахад дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2024 онд эрүүлжүүлэгдсэн нийт хүний 65 хувь нь, 2023 онд эрүүлжүүлэгдсэн нийт хүний 70,5 хувь нь, 2022 онд эрүүлжүүлэгдэгсдийн 80,6 хувь нь, 2021 онд эрүүлжүүлэгдэгсдийн 78 хувь нь, 2020 онд эрүүлжүүлэгдэгсдийн 74,3 хувь нь тус тус Улаанбаатар хотод эрүүлжүүлэх үйлчилгээ авчээ.

<sup>72</sup> Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас ирүүлсэн статистик, дүн мэдээллээс



### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал

ЦЕГ-ын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын албаны харьяанд төв, орон нутгийн нийт 35 Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байр хамаардаг боловч Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа зогсоосон байдалтай байна. ЭШУС үндэсний ажиллагаа нь үйл ажиллагаагаа зогсоосноос бусад 34 байршлын 31-д нь 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийлээ. (Хүснэгт 7)

Үүнээс тайлант хугацаанд НЦУГ-ын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр болон Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Өвөрхангай аймгийн сум дундын Цагдаагийн хэлтэс, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр гэсэн нийт 16 байршилд ажиллав.

	2022 <sup>1</sup>	2023	2024
Эрүүлжүүлэх, саатуулах төв			2
Баянзүрх дүүргийн Цагдаагийн I			1
Сонгинохайрхан дүүргийн			1
Хан-Уул Цагдаагийн I хэлтэс			1
Багануур дүүргийн Цагдаагийн			1
Багахангай дүүргийн Цагдаагийн			1
Нагай дүүргийн Цагдаагийн			1
Архангай аймгийн Цагдаагийн			2
Баян-Өлгий аймгийн Цагдаагийн			1
Баянхонгор аймгийн Цагдаагийн			2
Булган аймгийн Цагдаагийн газар			2
Говь-Алтай аймгийн Цагдаагийн			2
Говьсүмбэр аймгийн Цагдаагийн			1
Дархан-Уул аймгийн Цагдаагийн			1
Шарын гол			
Дорноговь аймгийн Цагдаагийн			1
Замын-Үүд			
Дорнод аймгийн Цагдаагийн газар			1
Дундговь аймгийн Цагдаагийн			1
Завхан аймгийн Цагдаагийн газар			2
Төсөнцэнгэл			2
Орхон аймгийн Цагдаагийн газар			2
Өвөрхангай аймгийн Цагдаагийн			2
Хархорин			1
Өмнөговь аймгийн Цагдаагийн			1
Цогтцэций			1
Сүхбаатар аймгийн Цагдаагийн			1
Сэлэнгэ аймгийн Цагдаагийн			1
Мандаг			1
Сайхан			
Төв аймгийн Цагдаагийн газар			1
Увс аймгийн Цагдаагийн газар			1
Ховд аймгийн Цагдаагийн газар			1
Хөвсгөл аймгийн Цагдаагийн			2
Хэнтий аймгийн Цагдаагийн газар			1

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний удирдамжийн дагуу тухайн байршлуудад иргэдийн эрх чөлөөг түр хязгаарлах үйл ажиллагаанд хүний эрх, тэр дундаа эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцахаас ангид байх эрхийг хэрхэн хангаж ажиллаж буй эсэх, эрхийн зөрчил гарч болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шинжилгээ хийхэд Цагдаагийн байгууллагын албадан эрүүлжүүлэх ажиллагаа нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн С/18 дугаар тушаалаар баталсан согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үндэслэлээр албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүс (үйлчлүүлэгч)-т үйлчлэх “Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага” /MNS 5527:2019/ -ыг бүрэн хангаж хэрэгжихгүй байгаа нь дараах байдлаар тогтоогдоо:

## НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ ТӨВ

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Эрүүлжүүлэх, саатуулах төв нь дарга, ахлах байцаагч 2, жижүүрийн ахлах байцаагч 4, саатуулах байрны эмч 8, эрүүлжүүлэх байрны эмч 8, жижүүрийн цагдаа 49, цагдаа жолооч 2, бичиг хэргийн эрхлэгч 1, нярав 1, тогооч 3, сантехникч 4, үйлчлэгч 4, нийт 87 алба хаагчтай.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үндэслэлээр албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст үйлчлэх эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйлчлүүлэгчид үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавих шаардлагын дагуу эмчийн үзлэгийн, жижүүрийн, үйлчлүүлэгчийг насанд хүрсэн, насанд хүрээгүй, эрэгтэй, эмэгтэйгээр тусад нь байрлуулах өрөөнүүдтэй, модон ор (наар), гэмт хэрэг, зөрчилд сэрдэгдсэн, догшин хэрцгий авирлаж,

бусдын болон өөрийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах үйлдэл хийж болзошгүй үйлчлүүлэгчийг тусгаарлах, эд зүйлс, үйлчлүүлэгчийн хувцас хадгалах, тусгаарлах, эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчийн бие засах, усанд орох, угаалга, халдваргүйжүүлэлтийн гэсэн өрөөний зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.



Эрүүлжүүлэх байранд ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйц халуун, хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэгтэй, агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик агааржуулалтын системтэй байв. Мөн үйлчлүүлэгчийг байрлуулах өрөөний цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, дотор нь байгаа үйлчлүүлэгч харагдахуйц төмөр сараалжин хаалттай, гадна талаасаа гэрэлтүүлэх боломжтой унтраалга бүхий гэрэлтүүлэгтэй байлаа.

Бүртгэл, мэдээлэлтэй танилцахад тус төвийн эрүүлжүүлэх байранд цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг өдөр бүр, их цэвэрлэгээг 7 хоног тутамд, агаарын солилцоог өдөр бүр хийж, нян устгах, ариутгах төхөөрөмжөөр ариутгадаг, эрүүлжүүлэх ажиллагаанд хэрэглэсэн үйлчлүүлэгчийн нөмрөг, улавч, цагаан хэрэглэл болон бусад зөөлөн эдлэлийг тогтмол цэвэрлэж, угаалга ариутгал хийдэг байна.

Саатуулагдсан иргэдэд олгох хоолны цэсийг 7 хоногийн хугацаатай боловсруулж, Эрүүлжүүлэх, саатуулах төвийн даргын баталснаар саатуулах байрны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байгаа нь саатуулагдсан иргэдэд олгосон хоол, цайны бүртгэлээс тодорхой байлаа.

Эрүүлжүүлэх байрны эмч үйлчлүүлэгчийг хүлээн авахдаа хүргэж ирсэн цагдаагийн алба хаагч, иргэнийг байлцуулан эмчийг үзлэг хийж, согтолтын зэрэг, цусны даралт, зүрхний цохилт, амьсгалын тоо, үзлэгээр илэрсэн бусад онцлог шинж тэмдэг, шарх сорви, гэмтлийг тэмдэглэлд тусгаж бичсэн байв.

Эрүүлжүүлэх байр нь “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад заасан шаардлагатай эм, тариа, эмнэлгийн багаж хэрэгслээр хангагдсан, эмийн нөхөн хангалт, худалдан авах төсөв боломжтой гэсэн мэдээллийг хянахад заавал байвал зохилтой эмийн нэр, эмийн хэлбэр, шаардагдах тоо хэмжээндээ хүрч байлаа.



Тус төвд 2024 онд 20381 иргэн албадан эрүүлжүүлэгдэж, 17169 иргэн ЗШШТХ-ийн 5.2.1.1.2<sup>73</sup>-т заасан үндэслэлээр 24 цаг хүртэлх хугацаатай түр саатуулагдаж, 425 иргэн албадан<sup>74</sup> саатуулагджээ.

### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Эрүүлжүүлэх, саатуулах төв нь эмчийн үзлэгийн өрөөгүй учир эд зүйл, камерын хяналтын өрөө, үйлчлүүлэгчдийн биедээ авч яваа эд зүйлийг хадгалах сейф, эм эмнэлгийн хэрэгсэл, компьютер техник хангамжийн хэрэгслүүд байрлуулсан өрөөнд үйлчлүүлэгчдийг хүлээн авч үзлэг хийдэг;
- Хэд хэдэн бие засах өрөөний суултуур хагарсан;
- Бие засах өрөөг эрэгтэй, эмэгтэй гэж тусгаарласан боловч усанд орох шүршүүрийн хэсгийн нөхцөл байдал стандартад нийцээгүй;
- Өрөө болгонд чийгшил хэмжигч, модон ор байршуулаагүй;
- Үйлчлүүлэгчийн хувийн эд зүйл хадгалах шүүгээний түгжээ эвдэрсэн зэрэг нөхцөл байдал нь “Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага” /MNS 5527:2019/ стандартад нийцээгүй.

## **БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн Эрүүлжүүлэх байр нь цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтсүүдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гудамж талбай олон нийтийн газар согтуугаар танхайрсан, гэр бүл, ойр орчимдоо түгшүүр төрүүлдэг этгээдүүдийг эрүүлжүүлэх байранд хүлээн авч, хяналт тавин ажиллаж байна.

Эрүүлжүүлэх байр нь Нийгмийг аюулаас хамгаалах хэргийг эрхлэх яамны сайдын 1965 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 333 дугаар тушаалаар хуучнаар Найрамдлын районы Цагдан сэргийлэх хэлтсийн “Эрүүлжүүлэх, баривчлах байр” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ үеэс хойш тус байранд улсын төсвөөр ямар нэгэн томоохон хэмжээний засвар үйлчилгээ хийгдээгүй байна.

<sup>73</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Тавдугаар бүлэг, Эрх хязгаарлах арга хэмжээ, 5.2 дугаар зүйл. Хүнийг саатуулах, 1.2 дахь заалт: цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар;

<sup>74</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Саатуулах байрны дэглэм журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код – 622 (Алдабадан саатуулах) үндэслэлээр



Тус байр нь эрүүлжүүлэх 5, тусгаарлах 1, нийт 6 өрөөнд эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 3252 хүнийг тус эрүүлжүүлэх байранд 2024 онд хүлээн авч эрүүлжүүлэн, саатуулжээ.

**Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:**

- Байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийг журамд зааснаар шийдвэрлэж, агааржуулалтын нэгдсэн системийг тус байранд шинээр суурилуулсан гэх мэдээллийг хяналт шинжилгээний Ажлын хэсгийнхэнд өгсөн боловч тусгаарлах өрөөний чийгшил 18.6, үйлчлүүлэгчийн өрөөний чийгшил 10 хувьтай хэмжигдсэн нь MNS 5527:2019 стандартын 6.3.3-д заасан шаардлагыг хангаагүй;
- Үйлчлүүлэгчийн ариун цэврийн өрөөг эрэгтэй, эмэгтэй гэж тусгаарлаагүй, ялгах тэмдэггүй, усанд орох өрөө хаалтгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.6-д заасан шаардлагыг хангаагүй.

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

**Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:**



Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь 1 эмч, эрүүлжүүлэх, саатуулах байрны цагдаагийн 4 орон тоотой, дүүргийн Цагдаагийн хэлтсийн нэгдүгээр давхарт байрлан үйл ажиллагаа явуулж байна. Эрүүлжүүлэх, саатуулах байр нь 12 м2 талбайтай 4 хүн хүлээн авах

хүчин чадал бүхий тус бүр нь сараалжин төмөр хаалгатай 2 өрөөтэй ба 6,6 м2 хэмжээтэй ариун цэврийн өрөөний зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүлжүүлэх үйлчилгээнд хэрэглэх 3 ширхэг гудас, 10 ширхэг цагаан хэрэглэл, нөмрөгтэй. Үйлчлүүлсэн иргэн болгонд улавч хэрэглүүлдэг. Иргэд, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах дуу-дүрсний хяналтын 3 камерыг суурилуулж, жижүүрийн өрөөнөөс хяналтыг тавьдаг.



Саатуулах байранд 2024 онд 78 хүнийг хүлээн авсан бол Эрүүлжүүлэх байранд 20 хүнийг албадан эрүүлжүүлэх үйлчилгээг үзүүлсэн байна.

**Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:**

- Эмчийн өрөөнд агаар цэвэршүүлэгч байршуулаагүй нь MNS 5527:2019 стандартын 6.10-д заасан шаардлагыг хангаагүй;
- Тус хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны ачаалал бага байдаг тул 1 эмч нь өдрийн 8 цагаар ажиллаж, орой болон шөнийн цагаар Эрүүлжүүлэх, саатуулах байранд үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд дуудлагаар ирж үзлэг хийдэг, хүн эрүүлжүүлэгдэж байх үед ч эрүүлжүүлэх байранд хонож үүрэг гүйцэтгэдэг нь MNS 5527:2019 стандартын 8.10-д заасан үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, биеийн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, түргэн тусламж дуудах, эмнэлэгт хүргэх арга хэмжээг эрүүлжүүлэх байрны эмч зохион байгуулах гэсэн шаардлага хэрэгждэггүй, энэ нь үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлсэн;
- Албан үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч энгэрийн хяналтын камер ашиглахгүй байгаа нь алба хаагчийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэж болзошгүй байдлыг бий болгосон.

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

**Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:**



Тус Эрүүлжүүлэх, саатуулах байр нь Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн байранд эмч 4, цагдаа 4 гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Үйлчлүүлэгч байрлах нэг бүр нь 10,8 м<sup>2</sup> талбайтай 4 өрөө байгаа нь нэг хүнд 2 м<sup>2</sup>-ээс доошгүй талбай ногдох гэсэн, байрны чийгшил 50 хувьтай, халуун хүйтэн ус, бохирын системд холбогдсон, байгалийн гэрэл тусах, агаар сэлгэлт хийх нөхцөл

зэрэг үзүүлэлтүүд нь MNS 5527:2019 стандартыг хангасан байв. Налайх дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөр эрүүлжүүлэх байрны нөхцөл байдлыг стандартад

нийцүүлэн засварлаж, ариун цэврийн эрэгтэй, эмэгтэй өрөөнүүдийг бий болгожээ. Саатуулагдсан болон эрүүлжүүлэгдсэн хүн хэрэгцээтэй үедээ ундны усаар хангагдах боломжийг бүрдүүлж, ус цэвэршүүлэх төхөөрөмж байршуулсан, ариутгал, халдваргүйтгэлийг улирал тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвшсэн, эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааг 30 хоногийн бичлэг хадгалах хүчин чадал бүхий дуу-дүрсний хяналтын камераар хянаж, бичлэгийг хуулах, хадгалах, бүртгэл хөтлөх ажиллагааг зохих журмын дагуу явуулж хэвшсэнийг бичиг баримтад дүн шинжилгээ хийх хүрээнд баталгаажуулсан.



Эрүүлжүүлэх байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 385 хүнийг хүлээн авч эрүүлжүүлж, 217 хүнийг ЗШШТХ-ийн дагуу саатуулсан байна.

**Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:**

- Эрүүлжүүлэх, саатуулах байранд механик агааржуулалтын системгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 6.3.2 дахь заалтыг хангаагүй;
- Жижүүр эмчийн өрөөнд агаар цэвэршүүлэгч байршуулаагүй нь тус стандартын 6.10-д заасныг хангаагүй;
- Үйлчлүүлэгчийн усанд орох өрөөгүй байгаа нь стандартын 4.6-д заасан шаардлагыг хангаагүй.

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

**Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:**



Тус дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь 2015 онд ашиглалтад орсон, нийт 190 м<sup>2</sup> талбайтай, үйлчлүүлж байгаа иргэдийг байрлуулах 5, нийт 60 м<sup>2</sup> талбай бүхий 16 өрөөтэй бөгөөд “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартын дагуу нийт 28-30 иргэнийг хүлээн авах үйл

ажиллагааг 1 ахлах байцаагч, 4 эмч, 12 жижүүрийн цагдаа, 4 цагдаа жолооч, нийт 21 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй явуулж байна.



Тус байрны 16 өрөө бүрд дуу-дүрсний хяналтын камер суурилуулан иргэд, алба хаагчдын аюулгүй байдлыг ханган ажилладаг. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн дагуу 2024 онд 784 иргэн албадан эрүүлжүүлэгдэж, ЗШШТХ-ийн дагуу 6674 иргэн түр саатуулагджээ.

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчийн ариун цэврийн өрөө нэг дор байрлах ба зөвхөн модон хаалтаар тусгаарлагдсан, эмэгтэй ариун цэврийн өрөөний хаалга түгжээгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.6 буюу эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчид, алба хаагчдын зориулалтын бие засах өрөөтэй байх гэсэн стандартыг зөрчсөн;
- Өрөөний чийгшлийг хэмжихэд 21.8 хувийг зааж байсан нь уг стандартын 6.3.3-д заасан “Өрөөний дулаан нь хүйтний улиралд 180С, чийглэг нь 40-өөс 60 хувь байх” гэсэн стандартыг зөрчсөн;
- Жижүүрийн болон эмчийн өрөөнд агаар цэвэршүүлэгч байрлуулаагүй нь уг стандартын 6.10-д заасан “Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор жижүүрийн болон эмчийн үзлэгийн өрөөнд агаар цэвэршүүлэгчийг байрлуулна” гэсэн стандартыг зөрчсөн;
- Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ энгэрийн камер ашиглахгүй байгаа нь алба хаагч болон үйлчлүүлж буй иргэний аюулгүй байдалд эрсдэл учрах нөхцөлийг бүрдүүлсэн.

## ХАН-УУЛ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР

**Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:**



Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь 1985 онд баригдаж ашиглалтад орсон, хэлтсийн байрны В/1 давхарт одоог хүртэл 40 жилийн турш үйл ажиллагаа явуулж байна. ЦЕГ-ын даргын 2015 оны Б/284 дугаар тушаалаар батлагдсан орон тоогоор эмч-4, цагдаа-12, цагдаа жолооч-4 / одоогийн байдлаар жолооч 2 орон



тоо дутуу/, ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Б/285 дугаар тушаалаар эрүүлжүүлэх, саатуулах байр хариуцсан ахлах байцаагч 1 тус тус томилогдон, нийт 21 алба хаагч, 1 авто машинтайгаар 24 цагаар согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Тус цагдаагийн хэлтэс нь 2023 онд урсгал засвар хийж, үйлчлүүлэгчдийг байрлуулах 4, эмчийн үзлэгийн 1, эд зүйлс, хувцас хадгалах 1, эрүүлжүүлэгдэх иргэдийг хүлээн авах хэсэг 1, алба хаагчдын ариун цэврийн 1, үйлчлүүлэгчдийн ариун цэврийн 1, алба хаагчдын хувцас солих 1, угаалга халдваргүйтгэлийн 1, сургалтын 1, тусгай хэрэгслийн агуулах 2, нийт 16 өрөө тасалгааг ашиглалтад оруулж, хяналтын 24 теле камераар хангагджээ.

Гудамж талбай, олон нийтийн газарт согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн болон ахуйн хүрээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан нийт 196 хүнийг албадан эрүүлжүүлж, 2603 иргэнийг түр саатуулах арга хэмжээг хуулийн дагуу явуулжээ.

### **Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:**

- Хэмжигч төхөөрөмжөөр өрөөний чийгшлийн түвшнийг хэмжихэд 19,5 хувийг зааж байсан нь MNS 5527:2019 стандартын 6.3.3-д заасан “Өрөөний дулаан нь хүйтний улиралд 180С-ээс доошгүй, чийглэг нь 40-60 хувь байх” стандартыг хангаагүй;
- Үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөөг эрэгтэй болон эмэгтэй гэж тусгаарлаагүй, усанд орох хэсэг хаалтгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.6-д заасан шаардлагыг хангаагүй.



## АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ, БАРИВЧЛАХ БАЙР

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь эрүүлжүүлэх, саатуулах, захиргааны журмаар баривчлах шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн Эрүүлжүүлэх, саатуулах байрны 2 эмч, 4 жижүүрийн цагдаагийн бүрэлдэхүүнтэй 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

ЭШУС үндэсний ажиллагааны ажлын хэсэг тус байранд ажиллах үед Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь Цагдаагийн хэлтсийн байрны доод хонгилд байрлаж байсан ба эрэгтэй, эмэгтэй эрүүлжүүлэх тус бүр 1, эрэгтэй баривчлах 2, эмэгтэй баривчлах 1, албадан саатуулах 1, жижүүрийн 1, ариун цэврийн 1, нийт 8 өрөөний зохион байгуулалттай байв.



Эрүүлжүүлэх, саатуулах байрны шинэ барилгын ажил 2022 оны 10 дугаар сараас эхэлсэн бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 20-ны байдлаар барилгын ажил бүрэн дуусаж, өрөө, тасалгаануудыг хаягжуулах, стандартад нийцэж байгаа эсэхийг үзэж шалгах, цэвэрлэгээ үйлчилгээний ажил явагдаж, нүүн орох бэлтгэл ажил эхэлсэн байсан тул эрүүлжүүлэх, саатуулах ажиллагааг “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад нийцүүлэн явуулах орчин нөхцөл бүрэн хангагдсан хэмээн дүгнэсэн.

### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Тус аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд насанд хүрээгүй хүнийг байрлуулах өрөө байхгүй байсан боловч шинээр ашиглалтад оруулсан байранд тухайлсан өрөөний зохион байгуулалтыг хийсэн.

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Тус аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр нь нийт 129 м2 талбай бүхий албадан саатуулах, эрүүлжүүлэх 3, ариун цэврийн 1, баривчлагдсан этгээдүүд амрах 1, эмч нарын 1, жижүүрийн цагдаа нарын 1, баривчлагдсан этгээдүүдийн дамждаг 2, эмэгтэй 1, тусгаарлах 1, хүлээн авах 1, нийт 12 өрөөний зохион байгуулалттай. Эрүүлжүүлэх өрөөнд 6, албадан саатуулах өрөөнд 2, баривчлах шийтгэл эдлүүлэх өрөөнд 16 хүн хүлээн авах багтаамжтай. Тус байр нь 2006 онд эрүүлжүүлэх байрны зориулалтаар баригдсан боловч одоогоор уг байранд эрүүлжүүлэх, албадан саатуулах,

баривчлах гэсэн гурван үйл ажиллагааг хамтад нь явуулж байна.

Баривчлагдсан этгээдүүдэд олгодог хоолны илчлэгийг улирал бүр мэргэжлийн байгууллагаар шалгуулж, журамд заасны дагуу 2800 ккал илчлэг бүхий хоолоор хангаж ажиллаж буйг баримт бичгийн хөтлөлт, тэмдэглэлтэй танилцах хүрээнд баталгаажуулсан.

Эрүүлжүүлэх байранд мөрдөгдөх MNS 5527:2019 стандартыг хангасан нөхцөл байдалд хэмжилт, хяналт шинжилгээ хийхэд ердийн болон механик агааржуулалтын системтэй, өрөөний дулаан болон чийгшил хэвийн хэмжээнд, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж хэвшсэн нь тогтоогдсон.



Тус эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 111 хүнийг хүлээн авч эрүүлжүүлсэн бол 430 хүнийг ЗШШТХ-иар албадан саатуулж, 711 хүнд захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлсэн байна.

## Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Нэг байранд эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэл эдлүүлэх үйл ажиллагаа зэрэг явагдаж байгаа учир өрөөний багтаамжийг хэтрүүлэн, баривчлах шийтгэл эдэлж байгаа 14 иргэнийг 1 өрөөнд байрлуулсан нь MNS 5527:2019 стандартын 6.3.4-т заасан шаардлагыг зөрчсөн;
- Жижүүрийн эмч үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, биеийн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээр уг стандартын 8.10-т заасан боловч уг эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан байв.

## **БУЛГАН АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Булган аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр нь цагдаагийн газрын хонгилын давхарт байрладаг ба 8 хүний багтаамжтай эрүүлжүүлэх 2, 4 хүний багтаамжтай саатуулах 2, эмчийн үзлэгийн, эд зүйл хадгалах, алба хаагчдын бие засах, үйлчлүүлэгчдийн бие засах, сургалтын зориулалттай өрөө тус бүр 1 гэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.

Агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик агааржуулалтын системээр хангагдсан, өрөөний дулааныг хэмжихэд 25.20С, чийгшил нь 54.9 хувийг зааж байсан нь MNS 5527:2019 стандартад нийцэж байлаа.



Тус эрүүлжүүлэх байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 122 хүнийг хүлээн авч эрүүлжүүлж, 212 хүнийг хуулийн дагуу түр саатуулах арга хэмжээ авсан байна.

## Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Үйлчлүүлэгчдэд зориулсан эрэгтэй, эмэгтэй ангиллын бие засах өрөөгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.6-д заасан шаардлагыг хангаагүй;
- Үйлчлүүлэгчийг усанд оруулах өрөөгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.8-д заасан шаардлагыг хангаагүй;
- Угаалга, халдваргүйтгэлийн өрөөгүй байгаа нь уг стандартын 4.9-д заасан шаардлагад нийцээгүй;
- Эрүүлжүүлэх ажиллагаанд хэрэглэх наар буюу модон ор хуучирч муудсан, зарим хэсгээрээ илжирсэн нөхцөл тогтоогдсон ба энэ нь уг стандартын 6.3.5-д заасан эрүүл ахуйн шаардлага хангахуйц шалтай, модон ор /наар/, хөнжил, гудас, цагаан хэрэглэл, нөмрөгтэй байх шаардлагыг хангаагүй;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн хэсэгт зайлшгүй байх шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 5 нэр төрөл нь хугацаа дууссан зөрчил тогтоогдсон.

## **ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**


### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Эрүүлжүүлэх саатуулах байр нь цагдаагийн газрын 2 дугаар байр буюу Дотоодын цэргийн 214 дүгээр тусгай салбарын хашаанд эрүүлжүүлэх 3, баривчлах 2 өрөө, захиргааны журмаар албадан саатуулах 1, жижүүрийн 1, эмчийн 1, эмчийн үзлэгийн 1, сургалтын /номын сан/ 1, алба хаагч нарын бие засах 1, саатуулагдсан хүмүүсийн бие засах /усанд орох/ 1, нийт 12 өрөөний зохион

байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээнд тавигдах MNS 5527:2019 стандарт орчин нөхцөлийн нийцэж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээгээр тус байр нь ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйц агааржуулалтын системтэй, нян ариутгагч төхөөрөмж, үнэт зүйл, баримт бичиг хадгалах шүүгээ зэрэг зайлшгүй байх шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Эрүүлжүүлэх, саатуулах байр нь дарга-эмч 1, эмч 3, жижүүрийн цагдаа 4 гэсэн орон тоотой бөгөөд 1 эмч, 1 цагдаа жижүүрийн бүрэлдэхүүнтэйгээр эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүмүүст үзүүлэх үйлчилгээг өдөр тутамд гүйцэтгэж байна.



Тус Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 203 хүнийг хүлээн авч эрүүлжүүлсэн бол 156 хүнд захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлсэн байна.

Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Саатуулагдсан хүмүүсийн усанд орох болон бие засах өрөөг тусгаарлаагүй, хаалга түгжээгүй;
- Эрүүлжүүлэх өрөөний шалны паркет илжирч муудсан;
- Өрөөний дулаан 160С, чийглэг нь 21 хувьтай байгаа нь Эрүүлжүүлэх байрны стандартад нийцээгүй;
- Барилгын хана, таазны шавардлага ховхорч, элэгдсэн; Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан.

## ЗАВХАН АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Завхан аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр нь хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга-эмч, жижүүр цагдаа гэсэн бүрэлдэхүүнтэй, Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь 1979 онд 100 тонны багтаамжтай агуулахын зориулалтаар баригдсан чулуун ханатай барилгыг 2006 онд засварлан

Байр нь 275.52м2 талбайтай ба эрүүлжүүлэх эрэгтэй, эмэгтэй тус бүр 1, эрэгтэй саатуулах 2, эмэгтэй саатуулах 1, баривчлах өрөө эрэгтэй, эмэгтэй тус бүр 1, эрэгтэй, эмэгтэй бие засах тус бүр 1 өрөөний хүчин чадалтай.





Эрүүлжүүлэх байранд 2024 онд нийт 26 хүнийг хүлээн авсан бол саатуулах байранд 2024 онд 184 хүн хүлээн авчээ. Мөн Баривчлах байранд 2024 онд 229 хүнийг хүлээн авсан байна.

### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Өрөөний дулаан 16°C, чийглэг нь 30 хувьтай байгаа нь Эрүүлжүүлэх байрны стандартад нийцээгүй;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн хэсэгт зайлшгүй байх шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 5 нэр төрөл нь хугацаа дууссан.

### **ЗАВХАН АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

#### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:




Завхан аймгийн Цагдаагийн газрын Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр нь жижүүр эмч 1, жижүүр цагдаа 3 гэсэн бүрэлдэхүүнтэйгээр хэв журам сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад орсон.

Тус байр нь 146 м<sup>2</sup> талбайтай, эмчийн үзлэгийн, жижүүр цагдаагийн, эрэгтэй эрүүлжүүлэх, эрэгтэй саатуулах, эрэгтэй баривчлах, насанд хүрээгүй хүнийг баривчлах, эд зүйл хадгалах, гал тогооны, усанд орох, бие засах тус бүр 1, нийт 9 өрөөний зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүлжүүлэх байранд 2024 онд 14 хүн хүлээн авч эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлсэн бол албадан саатуулах байранд 78 хүнийг саатуулсан байна. ЗТХ-иар баривчлах шийтгэл оногдуулсан 116 иргэнд баривчлах шийтгэл эдлүүлжээ.





### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Өрөөний дулаан 20°C хэмтэй байсан боловч чийглэг нь 69 хувьтай байгаа нь Эрүүлжүүлэх байрны стандартад нийцээгүй;
- Барилгын ерөнхий бүтцэд суулт өгч, өрөөнүүдийн хана, таазны уулзвар хэсгээр хөндлөн чиглэлтэй хагарал үүсгэсэн;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн хэсэгт зайлшгүй байх шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 5 нэр төрөл нь хугацаа дууссан;
- Эмчийн үзлэгийн өрөөнд үзлэг хийх үеийн хаалт байхгүй.

### **ОРХОН АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

#### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Аймгийн Цагдаагийн газар нь албадан эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааг ээлжийн ахлах эмч-2, эрүүлжүүлэх байрны цагдаа-4 гэсэн бүрэлдэхүүнтэй, суурин болон гар станц-1, телекамерын системтэйгээр үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Эрүүлжүүлэх, саатуулах байр нь эмч, эмчийн үзлэгийн, үйлчлүүлэгч иргэдийг хүлээн авах, жижүүрийн, ариун цэврийн, усанд орох өрөө тус бүр 1, иргэнийг эрүүлжүүлэх 2, саатуулах 2 өрөөний зохион байгуулалттай. Эрүүлжүүлэх байранд өдөрт 12, Саатуулах байранд 16 хүн хүлээн хүчин чадалтай.

Эрүүлжүүлэх байранд ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйцаар халуун, хүйтэн усны холболт, агаарын солилцоог хангах механик болон агааржуулалтын системтэй бөгөөд хэмжилтээр эрүүлжүүлэх, саатуулах байрны өрөөний дулаан 210C, чийгшил 53.5 хувийг зааж байсан нь MNS 5527:2019 стандартыг хангаж байлаа.



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/20 дугаартай тушаал, ЦЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Орхон аймаг дахь Цагдаагийн газрын баривчлах чиг үүргийг ШШГ байгууллагад шилжүүлсэн байна.

Эрүүлжүүлэх байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 57 хүнийг хүлээн авч эрүүлжүүлж, Саатуулах байранд 779 хүнийг хуулийн дагуу түр саатуулжээ.

### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Үйлчлүүлэгчдэд зориулсан эрэгтэй, эмэгтэй ангиллын бие засах өрөөгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.6-д заасан шаардлагыг хангаагүй;
- Угаалга, халдваргүйтгэлийн өрөө байхгүй байгаа нь MNS 5527:2019 стандартын 4.9-д заасан шаардлагыг хангаагүй;
- Эрүүлжүүлэх ажиллагаанд хэрэглэх наар буюу модон ор хуучирч муудсан, зарим хэсгээрээ илжирсэн нөхцөл тогтоогдсон ба энэ нь уг стандартын 6.3.5-д заасан эрүүл ахуйн шаардлага хангахуйц шалтай, модон ор /наар/, хөнжил, гудас, цагаан хэрэглэл, нөмрөгтэй байх шаардлагыг хангаагүй;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн хэсэгт зайлшгүй байх шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 10 нэр төрөл нь хугацаа дууссан зөрчил тогтоогдсон.

### **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

#### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Өвөрхангай аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байр нь 1982 онд баригдсан байгууламжид эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэл эдлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна. Тус байр нь Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээнд баримтлах MNS 5527:2019 стандартын дагуу 4

хүний багтаамжтай эрүүлжүүлэх 11, 4 хүний багтаамжтай саатуулах 1, 4 хүний багтаамжтай тусгаарлах 1, 36 хүний багтаамжтай баривчлах шийтгэл эдлүүлэх 9, эмчийн үзлэгийн 1, эд зүйл хадгалах 1, алба хаагчдад зориулсан ариун цэврийн 1, эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн тус бүр 1, сургалтын, гал тогооны, усанд оруулах, угаалга, халдваргүйтгэлийн тус бүр 1 өрөөтэй.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны нөхцөл MNS 5527:2019 стандартыг хангаж буй эсэхэд хэмжилт, хяналт шинжилгээ хийхэд уг стандартын 6.1-д заасан эрүүлжүүлэх байранд ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахуйц агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик агааржуулалтын системтэй, баривчлах байрны өрөө бүр ариун цэврийн өрөөтэй, цэвэр бохир усны төвийн нэгдсэн холболттой, 30 өдрийн хугацаатай бичлэг хадгалах багтаамж бүхий дуу-дүрсний бичлэгийн камераар хяналт тавьдаг, эрүүлжүүлэх, тусгаарлах байранд халдваргүйтгэлийн бодис бүхий чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр, их цэвэрлэгээг долоо хоног тутамд хийж хэвшсэн зэрэг нөхцөл байдлыг тэмдэглэл хөтлөлт, баримтжуулалтаар баталгаажуулсан. Саатуулагдсан иргэдэд олгох хоолны цэсийг 7 хоногийн хугацаатай боловсруулж, саатуулах байрны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байгаа олгосон хоол, цайны бүртгэлээс тодорхой байлаа.



Тус эрүүлжүүлэх байранд 2024 онд архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 7 хүнийг хүлээн авч эрүүлжүүлж, 86 хүнийг ЗШШТХ-ийн дагуу албадан саатуулж, 174 хүнд захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлжээ.

### Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Эрүүлжүүлэх өрөөний дулааныг хэмжихэд 160С байсан нь MNS 5527:2019 стандартын 6.3.3-т заасан шаардлагыг хангаагүй;
- Жижүүрийн эмч үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, биеийн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээр уг стандартын 8.10-т заасан боловч Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан байв.

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ, БАРИВЧЛАХ БАЙР

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Өвөрхангай аймгийн Хархорин сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсгийн дарга, эрүүлжүүлэх саатуулах баривчлах байрны 3 эмч, эрүүлжүүлэх, саатуулах баривчлах

байрны 4 жижүүр цагдаагийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн хэлтсийн албаны байр нь 2010 оны 08 дугаар сард ашиглалтад орсон ба уг барилга нь зориулалтын саатуулах, баривчлах байргүй баригдсан бөгөөд тухайн үеийн удирдлагын шийдвэрээр байрны нэг давхрын урд жигүүрт эрүүлжүүлэх, баривчлах байрыг шинээр тохижуулан засварлан байгуулжээ.

Байр нь нийт 53.5 м.кв талбайтай, эрүүлжүүлэх, саатуулах 2, хувцас эд зүйл хадгалах 1, эрэгтэй баривчлах 1, эмэгтэй баривчлах 1, тусгаарлалтын 1, ариун цэврийн 1 өрөөний зохион байгуулалттай, төвлөрсөн халаалт, цэвэр бохир усны системд холбогдсон, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, 2021 онд IP загварын 5 ширхэг хяналтын камер суурилуулан байрны үйл ажиллагааг тогтмол хянан ажиллаж байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (ШШГТХ)-ийн 147 дугаар зүйлийн 147.1, Баривчлах байрны дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.4-т заасны дагуу эмэгтэй хүнийг байрлуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эмч нарын 14.8 м.кв бүхий өрөөг эмэгтэй - баривчлах өрөө болгон 4 хүн авах хүлээн авах боломжийг бүрдүүлжээ.

Сум дундын шүүхийн шийтгэврээр тус байранд 2024 онд 105 2023 онд 377 иргэн баривчлах шийтгэл эдэлсэн бол 30 хүн түр саатуулагдсан байна.

## Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:

- Эрүүлжүүлэх өрөөний модон орнуудын /наар/ хавтан цуурсан, илжирсэн;
- Усанд орох шүршүүр эвдэрсэн;
- Өрөөний дулаан 200С боловч, агаарын чийгшил нь 33 хувьтай байсан нь MNS 5527:2019 стандартын 6.3.3-т заасан шаардлагыг хангаагүй;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн үйлчилгээнд хэрэглэж буй үйлчлүүлэгчдийн цусан дахь сахар хэмжих төхөөрөмжийн тестийн хугацаа дууссан.

## **ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ БАЙР**

### Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх үеийн ерөнхий байдал:



Тус аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр нь 2020 онд ашиглалтад орсон байранд 5 хүнийг нэг дор хүлээн авах эрүүлжүүлэх 2, 16 хүнийг саатуулах багтаамжтай 5 өрөө, баривчлах шийтгэл эдлүүлэх 11 хүний багтаамжтай 4 өрөөний зохион байгуулалттай эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэл эдлүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байр нь эмчийн үзлэгийн 1, эд зүйлс хадгалах 2, алба хаагчдад зориулсан ариун цэврийн, эрэгтэй болон эмэгтэй үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн, усанд оруулах, ариутгал, халдваргүйтгэл хийх зориулалтын тус бүр 1 өрөөтэй. Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний шаардлагыг хангасан байдалд хяналт шинжилгээ хийхэд эрүүлжүүлэх, саатуулах байранд ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйцаар халуун, хүйтэн усны хангамж, бохирын системийг шийдсэн ба, байгалийн гэрэлтүүлэгтэй, агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик агааржуулалттай байлаа. Хэмжилтээр өрөөний дулаан 19.2 0С, чийгшил 60 хувийг зааж байсан нь мөрдөгдөх стандартыг бүрэн хангаж байв.





Тус эрүүлжүүлэх байранд 2024 онд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 17 хүнийг СУХХЭАЭТХ-ийн дагуу хүлээн авч эрүүлжүүлж, 526 хүнийг ЗШШТХ-ийн дагуу албадан саатуулж, 245 хүнд захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлүүлжээ.

### **Хяналт шинжилгээгээр тогтоогдсон, цаашид анхаарах, сайжруулах нөхцөл байдал:**

- Эрүүлжүүлэх ажиллагаанд хэрэглэх наар буюу модон ор хуучирч муудсан, зарим хэсгээрээ илжирсэн нөхцөл тогтоогдсон ба энэ нь уг стандартын 6.3.5-д заасан эрүүл ахуйн шаардлага хангахуйц шалтай, модон ор /наар/, хөнжил, гудас, цагаан хэрэглэл, нөмрөгтэй байх шаардлагыг хангаагүй;
- Эрүүлжүүлэх байрны эмнэлгийн хэсэгт зайлшгүй байх шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 5 нэр төрөл нь хугацаа дууссан зөрчил тогтоогдсон.

## **ХУУЛИАР ҮЛ ХЯЗГААРЛАГДАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭГЭЭР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ:**

### **Албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн эрхийн хэрэгжилт:**

НЦУГ-ын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, дүүргүүдийн Цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр, Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг болон Өвөрхангай аймгийн Хар хорин сумын сум дундын, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх байранд албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн хуулиар хязгаарлагдаагүй эрхийн хэрэгжилтийг асуумжийн аргаар тодорхойлоход дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

НЦУГ-ын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, дүүргүүдийн Цагдаагийн газар, хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр, Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг болон Өвөрхангай аймгийн Хар хорин сумын сум дундын, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн 53 хүнтэй ганцаарчлан уулзалт хийж, эрхийн зөрчлийг тогтоох асуумж авахад “Эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч Тантай зүй бусаар харьцсан уу?” гэх асуултад 37,5 хувь буюу 20 хүн зүй бус харьцаанд өртсөн гэж, алба хаагчид хэрхэн зүй бус харьцсан талаар тодруулахад “биед хүрч, дураараа юм хурааж авсан”, “харааж зүхэж, ялтан шиг харьцсан” гэж дийлэнх нь хариулжээ. Харин хамт эрүүлжүүлэгдсэн иргэдийн зүгээс хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалт ирдэг эсэх талаар тодруулахад 28,6 хувь буюу 15 хүн тийм харьцаанд өртдөг гэсэн байна.




## Зөрчлийн тухайн хуулиар баривчлах шийтгэл эдэлж буй хүмүүсийн эрхийн хэрэгжилт:

Хяналт шинжилгээ хийсэн эдгээр 16 байршилд ЗтХ-иар баривчлах шийтгэл эдэлж буй хүмүүсийн хуулиар хязгаарлагдаагүй эрхийн хэрэгжилтийг асуумжийн аргаар тодорхойлоход дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:


- Баривчлах шийтгэл эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авсан эсэх талаарх асуултад хариулсан 114 иргэний 60 нь “хангалттай” мэдээлэл авсан гэж, 54 нь “бүрэн дүүрэн мэдээллээр хангагдаагүй” гэж;




- Баривчлах байрны захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар ямарваа байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрхээ эдлэх боломжоор хангагдаж байгаа эсэх талаарх асуултад 105 хариулт ирснээс 43 нь “хангагдаж байгаа” гэсэн боловч 62 буюу 59 хувь нь “хангагдаж чадаагүй” гэж;




- Өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг тодруулсан асуултад 103 иргэн оролцсоны 55 буюу 53,3 хувь нь “өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлж чадахгүй байгаа” гэж;




- Эмнэлгийн тусламж авах эрхийн хэрэгжилтийн асуултад 91 иргэн оролцсоны 40 буюу 43,9 хувь нь “хангалттай авч чадахгүй байгаа” гэж;




- Баривчлах байрны алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах эрхээ эдэлж чадаж байгаа эсэхийг тодруулахад 105 иргэний 52 нь “чадахгүй байгаа” гэж;




- Шашны зан үйлээ үйлдэж чадаж байгаа эсэхийг тодруулахад 88 иргэний 61 буюу 69,3 хувь нь “чадахгүй байгаа” гэж;



- Долоо хоногт 1 удаа 1 цаг хүртэл хугацаагаар бусадтай уулзалт хийх, нэг удаа илгээмж авах, нэг удаа захидал илгээх эрхээ эдэлж чадаж байгаа эсэхийг тодруулахад 130 хүний 40 буюу 30,7 хувь нь “эл эрхээ эдэлж чадахгүй байгаа” гэж;



- Баривчлах байрны алба хаагчийн зүгээс зүй бус харьцаанд өртөж байсан эсэхийг тодруулахад 126 иргэний 80 нь өртөж байгаагүй гэж хариулсан нь сайшаалтай боловч 36,5 хувь буюу 46 нь “алба хаагчдын зүгээс зүй бус харьцаанд өртөж байсан” гэж тус тус хариулжээ.



### **Алба хаагчдын зүгээс ямар байдлаар зүй бус харьцаанд өртсөн талаарх тодруулга асуултад:**

- Архангай аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэн “Харилцаа хандлагыг өөрчлөх хэрэгтэй. Харилцаанаас харилцаа үүсдэг” гэж, Баянхонгор аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэд “Өнгө мөнгөтэй, танил талаа харж ялгаварлаж харьцдаг”, “Ялгавартай харьцдаг”, “Ялтан шиг харьцдаг байдлаа болих” гэж; Говь-Алтай аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэн “Төрийн албан хаагч байж гайгүй бие хаатай хүнтэй эвээр, дорой хүнтэй дээрэлхүү харьцаж байна” гэж, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэн “Бос, гүй, арчаагүй архичин минь гэх мэтээр нэр төрд минь халдаж байсан” гэж тус тус хариулсан байна.

### **Баривчлах байрны ахуй нөхцөлтэй холбоотой санал хүсэлтийг иргэдээс авахад:**

- Орхон аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэд “Агааржуулалтыг шийдэх. Ариун цэврийн өрөөг тусад нь шийдэх”, “Баривчлах байрны хэмжээ арай л жижиг байна. Өдөрт 3 удаа салхинд гаргаж байх”, “Агааржуулалтгүй байна. Хоол маш муу байна, бид бие засах өрөөний хажууд унтаж байна” гэж; Завхан аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэд “Хоол үнэхээр муу. Бие засах өрөө нь байр дотроо болохоор үнэр маш их, бохир, заваан байдаг”, “Хоол нь арай биш ээ, бид нохойноос доор хоол идэж байна” гэж; Булган аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэн “Хоолондоо анхаарах. Баривчилгаанд байгаа хүмүүсийн бие засах өрөөг гадна талд гаргаж, нийтийн болгох” гэж; Баянхонгор аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэд “Агааржуулалт муу, хүний тоо их, унтах ор хүрэлцэхгүй, усанд орох газаргүй”, “Агааржуулалт муу, цаг тухайд нь салхилуулж баймаар байна. Маш бүгчим байна”, “Усанд орох газар байхгүй” гэж; Архангай аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй хүн “Агааржуулалт муу учраас орж ирж байгаа иргэд эрүүл мэндээрээ хохирч байна” гэж тус бүрийн баривчлах шийтгэл эдэлж буй нөхцөл байдлыг бичсэн.

### **Албадан саатуулагдсан хүмүүсийн эрхийн хэрэгжилт:**

Хяналт шинжилгээ хийсэн эдгээр 16 байршлын түр саатуулах байранд албадан саатуулагдсан хүмүүсийн хуулиар хязгаарлагдаагүй эрхийн хэрэгжилтийг асуумжийн аргаар тодорхойлоход дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

- Саатуулагдсан хүмүүст 6 цаг саатуулсан тухай тэдгээрийн гэр бүлийн 18 насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, ойр дотнын хүнд мэдэгдсэн эсэх талаар тодруулахад 53 хүний 36-ийн гэр бүлд мэдэгдсэн боловч 12 хүний гэр бүлд мэдэгдээгүй гэж хариулсан ба 3 хүн тэдний гэр бүлийнхэнд мэдэгдсэн эсэх талаар мэдэхгүй байна гэж;
- Түр саатуулагдаж байх хугацаанд бусад хүний зүгээс болон албан хаагчдын зүгээс эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа эсэх асуултад тус бүр 58 хүн оролцож, тэдний 4 нь алба хаагчдын зүгээс тухайн эрхийн зөрчилд өртдөг гэж, 2 нь бусад хүний зүгээс эрхийн зөрчилд өртдөг гэж хариулсан.


**Түр саатуулах байранд саатуулагдах хугацаанд ажигласан, сайжруулах аливаа асуудалд санал өгөх боломжийг тэдэнд олгоход:**

Говь-Алтай аймгийн Цагдаагийн хэлтэст албадан саатуулагдсан иргэн “Эмэгтэй хүний гоо сайхны хэрэгслүүдийг устгамааргүй байна” гэж; Өвөрхангай аймгийн Цагдаагийн хэлтэст саатуулагдсан иргэд “Хоолыг сайжруулах хэрэгтэй”, “Саатуулах байрны номын санг баяжуулах. Хоолны хуваариа баримталж ажилламаар байна” гэж бичжээ.


**Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүсийн эрхийн хэрэгжилт:**

Хяналт шинжилгээ хийсэн эдгээр 16 байршилд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-д заасан цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүсийн хуулиар хязгаарлагдаагүй эрхийн хэрэгжилтийг асуумжийн аргаар тодорхойлоход дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

- Мөрдөгч, прокурор, бусад хүний зүгээс эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, ялгаварлан гадуурхах үйлдэл гаргасан эсэх талаар тодруулахад 172 хүний 47 буюу 27,3 хувь нь ийм үйлдэлд өртсөн гэж;



- Ямар хэлбэрийн үйлдэлд өртсөн талаар Баянхонгор аймгийн баривчлах байранд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан иргэд “Эрүүгийн мөрдөгч хэл амаар доромжилж, өшиглөж, зодох аргаар худал мэдүүлэг авсан. Тухайн үед нь прокурорт мэдэгдсэн”, “Хэсгийн төлөөлөгч дэслэгч Ө нь энэ хэргийн талаар зодож, дарамталж мэдүүлэг авсан. АТГ энэ асуудал шалгагдаж байгаа ч одоо болтол надад хариу ирүүлээгүй байна” гэж; Орхон аймгийн баривчлах байранд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан иргэд “Ялгаварлаж ханддаг, үл тоомсорлодог” гэж тус тус бичжээ;
- Тэдэнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийнх нь талаар мөрдөгч, прокурор тайлбарлаж, мэдээлэл өгсөн эсэх талаар тодруулахад 52 хүний 35 буюу 67,3 хувь нь энэ эрхийнхээ талаар мэдээлэл аваагүй гэж;



- Мөрдөгч, прокурорт ямар нэгэн гомдол бий эсэх талаар лавлахад 53 иргэний 27 буюу 50,9 хувь нь “Тийм” гээд тэдний зарим нь тодруулан бичжээ. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Цагдаагийн хэлтэст цагдан хоригдож буй иргэд “Прокурор У, мөрдөгч А нар удаа дараа ирж, хийгээгүй хэрэг тулгаж, дарамталж байна”, “Дэслэгч Б санал хүсэлт огт авдаггүй. Юм асуухад надад хамаагүй гэдэг. Төлөөлөгч Х хүсэлт бичиж өгөхөд түүнийг уншчихаад хэрэгт хамт татагдсан хүнд хэлж, хагаралдуулдаг. Хавтаст хэрэгтэй танилцах хүсэлт 10 удаа өгсөн боловч бүрэн танилцуулдаггүй, хааяа нэг өдөрт 2 цаг л танилцуулдаг”, “Төлөөлөгч Х харилцаа хандлага маш муу, дарамтлах, өөрт холбогдолгүй хэргийн талаар асуух, заналхийлэх, гарахгүй шүү, лалар минь гэх мэтээр дарамталдаг” гэж; Орхон аймгийн Цагдаагийн хэлтэст баривчлах шийтгэл эдэлж буй иргэн “Байцаагч, прокурор хоёр хүний өгсөн мэдүүлгийг бүрэн бичдэггүй юм байна лээ. Яллахад тохируулаад хасахыг нь хасаад шүүхэд өгчихдөг юм байна лээ” гэж; Өвөрхангай аймгийн Цагдаагийн хэлтэст таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүн “Мөрдөгч орой 21 цагт ирээд шөнийн 02 цаг хүртэл сүрдүүлж, дарамталсан” гэж тус тус бичсэн байна.


### **ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ҮЙЛДЭЖ БҮЙ ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХ ШИНЖТЭЙ ЗӨРЧЛИЙН ХЭВ ШИНЖ**

Олон улсын хүний эрхийн эрх зүйд эрүү шүүлт тулгах үйлдлийг “бие махбодын”, “бэлгийн хүчирхийллийн”, “сэтгэцийн” гэсэн гурван хэв шинжид тодорхойлсон<sup>75</sup>. ЭШУС үндэсний ажиллагаа нь 2022 оны 08 дугаар сараас 2025 оны 3 дугаар сарын хугацаанд Цагдаагийн байгууллагын 57 байршилд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан 1,180 иргэнээс асуумж авч эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг тодорхойлоход хүний бие махбодод санаатай, тодорхой зорилгын үүднээс гэмтэл учруулах “бие махбодын эрүү шүүлт”-д тооцогдох зөрчилд өртсөн гэж 32 хувь нь, хүний сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох шинжтэй, шууд бие махбодын хүчирхийлэл, гэмтэл учруулдаггүй “сэтгэцийн эрүүл шүүлт”-д тооцогдох зөрчилд өртсөн гэж 25 хувь нь, хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй “хэрцгий буюу хүнлэг бус харьцах” болон

<sup>75</sup> What is torture? | Freedom from Torture



хүнийг бусдын өмнө бүдүүлгээр доромжлох, баривчлагдсан этгээдийг хүсэл зориг, ухамсрынх нь эсрэг үйлдэл хийхэд түлхэц өгөх нэр төрийг нь доромжлон харьцах үйлдэлд өртсөн гэж 43 хувь нь хариулсан.



Эдгээр үйлдэл нь Цагдаагийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтээр мөн ангилагдаж байгаа ба нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүрээнд албадан эрүүлжүүлэгдсэн, албадан саатуулагдсан, баривчлагдсан хүнтэй харьцахдаа хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж байгаа байдал түлхүү үйлдэгдэж байна. Энэ тухай асуумжид оролцсон 1,180 иргэний 48,7 хувь нь дараах байдлаар тэмдэглэн үлдээсэн:

*“БЗД-ийн Цагдаагийн ... хэлтсийн мөрдөгч Х, эрүүгийн тасгийнхан бүгд намайг шоолж, инээлдэж, хүнлэг бусаар харьцаж хүйсийн чиг баримжаагаар минь доромжилж байсан”, “Жижиг бүгчим орчинд 4-үүлээ байх нь нүүр хавагнах, ойр ойрхон шээс хүрэх, толгой эргэх, бачимдах, түүнээс болж сэтгэл санаагаар унах зэргээр эрүүл мэнд болон сэтгэл санааны хямралд оруулж байна. Энэ нь хүний эрхийг зөрчиж байна гэж үзэж байна”, “Ялтан шиг харьцахаа болих”, “Бие засаж болох уу гэж асуухад яриа тасалдууллаа гээд хараалын үгээр доромжилсон”, “Жорлон ор гэхэд нь үгүй гэснээс болж намайг шөнөжин дэглэж хонуулсан”, “Бөөстэй хүнтэй хамт хийж байна”, “Нинжа, ялтан, гөлөг, п... гэх мэт үгээр байнга доромжлон дууддаг”, “Эрүүл мэндийн шаардлагын улмаас зайлшгүй бие засах шаардлагатай байхад хясан боогдуулж, дээрэнгүй харьцсан”.*

*Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд авсан асуумжийн илэрцээс*

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд бие махбодын болон сэтгэцийн эрүү шүүлтэд тооцогдох дараа үйлдлийг асуумжид оролцогсдын 51,3 хувь нь тэмдэглэсэн:

“Намайг хамгийн анх цагдан хориход чи хэргээ хүлээхээд алга боллоо гээд гартаа гавтай байхад цахилгаан бороохойгоор бороохойдсон. Мөн хэлтсийн дарга нь “өнөөдөр камер дээр дарга байхгүй биз дээ?” гээд намайг алгадсан”, “Мөрдөн байцаах тасгийн дарга хошууч Б нь надтай зүй бусаар харьцсан. Өрөөндөө эрүү шүүлт тулгаад, дараа цаас шидээд өргөдөл гомдол гаргаад байв аа гэсэн”, “Баянзүрх дүүргийн Цагдаагийн ... хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч (эмэгтэй ахмад) бас бус эрүүгийн төлөөлөгчид 8, 9 цагийн турш гарт шигдтэл гавтай байлгасан, зодсон. Нааш цааш явахад, шатаар өгсөхөд галуун цуваагаар алхуулсан”, “3 хоног гавтай байлгаж, шөнө хүртэл юмнаас гавлаж, суугаагаар минь хоёр хонуулж хэрэг хүлээхээс өөр арга замгүй болгосон”, “Эргэлт өгөхгүй, байнга айлган сүрдүүлж мэдүүлэг авч, ойр дотнын хүнийг хамсаатнаар татна гэх мэтээр эрүүдэн шүүх нарийн аргуудтай”, “Чингэлтэй дүүргийн ... хэлтсийн Эрүүгийн тасгийн ахлах Б ар гэрээр минь сүрдүүлэн далайлгаж, айлгасан. Хэргээ хүлээхгүй бол ар гэрийг чинь шалгаж байцаана гэж сүрдүүлсэн”, “Сонгинохайрхан дүүргийн хэлтсийн байцаагч, ахлах дэслэгч Б намайг ажлын газартайгаа холбоо барьж мэдэгдэх гэтэл холбоо бариулаагүй. Мөн миний 17 настай охиныг байцаалтад дуудаж, “хөөрхөн охин байна” гэх зэргээр хоорондоо ярьж инээлдэн, шүүхээр тогтоогдоогүй байхад доромжилсон”.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд авсан асуумжийн илэрцээс

Алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд шалгагдаж буй болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, албадан эрүүлжүүлэгдсэн, түүнчлэн Монгол хэл, бичиг мэддэггүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнд эдлэх эрх, хүлээх үүргийг нь тогтмол тайлбарлаж ажилладаг эсэх, тайлбарлахад бэрхшээл тулгардаг эсэх талаар тодруулахад асуумжид оролцсон алба хаагчдын 28 хувь буюу 126 нь иргэдийн эрх, үүргийг тогтмол тайлбарладаггүй гэж, 52,2 хувь буюу 235 нь Монгол хэл, бичиг мэддэггүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх, үүргийг нь тайлбарлахад бэрхшээл тулгардаг, ойлголцоход хүндрэлтэй байдаг гэж хариулсан.

ЭШУС үндэсний ажиллагааны 2022 оны 08 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сарыг хүртэлх хугацаанд ЦЕГ-ын 57 байршилд хийсэн хяналт шинжилгээний ажиглалтаар тогтоогдсон нөхцөл байдал, явуулсан асуумж судалгаа, танилцсан баримт мэдээлэл, ганцаарчлан хийсэн уулзалтын тэмдэглэл зэрэг эх сурвалжид үндэслэн хууль сахиулах байгууллагын алба хаагчдын санаатай болон санамсаргүйгээр үйлдэж буй эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийг тодорхойлоход ЦАТХ-ийн 22.1, 22.2, 22.3, 22.4, 22.5-д заасан Цагдаагийн байгууллага, албан хаагчдын үүрэг, үйл ажиллагаанд тавих хоригууд<sup>76</sup>, ЦЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.4.3, 2.3.1, 2.3.2, 2.3.3,

<sup>76</sup> Цагдаагийн албаны тухай хууль, Дөрөвдүгээр бүлэг, Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам. 22 дугаар зүйлийн:

22.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.

22.2.Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийгнөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.

22.3.Цагдаагийн байгууллага, алба хаагч баривчлагдсан, түр саатуулагдсан насанд хүрээгүй этгээдийн 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, эсхүл төрөл садны хүнд энэ тухай мэдэгдэх үүрэгтэй.

22.4.Цагдаагийн алба хаагч бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.


22.5.Цагдаагийн алба хаагч, үүргээ гүйцэтгэхдээ бусдадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.

2.4.1-д заасан цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээг<sup>77</sup> зарим талаар үл огоорч, энэ нь цагдаагийн байгууллагын салбар, нэгжүүдийн өдөр тутмын хэвшмэл ажлын арга хэлбэр болон оршин байгаа нь хяналт шинжилгээгээр ажилласан 57 салбар нэгжүүдэд хийсэн ажиглалт, дүгнэлтээр ийнхүү тогтоогдсон.

### ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХҮРЭЭНД ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Цагдаагийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийн хүрээнд үйлдэгдэж буй эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодруулах зорилгоор алба хаагчдаас тэдний хөдөлмөрлөх эрхийн тухайд асуумж авахад дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

- Алба хаагчид 7 хоногийн амралт болон бүх нийтийн баярын үеэр ажилласан илүү цагаа нөхөн амарч чадаж буй эсэх, эсхүл нөхөн олговор авдаг эсэх талаарх асуултад 420 алба хаагч оролцсоны 91 хувь буюу 382 нь “чаддаггүй” гэж;




### Албан үүргээ биелүүлэхтэй холбоотой гардаг хүндрэл, бэрхшээлийн талаар тодруулахад:

- Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын боловсронгуй бус байдлаас үүдэлтэй хүндрэл гардаг гэж 157 нь;
- Удирдлагын арга барил, ажлын зохион байгуулалтаас үүдэлтэй хүндрэл гардаг гэж 132 нь;

<sup>77</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/194 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”

- Удирдлагын зүгээс ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт учруулдаг гэж 75 нь;
- Ажлын ачаалал их, олон цагаар ажиллуулдаг гэж нийт оролцогчдын дийлэнх буюу 322 нь;
- Хуульд заагаагүй ажил үүрэг гүйцэтгүүлдэг гэж 88 алба хаагч тус тус хариулсан.



**Асуумжид дурдаагүй боловч удирдлагын түвшинд уламжлуулах санал, хүсэлт, хөндөх асуудлын талаар зарим алба хаагч дараах байдлаар тэмдэглэн үлдээсэн. Үүнд:**

- Хөдөө, орон нутагт томилогдон ажиллаж байгаа алба хаагчдын ар гэрийг ажлын байраар хангах;
- Цагдаагийн байгууллагад хүйсээр ялгаварлах тохиолдол байдаг. Үүнийг зогсоох;
- Хууль эрх зүйн орчин боловсронгуй болж байгаа боловч түүнийг хэрхэн, яаж хэрэгжүүлэх, техник хэрэгсэл ашиглах зэрэг зааварчлах ажлыг нарийвчлан зохион байгуулах. Хуулиа дагаж тогтмол арга зүйн шинэчлэлт хийж байхгүй бол алба хаагчдад тэр хэрээр эрсдэл үүсэж байна;
- Цагдаагийн хүний нөөцийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Ажлын ачаалал хэрээс хэтэрлээ. Нэг алба хаагч олон төрлийн чиг үүргийг хольж хийдэг асуудал бэрхшээл үүсгэж байна;
- Цагдаагийн байгууллагын ажлын ачаалал их, ар гэртээ зарцуулах цаг зав муу. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд гаргах цаг муу. Энэ нь цагдаагийн алба хаагчийн үр хүүхэд, ар гэрийнхний эрх ашгийг маш их зөрчдөг.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг албан тушаалд нь тохируулах. Үүрэг нэрийн доор ажлын ачаалал эрс нэмэгдэж, стресстүүлдэг;
- Ээлжээр үүрэг гүйцэтгэж, дандаа илүү цагаар ажилладаг. Ар гэрт үүнээс болж байнга хэрүүл маргаан гардаг;
- Цагдаагийн байгууллагад цолны дарамт шахалт, дээрэлхэлт гэх зэрэг

хүний эрхийн зөрчил их гардаг. “Бид л дарга” гэсэн үүднээс харьцаж, хов живээр ажлаа хийж, бусдыг гаднах өнгөц байдлаас дүгнэдэг. Энэ байгууллагад ар гэрээ авч яваа өрх толгойлсон эмэгтэй алба хаагчид их байдаг. Хүүхэд төрүүлэх болгонд “энэ нэг юм ажлаа хийхгүй, төрөөд, ажлын садаа болоод” гэх зэрэг яриа үүсгэдэг;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцахад хэлмэрч, орчуулагч дутмаг байна;
- Дүүргийн цагдаагийн алба хаагч нар харилцааны доголдол маш их гаргадаг. Манай төвийн эмч болон цагдаа нар мөн адил хүнтэй хүнлэг бус харилцаж, хэл амаар доромжлох, өөрийн эрүүлжүүлэх төлбөрөөс гадна өөр хүний эрүүлжүүлэх төлбөрийг төлөхийг шаарддаг, төлөхгүй бол гаргахгүй гэх мэтээр загнах нь бүдүүлэг, дарга ахлах нь үүнд анхаарал хандуулж ажилладаггүй;
- Эрүүлжүүлэх, баривчлах байрны эмчийн орон тоо дутуу учир ажлын ачаалал их үед амарч чаддаггүй. Ажлын байрны орчин нөхцөлөөс шалтгаалж Эрүүлжүүлэх, саатуулах байранд ажиллаж байгаа алба хаагчдын эрх ч бас зөрчигддөг. Эм тарианы төсөв муу учир хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл учрахгүй гэх баталгаа байхгүй. Цаашид эм тарианы төсвийг нэмэгдүүлж, стандартаа мөрдөх боломжийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хөдөлмөрлөх эрхийн талаарх эдгээр асуумж нь хүний нөөцийн дутагдал, түүнээс үүдэлтэй нэг алба хаагчид оногдох хэтийдсэн ачаалал, хуулийн дагуу хөдөлмөрөө шударгаар үнэлүүлж чадахгүй байгаа байдал, удирдлагын зүгээс ирэх дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт цагдаагийн байгууллагад нүүрлэсэн байгааг харуулж байгаа ба энэ нь цагдаагийн алба хаагч байнгын стресст өртөх, гэр бүлийн гишүүдээ үл хайхрах, цаашлаад гэр бүлийн хүрээний үл ойлголцол үүсэх шалтгаан ч болж байна.

Ийнхүү хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсөн, сэтгэл зүйн хувьд тэнцвэрт байдал нь алдагдсан алба хаагч хууль сахиулах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэнтэй зүй зохистой харьцаж, хүний эрхийг дээдлэн шударгаар гүйцэтгэх үүргээ ухамсарлахгүй байх, мэддэг ч биелүүлэхгүй байхад хүргэж байж болзошгүй байна.

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ЭРҮҮ ҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ<sup>78 79</sup>

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “... үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах...”, 38 дугаар зүйлд заасан “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх...” төрийн үүргийг хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг болохынхоо хувьд Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын ЦАТХ-иар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах чиг үүргээ Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон НҮБ-ын гэрээ, конвенцууд, олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хууль сахиулах ажиллагаанд мөрдөгдөх олон улсын стандарт, дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийг дагаж мөрдөх, ингэхдээ:

- “Бүх хүнтэй заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцах”;
- “Яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ялгаварлан гадуурхаж болохгүй”;
- “Хэнийг ч эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж болохгүй” гэсэн хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг ямагт чанд баримтлахыг сануулж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг холбогдох удирдах албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:

### ЗӨВЛӨМЖ 1:

ЭШУС үндэсний ажиллагаа нь Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн үндэслэн НЦУГ-ын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар, хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, тогтоогдсон эрхийн зөрчлийг арилгах, иргэнийг хуулийн дагуу саатуулах нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тусгасан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай зөвлөмжийг ЦЕГ-ын дэд дарга бөгөөд НЦУГ-ын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбатад хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон.



78 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай 6 заалт бүхий зөвлөмж

79 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08/05 дугаартай 11 заалт бүхий зөвлөмж



## ЗӨВЛӨМЖ 2:

ЭШУС үндэсний ажиллагаа нь 2024 оны 06 дугаар сараас 08 дугаар сарын хугацаанд Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Орхон, Булган, Хөвсгөл аймаг болон Өвөрхангай аймгийн Хар хорин сумын сум дундын, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтэс буюу нийт 10 цагдаагийн Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байранд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Улмаар хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг зөрчиж байж болзошгүй шалтгаан нөхцөлийг арилгах, НҮБ-ын хүний эрхийн түгээмэл баримт бичиг болон хууль сахиулах ажиллагаанд хамаатуулах дүрэм, зарчмууд, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль (ТатХ), Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль (ТАХЭЗтХ), ЦАТХ, холбогдох тогтоомж, ЦЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/194 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм” болон бусад эрх зүйн баримт бичгүүдээр хүлээсэн цагдаагийн алба хаагчдын чиг үүргээ биелүүлэх явцад баримтлах сахилга, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн нөхцөл байдалд анхаарал хандуулж, цаашид сайжруулах арга зүйн чиглэл болгон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 08/05 дугаартай зөвлөмжийг ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболдод хүргүүлсэн.



## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

### ЗӨВЛӨМЖ 1 - БИЕЛЭЛТ:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг НЦУГ-ын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 306/3837 дугаартай албан бичгээр<sup>80</sup> Дэд бөгөөд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Баатар ирүүлсэн.

НЦУГ-ын нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар нь зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангасан ба түүний мөрөөр авсан арга хэмжээний тайланг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны



<sup>80</sup> Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 306/3837 дугаартай, 13 бүлэг бүхий зорилтын хүрээнд авсан 20 арга хэмжээний тайланг хавсаргасан албан бичиг

09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд биелэлт нийт 83 хувийн гүйцэтгэлтэй тооцогдсон.

**1. “Эрүүлжүүлэгдсэн иргэдийн эрх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмчийн үзлэгийн өрөөг бий болгох зохион байгуулалтын арга хэмжээ авах” зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Эрүүлжүүлэх, саатуулах төвийн өрөөний зохион байгуулалтыг өөрчлөн, эмчийн үзлэг хийх зориулалттай өрөөг бий болгосон;
- Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд яаралтай тусламж үзүүлэх өрөө, эмчийн үзлэгийн өрөөг бий болгож, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, тариа, туслах материалыг байршуулсан;

**2. Эрүүлжүүлэх байранд “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5527:2019” стандартын шаардлагыг хангасан орчин, нөхцөлийг бүрдүүлэх зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Эрүүлжүүлэх, саатуулах төвийн эрэгтэй эрүүлжүүлэх байрны усанд орох өрөөний шүршүүрийн толгой, эд зүйл хадгалах өрөөний шүүгээний цоож, эрэгтэй алба хаагчдын хувцас солих өрөөний шалны хулдаас, эмэгтэй эрүүлжүүлэх байрны бие засах өрөөний суултуурыг солих төсвийг хуваарилан, засварын ажлыг хийж дуусгасан;
- Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны бие засах, усанд орох, алба хаагчдын хувцас солих өрөө, үйлчлүүлэгчдийн хувийн эд зүйл хадгалах өрөөнүүдэд засвар үйлчилгээ хийж, Монгол Улсын MNS 5527:2019 стандартын шаардлагад нийцүүлсэн;
- Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны ариун цэврийн өрөөний хаалганы гадна эрэгтэй, эмэгтэй ялгах тэмдэг байрлуулж, цоож суулгасан;
- Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн болон эмчийн өрөөнд KJ-C06 загварын агаар цэвэршүүлэгч байршуулсан;
- Баянзүрх дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны усанд орох өрөөнд 2 ширхэг хаалт байршуулж, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны усанд орох өрөөнд засвар хийж, хаалттай болгож, хэвийн ажиллагааг хангасан;
- Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт Эрүүлжүүлэх, саатуулах байрны урсгал засвар хийх 9,6 сая төгрөгийн төсвийн тооцоо, судалгаа хийж, шийдвэрлүүлэх саналыг хүргүүлсэн;
- Баянзүрх дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны засвар үйлчилгээнд Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Засаг даргын тамгын газарт хүсэлт хүргүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийх төсвийг шийдвэрлүүлэн, засварын ажлыг хийж гүйцэтгүүлэн, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдүүлсэн.

**3. Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын удирдлага, алба хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж ажиллах, алба хаагч ажлын байран дээр дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Эрүүлжүүлэх, саатуулах төв, байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхаас, түүнчлэн алба хаагчид өөрсдөө иргэдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энгэрийн камер тогтмол ашиглах талаар удирдлагын зүгээс үүрэг, чиглэл өгч, хяналт тавьж байгаа ба энгэрийн камерын бичлэгийг тухай бүрд хуулан авч, сан үүсгэн ажиллаж байна.

**4. Алба хаагчдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, энэхүү гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг тогтмолжуулах зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Алба хаагчдад “Эрүү шүүлт тулгах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх”, “Согтуу хүнтэй хэрхэн харьцах, өөрийн үйлдлээ алба хаагч хэрхэн хянах” сэдвээр 1 цагийн сургалт зохион байгуулж, 47 алба хаагчийг хамруулсан;
- Алба хаагчдад иргэдтэй хуулийн дагуу харьцаж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, холбогдох хууль, тогтоомж, журмыг баримтлан, сахилга, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэнтэй зүй бус харьцаж, албаны нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байхад онцгойлон анхаарах зааварчилгааг өдөр бүр бичгээр өгч хэвшсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн эмчид 18, жижүүрийн цагдаа нарт 17, жижүүрийн жолооч цагдаа нарт 8 заалт бүхий холбогдох хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэх зааварчилгааг өгсөн;
- Эрүүлжүүлэх, саатуулах төв, байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад иргэдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор 2 цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 141 алба хаагчийг хамруулсан.

**5. Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэх жижүүрийн ээлжийн үүргийн хуваарийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх зохион байгуулалтын арга хэмжээг авах, түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд заасан хугацаанаас илүү цагаар ажиллуулсан тохиолдолд олговрыг олгох зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Эрүүлжүүлэх, саатуулах төв, байранд үүрэг гүйцэтгэж багаа алба хаагчдыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 24/72 цагаар үүрэг гүйцэтгүүлж, алба хаагчдаас ээлжийн амралт авах, орон тоо дутсан үед 24/48 цагаар үүрэг гүйцэтгэх зохион байгуулалт хийж, амарч байгаа үед эргүүл томилгоонд ажиллуулахгүй байхад анхаарч ажиллаж байна.


**6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн 5-д дурдсан “Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийг**

хэрэгжүүлэхэд Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмчийн шаардлагатай орон тоог нэмэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх” гэсэн заалтын биелэлт тайланд тусгагдаагүй тул уг зөвлөмжийн дагуу арга хэмжээ аваагүй гэж үнэлсэн.

## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ БУСАД ЗӨВЛӨМЖ, ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

### ЗӨВЛӨМЖ 3:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08/01 дугаартай албан бичгээр “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.9 (Хууль бусаар баривчлах), 14.1 (Ялгаварлан гадуурхах), 21.12 (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргүүдэд цагдаагийн алба хаагч холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2023 онд цагдаагийн байгууллагын хэмжээнд төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах” зөвлөмжийг ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагч, хошууч генерал Ж.Болдод хүргүүлсэн боловч энэ төрлийн гэмт хэрэгт цагдаагийн 2 алба хаагч шүүхээр шийтгүүлж, 1 алба хаагч эрүүгийн хэрэгт мөрдөн шалгагдаж байгаа тухай албан мэдээллийг УЕПГ, ШЕЗ-ийн Мэдээллийн технологийн газар, АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс тус бүрийн албан тоот<sup>81 82 83</sup> оор ирүүлсэн.



ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 11.1, 34.1.3, 34.1.7-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд УЕП, ШЕЗ, АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс ЭХ-ийн тусгай ангид заасан 13.9 (Хууль бусаар баривчлах), 14.1 (Ялгаварлан гадуурхах), 21.12 (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд холбогдсон төрийн албан хаагчдад хамаарах статистикийг гаргуулан танилцахад 2023 онд эдгээр гэмт хэргийн шинжтэй 87 гомдол, мэдээллийн 64-д хэрэг бүртгэлт нээхээс татгалзсан, 20 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлт нээсэн, 3 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан байв.

Нийт 87 гомдол, мэдээллийн ЭХ-ийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл (Хууль бусаар баривчлах, саатуулах) гэмт хэрэгт 5 цагдаагийн алба хаагч холбогдон шалгагдсанаас 5 цагдаагийн алба хаагч холбогдсон 4 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлт нээхээс татгалзаж, 1 хэрэгт хэрэг бүртгэлт нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар

81 Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/1783 тоот албан бичиг

82 Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 04/215 тоот албан бичиг

83 Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны даргын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/2846 тоот албан бичиг

зүйл (Эрүү шүүлт тулгах) гэмт хэрэгт 16 цагдаагийн алба хаагч, бусад төрийн байгууллагын 2 алба хаагчид холбогдуулан 82 гомдол, мэдээлэл шалгагдсанаас, 15 цагдаагийн алба хаагчдад холбогдох 64 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлт нээхээс татгалзаж, 15 нь хэрэг бүртгэлт нээж, 3 алба хаагчид эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 2 алба хаагчид холбогдох хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэн, 1 алба хаагчид холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл (Ялгаварлан гадуурхах) гэмт хэрэгт төрийн алба хаагчдад холбогдол гомдол, мэдээлэл ирээгүй гэсэн мэдээллийг УЕП, ШЕЗ, АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн албан бичигт дурдсан байлаа.

*ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн албан мэдээнд "... Иргэнээс гаргасан гомдлын дагуу Баянгол дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн мэдүүлэг авах өрөөний камерын бичлэгийг гаргуулан авахаар очих үед тус хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасаг байрлах 2 дугаар давхрын зүүн хэсэгт байрлах 1 ширхэг камерын чиглэлийг зориуд өөрчилсөн, эрүүгийн мөрдөгч нар суух өрөөнд дүрс бичлэгийн камер байршуулаагүй байсан. Дүүргийн цагдаагийн хэлтсийн байрны Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч нарын байрлах хэсэг болон албаны үйл ажиллагаа явуулах албан өрөөнд дүрс бичлэгийн камер суурилуулаагүй нөхцөл байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан "Халдашгүй чөлөөтэй байх" эрхийг зөрчсөн, гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж буй этгээдэд эрүү шүүлт тулгах, бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг хийх орчныг бүрдүүлсэн, камергүй учир эрүү шүүлт тулгах, бие махбодод хүч хэрэглэх үйлдэл нотлогдохгүй гэх сэтгэлгээг мөрдөгч нарт бий болгосон гэж үзэх нөхцөл байдал илэрсэн" гэх хуулиар үл хязгаарлагдах хүний эрхийн ноцтой зөрчил дурдагдсан.*

*ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн албан бичгээс*

Ийнхүү төрийн бусад чиг үүргийн байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, холбогдох статистик дүн мэдээг гаргуулан авсны дүнд Цагдаагийн байгууллагын алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангид зүйлчилсэн ЭХ-ийн Тусгай ангид заасан 13.9 (Хууль бусаар баривчлах), 14.1 (Ялгаварлан гадуурхах), 21.12 (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргүүдэд холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08/06 дугаартай Зөвлөмж<sup>84</sup>-ийг ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболдод хүргүүлсэн.

### **ЗӨВЛӨМЖ 3 - БИЕЛЭЛТ:**

ЦЕГ-ын дарга, Дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/314 дугаар албан бичгээр<sup>85</sup> ирүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08/06 дугаартай зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 83 хувийн гүйцэтгэлтэй тооцогдсон байна. Үүнд:

<sup>84</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08/06 дугаартай 1 заалт бүхий Зөвлөмж

<sup>85</sup> Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, Цагдаагийн хурандаа Т.Сүхболдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/314 дугаартай "Танилцуулга хүргүүлэх тухай" албан бичгээр ирүүлсэн 5 бүлэг арга хэмжээг агуулсан тайлан-танилцуулга

**Алба хаагчдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, энэхүү гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг тогтмолжуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран эрүү шүүлт тулгах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах чиглэлээр 22 удаагийн сургалтад давхардсан тоогоор 5977 алба хаагчийг хамруулж, хүний эрхийн сургагч багшаар 15 алба хаагчийг томилон ажиллуулж байна;
- “Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт, үндсэн шинжүүд, хязгаарлалт”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь”, “Халдашгүй чөлөөтэй байх эрх”, “Та хүний эрх хамгаалагч уу”, “Жагсаал, цуглааны үед хүний эрхийг хангах нь”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тухай ойлголт” зэрэг 6 төрлийн сургалтыг байгууллагын цахим сургалтын /esurgalt.police.gov/ цэсэд байршуулж, алба хаагчдаар судлуулах ажлыг зохион байгуулсан;
- Эрүүгийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хууль, хяналтын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, эрх бүхий албан тушаалтны хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилгоор Завхан аймгийн цагдаагийн газраас ХЭҮК, Прокурор, ШШГ газартай хамтран “Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хууль, хяналтын байгууллагын 26 алба хаагчийг хамруулсан;
- Хүний эрхийг хангах, түүнчлэн хүнлэг бус харьцах, бусдыг ялгаварлан гадуурхах зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэнтий аймгийн цагдаагийн газраас 2 төрлийн видео мэдээлэл бэлтгэн, орон нутгийн 22 цахим сайтад байршуулж, Архангай, Хэнтий аймгийн цагдаагийн газарт иргэд, олон нийттэй харилцах, хүлээлгийн танхимд “Санал хүсэлтийн хайрцаг” байршуулж, энэ төрлийн санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн;
- Цаашид “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2024 оны албаны болон давтан, мэргэжүүлэх сургалтын хөтөлбөр” төлөвлөгөөний дагуу алба хаагчдыг давтан мэргэшүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч, үр дүнг тооцон ажиллаж байна.



## ЗӨВЛӨМЖ 4:

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан АТГ-ын холбогдох албанаас 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06/2846<sup>86</sup>, 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 06/18366<sup>87</sup> дугаартай албан бичгийг тус тус ирүүлсэн ба 06/2846 дугаартай албан бичигт хамаарах асуудлыг Шигтгээ 1-д дурдсан.

Харин 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 06/18366 дугаартай албан бичигт “Баянгол дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч нь “бусдад дээрэмдүүлж, гар утас, хөөргөө алдсан” гэх хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа уг хэрэгт сэрдэгдсэн иргэнийг 2024 оны 07 дугаар сарын 23-ны 00:41 цагт тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах зочид буудлаас баривчлан Цагдаагийн хэлтсийн байранд авчирсны дараа ЭХХШТХ-ийн 31.4, 31.5 дугаар зүйлүүдэд зааснаар сэжигтнийг баривчлаж шийдвэр гаргахгүйгээр тухайн өдрийн 18:10 цаг хүртэл баривчилж, нийт 17 цаг саатуулж хүнийг хууль бусаар баривчлан саатуулсан, мөн “хэргээ хүлээ, гэмт хэрэг үйлдэж олсон гар утас, хөөргийг яаснаа хэл, чамайг гэрчилж байгаа хүний мэдүүлгээр чамайг тултал шоронд явуулна, тэр хүнийг тултал нь шахаж байгаад чамайг шоронд хатаана” гэх зэргээр хэргээ хүлээх талаар дарамт учруулан сэтгэл санааг нь шаналган зовоосон, шөнийн 00:41 цагаас 08:30 цаг хүртэлх хугацаанд хөлийг нь өвдгөөр нугалж, явган суулгаж, хоёр гарыг нь паарны доод хэсэгтэй холбогдсон нарийн трубанаас гавлаж, 18:30 цагаас 17:55 цаг хүртэлх хугацаанд 2 гарыг нь биеийн урд болон ар хэсэгт гавлаж зогсоох болон сандал дээр суулгах байдалтай байлгаж бие махбодыг шаналган зовоож, эрүү шүүлт тулгасан...” нөхцөл байдал тогтоогдсон талаар дурдсан.

АТГ-ын Эрүү шүүлт тулгах, мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын “Хүний эрхийг хамгаалах болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах тухай” 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 06/18366 тоот албан бичгээс

Улмаар эл гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, хүний эрхийг хамгаалах, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах тухай 06/2846 дугаартай албан бичгийг АТГ-ын холбогдох албанаас 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хүргүүлсэн.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 11 дүгээр зүйлд “Оролцогч улсууд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор түүний харьяа нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсээс мэдүүлэг авахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгсэл, түүнчлэн тэднийг хянан харгалзах, тэдэнтэй харьцах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд шат дараалсан хяналт тавих”-ыг, түүнчлэн 16 дугаар зүйлд “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээн...” гэж заасан.

86 Авлигатай тэмцэх газрын Эрүү шүүлт тулгах, мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын “Хүний эрхийг хамгаалах болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах тухай” 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/2846 тоот албан бичиг

87 Авлигатай тэмцэх газрын Эрүү шүүлт тулгах, мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын “Хүний эрхийг хамгаалах болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах тухай” 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 06/18366 тоот албан бичиг

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан "...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй..., хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй..." гэсэн заалт зөрчигдөж байж болзошгүй дээрх үйлдлийг даруй зогсоох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08/13 дугаар бүхий зөвлөмж<sup>88</sup>ийг Баянгол дүүргийн Цагдаагийн газрын даргад хүргүүлсэн.

#### **ЗӨВЛӨМЖ 4 - БИЕЛЭЛТ:**

Баянгол дүүргийн Цагдаагийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 30ё/2872 дугаар албан бичгээр<sup>89</sup> ирүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний 08/13 дугаартай зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд биелэлт 45 хувийн гүйцэтгэлтэй "хэрэгжилт хангалтгүй" гэж тооцогдсон.

Иймд 2024 оны 12 дугаар сарын 04-ний 08/13 дугаартай зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь Баянгол дүүргийн Цагдаагийн газрын удирдлагатай уулзаж, эрүү шүүлт тулгаж, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Монгол Улсын ЭХ-ийн хуулийн Тусгай ангид заасан эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийг албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад санаатай болон санамсаргүйгээр үйлдэхгүй байх бүхий л боломжит арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгч, хэрэгжилтийг нөхөн гүйцэтгүүлснээр 08/13 дугаартай зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт 93 хувийн гүйцэтгэлтэй хангагдсан. Үүнд:

**1. Алба хаагч нар "Эрүү шүүлт тулгах", "Хууль бусаар баривчлах, саатуулах" гэмт хэргийн шинжтэй үйлдэл давтан үйлдэж буй үндэслэл, шалтгааныг тогтоон, дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар баталсан "Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага"-ыг хэрэгжүүлж, дүүргийн Прокурорын газраас зөвшөөрөл олгогдсон нийт 19 мэдүүлэг авах өрөөнд иргэдтэй уулзах, тайлбар мэдүүлэг авах үйл ажиллагааг явуулж, хэлтэс, тасгийн дарга нар тогтмол хяналт тавин ажиллаж байна;
- Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах зорилгын үүднээс мэдүүлэг авах өрөө болон хэсгийн байцаагч нарын өрөөг хуульд заасан стандартад нийцүүлэн камержуулахад шаардлагатай

<sup>88</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08/13 дугаартай, 6 заалт бүхий Зөвлөмж

<sup>89</sup> Баянгол дүүргийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа Ч.Алтанхуягийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 30ё/2872 дугаартай, 6 бүлэг зорилтын хүрээнд авсан 27 арга хэмжээний тайлан

төсвийг дүүргийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж, нэг, хоёрдугаар хэлтсийн алба хаагчдын болон мэдүүлэг авах өрөөнд 26, нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчдын өрөөнд 34 камерыг суурилуулсан;

- Мэдүүлэг авах өрөө тус бүрд байрлах камерын дуу-дүрсний бичлэгийг гучаас дээш хоног хадгалж байгаа ба нийт 7 өрөөнд тусгайлан хөдөлгөөн мэдрэгчтэй, оролцогчийн царайг ойроос харуулах боломжтой камераар тоногдсон, хяналтын прокурор, хэргийн оролцогчдод цахимаар харилцах боломжийг бүрдүүлсэн;
- Алба хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй энгэрийн камерын бичлэгийг хуулбарлах, өгөгдөл цуглуулах 2 ширхэг төхөөрөмжийг шинээр албан хэрэгцээнд ашиглаж эхэлсэн;
- Алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр нийт алба хаагчидтай долоо хоног бүрийн Даваа гаригт нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, чиглэл, үүрэг, зөвлөмжийг алба хаагч нэг бүрд танилцуулж хэвшсэн;
- Цагдаагийн газраас иргэдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай, ил тод байлгах, иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэлд хяналт тавих, дуудлага өгсөн иргэнтэй уулзах, холбогдох зорилгоор ажлын өдрүүдэд тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудыг хэлтсүүдийн угтах үйлчилгээнд нэмэлтээр ажиллуулж байна.

**2. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагч бүрийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх дадлыг эзэмшүүлэх, үйл ажиллагааны үндсэн зарчим болгоход үр нөлөөтэй бүхий л арга хэмжээг зохион байгуулах зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан “Бидний соёл” нөлөөллийн аяны хүрээнд зохион байгуулсан “Албандаа хандах хандлага, иргэдтэй харилцах харилцаа” сэдэвт сургалтад гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий 50 алба хаагч, “Цагдаагийн алба хаагчдын сэтгэл зүйн онцлог, харилцаа, хандлага” сэдэвт сургалтад 81 алба хаагчийг хамруулсан;
- “Эерэг харилцааг бий болгох сэтгэл зүйн ойлголтууд”, “Цагдаагийн алба хаагчийн нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, анхаарах зарим асуудал”, “Авлигын эсрэг үйл ажиллагаа”, “Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн тухай ойлголт” сэдвүүдийн хүрээнд Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран зохион байгуулсан сургалтад гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн 210 алба хаагчийг хамруулсан;
- Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны зүгээс “Эерэг харилцаа”, “Цагдаагийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдож буй шалтгаан нөхцөл, анхаарах асуудал”, “Ахын захиас” сэдвүүдээр сургалт, мэдээллийн ажил зохион байгуулж, 197 алба хаагчийг хамруулсан;

- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сэдэвт сургалтад танхим болон цахимаар 124 алба хаагч хамрагдсан;
- Дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгаас “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн ойлголт, мөн чанар”, “Эрүү шүүлт тулгахаас ангид байх хүний эрх”, “Иргэдтэй зөв боловсон харьцах” сэдвүүдийн хүрээнд танхим, цахимаар сургалт зохион байгуулж, 153 алба хаагчийг хамруулсан;

**3. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт алба хаагч холбогдохгүй байхад онцгой анхаарч, Авлигатай тэмцэх газар болон Прокурорын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, хамтран ажиллах зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих хяналт, хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн Прокурорын газартай хамтран 6 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, 91 алба хаагчийг хамруулсан;
- ЭШУС үндэсний ажиллагаа болон Баянгол дүүргийн Прокурорын газартай хамтран “Эрүү шүүлтээс ангид байх эрх” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн 85 алба хаагчдад эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангаж ажиллах мэдлэг, мэдээлэл өгсөн;

**4. Мэдүүлэг авах өрөө, Цагдаагийн газрын иргэдэд үйлчлэх угтах хэсэг, мөрдөх болон бусад чиг үүргийн албан тушаалтнуудын өрөө тасалгаанд эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн талаар мэдээлэл байршуулах зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:**

- Дүүргийн цагдаагийн газрын хэлтсүүдийн иргэдэд үйлчлэх угтах хэсэг болон мэдүүлэг авах 19 өрөө, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн алба хаагчдын 41 өрөөнд “Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх”-ийн талаар зурагт хуудас, хууль тогтоомжийг байршуулсан;

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний 08/13 дугаартай зөвлөмжийн 6 дахь заалт болох "Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/18366 дугаартай албан бичигт дурдагдсан асуудлуудад холбогдсон алба хаагч нар болон нэгжийн удирдлагуудад албаны хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг эргэн мэдээлэх" ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай танилцахад "мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын чиглэлээр 8 удаагийн зааварчилгаг нийт эрүүгийн мөрдөгч нарт, сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх, хуульч ажиллагаатай байх, хэргийн оролцогчидтой Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд зааснаар харилцах, авлига, албан тушаалын хэргээс ангид байх чиглэлээр нийт 9 төрлийн баталгааг гаргуулан авсан ба шинээр томилогдсон 4 алба хаагчийг сурган дадлагажуулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг тооцон ажилласан" зэрэг алба хаагчдад өгсөн зааварчилгааны тайланг ирүүлсэн байх тул уг зөвлөмжийг биелүүлээгүй хэмээн дүгнэж, хэрэгжилтийг хангуулахаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын нэмэлт зөвлөмжийг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Баянгол дүүргийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Алтанхуягт өгсөн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 08/13 дугаартай Зөвлөмжийн хэрэгжилтийн нөхцөл байдлаас

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нэмэлт зөвлөмжийн дагуу уг асуудалд нэр холбогдсон Баянгол дүүргийн цагдаагийн Нэгдүгээр хэлтсийн нэр бүхий алба хаагч нарт холбогдуулан ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газраас албаны шалгалт явуулж эхэлсэн. Гэвч 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 06/18366 дугаартай ирүүлсэн албан бичигт дурдагдсан асуудлуудад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам Код-111 (Байгууллагын үйл ажиллагаанд дотоод болон санхүүгийн хяналт шалгалт хийх)-ын 111.7.8 (Албаны шалгалт явуулахгүй тохиолдол/-ын в /энэ журмын 111.7.7-д заасан үндэслэл тогтоогдсон), 111.7.7-ийн е (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа бол)-д зааснаар уг хэрэгт нэр холбогдсон алба хаагч нарт Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан дээрх үндэслэлээр албаны шалгалт явуулж болохгүй гэх нөхцөл байдал тогтоогдсон байна.

Түүнчлэн, ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газраас албаны шалгалт явуулж байх хугацаанд АТГ-аас гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоохоор мөрдөн шалгах ажиллагааг мөн явуулж байсан тул ЦЕГ-ын зүгээс албаны шалгалтаа хааж шийдвэрлэсэн байна.

Уг зөвлөмжид тусгагдсан нөхцөл байдал, гэмт хэргийн чанартай үйлдлүүдэд дотоод хяналт шалгалт явуулж, дахин давтагдахгүй байх арга хэмжээ авах, гэм буруутай нь тогтоогдвол нэр дурдагдсан алба хаагчдад хариуцлага тооцуулах үүднээс Баянгол дүүргийн Цагдаагийн газрын удирдлагад хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 08/13 дугаартай зөвлөмжийн хувийг ЦЕГ-т явуулсан. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг ЦЕГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/22 дугаартай "Хариу хүргүүлэх тухай албан бичиг"<sup>90</sup>-ээр ирүүлэхдээ Баянгол дүүргийн Цагдаагийн газрын даргын тайланд дурдагдсан агуулгыг хуулбарлаж, харин ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн 6 дахь хэсэгт тусгасан "Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/18366 дугаартай албан бичигт дурдагдсан асуудлуудад холбогдсон алба хаагч нар болон нэгжийн удирдлагуудад албаны хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг эргэн мэдээлэх" ажлын хүрээнд явуулсан албаны хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар тайлагнаагүй байв.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 08/13 дугаартай зөвлөмжийн хэрэгжилтийн нөхцөл байдлаас

Иймд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна" гэж заасныг дахин сануулж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/18366 дугаартай албан бичигт дурдагдсан асуудлуудад холбогдсон алба хаагч нар болон нэгжийн удирдлагуудад явуулсан албаны хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээний тайланг гаргуулахаар 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 08/325 дугаартай албан бичгийг<sup>91</sup> ЦЕГ-ын даргад хүргүүлсэн.

## **ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ АЛБАН БИЧИГ - 1:**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/01, 2024 оны 08/06 дугаартай албан бичгүүдээр ЦЕГ-ын даргад хүргүүлсэн зөвлөмжүүдэд ЭХ-ийн Тусгай ангид заасан 13.9 (Хууль бусаар баривчлах), 14.1 (Ялгаварлан гадуурхах), 21.12 (Эрүү шүүлт тулгах) гэмт хэргүүдэд цагдаагийн алба хаагч холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг удаа дараа дурдсан.

Гэвч Баянгол дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэс, Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний эдгээр зөвлөмжүүдэд тусгасан цагдаагийн алба хаагч энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцож ажиллаагүйн улмаас цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэнд эрүү шүүлт тулгах, зүй бус харьцах үйлдэл гаргасан тохиолдолд албаны шалгалт явагдаж байгаа, түүнчлэн тодорхой тохиолдлууд нь гэмт хэргийн чанартай болох нь албаны хяналт шалгалтаар тогтоогдож, ЭХ-ийн Тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, мөн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар

90 Цагдаагийн ерөнхий газраас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/22 дугаартай 11 арга хэмжээг тайлагнасан "Хариу хүргүүлэх тухай албан бичиг"

91 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 08/325 дугаартай "Мэдээлэл хүсэх тухай" албан бичиг



зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн гэх танилцуулга, мэдээллийг АТГ92 болон Прокурорын байгууллагын93 албан бичгээр хүлээж авсан.

Иймд Монгол Улсын ХЭҮКтХ-ийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-д заасан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэсэн бүрэн эрхийн хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08/1456 дугаартай “Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд санал хүргүүлэх тухай” албан бичгээр Баянгол дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэс, Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын дарга нарыг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх саналыг ЦЕГ-ын даргад хүргүүлсэн.

### **“ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ” АЛБАН БИЧГИЙН ХАРИУ:**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08/1456 дугаартай “Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд санал хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу авсан арга хэмжээний талаарх тайланг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/871 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр94 ЦЕГ-ын даргаас дараах байдлаар ирүүлсэн. Үүнд:

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн 5 алба хаагч 2023 оны 08 дугаар сарын 02-ны шөнө гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийг баривчлах үедээ хууль бусаар саатуулж, эрүү шүүлт тулгасан асуудалд Авлигатай тэмцэх газраас холбогдох хууль тогтоомжийн дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна;

Говь-Алтай аймгийн цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч Ш.Б нь 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон иргэн Б-г зөрчлийн хэрэг хүлээлгэх зорилгоор цагдаагийн хэсгийн байранд биед нь халдаж, эрүүл мэндэд нь хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдон, улмаар аймгийн Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн /Эрүү шүүлт тулгах/ 1 дэх хэсэгт зааснаар торгох ял шийтгэгдсэн, ял шийтгэгдсэн этгээд нь шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд хандаад байна;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангид цагдан хоригдож байсан иргэн 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр эмнэлэгт хэвтэж байхдаа нас барсан асуудалд Баянгол дүүргийн

92 Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар даргын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/2846 дугаартай албан бичиг; 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 06/12888 дугаартай албан бичиг

93 Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурорын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/536 дугаартай албан бичиг

94 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/871 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг

цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн алба хаагчдад холбогдуулан албаны шалгалт явуулахад буруутай үйл ажиллагаа одоогоор тогтоогдоогүй;

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас 2024 оны 09 дүгээр сард Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, хэсэгчилсэн шалгалт зохион байгуулж, тус хэлтсийн даргад Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.3 дахь хэсэгт заасныг баримтлан “Албан тушаал бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсан;

Авлигатай тэмцэх газраас Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэс, Говь-Алтай аймгийн цагдаагийн газрын нэр бүхий алба хаагчдад холбогдох эрүүгийн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд хэргийн шийдвэрлэлтийг эргэн мэдэгдэх болно.

## **ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ АЛБАН БИЧИГ – 2**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08/1456 дугаартай “Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд санал хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу ирүүлсэн ЦЕГ-ын даргын албан тоотод 95 Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч холбогдсон хэргийн тухайд “ЭХ-ийн Тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн (Эрүү шүүлт тулгах) 1 дэх хэсэгт зааснаар торгох ял шийтгэгдсэн этгээд нь шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд хандаад байна” гэсэн мэдээлэл өгч, “хэргийн шийдвэрлэлтийг эргэн мэдэгдэх”-ээ дурдсан.

Гэвч тус хэрэг нь Говь-Алтай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр тус тус хэлэлцүүлэгдэж, Улсын Дээд Шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Ш.Б-д холбогдох эрүүгийн хэргийн тухай Дугаар 2025/ХШТ/07 тогтоолоор шийдвэрлэгдсэн байх боловч уг шийдвэрлэлтийн талаар ЦЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/871 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичигт дурдсаны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд эргэн мэдэгдээгүй байна.

ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4-д заасан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын холбогдох удирдлагад хариуцлага тооцох, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах саналыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08/485 тоот “Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” албан бичгийг ЦЕГ-ын даргад хүргүүлэв.

95 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/871 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг

## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь тайлант хугацаанд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр болон Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Өвөрхангай аймгийн сум дундын Цагдаагийн хэлтэс, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр гэсэн нийт 16 байршилд ажиллаж, хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, албадан эрүүлжүүлэгдсэн, түр саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан 609 иргэн болон 131 цагдаагийн алба хаагчаас асуумжийн аргаар эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар судалгаа авч, 43 иргэн, цагдаагийн 27 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийв.

Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын албаны харьяанд төв, орон нутгийн нийт 35 Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байр хамаардаг боловч Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа зогсоосон байдалтай байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь 2022-2025 оны 03 дугаар сарыг хүртэл үйл ажиллагаагаа зогсоосноос бусад 34 байршлын 31-д хуулийн дагуу иргэний эрх чөлөөг хязгаарлан, албадан эрүүлжүүлэх, саатуулах, түүнчлэн Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу оногдуулсан баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээг эдлүүлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх хэрхэн хангагдан хэрэгжиж буй байдал, эдгээр эрх зөрчигдөж байж болзошгүй шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Хуулийн дагуу иргэний эрх чөлөөг хязгаарлах, албадан эрүүлжүүлэх, саатуулах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эдлүүлэх ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийг арилгуулж, сайжруулахаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/01 дугаартай зөвлөмжийг Төв аймаг дахь Цагдаагийн газрын даргад, 2023 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 08/01 дугаартай зөвлөмжийг ЦЕГ-н даргад, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 08/13 дугаартай зөвлөмжийг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн даргад, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай зөвлөмжийг ЦЕГ-ын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргад, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08/13 дугаартай зөвлөмжийг Баянгол дүүргийн Цагдаагийн газрын даргад тус тус хүргүүлсэн.

Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны дотооддоо мөрддөг Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох аргачлал<sup>96</sup>-ын дагуу үнэлэхэд 83,0 хувийн гүйцэтгэлтэй тооцогдсон.

96 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал"

Төв аймгийн цагдаагийн газарт хяналт шинжилгээгээр ажиллахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч шалгахдаа иргэнээс гаргасан гомдол, мэдээллийн тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулаагүй, тэмдэглэлийн үлдэх хувийг иргэнд өгөөгүй, эцсийн шийдвэрлэлтийн талаар иргэнд хариу бичгээр мэдэгдээгүй, өөрийн үйл ажиллагааны тухай илтгэх хуудасны хамт шилжүүлээгүй, мэдээллийн санд шивэлт хийгээгүй, бүртгэлийн нэгдсэн дугаар аваагүй зэрэг холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэл тогтоогдож, улмаар зөрчлийг арилгах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, удирдлагын хяналт, зохион байгуулалтыг бүрэн хангаж ажиллах тухай 4 заалт бүхий 2022 оны 08/01 дугаартай Зөвлөмжийг хүргүүлж, заалт тухай бүрийн биелэлтийг хангуулсан.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд хийсэн хяналт шинжилгээгээр иргэдийг албадан эрүүлжүүлэхдээ хүйтэн, цементэн шалан дээр хөл нүцгэн 24 цагийн турш байлгадаг байдал тогтоогдож байв. Энэ нь олон улсын хүний эрхийн эрх зүйд бие махбодын эсрэг үйлдэж буй эрүү шүүлтийн нэг хэлбэр гэж тооцогддог үйлдэл тул хүний эрхийн зөрчлийг арилгах, цаашид давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх 2023 оны 08/13 дугаартай 5 заалт бүхий Зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулснаар тус цагдаагийн хэлтэст саатуулагдсан иргэдийг байршуулахдаа углааш хэрэглүүлдэг болсон, баривчлах шийтгэл эдлүүлэх өрөөнд нэмэлт цонх бий болгож, MNS 5527:2019 стандартын шаардлагад нийцүүлэн орчин нөхцөлөө сайжруулсан, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар иргэний мэдэх болон мэдээлэл авах эрхийг хангахад анхаарч, сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг эрүүлжүүлэх, саатуулах байрны сургалтын өрөөнд байршуулж, саатуулагдсан иргэдэд мэдээлэл өгч ажилладаг болсон.

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар, хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, тогтоогдсон эрхийн зөрчлийг арилгах, иргэнийг хуулийн дагуу саатуулах нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тусгасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай Зөвлөмжийг Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын даргад хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон.

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв болон Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрууд нь эмчийн үзлэгийн өрөөгүй байсан нь эрүүлжүүлэгдэж буй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд эрсдэл учруулахуйц нөхцөлийг бүрдүүлсэн байв.

Иргэний эрүүл мэндэд эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үйлчилгээг “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5527:2019” стандартын шаардлагад нийцүүлэх, цагдаагийн алба хаагч хүний эрхийг зөрчих, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 08/08 тоот

зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд Эрүүлжүүлэх, саатуулах төв, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь яаралтай тусламж үзүүлэх, эмчийн үзлэгийн өрөөг тус тус бий болгож, эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан иргэний эрүүл мэндийг сахин хамгаалахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, тариа, туслах материалаар хангагдсан, Эрүүлжүүлэх, саатуулах төв, байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхаас, алба хаагчид иргэдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энгэрийн камер ашиглалтыг тогтмолжуулж, энгэрийн камерын бичлэгийн сан үүсгэн ажилладаг болсон.

Нийслэлийн хэмжээний Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байруудад алба хааж буй цагдаа, жижүүр эмч, цагдаа жолооч зэрэг архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, холбогдох магадлалтай, энэ хэрээр хуулиар үл хязгаарлагдах эрхээ хамгаалуулах, шаардах чадвар нь суларсан иргэдтэй төрийн нэрийн өмнөөс анхлан уулзаж, эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлдэг алба хаагчдад иргэдтэй хуулийн дагуу харьцаж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, холбогдох хууль, тогтоомж, журмыг баримтлан, сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байхад хэлтсүүдийн удирдлагын зүгээс өдөр бүр зааварчилгаа, зөвлөмж өгч хэвшсэн, эрүүлжүүлэх, саатуулах орчин нөхцөлийг стандартад нийцүүлж байгаа зэрэг ахиц дэвшил гарч байна.

Хяналт шинжилгээний хүрээнд ажилласан нийт Цагдаагийн хэлтэс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдээлэл олгох сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг угтах үйлчилгээний орчин, Эрүүлжүүлэх, саатуулах байранд байршуулж хэвшсэн нь иргэдийн хуулиар үл хязгаарлагдах эрхийнхээ талаар мэдлэг, мэдээлэл авах чухал эх сурвалж болж байгаа нь эдгээр байршлуудад хийсэн хяналт шинжилгээний үеэр албадан саатуулагдсан, эрүүлжүүлэгдэж буй иргэдээс авсан асуумжийн хүний эрхийн зөрчлийн тухайд өгсөн хариултын илэрцээр тогтоогдсон.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2024 оноос Зөвлөмжийн хэрэгжилт нь “хангалтгүй” гэж үнэлэгдсэн байгууллагын удирдлагуудтай үргэлжилсэн яриа хэлэлцээр өрнүүлж, зөвлөмжийн биелэлтийн талаарх тодруулга, мэдээлэл авах, хангалтгүй, эсхүл ерөөс хэрэгжүүлээгүй зөвлөмжийн заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсох, цаашид хэрэгжүүлэх арга замыг дахин зөвлөх зэрэг тухайн зөрчил арилах нөхцөл бүрдэх хүртэл харилцан холбоотой ажилласнаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн хэрэгжилтийг нэг мөр хангагдахад ахиц дэвшил гарч байна.

Цагдаагийн байгууллагын тухайд, 2024 оны 12 дугаар сарын 04-ний 08/13 дугаартай Зөвлөмжийн хэрэгжилт 45 хувьтай “хангалтгүй” гэж үнэлэгдсэн тул Баянгол дүүргийн Цагдаагийн газрын удирдлагатай уулзаж, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийг цагдаагийн алба хаагч албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад санаатай болон санамсаргүйгээр үйлдэхгүй байх бүхий

л боломжит арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгч, хэрэгжилтийг нөхөн гүйцэтгүүлснээр 08/13 дугаартай Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт 93 хувийн гүйцэтгэлтэй хангагдсан.

Зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авсны дүнд Баянгол дүүргийн Цагдаагийн газар нь нэг, хоёрдугаар хэлтсийн алба хаагчдын болон мэдүүлэг авах өрөөнд 26, нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчдын өрөөнд 34 камерыг суурилуулсан, мэдүүлэг авах өрөө тус бүрд байрлах камерын дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бичлэгийг 30-аас дээш хоног хадгалдаг болсон, нийт 7 өрөөнд хөдөлгөөн мэдрэгчтэй, мэдүүлэг авах ажиллагаанд оролцогчийн царайг ойроос харах боломжтой камераар тоногдсон, хяналтын прокурор, хэргийн оролцогчдод цахимаар харилцах боломжийг бүрдүүлсэн зэрэг нь хэрэг бүртгэл, мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Цагдаагийн байгууллагын Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааг “Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага MNS 5527:2019”-д бүрэн нийцүүлэх нь эрүүлжүүлэх үйлчилгээний явцад иргэний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлийг бууруулах, хүний эрхийн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэх тул Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг Цагдаагийн байгууллагын холбогдох удирдлага, албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтийг нэг бүрчлэн тооцон ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах ажиллагааг уг стандартад нийцүүлэн явуулахгүй байгаа байдал нь албадан эрүүлжүүлэгдэж буй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигдөх, цаашлаад амь нас хохирох шалтгаан болж байгаа нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон.

Цагдаагийн байгууллагад эрүүлжүүлэгдэж байсан нийт 21 иргэн сүүлийн таван жилийн хугацаанд Нийслэл болон орон нутаг дахь Эрүүлжүүлэх, саатуулах байранд нас барсан тохиолдол бүртгэгдсэнээс 2022 – 2024 онд 10 иргэн амь нас хохирсон тохиолдлуудад албан шалгалт явуулахад 5 тохиолдолд Эрүүлжүүлэх байранд баримтлах стандарт зөрчигдсөнөөс үүдэлтэй нь тогтоогдож, холбогдох албан тушаалтнуудад Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийг үндэслэн сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны ажлын хэсэг Баянхонгор аймгийн Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд хяналт шинжилгээгээр ажиллах үедээ албадан эрүүлжүүлэгдэж байсан иргэн нас барсан тохиолдлыг баримт бичигтэй танилцах явцад олж мэдсэн. Эрүүлжүүлэх, саатуулах байрны удирдлагын зүгээс ажлын хэсгийнхэнд өгсөн мэдээллээр “иргэний зүрх зогссон” гэсэн урьдчилсан дүгнэлттэй байсан ба энэ нь Эрүүлжүүлэх, саатуулах байрны нэг хүнд оногдох талбайн хэмжээ MNS 5527:2019 стандартад нийцээгүй, үүнээс үүдэлтэй халуун бүгчим, агааргүй орчин нөхцөлд тухайн иргэний эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулсан байж болзошгүй байв.

Иргэний амь нас хохирсон уг тохиолдолд албан шалгалт явуулж, улмаар Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны



өдрийн Б/115 дугаар тушаалаар тус газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга, тасгийн эрүүлжүүлэх саатуулах байр хариуцсан дарга, эмч зэрэг албан тушаалтнуудад сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу “хууль бусаар баривчлах”, 14.1 дүгээр зүйл буюу “ялгаварлан гадуурхах”, 21.12 дугаар зүйл буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэргүүдийн тухай гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаар Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд ирүүлсэн мэдээгээр 2017 оны сүүлийн хагас жил, 2018-2022 онд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэж, 471 хүн тэдгээрт шалгагдсанаас 359 гомдол, мэдээлэлд буюу 93,2 хувьд нь цагдаагийн алба хаагч холбогдсон бол 2023 онд 87 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 82 нь зөвхөн “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжтэй байсан ба тэдгээрт нийт 16 цагдаагийн алба хаагч холбогдон шалгагдсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа Эрүүгийн хуулийн Тусгай ангид зүйлчилсэн “хууль бусаар баривчлах”, “ялгаварлан гадуурхах”, “эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ЦЕГ-ын өмнөх болоод одоогийн удирдлага, төв, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн дарга, удирдлагуудад хүргүүлсэн Зөвлөмжүүдэд удаа дараа тусгаж, Цагдаагийн байгууллагад хийх хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг арга хэмжээ бүрд үр дүнд суурилсан оновчтой, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удаа дараа зөвлөн сануулсаар ирсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн цагдаагийн алба хаагч энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөсөөр байтал хэрэгжилтийг үр дүнтэй хангаж ажиллаагүйн улмаас чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэнд эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцсан гэх гомдол, мэдээлэлд Булган аймгийн Сайхан сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад С, У нар, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын цагдаагийн алба хаагч О нар 2023 онд, Говь-Алтай аймгийн Бигэр сумын хэсгийн төлөөлөгч Б, Баянхонгор аймгийн Эрүүгийн цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, Баянгол, Сүхбаатар дүүргүүдийн Цагдаагийн хэлтсийн нэр бүхий алба хаагчид 2024 онд холбогдон шалгагдсан, тодорхой тохиолдлуудын гэмт хэргийн чанартай болох нь тогтоогдож, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, мөн хуулийн Тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээсэн.

Цагдаагийн байгууллагын орон нутгийн газар, хэлтсийн алба хаагчид эдгээр гэмт хэрэгт илүүтэй холбогдсон байгаа нь Цагдаагийн ерөнхий газрын орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаа дахь хяналт, хариуцлагын тогтолцоо сул байгааг илтгэж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т заасан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны

зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэх бүрэн эрхийн хүрээнд “эрүү шүүлт тулгах”, “хууль бусаар баривчлах”, “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт цагдаагийн алба хаагч холбогдохоос урьдчилан сэргийлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйн улмаас алба хаагч эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдон, эрүүгийн хариуцлага хүлээсэн Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын холбогдох удирдлагад хариуцлага тооцох, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх саналыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08/485 тоот “Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын даргад хүргүүлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь 2022 оны 08 дугаар сараас 2025 оны 03 дугаар сарыг хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байруудад хийсэн хяналт шинжилгээний хүрээнд хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, албадан эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан 1,180 иргэн болон 451 цагдаагийн алба хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар асуумж авсан.

Энэ хугацаанд авсан асуумж нь тухайн байршлуудад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл, цагдаагийн алба хаагчдын үйлдэж буй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийг тодорхойлох мэдээллийн бааз суурь болсон.

Асуумжийн илэрцэд дүн шинжилгээ хийснээр Цагдаагийн байгууллагын нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтэд ялангуяа ахлагч бүрэлдэхүүний иргэнтэй харьцах үйл ажиллагаанд тодорхой зорилгогүйгээр, ажлын хэвшмэл арга барил хэлбэрээр хайхрамжгүй үйлдэгддэг, бие махбодод шарх сорви үлдээдэггүй ч удаан үргэлжилдэг, хэзээ ч бүрэн эдгэдэггүй сэтгэцийн гэмтэл учруулдаг, хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор доромжилсон, хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж, ялгаварлан гадуурхах зөрчил тогтоогдсон.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хэрэгжилтэд хэрэг хүлээлгэх зорилгоор бие махбод, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох шинжтэй “эрүү шүүлт тулгах” үйлдэлд тооцогдох зөрчил хэвшин үйлдэгдэж байгааг тогтоосон.

Төрийн албан хаагч нь аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүстэй харьцах үйл ажиллагаа явуулахдаа хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдэл гаргасан бол уг үйлдлийг “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн нэгэн адил үзэх, мөн түүнээс урьдчилан сэргийлэх тухай Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйлд заасан.

Асуумжид оролцсон 451 алба хаагчдын 70 хувь буюу 317 нь гэмт хэрэг, зөрчилд шалгагдаж буй хүнтэй хэрхэн харьцах, ярилцах талаар сургалтад хамрагддаг гэж хариулсан. Тэдгээрийн 299 нь эрүү шүүлт тулгах, хүнлэг бус

харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар сургалтад хамрагдсан гэсэн байв. Асуумжид хамрагдсан цагдаагийн алба хаагчдын 66 хувь нь иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон гэх боловч урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийн төлөв байдал нь цагдаагийн байгууллагын сургалт, тэр дундаа ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтын агуулга, сургалтаас олж авсан мэдлэг, мэдээллийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж буй эсэхэд тавьдаг удирдлагын хяналт, хариуцлагын тогтолцоо шууд холбоотойг харуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга болон бусад газар, хэлтсийн удирдлагад хүргүүлсэн Зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний тайланд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангаж ажиллах хүрээнд олон тооны сургалт, нөлөөллийн ажлыг алба хаагчдад явуулсан гэх мэдээлэл тогтмол агуулагддаг боловч 2022-2025 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд асуумжид оролцсон эрх чөлөөгөө хасуулсан 1,180 хүний 48,7 хувь буюу 574 нь эрүү шүүлтээс ангид байх эрх нь хэрхэн зөрчигдсөн, цагдаагийн алба хаагчид өөртэй нь хэрхэн хүнлэг бус, хэрцгий хандсан талаар бичсэн байгаа нь Цагдаагийн байгууллагын сургалт, нөлөөллийн ажил оновчтой бус байгаатай холбоотой.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчил үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл нь нэг талаас алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, боловсролын түвшинтэй салшгүй холбоотой байгаа нь ийнхүү тогтоогдож байх тул хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхэд суурилсан үр дүнтэй ярилцлага хийх “Мендезийн зарчмууд”-ыг нутагшуулах, эрүүлжүүлэх, саатуулах ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх, цагдаагийн бүхий л үйл ажиллагаанд НҮБ-ын “Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-ыг мөрдлөг болгон хэвшүүлэхэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг Цагдаагийн байгууллага болон Олон улсын байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байна.

Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” (Мендезийн зарчмууд)-ыг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд нутагшуулах хүрээнд Швейцарын холбооны улсын Женев хотноо төвтэй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллага, Цагдаагийн ерөнхий газартай хамтран 3 үе шат бүхий сургалт – хэлэлцүүлгийг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба Нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран “Хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 онд хийж гүйцэтгэж ажлын төлөвлөгөө”-г батлан хамтран ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссаруудын газар нь Хүний эрхийн билл, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон бусад хүний эрхийн конвенцууд, Хууль сахиулах байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны хүч хэрэглэх, галт зэвсэг ашиглах үндсэн зарчим, Аливаа хэлбэрээр баривчлагдсан болон хорих ял эдэлж байгаа бүх хүнийг хамгаалах зарчмын багц зэрэг хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд баримтлах олон улсын дүрэм, журмуудыг эх

сурвалжаа болгон Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс болгон эрх зүйн тогтолцооноосоо үл хамааран дагаж мөрдөх ёстой “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-ыг 2004 онд баталсан ба түүнд цагдаагийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хүний эрхийн стандартуудыг тогтоосон. Тухайлбал:

Хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд:

- “Хууль сахиулахын албан хаагчид нь олон улсын хүний стандартуудыг мэдэх, хэрэглэх үүрэг хүлээнэ” гэж;

Хууль сахиулах ажиллагаа ба ёс зүйн зарчмын хүрээнд:

- “Хууль сахиулах байгууллагын албан тушаалтан нь хуулиар хүлээсэн үүргээ цаг ямагт чандлан биелүүлж, олон нийтэд үйлчилж, хууль бус үйлдлээс хүн бүрийг хамгаалж, чиг үүргээр хүлээсэн өндөр хариуцлагыг баримтлан ажиллана”; “Хууль сахиулах байгууллага нь хүний нэр төрийг хүндэтгэж, хамгаалж, бүх хүний эрхийг хангаж, хамгаална”; “Цагдаагийн байгууллагын бүхий л үйл ажиллагаа нь хууль ёсны, зайлшгүй байх ёстой ба ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байх, хүмүүнлэг байх зарчмуудыг хүндэтгэх ёстой” гэж;

Хууль сахиулах ажиллагаа ба ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хүрээнд:

- “Хуулийн өмнө хүн бүр адил тэгш бөгөөд ялгаварлан гадуурхагдахгүйгээр хуулиар тэгш хамгаалагдах эрхтэй”; “Цагдаагийн байгууллага нь нийгмийг хамгаалах, иргэдэд үйлчлэхдээ үндэс угсаа, хүйс, шашин шүтлэг, хэл, арьсны өнгө, улс төрийн үзэл бодол, хөрөнгө чинээ, гэр бүлийн байдал болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж;

Цагдаагийн байгууллагын тайлбар, мэдүүлэг авах ажиллагааны хүрээнд:

“Хүн бүр өөрийнхөө аюулгүй байдлыг хангуулах эрхтэй”; “Хүн бүр шударга шүүхээр шүүлгэх эрхтэй”; “Шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл хүн бүр гэм буруугүйд тооцогдоно”; “Мэдүүлэг өгч буй иргэний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй”; “Сэжигтэн, гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа бие махбодын болон сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглоно”; “Эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлохыг туйлын хориглоно”; “Хохирогч болон гэрчид хүнлэг, анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй”; “Хэнийг ч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг албадах ёсгүй” гэж;

Баривчлах ажиллагааны хүрээнд:

- “Хэнийг ч дур мэдэн баривчлах, цагдан хорихыг хориглоно”; “Баривчлагдсан хэн бүхэнд баривчлагдах болсон шалтгааныг тэр даруйд мэдэгдэнэ”; “Баривчлагдсан, цагдан хоригдсон бүх хүн өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгчтэйгөө уулзаж, харилцах хангалттай боломжоор хангагдана” гэж;

Цагдан хорих ажиллагааны хүрээнд:

- “Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг ёсоор хандаж, төрөлхийн нэр төрд нь хүндэтгэлтэй хандана”; “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хүн бүр шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдоно”; “Цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий,

хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх, аливаа хэлбэрээр хүчирхийлэх, заналхийлэхийг хориглоно”; “Цагдан хоригдсон этгээдийн эрүүл мэндийг сахин хамгаалахад шаардлагатай зориулалтын байранд байлгаж, зохих хоол хүнс, ус, орон байр, хувцас, эмнэлгийн үйлчилгээ, дасгал хөдөлгөөн хийх боломж, хувийн ариун цэврийн хэрэглэлээр хангана”; “Цагдан хоригдсон этгээдийн шашин шүтлэг, ёс суртахууны итгэл үнэмшлийг хүндэтгэнэ”; “Цагдан хоригдсон хүний нөхцөл байдлыг ашиглан түүнийг хэргээ хүлээхийг албадах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөд хүргэхийг хориглоно”; Сахилга, дэг журмыг сахиулах арга хэмжээ нь гагцхүү хууль, журамд нийцсэн байх бөгөөд аюулгүй байлгахад шаардлагатай хэм хэмжээнээс хэтрэх ёсгүй, хүнлэг бус байж болохгүй” гэж тус тус заасан.

Монгол Улсын Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хүний эрхэд суурилсан, олон улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд баримтлах стандартад нийцсэн бодлогыг баримтлах, үүний тулд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хангаж ажиллахад дагаж мөрдөх олон улсын конвенц, стандарт, журмуудын талаарх мэдлэг, боловсролыг байнга дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг чанаржуулах, үр дүнг баталгаажуулахын тулд хариуцлагын тогтолцоог бий болгох, энэ зорилгын үүднээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-д нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, хууль эрх зүйн зохицуулалтаар шаардлагатай нийцлийг хангах, Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл сургалтын төрөлд хүний эрхийн тухай суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг тусгах, Цагдаагийн алба хаагчдын ур чадварын үнэлгээнд хүний эрхийн мэдлэгийн үзүүлэлтийг тусгах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

## САНАЛ

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-д нийцэж буй эсэх, хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх;
- Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл сургалтын төрөлд хүний эрхийн тухай суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг нэмэлтээр тусгах;
- Цагдаагийн алба хаагчдын ур чадварын үнэлгээнд хүний эрхийн мэдлэгийн үзүүлэлтийг нэмэлтээр тусгах;
- “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.10 дахь заалтын

хүрээнд, түүнчлэн “Хүний эрхийг хангах Үндэсний II хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн зүүн, баруун бүсэд эрүүлжүүлэх, саатуулах нэгдсэн төв, аймгуудад эрүүлжүүлэх, саатуулах байруудыг Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ Ерөнхий шаардлага MN 5527:2019 стандартад нийцүүлэн ашиглалтад оруулах;

- Холбогдох хууль эрх зүй, стандартад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах чиг үүргийг эрүүл мэндийн байгууллагад хариуцуулах;
- Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, алба хаагч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалтыг эрүүл мэндийн байгууллагаас үе шаттай зохион байгуулж, хамтын ажиллагааг сайжруулж, алба хаагчдыг чадавхжуулах;
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай үйлчлүүлэгчийн эрэмбэлэх журам”-ын 4.2.8-ыг үндэслэн яаралтай түргэн тусламжийн эмч нь дээрх нөхцөл байдлыг тогтоох боломжгүй бол ойр байрлах эмнэлгийн яаралтай тусламжийн хүлээн авах тасагт хүргэж, шаардлагатай үзлэг, шинжилгээ хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хийх



## 2.4 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН ЭЭЛЖИТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

**Нэг.** Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34.1.1 дэх заалт, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 2.1 дэх хэсэг “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх” заалтыг тус тус үндэслэн ШШГ байгууллагын хорих анги, цагдан хорих, саатуулах, баривчлах байруудад тогтмол хяналт шинжилгээ хийж ажиллав.

ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн 2022 оноос хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нэгж, байгууллагуудад 43, үүнээс тайлант хугацаанд 22 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг НҮБ-ын ЭШЭК-ын Нэмэлт протоколын зарчим, хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дагаж мөрдөх олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хязгаарлаж болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн ба ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нийт 24 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажилласан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ШШГЕГ-ын болон салбар, нэгжүүдийн дарга, удирдлагад хүргүүлсэн зөвлөмж бүрд сахилга, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээр арга хэмжээ авах талаар дурдсаар ирсэн боловч салбар, нэгжүүдэд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, тогтмол очиж хяналт шинжилгээ хийх бүрд өмнөх алдаа дутагдал, зөрчил дахин давтагдан тогтоогдох нөхцөл байдал илэрсээр байв.

Тиймээс тайлант хугацаанд ШШГ байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд нэгдсэн дүн шинжилгээ хийж ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболорт хандаж хоёр чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:

*1.Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдахгүй байсаар, тодорхой тохиолдлуудад эдгээр эрхийн зөрчил нь байгууллагын дотоод журамд тусгагдан, дагаж мөрдөгдөх үйл ажиллагаа болтлоо хэлбэржин оршсоор байгааг таслан зогсоох чиглэл бүхий Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 08/09 дүгээр зөвлөмж*

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааны алба хаагчдын чиг үүргээ биелүүлэх явцад баримтлах сахилга, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн нөхцөл байдлыг анхаарч ажиллах чиглэл бүхий 08/10 дугаар зөвлөмжийг тус тус хүргүүлж салбарын хэмжээнд засаж сайжруулах шаардлагатай зөрчил дутагдлыг цогцоор нь дүгнэж ажилласан.*

Тайлант хугацаанд ШШГЕГ-ын харьяа 409, 437, 427, 407, 405, 439, 445, 435, 457, 413, 423 дугаар хорих ангиуд, Төв, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Налайх, Багахангай

дүүргийн Цагдан хорих, баривчлах байруудад тус тус урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Эдгээрээс ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 08/14 дүгээр зөвлөмж, ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаярт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 27-ны 08/15 дугаар зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

### **Хоёр. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний аргачлал**

ШШГ хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, Цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байруудад хяналт шинжилгээг хийхдээ тус байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтан, хорих ангид хорих ял эдэлж байгаа, цагдан хоригдсон, баривчлагдсан, саатуулагдсан хүмүүстэй ярилцлага хийх, түүврийн аргаар асуумж бөглүүлэх, холбогдох баримт бичигтэй танилцах шаардлагатай бол хуулбарлан авах, хорих анги, цагдан хорих, саатуулах, баривчлах байрны нөхцөлийг дууны, дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан баримтжуулах аргачлалыг ашиглаж ажилласан.

ЭШУС үндэсний үйл ажиллагаа нь 2022 оноос хойш 4500 хорих ял эдэлж буй хүмүүс, 707 шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас асуумж авч, шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан уулзалт хийж ажилласан. Үүний дүнд хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэний эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийг тодорхойлж гаргаж ирсэн.

Тайлант хугацаанд 150 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, 19 ШШГ байгууллагын алба хаагчтай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, 894 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэн, 50 алба хаагчаас асуумж авсан.

Асуумжид оролцсон хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүсийн 32 хувь нь алба хаагчдын зүгээс бие махбодын, 45 хувь нь сэтгэцийн эрүү шүүлтийн хэв шинжид хамаарах дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, доромжлох зорилгоор бие махбодын болон сэтгэл санааны хүнд өвдөлт, зовлон зүдүүр учруулах шинжтэй эрхийн зөрчилд өртсөн гэсэн бол 23 хувь нь хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хэрцгий, хүнлэг бус харьцаа, хүнийг доромжлох, гутаах зорилготой болон ялгаварлан гадуурхах шинжтэй үйлдэл, харьцаанд өртдөг гэсэн асуумжаар авсан дүгнэлтийг бид гаргаад байна.

ЭШУС хяналт шинжилгээний хүрээнд хорих анги, цагдан хорих байр, төвийн алба хаагчдаас хоригдсон, баривчлагдсан хүнтэй хэрхэн харьцах, ярилцах талаар сургалтад хамрагддаг эсэх талаарх асуумж авахад 75,6 хувь нь хамрагддаг болохоо илэрхийлсэн. Хэдий тийм боловч алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүсийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн эсрэг үйлдэл гаргасаар байгаад анхаарлаа хандуулж ажиллаж байна.

Мөн ЭШУС үндэсний ажиллагаа нь 3,878 хорих ял эдэлж буй хүмүүсийн хорих ял шийтгэгдсэн байдлын давтамжид судалгаа авахад 1,285 нь буюу 33.1 хувь нь хоёр болон түүнээс дээш удаа хорих ял шийтгэгдэн ял эдэлж байгаа тухай хариулсан.

### **Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай ангийн товч танилцуулга**

ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Сайд нарын зөвлөлийн 1985 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 301 дүгээр тогтоол, Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1985 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 985 тушаалаар, 1986 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони нэртэйгээр анх байгуулагдан цэргийн 45, энгийн 7, нийт 52 алба хаагчтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тухайн үед 3 гэрт конторлож чанга дэглэмтэй ялтанд хяналт тавин тэдний дундаас гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, мод зүсэх чиглэлээр байгуулагдсан бөгөөд бүтээгдэхүүнээ БНХАУ-д экспортлон, дотооддоо борлуулан ажиллаж байсан.



Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 82 дугаар тогтоолоор 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги болон нээлттэй дэглэмийн хоригдлуудыг шинээр хүлээн авч эхлэн, шинэчлэн байгуулагдаж, одоог хүртэл үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.



- 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт байрлалтай бөгөөд хоригдлын байр нь 2008 онд ашиглалтад орсон 1050 м<sup>2</sup> талбай бүхий 2 давхар барилга, нийт 50 хорих өрөөтэй ба 420 хоригдол хүлээн авах багтаамжтай.

- Тус анги нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, хоригдлыг иргэний эрх зүйн харилцаанд оролцох эрхийг хангах зорилгоор “Гео инженер сүрвей” ХХК-ийн хөгжүүлж боловсруулсан “Мини хөтөч 2.0” киоск төхөөрөмж бүхий системийг нэвтрүүлэн ажиллаж байна.
- Тус ангийн нийгэм, сэтгэл зүйн нэгж нь хоригдлыг ял эдлэх эхэн үе, дунд үе, суллагдахын өмнөх үе гэсэн 3 үе шаттай сургалтад хамруулан, батламж, чадамжийн гэрчилгээ зэргээр урамшуулах ажлыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Хоригдлын сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгаж эерэг нөлөөлөл үзүүлж, тулгамдсан асуудлыг шийдэх, гэр бүлийн тогтвортой харилцааг бий болгох зорилгоор хоригдлын болон ар гэрийн хүсэлтийн дагуу гэрлэлт бүртгүүлэх, бичиг баримтжуулах ажиллагааг Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулж байна.



Хорих ял эдэлж буй хоригдлыг цалинтай ажлын байраар хангах, ажлын дадлага, туршлага олгох, мэргэжил эзэмшүүлэх, цагийг үр ашигтай өнгөрүүлэх, нийгэмшүүлэх, бусдад учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулах зорилгоор тус хорих анги нь иргэн, аж ахуйн байгууллагатай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулан ажилласан 2024 онд нийт 162 хоригдолд 370,160,297 төгрөгийн цалин бодож, ХХОАТ-т 37,016,029.7 төгрөгийг тушааж, гэм хорын төлбөрт 41 хоригдлын 57,350,940 төгрөг суутган шилжүүлж гарт 275,793,327 төгрөгийг олгосон нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.

- 2024 оны жилийн эцсийн байдлаар ял эдэлж буй хоригдлын зүгээс ангийн даргатай уулзах хүсэлт гаргасан 52, ангийн Арга зүйн зөвлөлийн хуралд оролцох 126, төрийн болон төрийн бус байгууллага, бусад иргэн, байгууллагад хандан гаргасан 139, нийт 317 хүсэлт, өргөдөл, гомдлыг тус тус хүлээн авч, хуулийн хугацаанд тухай бүр шийдвэрлэж, холбогдох албан тушаалтнуудад уламжлан ажилласан.

## 427 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ

2020-2024 ОНД ХОРИГДЛООС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

д/д	Хаана хэнд	Агуулга	Он												Тайлбар			
			2020			2021			2022			2023				2024		
			Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН	Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН	Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН	Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН	Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН	Нийт	ШИЙДЭРЛЭСЭН БУЦААСАН, ХОЙШЛУУЛСАН				
1	Ангийн захиргаанд	Биечлэн уулзах	18	18	-	26	26	-	38	38	-	47	47	-	52	52	-	
		Ангийн арга зүйн хуралд орох	192	119	73	151	85	86	135	81	54	153	77	76	199	126	73	
		Бусад албан тушаалтай холбоотой	1	1	-	-	-	-	-	-	-	3	3	-	-	-	-	
2	Бусад төрийн болон төрийн бус байгууллагад	Бусад асуудлаар	74	74	-	192	192	-	529	529	-	124	124	-	140	139	1	Өөрийн хүсэлтээр буцаасан 1 хүсэлт
Нийт			285	212	73	369	303	66	702	648	54	327	251	76	391	317	74	
Тус хорих ангид 2020-2024 оны байдлаар хоригдлын зүгээс нийт 2074 хүсэлт ирснээс 1731 хүсэлтийг шийдвэрлэж, 343 хүсэлтийг өөрийн хүсэлтээр болон ангийн арга зүйн хуралдаанаар хэлэлцэн хүсэлтийг буцаасан болон хойшуулсан.																		

Хоригдлын дундаас гаргасан өргөдөл, гомдлын сүүлийн 5 жилийн судалгаа

**Дөрөв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 437 дугаар нээлттэй, хаалттай ангийн товч танилцуулга**

Тус хорих анги нь анх Монгол Улсын Засгийн Газрын 1990 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 153 дугаар тогтоолоор Хорих Байгууллагыг Удирдах газрын харьяа Эрдэнэт хотын Засан хүмүүжүүлэх Хорих анги нэртэйгээр одоогийн Орхон аймгийн Дэнж багийн нутаг дэвсгэрт орших хуучин орос цэргийн ангийн сахилгажуулах батальоны байрыг засаж, тохижуулан байгуулагдсан цагаас хойш 32 дох жилдээ үйл ажиллагаагаа тасралгүй явуулан ажиллаж байна.

Тус хорих анги нь Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 312 дугаар тогтоолоор тус газрын харьяанд жирийн дэглэмтэй төвлөрсөн хорих 437 дугаар анги шинээр зохион байгуулагдан жирийн дэглэмтэй хорих анги, баривчлах байр, цагдан хорих, шийдвэр гүйцэтгэл гэсэн 4 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад ШШГЕГ-ын даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн Б/1077 дугаар тушаалаар Орхон аймаг дахь ШШГ газар-437 дугаар нээлттэй хорих анги болгон нэр, хаяг өөрчлөгдөж Шийдвэр гүйцэтгэлийн тасаг, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тасаг, Хорих анги, Хорих байр гэсэн 4 чиглэлд батлагдсан орон тоогоор 76 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Анги, байгууллагын нийт талбай 21.781м<sup>2</sup> хэмжээст 721 метр урт, 5 метр 30 см өндөртэй үндсэн хашаагаар тусгаарлан үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Хорих ангийн нийт талбайн хэмжээ 675м<sup>2</sup>, нэг өрөө 29м<sup>2</sup> бүхий 12 хорих өрөөтэй хорих ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулан ажилладаг.





Шинээр хорих ял шийтгүүлсэн Шүүхийн тогтоолыг үндэслэн зэрэглэлийг ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны хоригдлыг ял эдлүүлэх, хорих анги болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөлийн тогтоолоор хэлэлцэн шийдвэрлэсэн хоригдлыг хууль, тогтоомжид заасанчлан эрх, үүргийг танилцуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж харуул хамгаалалтын ажлыг зохион байгуулж байна.



Тус анги нь 2023-2024 онд бүтээн байгуулалтын чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд:

Албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр захиргааны байр, гадна жагсаалын талбай, хашаа, гэрэлтүүлэг, индэр зэргийг шинээр бүтээн байгуулж ангийн гадна болон дотор тохижилтыг хийж ажилласан.

Алба хаагчдын ажиллах ачааллыг бууруулах, иргэдэд төрийн үйлчилгээг тохилог орчинд хүлээн авах зорилт тавин ангийн захиргааны байранд засварын ажил хийж иргэдийг угтах үйлчилгээнд 18 офицерыг 08:00-18:00 цагийн хооронд жижүүрээр ажиллуулж байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл авах дэлгэц бүхий киоск төхөөрөмж байрлуулж иргэдэд туслах үйлчилгээ үзүүлж байна.

Алба хаагчийн ажлын байрны орчин нөхцөлийг хэвийн тасралтгүй явуулах, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэх, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор дүн шинжилгээг хийж Эмнэлгийн албаны өрөө тасалгааг стандартжуулан засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн.

Мөн хорих ангийн телекамерын хяналтын өрөөг хорих ангийн нэгдсэн байрны 2 давхарт байсныг хоригдлын амьдралын бүсээс гарган захиргааны байрны 2 давхарт нүүлгэн шилжүүлж зохих стандартад нийцүүлэн, алба хаагчийн ажиллах орчин, албаны нууцлалыг хангаж ажилласан.





Орон нутгийн төсвийн төсөлд 2024 онд Хорих ангийн засвар үйлчилгээнд 111,8 сая төгрөгийг шийдүүлж ажилласан бөгөөд тендер шалгаруулалтын шатанд үйл ажиллагаа явагдаж байна. Тухайн төсвийн хөрөнгөөр хорих ангийн өрөө тасалгаа, нийгэм, сэтгэлзүйн нэгжийн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг стандартжуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Орон нутгийн 2024 онд нийт 363.5 сая төгрөгийг төсвөөс шийдүүлж гал тогооны, техник хяналтын, эмнэлгийн тусламж үйлчилгээний, нийгэмшүүлэх ажлын тоног төхөөрөмж болон шахмал түлшний машин, чулуун, модон, төмрийн снс тоног төхөөрөмжүүдийг авч үйл ажиллагаанд ашиглаж байна.



Тус анги нь хоригдолд хөдөлмөрийн дадал олгох, хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, ажлын байраар хангах, гэм хорын төлбөрийг барагдуулах үйлдвэрлэлийн төрөл чиглэлийг өргөжүүлэхэд анхаарч үйлдвэрлэлийн судалгаа явуулж хоригдогсдыг ажлын байраар хангахад анхаарч хоригдлыг ажлын байраар ханган зорилгоор хоригдлын мужаан цехэд сийлбэртэй шатар, эмээлийн тавиур, морин хуур, сийлбэртэй цаг бусад бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, суран эдлэл, хазаар ногт, чөдөр хийлгүүлж худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилладаг.

Мөн “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-тай баяжмалын уут оёж нийлүүлэх гэрээг хийж үргэлжлүүлэн ажиллаж байна.

### **Тав. Хууль эрх зүйн орчин**

ШШГ байгууллага нь түүхэн хөгжлийн явцад 1930, 1936, 1940, 1956, 1963, 1981, 1992, 1996 онуудад байгууллагын нэршил тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдан өөрчлөгдөж байсан ба 2002 оноос одоог хүртэл ШШГЕГ нэршилтэйгээр хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, иргэний шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийн тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолоор ШШГ



байгууллагын хаалттай 5, нээлттэй 7, нээлттэй, хаалттай 5 хорих анги, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих 1, нийт 21 хорих анги, баривчлах төв байр тус бүр 1, Улаанбаатар хотод цагдан хорих төв 1, орон нутагт цагдан хорих байр 28, баривчлах 5 байртайгаар ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.



ШШГ байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Согтууруулах, мансууруулах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд, Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай, Хорих байгууллагын албан хаагчдад хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журмын тухай, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журмын тухай, Хорих байгууллагын алба хаагчдын ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журмын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, ШШГ байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалтын хэмжээ тогтоох тухай Засгийн газрын тогтоолууд, Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам, Хорих ангийн дотоод журам, ШШГ байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам, Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх тодорхойлолт лавлагаа гаргах журам, ШШГ байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг батлах тухай, ШШГ байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам, Баривчлагдсан этгээдийн баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг тооцох журам, ШШГ байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх сэлгэн ажиллуулах журам, Хууль зүй, дотоод хэргийн салбарын шагнал олгох журам зэрэг Хууль зүй дотоод хэргийн Сайдын тушаалууд, ШШГ байгууллагын ажилтанд шагнал,

урамшуулал олгох журам, ШШГ байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг боловсруулах хэрэгжүүлэх журам, Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам, ШШГ байгууллагын үйлчилгээний стандарт, ШШГ байгууллага, Цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам, Нийгмийн ажлын аргачилсан заавар, ШШГ байгууллагын Ахлагчийн зөвлөлийн ажиллах журам, ШШГ байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэрэг ШШГЕГ-ын даргын тушаалууд болон холбогдох бусад баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

## **Зургаа. Урьдчилан сэргийлэх хяналт, шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал**



6.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболорт хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 10 дугаар сарын 18-ны 08/09 дугаар зөвлөмжийн хүрээнд:

ЭШУС үндэсний ажиллагаа нь хүний эрхийн, тэр дундаа хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийг илрүүлэх цогц арга ашиглан ШШГЕГ-ын харьяа салбар, нэгжүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзсэн тохиолдол бүрд НҮБ-ын холбогдох хэм хэмжээг харгалзан тэдгээрт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, байршин байгаа нөхцөлийг нь сайжруулах зорилгоор холбогдох удирдлага, албан тушаалтан, түүнчлэн салбарын сайдад ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт хорих ангиуд, цагдан хорих байр, төвүүдэд хангагдахгүй байсаар, тодорхой тохиолдлуудад эдгээр эрхийн зөрчил нь байгууллагын дотоод журамд тусгагдан, дагаж мөрдөгдөх үйл ажиллагаа болтлоо хэлбэржин оршсоор байгааг ил гаргах, даруй засаж залруулах арга хэмжээ авах цаг болсон хэмээн дүгнэлээ.

Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэний эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийн хэв шинж дараах байдлаар илэрч байна.

Олон улсын хүний эрхийн эрх зүйд “бие махбодын эрүү шүүлт”-ийн хэлбэрт тооцогддог дараах зөрчлүүд тогтоогдсон.

1.Ажлын заалтгүй хоригдлыг амралтын цагаас бусад үед модон, хуванцар сандал дээр удаан хугацаагаар суулгах буюу хорих ял эдэлж байгаа хүмүүсийн хэлж заншсанаар “зоонд суулгах”, “улааншугамд суулгах”. Биеийн тогтсон нэг байрлалд удаан хугацааны турш албадан байлгах, суулгах нь олон улсын хүний эрхийн эрх зүйд “албадлагын байрлал”, “стрессийн байрлал” гэх нэршилтэй эрүү шүүлт тулгах үйлдлийн нэг хэлбэр юм. Хатуу, чийг татдаг гадаргуу дээр удаан суулгадгаас болж хоригдлуудын цагаан мах эргэсэн, үргэлж цустай бие засдаг болсон, өдөр болгон суулгадаг учир цагаан мах, шамбарам нь эдгэрдэггүй, улам бүр хүндэрсэн, нуруу бөөрний өвчтэй болсон, хөдөлгөөний дутагдалд орсон, зүрх судасны өвчтэй болсон гэсэн илэрц бидний авсан асуумжид 32 хувийг эзэлж байна.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 08/08 дугаартай ШШГЕГ-ын даргад хүргүүлсэн зөвлөмжид хоригдлыг нэг газар олон цагаар, хэт удаан суулгаж, хүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хүнлэг бус хандлагыг даруй зогсоох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай тусгагдсан.

Гэвч ЭШУС үндэсний ажиллагааны 2023 онд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр ажилласан зарим хорих анги тухайлбал, 427 дугаар нээлттэй, хаалттай, 435 дугаар хаалттай, 445 дугаар нээлттэй, 457 дугаар нээлттэй, хаалттай, 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиудад энэ байдал илэрсэн бөгөөд 2024 оны хяналт шинжилгээгээр дахин тогтоогдсон нь ШШГЕГ-ын даргад хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж биелэгдээгүйг илтгэж байна.

2.Бясалгал хийлгэх буюу хорих ял эдэлж буй иргэдийн хэлж заншсанаар “бясалгалд хүчээр суулгах”. Энгийн үед бясалгал хийж суух нь тайвшрал өгч, оюун ухаанаа цэгцтэй болгоход хамгийн их нөлөө үзүүлдэг. Харин 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хийлгэж байгаа бясалгалд суулгах арга нь нэг төрлийн эрүү шүүлтийн дэглэм болжээ. Хүн халуун хоол, цайны дараа биеийн дулаан нэмэгдэж, тайвширч, хэсэг хугацаанд биеийн идэвх сулардаг.

Мөн орой унтахын өмнө бие махбодын идэвхтэй ажиллагаа суларч, нозоорлын байдалд ордог. Гэтэл өдрийн хоолны цагийн дараа, эсвэл амрах буюу шөнийн 22 цагийн өмнө бясалгалд суулгаж байгаа нь нэг талаас хүний бие махбодын биологийн процессыг алдагдуулж байгаа зовоох үйлдэл бөгөөд нөгөө талаас бясалгалын үеэрээ нойрмоглож унтсан хоригдлыг алба хаагч дур зоргоор шийтгэх “таатай” нөхцөлийг бүрдүүлжээ.

Хоригдлыг ял эдлүүлэх, ахуй нөхцөлөөр хангах, тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдүүлэх Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”-ын 13 дахь хэсэг, Хорих ангид мөрдөх цагийн хуваарьт үйл ажиллагаа хэмээх зохицуулалтын 13.6-д “Хорих өрөөний хаалгыг цоожтой байлгах ба амрах үед хоригдлыг хорих өрөөнд нэвтрүүлнэ” гэж заасан. Ял эдэлж буй нийт хоригдлыг хамруулах хангалттай сургалт, нийгэмшүүлэх ажил, соён гэгээрүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа, хоригдол бүрд хүрэлцэх ажлын байраар хангаагүй нөхцөлд сургалт, нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтэд хамрагдаагүй хоригдлыг хорих өрөөний гадна удаан хугацаагаар сандал дээр суулгах болон бясалгал хийлгэж суулгах нь тус заалтыг хорих ангийн хуваарьт үйл ажиллагаа болгон мөрдүүлэх шалтгаан болж, улмаар хоригдлын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байна.

3. Эрх чөлөөгөө хасуулснаас бусад жам ёсны эрх тухайлбал, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хязгаарлах үйлдэл. НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 24-т хоригдлуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг болохыг дурдсан ба хоригдлууд эрх зүйн байдлынх нь үндэслэлээр ялгаварлан гадуурхагдахгүйгээр энгийн иргэдэд үзүүлдэг эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх тухай заасан байдаг.

Түүнчлэн 27 дугаар дүрэмд хорих анги нь яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, үүний тулд өвчтөнийг зохих ёсоор сувилах, эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмийн хангамжтай байхыг, мөн нарийн мэргэжлийн эмчилгээ шаардлагатай хорих ял эдэлж буй хүнийг төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, эсвэл иргэдэд үйлчилдэг ердийн эмнэлэгт шилжүүлэхийг тусгасан. 30 дугаар дүрмийн (а) хэсэгт “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, эмчилгээнд шаардлагатай бүх арга хэмжээ авах”-ыг заасан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ганцаарчлан уулзсан, ярилцсан, асуумж судалгаанд хамрагдсан хорих ял эдэлж буй хүмүүсийн 42 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээг зохих ёсоор авч чаддаггүй гэж хариулсан нь анхаарал татаж байна. Ялангуяа эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж тун хангалтгүй байдгаас ар гэрээс нь захиалж хэрэглүүлдэг явдал ШШГЕГ-ын харьяа салбар, нэгжүүдэд нэгэнтээ энгийн үзэгдэл болжээ.

Нөгөө талаас гэр бүлийнхнийх нь зүгээс харилцаагүй болсон, эсхүл ойр төрлийн садангүй хоригдол хорих ангийн эмийн хангалт хүрэлцээгүй бол эмчлүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг тэгш хүртэх эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг тухай тэмдэглэл асуумжид бий. Эмнэлгийн ажилтны мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүйн асуудал ч энд хөндөгдөнө. Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид цагдан хоригдож байсан 21 настай, О гэх иргэн 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Гуравдугаар төв эмнэлэгт хүргэгдсэн боловч амин үзүүлэлтүүд нь сэргэхгүй байсаар нас барсан явдал нь эмнэлгийн анхан шатны болон бусад шатлалт мэргэшлийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдийн хариуцлагагүй байдлаас үүдсэн байж болзошгүй байна.

4. “Хэрэгцээт хоол хүнсээр хангагдах” эрхийг хязгаарлах үйлдэл. НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 22-т “Хорих ангийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдол бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалагдахад хангалттай тэжээллэг, сайн чанарын, сайтар бэлтгэж боловсруулсан хоол, ундаар хангана” гэж тусгасан.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/214 дүгээр тушаалаар батлагдсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлыг хоногийн хоол хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм”-д мах болон бусад нэр төрлийн хүнсний хэрэглээнээс авах илчлэгийн хэмжээг эрх чөлөөгөө хасуулсан иргэдийн тухайд 3400-3500 ккал байхаар, хоногт авах махны хэрэглээг:

- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь 200 грамм;
- Нээлтэй хорих ангид ял эдэлж буй хоригдол 230 грамм ;
- Хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдол 210 грамм байхаар заасан байна.

Хэдий тийм боловч урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ганцаарчлан уулзсан, бүлгийн ярилцлагад оролцсон, мэдээлэл өгсөн, асуумж,



судалгаанд хамрагдсан хорих ял эдэлж буй иргэдээс авсан мэдээлэл, тэмдэглэлд хоол хүнсний чанар хангалтгүй гэх үнэлгээг 70 хувь нь өгсөн бөгөөд ялангуяа “7 хоногт нэг л удаа махан хоол өгдөг” гэсэн хариулт давамгайлсан.

*Ганцаарчилсан уулзалт, ярилцлага, асуумж судалгаа болон урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд гаргуулан авч, дүн шинжилгээ хийсэн баримт бичиг, тэмдэглэлийн хүрээнд тогтоогдсон нөхцөл байдал нь “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлыг хоногийн хоол хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм” хэрэгжихгүй байгааг нотолсон төдийгүй, дээр дурдсан “Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах илчлэг, шимт бодисын зөвлөмж хэмжээ”-нд ч хүрэхгүй байх эрсдэлтэйг харуулж байна.*

Хоолноос авах ёстой шим тэжээлээ авч чаддаггүйн улмаас дархлаа унасан, өвчинд өртөмтгий болсон, кальцийн алдагдалд орж, шүд үйрч унасан, яс сийрэгжсэн, гар хөл янгинадаг болсон буюу “доройтолд өртсөн” гэх тэмдэглэл хорих анги бүрд хамаарах асуумжийн хариултад бий. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар баталсан «Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах илчлэг, шимт бодисын зөвлөмж хэмжээ»-нд:

- 18-29 насны эрэгтэй хүний хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэгийн хэмжээ 2,400, эмэгтэй хүний тухайд 1,990 ккал;
- 30-59 насны эрэгтэй хүний хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэгийн хэмжээ 2,380, эмэгтэй хүний тухайд 1,850 ккал;
- 60 болон түүнээс дээш настай хүний хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэгийн хэмжээ 1,920, эмэгтэй хүний тухайд 1,680 ккал байна гэж заажээ.

Мөн тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-нд:

- Малын махны хоногт хэрэглэх хэмжээ 120 грамм;
- 3,2 хувийн тослогтой сүү 160 грамм;
- Цагаан идээ /тараг/ 180 грамм;
- Гурил 100 грамм;
- Гурилан бүтээгдэхүүн 180 грамм;
- Төрөл бүрийн будаа 50 грамм;
- Хүнсний ногоо 260 грамм;
- Буурцагт ургамал 40 грамм;
- Жимс жимсгэнэ 200 грамм;
- Өндөг 20 грамм;
- Ургамлын тос 23 грамм;
- Сахар, чихрийн зүйлс 33 грамм байхаар тус тус Монгол хүний хүнсний дундаж хэрэглээг үндэслэн тогтоосон байна.



5. Жам ёсны буюу “эрүүл байх” эрхийн эсрэг үйлдэл. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүсийн эрүүл байх эрхийг хангах, дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш бус байдлыг бууруулах нь тэдний амьдралын туршид сайн сайхан байдлаа хадгалах баталгаа юм.

Эрүүл хараа, эрүүл шүдтэй хүн хорих ангид ирээд хоригдож буй орчны нөхцөлөөс болж хараа нь эрс муудсан гэх мэдээлэл хяналт шинжилгээний явцад бидэнд олонтоо ирсэн бөгөөд тухайлбал, хоёр давхар орны дээд хэсэгт унтдаг хоригдолтой тун ойр буюу 1 метрийн зайд хурц гэрэл байдаг, шөнийн цагт ч асаалттай байлгадаг тул тухайн хүний хараа богино хугацаанд эрс мууддаг тухай асуумжид оролцогсод тэмдэглэн үлдээжээ.

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 43-т хоригдлуудыг байнгын гэрэлтэй өрөөнд байрлуулах нь эрүү шүүлтийн нэг хэлбэр бөгөөд энэ явдлыг хориглох тухай заасан бол 14 дүгээр дүрмийн (б)-д өрөөний гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд гэмтэл учруулахааргүй байх ёстойг дурдсан. “Эрүүл ирээд, өвчний үүр болоод суллагдах нь” гэж бичсэн нэгэн хоригдлын үгийг энд иш татах нь ямар ч хууль, журам, олон улсын гэрээ конвенцыг дурдахаас илүү ихийг өгүүлнэ.

6. “Ариун цэвэр сахих” жам ёсны эрхийг хязгаарлах үйлдэл. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”-ын 4.2-т “Халуун усны газарт шүршүүрийг байрлуулж, батлагдсан хуваарийн дагуу 14 хоног тутам хоригдлыг усанд оруулж, бүртгэл хөтлөх ба хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран тухай бүр усанд оруулж болно” хэмээн заасан нь хорих ял эдэлж буй иргэний ариун цэвэр сахих жам ёсны эдлэх эрхийг хязгаарлаж, ердийн цаг агаарын нөхцөлд ядахдаа 7 хоногт нэг удаа халуун усанд орж байх хэмжүүрийг тогтоосон НҮБ-ын хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 16 дугаар дүрмийг хангахгүй байна.

Ихэнх хорих анги уг журмын заалтаас үл хамааран хоригдлын 7 хоног тутам халуун усанд орох эрхийг хангаж байгаа нь сайшаалтай боловч “14 хоног” гэх заалтыг баримталж байгаа талаар 435 дугаар хаалттай хорих ангид ял эдэлж буй иргэдийн асуумжийн хариултад дурдагдсан бөгөөд өөр бусад салбар, нэгжид ч уг заалт хэрэгжиж байх магадлалтай.

Аливаа улсын хүний биеийн өсөлт хөгжлийн ерөнхий индекс нь тухайн үндэстний оршин тогтнох нийгмийн үндэс болдог. Хүний биеийн хөгжил нь нэг талаас удамшлаар нөхцөлдөх ба нөгөө талаас амьдралын хэв маягаас шууд хамааралтай. Асуумж, судалгаанд хамрагдсан хорих ял эдэлж буй иргэдийн 2,929 нь тэдний насыг тодруулсан асуултад:

- 18-23 настай гэж 281;
- 24-27 настай гэж 311;
- 28-31 настай гэж 418;
- 32-35 настай гэж 472;
- 36-39 настай гэж 352;
- 40-43 настай гэж 294;
- 44-47 настай гэж 236;

- 48-51 настай гэж 220;
- 52-55 настай гэж 134;
- 211 нь 56 болон түүнээс дээш настай гэж хариулсан.

Тэдний 2,182 нь шүүхээр оноосон ялын хугацаагаа эдэлж дууссаны дараа гэр бүлийн харилцаанд орох, ажил хөдөлмөр эрхлэх, өөрөөр хэлбэл нийгмийн идэвхтэй иргэн байх боломжит насны буюу залуу, идэр, дунд насны ангилалд хамаарч байна.

Дээр дурдагдсан ажлын өдрүүдэд олон цагаар суулгаж, бясалгах байдлаар хорих ял эдэлж буй иргэдийн хөдөлгөөнийг хорьж байгаа нь, түүнчлэн тэдний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртэх эрх, тэжээллэг хоол хүнсээр хангагдах эрхийг зөрчиж байгаа нь Монгол Улсын иргэний бие бялдрын хөгжлийн индексэд сөргөөр нөлөөлөх, тодруулбал, нийгмийн идэвхтэй бүлэгт хамаарах эдгээр иргэд хөдөлгөөний дутагдалд орох, яс сийрэгжих, улмаар хоол хүнсний хэрэглээ, амьдралын хэв маяг зэрэг хүчин зүйлээр нөхцөлддөг биеийн жин, өндөр, цээжний бүслүүр, мөрний өргөн, өөхөн давхарга, өөхний жин, тэр дундаа биеийн ерөнхий үзүүлэлт, булчингийн байдлын ерөнхий хэмжээг харуулах шилбэний булчингийн радиусын хэмжээ багасах, цаашлаад хүний анатоми бүтэц зүйн хэвийн байдал алдагдах буюу удамших магадлал хамгийн өндөр байдаг халдварт бус өвчлөлтэй болоход нөлөөлж байх магадлалтай.

*Олон улсын хүний эрхийн эрх зүйд сэтгэцийн эрүү шүүлтийн хэлбэрт тооцогддог дараах зөрчлүүд тогтоогдсон.*

*1.Хорих ял эдэлж буй, цагдан хоригдсон хүмүүсийн эрх зүйн байдлыг дордуулна гэж сүрдүүлэх, тухайлбал, “дэглэм дээшлүүлнэ”, “сахилгад хийнэ”, “талон цоолно”, “ажлын заалтаас буулгана”, “магадланд тэнцүүлэхгүй эсвэл оруулахгүй” гэх, гэр бүлийн гишүүдийнх нь эсрэг заналхийлэх, “цөхрөлд оруулах” буюу нэгэнт хоригдсон учир та нарт ямар ч ирээдүй байхгүй, эдлэх эрх байхгүй гэж “Заналхийлэх” үйлдэл.*

Асуумжид хамрагдсан эрх чөлөөгөө хасуулсан 4500 иргэний 45 хувь нь олон улсын хүний эрхийн эрх зүйд “Заналхийлэх” гэж нэршсэн сэтгэцийн хувьд хүчтэй шаналган зовоох шинжтэй эдгээр үйлдэлд өртсөн гэж хариулсан байна.

Эдгээр үйлдэлд өртсөн эрх чөлөөгөө хасуулсан иргэн нь сэтгэл гутралд орох, айдас түгшүүрийн эмгэгтэй болох, сайн сайхан зүйлд тэмүүлэх тэмүүлэлгүй, зорилгогүй, нийгмээс гадуурхагдсан хүн гэх мэдрэмжийг байнга авах, гэр бүлийнхнийхээ төлөө юу ч хийж чадахгүй сул дорой нэгэн гэж өөрийгөө зүхэх, ингэснээр байнгын сэтгэл санааны гүн шаналалд өртөх, цаашлаад нийгэмд гараад бусдад мөн адил шаналал учруулдаг болохыг 2023 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд Дани Улсын Копенхаген хотноо зохион байгуулагдсан “Эрх чөлөөг хязгаарлах үеийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаарх Европын Аюулгүй Байдлын Хамтын Ажиллагааны Байгууллагын бүс нутгийн Үндэсний урьдчилан сэргийлэх механизм болон Иргэний нийгмийн нийгмийн байгууллагуудын бүсийн уулзалт”-аар анхааруулан онцолсон байдаг.

*Хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхах шинжтэй дараах зөрчлүүд тогтоогдсон.*

1.НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын акт зэрэг хүний эрхийн түгээмэл баримт бичиг болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулах Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм, Хоригдолтой харьцах үндсэн зарчим, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс бүх хүнийг хамгаалах тухай тунхаглал, Хоригдсон болон саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон харгис хэрцгийгээр хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахад эрүүлийг хамгаалахын ажилтнуудын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмууд нь:

- Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцах;
- Яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ялгаварлан гадуурхаж болохгүй;
- Хэнийг ч эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж болохгүй гэсэн хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг агуулсан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7.3-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно” гэж иргэн бүрийн нэр төртэй байх, хүнлэг бус, доромжлон харьцах, ялгаварлан гадуурхах аас ангид байх эрхийг баталгаажуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183<sup>97</sup> дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1.6; 2.1.7; 2.1.11; 2.1.12 заалтуудын дагуу алба хаагч нь ялтан, хоригдол, хоригдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлохгүй байх, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, хууль бусаар бие махбодод нь хүч хэрэглэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрд нь халдахгүй байх, сүрдүүлэхгүй байх, бусдын нэр төрийг гутаах зорилгоор худал ташаа цуурхал, мэдээлэл тараахгүй байх ёс зүйн зарчмыг чанд сахин ажиллах үүрэгтэй.

Дагаж мөрдөх хууль эрх зүйн баримт бичиг, чанд сахин биелүүлэх дүрэм журам нь хорих ял эдэлж буй болон хоригдсон иргэдийн хэзээд үл хязгаарлагдах эрхийн хэрэгжилтийг ийнхүү баталгаажуулсан хэдий ч тэдгээрийн хэрэгжилт бодит байдал дээр хангагдахгүй байна.

97 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны А/183 дугаар тушаал

2. Хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй “хэрцгий буюу хүнлэг бус харьцах” үйлдэл хэмээн олон улсын хүний эрхийн эрх зүйд тодорхойлсон гэр бүлийн гишүүдэд нь сэтгэл санааны зовлон шаналал учруулах үйлдэл.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/197<sup>98</sup> дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын 11.14-т “Хоригдлыг хуулийн дагуу түр хугацааны уулзалт хийх үед түр уулзалтын өрөөнд шалтай бэхлэгдсэн гавыг хөлд зүүсний дараа, гарыг урд нь гавлаж, харуул хамгаалалтын ажилтны хяналтад уулзуулна” гэж заасан нь хоригдлын гэр бүлийнхний сэтгэл зүрхийг шаналган зовоосон, хүнлэг бус явдал юм.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газрын урилгаар 2022 оны 10 дугаар сарын 03-14-ний өдрүүдэд хийсэн айлчлалынхаа үеэр 405 дугаар тусгай хаалттай хорих ангид ажиллаж, улмаар 2023 оны 10 дугаар сард Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмждөө “405 дугаар тусгай хаалттай хорих ангийн ганцаарчлан хорих арга хэмжээг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 43 (1) (b) болон 44 дүгээр заалтуудад нийцүүлэх, гар, хөлийн гав, ялангуяа уулзалтын танхимын шаланд бэхлэгдсэн гавыг нэн даруй халах”-ыг тусгасныг энд дахин сануулах нь зүйтэй.

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 106 дахь дүрэмд хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хоригдол болон түүний гэр бүлийн хоорондын харилцааг хоёр талын ашиг сонирхолд нийцүүлэн хадгалах, сайжруулахад онцгой анхаарал хандуулахад чиглэхийг зөвлөсөн ба 5 дугаар дүрэмд зааснаар хорих ангийн дэглэм нь хорих анги дахь болон эрх чөлөөт амьдралын хоорондын ялгааг аль болох багасгахыг эрмэлзэх учиртай. Түүнчлэн, хорих ял эдэлж буй иргэнийг нийгэмшүүлэх нь хорих ангийн нэг чиг үүрэг бөгөөд гэр бүлтэй нь уулзуулах, эргэн нэгтгэх нь нийгэмшүүлэх ажлын чухал хэсэг юм.

Гэвч хорих ангиуд “Хорих ангийн дотоод журам”-ын 16.2-т заасны дагуу түр уулзалтын хэсгийг шилэн хаалтаар тоноглогсон байгаа нь хорих ял эдэлж буй хүн гэр бүлийнхэнтэйгээ харьцах чин сэтгэлийн харьцаанд хязгаарлалт үүсгэж байгаа нь хүнлэг бус үйлдэл болно.

### **Нэг эрхийг нөгөө эрхээр хясан боогдуулах “хүнлэг бус” үйлдэл.**

ШШГЕГ-ын даргын А/165 тоот тушаалаар баталсан “Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын<sup>99</sup> 2.2-т “Хоригдлын тухайн сард хөдөлмөр эрхэлсэн ажлын цаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224.3-т заасан хэмжээнд хүрээгүй бол тухайн сард шагналын хоног олгохгүй” гэсэн заалт нь хорих ял эдэлж буй иргэн эрүүл мэндийн шалтгааны улмаас хэвтэн эмчлүүлэх, урт хугацааны уулзалтад гарах эрхтэй зөрчилдөж байна.

Хуульд заасан нэг сард ажилласан байх 160 цагт 10 хоногийг дүйцүүлэн шагнал болгон олгох нь хорих ялын хугацааг төдий хэрээр багасгаж, хоригдолд урам зориг өгөх арга хэлбэр мөн боловч хоригдлын ажилласан цаг тухайлсан хэмжээнд хүрээгүй тохиолдолд олгогдохгүй гэсэн уг зохицуулалт нь сөрөг үр

98 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаал

99 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/165 тоот тушаал

дагавар үүсгэж, хоригдол өвдсөн ч ажиллах, өвдсөнөө нуухад хүргэж байгаа нь хяналт шинжилгээний хүрээнд илэрсэн. Нөгөө талаас энэхүү заалт нь алба хаагчийн зүгээс хоригдлыг “Заналхийлэх” хэлбэрээр сэтгэцийн эрүү шүүлт тулгах үйлдэл гаргах буюу “Ажлаас буулгана” хэмээн “дарамтлах” нөхцөлийг бүрдүүлж байна.

*4.Ялгаварлан гадуурхах. Хорих ангийн дотоод журмын 18.1-д “Хоригдол албан хаагчтай харьцахдаа түүний албан тушаал, эсвэл цолыг хэлж, өөрийн овог, нэр, шийтгүүлсэн эрүүгийн хуулийн зүйл, хэсгийг танилцуулж, хүсэлт гомдлоо товч тодорхой илэрхийлнэ” гэж заасан нь; хорих өрөөний хаалган талын баруун хананд тухайн өрөөнд байрлаж буй хоригдлуудын мэдээллийг байрлуулахдаа шийтгүүлсэн эрүүгийн хуулийн зүйл, заалтыг бичдэг нь хоригдлууд нэгнээ, албан хаагчид хоригдлыг үйлдсэн хэргээр нь ялгаварлах, доромжлох үндэс болжээ.*

Асуумжид оролцсон хорих ял эдэлж буй 4,500 иргэний 1,978 нь алба хаагчдын зүгээс харин 1205 нь бусад хорих ял эдлэгчдийн зүгээс шийтгэгдсэн эрүүгийн хуулийн зүйл анги, тухайн хорих ангид удаж байгаа үгүй эсэх, үндэс угсаа, гэр бүлийн байдал, эргэлт уулзалт авдаг эсэх, бие эрхтний согог, хөгжлийн бэрхшээл зэрэг байдлаар ялгаварлан гадуурхалтад байнга өртдөг гэж хариулсан нь анхаарал татсан асуудал байв.

Түүнчлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208.3-т “Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.” хэмээн заасан боловч зарим хорих анги дахь хяналт шинжилгээ, ганцаарчилсан ярилцлага, асуумжаар байдал өөр байгааг илтгэж байна.

Тав, арав, хорин жилийн хугацаанд ял эдэлж байгаа хүнийг 18-24 насны залуу, анхны шийтгэлтэй хүнтэй хамт нэг өрөөнд байлгах, хамт ажил хийлгэж байгаа нь хоригдлууд нэгнийгээ хүчирхийлэх, дээрэлхэх, дарамтлах, эрхшээлдээ байлгах зэргээр бие махбодын болон сэтгэл зүйн шаналалд өртөх эрсдэл үүсгэсэн.

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 12 дугаар<sup>100</sup> дүрэмд энэ байдлаас урьдчилан сэргийлж “бие биетэйгээ харилцахад тохиромжтой гэж сайтар сонгосон хоригдлуудыг нэг өрөөнд байрлуулах”; 11 дүгээр дүрмийн (с) хэсэгт “эдийн засгийн болон иргэний гэмт хэрэгтэй хоригдлыг эрүүгийн гэмт хэргийн улмаас хоригдогсдоос тусад нь байрлуулах” талаар тусгасан байдаг.

100 НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм

6.2. ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболорт хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 10 дугаар сарын 18-ны 08/10 дугаар зөвлөмжийн хүрээнд:



Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж бүхий л чиг үүргийн төрийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх суурь зарчмыг хуульчилсан.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д101 зааснаар хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмын хүрээнд, уг хуулийн 7.1 дэх заалтын дагуу хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хэрэгжих ба бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, нэр төрийг нь доромжилж харьцахыг 7.3 болон 251.1.5 дахь заалтуудаар хорих анги, хорих ангийн албан хаагчдад хориглосон.

Түүнчлэн “ШШГБ-ын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1.6; 2.1.7; 2.1.11; 2.1.12 заалтуудын дагуу алба хаагч нь ялтан, хоригдол, хоригдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлохгүй байх, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, хууль бусаар бие махбодод нь хүч хэрэглэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрд нь халдахгүй байх, сүрдүүлэхгүй байх, бусдын нэр төрийг гутаах зорилгоор худал ташаа цуурхал, мэдээлэл тараахгүй байх ёс зүйн зарчмыг чанд сахин ажиллах үүрэгтэй аж.

Гэвч ЭШУС үндэсний ажиллагаа 2022 оны 08 дугаар сараас 2024 оны 12 дугаар сарыг хүртэлх хугацаанд ШШГЕГ-ын харьяа салбар, нэгжүүдэд хийсэн хяналт шинжилгээгээр илэрсэн нөхцөл байдал, явуулсан асуумж судалгаа, танилцсан баримт мэдээлэл, ганцаарчлан хийсэн уулзалтын тэмдэглэл зэрэг эх сурвалжид үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааны алба хаагчдын санаатай болон санамсаргүйгээр үйлдэж буй эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийг тодорхойлоход “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 1.4-т “Алба хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа сахилга, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй” хэмээх заалтаа хорих анги, цагдан хорих байр, төв, тэдгээрийн алба хаагчид зарим талаар үл огоорч, энэ нь хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өдөр тутмын хэвшмэл ажлын арга хэлбэр болон оршин байгаа нь тогтоогдов.

Асуумжид оролцсон хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүсийн 32 хувь нь алба хаагчдын зүгээс бие махбодын, 45 хувь нь сэтгэцийн эрүү шүүлтийн хэв шинжид хамаарах дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, доромжлох зорилгоор бие махбодын болон сэтгэл санааны хүнд өвдөлт, зовлон



зүдүүр учруулах шинжтэй эрхийн зөрчилд өртсөн гэсэн ба дараах илэрцүүд зөвхөн нэгээхэн хэсэг нь юм:

- Жам ёсны бие засах эрхээ эдэлж чадахгүй байсаар шингэн ялгадасдаа түлэгдэж, үүнийгээ удирдах албан тушаалтад хэлснээсээ болж эргээд алба хаагчийн дарамтад орж, амиа хорлохыг завдсан;
- Санамсаргүй булан эргээд гарч ирэхэд өөдөөс нүүр тулж таарсан алба хаагч «Замаа хар п.. минь» гээд хоёр цохисон;
- Б гэдэг ахлагч оройн унтлагын өмнө бясалгалд сууж байхад “унтлаа” гэж намайг дээш нь гаргаж цохисон;
- Би л гэхэд сахилгын хорих байранд ерөнхий жижүүрт боолгож, цахилгаан бороохойдуулж л байлаа;
- А/а Д нэг удаа Г гэх хоригдолд 2 литр ундааг газар дээр нь уулгасан;
- Хөдөлмөр аюулгүй байдлын ажилтан Б камер унтрааж байгаад зодож байсан;
- Энэ ангид улаан шугам үйлчилж, бөгсөө сайрттал сууж байна. Бүх хоригдлын цагаан мах эргэсэн, эдгэх ямар ч боломжгүйгээр байнга суулгадаг;
- Дэглэм дээшлүүлнэ, гянданд хийнэ гэж олон албан хаагч заналхийлж, сүрдүүлдэг
- Та нарт ямар ч эрх байхгүй гэж дарамталдаг;
- Биднийг нийгэмшүүлэх хүмүүс атал дандаа харааж, зодож, сахилгад хийж, дэглэм дээшлүүлнэ гэж айлгадаг. Ийм зүйлүүдээс болж амиа хорлох бодол ихэнх хүнд төрдөг, байнгын айдас, түгшүүртэй байдаг болсон;
- Ажлын заалтаас буулгана гэж алба хаагчдын ихэнх нь дарамталдаг;
- Алба хаагчид хоригдлуудын голд яс хаях маягаар дарамтад оруулдаг;
- FM радионы сүлжээгээ тааруулахгүй тавьж, байнга шуугиантай юм сонсгодог;

Харин 23 хувь нь хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хэрцгий, хүнлэг бус харьцаа, хүнийг доромжлох, гутаах зорилготой болон ялгаварлан гадуурхах шинжтэй үйлдэл, харьцаанд өртдөг гээд дараах байдлаар асуумж, ярилцлагад хариулсан байна:

- Харуулууд дандаа хараалын үг хэрэглэдэг;
- Нохой, гахайтай харьцаж байгаа мэт харьцдаг;
- Хорих ангийн дэд дарга М намайг 200 хоригдлын өмнө өвдөг сөхрүүлсэн;
- Олон хоригдлын дунд нэр төрд халддаг ба өдөөн хатгалт хийдэг;
- Бага зэргийн зөрчил дээр нээлттэй зооны голд суулгадаг;
- С гэдэг ээлжийн дарга хөл муутайгаар гадуурхаж, “янжигар” гэж дууддаг;

- Хөгжлийн бэрхшээлээр минь далимдуулж “дүк” гэж дууддаг;
- Өдөөн хатгаж, уур хүргэдэг;
- Алба хаагч нар ялгаварлаж харьцдаг. Хүйсийн болон бэлгийн цөөнх гээд алагчилж, дорд үгээр харьцдаг;
- Алба хаагч Х нь миний талаар бусдад худал мэдээлэл тараасны улмаас хүмүүс намайг ялгаварлан гадуурхдаг болсон;
- Алба хаагчдын зан харилцаа маш муу, хоригдол бид нарт шаардлага тавихдаа хэтэрхий их хараалын үг хэрэглэдэг;
- Гэм буруу тогтоогдоогүй байхад зүйл ангиар ялгаварлан гадуурхдаг;

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд хорих анги, хорих ангийн алба хаагч хоригдол, цагдан хоригдсон хүмүүстэй харьцах зарчмуудыг тодорхойлохдоо:

- Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцана;
- Үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, шашны, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гэр бүлийн гарал, нийгмийн гарлаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй;
- Хүн амын аливаа бүлэгт хамаардаг хоригдлуудын шашны итгэл үнэмшил, зан суртахууны төлөвшилтийг хүндэтгэх хэрэгтэй;
- Хорих ангийн ажилтнууд хоригдлуудад эергээр нөлөөлж, тэдэнд үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэлийг хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэдэг байх ёстой;
- Хорих ангийн алба хаагчид зөвхөн өөрийгөө хамгаалах, эсхүл оргох оролдлого хийх, хууль тогтоомжид үндэслэсэн тушаалыг идэвхтэй болон идэвхгүй хэлбэрээр эсэргүүцэхээс бусад тохиолдолд хоригдлуудтай харьцахдаа хүч хэрэглэхийг хориглоно. Хүч хэрэглэж буй алба хаагчид зөвхөн зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэх бөгөөд болсон явдлын талаар хорих ангийн даргад даруй мэдэгдэх ёстой;
- Ял шийтгүүлээгүй хоригдогсдыг гэм буруугүйд тооцож, ийм байдлаар харьцах ёстой гэж заасан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ШШГЕГ-ын болон салбар, нэгжүүдийн дарга, удирдлагад хүргүүлсэн зөвлөмж бүрд сахилга, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх алба хаагчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хангаж ажиллахад сургалт, арга хэмжээ явуулах талаар дурдсаар ирсэн боловч салбар, нэгжүүдэд хийсэн хяналт шинжилгээ тутмаар энэ байдал хэвээр оршсоор буй нь тогтоогдож байна.

Энэ нь ШШГ байгууллагын удирдлага, алба хаагчид Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-ын холбогдох гэрээ конвенцоор олгогдсон хүний хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг үл хүндэтгэж, үл хангаж, цаашилбал, Монгол Улсын хүний эрхийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна.

Шинжлэх ухаанд “Ёс зүй” гэдэг ойлголтыг хүмүүс хоорондын харилцаа, түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй, нийгэм, бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буй байдал гэж тодорхойлсон бөгөөд харилцаа нь хүмүүсийг хооронд нь холбох, хүнийг төлөвшүүлэх, бие хүнийг хүнийх нь хувьд оршин буйг батлан нотлох гол зангилаа гэжээ.

Өөрөөр хэлбэл, ШШГ байгууллагын алба хаагч нь нийгэм болон бусдын өмнө хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эрх чөлөөгөө хасуулсан хүнтэй болон бусад этгээдтэй харьцахдаа зөв, бурууг үйлдсэн, үйлдэж байгаа эсэхээ ухамсарлаж буй байдал нь танай байгууллагын ёс зүйн хэм хэмжээний үзүүлэлтийг илэрхийлэх учиртай.

Алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүсийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн эсрэг үйлдэл гаргасаар байгаа нь ШШГЕГ-ын салбар, нэгжийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа сургалт оновчтой бус, хэлбэр төдий байх магадлалыг илтгэж байгаагаас гадна “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн ялангуяа 2.1.6; 2.1.7; 2.1.11; 2.1.12 заалтууд ёсчлон мөрдөгддөггүй, сахилга, ёс зүйн зөрчлийг шалгах ажиллагаа дүрэмд заасны дагуу гүйцэд хэрэгждэггүй байж болзошгүйг харуулж байна.

ШШГЕГ-ын хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг чиг үүрэг нь хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэхэд чиглэгдэх ба энэ чиг үүргийн хэрэгжилтийн тухайд НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 4-ийн (1)-д “Хүний эрх чөлөөг хассан хорих ял, түүнтэй адилтгах арга хэмжээний зорилго нь юун түрүүнд нийгмийг гэмт хэргээс хамгаалах, дахин гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэгддэг. Үүний тулд хоригдлыг хорих ял эдлэх хугацаанд нь суллагдсаныхаа дараа нийгэмд эргэн нэгдэж, хууль тогтоомжийг даган мөрдөж, бие даан амьдрахад нь чиглүүлсэн тохиолдолд л эдгээр зорилгод хүрч чадна.” гэж дурдсан.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны нийгэмшүүлэх чиг үүргийн үр нөлөө, чанартай шууд холбогдохоос гадна, нөгөө талаас хорих ангийн алба хаагч бүрийн сахилга, ёс зүйн хэм хэмжээгээ хэрхэн баримтлан тэдгээр хорих ял эдэлж байгаа хүмүүстэй харьцаж буй байдлаас ихээхэн хамаарч байгааг энд дурдах нь зүйтэй.

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 77-д “Хорих ангийн ажилтнууд хоригдлуудад эергээр нөлөөлж, тэдэнд үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэлийг хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэдэг байх ёстой” гэсэн заалтыг дахин онцолъё.

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ёс зүйтэй байх, ёс зүйн шаардлагыг дагаж мөрдөх явдлыг Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/183 дугаар тушаалын<sup>102</sup> хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-д заасан боловч хэрэгжилтийн бодит байдал хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрөх цаг нэгэнт болсон гэж үзэж байна.*

102 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/183 дугаар тушаал

6.3. ШШГЕГ-ын 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирт хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 20-ны 08/14 дүгээр зөвлөмжийн хүрээнд:

1.Хорих ангийн сахилгын байрны коридорын хэсэг, соёлын танхимын тайзны ар, халуун ус,угаалгын хэсэг, спорт заал дахь өрөө, уурын зуух гэсэн байршлууд нь дуу-дүрсний бичлэгийн хяналтгүй байгаа нь орчны ажиглалт хийх хүрээнд тогтоогдсон.



ЭШУС үндэсний ажиллагаа нь тус ангид 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, 08/03 тоот зөвлөмжийг 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа С.Батсайханд хүргүүлсэн.<sup>103</sup> Уг зөвлөмжид “Хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих хэсгийн хяналтын камергүй хэсгийг дуу-дүрсний бичлэгийн хяналтын камертай болгох” гэсэн заалт багтсан. Зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний биелэлт болгон ирүүлсэн 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамираас ирүүлсэн албан хариунд<sup>104</sup> “Зөвлөмжийн хугацаанд хорих байрны ариун цэврийн 3 өрөөнд 3 ширхэг камер шинээр суурилуулсан” гэсэн байх боловч ийнхүү 2024 онд хийсэн хяналт шинжилгээгээр дуу-дүрсний бичлэгийн камерын хяналтгүй байршлууд дахин тогтоогдсон нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж бүрэн биеллээгүйг харууллаа.

2.НУБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13 болон бусад олон улсын, үндэсний хууль, эрх зүйн баримт бичгүүдээр хэн боловч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх баталгаагаар хангагдсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид иргэний энэхүү баталгааг хангах үүргийг Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1.6, 2.1.7 2.1.11 дэх заалтуудаар хүлээсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 243 дугаар зүйлийн 243.3 дахь заалтад дурдсаны дагуу хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг дуу-дүрсний бичлэгээр хянах нь хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилготой. Түүнчлэн хоригдлын эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн үйлдлийг илрүүлэх арга хэрэгсэл юм.

3.НУБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүдтэй хамтран явуулсан хяналт шинжилгээний дүгнэх уулзалтын үеэр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны

<sup>103</sup> ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 08/03 тоот зөвлөмж

<sup>104</sup> ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/411 дугаар албан бичиг

дагуу хорих ангийн дуу-дүрсний бичлэгийн хяналтгүй байршлуудыг хяналтын камертай болгох тухай тавьсан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх ёстой үүргээ хэрэгжүүлсэн эсэх нь 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар эргэн танилцуулагдаагүй байна.

4.Хорих ял эдэлж буй иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад хуульд заасан хугацаанд шилжүүлж, шийдвэрлэдэггүй явдал тус ангид оршоор байгаа нь хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон. Тухайлбал, "Төрийн байгууллага, албан тушаалтны талаар гаргасан Таны гомдлыг холбогдох байгууллагад хорих ангиас шуурхай шилжүүлдэг үү?" гэсэн асуумжид 245 хариулт ирснээс 82 нь тэдний гаргасан гомдлыг шуурхай шилжүүлдэггүй гэж хариулсан. Тэдгээр хариултаас онцлоход "Хүүхдээ өөрийн нэрээр овоглох тухай өргөдөл бичиж, нийгмийн ажилтанд өгсөн боловч 14 хонож байхад хүлээж авах ёстой байгууллагад очоогүй байна", "Ангиас өргөдөл, гомдол явдаг болоосой. Ар гэр рүүгээ 7 хоногт нэг удаа захидал харилцаа явуулах ёстой атлаа нийгмийн ажилтны зүгээс сард нэг л удаа явуулна гэсэн хариулт өгдөг" гэж тэмдэглэн үлдээжээ.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний дүгнэх уулзалтын үеэр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зүгээс ангийн удирдлагад хандаж хорих ял эдэлж буй хүмүүсээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүрд холбогдох этгээдэд шилжүүлж, шийдвэрлэдэг байх тухай аман хэлбэрээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хяналт шинжилгээнээс хойш хагас жилийн хугацаа өнгөрсөн боловч эргэн танилцуулагдаагүй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/1837 тоот албан бичгийг ангийн дарга Танаа хүргүүлж, тус хорих ангид ял эдэлж буй иргэдийн зүгээс ангийн удирдлага, алба хаагч, төрийн бусад байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн бүртгэл, шийдвэрлэлт, бусад холбогдох мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар гаргуулан авсан.

Ангийн дарга, хурандаа Б.Тамир "таны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/1082 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 2020-2024 онд хоригдлоос гаргасан өргөдөл, гомдлын дэлгэрэнгүй судалгаатай танилцахад нийт 2074 хүсэлт хоригдлын зүгээс ирснээс 1731 хүсэлтийг шийдвэрлэж, 343 хүсэлтийг өөрийн хүсэлтээр болон ангийн арга зүйн хуралдаанаар хэлэлцэн, буцаасан болон хойшлуулсан" гэжээ.

Судалгаанд хоригдлын зүгээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг тухай бүрээр ангилаагүй, түүнчлэн хорих ангид ял эдэлж буй иргэдийн зүгээс ангийн удирдлага, алба хаагч, төрийн бусад байгууллага, албан тушаалтад хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн бүртгэл хөтлөлтийн баримтжуулалтыг хавсаргаагүй, үүний учир нэгж өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хуульд заасан хугацаанд шилжүүлж, шийдвэрлэж буй эсэхтэй танилцах боломжгүй байна.

Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрхийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх заалтад баталгаажуулсан ба хоригдлын гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 237 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэхээр хуульчилжээ. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах

наад захын жишиг дүрмийн 57 дугаар дүрмийн 1 дэх хэсэгт “хоригдлын зүгээс уламжилсан өргөдөл, гомдол бүрийг шуурхай шийдвэрлэж, цаг алдалгүй хариу өгөх”-ийг, 2 дахь хэсэгт “хоригдол өргөдөл, гомдол гаргасны төлөө айлган сүрдүүлэлт болон бусад сөрөг үр дагаварт өртөх ёсгүй”-г тусгасан.

5.Хяналт шинжилгээний хүрээнд авсан асуумжид 280 хоригдол оролцоноос 152 нь “хөдөлмөр эрхэлдэг” гэж хариулсан. Харин сургалт, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагддаггүй хоригдлууд “бөгсөө сайртгал өдөржин суудаг”, “Өдөр болгон 8 цагаас хойш 17 цаг хүртэл сандал дээр суугаад, нуруу бөөр өвддөг болсон. Цагаан мах гардаг болж, бид эрүүл мэндээрээ хохирч байна, “Энэ бол эрүү шүүлт, залхаан цээрлүүлэлтийн нэг хэлбэр мөнөөсөө мөн” хэмээн хариулсан.

Энэ нь хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирын 2023 оны 01/411 тоот албан хариунд “...өдрийн цагаар 04 цаг 40 минутын хугацаанд хоригдол өрөөндөө байршиж болохоор зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна” хэмээн тайлагнасан байгаа нь бодит бус байх магадлалыг харуулж байна.

Биеийн тогтсон нэг байрлалд удаан хугацааны турш албадан байлгах, суулгах нь олон улсын хүний эрхийн эрх зүйд “албадлагын байрлал”, “стрессийн байрлал” гэх нэршилтэй эрүү шүүлт тулгах үйлдлийн нэг хэлбэр бөгөөд хатуу гадаргуу дээр хөдөлгөөнгүй удаан сууснаас шулуун гэдэсний хананд байнга даралт ирж, улмаар судаснууд өргөсөн үрэвсэж, шулуун гэдэсний амсраар түрэн гарч ирэх эмгэг буюу шулуун гэдэсний эдийн үрэвслийн архаг өвчлөлтэй болж байгааг цохон тэмдэглэх нь зүй.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”-ын 13 дахь хэсэг, Хорих ангид мөрдөх цагийн хуваарьт үйл ажиллагаа хэмээх зохицуулалтын 13.6-д “Хорих өрөөний хаалгыг цоожтой байлгах ба амрах үед хоригдлыг хорих өрөөнд нэвтрүүлнэ” гэсэн заалтыг дагаж мөрдөх нь тухайн байршилд ял эдэлж буй нийт хоригдлыг хамруулах хангалттай, олон нэр төрөл бүхий сургалт, нийгэмшүүлэх ажил, соён гэгээрүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдол бүрд хүрэлцэх ажлын байраар хангаагүй нөхцөлд сургалт, нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлтэд хамрагдаагүй хоригдлыг хорих өрөөний гадна удаан хугацаагаар сандал дээр суулгах, үүнийг хорих ангийн хуваарьт үйл ажиллагаа болгон мөрдүүлэх шалтгаан болж, улмаар хоригдлын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байна.

6.ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/03 тоот зөвлөмжийн “Хоригдогчдыг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар сургалт, бусад арга хэмжээг зохион байгуулах”, “Алба хаагчдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, энэхүү гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг тогтмолжуулах” гэсэн заалт оновчтой хэрэгжээгүй нөхцөл байдал тогтоогдсон.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн тус хорих ангийн даргын 2023 оны 01/411 тоот албан хариунд “хоригдлыг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад чиглэсэн, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар сургалтыг алба хаагчдад явуулж, нийт хоригдлуудын хорих ял эдлүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг сонсож, тэдэнд гэмт хэрэг, зөрчлөөс ангид байх чиглэлээр яриа таниулга хийсэн” хэмээн тайлагнасан байгаа



боловч хорих ял эдэлж буй иргэдийн хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдахгүй байсаар байна.

*Алба хаагчдын зүгээс хоригдлуудад хэрхэн ханддаг байдлыг тодорхойлох асуултад 257 хоригдол оролцсоноос 107 нь алба хаагчдын зүгээс зүй бус харьцаанд өртдөг гэж хариулсан ба “Зүйл ангиар ялгаварладаг”, “Алба хаагчид хоригдол бидэнд шаардлага тавихдаа хэтэрхий их хараалын үг хэрэглэдэг”, “Төлөөлөгчид “п...а”, “гөлөг”, “алны мах” гэх мэтээр байнга доромжилдог”, “Төлөөлөгчид юм л бол “гяндан явуулна”, “магадланд оруулахгүй”, “ажил хийлгэхгүй” гэж дарамталдаг”, “Ажил олгох үедээ маш их ялгаварлаж байна. Дарга, удирдлагад таалагдсан нь, бас мөнгөтэй нь биш, юм сурч мэдье, засарья гэж жинхэнэ хүсэж байгаа хүмүүс нь ажил хийдэг баймаар байна” хэмээн хариулсан.*

7. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хорих ангийн 14 алба хаагч асуумжид оролцсоноос 12 нь “Баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлж буй хүнтэй хэрхэн харьцах, ярилцах талаар сургалтад хамрагддаг” гэж хариулсан боловч хоригдлуудын дээрх тэмдэглэл ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/03 тоот зөвлөмжийн биелэлт оновчтой хангагдаагүй байх үндэслэлийг харуулж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 70 дахь хуралдаанаар баталсан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд хорих анги, хорих ангийн алба хаагч хоригдол, цагдан хоригдсон хүмүүстэй харьцах зарчмуудыг тодорхойлохдоо “Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцана”; “Үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, шашны, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гэр бүлийн гарал, нийгмийн гарлаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй”; “Хүн амын аливаа бүлэгт хамаардаг хоригдлуудын шашны итгэл үнэмшил, зан суртахууны төлөвшилтийг хүндэтгэх хэрэгтэй”; “Хорих ангийн ажилтнууд хоригдлуудад эергээр нөлөөлж, тэдэнд үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэлийг хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэдэг байх ёстой” гэж заасан.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1.6, 2.1.7 2.1.11 дэх заалтуудад дагуу дагуу алба хаагч нь ялтан, хоригдол, хоригдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлохгүй байх, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, хууль бусаар бие махбодод нь хүч хэрэглэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрд нь халдахгүй байх, сүрдүүлэхгүй байх ёс зүйн зарчмыг чанд сахин ажиллах үүрэгтэй.

8. Олон жилийн хугацаанд ял эдэлж байгаа хүнийг нас залуу, анхны шийтгэлтэй хүнтэй хамт нэг ерөөнд байлгаж байгаа явдал нь хоригдлууд нэгэндээ хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байна.

*Энэ тухай асуумжид оролцсон хоригдлуудын тэмдэглэлд дурдсан бөгөөд тухайлбал “Олон жилийн ялтай хоригдлуудыг залуу хүмүүстэй нэг ерөөнд байлгадаг. Олон жилийн ялтай хоригдлууд нь тэднийгээ зодож, дарамталж, хувийн цэвэрлэгч, үйлчлэгч нь юм шиг бүх юмаа хийлгэдэг, сэтгэл зүйн байдлыг нь маш хэцүү байдалд оруулдаг”, “Хоригдлыг ерөөнд хуваарилахдаа боловсрол болон хэдэн удаагийн ял шийтгэлтэй эсэхийг нь харгалзан үзэж ерөөнд хуваарилах хэрэгтэй. Хорихын дотоод журамд ингэж тусгасан байдаг ч дагаж мөрддөггүй. Энэ бол маш чухал” гэж бичжээ.*

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 12 дугаар дүрэмд хоригдлууд нэгэндээ хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхахаас урьдчилан

сэргийлж “бие биетэйгээ харилцахад тохиромжтой гэж сайтар сонгосон хоригдлуудыг нэг өрөөнд байрлуулах” тухай заасан. Түүнчлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.” хэмээн хуульчилсан.

9.Хорих ангийн алба хаагчдын ялгамжтай харьцаа нь хоригдлууд нэгэндээ хүнлэг бус харьцахад нөлөөлж байгаа нь асуумжид оролцогсдын хариултаас тогтоогдлоо. Нийт 245 хорих ял эдэлж буй хүн асуултад хариулснаас 89 нь хамт хоригдож байгаа хүмүүс зүй бус харьцдаг гээд “Хэргийн байдал, биеийн үзэмжээр намайг ялгаварлан гадуурхдаг. Алба хаагчдад хэлсэн ч туслалцаа үзүүлдэггүй”, “Алба хаагчид хуучин хоригдлуудаа өмөөрдөг болохоор шинэ ирсэн хоригдлуудыг хуучуул нь янз бүрээр хэлдэг”, “Шинээр ирсэн хоригдлуудаас хувцас, эргэлт тойролтыг нь байнга дээрэлхэж авдаг, эрхшээлдээ оруулдаг. Алба хаагчид нь хуучин хоригдлууддаа юм хэлж чаддаггүй” гэж бичжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 тоот тушаалын хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 1.3-т “Алба хаагч нь шуурхай, чирэгдэлгүй байж, хуулиа дээдлэн, шударга ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөө, үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэн, үйлчилгээний таатай орчныг бүрдүүлж, алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин биелүүлж, ажил хэрэгч, соёлч боловсон харьцааг чухалчлан, байгууллагын болон төрийн албаны нэр хүндийг өргөж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажиллахыг эрхэмлэнэ” хэмээн заасан.

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 1-д хоригдлуудыг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцаж шийтгэж болохгүй бөгөөд хоригдлыг ямар ч үед ийм зөрчилд өртөхөөс хамгаалах ёстойг, уг дүрмийн 76-д алба хаагчид хоригдлуудыг хооронд нь эвлэрүүлэн зуучлах, харилцан ойлголцолд хүргэх зэрэг урьдчилан сэргийлэх, саармагжуулах арга зүйг эзэмших сургалтад хамрагддаг байхыг тусгасан.

10.ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 08/03 тоот, нийт 14 заалт бүхий зөвлөмжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа С.Батсайханд хүргүүлсэн.

Тус хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирын 2023 оны 06 дугаар сарын 19-ний 01/411 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний тайланг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний өдрийн А/03 тоот<sup>105</sup> тушаалаар баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд “Хорих ангийн харуул хамгаалалт, жижүүрийн ээлжийн үүргийн хуваарийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэх өөрчлөх зохион байгуулалтын арга хэмжээ авах, түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуульд заасан хугацаанаас илүү цагаар ажиллуулсан тохиолдолд олговрыг олгох” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт дурдагдаагүй буюу

105 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаал

0 хувьтай, “Алба хаагчдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, энэхүү гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг тогтмолжуулах” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай үнэлэгдэж, тус хорих ангийн удирдлагад хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж нийт 90 хувийн биелэлттэй тооцогдсон байна.

Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланд үндэслэн дүгнэхэд ийнхүү хэрэгжилтийн байдал 90 хувьтай тогтоогдсон хэдий ч, тухайн хяналт шинжилгээгээр тогтоогдсон зөрчлүүд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны төлөөлөгч гишүүд болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах нэгжийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хяналт шинжилгээгээр дахин тогтоогдсон.

6.4.ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаярт хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 12 дугаар сарын 27-ны 08/15 дугаар зөвлөмжийн хүрээнд:

1.Хорих ангийн оёдлын үйлдвэр болон мужаан цехийн барилгын гаднах 10 орчим м2талбай, хоригдлуудын амьдралын бүс болон оёдлын цехийн дунд байрлах байгууламж дахь гадуур ажлын заалттай хоригдлуудын хувцас солих өрөө нь дуу-дүрсний бичлэгийн хяналтгүй байгааг орчны ажиглалтын хүрээнд тогтоогдсон.



2.ЭШУС үндэсний ажиллагаанаас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тус хорих ангид урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, ангийн материаллаг нөхцөл, дүрэм журам, бодлого, байгууллагын соёл, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн нөхцөл байдал зэрэгт тулгуурлан хорих ял эдэлж буй иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдэл гарахаас сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг засаж сайжруулахаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг мөн оны 07

дугаар сарын 03-ны өдрийн 08/08 тоот албан бичгээр 437 дугаар нээлттэй хорих ангийн дарга Р.Ууганбаярт хүргүүлсэн.

Уг зөвлөмжид “Хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих хэсгийн хяналтын камергүй хэсгийг дуу-дүрсний бичлэгийн хяналтын камертай болгож”-ыг тусгасан ба хорих ангийн даргын мөн оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 01/1291 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн зөвлөмжийн хариунд “Хорих ангийн дотор хоригдол зорчих хэсгийн хяналтын телекамергүй хорих ангийн үүдний хэсэг, халуун усны хэсэг, сахилгын өрөөнүүдийн үүдний хэсэгт шаардлагатай дуу дүрсний бичлэгийн хяналтын телекамер шийдвэрлүүлэхээр ШШГЕГ-ын газрын Холбоо мэдээлэл, технологийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн” гэжээ.

Гэвч ЭШУС үндэсний ажиллагааны хяналт шинжилгээний ажлын хэсэг тус ангид 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр ажиллахад дуу-дүрсний бичлэгийн хяналтгүй хоригдол зорчих хэсгүүд дахин тогтоогдсон нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/08 тоот Зөвлөмжийн тухайлсан заалт бүрэн биелээгүйг харууллаа.

*3. Хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хүнлэг бус харьцаа; хүнийг ялгаварлан гадуурхах шинжтэй үйлдэл, харьцаанд өртдөг эсэхийг тодруулсан асуулгад 173 хоригдол оролцсоноос 43 хувь буюу 75 нь "ийм харьцаанд өртдөг" гэж хариулсан.*

ЭШУС үндэсний ажиллагаа нь тус ангид 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, мөн оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 08/08 тоот зөвлөмжийг 437 дугаар нээлттэй хорих ангийн даргад хүргүүлсэн. Зөвлөмжийн 4 дүгээр хэсэгт "Хорих ангид алба хаагч зүй бусаар харьцаж байсан уу?" гэх асуултад хоригдлууд хэрхэн хариулсан байдлыг дурдсан бөгөөд асуумжид оролцсон 118 хоригдлын 39 буюу 33,1 хувь нь "Алба хаагчдын зүгээс зүй бус харьцаанд өртдөг" гэж хариулсан болох, түүнчлэн ахлах төлөөлөгч, хошууч А.Э, ээлжийн дарга, хошууч С.Б, ахлах ахлагч Б.Л нарт холбогдох зүй бус харьцсан тухай илэрц багтсан.

Зөвлөмжийн биелэлт болгон ирүүлсэн ангийн дарга Р.Ууганбаярын 2023 оны 01/1291 тоот хариунд эдгээр алба хаагчдад "албаны шалгалт явуулахад зөвлөмжид дурдагдсан асуудлууд тогтоогдоогүй бөгөөд дээрх алба хаагчид хууль ёсны шаардлага тавьж ажилладаг" гэсэн байна. Гэвч тус ангид 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хяналт шинжилгээ хийхэд өмнөх онд тогтоогдож, улмаар засаж, сайжруулахаар ангийн даргад хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/08 зөвлөмжид зүй бус харьцсан гэх асуудалд нэр нь дурдагдаж байсан алба хаагчдад хамаарах гомдол, мэдээлэл дахин тогтоогдсон.

4. Гэвч тус ангид 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхэд өмнөх онд тогтоогдож, улмаар засаж, сайжруулахаар ангийн дарга танаа хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 08/08 зөвлөмжид зүй бус харьцсан гэх асуудалд нэр нь дурдагдаж байсан алба хаагчдад хамаарах гомдол, мэдээлэл дахин тогтоогдсон.

Тухайлбал: "Ахлах төлөөлөгч хошууч А.Э, ахлах ахлагч Б, ахлагч Э, ахлах Б нар ёс бус үг, үйлдэл маш их гаргаж байна", "Хөдөлмөр аюулгүй байдлын алба хаагч Б нь 2024 оны 07 дугаар сарын 10-ны орой 20:10 цагт намайг цохиж, зодсон", "Хөдөлмөр аюулгүй байдлын алба хаагч Б камер унтрааж байгаад зодож байсан", "а/а Л хоригдлуудыг ялгаж харьцдаг ба өөрийн сайн гэсэн хоригдлуудтайгаа нийлж, дургүй хоригдлоо дарамталж, эсвэл хоригдлыг хоригдлоор нь дарамтлуулдаг. Энэ архагшсан хүнд арга хэмжээ авмаар байна", "Нийгмийн ажилтан А.А надад туслалцаа үзүүлэхгүй хөөдөг. Юм асуухад хариу өгдөггүй", "Төлөөлөгч Г хулгайч, ялтнаар дуудаж, дунд хуруу гаргасан", "Алба хаагчид хууль ёсны шаардлага тавихдаа байнга хараалын үг урсгадаг", "Алба хаагч нар харилцааны асуудалтай. П.....а, наахуугаар дуудаж, цохиж зоддог. Бид юм хэлж ярих ямар ч эрхгүй, маш их дарамтад байдаг" хэмээн бичжээ.

Нэр дурдагдсан алба хаагчдад явуулсан албан шалгалтын дүгнэлтийг 437 дугаар нээлттэй хорих ангийн даргын 2023 оны 01/1291 дугаар албан бичигт хавсаргаагүй байх тул Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3-т заасан бүрэн эрхийн дагуу нөхөн гаргуулж авсан.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг хүний эрхийн түгээмэл баримт бичиг болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулах Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм, Хоригдолтой харьцах үндсэн зарчим, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс бүх хүнийг хамгаалах тухай тунхаглал, Хоригдсон болон саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон харгис хэрцгийгээр хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахад эрүүлийг хамгаалахын ажилтнуудын гүйцэтгэх үүргийн ёс зүйн зарчмууд нь:

- Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцах;
- Хэнийг ч эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхгүй байх;
- Хорих ангийн алба хаагчид зөвхөн өөрийгөө хамгаалах, эсхүл оргох оролдлого хийх, хууль тогтоомжид үндэслэсэн тушаалыг идэвхтэй болон идэвхгүй хэлбэрээр эсэргүүцэхээс бусад тохиолдолд хоригдлуудтай харьцахдаа хүч хэрэглэхийг хориглоно. Хүч хэрэглэж буй алба хаагчид зөвхөн зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэх бөгөөд болсон явдлын талаар хорих ангийн даргад даруй мэдэгдэх;
- Хоригдлуудад эергээр нөлөөлж, тэдэнд үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэлийг хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэх гэсэн хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг агуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т "...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй" гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7.3-т "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлохыг хориглоно" гэж иргэн бүрийн нэр төртэй байх, хүнлэг бус, доромжлон харьцах, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийг баталгаажуулсан.

Өөрөөр хэлбэл, хорих ангийн алба хаагч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих ял эдлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хоригдлуудын заяамал нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцаж, тэдний зан суртахууны төлөвшлийн онцлогийг анхаарч, эергээр нөлөөлж, хүндэтгэлийг хүлээхүйцээр биеэ авч явахыг Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд заасан.

Иймд ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаяр та Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын

2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/96 дугаар тушаалтын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.3-т заасан “Салбар нэгжийн дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, өөрийн байгууллагын хөдөлмөрийн харилцаатай холбогдсон үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж...” ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.

5.“Шаардлагатай үед танд хэрэгцээт эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслээр үйлчилдэг үү?” гэсэн асуултад өгсөн 179 хариултын 91 буюу 55,4 хувь нь шаардлагатай үедээ хэрэгцээт эм бэлдмэлээр хангагддаггүй гэж, “Хорих ангийн эмч, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байна уу?” гэсэн асуултад 148 хоригдол хариулснаас 44 нь “сэтгэл ханамжтай” гэж, 45 нь “хангалуун бус” гэж, харин 59 нь эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны талаар дараах байдлаар бичжээ.

Тухайлбал: “Сувилагч нар харилцаа муутай. Ямар амралтын газар юм уу гэж загнадаг”, “Улсын төсөв хүрэлцдэггүй гэдэг шалтгаанаар ангид эм, тарианы олдоц маш муу. Энэ байдлаас болж өвчнөө хүндрүүлж байна”, “Бие өвдөөд үзүүлэхэд ажлын заалтаас буулгадаг. Тийм болохоор өвдөх эрх байдаггүй”, “Толгой тархи, нуруу бөөр өвдөөд эмчид үзүүлэе гээд ороход та нар цэцэрлэгт ирсэн юм уу, эм байхгүй, ар гэр лүүгээ захь гэж хөөдөг”, “Эмч сувилагчдын харилцаа маш доголдолтой”, “Байн байн өвчин хэллээ гэж загнадаг”, “Толгой өвдлөө гээд үзүүлэхэд урдаас загнаж, шууд ажлаасаа буу гэдэг”, “Загнуулж байж ганц нэг эм авдаг болохоор өвдсөнөө хэлдэггүй, гүрийгээд, өвчнөө давж байна”, “Энэ цэцэрлэг биш гэж загнаж байж өвчин намдаах эм л өгдөг”.

*Тус ангид хорих ял эдэлж буй иргэдийн эрүүл байх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн зөрчил эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төсвийн хангалтгүй байдлаас гадна эмч, сувилагчдын мэргэжлийн ур чадвар, албан үүргээ гүйцэтгэх үеийн ёс зүй, зүй бус харилцаа, хандлагаас ихээхэн хамаарч байна.*

Эрүүл байх эрх нь Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон үндэсний бусад хууль, олон улсын гэрээ, конвенцуудаар баталгаажсан хүн бүрийн туйлын, зайлшгүй болоод тэгш эдлэх эрх юм.

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 24-т хоригдлуудад эрх зүйн байдлынх нь үндэслэлээр ялгаварлан гадуурхагдахгүйгээр энгийн иргэдэд үзүүлдэг эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх тухай заасан. Түүнчлэн, 27 дугаар дүрэмд хорих анги нь яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, үүний тулд өвчтөнийг зохих ёсоор сувилах, эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмийн хангамжтай байхыг, мөн нарийн мэргэжлийн эмчилгээ шаардлагатай хорих ял эдэлж буй хүнийг төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, эсвэл иргэдэд үйлчилдэг ердийн эмнэлэгт шилжүүлэхийг тусгасан. 30 дугаар дүрмийн (а) хэсэгт “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, эмчилгээнд шаардлагатай бүх арга хэмжээ авах”-ыг заасан.

6.Асуумжид дурдагдаагүй асуулт, хэлэхийг хүссэн санал, хүсэлт байгаа эсэхийг асуусан хэсэгт 81 хариулт өгснөөс олонтоо дурдагдсан агуулгыг дор жагсаав:

- Ном, сонины хүрэлцээ муу. Номын сантай болмоор байна;



- Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломж маш тааруу. Ном, сонин үзэх, захиалах боломжоор хангагдмаар байна;
- Хууль эрх зүйн талаар мэдээ, мэдээлэл авмаар байна;
- Сургалт муу;
- Урлаг, спортын арга хэмжээ явагддаггүй. Хоригдол бидний сэтгэл зүйд чиглэсэн ямар ч үйл ажиллагаа байдаггүй. Өөрт болон бусдад хэрэгцээтэй санал, хүсэлтийг хүлээн авдаггүй;
- Залуучуудын авьяас, хүсэл сонирхолд чиглэсэн ажил явагддаггүй;
- Сэтгэл зүйн болон өөрт холбогдох асуудалд туслалцаа авахад хүндрэлтэй байна;
- Хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх боломж огт байхгүй;
- Спорт талбай ашиглагдахгүй байна;
- Ангийн даргад хүсэлт тавихад доод албан тушаалтан нь хүсэлтийг дамжуулж өгдөггүй;
- Хорих ангийн дарга манай ангид томилогдож ирснээсээ хойш хоригдлууд бидний ахуй нөхцөлийг сайжруулах талаар их зүйл хийсэн. Мөн хоригдлуудын чөлөөт цаг, сургалт хүмүүжлийн нөхцөлөөр бүрэн хангасан боловч бусад алба хаагч нар чөлөөт цаг, сурч хөгжих боломжоор хавчин боож байна;

6.5.ШШГЕГ-ын 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр “ЭШУС нийгэмлэг” Олон улсын байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакландтай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.<sup>106</sup>



НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ирүүлсэн Тайлан, Зөвлөмж<sup>107</sup> болон ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор ТОГТМОЛ хяналт шинжилгээ хийх” заалт болон

<sup>106</sup> ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан ШШГ-ын 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хяналт шинжилгээ хийх “24/23” дугаартай удирдамж

<sup>107</sup> НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын урьдчилсан тайланг Ерөнхий ассамблейн Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн, батлаад Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Зөвлөмж.

ЭШУСАЭ гишүүнд хандаж ирүүлсэн нийт гомдол, мэдээллийн дийлэнхэд ШШГ байгууллагын орчин нөхцөл болон халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдөж буй асуудал хөндөгддөг зэрэг нөхцөл байдлыг үндэслэн ШШГЕГ-ын 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр “ЭШУС нийгэмлэг” Олон улсын байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакландтай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.<sup>108</sup>

Тус хорих ангийн Эх, нярайн тасагт 0-2 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд хорих ял эдэлж байх бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар нярай, нялх насны буюу 0-2 насны хүүхэдтэй 19 эмэгтэйчүүд 4 монгол гэрт хуваагдан байрлаж байна.

Хорих ял эдэлж буй нийт эмэгтэйчүүдтэй бүлгийн ярилцлага хийж 11 эмэгтэйтэй ганцаарчилсан ярилцлага хийж ажилласан. Тус хорих ангид хорих ял эдэлж буй бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг тав тухтай байлгахад ангийн захирагч, хурандаа П.Очгэрэл боломжит бүхий л зүйлийг хийж, анхаарал халамж хандуулдаг тухай танилцуулсан.

Хорих ял эдэлж буй бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд дараах асуудлыг нийтлэг байдлаар хөндөгдөж байна. ганцаарчилсан ярилцлагаас дараах асуудлыг хөндсөн.

*Эх, нярайн тасагт хоёр эмч ажилладаг боловч хүүхдийн мэргэжлээр мэргэшээгүй. Нэг нь тэтгэврийн насны хүн бөгөөд тус байгууллагад гэрээгээр ажилладаг, нөгөө нь дэслэгч цолтой эмч. Нэг хүүхэд өвдөхөд бусад хүүхдэдээ халддаг, улмаар хүүхдийн өвчин хүндрээд байхад эмч нар арга хэмжээ авахгүй тээршаадаг, ингэж хугацаа алдсанаас өөр эмнэлэг рүү шилжих тохиолдол гардаг. Тухайлбал, 2023 оны 09 дүгээр сард хүүхэд халуураад байсан ч лаа эмчилгээ хийгээд байсан, тухайн хүүхэд бөөлжиж эхэлсэн тул БЗД-ийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлэн шинжилгээ өгөхөд элэгний өөрчлөлт илэрснээр хэвтэн эмчлүүлсэн. Энэ мэтчилэн хүүхдүүд гүйлгэх, шингэн алдах өвчин их тусдаг бөгөөд эмч нар тээршаагаад байхаар ар гэртээ эм захиж хугацаа их алддаг. Ерөнхийдөө өвчнийг тартагт нь тулгадаг<sup>109</sup>*

*Хүүхдийн өвчин хүндэрснээр дараагийн шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдахаар явахдаа эмэгтэйчүүд хоригдлын хувцастайгаа, мөн камертай алба хаагч байнга хамт явдаг зэрэг нь сэтгэл зүйн хувьд хүнд дарамтад оруулдаг, "...таньдаг хүн тааралдах вий, намайг хоригдлын хувцастай явааг харах вий гэсэн айдастай явах үнэхээр хэцүү..."<sup>110</sup>*

*Хүүхэд нялх бага наснаасаа энгийн хувцастай хүн дээр бишүүрхээд очдоггүй, эрээн хувцастай хүнээс бишүүрхэхгүй дуртай очдог, эмнэлэгт үзүүлэхээр явахдаа машины тортой цонхноос айдаг, хорих ангийн орчинд хүүхэд "болохгүй" гэдэг үгийг байнга сонсож өсөж бойжиж байна...", "...хоригдлууд тоонд гарах дохио дуугарахаар хүүхэд ээжийнхээ хоригдлын шар хувцсыг барьсаар гүйж ирэхийг харахад өр зүрх минь эмтэрдэг..."<sup>111</sup>*

108 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан ШШГ-ын 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хяналт шинжилгээ хийх "24/23" дугаартай удирдамж.

109 Ганцаарчилсан ярилцлагаас

110 Ганцаарчилсан ярилцлагаас

111 Ганцаарчилсан ярилцлагаас

Хүүхдийг 2 нас хүрэхэд ар гэрийнхэндээ хүлээлгэн өгөх зохицуулалттай. Хүүхдийг түр эргэлтэд гаргадаггүй тул хүүхэд огт танихгүй хүмүүсийн гар дээр очих тохиолдол байгаа бөгөөд хүүхдийн сэтгэл зүй, хүмүүжил, төлөвшилд хүндээр нөлөөлдөг, аав дээрээ очсоноос хойш хэлд орох насанд хүрсэн боловч хэлд орохгүй байгаа тохиолдол гарсан. Хүүхдийг асрамжийн газарт түр өгөөд ээж нь хорих ялаа эдэлж дуусгаад асрамжийн газраас хүүхдээ авах гэхээр эрхэлсэн ажилтай байх, орон байртай байх зэрэг үзүүлэлтүүд шаардагддаг тул хүндрэл бэрхшээл учирдаг.<sup>112</sup>



НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцод "...бүх хүүхдүүд эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах болон хүчирхийлэл, доромжлол, ялгаварлан гадуурхалтаас хамгаалуулах эрхтэй..." гэж заасан байдаг. Хүүхдийн эрхийн конвенц нь "...хүүхдийг бүх талаар эерэг, хувь хүн болж төлөвших" хамгийн сайн орчин бол гэр бүл гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хүний амьдралын эхний гурван жилд уураг тархи (мэдрэлийн нөхөн сэргэх чадвар) шинэ зүйлд амархан дасан зохицож, өөрчлөгддөг учир хүүхдийн хөгжил, өсөлт түргэн байдаг бөгөөд энэхүү гурван жилийн хугацаанд тухайн хүний хөгжил, төлөвшлийн 70 хувь нь бүрэлддэг гэж үздэг. Удамшлын хүчин зүйлүүд хүүхдийн хөгжилд тодорхой нөлөөтэй хэдий ч, хоол тэжээлийн дутагдал, архаг өвчин болон бие махбодын бусад эргэшгүй өөрчлөлтүүд, ялангуяа бага балчир үеийн өсөж бойжсон орчин хамгаас илүү нөлөөтэй гэж үздэг.

Тиймээс дөнгөж төрсөн, нярай хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нөхцөл, боломжийг судлан, зохих шийдвэр гаргах, Эх, нярайн тасагт хүүхдийн эмчийн орон тоог бий болгох асуудал зайлгүй шаардлагатай гэж ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс үзэж байна.

## Долоо. Онцлох тохиолдол

1.ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй хаалттай хорих ангид хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд авсан асуумжид 280 хоригдол оролцсоноос 152 нь "хөдөлмөр эрхэлдэг" гэж хариулсан. Харин сургалт, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагддаггүй хоригдлууд "бөгсөө сайртгал өдөржин суудаг", "Өдөр болгон 8 цагаас хойш 17 цаг хүртэл сандал дээр суугаад, нуруу бөөр өвддөг болсон. Цагаан мах гардаг болж, эрүүл мэндээрээ хохирч байна, бид. Энэ бол эрүү шүүлт, залхаан цээрлүүлэлтийн нэг хэлбэр мөнөөсөө мөн" хэмээн хариулсан.

112 Ганцаарчилсан ярилцлагаас

2. ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй хаалттай хорих ангид хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд тус хорих ангийн алба хаагчдад хамаарах гомдол анхаарал татаж байв. Нэр бүхий 6-7 алба хаагчидтай холбоотой гомдол мэдээлэл тогтоогдсон ба зарим нь өмнөх онд тогтоогдож байсан алба хаагч нарт хамаарах гомдол дахин илэрсэн явдал байв.

Хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хүнлэг бус харьцаа, хүнийг ялгаварлан гадуурхах шинжтэй үйлдэл, харьцаанд өртдөг эсэхийг тодруулсан асуулгад 173 хоригдол оролцсоноос 43 хувь буюу 75 нь “ийм харьцаанд өртдөг” гэж хариулсан.

ЭШУС үндэсний ажиллагаа нь тус ангид 2023 онд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан ба тухайн үеийн илэрсэн нөхцөл байдалд мөн л тус ангийн алба хаагчдад хамаарах гомдол илэрч байсан. “Хорих ангид алба хаагч зүй бусаар харьцаж байсан уу?” гэх асуултад хоригдлууд хэрхэн хариулсан байдлыг дурдсан бөгөөд асуумжид оролцсон 118 хоригдлын 39 буюу 33,1 хувь нь “Алба хаагчдын зүгээс зүй бус харьцаанд өртдөг” гэж хариулсан. Энэхүү алба хаагч нарт хамаарах асуудлыг гишүүний 2023 оны 08/08 дугаар зөвлөмжийн 4 дүгээр хэсэгт тусгаж засаж, сайжруулахаар ангийн даргад хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлт болгон ирүүлсэн ангийн дарга Р.Ууганбаярын 2023 оны 01/1291 тоот хариунд эдгээр алба хаагчдад “албаны шалгалт явуулахад зөвлөмжид дурдагдсан асуудлууд тогтоогдоогүй бөгөөд дээрх алба хаагчид хууль ёсны шаардлага тавьж ажилладаг” гэсэн байв. Нэр дурдагдсан алба хаагчдад явуулсан албан шалгалтын дүгнэлтийг 437 дугаар нээлттэй хорих ангийн даргаас ирүүлсэн албан тоотод хавсаргаагүй







байсан тул ХЭҮКТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.3-т заасан бүрэн эрхийн дагуу нөхөн гаргуулж авч дүн шинжилгээ хийсэн.

Гэтэл 2024 оны давтан хяналт шинжилгээгээр тус алба хаагч нарт хамаарах зөрчил арилаагүйн дээр нэмж хэд хэдэн алба хаагч нарт хамаарах гомдол, мэдээлэл илэрсэн. Энэ талаар 2024 оны зөвлөмжид дэлгэрэнгүй дурдаж үнэлэлт, дүгнэлт өгч зөвлөмжөөр Алба хаагчдын албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд явуулсан албан шалгалтын зөвхөн нэг талыг барьж үйлдсэн, зөрчлийг хаацайлсан шинжтэй тайлан, дүгнэлт нь тус хорих ангид хүний хэзээд үл хязгаарлагдах эрх зөрчигдөх тогтолцоо бодитоор оршин байгааг нотолж байна.

3.Ажлын заалтгүй хоригдлыг амралтын цагаас бусад үед модон, хуванцар сандал дээр удаан хугацаагаар суулгах буюу хорих ял эдэлж байгаа хүмүүсийн хэлж заншсанаар “зоонд суулгах”, “улаан шугамд суулгах” асуудал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад байгаа нийтлэг томоохон зөрчлүүдийн нэг мөн. Биеийн тогтсон нэг байрлалд удаан хугацааны турш албадан

байлгах, суулгах нь олон улсын хүний эрхийн эрх зүйд “албадлагын байрлал”, “стрессийн байрлал” гэх нэршилтэй эрүү шүүлт тулгах үйлдлийн нэг хэлбэр юм. Хатуу, чийг татдаг гадаргуу дээр удаан суулгадгаас болж хоригдлуудын цагаан мах эргэсэн, үргэлж цустай бие засдаг болсон, өдөр болгон суулгадаг учир цагаан мах, шамбарам нь эдгэрдэггүй, улам бүр хүндэрсэн, нуруу бөөрний өвчтэй болсон, хөдөлгөөний дутагдалд орсон, зүрх судасны өвчтэй болсон гэсэн илэрц бидний авсан асуумжид 32 хувийг эзэлж байна.

4. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ШШГЕГ-ын болон салбар, нэгжүүдийн дарга, удирдлагад хүргүүлсэн зөвлөмж бүрд сахилга, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх; эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх алба хаагчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хангаж ажиллахад сургалт, арга хэмжээ явуулах талаар дурдсаар ирсэн боловч салбар, нэгжүүдэд хийсэн хяналт шинжилгээ тутмаар энэ байдал хэвээр оршсоор байна.

Энэ нь ШШГ байгууллага, удирдлага, алба хаагчид Монгол Улсын Үндсэн хууль, НҮБ-ын холбогдох гэрээ конвенцоор олгогдсон хүний хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг үл хүндэтгэж, үл хангаж, цаашилбал, Монгол

Улсын хүний эрхийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж буй тул энэ асуудлыг жил жилд бууруулах эцэст нь таслан зогсооход онцгойлон анхаарч ажиллана.

**Найм. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлсэн зөвлөмж**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нийт 483 заалт бүхий 49 зөвлөмжийг албажуулж холбогдох газруудад хүргүүлсэн. Үүнээс 2024 оны байдлаар ШШГЕГ, түүний харьяа хорих 7 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийсэн байна.

*ШШГ байгууллагад 2022-2024 оны хугацаанд ШШГ байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболорт хандаж*

- *Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдийн эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт,*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааны алба хаагчдын чиг үүргээ биелүүлэх явцад баримтлах сахилга, ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн хүрээнд нийт 32 заалт бүхий 2 зөвлөмжийг хүргүүлсэн.*

*Мөн ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай хорих 437, 427 дугаар ангиудад 20 заалт бүхий 2 зөвлөмжийг 2024 оны 04 сарын 01-ээс 2025 оны 04 сарын 01-ний хоорондох тайлант хугацаанд хүргүүлэн ажиллажээ*

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлэхдээ:

- Хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон НҮБ-ын гэрээ, конвенц, олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийг дагаж мөрдөн хэрэгжүүлэхдээ “Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцах”; “Яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ялгаварлан гадуурхаж болохгүй”; “Хэнийг ч эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж болохгүй” гэсэн хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг ямагт чанд баримтлахыг сануулж;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.5.Шүүх засаглал бүлгийн 4.1.5.4-т “Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ” гэсэн зорилтыг үндэс болгон, дэлхий нийтээр 2030 он гэхэд энх тайван, шударга ёс цогцлоох тогтвортой хөгжлийн 16 дахь зорилтын хэрэгжилтийг хангахад тэмүүлж, хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон НҮБ-ын гэрээ, конвенц, олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг чанд баримтлахад арга зүйн чиглэл болгохыг сануулж зөвлөмжийг хүргүүлсэн.



## Ес. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт



ЭШУС үндэсний үйл ажиллагаа нь ийнхүү байгуулагдсан цагаас хойш Монгол Улсын нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлэн ажилладаг.

Тус бүрэн эрхийн хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нийт 483 заалт бүхий 49 зөвлөмжийг албажуулж холбогдох газруудад хүргүүлсэн байна. Үүнээс 2024 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа хорих 7 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийсэн байна.

Тайлант хугацаанд буюу 2024 оны 04 сарын 01-нээс 2025 оны 04 сарын 01 хүртэлх хугацаанд ШШГЕГ-т хүргүүлсэн 2 зөвлөмж, түүний харьяа нээлттэй, хаалттай хорих 2 байгууллагад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт 81.0 хувь хангагдаж ажиллав.

Улсын Их хурлын Тамгын газраас ХЭҮКтХ-ийн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ЭШУС үйл ажиллагааны 2023

оны тайланд хийсэн хяналт шинжилгээний танилцуулгад зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд хийсэн дүн шинжилгээг нарийвчлан тусгаагүй талаар дурдсан. Тус дүгнэлтийн хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн нийт 45 зөвлөмжид хяналт, шинжилгээ хийж дүгнэлээ.

Зөвлөмжийн хэрэгжилтийг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний “Аргачлал батлах тухай” А/03 дугаар тушаалаар баталсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх

аргачлалаар үнэлэв. Мөн зөвлөмжийн заалт тус бүрийг үнэлж, үнэлгээг нарийвчлан гаргаж, дүн шинжилгээг бодитой хийж дүгнэв. Нийт 45 зөвлөмжийн 448 заалтын хэрэгжилтийг үнэлэв.

ШШГ байгууллагын хувьд ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх гол томоохон объектын нэг юм. Тайлант хугацаанд ШШГ байгууллагад хүргүүлсэн 4 зөвлөмжийн 52 заалтын хүрээнд хэрэгжилтийг тооцож ажиллав.

ХЭҮКТХ-ийн 33.1.1 дэх хэсэг “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх” гэж заасан тул өмнө онд ажилласан байгууллага дээр дахин очиж давтан хяналт шинжилгээ хийх, хуульд заасан тогтмол хяналт шинжилгээ хийх чиг үүргээ баримтлан ажиллаж байна.

ШШГ байгууллагын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад давтан хяналт шинжилгээ хийж ажиллахад хэдийгээр өмнө гарсан зөрчил, дутагдал давтагдах, дахин илрэх, нөхцөл байдал тогтоогдох тохиолдол гарч байгаа ч энэ нь жил ирэх бүр хумигдаж, нэг мөр шийдвэрлэгдэх, арилах зэрэг сайшаалтай алхмууд тодорхой үр дүнгүүд гарсаар байна.

ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс нээлттэй, хаалттай хорих анги, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, нэгдсэн төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, эмэгтэйчүүдийн хорих анги бусад баривчлах төв байр, цагдан хорих байр зэрэг Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх газарт урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж зарим газруудад давтан хяналт шинжилгээг хийн ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд хамрагдсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан, зөвлөмжид тусгагдсан зөрчил, дутагдлыг арилгасан, бууруулсан цаашид эрхийн зөрчил гаргахгүй байхын тулд хэрхэн ямар арга хэмжээ авч ажиллах талаар тодорхой тайлбар, үндэслэл, хавсралт материал, холбогдох зураг, шаардлагатай баримт нотолгооны хамт ирүүлдэг.



ЭШУС чиг үүргийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг 2022 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нээлттэй, хаалттай хорих ангиудад 2022 онд 3, 2023 онд 15, 2024 онд 12 газарт урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийж ажилласан байна.

Хүснэгт 17

№	Хүргүүлсэн байгууллага	Огноо, дугаар	Заалтын тоо	Хувь
<b>2022 оны байдлаар</b>				
1	ШШГЕГ-ын дарга хурандаа О.Амарсанаа	2022.12.28 08/08	11	77.0%
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын баривчлах байрны дарга хурандаа Т.Зулзүсэм	2022.12.28 08/09	10	50.0%
3	ШШГЕГ-ын Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн дарга, хурандаа Б.Нямгомбо	2022.12.28 08/10	11	97.0%
<b>Нийт үнэлгээ</b>				75.0%
<b>2023 оны байдлаар</b>				
1	ШШГЕГ-ын 417 дугаар нээлттэй ангийн дарга, хурандаа П.Ууганбаяр	2023.05.19 08/02	13	20.0%
2	ШШГЕГ-ын 427 дугаар нээлттэй, хаалттай ангийн дарга, хурандаа С.Батсайхан	2023.05.19 08/03	14	90.0%
3	ШШГЕГ-ын 419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Д.Хатанбаатар	2023.06.22 08/05	11	100.0%
4	ШШГЕГ-ын 407 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Ц.Очгэрэл	2023.07.03 08/06	12	100.0%
5	ШШГЕГ-ын 439 дүгээр хаалттай хорих ангийн дарга, хурандаа Д.Батгэрэл	2023.07.03 08/07	12	80.0%
6	ШШГЕГ-ын 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хошууч Р.Ууганбаяр	2023.07.03 08/08	14	97.0%
7	ШШГЕГ-ын 445 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа С.Лхагвасүрэн	2023.08.16 08/09	13	53.0%
8	ШШГЕГ-ын 435 дугаар хаалттай хорих ангийн дарга, хурандаа Д.Өлзийбат	2023.08.16 08/10	13	76.0%
9	Увс аймаг дахь ШШГ газрын дарга, хошууч З.Ариунбаяр	2023.09.18 08/12	7	100.0%

10	ШШГЕГ-ын 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга хурандаа А.Батхуяг	2023.10.04 08/14	22	100.0%
11	ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн дарга, хурандаа Л.Эрдэнэбат	2023.10.12 08/15	17	100.0%
12	ШШГЕГ-ын 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Түвшинтөгс	2023.10.12 08/16	14	62.0%
13	ШШГЕГ-ын баривчлах төвийн дарга, хурандаа Д.Чинзориг	2023.11.30 08/18	10	100.0%
14	ШШГЕГ-ын 421 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Б.Юмчинбагана	2023.12.04 08/19	22	95.0%
15	ШШГЕГ-ын 441 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Ч.Мөнх-Эрдэнэ	2023.12.04 08/20	15	80.0%
<b>Нийт үнэлгээ</b>				84.0%
<b>2024 оны байдлаар</b>				
1	ШШГЕГ-ын 409 дүгээр хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Батбаяр	2024.02.16 08/04	16	100.0%
2	ШШГЕГ-ын 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих ангийн дарга, дэд хурандаа Г.Амгаланбаатар	2024.02.28 08/05	14	91.0%
<b>Тайлант хугацаанд хамрагдаж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд</b>				
3	ШШГЕГ-ын дарга хурандаа Б.Нандинболор	2024.10.18 08/9	19	78.0%
4	ШШГЕГ-ын дарга хурандаа Б.Нандинболор	2024.10.18 08/10	13	74.0%
5	ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамир	2024.12.20 08/14	8	91.0%
6	ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаяр	2024.12.27 08/15	12	80.0%
<b>Нийт үнэлгээ</b>				85.5%

## 9.1 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ, ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ АЛБА ХААГЧДЫН ЧИГ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ ЯВЦАД БАРИМТЛАХ САХИЛГА ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АХИЦ ДЭВШИЛ, ГАРСАН ҮР ДҮН

Нэг.ШШГЕГ-ын салбар, нэгжүүдийн нийт алба хаагчдын хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг тогтоох чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

ШШГ байгууллагын харьяа анги байгууллага, салбар нэгжүүд алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгийн түвшнийг тогтоох, түүнд үндэслэн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох арга хэмжээг нийтлэг байдлаар зохион байгуулан ажилласан.

Үүнд: 401, 405, 407, 409, 413, 417, 441, 445, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Тосонцэнгэл, Ханбогд, Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсүүд сорил, тест болон ярилцлагын арга ашиглан алба хаагчдын хүний эрхийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон.



Мөн алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Хүний эрхийн үндэсний комисс, Прокурорын байгууллага, Насан туршийн боловсролын төв болон хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчидтай хамтран сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нийт анги байгууллагын алба хаагчдаас авсан судалгаанаас дүгнэхэд хүний эрхийн үндсэн ойлголт, ерөнхий мэдлэгийн түвшин сайн боловч Станбулын протокол, Эрүүдэн шүүхтэй холбогдолтой олон улсын гэрээ конвенц гэх мэт чиглэлээр тусгайлсан сургалт зохион байгуулахаас гадна өдөр тутмын үйл ажиллагаанд дадал болгон хэвшүүлэх, бататгах

хэрэгцээ шаардлагатай байна.

Хоёр. Сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, тогтмолжуулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

ШШГЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүд танхимын сургалтаас гадна тодорхой кейс, өгөгдөл дээр ажиллуулах, хичээл сургалтаар олгосон мэдлэгийг бататгах зорилгоор ажлын байранд дадлага ажил хийлгэх зэргээр алба хаагчдын оролцоог дэмжиж, сургалтын шинэлэг арга зүйг нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн алба хаагчдад бие даан хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээл сургалтын материалыг цахим сургалтын платформ “Зангиа академи”-ийн дотоод сургалтын санд байршуулсан. Энэхүү

сургалтыг 99 алба хаагч үзэж, судалсан байна.

Өмнөговь аймаг дахь ШШГГ: Аймгийн Прокурорын газартай хамтран “Эрүү шүүлтээс ангид байх” аяныг зохион байгуулж, 8 алба хаагчийг “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт сургалтад хамруулсан. Мөн цахим орчинд эрүүдэн шүүхээс татгалзахыг уриалсан утга агуулга бүхий богино хэмжээний видео бичлэг байршуулан ажилласан байна.

*Гурав. Олон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааны тэргүүн туршлагаас суралцах, нэвтрүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

ШШГ байгууллагаас 2024 онд Япон, Солонгос, Герман, Гүрж улсын ижил чиг үүргийн 5 байгууллагад хорих ял эдлүүлэх ажиллагаа болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр нийт 36 алба хаагч туршлага судалж, танилцах дадлагад хамрагдсан.

*Дөрөв. НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын үзэл баримтлал, суурь зарчим, тэдгээрийг үйл ажиллагаандаа мөрдөх хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын үзэл баримтлал, суурь зарчим, тэдгээрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх хүрээнд алба хаагчдын дунд сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулахаар 2025 оны хичээл сургалтын хөтөлбөр болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг ШШГЕГ-аас газраас нийт анги байгууллага, салбар нэгжид хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

*Тав. Хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хангаж ажиллах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

ШШГЕГ-ын сургалт хариуцсан нэгж нь тус арга хэмжээний хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо 11 дүгээр сарыг “Ёс зүй”-н сар болгосонтой холбогдуулан “7:4:10” арга зүйн 4 удаагийн цахим сургалтад төв байгууллага, харьяа салбар нэгжийн давхардсан тоогоор 2978 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэх, дадал суулгах зорилгоор харьяа анги байгууллагууд дараах тодорхой сэдэвт аяныг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг: “Ёс зүйг эрхэмлэе” аян зохион байгуулсан;



- 407, 417, 439, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд: “Харилцан хүндэтгэе” уриа бүхий аян зохион байгуулж, алба хаагчдад хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх сэдвээр сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулсан;
- Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГ хэлтэс 413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: “Мэндлэх, хүндлэх ёсыг төлөвшүүлье” уриа бүхий 1 сарын аян зохион байгуулсан;
- Говьсүмбэр аймаг дахь ШШГ газар-425 дугаар нээлттэй хорих анги: Албаны сургалтын төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сард хүний эрхийн чиглэлээр аймгийн Прокурорын газартай хамтран 3 цагийн сургалтыг давхардсан тоогоор нийт 158 алба хаагчдад зохион байгуулсан;
- Орхон аймаг дахь ШШГ -437 дугаар нээлттэй хорих анги: “ Хүний эрхийг дээдэлъе” уриатай 45 хоногийн аян зохион байгуулсан
- Дархан-Уул аймаг дахь ШШГ -445 дугаар нээлттэй хорих анги: “Ярьдаг нь биш мөрддөг нь бай” уриатай 1 сарын аяныг зохион байгуулсан;
- Говь-Алтай аймаг дахь ШШГ “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал” сэдвээр зохион байгуулсан;
- Баривчлах төв: Алба хаагч болон баривчлагдсан этгээдийн харьцаанаас үүдэлтэй зөрчил дутагдалд дүгнэлт хийж ажиллах төлөвлөгөөний дагуу “Алба хаагч танд талархъя” уриатай 14 хоногийн аяныг зохион байгуулж, баривчлагдсан этгээдүүдийн байранд санал сэтгэгдэл бичих “Талархлын мод” байршуулж, үр дүнг нэгтгэн ажилласан;

*Зургаа. Нийт алба хаагчдын хоригдол, хоригдогсодтой харьцахад шаардагдах мэдлэг, ур чадварын түвшнийг тогтоох, тогтоогдсон үр дүнд үндэслэн хоригдол, хоригдогсодтой харьцах хэрэгцээт дотоод сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн алба хаагчдын зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр “Хүний эрх”-ийн сургалтыг мэргэжлийн байгууллага болон хүний эрхийн сургагч багш нартай хамтран сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, хичээл сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комисс, ЭШУС үндэсний үйл ажиллагаатай хамтран сүүлийн 2 жилийн хугацаанд хүний эрхийн сургагч багшийг үе шаттайгаар бэлтгэсэн.

*Долоо. Нийт алба хаагчдын зан суртахуун, үйл, ёс суртахуун, ёс зүй, сэтгэл зүйн төлөв байдлын судалгааг мэргэжлийн байгууллагын оролцоотой явуулах, үр дүнд үндэслэн сургалт, нөлөөллийн хөтөлбөр боловсруулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

ШШГЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүд алба хаагчдын ёс зүй, ажлаас халшрах хам шинж болон сэтгэл зүйн төлөв байдлын судалгааг мэргэжлийн байгууллага болон алба хаагчидтай хамтран зохион байгуулж, судалгааны үр дүнд үндэслэн сургалт, нөлөөллийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

- 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Глобал удирдагч их сургуулийн Хууль эрх зүйн сургуулийн тэнхимийн эрхлэгч Д.Насанбаттай хамтран алба хаагчдын ёс зүй, сэтгэл зүйн төлөв байдлын судалгаа авч, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2 цагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан;
- Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГХ-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: “Монголын мэргэшсэн сэтгэл судлаачдын үндэсний төв”-тэй хамтран сэтгэл зүйч Ж.Үйлст, сэтгэл зүйн магистр, сэтгэл зүйч С.Отгонжаргал нар “Зүрх сэтгэлийн боловсрол”, “Гэмт хэрэг үйлдсэн хүний сэтгэл зүй, тэдэнтэй ажиллаж буй хүний сэтгэл зүйн байдал”, “Хүний сэтгэл зүйг хэрхэн тодорхойлох талаар” сэдвээр алба хаагчидтай чөлөөтэй ярилцаж, дасгал ажил хийлгэх, багаар ажиллах зэргээр танхимын 2 цагийн сургалт зохион байгуулсан;
- Орхон аймаг дахь ШШГГ 437 дугаар нээлттэй хорих анги: Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран алба хаагчдын харилцаанд эерэг зан үйл төлөвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, харилцан ойлголцох, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх гарц шийдлийг бий болгох зорилгоор “Өглөөний уулзалт” арга хэмжээг зохион байгуулсан;
- 435 дугаар хаалттай хорих анги: Алба хаагчдаас ажлаас халшрах хам шинжийн судалгааг авч, судалгааны үр дүнг нэгтгэхэд ажлаас халшрах хам шинжтэй 28 хувь, ажлаас халшрах хам шинжтэй болж байгаа 40 хувь, хэвийн 7 хувь байсан. Нийт алба хаагчдын 55 хувь буюу 40 алба хаагч стрессийн түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсанаас 90 хувь стрессийн хөнгөн түвшинтэй, 10 хувь нь стрессийн илрэл дунд зэрэг гэж оношлогдсон;
- Өмнөговь аймаг дахь ШШГГ-ын нийт алба хаагчдын зан суртахуун, ёс зүй, сэтгэл зүйн төлөв байдал, хувь хүний зан төлөв буюу темпераментыг тодорхойлох тест мөн тэвчээр, стрессийн түвшнийг тодорхойлох сорил, судалгаа авах ажлыг аймгийн Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын газрын сэтгэл зүйч С.Долгорсүрэнтэй хамтран зохион байгуулж, алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Найм. НҮБ-ын ЭШЭК, Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичиг, Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хуулиар баталгаажуулсан хүний хэзээд үл хязгаарлагдах эрхүүд, “ШШГ байгууллагын алба хаагчдын сахилга, ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Харьяа салбар нэгжүүд алба хаагчдын сахилга, ёс зүйн хэм хэмжээний заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот уриа бүхий сарын аян өрнүүлж, үр дүнг тооцон ажилласан. Үүнд:

- 405 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх, үнэт зүйлс, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх зорилго бүхий “Ёс зүйтэй алба хаагч-бидний манлайлал” 1 сарын аян зохион байгуулж, үр дүнг тооцсон;
- 415 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагчид “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” уриа бүхий 1 сарын аян зохион байгуулж, хамт олны уур амьсгалд эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор “Баярлалаа” сэдэвт захидлын аян, “Ёс зүйтэй офицер”, “Ёс зүйтэй алба хаагч” сэдэвт санал асуулга авч, ёс зүйтэй алба хаагчдыг шалгаруулан ажилласан;
- Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагчид “Хариуцлагатай алба хаагч-бидний бахархал” уриатай 1 сарын аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд цэрэгжилт, жагсаалч байдал, сахилга ёс зүй, ажлаараа бусдыгаа манлайлан ажиллаж буй алба хаагчдаас хоёр “Онцлох алба хаагч”-ийг шалгаруулж, ангийн даргын тушаалаар сарын үндсэн цалингийн хувиар шагнаж урамшуулсан;
- 435 дугаар хаалттай хорих анги, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын алба хаагч нар Хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийг бататгах, дадал болгон хэвшүүлэх зорилгоор “Ёс зүйтэй алба хаагч” уриатай 21 хоногийн аян зохион байгуулсан;
- 441 дүгээр нээлттэй хорих ангийн алба хаагчид “Ёс зүй биднээс эхэлнэ” уриатай 1 сарын аян зохион байгуулсан. Тус аяны хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сэдвээр цахим сургалтад алба хаагчдыг хамруулсан;
- Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн алба хаагчдын сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хүний эрхийг дээдлэх” уриатай долоо хоногийн аян зохион байгуулсан;
- Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар “Ёс зүйг сахиж, хүнлэг харилцааг эрхэмлэе” уриатай 22 хоногийн аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөг, “Ёс зүй ба ёс суртахуун” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг алба хаагчдын дунд зохион байгуулсан;
- Дорнод аймаг дахь ШШГГ “Ёс зүй миний таны нэрийн хуудас” уриа

дэвшүүлэн алба хаагчдад “Харилцаа”, “Сэтгэл зүйн насны онцлог”, “Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албаны үйл ажиллагаа сэдвүүдээр 6 цагийн сургалт зохион байгуулж, аяны агуулгыг илэрхийлсэн постер, зурагт хуудсыг байгууллагын цахим хаягт байршуулан ажилласан;

- Увс аймаг дахь ШШГГ Хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийг эзэмшүүлэх зорилгоор “Хүний эрх-бидний найз” уриатай 1 сарын аян зохион байгуулсан;
- Багануур дүүрэг дэх ШШГГ “Ёс зүйг төлөвшүүлье” уриатай 1 сарын аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийг хэн сайн мэдэх вэ? асуулт хариултын тэмцээн, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ” сэдэвт илтгэлийн тэмцээнийг нийт алба хаагчдын дунд зохион байгуулсан;
- Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШШГ хэлтсийн Алба хаагчдын албаны бэлэн байдал, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Хариуцлагатай хамт олон” уриатай 1 сарын аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд цэрэгжилт, жагсаалч байдал, албаны бэлэн байдал, сахилга ёс зүй, ажлаараа бусдыгаа манлайлан ажиллаж буй алба хаагчдаас нэг “Онцлох алба хаагч”-ийг шалгаруулж шагнаж урамшуулсан;
- “Амгалан” мэргэжлийн боловсролын сургууль: “Ёс зүйтэй манлайлагч-зөв үлгэрлэгч” уриатай 1 сарын аяныг алба хаагчдын цэрэгжилт жагсаалч байдал, ажлын цаг ашиглалт, харилцааны ёс зүй, манлайлал зэрэг үзүүлэлтээр алба хаагчдыг дүгнэсэн.

*Ёс. Алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэх орчин нөхцөл, хангамжийг олон улсын жишигт хүргэх шаардлагыг тодорхойлох, шат дараалсан арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, тохижилт, ногоон байгууламж, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах, тэдний хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор өдөр өнжүүлэх өрөөг шинээр тохижуулан ажиллуулж байна. Хүүхдийн өдөр өнжүүлэх өрөө нь 2-10 насны 8-10 хүүхдийг хүлээн авах хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар 5-8 хүүхэд тогтмол үйлчлүүлдэг болсон;
- Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын алба хаагчдын хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг, хариуцлагаа биелүүлэх ажлын хүрээнд “Ахлагчийн зөвлөл”, “Эцэг, эхийн зөвлөл” хамтран 5 ханатай гэр

барьж, тохижуулан алба хаагчдын хүүхдүүд ажлын байранд ирсэн үед хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үлгэрийн болон танин мэдэхүйн, зохиолын ном, сурах бичгийг ашиглуулах боломж бүрдсэн;

- 421 дүгээр нээлттэй хорих ангийн алба хаагчдын ая тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд алба хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор бялдаржуулах танхимыг засварлан тохижуулж, ашиглалтад оруулсан. Мөн харуул хамгаалалтын алба хаагчдын хувцас солих өрөө, шүүгээг стандартын дагуу жигдрүүлэн ажилласан;
- Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГ хэлтсийн 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Амралтын өрөө”-г шинээр засварлан тохижуулсан;
- Говьсүмбэр аймаг дахь ШШГ 425 дугаар нээлттэй хорих ангийн ахлагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, бодит тусламж, дэмжлэгийг үзүүлэх зорилтын хүрээнд ахлагч бүрэлдэхүүний 2 алба хаагчдад гэр олгох, 3 алба хаагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамрагдах боломжоор хангаж, нийт алба хаагчдын 90 хувийг албаны орон сууцаар хангасан;
- 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн алба хаагчдын ая тухтай ажиллах, амрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Нэг цэгийн үйлчилгээ”-ний хэсэгт “Coffee shop” шинээр тохижуулан, ашиглалтад оруулсан;
- 433 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчдыг ая тухтай орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор стандарт шаардлагад нийцсэн амралтын өрөөтэй цайны газрыг ашиглалтад оруулсан;
- Орхон аймаг дахь ШШГ -437 дугаар нээлттэй хорих анги: Алба хаагчийн ажиллах ажлын байрны хэвийн орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор эмнэлгийн албаны өрөө тасалгаанд засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн;
- 441 дүгээр нээлттэй хорих ангийн ахлагч бүрэлдэхүүний чадавхыг бэхжүүлэх, санал хүсэлтийг нь шийдвэрлэх, ахлагч нарын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, ахлагч бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: Иж бүрэн 5 ханатай Монгол гэрийг 1 алба хаагчдад олгосон;
- Төв аймаг дахь ШШГ-ын алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан “Хүүхдийн өрөө”-г шинээр гаргаж, тохижуулсан;
- Алба хаагчдын мэдлэг боловсролоо дээшлүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын номын сангаас шаардлагатай ном, сурах бичгээр ханган ажилласан байна;



*Арав. "ШШГ байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм"-д тусгасан сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, арга хэмжээ авагдсан алба хаагчдыг дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

ШШГ байгууллагын сахилга, ёс зүйн дүрэмд заасны дагуу ШШГЕГ-ын дарга болон салбар нэгжийн даргын тушаалаар

- 2018 онд 666;
- 2019 онд 911;
- 2020 онд 610;
- 2021 онд 349;
- 2022 онд 449;
- 2023 онд 670;
- 2024 онд 605 алба хаагч тус тус сахилга, ёс зүйн зөрчил гаргасан байна.

2024 онд алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, 2025 оны 1 дүгээр улиралд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар төлөвлөн, төлөвлөгөө гарган батлуулсан байна.



## 9.2. ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ БОЛОН ЦАГДАН ХОРИГДСОН ИРГЭДИЙН ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУС ХАРЬЦАА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ГАРСАН ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ

Нэг. Хорих өрөөнүүдийн одоогийн гэрэлтүүлгийг бүдгэрүүлэгчтэй унтраалган зохицуулалттай гэрэлтүүлгээр солих, эсхүл шөнийн хараатай камераар хянах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 241 дүгээр зүйлд хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны төрөл, бүрэлдэхүүнд техникийн хяналт, хамгаалалтыг ашиглах зохицуулалттай бөгөөд үүний дагуу өнөөдрийн байдлаар байгууллагын хэмжээнд 5020 ширхэг телекамер ашиглагдаж байна. Үүнээс 2024 онд 313 ширхэг телекамерыг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн санхүүжилт болон байгууллагын төсвөөр шийдвэрлэж, нэмэлтээр суурилуулсан. Цаашид нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд уг асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхээр ажиллаж байна.

Одоо ашиглагдаж байгаа телекамерууд нь гэрэлгүй нөхцөлд хяналтыг бүрэн тавих боломжгүй, шөнийн хараатай телекамерын өртөг өндөр байдаг тул “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-ийн 43-т хоригдлуудыг байнгын гэрэлтэй өрөөнд байрлуулах нь эрүү шүүлтийн нэг хэлбэр бөгөөд энэ явдлыг хориглох тухай заасан бол 14 дүгээр дүрмийн (б)-д өрөөний гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд гэмтэл учруулахааргүй байхаар заасан байдаг.

Энэ хүрээнд эхний ээлжид 421 дүгээр нээлттэй хорих ангийн хоригдлын байр болон 29 хорих өрөө нийт 42 гэрэлтүүлгийг 4,3 сая төгрөгийн санхүүжилтээр бүдгэрүүлэгчтэй унтраалган зохицуулалттай гэрэлтүүлгээр сольж, харуул хамгаалалтын хяналтад ашиглаж болох эсэхийг турших ажлыг эхлүүлсэн.

Уг туршилтын ажлын үр дүнгээс хамаарч нийт хорих ангид хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэж, ирэх онуудын төсөвт зардлыг тусган шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

*Хоёр. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн ШШГЕГ-ын харьяа 405 дугаар тусгай хаалттай хорих ангид хамаарах зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200.1 дэх хэсэгт заасны дагуу "... хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болно" гэж заасны дагуу тусгай нэгжийн хоригдлуудыг хоёроор хорих саналыг ангийн арга зүйн хурлаар хэлэлцэн саналын материалыг судалгааны хамт Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

Мөн 405 дугаар хаалттай хорих ангийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө, бясалгалын өрөө, төлөөлөгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны уулзалтын өрөөнүүдийн шаланд бэхлэгдсэн хөлийн гавыг салгаж авсан ба "Хорих ангийн харуул хамгаалалтын журам"-ын 11.14-т "Хоригдлыг хуулийн дагуу түр хугацааны уулзалт хийх үед түр уулзалтын өрөөнд шалтай бэхлэгдсэн гавыг хөлд зүүсний дараа, гарыг урд гавлаж, харуул хамгаалалтын уулзуулна." гэснийг өөрчлөх санал болон тусгай нэгжийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах хууль, журмын саналын боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр төлөвлөсөн.



Өмнө



дараа нь

*Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө, бясалгалын өрөө, төлөөлөгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны уулзалтын өрөөнүүдийн шаланд бэхлэгдсэн хөлийн гавыг салгаж авсан.*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200.3 дахь хэсэгт заасны дагуу "Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно" гэсэн заалтын дагуу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл

бололцоог судлан 2023 оноос хойш “Дарь Ундрах” төрийн бус байгууллагын эсгий урлалын сургалтад 6, “Орчлонд наран мөнх гэр” төрийн бус байгууллагын цаасан урлалын сургалтад 6, зоосон ширээний сүлжмэл сүлжих цахим сургалтад 2, даалин оёх сургалтад 2, нийт 16 хоригдлыг хөдөлмөр эрхлэх дадлага сургалтад хамруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224 дүгээр зүйл, 272 дугаар зүйлийн 2.4, хорих ангийн дотоод журмын 19.4 дэх заалтыг үндэслэн ангийн арга зүйн хурлаар саналыг оруулан ангийн даргын тушаалаар шагналын 2-8 хоногоор урамшуулж байна.



*Гурав. Бүх хоригдлыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, тогтмолжуулах. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлт үндэслэн хоригдлуудын эрүүл мэндийн төлөв байдлыг тодорхойлох. Шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, эрүүл мэндийн үйлчилгээг хоригдол бүрд тэгш, хүртээмжтэй үзүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Улсын Гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, аймаг, сум, дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг тус тус байгуулж хоригдол, хоригдогч, албадан эмчлүүлэгч, баривчлагдсан этгээдүүдийг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд тогтмол хамруулж байна. Мөн 11 зөвлөх эмч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторитой Хамтран ажиллах гэрээг тус тус байгуулан хамтран ажилладаг.

*Зөвлөмжийн хүрээнд хоригдол, хоригдогсдыг хорих анги байгууллагын эмч нарын үзлэгээс гадна 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарын үзлэгт хамруулахад зовуурь, шинж тэмдэггүй 3321 хоригдол, хоригдогч байна.*

Харин үзлэгээр зовуурь, шинж тэмдэг илэрсэн 1,627 хоригдогсдыг өвчний ангиллаар нь авч үзвэл:

Д/д	Өвчний ангилал	Нийт хоригдол, хоригдогсдын тоо
1	Амьсгалын тогтолцооны өвчин	92
2	Дотоод шүүрэл	61
3	Сэтгэц зан үйлийн эмгэг	55
4	Мэдрэлийн тогтолцооны эмгэг	195
5	Гэмтэл, нүдний дайвар эрхтний өвчин	106
6	Зүрх, судасны өвчин	428
7	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	204
8	Арьс, харшил	35
9	Бөөр, шээс дамжуулах замын өвчин	119
10	Үе мөчний тогтолцооны өвчин	37
11	Шүд, мэс заслын өвчин	55
12	Хөгжлийн бэрхшээлтэй	240
<b>Нийт</b>		1627 өвчлөл илэрсэн.

Архаг суурь өвчтэй хоригдол, хоригдогсдыг шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах гэрээний дагуу аймаг, сумын эмнэлэг, 401, 429, 461 дүгээр хаалттай ангийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж байна.

Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд яаралтай түргэн тусламжийн 103 дугаарт дуудлага өгч үзүүлэх, аймаг, сумын эмнэлэгт хуяглан хүргэж үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах зэрэг арга хэмжээ авч ажилладаг.

Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/142, А/47 дугаар тушаалын 2.3-т “Хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн нь хоригдсон этгээдийн эмнэлгийн тусламж авах хүсэлтийн дагуу цаг алдалгүй, эрүүл мэндийн үзлэг хийж, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хамруулна.”,

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны А/214, А/462 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн эмчлэх” журмын 2.2-т “Яаралтай тусламж шаардлагатай бол хорих ангийн эмч нь хоригдлыг хамгийн ойрын эмнэлэгт үзүүлж, эмчлүүлж болно.”, 2.3-д “Хүнд өвчний шинж тэмдэг илэрсэн, өвчний онош тодорхойгүй, нэмэлт оношилгоо, шинжилгээ хийлгэх шаардлагатай, онош тодорхой боловч эмчилгээний үр дүн хангалтгүй байгаа тохиолдолд Нэгдсэн эмнэлгийн эмнэлэг, хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн хоригдлыг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлнэ” гэж тус тус заасны дагуу хоригдол, хоригдогчид нь хорих байгууллагын эмнэлгээс гадна хараат бус хөндлөнгийн эмчид үнэ төлбөргүй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах эрх зүйн баталгаа хангагдсан.

Хууль тогтоомжид заасан хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрх болон дээрх журмуудын дагуу өвчний ангилал, хүндрэлээс шалтгаалж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Одоогийн байдлаар эмчийн хяналтад буюу архаг суурь өвчтэй 622, биеийн байдал хүндэрч болзошгүй 152, биеийн байдал хүнд 2, хүндэвтэр 14, хорих ангийн эмнэлгийн хэсэгт хэвтэн эмчлүүлж байгаа 184 хоригдол, 401 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 96 хоригдол, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 36 хоригдогч, гадна эмнэлэгт 1 хоригдол, 2 хоригдогч хэвтэн эмчлүүлж байна.

Мөн 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн “Эмнэлэг хяналтын комисс”-ын хурлаар хүнд өвчний учир хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх дүгнэлт гаргаж, шинжээч эмч томилуулахаар 1, шинжээч эмчийн дүгнэлт хүлээж байгаа 2, нийт 3 хоригдлын асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлээд байна.

Нэн шаардлагатай эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлох ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэгт шүдний сувгийн эмчилгээ хийх материал, түүхий эд байдаггүй учир хийдэггүй. Үүнтэй холбоотой “Хоригдол, хоригдогсод нь өвдсөн шүдээ авхуулахгүй, эмчлүүлэх” хүсэлтэй байдаг.

Шүдний эмчилгээ хийх нөхцөл боломжоор хангах, эмнэлэг, эмнэлгийн хэсэгт хүний нөөцийн орон тоог нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, эмийн төсвийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг богино болон урт хугацааны танхимын сургалтад хамруулах хэрэгцээ шаардлагатай байна.

Яаралтай болон өндөр өртөгт оношилгоо, эмчилгээний зардлыг 2021-2024 оны судалгаанд үндэслэн тооцоог гаргахад;

- 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь 2021 он-67, 2022 он- 43, 2023 он-62, 2024-64 нийт 236 хоригдлыг өндөр өртөгт оношилгоо, шинжилгээнд хамруулсан;
- 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги нь 2021 онд 2, 2022 онд 7, 2023 онд 7, 2024 онд 4 нийт 16 хоригдлыг өндөр өртөгт оношилгоо, шинжилгээнд хамруулсан;
- 421 дүгээр нээлттэй хорих анги нь 2021-2024 онд 4 хоригдлыг өндөр өртөгт оношилгоо, шинжилгээнд хамруулсан;

Дээрх оношилгоо, шинжилгээнд хамруулахад эрүүл мэндийн даатгал болон хоригдлын ар гэрээс төлбөрийг хариуцсан.

Хоригдлын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж ажилласнаар :

- Хоригдлын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай төсвийн төсөөллийг Төсвийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 07 дугаар сард хүргүүлэхээр бэлтгэл ажил хангагдсан.
- 2025 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд нэгдсэн болон төрөлжсөн эмнэлгүүдийг эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашинаар хангах 2,423.8 сая төгрөгийн санхүүжилтийг тусган шийдвэрлүүлсэн.

*Дөрөв. Эмнэлгийн шат дараалсан тусламж үйлчилгээ үзүүлэх ажлын аргачлал, холбогдох журамд дүн шинжилгээ хийх, өөрчлөлт оруулах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Хоригдол, хоригдогсдод үзүүлдэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, сайжруулах зорилгоор батлуулсан дараах журам зааврыг батлуулсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/38 дугаар тушаалаар “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, заавар”;
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/61, А/40 дүгээр тушаалаар “Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар”, “Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт”, “Өлсгөлөн зарласан үед хөтлөх маягтын загвар”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/48, А/70 дугаар тушаалаар “Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх журам, жагсаалт”;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/219 дүгээр тушаалаар “Эмнэлэг хяналтын комиссын үйл ажиллагаа”-ны журам ;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/352 дугаар тушаалаар батлагдсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, албадан эмчлүүлэгч, хоригдлын хоолны газрын үйл ажиллагаа, хоол хүнсээр хангах, олгох журам”-ын илчлэг нормд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар тус тус батлуулсан байна.

Үүнээс гадна дараах журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. Үүнд:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Баривчлах байрны дотоод журам”;
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/142, А/47 дугаар тушаалаар баталсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”;
- “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн журам” зэрэг болно;



Цаашид согтуурах, мансуурах донтой өвчтөнд албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх үйл ажиллагаанд мөрдөгддөг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар батлагдсан “Согтуурах, мансуурах донтой хүнд эрүүл мэндийн дүгнэлт гаргах журам”, “Согтуурах, мансуурах донтой эсэхийг тогтоох эрүүл мэндийн дүгнэлтийн загвар”, “Согтуурах, мансуурах донтой хүнд албадан эмчилгээ хийхийг хориглох биеийн хүнд эмгэгийн жагсаалт”, “Согтуурах, мансуурах донтох хүнийг албадан эмчлэх журам”-д холбогдох заалтуудыг нэмж тусгуулахаар саналаа боловсруулан ажиллаж байна.

*Тав. ШШГЕГ-ын даргын А/164 дугаар тушаалаар<sup>113</sup> баталсан “Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын<sup>114</sup> 2.2 дахь заалтыг өөрчлөх<sup>115</sup> чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан, тус хуульд нийцүүлэн ШШГЕГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 224.3-т “...хоригдол энэ хуулийн 224.1-д заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрт хамрагдсан хугацаа нь ял эдэлж байгаа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст тухайн сард ажилласан хугацаа нь дангаар, эсхүл шилжин ирэхээс өмнө ял эдэлж байсан хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажилласан хугацааны нийлбэр нь 160 цагаас доошгүй тохиолдолд ажлын бүтээмж, чанарыг үндэслэн 1 сард 10 хүртэл хоногийн шагналын хоног олгоно” гэж заасан.

“Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2-т “...Хоригдлын тухайн сард хөдөлмөр эрхлэх ажлын цаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 224.3-т заасан хэмжээнд хүрээгүй бол тухайн сард шагналын хоног олгохгүй” гэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224.1, 224.3-т тусгагдсан агуулга, баримтлалыг хэрэгжүүлж ажиллах шинжтэй заалт юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна гэж тусгагдсан.

Тиймээс тус ажлын хүрээнд хийгдэх хууль, эрх зүйн шинэчлэлтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224.3 дахь заалт болон бусад зүйл, заалтуудыг өөрчлөх тодорхой саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлж ажиллана.

<sup>113</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/164 дугаар тушаал

<sup>114</sup> “Арга зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2 дахь заалт “Хоригдлын тухайн сард хөдөлмөр эрхэлсэн ажлын цаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224.3-т заасан хэмжээнд хүрээгүй бол тухайн сард шагналын хоног олгохгүй”

<sup>115</sup> “Хоригдлын тухайн сард хөдөлмөр эрхэлсэн ажлын цаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224.3-т заасан хэмжээнд хүрээгүй бол хоригдлын хөдөлмөр эрхлээгүй шалтгааныг магадалж, хэрэв “зайлшгүй” гэх нөхцөл байдал түүгээр тогтоогдвол хоригдлын ажилласан цагт дүйцэх өдрийг олгох” гэж өөрчлөх

Зургаа. Удаан хугацаанд суулгах, хүний биологийн процессын эсрэг шинжтэй, өдрийн хоолны дараа болон орой амрах цагийн өмнө бясалгалд хүчээр суулгах явдлыг хориглох чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Хоригдлын сэтгэл зүйн тэнцвэрт байдлыг хангаж, үйлдсэн гэмт хэрэгтээ дүгнэлт хийх, гэмт санаа бодлоос татгалзуулах, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор бясалгалын хөтөлбөрийг анхан болон дунд гүнзгийрүүлсэн хэлбэрээр 3,782 хоригдлыг хамруулан сайн дурын үндсэн дээр зохион байгуулан ажиллаж байна.

Хоригдлын хөдөлмөрийн нөхцөл, ажиллах цагтай уялдуулан бясалгалд хамрагдах цагийн хуваарийг баталж хамруулахын зэрэгцээ хөдөлмөрт хамрагдаагүй хоригдлуудад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар цаг үеийн байдлаар яриа таниулга хийх, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, ширээний теннис, шатар, даам тоглуулах, хөдөлгөөнт дасгал хийлгэх зэргээр хоригдлын цагийг зөв зохистой ашиглах асуудалд анхааран ажиллажээ. Тухайлбал:

- ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих анги нь “Хоригдолд хөдөлгөөнт дасгал хийлгэх заавар”-ыг боловсруулан зурган мэдээллийг хоригдол танилцах боломжтой бүх цэгүүдэд байршуулан, дүрс бичлэг бэлтгэн хоригдлуудыг дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамруулах, эрүүл хэв маягт суралцах зэрэгт ач холбогдол өгч, энэ чиглэлээр яриа таниулга хийсэн;

Хорих анги, байгууллагын хэмжээнд нийт 3,370 хоригдол буюу нийт хоригдлын 74.6 хувийг 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрт хамруулсан байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 246 хоригдлын 168 хоригдлыг ажлын байраар хангасан.

-ШШГЕГ-ын даргын А/222 дугаар “Заавар шинэчлэн батлах тухай” тушаалаар<sup>116</sup> батлагдсан “Нийгмийн ажлын заавар”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу шинээр хүлээн авсан хоригдлыг 14 хоногийн хугацаанд сургалтад хамруулан, орчин нөхцөлдөө дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэн сургалт, нөлөөллийн ажилд хамруулсан;

Эрүүл мэнд, өндөр настай, жирэмсэн зэрэг шалтгаанаар хөдөлмөрт хамрагдах боломжгүй хоригдлуудад дараах байдлаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал:

- ШШГЕГ-ын харьяа 413, 427, 435, 445, 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2023 оны 7 дугаар сараас эхлэн хөдөлмөрийн заалтгүй хоригдлыг удаан хугацаагаар суулгах асуудлыг байхгүй болгож, сургалт, нийгэмшүүлэх ажилд хамруулах, бусад цагаар шатар, даам, шагай харваа, ширээний теннис тоглох зэрэг нөхцөл боломжоор хангасан;

-Түүнчлэн хоригдлыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн чилээг гаргах, эрүүл мэндийг дэмжих зорилгоор 12:00, 16:00 цагуудад өдөрт 2 удаа 15 минутын хугацаатай 8 тоот дасгалыг алба хаагчийн хяналтад хийж хэвшүүлсэн.

- ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь зөвлөмжийн хүрээнд хоригдолд мөрдүүлэх цагийн хуваарьт өөрчлөлт оруулж өдрийн цагаар

<sup>116</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/222 дугаар “Заавар шинэчлэн батлах тухай” тушаал

нээлттэй дэглэмийн хоригдлыг 2 цаг, хаалттай дэглэмийн хоригдлыг 1 цаг 30 минутын хугацаанд хорих өрөөнд нь амруулж байхаар цагийн хуваарийг баталж мөрдүүлэн ажиллахын зэрэгцээ 13:00-15:00 цагт хоригдлуудын дунд “Кино өдөрлөг”-ийг зохион байгуулж ажиллаж байна.


-Дархан-Уул аймаг дахь ШШГГ 445 дугаар нээлттэй хорих анги нь “Шинэ амьдралын эхлэл” төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу хоригдол нарт төлөвлөгөөний дагуу 7 хоногт 1 удаа амьдрах ухааны сургалтыг зохион явуулсан.

- ШШГГГ-ын харьяа 435 дугаар хаалттай хорих анги нь 09:10-12:00, 14:10-17:40 цагийн хооронд танин мэдэхүйн нэвтрүүлэг үзүүлэх, хорих ангиас зохиож буй сургалт, дугуйланд хамрагдах, 19:10-21:50 цагт зурагт үзэх, ном унших, уламжлалт тоглоом тоглуулах зэргээр нэг байрлалд удаан суулгаж, залхаахгүйгээр сургалт, нөлөөллийн ажилд хамруулж байна.

*Мөн хоригдлуудын дунд “Зоонд суулгах, Улаан шугамд суулгах” гэх буруу ойлголтыг арилгах, холбогдох журмыг нэг мөр таниулах зорилгоор алба хаагчдад “Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, аюулгүйн тойрог тогтоох журам”-аар хууль, эрх зүйн сургалтыг дахин орж, мэдээлэл өгсөн.*

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь батлагдсан дотоод цагийн хуваарийн дагуу хоригдлуудад сургалтуудыг зохион байгуулахаас гадна эрүүл мэндийн шалтгаанаар ажил хөдөлмөрт хамрагдаагүй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг өдрийн турш тогтсон ажилгүй байдаг хоригдлуудад зориулж хоригдлын амьдралын бүсэд “Сонсдог ном, цахим сан”-г бий болгож өгсөн.

Дээрх булангаар хоригдлууд чөлөөт цагаараа үйлчлүүлж, ялын тооцоо, гэм хорын төлбөр төлөлт, гаргасан өргөдөл гомдол, нэрийн дансны мэдээлэл зэрэг өөрт хэрэгцээт мэдээллүүдийг авч, харилцаа хандлага, уур бухимдал, хувь хүний хөгжлийн зайны сургалтуудыг судалж, сургамжит өгүүллэг, тууж, роман сонсож, спорт, танин мэдэхүйн нэвтрүүлэг үзэж өөрийгөө хөгжүүлж байна.



ШШГГГ-ын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага хүмүүжигчдийг ар гэртэйгээ цахимаар уулзах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Цахим уулзалт”-ын өрөөг шинээр тохижуулж, ашиглалтад оруулжээ. Тус өрөөг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Цахим уулзалт зохион байгуулах журам”,117 цахим уулзалтын өрөөнд тавигдах ерөнхий шаардлагын дагуу шинээр засварлан үйл ажиллагааг эхлүүллээ. Ингэснээр алслагдсан газар, сум, орон нутагт амьдардаг, түр хугацааны уулзалтаар ирэх боломжгүй хүмүүжигчдийн гэр бүлийн гишүүдийг цахимаар уулзуулах нөхцөлийг бүрдүүллээ.

117 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 24-ний А/165 дугаар тушаал

ШШГЕГ-ын харьяа 423 дугаар нээлтэй, хаалттай хорих анги нь бясалгалд хамрагдаагүй гэх үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулсан хоригдол байхгүй бөгөөд зөвлөмжид дурдагдсан өдрийн хоолны дараа 13 цагт, орой унтахын өмнө 21 цагт тус тус сайн дурын үндсэн дээр бясалгалд хамрагддаг байсныг ангийн даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр дотоод цагийн хуваарьт өөрчлөлт оруулж өдөрт 1 удаа буюу 09.30-11.50 цагийн хооронд хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагтай уялдуулан боломжит байдлаар хамрагдахаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

Хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдол бүрийг ажлын байраар хангах цогц арга хэмжээ авах зөвлөмжийн хүрээнд:

ШШГ байгууллагын хэмжээнд хорих анги, байгууллагуудад 4,559 хоригдол ял эдэлж байгаагаас 3,370 хоригдол буюу 74.6 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас 36.4 хувь нь цалинтай ажлын байраар хангагдсан. Хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдлыг ажлын байраар хангах хувь хэмжээг 2025 онд өсгөх зорилгоор хорих ангийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхээр тодорхой ажлуудыг төлөвлөж байна. Тухайлбал, “Хэрэмт цамхаг” УТҮГ, “ШТН” ТӨААТҮГ-уудын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 2025 онд шинэчлэхээр 527.4 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусган шийдвэрлүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу бүх хорих ангийн хүрээнд “Бүх хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй иргэдийн бие бялдрын ерөнхий үзүүлэлт, өсөлт хөгжлийг тодорхойлох антропометрийн судалгаа”-г гүйцэтгэж, судалгааны дүнд үндэслэгдсэн хорих ял эдэлж буй хүн бүрийг тэгш хамруулах олон талт арга хэмжээ, хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиглэлийг хүргүүлж ажилласан байна.

Тус ажлын хүрээнд нийт хорих анги, байгууллагын 4948 хоригдол, хоригдогсдын дунд биеийн жингийн индексийг тодорхойлсон.

Биеийн жингийн индексийн үзүүлэлтээр хэвийн, илүүдэл жин, таргалалтын зэрэг, жингийн алдагдлын судалгааг гаргахад дараах үзүүлэлттэй байна. Үүнд:



Нийт хоригдогсдын 70 хувь нь хэвийн жинтэй, 18,7 хувь нь илүүдэл жинтэй, 8,4 хувь нь I зэргийн таргалалттай, 1,7 хувь нь II зэргийн таргалалттай, 0,16 хувь нь III зэргийн таргалалттай, 2,6 хувь нь жингийн алдагдалтай байна.

Биеийн жингийн индекс өөрчлөлттэй гарсан хоригдол, хоригдогсдын хооллолтод анхаарч, тохирсон дасгал, хөдөлгөөнийг тогтмол хийлгэж, сар бүр БЖИ-ийг тодорхойлж зохих арга хэмжээ авч ажиллаж байна.

*Зөвлөмжийн хүрээнд хоригдлын боловсрол, мэргэжлийн чиг баримжаа, хүмүүжил, ёс суртахуун, оюун санаа, нийгэм, соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйн төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг тодорхойлох судалгааг гаргаж ажилласан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллагад бага боловсролтой 597 хоригдол ял эдэлж байна.*

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны 41 хоригдол 407, 409, 421, 433, 437, 439 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд нь “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран нэр бүхий 112, нийт 153 хоригдлыг суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулсан байна.

*Мөн бичиг үсэггүй 243 хоригдол байгаа бөгөөд 16 хорих анги, байгууллагын нийгмийн ажилтан бичиг үсэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулан нийт 240 хоригдол хамруулснаас 142 хоригдлыг уншиж, бичиж сургасан.*

ШШГ байгууллага нь 2024 онд шүүхээр гэм буруутай нь тогтоогдож ял шийтгүүлэн “Шинээр ирсэн хоригдолд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийн дагуу хорих ангид шинээр ирсэн нийт давхардсан тоогоор 2431 хоригдолд хууль, эрх зүйн сургалтыг зохион байгуулж, тэдний сэтгэл зүйд эерэг нөлөөлөл үзүүлэхүйц сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллажээ.

*Хорих анги, байгууллагууд нь “Хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийн дагуу сургалтыг зохион байгуулан ажилласан ба сургалтад нийт давхардсан тоогоор 34338 хоригдлыг хамруулжээ.*

ШШГЕГ-ын Амгалан мэргэжлийн боловсролын сургууль нь хоригдлуудад дараах мэргэжлээр сургалт явуулан мэргэжлийн үнэмлэх олгосон байна. Үүнд:

- Барилгын бетон арматурчин 16;
- Барилгын засал чимэглэл 21;
- Тогооч 120;
- Барилгын сантехникч 102;
- Гагнуурчин 50;
- Барилгын мужаан 25
- Барилгын цахилгаанчин 65 нийт 422 хоригдолд мэргэжил олгох сургалтыг зохион байгуулсан.

Мөн 700 хоригдолд мэргэжлийн “Чадамжийн гэрчилгээ” олгосон бөгөөд аймаг, орон нутгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник, коллежтой хамтран 574 хоригдлыг мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулж, 294 хоригдлыг Мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулан ажиллаж байна.

Хорих ангид ял эдэлж байгаа сэтгэл зүйн байдал тогтворгүй хоригдлуудаас одоогийн санаа зовнил, түгшүүрийн илрэл ямар түвшинд байгааг тодруулах зорилготой (gad-7), сэтгэл гутралын түвшнийг тодорхойлох (phq-9), бие хүний шинжийг тодорхойлох (Р.Кеттел), дасан зохицох чадварыг тодорхойлох, насанд хүрэгчдийн оюун ухааны чадамжийг тодорхойлох хялбаршуулсан сорил, архины хэтрүүлсэн хэрэглээг тодруулах (audit), бие хүний чиг хандлагыг тодорхойлох зэрэг сэтгэл зүйн сорилуудаар судалгааг авахад сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай нийт 287 хоригдол байгааг судалгаанд авч тусгайлсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

*Эдгээр 287 хоригдлоос сэтгэл гутралд орох эрсдэл өндөр 39, амь бие эрхтэндээ гэмтэл учруулж болзошгүй 54, гэмт хэргийн байдлаа хүлээн зөвшөөрөөгүйн улмаас эрсдэл гаргаж болзошгүй 28, сэтгэл санаа тогтворгүй 69, сэтгэцийн эмгэг оноштой хоригдол 60, сэтгэцийн өөрчлөлттэй байж болзошгүй хоригдол 37 хоригдол хорих ял эдэлж байгаа бөгөөд тэдэнд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг тухай бүрд нь хүргэн ажиллаж байна.*

Хорих ял эдлүүлэх алба нь 2024 онд 23 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Дээрх төрийн бус байгууллагуудаас 2024 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг төвлөрүүлж, дүн шинжилгээ хийн, 2025 оны хамтран ажиллах төлөвлөгөөнд судалгааны үр дүнгээс шалтгаалсан нөхцөл байдлыг тусган хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

ШШГЕГ-ын харьяа 413, 415, 439 дүгээр хаалттай хорих анги, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Сүхбаатар, Завхан, Баян-Өлгий, Дорноговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх газар, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГ хэлтэс нь зарлан мэдээлэх системийг ашиглан хоригдолд эерэг нөлөөлөл үзүүлэхүйц мэдээ, мэдээллийг байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:

- 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Эрүү шүүлтийн талаарх ойлголт, эрүү шүүлтээс ангид байх эрх, энэ чиглэлээр гаргасан өргөдөл гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллүүдийг агуулсан “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдэвт танилцуулгыг хоригдлын амьдралын бүсэд байрлах мэдээллийн самбарт байршуулсан;
- 439 дүгээр хаалттай хорих анги нь хорих ангид ял эдэлж буй хоригдлуудыг мэдээллээр хангах ажлын хүрээнд хууль журамд заагдсан хоригдлын эрх, үүргийг таниулах чиглэлээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахын зэрэгцээ хоригдлын амьдралын бүсийн мэдээллийн самбарт холбогдох хууль, журмын заалтуудыг байршуулан мэдээллээр ханган ажилласан;
- Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГГ нь Монгол Улсын ерөнхий прокурорын 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/71 “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”-ыг шинэчлэн сольж санал хүсэлтийн хайрцгийн хажууд нүдэнд ил харагдахаар байршуулан мэдээллээр ханган ажилласан;
- Төв аймаг дахь ШШГГ Эрүүл мэндийн сайдын А/814 дүгээр тушаалын<sup>118</sup> гуравдугаар хавсралт “Эмнэлгийн яаралтай тусламжийн эрэмбэлэлт” “Анафилаксийн шокийн үед үзүүлэх зааварчилгаа”, “Глазго комын

<sup>118</sup> Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/814 дүгээр тушаал



үнэлгээ"-ний заавар зэргийг өнгөт самбар болгон хэвлүүлж, цагдан хорих байрны эмнэлгийн хэсэгт байршуулсан;

- Өвөрхангай аймаг дахь ШШГГ нь алба хаагч болон хоригдолд хүний эрхийн талаар мэдээ, мэдээлэл олгох зорилгоор Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх талаарх сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг шалган нэвтрүүлэх байр, хоригдлын байр, хорих өрөөнүүд, түр болон удаан хугацааны эргэлт, уулзалтын байр мэдүүлэг авах хэсгийн орчинд байршуулсан;
- Увс аймаг дахь ШШГГ нь хорих өрөөний гадна хэсэгт хоригдогчийн цээж зураг бүхий хувийн мэдээлэлтэй танилцуулга байсныг өөрчлөн, зөвхөн тухайн хорих өрөөнд байх хоригдогчийн тоог илэрхийлсэн хуудастай болгон өөрчилсөн бөгөөд бусад хорих анги, газар хэлтсүүд мөн адил өөрчлөн шинэчилж байна.
- Сүхбаатар аймаг дахь ШШГГ нь Хууль зүй дотоод хэргийн сайдын А/111 дугаар тушаалаар<sup>119</sup> батлагдсан "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, албадан эмчлүүлэх, хоригдлыг хоногийн хоол хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм"-д заасны дагуу хоригдол, хоригдогчийн хоол хүнсэнд мах, махан бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэж байгаа бөгөөд улирал тутам мэргэжлийн байгууллагаар хоолны илчлэгийг тодорхойлуулж, хоригдол, хоригдогчид олгох хоолны цэсийг 7 хоног бүр шинэчлэн баталж мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн;
- Завхан аймаг дахь ШШГГ нь Хүний эрхийн ойлголт, мэдлэг, мэдээлэл олгох "Эрүү шүүлт" мэдээллийн самбарыг харьяа Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь референтээр хянуулан боловсруулж хоригдогч, хоригдлуудад үйлчилгээ авч буй уулзалтын хэсэгт байршуулсан;

*ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 08/09 дугаартай зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний дагуу 407, 417, 419, 423, 425, 427, 429, 437, 445 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Баянхонгор, Дорнод, Архангай, Ховд аймаг дахь ШШГГ, Багануур дүүрэг дахь ШШГХ нь хоригдолд эерэг нөлөөлөл үзүүлэхүйц мэдээ, мэдээлэл, урьдчилан бэлтгэсэн нэвтрүүлэг, сургалтыг зохион байгуулан ажилласан байна.*

ШШГГ-ын харьяа 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын үзэл баримтлал, суурь зарчим, тэдгээрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах хүрээнд "Алба хаагчдын мэдлэг дээшлүүлэх", "Сахилга ёс зүйг эрхэмлэгч-Эвсэг хамт олон" аяныг тус тус зохион байгуулж зурагт шторкийг хийж тус ангийн цахим хаягт байршуулан ажилласан байна.

Мөн нийт хоригдлуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Хүний эрхийн тухай ойлголт" сэдвээр 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр батлагдан гарсан "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" сэдвээр видео хичээлийг зохион байгуулсан байна.

Хорих анги, байгууллага нь "Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх" гэмт хэргээр ял шийтгүүлсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг

119 Хууль зүй дотоод хэргийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/111 дугаар тушаал

ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр “Мансууруулах бодисын хор нөлөө”, “Сэтгэл зүйн эрүүл мэнд”, “Хорт зуршлаас татгалзъя”, “Хар тамхи” зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж, сургалтад нийт 1921 хоригдол хамрагдсан байна. Сургалтад хамрагдсанаар гэмт үйлдэлдээ гэмшиж хорт зуршлаас ангижрах, дахин гэмт хэрэгт холбогдохгүйгээр ухамсартайгаар амьдрах, өөртөө зөв хандлагыг төлөвшүүлэх чадварт суралцжээ.

*Мөн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж “Олон улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн боловсрол олгох сургалт”, “Гэр бүл түүний нийгмийн үүрэг”, “Гэр бүлийн гишүүдийн эрх үүрэг” зэрэг сэдвээр нийт давхардсан тоогоор 2551 хоригдол сургалтад хамрагджээ*

Согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай, гэмт хэрэгт холбогдохоос өмнө архины хамааралтай байсан хоригдлуудад “Согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзах”, “Согтууруулах ундааны харшил”, Согтууруулах ундааны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө”, “Алкоголны талаарх 10 баримт”, “Архины харшил гэж юу вэ”, “Согтууруулах ундаа таны биед тохирохгүйг илтгэх шинж”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Архи согтууруулах ундааны хор уршиг”, “Архины хэрэглээ ба осол гэмтэл” зэрэг сэдвээр сургалтууд зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 9512 хоригдлыг хамруулсан байна.

*“Зөрчлийн хууль”-аар шүүхээс 7-30 хоног баривчлах ялаар шийтгэгдсэн нийт 1,0170 эмэгтэй 397, эрэгтэй 9,747, өсвөр насны хоригдол 21, гадаад 5 иргэнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтуудыг зохион байгуулан ажиллажээ.*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан А/167, А/233 дугаар тушаалаар<sup>120</sup> баталсан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулж ажилласан ба сургалтад нийт давхардсан тоогоор 4268 хоригдлыг тус тус хамруулан, хорих ангиас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, гэр бүлтэйгээ эргэн нэгдэх болон ажлын байранд зуучлан ажилласан байна.

Долоо. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208.3, хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 11, 12 дахь заалтуудын хэрэгжилтийн байдалд дотоод хяналт шалгалт явуулж, илэрсэн нөхцөл байдлыг засаж залруулах, цаашид давтагдахгүй байх арга хэмжээ авах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Харьяа хорих ангиудын багтаамж дүүрч, 9 хорих ангид 314 буюу 6.8 хувиар багтаамж хэтэрсэн нөхцөл байдалтай байгаа бөгөөд “Шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих болон хорих ангийн зэрэглэлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл”-ийн хуралдаанаар хорих ангийн хоригдлын багтаамжийг харгалзан хоригдлын хуваарилалтыг хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Тус зөвлөлөөр өнөөдрийн байдлаар 42 удаагийн хурлаар нээлттэй хорих ангид 2169, хаалттай хорих ангид 125, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 4, эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид 233, сургалт-хүмүүжлийн

<sup>120</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар тушаал

тусгай байгууллагад 64, нийт 2595 хоригдлын ял эдлэх хорих анги, хорих ангийн зэрэглэлийг тогтоож, хуваарилсан хорих ангид хуяглан хүргэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208.3-т<sup>121</sup> заасны дагуу хоригдлуудын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангид шинээр хүлээн авсан хоригдлыг 14 хүртэл хоног тусгаарлан байрлуулж, ангийн дотоод журамтай танилцуулан зохих сургалтад хамруулж, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч түүнтэй биечлэн уулзалт хийж, зан байдлыг тодорхойлсны үндсэн дээр хорих өрөөнд хуваарилан ажиллаж байна.

Найм. Нээлттэй хорих ангийн түр уулзалтын хэсгийн шилэн хаалт бүхий тоноглолыг хүний эрхэд ээлтэй байдлаар өөрчлөх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

“Хорих ангийн дотоод журам”-ын 16.2-т заасны дагуу “түр уулзалтын байранд шаланд бэхлэгдсэн ширээ, сандал байрлуулах ба аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгаарлан тоноглож болно” гэх заалтыг ангийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч хоригдлыг гэр бүлийнхэнтэйгээ харьцах чин сэтгэлийн харьцааг нэмэгдүүлэх зорилгоор түр уулзалтын хэсгийн хатуулаг чанартай хуванцар хаалтын доод хэсгийг авсан.

*Энэ хугацаанд давхардсан тоогоор 276 хоригдолтой ар гэрийн 414 иргэний түр хугацааны уулзалтыг харилцуургүйгээр ярилцах, гар хүрэлцэх боломжтой байдлаар зохион байгуулсан. Өнөөдрийн байдлаар хоригдол болон эргэлтээр ирж буй иргэдийн дундаас хориотой эд зүйл дамжуулах болон бусад байдлаар зөрчил илрээгүй, энэхүү үйл ажиллагаанд эерэг сэтгэгдэлтэй байсан.*

Хорих ангиудын барилга, байгууламжийн онцлогоос шалтгаалж түр хугацааны уулзалтын хэсгийн зохион байгуулалт харилцан адилгүй, харуул хамгаалалтын хяналтыг дээрх нөхцөлийг харгалзан явуулж байна.



Харилцууртай,  
хаалттай байгаа нь



Түр уулзалтын хэсгийн хаалтгүйгээр  
уулзалт зохион байгуулж буй байдал.

121 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

*Ес. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон хүмүүст эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар мэдээлэл олгох хэлбэр салбар, нэгжүүдэд харилцан адилгүй байдлаар ажиллаж байгааг нэгдсэн загвар, бүтцэд оруулж, мэдээ, мэдээллийг тогтмолжуулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд:*

Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчдыг давтан сургах, эрх зүйн сургалт авах хүсэлтийг Хүний эрхийн Үндэсний комисс, ЭШУС үндэсний ажиллагаанд тогтмол хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Хүний эрхийн 50 сургагч багшийн давтан сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулж, Улаанбаатар хотын бүсийн хорих анги, байгууллагын 11 эмчийг нэмэлтээр хамруулсан.

ШШЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн Эрүүдэн шүүхийн эсрэг хүний эрхийн сургагч багш нарт сургалтын материалыг хүргүүлэн ажилласан байна. Үүнд:



- Олон улсын гэрээ, конвенцын үзэл баримтлал, МУ-ын хууль тогтоомжид тусгагдсан агуулга, харьцуулсан судалгаа;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, зөрчил, анхаарах асуудлууд;
- Танилцуулга хийх аргачлал;
- Насанд хүрэгчдийн сургалтын онцлог;
- Оролцооны арга зүй;

Мөн алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор дээрх сургалтын материалыг цахим сургалтын платформ “Зангиа академи”-ийн дотоод сургалтын санд байршуулсан. Энэхүү сургалтыг 99 алба хаагч үзэж, судалсан байна.

*ШШЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид “Хүний эрх”-ийг хангах чиглэлээр 2024 оны III, IV улиралд танхим, цахим, дадлага семинарын хэлбэрээр дараах сэдвүүдийн хүрээнд 186 цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2,285 алба хаагч хамрагдсан байна. Үүнд:*

- “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”;
- “Эрүү шүүлтээс ангид байх эрх”;
- “Харилцааны зөрчил, түүний үр дагавар”;
- “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”;
- “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц түүний хэрэгжилт”;
- “Хүний эрхийн өнөөгийн байдал, анхаарах асуудал”;
- “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний механизм”;
- “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах”;
- “Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”;
- “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”;

ШШГ байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд сар бүр сургалтын тайлан ирүүлэх нэгдсэн загварыг боловсруулж харьяа анги, салбар нэгжид хүргүүлэн ажиллажээ.

*Арав. Хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг эрхлэхдээ хорих анги болон эрх чөлөөт амьдралын ялгааг багасгахад эрмэлзэн, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэнийг хүмүүжүүлэх, эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл саруул оюун ухаантай, эрүүл зан үйл, амьдралын хэвшилтэй иргэнийг нийгэмшүүлж, судалгаанд суурилсан олон хувилбарт хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

“Эрүүл чийрэг Монгол хүн” үзэл баримтлалын дагуу нийт хоригдол, хоригдогсдын дунд “Хөдөлгөөнт дасгал”-ыг өдөрт 15 минутаар 1-2 удаа хийлгэж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, стресс бууруулах, биеийн жинг зохицуулах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн цаашид хэвшүүлэн ажиллахаар тогтмолжуулж байна.



ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт 2024 оны жилийн эцсийн байдлаар 2585 хоригдол хэвтэн эмчлүүлсэн бол яаралтайгаар ирсэн 70 өвчтөнг цаг алдалгүй хүлээн авч, тасагт хэвтүүлэн оношилгоо, эмчилгээнд хамруулан, оношийг тодруулан, 57 дуудлагыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж ажилласан байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор дотор 1,743, мэдрэл 703, мэд засал 515, чих хамар хоолойн өвчлөл 784, оношилгоо шинжилгээнд 1,224, нийт 4,116 хоригдлыг хамруулж, хэвтүүлэн эмчлүүлэхээр шийдвэрлэсэн 340 хоригдол байна.

Тус Нэгдсэн эмнэлэг нь хоригдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/142, А/47 дугаар тушаал<sup>122</sup>, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 А/214, А/462 дугаар тушаалуудыг<sup>123</sup> тус тус үндэслэн Улсын нэгдүгээр төв эмнэлэг, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цус сэлбэлт, судлалын үндэсний төв зэрэг нийт 6 эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 13 зөвлөх эмчтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гуравдугаар шатлалын эмнэлэгт давхардсан тоогоор 408 өвчтөн нарийн мэргэшлийн эмч, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.

ШШГЕГ-ын харьяа 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь Эрүүл мэндийн яам, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагаар 2024-2026 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны гэрээ байгуулан төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Судалгаагаар 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар сүрьеэгийн нийт 39 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнээс эмд мэдрэг сүрьеэгийн 35 тохиолдол, эмд тэсвэртэй сүрьеэгийн 4 тохиолдол байна. Эмд мэдрэг сүрьеэгийн эмчилгээнд 35 тохиолдол хамрагдсанаас шинэ-28 (80%), дахилт-7 (20%) бүртгэгдсэн байна. Мөн гадна эмнэлгийн тусламж үйлчилгээнд 25 хоригдлыг хамруулсан.*

Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ/Сүрьеэгийн 2024-2026 оны төслийн хүрээнд нийт 206 алба хаагч, 7,560 баривчлагдсан этгээд, хоригдогч, хоригдлыг дижитал рентген аппаратаар цээжний гэрлийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт хийсэн.

*Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн эмнэлэг нь давхардсан тоогоор хэвтүүлэн эмчилсэн 958, урьдчилан сэргийлэх үзлэгийг 8,510, амбулаторийн үзлэг 6,065, хяналтын үзлэгт 7,244 удаа тус тус хамруулсан. Мөн лавлагаа шатлалын эмнэлгийн эмч нарт үзүүлсэн 37, оношилгоо шинжилгээнд хамруулсан 59, эмчилгээнд хамруулсан 108 хоригдогч байна.*

Орон нутаг дахь эмнэлгийн хэсэг нь “Хорих байрны дотоод журам”-ын 16 дугаар зүйлийн 16.2.2-т заасны дагуу давхардсан тоогоор 1921 хоригдогчийг эмч, сувилагч үзэж картад тэмдэглэл хөтлөн ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан А/167, А/233 дугаар тушаалаар<sup>124</sup> батлагдсан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран хоригдлыг нийгмийн

122 Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/142, А/47 дугаар тушаал

123 Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/214, А/462 дугаар тушаал

124 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар тушаал



амьдралд эргэн нэгтгэх зорилгоор шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд “Суллахад бэлтгэх байр”-ыг хорих анги, байгууллагад шинээр байгуулахад шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулж 407, 409, 415, 437, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги, Өмнөговь, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст нийт 198,500,000 төгрөгийг шийдвэрлэсэн.

Сурч боловсрох эрхийг хангах, мэргэжил эзэмших хүсэл сонирхлыг дэмжин 407, 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиас тус бүр 1 хоригдлыг элсэлтийн ерөнхий шалгалтад хамруулсан. Хоригдлыг ял эдлүүлэх, нийгэмшүүлэх ажлыг Монгол Улсын хөгжлийн бодлого чиглэлд нийцүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл саруул оюун ухаантай, эрүүл зан үйл, амьдралын хэвшилтэй иргэнийг нийгэмшүүлэхэд чиглүүлэн ажиллаж байна.

### **9.3. ШШГЕГ-ЫН ХАРЬЯА 427 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИД ХҮРГҮҮЛСЭН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ГАРСАН ҮР ДҮН АХИЦ, ДЭВШИЛ**

*Сахилгын байрны коридорын хэсэг, соёлын танхимын тайзны ар, халуун ус, угаалгын хэсэг, спорт заал дахь өрөө, уурын зуух гэсэн байршлуудад дуу-дүрсний бичлэгийн хяналтын камер суурилуулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд:*

Тус хорих ангийн 2024 оны жилийн эцсийн байдлаар теле хяналтын системд 118 камер (IP), 20 аналог телекамер, нийт 138 телекамер, үүнээс хонгилын камер 7, өрөөний камер 113, хөдөлгөөнт камер 3, хамгаалалтын бүсийн камер 15, дүрс бичлэгийн хяналтын төхөөрөмж 14 (NVR), дүрс бичлэгийн төхөөрөмж 1 (DVR), хяналтын дэлгэц 10/3 дэлгэц гэмтэлтэй/ болон бусад дагалдах хэрэгслийг ашиглаж байна. Дүрс бичлэгийн хяналтын ажилтны хяналтад 2 жижиг дэлгэц суурилуулан хяналтыг тасралтгүй тавиулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 43 инчийн 3 ширхэг хяналтын дэлгэц шинээр суурилуулахаар ШШГЕГ-ын “Холбоо техник ашиглалт”-ын хэлтэст судалгааг гарган хүргүүлсэн.

Мөн дүрс бичлэгийн тоног төхөөрөмж, телекамерын тоог нэмэгдүүлэх тооцоо, судалгааг жил бүрийн улсын төсвийн төсөлд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох хэлтэст хүргүүлж, шаардлагатай газруудад телекамерыг суурилуулан ажилласан. Тухайлбал: Сүүлийн 3 жилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хөрөнгө оруулалт болон ангийн дотоод орлогоос Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн “Juancloud”, “МНК” брэндийн хяналтын 16 ширхэг телекамер, дагалдах хэрэгслийг худалдан авч, шинээр суурилуулснаас өнөөдрийн байдлаар 4 ширхэг камер нь эвдэрч, 2 ширхэг 43 инчийн дэлгэц нь шатсан зэрэг техникийн нөхцөл байдал үүссэн байгааг дээрх байгууллагуудад хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахаар төлөвлөсөн байна.

Теле хяналтын системийг шинэчлэн, техникийн үзүүлэлт, шаардлага хангасан 38 хяналтын камер /IP/, 2 дүрс бичлэгийн төхөөрөмж /NVR-16CH/, 4 хяналтын дэлгэц/ monitor LED 43 инч/, дагалдах тоног төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлэх, хяналтгүй бүсүүдэд телекамер шинээр суурилуулан харуул хамгаалалтын

болон хоригдлын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардагдах телекамерын тооцоо, судалгааг гарган 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн Багануур дүүргийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналаа хүргүүлсэн ба шийдвэр нь одоогийн байдлаар ирээгүй байна. Цаашид байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 14 дэх заалтад телекамерыг 22-оор нэмэгдүүлэн ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Хорих ангийн сахилгын байрны коридорын хэсэг, соёлын танхимын тайзны ар, халуун ус, угаалгын хэсэг, спорт заал дахь өрөө, уурын зуухны гэсэн байршлуудад дуу-дүрсний бичлэгийн хяналтгүй байгаа бөгөөд тухайн байршлуудад суурилуулах телекамерын төсөв, санхүү байхгүй ч байгууллагын дотоод орлого, нөөц бололцоог ашиглан “SKYWORLD” IP 4 камерыг сахилгын байрны коридорын хэсэг, соёлын танхимын тайзны ар, халуун ус, угаалгын хэсэг, спорт заал дахь өрөөнд тус тус байршуулан, хоригдлын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.



(Зөвлөмжийн өмнө)

(Зөвлөмжийн дараа)

Хорих ангид ял эдэлж буй иргэдийн зүгээс ангийн удирдлага, алба хаагч, төрийн бусад байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх, шилжүүлэх ажлыг хуулийн дагуу хэрэгжүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

2024 оны жилийн эцсийн байдлаар ял эдэлж буй хоригдлын зүгээс ангийн даргатай уулзах хүсэлт гаргасан 52, ангийн Арга зүйн зөвлөлийн хуралд оролцох 126, төрийн болон төрийн бус байгууллага, бусад иргэн, байгууллагад хандан гаргасан 139, нийт 317 хүсэлт, өргөдөл, гомдлыг тус тус хүлээн авч, хуулийн хугацаанд тухай бүр шийдвэрлэж, холбогдох албан тушаалтнуудад уламжлан ажилласан байна.

Хүснэгт 17

**427 ДУГААР НЭЭЛТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ**  
2020-2024 ОНД ХОРИГДЛООС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

д/д	Хаана хэнд	Агуулга	Он												Тайлбар			
			2020			2021			2022			2023				2024		
			Нийт	Шийдвэрлэсэн	Буцаасан, хойшлуулсан	Нийт	Шийдвэрлэсэн	Буцаасан, хойшлуулсан	Нийт	Шийдвэрлэсэн	Буцаасан, хойшлуулсан	Нийт	Шийдвэрлэсэн	Буцаасан, хойшлуулсан		Нийт	Шийдвэрлэсэн	Буцаасан, хойшлуулсан
1	Ангийн захиргаанд	Биечлэн уулзах	18	18	-	26	26	-	38	38	-	47	47	-	52	52	-	
		Ангийн арга зүйн хуралд орох	192	119	73	151	85	66	135	81	54	153	77	76	199	126	73	
		Бусад албан тушаалтантай холбоотой	1	1	-	-	-	-	-	-	-	3	3	-	-	-	-	
2	Бусад төрийн болон төрийн бус байгууллагад	Бусад асуудлаар	74	74	-	192	192	-	529	529	-	124	124	-	140	139	1	Өөрийн хүсэлтээр буцаасан 1 хүсэлт
<b>Нийт</b>			<b>285</b>	<b>212</b>	<b>73</b>	<b>369</b>	<b>303</b>	<b>66</b>	<b>702</b>	<b>648</b>	<b>54</b>	<b>327</b>	<b>251</b>	<b>76</b>	<b>391</b>	<b>317</b>	<b>74</b>	


Тус хорих ангид 2020-2024 оны байдлаар хоригдлын зүгээс нийт 2074 хүсэлт ирснээс 1731 хүсэлтийг шийдвэрлэж, 343 хүсэлтийг өөрийн хүсэлтээр болон ангийн арга зүйн хуралдаанаар хэлэлцэн хүсэлтийг буцаасан болон хойшлуулсан.

Хоригдлын дундаас гаргасан өргөдөл, гомдлын сүүлийн 5 жилийн судалгаа



Хүснэгт 1. 2020-2024 оны хугацаанд хоригдлын дундаас гаргасан өргөдөл гомдлын тоо, тэдгээрийг шийдвэрлэсэн, буцаасан талаарх судалгааг дүгнэн

ажиллахад 2024 онд гаргасан өргөдөл гомдлын тоо нь өмнөх оныхоос 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо өмнөх оныхоос 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 2. Хорих ангид болон бусад төрийн байгууллагад гаргасан өргөдөл гомдлын тоон харьцааг дүгнэхэд 2024 онд бусад байгууллагад гаргасан өргөдөл гомдол өмнөх оныхоос нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа ба ангийн захиргаанд гаргасан өргөдөл гомдол буурсан үзүүлэлттэй байна.



Хүснэгт 3. Ангийн захиргаанд гаргасан өргөдөл, гомдлыг ангилсан байдлаар авч үзэхэд ангийн арга зүйн хуралд орохоор өгсөн өргөдөл гомдол дийлэнх хувийг эзэлж байгаа ба ангийн удирдлагатай биечлэн уулзах хүсэлт өргөдөл өссөн үзүүлэлттэй байна.

2025 оны 1 дүгээр сарын 16-ны байдлаар нийт 7 хоригдлын өргөдөл, гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар<sup>125</sup> батлагдсан “Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлын тойрог тогтоох шугам”-ыг хэрэглэхдээ хоригдлын бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох шинжтэй “улаан шугамд суулгах” явдлыг халах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдол бүрийг ажлын байраар хангах цогц арга хэмжээ авах:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/183 дугаар тушаалаар<sup>126</sup> баталсан “Хорих ангийн дотоод журам”-ын 13 дугаар зүйлийн 13.6 “Хорих өрөөний хаалгыг цоожтой байлгах ба амрах үед хоригдлыг хорих өрөөнд нэвтрүүлнэ” гэж заасны дагуу хорих ангийн дотоод цагийн хуваарьт 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр өөрчлөлт оруулж, сургалт, нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэх, шатар, даам тоглох, даалин оёх, зурагт үзэхээс бусад хугацааг хоригдлын чөлөөт цагт тооцон хорих өрөөнд байршиж болохоор тусгаж ангийн даргаар батлуулж, мөрдүүлэн ажиллаж байна.

№	Хоригдлын нэр	Ажлын байр	Хяналт
1	Дорнод	Ажил үйлдвэр	Х.Сүхбаатар
2	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
3	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо
4	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
5	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
6	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо
7	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
8	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
9	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо

№	Хоригдлын нэр	Ажлын байр	Хяналт
10	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
11	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
12	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо
13	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
14	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
15	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо
16	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
17	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
18	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо
19	Дорнод	Хөдөлмөр эрхлэх	Х.Сүхбаатар
20	Хангайн	Хөдөлмөр эрхлэх	М.Оюун
21	Завхан	Хөдөлмөр эрхлэх	С.Дорноо

Нийт хоригдлуудын дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулахад “Хорих өрөөнд байршдаг болсон нь сэтгэл санааны байдал тогтвортой болж байна” гэсэн саналыг нийт хоригдлууд илэрхийлсэн.

Хорих ял эдэлж буй иргэдийн боловсрол, мэргэжлийн сургалт, хүмүүжил, ёс суртахуун, оюун санаа, нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, спортын шинж чанартай, зохих бөгөөд боломжтой бусад төрлийн нийгэмшүүлэх ажил, сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөтөлбөрт үйл ажиллагааг оновчтой төлөвлөн боловсруулж, тогтмол явуулах чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Тус ангийн нийгэм сэтгэл зүйн нэгж болон гүйцэтгэх ажилтнууд хоригдол нэг бүртэй уулзаж, тэдгээрийг ажлын байраар хангах асуудлыг “Ангийн арга зүйн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэн ажиллаж байна. Тус анги нь 2024 оны оны байдлаар 324 хоригдлыг ажлын байраар хангасан ба 2025 оны 01 дүгээр сард 385 хоригдлоос 231 хоригдлыг ажлын байраар ханган ажилласан байна.

125 Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/192, А/81 дүгээр хамтарсан тушаал  
 126 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаал



Ангилал дараах 2024 онд хоригдлыг хяналтаар хянагдлага болон өндөрлөхөд хяналтын өөрчлөлт тухай нэгдсэн тухайн судалгаа

ЭЗӨ	Тухайнхны дүнгийн	Тухайнхны өсөлтийн	Хяналтын өөрчлөлт	Хяналтын өөрчлөлт
1	8063	2024.01.08	20	4
2	8012	2024.02.01	20	0
3	8019	2024.02.01	14	4
4	8071	2024.02.04	44	12
5	8027	2024.02.01	22	18
6	8022	2024.02.02	40	7
7	8026	2024.02.02	22	0
8	8030	2024.02.02	0	2
9	8040	2024.02.02	14	18
10	8044	2024.02.02	200	-
11	8051	2024.11.09	288	-
12	8057	2024.12.09	231	-

Ангилал дараах 2024 онд хоригдлыг хяналтаар хянагдлага болон өндөрлөхөд хяналтын өөрчлөлт тухай нэгдсэн тухайн судалгаа

Алд	Тухайнхны дүнгийн	Тухайнхны өсөлтийн
1	Зарим хэргийн үргэлжлэл	12
2	Хүндэтгэсэн хэргийн үргэлжлэл	12
3	Хүндэтгэсэн хэргийн үргэлжлэл	34
4	Хүндэтгэсэн хэргийн үргэлжлэл	28


2024 онд хоригдлын хөдөлмөрт хуваарилсан болон хөдөлмөрийн хуваарь өөрчилсөн талаарх тоон судалгаа

Хорих ял эдэлж буй хоригдлыг цалинтай ажлын байраар хангах, ажлын дадлага, туршлага олгох, мэргэжил эзэмшүүлэх, цагийг үр ашигтай өнгөрүүлэх, нийгэмшүүлэх, бусдад учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулах зорилгоор тус хорих анги нь иргэн, аж ахуйн байгууллагатай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулан ажилласан.

Хорих анги нь 2024 онд нийт 162 хоригдолд 370,160,297 төгрөгийн цалин бодож, ХХОАТ-т 37,016,029.7 төгрөгийг тушааж, гэм хорын төлбөрт 41 хоригдлын 57,350,940 төгрөг суутган шилжүүлж гарт 275,793,327 төгрөгийг олгосон нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 3 дахин нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.

Цаашид хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, цалинтай ажлын байраар хангах үйл ажиллагааг нэмэгдүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт 18



Тус анги нь 2024 онд Багануур дүүргийн албан бус Насан туршийн боловсролын төвийн англи хэлний сургалтад нээлттэй дэглэмийн 18 хоригдол, "Хөгжим, гоо зүй"-н сургалтад нээлттэй дэглэмийн 15 хоригдол, "Бичиг үсэг"-ийн боловсрол олгох сургалтад хаалттай дэглэмийн 18 хоригдол, "Гэр бүлийн боловсрол" олгох сургалтад нээлттэй дэглэмийн 22 хоригдол тус тус хамрагдаж нийт 72 хоригдол сургалтад хамруулсан.



Өнөөдрийн байдлаар Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн “Амьдрах ухаан, гар урлал” сургалтад хаалттай дэглэмийн нэр бүхий 13 хоригдол, “Монгол хэл-бичиг” сургалтад 23 хоригдол, нийт 36 хоригдол хамрагдаж байна.

Мөн тус төвөөс зохион байгуулж буй “Харилцаа ба Хандлага” сэдэвт сургалтад 26 хоригдлын нэрсийг ангийн даргаар батлуулан, хамруулан ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу англи хэлний дугуйланд суралцаж байгаа нэр бүхий 16 хоригдолд Насан туршийн суралцахуйн төв багш Ж.Отгонцэцэг сургалт зохион байгуулж түвшин тогтоох шалгалт авч үнэлгээ өгч ажилласан.

“Амгалан” мэргэжлийн боловсролын сургуулийн багш, хошууч Д.Оюунбилэг, ахмад Д.Алтантуяа нар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс барилгын засал чимэглэлчин, тогоочийн мэргэжил олгох сургалт зохион байгуулж ажилласан.

Мөн “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлээр нээлттэй дэглэмийн 22 хоригдол, хаалттай дэглэмийн 21 хоригдол тус сургалтад идэвх санаачилгатай хамрагдсан.

Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн “Иргэний боловсрол” олгох сургалтад хаалттай дэглэмийн нэр бүхий 23 хоригдол хамрагдаж амжилттай төгссөн. Сургалтын төгсгөлд асуулт, хариулт танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, хоригдол Ж.Даваахүү, М.Дэлгэрцогт нар амжилттай оролцож шагналт байранд шалгарсан.

Тус ангийн нийгэм, сэтгэл зүйн нэгж нь 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 6-ны өдөр хүртэлх хугацаанд ШШГЕГ-ын харьяа “Амгалан” мэргэжлийн боловсролын сургуультай хамтран “Гагнуурчин” мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

Мөн 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс “Авто машин засвар” “Сантехникч” мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

Хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоолгох болон хугацаа дуусаж суллагдах хоригдлуудтай ганцаарчлан уулзаж цаг үеийн шинжтэй мэдээллийг хүргэн заавар, зөвлөгөөг өгч, ар гэрийнхэнтэй утсаар холбогдон суллагдан гарахад хүлээн авах орчин нөхцөлийг тодорхойлсон.

Хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоолгох болон хугацаа дуусаж суллагдах нэр бүхий 45 хоригдолд “Суллагдахын өмнөх сургалтын жишиг хөтөлбөр”-ийн дагуу “Нийгмийн халамжийн тухай хууль”, “Гэр бүлийн тухай хууль”-аар тус тус хууль, эрх зүйн сургалт зохион байгуулж ажилласан.

Суллагдах дөхсөн хоригдлуудад 7 хоног бүр Суллагдахын өмнөх хууль, эрх зүйн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Сургалтын хүрээнд боловсруулсан сургалтын материалыг сургалтын байранд байршуулан бие даан сурах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.



Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын хэлтсийн мэргэжилтэн Л.Хулан, О.Хонгорзул нартай хамтран 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Хоригдлын суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Гэр бүлийн тухай ойлголт” сэдвийн хүрээнд 60 минутын сургалтыг нэр бүхий 28 хоригдолд зохион байгуулж ажиллаа.

Тус сургалтад нэр бүхий 28 хоригдол идэвх, санаачилгатай хамрагдан, гэрлэлт, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийн талаарх ойлголтыг олж авсан.

Багануур дүүргийн Хөдөлмөр нийгмийн хамгааллын хэлтсийн дарга Ж.Баярхүү, мэргэжилтэн Г.Тунгалаг нартай хамтран “Хоригдлын суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Хоригдлын ур чадвар хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн ур чадвар олгох хөдөлмөрт бэлтгэх”, “Нөхөрлөл”, “Суллагдсан хоригдолд олгох мөнгөн тэтгэмж” гэх мэт сэдвээр 90 минутын сургалтыг нэр бүхий 22 хоригдолд зохион байгуулж ажиллаа.

Тус сургалтад нэр бүхий 22 хоригдол идэвх, санаачилгатай хамрагдан, суллагдан гарсан тохиолдолд хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэстэй хамтран хөдөлмөрт хамрагдаж болдог, нөхөрлөлийн үнэ цэнэ, суллагдсаны дараах мөнгөн тэтгэмжийн талаарх ойлголтыг олж авсан.

“Суллагдахын өмнөх хууль эрх зүйн” сургалт болох “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Нийгмийн халамжийн тухай хууль” сэдэвт 2 багц цагийн сургалтыг нээлттэй дэглэмийн нэр бүхий 25 хоригдолд зохион байгуулж ажиллаа. Сургалтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн төрөл, өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн талаар тодорхой мэдлэг мэдээлэл өгч ажилласан байна.

Сургалтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн төрөл, өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн талаар мөн хөдөлмөрийн харилцааны зарчим, суурь хэм хэмжээ, уг харилцаанд оролцогч талуудын үндсэн эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын харилцааны талаар тодорхой мэдлэг мэдээлэл өгч ажилласан.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах Номгон өртөө “МОНГОЛИАН ТРАНС ЛАЙН” төмөр замын гэрээт хэсэгт ажиллаж буй нээлттэй дэглэмийн 20 хоригдолтой “Zoom” хаягаар цахим уулзалт, сургалт зохион байгуулж амьдарч буй орчин нөхцөл, ар гэрийн харилцаа холбоо зэрэгтэй танилцаж санал хүсэлтийг сонсож ажилласан.

Мөн тус хоригдлуудад “Нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль” зэрэг сэдэвт сургалт зохион байгуулж ажиллаа. Тус сургалтад хоригдол Б.Буянбаатар, А.Мөрөн, Б.Бат-Эрдэнэ, Б.Өнөрбат, Б.Цолмон, З.Норовринчин, Б.Хүрэлчулуун, Д.Дашдорж, Л.Дэмбэрэлнямбуу, Ц.Өсөхбаяр, О.Эрдэнэболд, Б.Батжаргал, Г.Лхагва-Эрдэнэ, С.Шинэбаяр, Б.Оюунбат, Т.Ерболат, Ш.Эрдэнэбаяр, Ц.Энхбаатар, Ч.Бат-Эрдэнэ

нар оролцлоо. Тус сургалтаар нээлттэй ярилцлага зохион байгуулж санал бодлоо илэрхийлэн сургалт нийгэмшүүлэх ажилд хоригдлуудын зүгээс идэвх санаачилгатай хамрагдсан.

Нийт хоригдлуудын уур амьсгалыг сайжруулах, сургалт нийгэмшүүлэх ажилд идэвхжүүлэх зорилгоор нээлттэй дэглэмийн хоёрдугаар хэсгийн хоригдлууд дунд нийгэмшүүлэх ажлын үйлчилгээ үзүүлэх гэрээний ач тус, хүрэх үр дүн, хэрэгжилтийн талаар яриа хийж, соёлын арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Мөн ангийн санхүүгийн нэгжээс холбогдох алба хаагчдыг байлцуулж нийт хоригдлуудад нэрийн дансны үлдэгдэл, цалин хөлс, банкны картын талаарх мэдээ мэдээллийг өгч санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа.

“Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд “Баярлалаа-Уучлаарай” сэдэвт захидлын хайрцаг байрлуулан алба хаагч, хоригдлуудын дунд уур амьсгалыг нэмэгдүүлэх, эерэг харилцаа, хандлагыг бүрдүүлсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

*Алба хаагчид хоригдлуудын дунд “Баярлалаа, уучлаарай” санал хүсэлтийн хайрцаг байрлуулсан.*

Аяны хүрээнд сар бүр тэмцээн уралдаан зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд нээлттэй, хаалттай дэглэмийн хоригдлуудын дунд сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан.

“Хүндлэлээс хүндлэл, Харилцаанаас харилцаа” аяны хүрээнд нээлттэй болон хаалттай дэглэмийн хоригдлуудын дунд “Чанга шивнээ”, “Тата Тунгаа”, “Хөгжөөнт”, “Аха” танин мэдэхүйн гэсэн 4 төрлийн тэмцээнийг зохион байгуулж ажиллаа. Мөн тэмцээний нээлтийн үеэр нээлттэй дэглэмийн хоригдол Ж.Эрдэнэбаяр нийт хоригдлуудад ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн. Нийт 6 баг буюу 36 хоригдол, ганцаарчилсан тэмцээнд 50 хоригдол, нийт 86 хоригдол өрсөлдөж шалгарсан хоригдлыг өргөмжлөл, ангийн дэлгүүрээр үйлчлүүлэх 20.000, 15.000, 10.000 төгрөггүй эрхээр тус тус шагнаж урамшуулан ажиллажээ.

*Шулуун гэдэсний эдийн үрэвслийн архаг өвчлөлтэй хоригдлуудад шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Ангийн зүгээс 2024 оны байдлаар 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн мэргэшлийн эмнэлэгт 7 хоригдлыг шулуун гэдэсний цус алдалт, шамбарам оноштойгоор Мэс заслын тасагт хэвтүүлэн эмчлүүлж, үргэлжлүүлэн эмчлэх эмчийн заавар зөвлөгөө авч ажилласан.

Мөн 2024 онд Эмнэлэгт эмчийн заавраар хоригдол Р.А, Ц.А нар шамбарам оноштойгоор 8 хоног эмчилгээ, үйлчилгээ хийхэд хүндрэл гаргаагүй ба биеийн байдал хэвийн, зовуурь намдсан тул эмчийн заавраар эмнэлгээс гаргасан. Одоогоор эдгээр хоригдлуудын биеийн байдал хэвийн байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэсэг нь 2024 онд 500,000 төгрөгийн эмийн төсөвтэй байсан 2025 онд сарын эмийн төсөв 2,200,000 төгрөг болсон. 2024 онд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт дараах нэр бүхий хоригдлууд хэвтэн эмчилгээ хийлгэсэн. Үүнд:

- 1.Д. Б-Шамбарам оноштой 2 удаа;
- 2.Р. А-3 удаа шулуун гэдэсний цус алдалт оноштой;
- 3.Ц. А- нь шулуун гэдэсний цус алдалт оноштой;
- 4.П. Б- нь шамбарам оноштой;
- 5.А. Б- нь архаг шамбарам оноштой 5 удаа;
- 6.Д.Б- нь шулуун гэдсээр цус гарна зовуурьтай оноштой;
- 7.Н.М- нь шамбарам оноштой 8 хоног тус тус хэвтэн эмчлүүлсэн байна;

*Хорих ангийн алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих олон улсын гэрээ, конвенцын суурь зарчмууд, эрхээ хязгаарлуулсан хүнтэй хэрхэн харьцах олон улсын дүрмүүдийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Хорих ангийн алба хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих олон улсын гэрээ, конвенцын суурь зарчмууд, эрхээ хязгаарлуулсан хүнтэй хэрхэн харьцах олон улсын дүрмүүдийн талаар 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр “ДСМ” консалтингийн гүйцэтгэх захирал, хүний эрхийн судлаач багш, Ч.Дүгэрсүрэн “Эрүүдэн шүүлтээс ангид байх эрх” “Хоригдлын эрх” сэдвээр нийт алба хаагчдад сургалт явуулсан.

Хүний эрхийг хангах чиглэлээр 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх” сэдвээр тус тус нэр бүхий 32 алба хаагчид 90 минутын сургалтыг зохион байгуулсан.

“Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сэдвээр 2024 оны Зөвлөмжийн хүрээнд 11 дүгээр сарын 5-ны өдөр 30 алба хаагчид 90 минутын сургалтыг зохион байгуулсан. Сургалтын агуулга:

Хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар олон улсын гэрээ, конвенц, баримт бичиг болон дотоодын хууль тогтоомжид хоригдол, хоригдогчийн эрхийг хэрхэн хангах тухай эрх зүйн зохицуулалт, хоригдлын эрх / мэдээлэл авах, өргөдөл, гомдол гаргах, хууль зүйн туслалцаа авах, эмнэлгийн тусламж авах, гадаад орчинтой харилцах, сурч боловсрох ..../ онцгой анхаарал шаардлагатай хоригдлуудтай /хүүхэд, эмэгтэйчүүд, урт хугацаагаар хорих ял шийтгэгдсэн хоригдлууд/ хэрхэн ажиллах, тэдгээрийн онцлог, шинж болон “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-д хэрхэн тусгагдсан байдал, хоригдлын жам ёсны эрхийг хязгаарлаж үл болох талаар ойлголт, мэдээллийг өгч, бодит кейс дээр харилцан ярилцах хэлбэрээр сургалтын зохион байгуулж ажилласан.

Багануур дүүргийн Прокурорын газрын хууль цаазын ахлах зөвлөх, ахлах прокурор С.Ууганбаяр нь 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Төрийн алба хаагчид “Эрүүдэн шүүлтээс ангид байх”, хяналтын прокурор Э.Батзолбоо нь “Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, онцлог заалтууд”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт танхим сургалтуудыг нийт алба хаагчдын дунд тус тус зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208.3 дахь заалт<sup>127</sup>, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 12 дугаар дүрмийн хэрэгжилтийг даруй хангаж, хоригдлууд нэгэндээ зүй бус хандах, нэгнийгээ ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.3 дахь заалт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 12 дугаар дүрмийн хэрэгжилтийг хангаж, хоригдлууд нэгэндээ зүй бус хандах нэгнийгээ ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: Харуул хамгаалалт гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, ахлах төлөөлөгч, харуул хамгаалалтын ахлах байцаагч, нийгмийн ахлах ажилтан, сэтгэл зүйч, тоо бүртгэлийн ажилтан нар нь төлөвлөгөө гарган нийт хоригдлуудад хоригдлын эрх, "Хорих ангийн дотоод журам"-ын талаар яриа таниулгыг тогтмол өгч ажиллаж байна.



Мөн хорих ял эдэлж буй хоригдлуудаас санал, хүсэлтийг нь авч тухай бүр нь холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэн шийдвэрлэсэн.

Хоригдлуудад харилцаа хандлага, сургамжит видео, контент үзүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай яриа таниулга, холбогдох хууль журам


зэргийг танилцуулан ажилласан ба ганцаарчилсан сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Хоригдлуудад нэгэндээ зүй бус хандах асуудал дээр нийт хоригдлуудад харилцааны сургалтыг 7 хоног бүр тогтмол зохион байгуулж, ганцаарчилсан болон бүлгээр хамруулан багийн үйл ажиллагааг сайжруулж нийт дунд яриулах, нээлттэй байх хэлбэрээр тогтмол зохион байгуулж байна.

Нийт хоригдлуудад нэгэндээ зүй бус хандахын хор уршиг үүнээс хэрхэн зайлсхийх, зөрчлийн сул тал, хууль эрх зүй талаар яриа таниулга болон сургалтаар тогтмол зохион байгуулж байна.

*Хоригдлууд нэгэндээ зүй бус хандах, гэмт хэрэг, зүйл ангиар ялгаварлан гадуурхахгүй байх үүднээс урьдчилан сэргийлэн хоригдлын өрөөний нэрийн мэдээлэл, энгэрийн тэмдгийг хувийн дугаар, овог нэрийг байршуулан ажиллаж байна.*

<sup>127</sup> 208.3. Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.



Хорих ял эдэлж буй иргэдийг эвлэрүүлэн зуучлах, харилцан ойлголцолд хүргэх зэрэг аливаа зөрчил, үйлдлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах арга зүйг алба хаагчдад цогц байдлаар, чанартай олгох чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Тус ангид хорих ял эдэлж буй нэр бүхий 2 хоригдол нь гэр бүлийн тогтворгүй харилцаатай, үүнээс үүдэн сэтгэл зүйн байдалд өөрчлөлт орж гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж, хоригдлын ар гэртэй нь харилцаа холбоо тогтоож, эвлэрүүлэн зуучилж хуулийн хугацаанд цахим уулзалтыг зохион байгуулж тогтмол хяналтыг тавьж ажиллаж байна.

Хоригдлын сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгаж эерэг нөлөөлөл үзүүлж, тулгамдсан асуудлыг шийдэх, гэр бүлийн тогтвортой харилцааг бий болгох зорилгоор хоригдлын болон ар гэрийн хүсэлтийн дагуу Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хоригдол Э.М, А.Ц нарын гэрлэлтийг бүртгүүлэн ажилласан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.6 дахь заалтын хүрээнд хоригдлыг ар гэртэй нь суурин утсаар ярих эрхийг бүрэн хангахын тулд “Жи мобайл” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж суурин утасны тоог 5-аар нэмэгдүүлэн ажилласнаар хоригдол хуулийн хугацаанд эцэг, эх, гэр бүл, хамаатан садантайгаа харилцаа холбоо тогтоох боломж бүрэн хангагдсан.

*Хоригдлын сэтгэл зүйн байдалд өөрчлөлт орох, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ар гэрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2024 оны жилийн эцсийн байдлаар хуулийн хугацаанд давхардсан тоогоор 1312 хоригдлыг ар гэрийн хүмүүстэй нь цахим уулзалтаар уулзуулсан, 2736 хоригдлын утсаар яриулж, тэдгээрийн яриа өгүүлэл, сэтгэл зүйн болон ар гэрийн байдалд биечлэн хяналт тавьж ажилласан.*

Ангийн удирдлагын зүгээс алба хаагчдад хоригдолтой хуулийн хүрээнд жигд шаардлага тавьж, хүнлэг бус харьцахгүй байх чиглэлээр холбогдох үүрэг, чиглэлийг амаар болон бичгээр өдөр тутам өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд хоригдол бие, биетэйгээ зүй бус харьцахгүй байх, тэдгээрийн дундаас гарч буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах ажлыг тухай бүр зохион байгуулсан.

Судалгаагаар 2023 онд нийт хоригдлын дундаас 39 зөрчил гарсан бөгөөд 2024 оны байдлаар 33 зөрчил гарсан байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6-аар буюу 7,6 хувиар буурсан зэрэг үзүүлэлттэй байгаа юм.

Зөрчил гаргасан хоригдлуудыг дахин давтан гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, харилцааны зөрчил гаргасан хоригдлуудыг хооронд нь



эвлэрүүлэн зуучлах зорилгоор төлөвлөгөө гарган, ганцаарчилсан болон бүлгийн сургалт, хүмүүжил, нөлөөллийн ажилд тухай бүр хамруулж байгаа бөгөөд “Харилцаа” сэдвийн хүрээнд нийт 18 удаа сургалтыг зохион байгуулан ажилласан.

Багануур дүүргийн Прокурорын газар, Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хамтаар “Хоригдол, хоригдогчийн эрхийг хангах, тэдгээрийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан.

Хамтарсан зөвлөгөөний зорилго нь хоригдол, хоригдогчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд анхаарал асуудал, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харилцаанаас ангид байх зарчмын болон Олон улсын гэрээ, конвенц, пактийн хэрэгжилтийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Нийт алба хаагчдад 2024 онд ШШГ байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтаар хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Г.Ууганцэцэг, ШШГ байгууллагын ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандарт, харуул хамгаалалтын журам, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах сэдвээр харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, дэд хурандаа Г.Гантулга тус тус сургалт зохион байгуулсан.

Ангийн нийгмийн ажилтан, дэслэгч Г.Чаминчулуун нь “Хорих байгууллага ба хүний эрх”-ийн сургалт, сэтгэл зүйч, дэслэгч О.Цэнд-Аюуш нь “Байгууллагын сэтгэл зүй” сэдвээр алба хаагчдад сургалт амжилттай зохион байгуулж, сургалтаар олсон мэдлэгийг алба хаагчид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.


Нийгмийн ажилтнуудын мэргэшүүлэх сургалтад 2024 оны 05 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2 өдөр нийгмийн ахлах ажилтан, дэслэгч Э.Нямцэцэг, нийгмийн ажилтан, дэслэгч Х.Алтан-Эрдэнэ, дэслэгч Г.Чаминчулуун, дэслэгч М.Номингэрэл нар амжилттай хамрагдсан. Тухайн сургалтаар хоригдлын эрхийг хангах, тэдгээрийн зөрчигдсэн эрх, зорилтод бүлгийн хоригдлуудын эрхийг хангах чиглэлээр онолын мэдлэг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ангийн зүгээс хорих ял эдэлж буй хоригдлыг эвлэрүүлэн зуучлах, харилцан ойлголцолд хүргэх зэрэг аливаа зөрчил, үйлдлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах арга зүйг алба хаагчдад тогтмол зохион байгуулж байна.

#### **9.4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА 437 ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ АНГИД ХҮРГҮҮЛСЭН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ГАРСАН ҮР ДҮН АХИЦ, ДЭВШИЛ**

Хорих ангийн оёдлын үйлдвэр болон мужаан цехийн барилгын гаднах 10 орчим м<sup>2</sup> талбай, хоригдлуудын амьдралын бүс болон оёдлын цехийн дунд байрлах байгууламж дахь гадуур ажлын заалттай хоригдлуудын хувцас солих өрөө гэсэн байршлуудыг дуу-дүрсний хяналтын камертай болгох чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Орхон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 2024 онд хорих ангийн харуул хамгаалалтад сүлжээний кабель-300 метр, дотор сүлжээний камер-3000 метр, Hikvision загварын хонгилын камер 20ш, өрөөний камер 50ш, PT2 360 градус эргэдэг камер 2ш, 4ТВ-ын хард диск 10ш, CD зөөврийн хард-20ш, энгэрийн камер-20ш, бичлэгийн төхөөрөмж NVR-1ш, камерын тэжээлийн блок 10ш, 43 инчийн дэлгэц 3ш, Baofeng загварын өндөр давтамжийн гар станц 25ш, суурин дэлгэц-2ш, сүлжээний толгой-2ш, сүлжээ салаалагч-2ш тус тус Орхон аймгийн засаг даргын тамгын газрын Худалдан авах ажиллагааны газраас дуудлага худалдаа зохион байгуулагдаж “Чандмань Биндэр” ХХК шалгарч 32,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч хяналтгүй цэгүүдийг камержуулан ажилласан.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэдээлэл технологийн хэлтсээс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр суурилуулалтын ажлыг зохион байгуулж нийт 9 дэлгэцээр 128 телекамерын хяналтыг тасралтгүй тавин ажиллаж байна. Мөн хорих анги, цагдан хорих байрнаас гадна эмнэлэгт хэвтэн эмчилгээ хийлгэж буй хоригдол, хоригдогчдыг 4G дэмждэг зөөврийн Juancloud загварын дүрс, дуу дамжуулах зориулалт бүхий IP камераар хяналт тавин ажиллаж байна.



*Нийт алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хууль, холбогдох олон улсын эрх зүйн баримт бичгийн хэм хэмжээг баримтлан ажиллах, аливаа сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/285 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт хөгжлийн хөтөлбөр”, Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчдад зохион байгуулах сургалт, хөгжлийн төлөвлөгөө”-ний дагуу алба хаагчдын сэтгэлгээ, харилцааны болон ёс суртахууны соёлыг дээшлүүлэх, тэсвэр хатуужил, ур чадвар, мэдлэг боловсролтой хүний нөөцийг бүрдүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургах зорилгоор сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллалаа.

Нийгмийн ажилтан, дэслэгч А.Аззаяаг “Дохионы хэлний анхан шатны чадвар эзэмшүүлэх” сургалтад хамруулан анхан шатны мэдлэгтэй болгож Хөгжлийн бэрхшээлтэй хоригдогсод болон иргэдийн эрхийг хангаж “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

*Өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих олон улсын гэрээ, конвенцын суурь зарчмууд, эрхээ хязгаарлуулсан хүнтэй хэрхэн харьцах олон улсын дүрмүүдийн талаарх ойлголт, мэдлэг; хорих ангийн алба хаагчийн чиг үүргээ гүйцэтгэхдээ хүлээх эрх, үүрэг, баримтлах ёс зүйн хэм хэмжээ; хорих ял эдэлж буй иргэдийг эвлэрүүлэн зуучлах, харилцан ойлголцолд хүргэх зэрэг аливаа зөрчил, үйлдлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах арга зүйг алба хаагчдадаа цогц байдлаар, чанартай олгох хэрэгжилтэд тогтмол хяналт тавих чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

“Монгол улсын Үндсэн хууль”, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжийн хүрээнд хорих, баривчлах, цагдан хорих үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх, Хүний эрх хамгаалагчийн тухай ойлголт мэдлэг, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай ойлголт сэдвээр танхимын сургалт мөн Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран Төрийн албан хаагчийн харилцаа, ёс зүй, Хүний эрхэд суурилсан хандлага сэдэвт танхимын 2 цагийн сургалтыг зохион байгуулж нийт алба хаагчийг хамруулсан.

Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг хоригдол бүрд тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд шаардагдах төсвийн төсөөллийг боловсруулан, дээд шатны удирдлагад хүргүүлж, шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ авах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг хоригдол бүрд тэгш хүртээмжтэй үзүүлэхэд шаардагдах эмийн төсвийг нэмүүлэх саналыг 2024 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж 2024 онд эмийн төсөв 280,000 төгрөг байсныг 2025 онд 1 дүгээр сарын эмийн төсөв 1,500,000 төгрөг болгон өөрчилсөн.

Орхон аймгийн орон нутгийн төсвөөс тус хорих ангийн эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хүчилтөрөгчийн аппарат 2 ширхэг хяналтын монитор 2 ширхэг яаралтай тусламжийн тэргэнцэр 2 ширхэг, эм хадгалах шкаф 2 ширхэг эвхэгддэг дамнуурга 2 ширхэг зөөврийн дефибриллятор 1 ширхэг, эмнэлгийн ор 5 ширхэг, хүчилтөрөгчийн баллон / 5л / 2 ширхэг, мэс заслын оёдлын багажийн иж бүрдэл 2 ширхэг, хажуугийн шарлагын гэрэл 2 ширхэг, тусгаарлагч хаалт 2 ширхэг эмч, сувилагчийн ширээ, сандал тус бүр 2 ширхгийг шийдвэрлэж хүлээлгэн өгсөн.

Мөн 2024 онд дотоод нөөц бололцоонд тулгарлан эмнэлгийн үйл ажиллагааны орчин нөхцөлийг сайжруулах, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зорилгоор хорих ангийн 2 дугаар давхарт эмнэлгийн хэсгийг шинээр нээн хэвтэн эмчлүүлэгчдийн өрөө, тарианы өрөө, сувилагчийн пост, эмчийн өрөө зэргийг шинээр засварлан тохижуулсан.





Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/129 дугаар тушаалын<sup>128</sup> нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ын<sup>129</sup> холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Нийгэм, сэтгэл зүйн нэгж нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/222 тушаалаар батлагдсан нийгмийн ажилтны аргачилсан заавар<sup>130</sup>”, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж”, холбогдох дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийн дагуу ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг зохион байгуулан сургалтын бүртгэл, сургалт орсон тэмдэглэлийг хөтлөн, “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц”-ийг мөрдөн хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, орчин нөхцөлд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Нийгмийн ажилтан нь хоригдлыг хорих ангид хуваарилагдан ирсэн дариуд хоригдлын зан төлөвийг тодорхойлсны үдсэн дээр нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах бөгөөд төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн хүний нөхцөл байдал, хэрэгцээ, зан төлөв, сургамж авах чадвар, ирээдүйн зорилтыг харгалзан үзэж хоригдлын зан төлөвийг сайжруулах, нийгмийн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх, боловсрол мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хоригдлыг бие даан амьдрах чадвартай болгох зэргийг харгалзан үздэг.

Үйлдсэн гэмт хэргийн болон түүний хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг дүгнэн ганцаарчилсан болон бүлгийн, нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттайгаар төлөвлөн төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулан ажилладаг бөгөөд тэдэнд албадан сургалтаас бусад сургалтад хамрагдах талаар санал болгох хуудсыг таниулж гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллаж байна.

Хоригдол нэг бүрд зориулсан төлөвлөгөө боловсруулж ажилласнаар тухайн хүн хуулийг дагаж мөрдөх дадалд суралцах, боловсрол мэргэжлийн ур чадвар нэмэгдэх, бусадтай эерэг харилцаа үүсгэх чадвар сайжрах, бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэнд тогтвортой болсон байх зэрэг эерэг нөлөө үзүүлсэн.

Хоригдлын нас, эрүүл мэнд, ажлын дадлага туршлага, мэргэжил, хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг харгалзан сайн дурын үндсэн дээр ажлын байр санал болгох бөгөөд ажил санал болгосон хуудсыг баталгаажуулан хоригдлын цаасан мэдээллийн санд баяжилт хэлбэрээр хийн ажиллаж байна.

<sup>128</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 дугаар тушаал

<sup>129</sup> “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ын 3.3.3; 3.3.4; 3.3.5; 3.3.11; 3.3.12, 3.3.13; 4.1; 4.2; 5.3; 5.4; 5.6; 5.7 заалтууд

<sup>130</sup> “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/222 тушаалаар батлагдсан нийгмийн ажилтны аргачилсан заавар

Хоригдлыг ажил хөдөлмөрт хамруулах нь хоригдолд шинэ ур чадвар эзэмшүүлэх, хоригдлын зан төлөвийг эергээр өөрчлөх, амьдралын баталгааг нэмэгдүүлэх, нийгмийн орчин нөхцөлд бэлтгэх, амьдралд эерэг өөрчлөлт хийхэд чиглэсэн нийгэмшүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Тэдний урлаг, спортын авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор хоригдлуудын дунд долоо хоног тутамд зохион байгуулсан сургалтыг бататгах, олж авсан мэдээллээ бусдадаа түгээх зорилгоор хөгжөөнт болон танин мэдэхүйн тэмцээн уралдааныг зохион байгуулж ажилласан бөгөөд тус арга хэмжээг зохион байгуулснаар хоригдлууд зохион байгуулж буй сургалтад идэвхтэй хамрагдах мөн түүнчлэн сургалтаас сурч мэдсэн зүйлсээ бусдадаа түгээн дэлгэрүүлэх цаашлаад хорих ангид байх болон хорих ангиас суллагдан гараад амьдрах хугацаанд сурч мэдсэн зүйлсээ хэрэгжүүлж амьдрахад эерэг үр нөлөө үзүүлсэн байна.

Гэм хорын төлбөртэй хоригдлуудад бусдад учруулсан төлбөрийг барагдуулах, хохирогчийн эрхийг хамгаалах, хоригдол хугацаанаас өмнө суллах нөхцөлийг бүрдүүлэх, хоригдол болон тэдгээрийн ар гэрээс хохирол төлөх эрмэлзлийг бий болгох зорилгоор яриа таниулгыг аяны хугацаанд 6 удаа 198 (давхардсан тоогоор) хоригдолд зохион явуулсан.

Хоригдлуудын дунд “Хохирлоо төлөөд гэртээ харья” аяны хүрээнд хорих ангийн аж ахуйн үйлдвэрлэл болон “Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар”-т мод тарих арчлах ажилд гэрээгээр нийт 302 (давхардсан тоогоор) хоригдлыг ажлын байраар хангасан бөгөөд үүнээс 114 хоригдлыг (давхардсан тоогоор) цалинтай ажлын байранд ажиллуулсан байна.

Хохирол, төлбөртэй нийт хоригдлоос давхардсан тоогоор 154 хоригдлыг Арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэж ажлын байраар хангуулсан бөгөөд 25 хоригдлыг цалинтай ажлын байраар хангасан. Иргэд хүлээн авах хэсэгт хохирол төлбөрөө барагдуулахыг уриалсан уриалга, мэдээ мэдээллийг байршуулан сурталчлан таниулсан.


Хохирол төлбөрийн талаар хуулийн хэрэгцээт мэдээ, мэдээллийг байршуулснаар иргэд хуулийн хэрэгцээт мэдээллээр хангагдаж байна. Аяны хугацаанд нийт төлбөртэй хоригдлуудын ар гэрээс төлбөрийг бүрэн барагдуулсан 7 хоригдлын 11,846.9 мянган төгрөг, Цалин хөлснөөс бүрэн барагдуулсан 2 хоригдлын 11.1 мянган төгрөг, Цалин хөлснөөс хэсэгчилж барагдуулсан 12 хоригдлын 12,400.3 мянган төгрөг төлбөр бүрэн төлж барагдуулсан. Цаашид хоригдлын гэм хорын төлбөрийг барагдуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллана





Хоригдлын хууль, тогтоомжоор хориглоогүй зарим эрх буюу иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломжоор хангахад эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх зорилгоор “Зөрчлийн тухай хууль” сэдвээр нийт хоригдлуудад, “ хоригдлын эрх” сэдвээр нийт хоригдлуудад, “Хорих ангийн дотоод журам” сэдвээр нийт хоригдлуудад, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл заалтууд” сэдвээр нийт хоригдлуудад, “Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журам” сэдвээр нийт хоригдлуудад сургалт зохион байгуулж сургалтын явцад гарын авлага бэлдэн танилцуулж гарын үсэг зуруулан хоригдлын кейс файл тус бүрд баяжилт хийж ажилласан.

Хоригдлуудын мэдээллийг тодруулах, тэдний санаа бодлыг чөлөөтэй сонсож тэдэнд тулгарч буй хэрэгцээ шаардлагыг нээн илрүүлэх зорилгоор тэдэнтэй ганцаарчилсан болон бүлгийн уулзалтыг улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүрд зохион байгуулж уулзалтын тэмдэглэл хөтлөн хоригдогсдын цахим системд баяжилт хийн ажилласан байна. Уулзалтын явцад сэтгэл санаа тогтворгүй, тулгамдаж буй асуудалтай хоригдлуудыг холбогдох албан тушаалтанд холбон зуучлах хуудсаар мэдэгдэн ажилласан байна.



*Хорих ял эдэлж буй иргэдийн бусадтай харьцах буюу утсаар ярих хэрэгцээг Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйлийн 3, 4131 дэх хэсгүүдэд заасны дагуу даруй хангаж, нийт хоригдлуудад хүртээмжтэй байдлаар зохион байгуулах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:*

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 198 дугаар зүйлийн 198.3, 198.4 дэх заалтыг хангаж нээлттэй хорих ангид ял эдэлж буй тусгай зэрэглэлийн хоригдлыг 7 хоногт 1 удаа, энгийн зэрэглэлийн хоригдлыг өдөр бүр утсаар ар гэртэй нь харуул хамгаалалтын хяналтад яриулж хоригдлуудын эрхийг хуульд зааснаар эдлүүлж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.

131 198.3.Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй.

198.4.Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 7 хоногт нэг удаа түр, 45 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй.

№	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					
21					
22					
23					
24					
25					
26					
27					
28					
29					
30					
31					
32					
33					
34					
35					
36					
37					
38					
39					
40					
41					
42					
43					
44					
45					
46					
47					
48					
49					
50					
51					
52					
53					
54					
55					
56					
57					
58					
59					
60					

№	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц	Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					
21					
22					
23					
24					
25					
26					
27					
28					
29					
30					
31					
32					
33					
34					
35					
36					
37					
38					
39					
40					
41					
42					
43					
44					
45					
46					
47					
48					
49					
50					
51					
52					
53					
54					
55					
56					
57					
58					
59					
60					

Зурагт: Харуул хамгаалалтын хяналтад утсаар яриулах явц

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд заасан ариун цэвэр сахих хэм хэмжээг ханган, мөн бусад хорих ангиудын сайн жишгийг нэвтрүүлж, хорих ял эдэлж буй иргэдийг 7 хоногт нэг удаа халуун усанд орох боломжийг бүрдүүлэх чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Тус хорих ангийн барилга нь 2013 онд 144 хоригдлын багтаамжтай баригдсан боловч өнөөдрийн байдлаар 196 хоригдол хоригдож хорих ангийн даац хэтрэлттэй байгаа бөгөөд хорих ангийн дотоод журмын 4.2 дахь хэсэгт заасны дагуу хоригдлыг 14 хоног тутам халуун усанд оруулж хөдөлмөрт хамрагдаж буй хоригдлуудыг ажлын байрнаас буух бүрд нь халуун усанд оруулж хувийн ариун цэврийг сахиулж байна.

Мөн 2024 онд хорих анги болон цагдан хорих байрны гадна фасад, дээвэр, дотор засвар, хоригдлын халуун ус зэрэг засварын ажилд орон нутгийн төсөвт санал хүргүүлэн 111.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн ба бараа материалыг худалдан авах тендерт “Их хөх чулуут” ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын материалыг 60 хоногт нийлүүлэхээр ажиллаж байна.



Хорих ангийн даац хэтэрсэн байдал нь хоригдлуудын хэзээд үл хязгаарлагдах олон эрх зөрчигдөж байх тул Монгол Улсын хууль, стандартад нийцүүлэх арга хэмжээ авах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ:

Хоригдлын хуулиар хязгаарлаагүй эрх зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлж тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар алба хаагчдыг хангаж, үүрэг чиглэлээр тогтмол өгч ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тус хорих ангийн хоригдлын байрны багтаамж хэтэрсэн талаар мэдэгдэж ажилласан.

Тус хорих ангийн хоригдлын байрны багтаамж хэтэрсэн байгаа нөхцөл байдалтай 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын ерөнхий прокурорын орлогч, Хууль цаазын итгэмжлэлт төлөөлөгч, шадар зөвлөх О.Машбат, улсын прокурор Э.Идэрбат, Орхон аймгийн ерөнхий прокурор Б.Батболд, хяналтын прокурор Б.Жавхлантуяа нар биечлэн танилцсан.

Хоригдлуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2023 онд дотоод нөөц бололцоогоор сагсны талбайг шинээр тохижуулж ашиглалтад оруулсан. Номын сан, шашны зан үйлийн өрөө, бясалгалын өрөө зэргийг томруулан шинэчлэн засварлах ажлыг хийж байгаа ба хоригдлын сургалтын танхимын дэлгэцийг шинэчлэн “Nova star v1060n” маркийн 220x520 см хэмжээтэй дэлгэцийг байрлуулан угсарч холболтын ажил хийгдэж байна.



Зураг: Сагсан бөмбөгийн талбай ашиглалтад оруулсан байдал

Орхон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 2024 онд тус хорих ангид хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ясны хөрөө 1 ширхэг, махны машин 1 ширхэг, хөлдөөгч 1 ширхэг, 4 ширэмтэй плитк 1 ширхэг, 1,2 дугаар хоолны тогоо тус бүр 1 ширхэг, гурил зуурагч 1 ширхэг, гурил элдэгч, хэрчигч машин 1 ширхэг, талх шарах шүүгээ 1 ширхэг, аяга таваг ариутгагч 1 ширхэг, буузны жигнүүр 1 ширхэг тус тус Орхон аймгийн засаг даргын тамгын газрын Худалдан авах ажиллагааны газраас дуудлага худалдаа зохион байгуулагдаж “Чандмань Биндэр” ХХК шалгарч 40,284,500 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч хоригдлын хоол үйлдвэрлэлд ашиглаж байна.



Хорих ял эдэлж буй, цагдан хоригдсон иргэдийн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээ, мэдээлэл олж авах эрхийг хангаж ажиллах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн дагуу авах арга хэмжээ:

Хорих ял эдэлж буй хоригдлууд, цагдан хоригдсон хоригдогч нарт эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээ, мэдээлэл олгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тэдний эрхийг хангаж, холбогдох сурталчилгааны хэрэглэгдэхүүн, хүний эрхтэй холбогдуулан мэдээ, мэдээллийг хорих ангид хоригдлын амьдралын бүс мөн шалган нэвтрүүлэх байр, цагдан хорих байранд байршуулж ажилласан ба самбарыг байршуулж мэдээлэл түгээснээр хоригдол, хоригдогч нар өөрсдийн эрхийг хамгаалах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой байна.



Монгол Улсын хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д зааснаар хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмын хүрээнд, уг хуулийн 7.1 дэх заалтын дагуу хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүй байх, мөн хуулийн бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, нэр төрийг нь доромжилж харьцахыг хориглосон.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7.3132 болон 251.1.5133 дахь заалтуудыг хэрэгжүүлэх чанд мөрдөж ажиллах шаардлагатай.

*Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд алба хаагчид нь төрөөс хуулиар олгогдсон албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шуурхай энэрэнгүй байх зарчмыг чанд баримталж, өргөсөн тангарагтаа үнэнч байж хоригдол, хоригдогч этгээдүүдтэй харилцахдаа хувийн ашиг сонирхлоос ангид байж төрийн нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэж байгааг ямагт ухамсарлан хоригдогсдын хуулиар олгогдсон эрхийг хүндэтгэн ажиллах талаар хичээл, сургалтаар болон хурал, зөвлөгөөний үеэр тогтмол бичгээр, амаар үүрэг чиглэл өгч ажиллаж байгаагаа илтгэн танилцуулсан байна.*

## **АРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ГАРСАН ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ**

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34.1.1 дэх заалт, 35.1 дэх заалт, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан “ЭШУС нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 2.1 дэх хэсэг “ЭШЭК-оор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх” заалтыг тус тус үндэслэн ШШГ байгууллагын хорих анги, цагдан хорих, саатуулах, баривчлах байруудад тогтмол хяналт шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах чиг үүрэгтэй ажиллаж ирлээ.

Мөн Улсын Их хурлын Тамгын газраас ХЭҮК-ын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний ЭШУС үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн хяналт шинжилгээний танилцуулгад зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд хийсэн дүн шинжилгээ хийж ажиллах чиглэлийг тусгаж өгсөн.

ЭШУС үндэсний ажиллагаа нь хүний эрхийн, тэр дундаа хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийг илрүүлэх цогц арга ашиглан ШШГЕГ-ын харьяа салбар, нэгжүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзсэн тохиолдол бүрд НҮБ-ын холбогдох хэм хэмжээг харгалзан тэдгээрт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, байршин байгаа нөхцөлийг нь сайжруулах зорилгоор холбогдох удирдлага, албан тушаалтан, түүнчлэн салбарын сайдад ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилладаг.

Зөвлөмжийн хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэнд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчлийг арилгах, дахин давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажилласнаар тус салбарт нэлээдгүй ахиц дэвшил гарсан.

132 7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.

133 251.1.5.хоригдолтой хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах.

Мөн “ШШГ байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм”-ийн 2.1.6; 2.1.7; 2.1.11; 2.1.12 заалтуудын дагуу алба хаагч нь ялтан, хоригдол, хоригдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлохгүй байх, хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, хууль бусаар бие махбодод нь хүч хэрэглэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрд нь халдахгүй байх, сүрдүүлэхгүй байх, бусдын нэр төрийг гутаах зорилгоор худал ташаа цуурхал, мэдээлэл тараахгүй байх ёс зүйн зарчмыг чанд сахин ажиллах үүрэгтэй гэх ойлголтыг улам ухамсарлах болсон нь сайшаалтай, дэвшилтэд хүрч буй нэг чухал үзүүлэлт юм.

*Шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлээгүй зөвлөмжийн заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсох, хэрэгжүүлэх арга зам, ойлголтыг дахин зөвлөж, хэрэгжилтийг нэмэлтээр авч дахин үнэлэх, тухайн зөрчлийг арилгах хүртэл харилцан холбоотой ажилласнаар үр дүнд суурилсан хэрэгжилт, гүйцэтгэл бүрэн хангагдсан ажил болсон. Зарим тохиолдолд тухайн байгууллага дээр зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр сургалт хийх, газар дээр нь очиж хэрэгжилтийг хангуулахад зөвлөн туслах зэргээр тогтмол харилцан хамтран ажилласан.*



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд гарсан үр дүн ахиц, дэвшлийн талаар:

- “ШШГ, ял эдлүүлэх ажиллагааны алба хаагчдын чиг үүргээ биелүүлэх явцад баримтлах сахилга ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн нөхцөл байдал, ахиц дэвшил, гарсан үр дүн”;
- “Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдийн Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдал, гарсан үр дүн, ахиц дэвшил”;
- “ШШГЕГ-ын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хүргүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүн ахиц, дэвшил”;
- “ШШГЕГ-ын харьяа 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид хүргүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүн ахиц, дэвшил”, дэд сэдвүүдийн хүрээнд дэлгэрэнгүй дурдсан болно.

Мөн бусад ШШГ байгууллагуудад бүрэн хэрэгжсэн зарим үр дүнгээс нэмж дурдахад:

- ШШГ байгууллагын тусгайлсан чиг үүргээ биелүүлэхэд шаардагдах зардал буюу цалин хөлс, тээвэр шатахуун, хоол, хүнс, нормын хувцас,



түлш халаалт, гэрэл цахилгааны зардал болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг Төсвийн тухай хуулийн хүрээнд тооцон хянаж, 38.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр 2024 оны улсын төсвийн төсөлд тусгасан;

- Хорих ангид хорих ял эдэлж буй хоригдлуудыг удаан хугацааны турш нэг газар (улаан шугам)-т удаан хугацаанд суулгах зөрчлийг таслан зогсоосон. Зарим газар тухайн зөрчил өөр байдлаар хэлбэржин үйлдэгдэж байгаа нөхцөл давтан хяналт шалгалтаар илэрсэн тул арилгуулах зөвлөмж өгсөн;
- Хоригдлын амьдрах өрөөний үүдэнд хоригдлын овог нэр, зураг, эрүүгийн хуулийн зүйл заалт бүхий өрөөний хаяг байршуулдаг байсныг хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах зорилгоор хоригдлын шийтгэгдсэн Эрүүгийн хуулийн зүйл заалтыг хасаж, шинэчлэн, зөвхөн хоригдлын овог нэр, зурагтай хаягаар сольсон;
- Хорих ял эдэлж буй хүний хувийн ба гэр бүл, захидал, харилцааны нууцыг хамгаалах эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс хоригдлыг утасны чанга яригчаар яриулдгийг таслан зогсоож, утсаар яриулахдаа утасны харилцуур ашиглаж яриулдаг болсон;
- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж хүлээн авсан ШШГ байгууллагууд хүний эрхийн хэрэгжилтийн талаар гомдол, мэдээлэл гаргах болон мэдээлэл авах эрхийг хангах хүрээнд сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг заагдсан газруудад байршуулсан;
- Алба хаагчдын хөдөлмөрлөх нөхцөл, ШШГ чиг үүрэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, шаардлагатай орон тооны судалгааг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн нь үр дүнгээ өгч батлагдсан төсөвт орон тоог нөхөж ажиллаж байна;
- Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар илүү цагаар ажиллуулсан тохиолдолд нөхөн олговрыг олгож байна. Тухайлбал, "... ангийн даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны Б/119 дүгээр тушаалаар илүү цагаар ажилласан нэр бүхий 20 алба хаагчид нөхөн олговор олгосон", "...Алба хаагчдын цагийн бүртгэлийг гарган 2023 онд нийт 39 алба хаагчид илүү цагийн мөнгө 677,679 төгрөгийг олгосон;
- ШШГ нийт 10 байгууллагад 69 камер шинээр суурилуулсан бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэгт нэн шаардлагатай 28 нэр төрлийн 47 ширхэг тоног төхөөрөмж, мөн дуут дохио 2, 60 инчийн дэлгэц байршуулан, агаар цэвэршүүлэгч 1-ийг нэмж тавьсан;
- Ш12 байгууллагад алба хаагч нар болон хоригдлуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийн хүрээнд шаардлагатай 13-15 өрөө гарган, засвар үйлчилгээ хийж зориулалтын дагуу тохижуулсан;
- Хоригдлын байрны гадна талбайд 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулан ашиглалтад оруулсан.

## АРВАН НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН 35.4-Т ЗААСНЫ ДАГУУ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН ТАЛААР

ХЭҮКТХ-ийн 35.4-т ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана гэж заасан байдаг.

*Энэ хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй албан хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авч ажиллах талаар санал хүргүүлж ажилласан. Тухайлбал:*

- Баянгол дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Э нь ШШГЕГ-ын даргын Цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож буй Б.У нар холбогдох эрүүгийн ...дугаартай хэрэгт хяналт тавьж ажиллахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан загварыг хэрэгжүүлээгүйн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч буюу яллагдагчийн эрхийг зөрчсөн зөрчил гаргасан болох нь шалгалтаар тогтоогдож, түүнд Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын 2024 оны 08 сарын 07-ны өдрийн тушаалаар Прокурорын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн 67.1.2-т зааснаар “албан тушаалын цалингийн хэмжээг нэг сарын хугацаагаар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл оногдуулсан болно;
- “... хяналтын прокурор Э.У-д бусадтай харилцахдаа гаргасан зөрчилтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн...”;
- “...Хорих ял эдэлж буй хүнийг ялгаварлан гадуурхаж, хүнлэг бус хэрцгий хандаж, доромжилдог гэх асуудалд нэр дурдагдсан 2 алба хаагчийг гүйцэтгэх ажилтнууд шалган тайлбар, тодорхойлолт гаргуулж авахад ШШГ байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг зөрчсөн байх тул сахилгын талоныг цоолж байгууллагын “Байгууллагын сахилга ёс зүйн хороо”-оор хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн”;
- Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын ерөнхий жижүүр, хошууч Б.Э нь өсвөр насны хоригдолтой зүй бус харьцсан нь тогтоогдсон тул 2024 оны 07 дугаар сарын 19-ний .. дугаар тушаалаар “цолны мөнгийг 1 сарын хугацаагаар хасах”, Б.Э-г .. дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн ерөнхий жижүүрийн албан тушаалд шилжүүлэн томилсон;
- “...401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн ахлах төлөөлөгч хошууч Н.Б нь хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл болох бугуйн гавыг өсвөр насны хоригдол Л.М-ын биед үндэслэлгүйгээр хэрэглэсэн нь тогтоогдсон тул 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ...дугаар тушаалаар “цолны мөнгийг 1 сарын хугацаагаар хасах” сахилгын шийтгэл оногдуулсан;
- “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын дарга, хурандаа Ц.Х-т ШШГЕГ-ын ... тушаалаар “албан тушаал бууруулах” сахилгын шийтгэл ногдуулж, ....дугаар нээлттэй хаалттай хорих ангийн харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд даргаар”;

- “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, дэд хурандаа Л.Н-д ШШГЕГ-ын даргын ... тушаалаар “албан тушаал бууруулах” сахилгын шийтгэл ногдуулж, ...дүгээр хаалттай хорих анги Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ахлах төлөөлөгчөөр тус тус томилсон”;
- “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын байгууллагын нийгмийн ажилтан дэслэгч Б.С-т нь өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт өгсөн тул ШШГЕГ-ын даргын...дугаар тушаалаар албан тушаалаас чөлөөлсөн;

ЭШУС чиглэлээр ШШГЕГ-ын харьяа Сургалт Хүмүүжлийн тусгай байгууллагад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад илэрсэн өсвөр насны хоригдлоос гаргасан гомдолтой холбогдуулан ШШГЕГ-ын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар, Хорих ял эдлүүлэх албанаас хяналт шалгалт явуулж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн тодорхой тооны алба хаагч нарт сахилгын шийтгэл ногдуулсан байдаг.

Гэвч ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс гишүүний хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй гэж үзэж ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний “Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд санал хүргүүлэх тухай” албан бичгээр 134 ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболорт хандаж тодорхой саналыг дахин хүргүүлсэн. Албан бичгээс дурдвал:



“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34135, 35136 дугаар зүйлд заасны дагуу ЭШУС үндэсний үйл ажиллагааны хүрээнд ШШГ холбогдох газруудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллав.

Үүнд: ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний

- ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболорт 2024 онд хүргүүлсэн 08/09, 08/10;
- ШШГЕГ-ын 417 дугаар нээлттэй ангийн дарга, хурандаа П.Ууганбаярт хүргүүлсэн 2023 онд хүргүүлсэн 08/02;
- ШШГЕГ-ын 427 дугаар нээлттэй, хаалттай ангийн дарга хурандаа С.Батсайханд хүргүүлсэн 08/03;
- ШШГЕГ-ын 419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Д.Хатанбаатарт хүргүүлсэн 08/05;
- ШШГЕГ-ын 407 дугаар нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Ц.Очгэрэлд

134 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 08/1678 дугаар “Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд санал хүргүүлэх тухай” албан бичиг

135 34 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх

136 35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж

хүргүүлсэн 08/06;

- ШШГЕГ-ын 439 дүгээр хаалттай хорих ангийн дарга, хурандаа Д.Батгэрэлд хүргүүлсэн 08/07;
- ШШГЕГ-ын 437 дугаар нээлттэй хорих ангийн дарга, хошууч Р.Ууганбаярт хүргүүлсэн 08/08;
- ШШГЕГ-ын 445 дугаар нээлттэй хорих ангийн дарга, хурандаа С.Лхагвасүрэнд хүргүүлсэн 08/09;
- ШШГЕГ-ын 435 дугаар хаалттай хорих ангийн дарга, хурандаа Д.Өлзийбатад хүргүүлсэн 08/10;
- ШШГЕГ-ын 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа А.Батхуягт хүргүүлсэн 08/14;
- ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн дарга, хурандаа Л.Эрдэнэбатад хүргүүлсэн 08/15;
- ШШГЕГ-ын 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Түвшинтөгст хүргүүлсэн 08/16;
- ШШГЕГ-ын 421 дүгээр нээлттэй ангийн дарга, хурандаа Б.Юмчинбаганад хүргүүлсэн 08/19;
- ШШГЕГ-ын 441 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Ч.Мөнх-Эрдэнэд хүргүүлсэн 08/20;
- ШШГЕГ-ын дарга хурандаа О.Амарсанаад 2022 онд хүргүүлсэн 08/08;
- ШШГЕГ-ын баривчлах байрны дарга Т.Зулзүсэмд хүргүүлсэн 08/09;
- ШШГЕГ-ын цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн дарга, хурандаа Б.Нямгомбод хүргүүлсэн 08/10 дугаар зөвлөмжүүд байна...”

“...Сургалт Хүмүүжлийн тусгай байгууллагын ээлжийн алба хаагчид хүүхдүүдийн чөлөөт цагийг хасах, хэл амаар доромжлох, дээрэлхэх асуудал нь үргэлжилсэн шинжтэй тогтмол гардаг болохыг тус байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдүүдээс авсан асуумж, ярилцлага, камерын бичлэгээс илрүүлэн тогтоосон болно.




Энэхүү зөрчил нь мөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг ангийн удирдлагын зүгээс хэрэгжүүлж ажиллагаагүй гэх бүрэн үндэслэлтэй байна...”, “... Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтад “ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.” гэж заасан.

Иймд Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4-д заасан “ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй

бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.” гэсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд ШШГЕГ-ын Сургалт Хүмүүжлийн тусгай байгууллагын дарга, алба хаагч нарт хариуцлага тооцох саналыг Танд хүргүүлж байна.....” гэсэн болно.

Тус албан бичгийн хүрээнд ШШГЕГ-ын дарга, хурандаа Б.Нандинболороос албан бичгээр 137 тус байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажилласан талаар тушаалын хуулбартай хамт хариу ирүүлсэн.



## АРВАН ХОЁР. БАРИВЧЛАГДСАН, ЦАГДАН ХОРИГДСОН ХУГАЦААГ ЯЛТНЫ ЭДЛЭХ ЯЛД ОРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД:

НҮБ-ын 1996 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”, Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно”, гэж тус тус заасан.

Гэвч Шүүхээс хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг эдлүүлж байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, иргэний үндсэн эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөхөд хүргэж байна.

Иймд шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцох талаар Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно”, гэсэн зохицуулалтыг

137 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболороос 2024 оны 11 дүгээр сарын 12-ны 01/2886 дугаар албан бичиг

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох талаар санал боловсруулах шаардлагатай байна.

Үүнээс үүсэж болох эрсдэл нь хорих ял эдэлж буй хүнийг өөр гэмт хэрэгт цагдан хорьж шалгах бүрд хорих ялын хугацаа тасарч, тухайн хүнийг ямар ч хугацаагаар өөр төрлийн хэрэгт холбогдуулан шалгаж хүний үндсэн эрх зөрчигдөх эрсдэлийг хууль тогтоогчид тооцож урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байх нь зүйтэй.

Энэ талаар ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны тайланд тусган ажиллаж байв.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 37 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл”<sup>138</sup>, ЭШУС үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын:

8/ Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр: а/шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно.” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох гэж заасан.

Тус асуудлын хүрээнд 2023 онд ШШГЕГ-аас ирүүлсэн тоон мэдээнд ШШГ байгууллагын хэмжээнд 2024 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хорих байр, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид тус тус хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг бүрэн эдлүүлж байгаа нэр бүхий 9 хоригдол байна гэжээ.

ШШГЕГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн мэдээлэлд “Тус байгууллагын хэмжээнд шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хорих байр, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид тус тус хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг бүрэн эдлүүлж байгаа нэр бүхий 8 хоригдлын судалгааг хүргүүлэв” гэсэн байна.

Энэ талаар Хууль зүй дотоод хэргийн сайд Д.Энхбаярт ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 08/07139 дугаар зөвлөмжийн 2 дах хэсэгт тодорхой зааж хүргүүлсэн. Хариуг нь Хууль зүй дотоод хэргийн сайд О.Алтангэрэлээс “Хариу хүргүүлэх тухай”<sup>140</sup> албан бичгээр ирүүлсэн ба дээрх асуудлын хүрээнд ямарваа ажил хэрэгжүүлж ажилласан талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

<sup>138</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл

<sup>139</sup> ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 05 дугаар сарын 31-ний 08/07

<sup>140</sup> ХЗДХ-ийн Сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1/1149 дугаар албан бичиг



Тиймээс Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолд заасан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх асуудлаар Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд холбогдох хуулийн төслийг боловсруулан, тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг нэн даруй эрчимжүүлэх шаардлагатай байна.

## АРВАН ГУРАВ.ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНЫ ӨМНӨ СУЛЛАЖ, ХЯНАЛТ ТОГТООЛГОХ ТУХАЙ АСУУДЛЫН ХҮРЭЭНД

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандаж эрх нь хязгаарлагдсан хүмүүсээс гомдол, санал, хүсэлт ирүүлдэг. Эдгээрээс тодорхой хувийг хугацаанаас өмнө суллагдах хүсэлтээ гаргасан болов ч Арга зүйн зөвлөлийн хурал, харьяа Прокурорын байгууллагаас буцаагдаж байгаа тухай гомдол байдаг. Сүүлийн 5 жилийн тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд:

Хүснэгт 19

№	Он	2021	2022	2023	2024
1	Хугацаанаас өмнө суллагдсан хоригдлын тоо	1318	747	1180	1074

Үүнээс хугацаанаас өмнө суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа хоригдлын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд 70 хүн байна.

Дээрх хугацааны өмнө суллагдсан хоригдлууд нь бүгд засрал хүмүүжлээ олсон, бүрэн нийгэмшсэн гэсэн үндэслэлээр суллагдсан байгаа ба давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжид энэ талаар түлхүү тусгаж хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Хүснэгт 20

Он	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолгох хүсэлтийн тоо	Арга зүйн зөвлөлийн хурлаас (анги магадлангаар) буцаагдсан тоо, үндэслэл				
		Зан байдал засрал хүмүүжлээ олоогүй	Үлдсэн ялын хугацаа их, үйлдсэн гэмт хэрэг хүнд	Хүлээн авах орчин ажлын байр тодорхой бус	Бусад	Нийт
2021	2258	142	176	46	180	525
2022	2053	227	221	35	138	591
2023	2628	287	310	82	152	814
2024	2852	319	244	146	279	968
Нийт	8623	975	951	308	748	2898

Арга зүйн зөвлөлийн хурлаар дэмжигдэж улмаар харьяа прокурорын газарт хүргүүлэн, шийдвэрлэгдэх ба тэндээс мөн буцаагдах, Шүүхийн байгууллагаас буцаагдах шалтгаан тохиолдлууд гардаг байна.

Хүснэгт 21

Он	Хүсэлт материалыг прокурорт хүргүүлсэн хоригдлын тоо	Прокуророос буцаасан тоо	Буцаасан үндэслэл	Шүүхээс буцаагдсан тоо
2021	1679	451	ЭХЕА-ийн 5.1, 6.12 дахь заалтыг хангаагүй, зан байдал, засрал хүмүүжлээрээ нийтэд аюулгүй болсон, засрал хүмүүжлээ олсон гэж дүгнэхэд учир дутагдалтай	16
2022	1393	564		1
2023	1781	651		14
2024	1835	789		22
Нийт	6689	2454		53

Арга зүйн зөвлөлийн хурал, Прокурорын байгууллагын татгалзсан, буцаасан үндэслэл нь тухайн хоригдлыг засрал хүмүүжлээ олоогүй, үлдсэн ялын хугацаа их, үйлдсэн гэмт хэрэг хүнд гэх зэрэг шалтгаан нөхцөлүүд байна. Хорих ангийн захиргаанаас гаргасан санал прокурорын байгууллагын дүгнэлт, үндэслэл, холбогдох нотлох баримтуудыг хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

### АРВАН ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА БОЛОН ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАГДСАН ИРГЭДИЙН ТОО МЭДЭЭГ 2020-2024 ОНЫ БАЙДЛААР АВЧ ҮЗЭХЭД

Шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлсэн иргэдийн тоо мэдээ.

Хүснэгт 22

№	Он	Хоригдол		Өсвөр нас		Нийт
		Эр	Эм	Эр	Эм	
1	2020 он	4214	245	27	3	4489
2	2021 он	167	167	15	0	3044
3	2022 он	254	254	38	0	4157
4	2023 он	279	279	36	0	4526
5	2024 он	330	330	46	2	4586

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан иргэдийн тоо мэдээ.

Хүснэгт 23

№	Он	Хоригдогч		Өсвөр нас		Нийт
		Эр	Эм	Эр	Эм	
1	2020 он	1025	120	23	1	1169
2	2021 он	908	94	21	1	1024
3	2022 он	709	73	11	0	793
4	2023 он	1003	92	25	1	1121
5	2024 он	967	88	17	0	1072

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хөл хорио цээрийн үетэй холбоотой байж болох шалтгааны улмаар 2020-2021 онуудад ял шийтгэгдсэн, цагдан хоригдсон иргэдийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

## АРВАН ТАВ. ШШГ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХОРООНЫ АЖИГЛАЛТ ДҮГНЭЛТ, ТҮҮНИЙ МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

United Nations

CAT/C/MNG/CO/3\*



### Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment

Distr.: General  
11 December 2024

Original: English

#### Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Монгол Улсын ээлжит гурав дахь тайланг хэлэлцээд гаргасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны ажиглалт, дүгнэлт

“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн.

- ◇ Эрх чөлөөгөө хасуулсан газрууд дахь гомдол гаргах механизмтай холбоотой илэрсэн нөхцөл байдал, анхаарал асуудалд:

Хорих анги, баривчлах байруудад прокурорууд очиж шалгаж байх гомдлын хайрцаг суурилуулж байгаа боловч эрх чөлөөгөө хасуулсан олон хүн хэлмэгдүүлэлт, айлган сүрдүүлгээс айж эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан тухай гомдол гаргахыг хүсдэггүй эсвэл мэдээгүй гэсэн мэдээлэлд Хороо санаа зовж байна. Баривчлагдсан хүмүүс цагдан хорих байрны захиргаагаар дамжуулан гомдлоо гаргаж болно гэж Оролцогч улсын тайланд тусгасан байгаа нь тэдний хувийн нууцын хамгаалалтад асуудал үүсгэж байгааг Хороо цохон тэмдэглэж байна.

- ◇ Эрх чөлөөгөө хасуулсан газрууд дахь гомдол гаргах механизмын тухайд дараах зөвлөмжийг ирүүлсэн.

Оролцогч улс эрх чөлөөгөө хасуулсан бүх газарт эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан үйлдлийн хохирогчдод үр дүнтэй, нууцлалтай, саадгүй хандах боломжийг хангах замаар гомдол гаргах механизмыг бэхжүүлэх арга хэмжээ авах ёстой, энэ талаарх мэдээллийг ил тод, өргөн хүрээнд тараах, харуул хамгаалалтын болон



- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/352 дугаар тушаалаар батлагдсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, албадан эмчлүүлэгч, хоригдлын хоолны газрын үйл ажиллагаа, хоол хүнсээр хангах, олгох журам”-ын илчлэг нормд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж мөн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар батлуулсан.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Баривчлах байрны дотоод журам”-д өөрчлөл оруулах саналаа хүргүүлсэн.
- “Зөрчлийн хууль”-аар шүүхээс 7-30 хоног баривчлах ялаар шийтгэгдсэн нийт 10170 эмэгтэй 397, эрэгтэй 9747, өсвөр насны хоригдол 21, гадаад 5 иргэнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтуудыг зохион байгуулан ажилласан.
- Баривчлах төвд Алба хаагч болон баривчлагдсан этгээдийн харьцаанаас үүдэлтэй зөрчил дутагдалд дүгнэлт хийж ажиллах төлөвлөгөөний дагуу “Алба хаагч танд талархъя” уриатай 14 хоногийн аяныг зохион байгуулж, баривчлагдсан этгээдүүдийн байранд санал сэтгэгдэл бичих “Талархлын мод” байршуулж, үр дүнг нэгтгэн ажилласан.
- ◊ 405 дугаар хаалттай хорих ангийн (тусгай нэгж) тухайд илэрсэн нөхцөл байдал, анхаарал асуудалд:

Цаазаар авах ялыг халсны дараа бүх цаазаар авах ялыг урт хугацааны хорих ялаар сольсныг сайшаахын хамт Хороо нь тусгай хаалттай ангид (405 дугаар хаалттай хорих анги) бүх насаараа хорих ял эдэлж байгаа хүмүүст тусгай хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаад, мөн хоригдлуудыг удаан хугацаанд ганцаарчлан тусгаарладаг, хорих өрөөний гадна дөнгөлдөг, бусад хоригдлууд болон гадаад ертөнцтэй харилцах харилцаа маш хязгаарлагдмал, ажил хөдөлмөр эрхлэх боломж хомс, нөхөн сэргээх хөтөлбөр хангалтгүй зэрэг байдалд Хороо санаа зовниж байна. Түүнчлэн, төлөөлөгчдийн тайлбарласнаар сэтгэл санаа нь тогтворгүй байгаа оюуны болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудыг ганцаарчлан тусгаарлах байранд хамгаалалтын арга хэмжээ болгон хэсэг хугацаанд ганцаарчлан хорьж байгаад санаа зовниж байна


- ◊ 405 дугаар хаалттай хорих ангийн (тусгай нэгж) тухайд илэрсэн нөхцөл байдалд дараах зөвлөмжийг ирүүлсэн.

Оролцогч улс тусгай хаалттай хорих ангид (405-р хорих анги), түүний дотор удаан хугацаагаар ял эдэлж буй хоригдлуудын хорих дэглэмийг эргэн харж, Нельсон Манделагийн дүрэм, ялангуяа 43(1) (b) зэрэг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан хорих ял эдэлж буй хоригдлуудын сэтгэцийн чадвар, нийгмийн чадавхыг доройтуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор бүх хоригдлыг хорих ангиас гадуур зохион байгуулалттай, зорилготой үйл ажиллагаагаар хангах, нийгэмшүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй. Хороо нь Нельсон Манделагийн дүрмийн оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хоригдлуудын нөхцөл байдлыг улам дордуулж болзошгүй тохиолдолд ганцаарчлан хорихыг хориглосон 45 (2) дахь дүрмийг анхаарахыг Оролцогч улсаас хүсэж байна.

◇ Тус асуудлаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжид тусгаж хэрэгжилтийг хангуулж ажилласан. Үүнд:

-Зөвлөмжид заагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200.1 дэх хэсэгт заасны дагуу "...хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болно" гэж заасны дагуу тусгай нэгжийн хоригдлуудыг хоёроор хорих саналыг ангийн арга зүйн хурлаар хэлэлцэн саналын материалыг судалгааны хамт Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэхэд бэлэн болсон.

- ШШГЕГ-ын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө, бясалгалын өрөө, төлөөлөгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны уулзалтын өрөөнүүдийн шаланд бэхлэгдсэн хөлийн гавыг салгаж авсан ба "Хорих ангийн харуул хамгаалалтын журам"-ын 11.14-т "Хоригдлыг хуулийн дагуу түр хугацааны уулзалт хийх үед түр уулзалтын өрөөнд шалтай бэхлэгдсэн гавыг хөлд зүүсний дараа, гарыг урд гавлаж, харуул хамгаалалтын уулзуулна." гэснийг өөрчлөх санал болон тусгай нэгжийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах хууль, журмын саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр төлөвлөсөн.



(Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө, бясалгалын өрөө, төлөөлөгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны уулзалтын өрөөнүүдийн шаланд бэхлэгдсэн хөлийн гавыг салгаж авсан байдал)

- ШШГЕГ-ын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчдад сорил, тест болон ярилцлагын арга ашиглан алба хаагчдын хүний эрхийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон. Мөн алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Хүний Эрхийн үндэсний Комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Прокурорын байгууллага, Насан туршийн боловсролын төв болон хүний эрхийн сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчидтай хамтран сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллав.

- ШШГЕГ-ын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх, үнэт зүйлс, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх зорилго бүхий "Ёс зүйтэй алба хаагч-бидний манлайлал" 1 сарын аян зохион байгуулж, үр дүнг тооцсон.



-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200.3 дахь хэсэгт заасны дагуу “Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно” гэсэн заалтын дагуу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл бололцоог судлан 2023 оноос хойш “Дарь Ундрах” төрийн бус байгууллагын эсгий урлалын сургалтад 6, “Орчлонд наран мөнх гэр” төрийн бус байгууллагын цаасан урлалын сургалтад 6, зоосон ширээний сүлжмэл сүлжих цахим сургалтад 2, даалин оёх сургалтад 2, нийт 16 хоригдлыг хөдөлмөр эрхлэх дадлага сургалтад хамруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224 дүгээр зүйл, 272 дугаар зүйлийн 2.4, хорих ангийн дотоод журмын 19.4 дэх заалтыг үндэслэн ангийн арга зүйн хурлаар саналыг оруулан ангийн даргын тушаалаар шагналын 2-8 хоногоор урамшуулж байна.



## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 22, 2022-2024, 2025 оны нэгдүгээр улиралд 43 салбар, нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийн ажиллав.

Тайлант хугацаанд 150 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 19 алба хаагчтай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, 894 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэн, 50 алба хаагчаас асуумж авсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжсэнээс хойш 4,500 хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 707 алба хаагчаас асуумж авч, ганцаарчлан ярилцсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхдээ тухайн байршилд буй эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрд хүрч, ганцаарчлан ярилцаж, нууцлал бүхий асуумж авдаг бөгөөд 2022 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд 4,500 хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 707 алба хаагчийг хамруулсан.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг тогтоож, түүнд үндэслэн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа дадал болгон ажиллах мөн ёс зүйн хэм хэмжээний заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнд хүрч ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарч буй алба хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн төлөв байдал зэргийг харгалзан судалгаанд суурилсан сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулан төвлөрсөн байдлаар алба хаагчдад сургалт явуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт харьяа газруудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон НҮБ-ын гэрээ, конвенцууд, олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалуудыг тэргүүнд үзэж, чанд мөрдөн ажиллахыг эрхэм зорилго болгон хэвшүүлэв.

Хоригдлуудын зан төлөв, эрсдэлийн төрөлд тохирсон арга зүйг боловсруулан хорих ангийн сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд ашиглах ажлыг шинээр эхлүүлэв.

Хоригдлыг гэр бүлийнхэнтэйгээ харьцах чин сэтгэлийн харьцааг нэмэгдүүлэх зорилгоор түр уулзалтын хэсгийн хатуулаг чанартай хуванцар хаалтын доод хэсгийг авсан ба цаашид бусад нээлттэй дэглэмийн хорих ангиудад дээрх ажил, арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах төлөвт шилжсэн.

Хорих ангийн хоригдлын байр, хорих өрөөг бүдгэрүүлэгчтэй унтраалган зохицуулалттай гэрэлтүүлгээр сольж, харуул хамгаалалтын хяналтад ашиглаж болох туршилтын ажлыг эхлүүлсэн.

Хоригдол, хоригдогсдыг хорих анги байгууллагын эмч нарын үзлэгээс гадна 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарын үзлэгт бүрэн хамруулсан.

Хөдөлмөрт хамрагдаагүй хоригдлуудад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар цаг үеийн байдлаар яриа таниулга хийх, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, хөдөлгөөнт дасгал хийлгэх зэргээр хоригдлын цагийг зөв зохистой ашиглах нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдлыг ажлын байраар хангах хувь хэмжээг 2025 онд өсгөх зорилгоор хорих ангийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхээр төлөвлөж 527.4 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусган шийдвэрлүүллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хорих өрөөний гадна хэсэгт хоригдогчийн цээж зураг бүхий хувийн мэдээлэлтэй танилцуулга байсныг өөрчлөн, зөвхөн тухайн хорих өрөөнд байх хоригдогчийн тоог илэрхийлсэн хуудаатай болгон өөрчлөн шинэчилсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь алба хаагч болон хоригдолд хүний эрхийн талаар мэдээ, мэдээлэл олгох зорилгоор Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх талаарх сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг шалган нэвтрүүлэх байр, хоригдлын байр, хорих өрөөнүүд, түр

болон удаан хугацааны эргэлт, уулзалтын байр мэдүүлэг авах хэсгийн орчинд байршуулах ажил хийгдсэн.

Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэний эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангуулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүлтэг, бэлгийн боловсрол болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хэрэгжих ба бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, нэр төрийг нь доромжилж харьцахыг хорих анги хорих ангийн алба хаагчдад хориглосон байдлыг сахин мөрдүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарсан байна.

## САНАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна гэж тусгагдсан<sup>142</sup>.

Тус ажлын хүрээнд хийгдэх хууль, эрх зүйн шинэчлэлтэд Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын үндсэн зарчмыг харгалзан үзэх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд алба хаагчдын эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол гарсан тохиолдолд заавал шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял завшуулахгүй байх сургалтын хөтөлбөр, дотоод журам, хяналтын тогтолцоог заавал бий болгох, энэ талаар тодорхой хугацаанд мэргэшлийн шалгалт давтамжтайгаар явуулдаг байх.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаараа болон Эрүүл мэндийн сайдтай хамтран баталдаг журамд өөрчлөлт оруулахаар Хууль зүй, дотоод хэргийн яамд дээр хүлээгдэж байгаа журмын төслүүдийг нэн даруй батлан мөрдүүлэх чиглэлийг Хууль зүйн байнгын хорооноос Хууль зүй, дотоод хэргийн яамд хүргүүлэх.

Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт хорих ангиуд, цагдан хорих байр, төвүүдэд хангагдахгүй байгаагийн нэг илрэл бол эдгээр эрхийн зөрчил нь байгууллагын дотоод журамд тусгагдан дагаж мөрдөгдөх үйл ажиллагаа болтлоо хэлбэржин оршиж байгаатай холбоотой юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмуудад өөрчлөлт оруулах замаар засаж сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах.

<sup>142</sup> 4.1.1.8. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна.

Хоригдлыг нийгэмшүүлэхэд төр, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Хорих ангийн зүгээс гэр бүл хоригдлуудын хоорондох харилцаа холбоог сайжруулахад анхаарах. Гэр бүл, төрөл төрөгсөдтэй тогтмол уулзуулж байх, захидал харилцаа явуулах, илгээмж авах, мөнгөн шилжүүлэг зэргийг саадгүй авхуулдаг байх зэргээр нийгэмд ойр байлгаснаар суллагдсаны дараа эргээд нийгэмд дасан зохицох үйл явц түргэн, үр нөлөөтэй байхыг анхаарч үзэх.

Хорих ял эдэлж байгаа хүмүүс, хорих байгууллагын алба хаагчдад зориулсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний шинэ арга хэрэгсэл, нөлөөллийн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, хоригдлын хувийн байдал, сэтгэл зүйн онцлогийг судлан хорих газруудад бий болдог сөрөг үзэгдлүүдийг таслан зогсооход чиглэж ажиллах.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 407 дугаар нээлттэй, хаалттай эмэгтэйчүүдийн хорих анги нь улсын хэмжээнд ганцхан байдаг учир бүх аймаг, сумдаас хорих ялтай иргэд ирдэг. Ар гэр амьдралын бололцоо, нутаг орны алслагдмал байдлаас шалтгаалан тэр бүр эргэлт авах бололцоогүй хоригдлууд их учир эмэгтэй хоригдлуудад зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэглэл гэх мэт зүйлд тодорхой хэмжээний мөнгө төсөвлөдөг байх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид дөнгөж төрсөн, нярай хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нөхцөл, боломжийг судлан, зохих шийдвэр гаргах.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид эх, нярайн тасагт хүүхдийн эмчийн орон тоог бий болгох.

Хэдийгээр хийсэн гэм хорынхоо уршгаар ял эдэлж буй ч тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх арга хэмжээг тогтмол авах, суллагдсаны дараа ажил, хөдөлмөр эрхэлж нийгэмд хурдан дасан зохицох нөхцөл бололцоог бий болгох асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэх.

## 2.5 СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХИЙСЭН ЭЭЛЖИТ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн ирүүлсэн Тайлан, Зөвлөмж 143 болон ХЭҮКТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор ТОГТМОЛ хяналт шинжилгээ хийх” заалтын дагуу ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд СЭМҮТ-д нийт 5 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлэн, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож ажилласан.



Тайлант хугацаанд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн 144 дагуу НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, ЭШУС нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсик, Мартин Зинклер, Хүний эрхийн дээд комисарын газрын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Армен Авестинан, Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ажилласан бол ЭШУС үндэсний ажиллагааны ажлын хэсэг тус клиникт хяналт шинжилгээ хийн 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01 дүгээр сард тус тус ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээнд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, иргэд болон төрийн албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллах зорилгоор “Монголын үнэн” сонинтой байгуулсан Хамтран ажиллах гэрээний дагуу тус сонины төлөөлөл болох сэтгүүлчидтэй хамтран ажилласан. Монголын үнэн сонины 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 002 дугаарт СЭМҮТ-ийн ШСЭСК-т хийсэн ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаар “Зэргэлдээ ертөнцөд гацагсад...” нийтлэл нийтлэгдсэн.

143 “...СЭМҮТ-д 20-25 жил эмчлүүлж буй эмчлүүлэгчид байгаа. Тэдэн дунд эмнэлгээс гаргах боломжтой 120 хүн байгаа боловч нийгэмд түшиглэсэн тусламж, үйлчилгээ байхгүй, мөн тэдгээр хүмүүсийг харж, хандах, тусламж, дэмжлэг үзүүлэх гэр бүл, төрөл садан байхгүй учраас тус төвөөс хэзээ гаргах нь тодорхойгүй байсаар байгаад Ажлын хэсэг санаа зовж байна...”

144 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх “02” дугаартай удирдамж

## Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний аргачлал

Тайлант хугацаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, асуумж ярилцлагад оролцох боломжтой гэж үзсэн 19 эмчлүүлэгч, 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 3 ШШГ байгууллагын алба хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийн, 9 эмчлүүлэгч, 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ШШГ байгууллагын алба хаагчаас асуумж авсан. Түүнчлэн тус байгууллагад өмнө хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн хүргүүлсэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжүүдийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшилтэй танилцсан.



## Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн тухай

ШСЭСК нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1971 оны 171 дүгээр тогтоолоор Сэтгэл мэдрэлийн больницын харьяанд “Хуулийн тасаг” нэртэйгээр 25 ортой анхлан байгуулагдсан түүхтэй. 1989 оноос Сэтгэцийн эмгэгийг эмчлэх клиникийн эмнэлгийн 20 ортой “Хуулийн тасаг”, 2006 оноос Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 20 ортой “Хуулийн тасаг”, 2014 оноос 30 ортой “Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник” болж өргөжин, 2024 оноос хэвтүүлэн эмчлэх 37 ортойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Сэтгэцийн эмгэг судлалын 3 дугаар клиникт шүүхийн шийтгэх тогтоолоор албадан эмчлүүлж байсан иргэн н.Х нь 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зөрчил гаргаснаар прокурорын шаардлагаар тухайн үед бусад үндсэн клиникт албадан эмчлэгдэж байсан 14 эмчлүүлэгчийг Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт нэгтгэсэн байна.

ШСЭСК-т 20-69 насны 38 хүн албадан эмчлүүлж байгаагийн 74 хувь нь эрэгтэй, 26 хувь нь эмэгтэй хүн байна. Анх удаа гэмт хэрэгт холбогдсон 31 хүн байгаа бол гэмт хэрэг давтан үйлдэж албадан эмчлүүлж буй 7 хүн байна.

Албадан эмчлүүлэгчдээс хорин хүн 1 жил, зургаан хүн 2-3 жил, гурван хүн 4-5 жил, хоёр хүн 6-7 жил, дөрвөн хүн 10-15 жил, хоёр хүн 16-18 жил, нэг хүн 22 жилийн турш тус клиникт албадан эмчлүүлж байгаа бол нийт албадан эмчлүүлэгчдийн 17 хувь нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг албан ёсоор тогтоолгожээ.

Тус клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд харуул хамгаалалтын үүргийг 1980-аад оны эхэн үеэс 2019 оны 05 дугаар сарын



24-ний өдрийг хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байсан бол 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн ШШГ байгууллагын алба хаагчид харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

*Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн үндсэн үзүүлэлт*

Хүснэгт 24

№	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Төсөвт ор	30	30	40	40	37	177
2	Хэвтсэн	29	41	105	57	102	334
3	Гарсан	40	54	65	57	98	314
4	Эмчлүүлсэн өвчтөн	34.5	47.5	86	57	100	325

**ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн биелэлт**

Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/07, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/05, СЭМҮТ-ийн захирал В.Баярмаад 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/02 дугаартай зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Хүснэгт 25

№	Зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан	Огноо, дугаар	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
<b>2022 онд</b>				
1	ХЗДХ-ийн сайд	2022.10.13, 08/07	5	60.0%
2	ЭМ-ийн сайд	2022.10.13, 08/05	5	64.0%
3	СЭМҮТ-ийн захирал	2022.10.13, 08/02	7	83.0%
<b>Нийт</b>				70.0%
<b>2024 онд</b>				
4	ЭМ-ийн сайд	2024.01.04, 08/01	4	82.0%
5	СЭМҮТ-ийн захирал	2024.01.16, 08/02	13	100%
6	Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн бүрэн эрхийн дагуу тавьсан шаардлага	2024.05.08	5	100%
<b>Нийт</b>				94.0%
<b>2025 онд</b>				
7	СЭМҮТ-ийн захирал	2025.02.07, 08/01	10	79.0%
<b>Нийт</b>				79.0%
<b>Ерөнхий хувь</b>				81.0%

## **ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил**

1. Нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулж тус байгууллагад байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг ар гэр нь авч зарцуулж Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хуулийн заалт зөрчигдөн нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулж байж болзошгүй зөрчлийг таслан зогсоох, сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг өөрсдийнх нь хэрэгцээт зүйлсэд зориулан зарцуулах боломж, нөхцөлийг сайжруулан ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн;
2. СЭМҮТ-ийн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйл, ЖЭТБХТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээг нарийвчлан тусгаж, төвийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/258 дугаар тушаалаар батлан, мөрдөж байна;
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сурталчлах арга хэмжээг байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тогтмол тусган, хэрэгжүүлж хэвшсэн;
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, ажилтны төлөөлөгч болон төвд байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах албан тушаалтныг томилон, түүний нэр, харилцах утас, цахим шуудангийн хаягийг нийт ажилтанд харагдахуйц газар буюу цаг бүртгэлийн хэсгүүдэд байршуулж, санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж хэвшсэн;
5. Төвийн бүх клиникийн байруудад засвар үйлчилгээг үе шаттай хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангасан түр амрах, хооллох зориулалтын өрөөг тус тус тохижуулсан;
6. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын цалин хөлсийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгасны дагуу сар бүр тогтсон өдөр олгож хэвшсэн;
7. Төвийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хурлаар сонгогдсон Үйлдвэрчний эвлэлийн шинэ даргыг Удирдлагын зөвлөлийн хурлаар батламжилсан бөгөөд үйл ажиллагаа хэвийн явагдаж байна;
8. СЭМҮТ-д “Байгууллагын сэтгэл зүйч”-ийн албан тушаалыг бий болгон, уг албан тушаалд мэргэжлийн сэтгэл зүйчийг томилон ажиллуулж байна;
9. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, үр дүнтэй явуулахад цэвэрлэгээний бараа материал, хог хаягдлын уут, аюулгүйн хайрцаг худалдан авах тендерийн хөрөнгө 2023 онд 20 сая төгрөг байсныг 2024 онд 85 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн;

10. Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах тендерийн төсөв 2023 онд 69 сая төгрөг байсныг 2024 онд 90 сая төгрөг болгон нэмэгдүүлж, тендерийн ажлын даалгаварт эмч, ажилтнуудын эрхэлж буй ажлын нөхцөл, ажил үүргийн болон улирлын онцлогт тохирсон ажлын гадуур хувцсаар хангах талаар оруулсан.

**Урьдчилан сэргийлэх ээлжит хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал:**



1. ЭХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.” гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, ЭХХШтХ, ШШГтХ, холбогдох захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй байна. Түүнчлэн Зөрчлийн тухай болон ЭХ-д заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн этгээдийн сэтгэцийн байдал нь тогтвортой, засрал сайжралын байдалд орсноор цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн шинжээчийн дүгнэлт, хяналтын прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг арга хэмжээг зогсоосон ч хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл эцэг эх, төрөл садан нь асран хамгаалалтдаа авахаас татгалзсаны улмаас албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй нөхцөл байдал хэвээр байна;
2. Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шинжлүүлэгчийг албадан эмчлүүлэгчидтэй хамтад нь байрлуулдаг;
3. СЭМҮТ-д байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэдийн тоо 2023 онд 232 байсан бол 2024 оны 11 дүгээр сарын байдлаар энэ тоо 244 болсон бөгөөд СЭМҮТ-ийн удирдлага энэ асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад удаа дараа хандаж байгаа хэдий ч шийдвэрлэгдээгүй хэвээр байна;
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А240/А369 хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын


арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих” журмын 4.8-д “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа СЭМҮТ нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” заалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй байгаа асуудал мөн шийдвэрлэгдээгүй;

5. Асрамжийн гэр төвд амьдарч буй зарим эмчлүүлэгч нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, “насны хишиг”-ийн мөнгийг өөрийн хэрэгцээтэй зүйлсэд захиран зарцуулах эрх нь хязгаарлагдаж байж болзошгүй байна. Төвөөр үйлчлүүлж буй бүх сэтгэцийн эмгэгтэй иргэдийн хүнсний бүтээгдэхүүн, эд юмсыг асрамжийн гэр төвийн нийгмийн ажилтан худалдан авч, авчирч өгдөг ч үйлчлүүлэгчийн хэрэгцээ, хүсэл сонирхол, шаардлагыг хангахгүй ахуйн эд зүйлсийг авчирч өгч байгаад тус төвөөр үйлчлүүлж буй зарим үйлчлүүлэгч сэтгэл хангалуун биш байна. Тухайлбал, тус асрамжийн төвийн ойролцоо байдаг хүнс, барааны дэлгүүрт өөрөө явж очоод хэрэгцээтэй зүйлсээ ялангуяа оймс, дотуур хувцсаа өөрөө худалдаж авмаар санагддаг гэж ярилцлагын явцад онцлон танилцуулж, тоо мэддэг, мөнгөөр худалдан авалт хийх чадвартай хүмүүс нь өөрсдөө тодорхой хэмжээний мөнгийг захиран зарцуулах хэрэгцээ, шаардлага байдаг тухайгаа хэлсэн;
6. Гишүүний “Иргэний үнэмлэхгүйн улмаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагддаггүй эмчлүүлэгчдийг бичиг баримтжуулах” зөвлөмжийн хүрээнд СЭМҮТ-д удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа гэр оронгүй, асран хамгаалагчгүй 5 эмчлүүлэгчийн иргэний үнэмлэхийг шинээр олгуулж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамруулах хүсэлтийг Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд албан бичгээр хүргүүлсэн тухай мэдэгдэж байсан ч энэ асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Тодруулбал, сэтгэцийн архаг өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай, урт хугацааны эмчилгээтэй 5 хэвтэн эмчлүүлэгч регистрийн дугааргүй бөгөөд дахин регистрийн дугаар нээлгэхэд шүүхийн байгууллагаар тухайн хүмүүсийн нас, хүйсийг тодорхойлуулах шаардлагатай болдог аж. БЗД-ийн Иргэний хэргийн шүүхэд хандахад тухайн хүмүүсийг хаягжилттай болгох шаардлага тавьдаг. СЭМҮТ-ийн хаягт бүртгүүлэхэд регистрийн дугаар шаардлагатай болдог энэ асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа. Эдгээр сэтгэцийн эмгэгтэй иргэд ийнхүү регистрийн дугааргүй байгаа тул Монгол Улсад бүртгэлгүй бөгөөд эдгээр иргэд нас барсан тохиолдолд оршуулах газар авах зэрэг асуудал хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байдаг талаар танилцуулж, энэ асуудалд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг ажлын хэсэгт тавьсан;

7. СЭМҮТ-ийн стационар хэвтүүлэн эмчлэх 550 ортой боловч сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэц нийгмийн сэргээн засах урт хугацааны эмчилгээ (эмийн биш), байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгээс гардаггүй 244 эмчлүүлэгч нийт орны 44.3 хувийг эзэлж байгаа асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Тус төвд байнга байрлаж байгаа

тэдгээр эмчлүүлэгчдийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад шилжүүлэх хүсэлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга Ц.Сарантуяад 2024 оны 10 дугаар сарын 29 өдрийн 2/962 тоот албан бичгээр, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2024 оны 11 дүгээр сарын 18 өдрийн 2/1044 тоот албан бичгээр, Монгол Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасанд тус тус хүргүүлсэн ч асуудал шийдвэрлэгдээгүй байна;



8. ШСЭСК-т албадан эмчлүүлэгчдийн батлагдсан орны тоо 37 боловч одоогоор нийт 43 хүн тус клиникт албадан эмчлүүлж зарим өрөөнд 11 хүн байгаа нь стандартын шаардлагыг хангахгүй байна;
9. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг ариун цэврийн өрөө хэрэглэдэг, тамхи татдаг хүмүүс уг ариун цэврийн өрөөнд тамхиа татдаг тул клиникийн дотор орчин тамхины эхүүн үнэртэй. Асуумжид оролцсон эмч, эмнэлгийн ажилтнууд "... сэтгэцийн эмгэгийн үндсэн клиник, донтох эмгэг судлалын клиникүүдэд эмчлүүлэгчид тамхи ихээр хэрэглэдгээс бид дам тамхидалтад байнга өртөж байна..." гэжээ;
10. Угтах хэсгийн санал хүсэлтийн хайрцаг доогуураа задарсан, ашиглах боломжгүй, эргэлт, уулзалтын өрөөнд засвар хийгдээгүй, тус өрөөнд байрлах мэдээллийн самбарт Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль (СЭМтХ)-ийн 10 дугаар зүйлд заасан сэтгэцийн эмгэгтэй хүний эрх, түүний хууль ёсны төлөөлөгчийн эрх, үүргийн талаар, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээний талаар, Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаал зэргийг тус тус байршуулсан хэдий ч мэдээллийн самбарыг хананд тогтоогоогүй цонхны тавцан дээр орхисон;
11. Номын санд бичиг үсэг заах, оюуны чадамжийг дээшлүүлэх, чөлөөт цагаа өнгөрөөх өрөө тасалгаатай. Ашиглагдаж буй номууд хэт хуучирсан ашиглах боломжгүй нөхцөл байдалтай;
12. Эрэгтэй албадан эмчлүүлэгчдийн байрладаг 305 дугаар өрөөнд агааржуулалтын хоолойгүй, эмэгтэй албадан эмчлүүлэгчдийн 302 дугаар өрөөний тааз нурсан, 306 дугаар өрөөний цонхны хэсгээр нуралт үүссэн, мөөгөнцөртэй, 301 дүгээр өрөөний цонхны дээд хэсгийн тааз болон дулааны шугамын арын хэсгийн шавардлага нурсан, шүршүүрийн "В" өрөөний дулааны шугамын арын хэсгээр мөөгөнцөртэй зэргээс үзэхэд барилгад засвар үйлчилгээ хийх шаардлага үүссэн;
13. Асрамжийн гэр төвийн хашаан доторх орчин хог хаягдал ихтэй.

Тус байгууллагад 2024 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үеэр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т зааснаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн бүрэн эрхийнхээ дагуу тавьсан шаардлагын биелэлтийг албан бичгээр ирүүлэхдээ "...Асрамжийн гэр төвийн хашаанд хуримтлагдсан барилгын засварын хог хаягдлыг цэвэрлэж, тохижилт хийж, эмчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллаж байна..." гэснийг газар дээр нь үзээд хангалттай биелэгдсэн гэж дүгнэх боломжгүй байна;



14. Асуумжид оролцсон эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд "... Байгууллагад ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамт байна. Энэ асуудлаар удирдлага, ёс зүйн хороо, үйлдвэрчний хороонд хандаж гомдол гаргаад дорвитой хариулт авч чадалгүй 2 сар гаруй хугацаа өнгөрсөн. Бэлгийн дарамт үзүүлээд байгаа хүн нь энэ байгууллагад ажилладаг гавьяат эмч бөгөөд энэ хүний бүх муу муухай зүйлсийг нь нуун дарагдуулж байгаад үнэхээр гомдолтой байна..." гэснээс үзэхэд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 01 дүгээр сарын 15-ны 08/02 дугаартай зөвлөмжөөр "Монгол Улсын ХТХ-ийн 7 дугаар зүйл, ЖЭТБХТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д заасны дагуу ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нарийвчлан тусгаж дарамт, хүчирхийлэл, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх" заалт бүрэн хэрэгжихгүй байгааг илтгэж байна;
15. Ажлын байрны дарамт, ажлын ачаалал хэт их, нэг хүнд ногдох эмчлүүлэгчийн тоо их, ажиллах орчныг сайжруулах дүрэмт хувцас хангалттай өгдөггүй гэх мэт СЭМҮТ-д хийдэг урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд асуумжид хөндөгддөг асуудлууд давтагдсан.



## Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж

Урьдчилан сэргийлэх ээлжит хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/01 дугаартай зөвлөмжийг СЭМҮТ-ийн захирал Г.Анхболдод хүргүүлсэн.



## ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлт

Гишүүний зөвлөмжийн биелэлтийг СЭМҮТ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Анхболдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/191 дугаартай албан бичгээр ирүүлсэн<sup>145</sup>.

Гишүүний зөвлөмжийн мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолоор баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгууллагын дотоод журмыг батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосон байдаг. Энэ хүрээнд тус байгууллагад хийсэн хяналт шинжилгээгээр илэрсэн ажлын байрны бэлгийн дарамт, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг нэн даруй Ёс зүйн дэд хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлэх, шийдвэрлэлтийн талаар эргэн танилцуулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор нийт ажилчдын санал асуулгаар төвийн дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн.
- Хүний нөөцийн хөгжлийн албаны мэргэжилтэн Б.Сарангэрэлийг Ерөнхийлөгчийн тамгын газар, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Зэлэм тархи” ТББ-ын хамтран хэрэгжүүлж буй сургагч

<sup>145</sup> СЭМҮТ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Анхболдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/191 дугаартай албан бичиг

багш бэлтгэх зөөлөн ур чадварын сургалтад хамруулан, сургагч багшаар бэлтгэсэн. Энэхүү сургалтын хөтөлбөрийн дагуу “Стрессийг таньж түүнээс ангижрах тухай” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

2. “Сэтгэцийн эмгэгтэй асруулагчдыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ИХШХШТХ)-ийн 141 дүгээр зүйлийн 141.1 дэх хэсэгт заасны дагуу сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг мөн зүйлийн 141.2 дахь хэсэгт заасны дагуу оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд асран хамгаалах байгууллага гаргаж, сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгүүлж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулж, харгалзан дэмжигч, асран хамгаалалтыг шүүхээр тогтоолгох. Тус асуудлаар өмгөөллийн хууль зүй туслалцаа үзүүлдэг фермтэй албан ёсоор гэрээ байгуулан, хуулийн этгээдийн төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлж ажиллах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Урт хугацаагаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулж, харгалзан дэмжигч, асран хамгаалалтыг шүүхээр тогтоолгох асуудлыг судалж, уг асуудлаар өмгөөллийн хууль зүй фермтэй албан ёсоор гэрээ байгуулан ажиллахаар шийдвэрлэсэн.

3. “ШСЭСК-ийн байранд нэгдсэн урсгал засвар хийх, уулзалтын өрөөг сэргээн засах, мэдээллийн самбарыг байршуулах, тамхи татах хэсгийг оновчтой зохион байгуулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ШСЭСК-ийн эргэлтийн өрөөг тус клиникийн орох хэсэгт шинээр зохион байгуулж, вакум хаалт бүхий өрөөг хийсэн. Эргэлтийн өрөөний тав тухыг бүрдүүлэх зорилгоор буй буйдан ширээ, ар гэр, асран хамгаалагчид мэдээлэл өгөх мэдээллийн самбарыг байршуулсан.

4. “Энгийн иргэдтэй адил өдөр тутмын сонин сэтгүүл, ном унших боломж төдийлөн байхгүй ч тусгай хэрэгцээнд тулгуурласан танин мэдэхүйн чиглэлийн ном, сонин сэтгүүлээр номын санг сэлбэж, унших цаг тусгайлан гаргах зэрэг арга туршлагыг эмчилгээний нэг хэлбэр болохуйц байдлаар хэрэглэхээр тус өрөөг тохижуулах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ШСЭСК-ийн эмчлүүлэгчийн идэвхжүүлэх өрөөний хана, таазанд засвар хийж, эмчлүүлэгчид ая тухтай орчин бүрдүүлсэн.

5. “Асрамжийн төвийн хашаанд хуримтлагдсан барилга засварын хог хаягдлыг цэвэрлэж тохижилт хийж, эмчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Хашаанд хуримтлагдсан барилгын засварын хог хаягдлыг ачуулж цэвэрлэсэн. Тохижилтын ажлыг дулааны улиралд хийж, эмчлүүлэгчдийн хашааг зүлэгжүүлж мод тарихаар төлөвлөсөн.

6. “Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг эрхэлж буй ажлын нөхцөлийг сайжруулах ялангуяа өрөө тасалгааны тав тухтай байдлыг хангах, ажил үүргийн болон улирлын онцлогт тохирсон дүрэмт хувцасны хангалтыг нэмэгдүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авч ажиллах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ШСЭСК-ийн ажилчдын хувцас солих өрөөнд бүрэн засвар хийж, эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувцас солих өрөөг тус тус бий болгон тохижуулсан.

7. “Хууль зүй дотоод хэргийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 5.4.5 дахь хэсэг “эмчлүүлэгч нь өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй үйлдэл хийхээр завдсан, эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд үзүүлж буй эсэргүүцлийн шинж, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан тусгай хэрэгсэл (резинэн бороохой, гав, нулимс асгаруулагч хий, хүлэг, ороох цамц, зөөлөн даруулга)-ийг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэглэж, энэ тухай тэмдэглэл үйлдэж, харуул хамгаалалтын хэсгийн даргад танилцуулна...” гэсний дагуу Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт 24 цагаар төмөр гав хэрэглэж байгаа эмчлүүлэгчдийг хүний эрх,эрүүл мэндэд ээлтэй байдлаар өөрчлөх буюу хүнлэг хандах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Улсын ерөнхий прокурор, Нийслэлийн прокурорын газрын төлөөллүүд 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр тус төвд ирж 2 өдөр ажилласан бөгөөд энэ хүрээнд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай санал солилцсон. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын төслийн 5.7.4 дэх заалтад (номхотгох аргыг холбогдох хууль дүрэм, журамд заасны дагуу хэрэглэж, тэмдэглэл үйлдэж, харуул хамгаалалтын ахлах ажилтанд танилцуулах) тусгагдсан байгаа тул уг журам шинэчлэгдэн батлагдсаны дараа хэрэгжүүлэн ажиллах боломжтой болно.
- “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын төсөл шинэчлэгдэн батлагдсаны дараа эмнэлгийн зориулалт бүхий номхотгох, даруулга хэрэглэх хэрэгслийн үнийн саналыг авч, худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

8. “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн тус эмнэлгийн дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж (камер) ашиглах журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Төвийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/57 дугаар тушаалаар “Хяналтын камерын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам” батлан, мөрдөж ажиллаж байна.

9. “ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн нийтэд танилцуулж болох хэсгийг албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийн талаар албан хаагч нарт тайлагнадаг байх” зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг удирдлагын зөвлөлийн хурал, нийт эмч нарын хурал, албадын өргөтгөсөн хуралд тус тус танилцуулсан.

## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд нийт 5 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Тайлант хугацаанд тус байгууллагад нийт 3 удаа ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн бөгөөд нэг удаад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсик, Мартин Зинклер, Хүний эрхийн дээд комиссарын газрын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга, Армен Авестинан, Хүний эрхийн дээд комиссарын газрын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ явуулсан.

Тайлант хугацаанд явуулсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, асуумж ярилцлагад оролцох боломжтой гэж үзсэн 19 эмчлүүлэгч, 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийн, 9 эмчлүүлэгч, 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаас асуумж авсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн ерөнхий хувь 81.0 гэж үнэлэгдсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлаас 2013 онд батлан, хэрэгжүүлж буй Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхтэй холбоотой дараах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үүнд:

- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэд (2025 оны 03 дугаар сарын байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нийт орны 50 орчим хувийг эзлэн байнга байрлан эмчлүүлж буй 244 иргэн байгаа бөгөөд энэ тоо жил тутамд өсөж байна)-д зориулсан асрамжийн үйлчилгээг бий болгох асуудал;
- Хүн амд, ялангуяа ерөнхий боловсролын болон их дээд сургууль, коллежид суралцагчдад эрүүл мэндийн мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин

чармайлтыг дэмжих, урамшуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх асуудал;

- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, үндэсний хөтөлбөрүүдийг сурталчлах нийслэлд болон орон нутагт нийгэм хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээ үзүүлэх төсөв санхүүжилтийн асуудал;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ачааллыг багасгах, төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах асуудал;
- Эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлал, албан тушаалын ангилал, зэрэглэлийг ажлын ачаалал, гүйцэтгэл, хариуцлага, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл, онцлогтой уялдуулан тогтоох, хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх асуудал;
- Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалттай холбоотой асуудал.

2. Нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулж тус байгууллагад байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг ар гэр нь авч зарцуулж Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хуулийн заалт зөрчигдөн нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулж байж болзошгүй зөрчлийг таслан зогсоох, сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг өөрсдийнх нь хэрэгцээт зүйлсэд зориулан зарцуулах боломж, нөхцөлийг сайжруулан ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна;

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор нийт ажилчдын санал асуулгаар төвийн дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн;

4. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн эргэлтийн өрөөг тус клиникийн орох хэсэгт шинээр зохион байгуулж, вакум хаалт бүхий өрөө бий болгон, уг эргэлтийн өрөөний тав тухыг бүрдүүлж буйдан, ширээ, ар гэр, асран хамгаалагчид мэдээлэл өгөх мэдээллийн самбар зэргийг байршуулсан;

5. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн эмчлүүлэгчийн “Идэвхжүүлэх өрөө”-ний хана, таазанд засвар хийж, эмчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүлсэн;

6. “Асрамжийн гэр төв”-ийн хашаанд хуримтлагдсан барилгын засварын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, дулааны улиралд зүлэгжүүлж, мод тарихаар бэлтгэл ажлыг хангаж байна;

7. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн ажилчдын хувцас солих өрөөнд бүрэн засвар хийж, эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувцас солих өрөөг тус тус бий болгон тохижуулсан;

8. Төвийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/57 дугаар тушаалаар “Хяналтын камерын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам” батлан, мөрдөж ажиллаж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжид тусгагдсан дараах асуудалд анхаарч холбогдох арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.” гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй асуудал;
2. Зөрчлийн тухай болон ЭХ-д заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн этгээдийн сэтгэцийн байдал нь тогтвортой, засрал сайжралын байдалд орсноор цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн шинжээчийн дүгнэлт, хяналтын прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг арга хэмжээг зогсоосон ч хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл эцэг эх, төрөл садан нь асран хамгаалалтдаа авахаас татгалзсаны улмаас албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй асуудал;
3. Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шинжлүүлэгчийг албадан эмчлүүлэгчидтэй хамтад нь байрлуулж буй асуудал;
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А240/А369 хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих” журмын 4.8-д “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” заалтыг хэрэгжүүлэх асуудал. Өөрөөр хэлбэл асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй байгаа асуудал.

## САНАЛ

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эрчимжүүлэх;
2. Сэтгэцийн архаг өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай, урт хугацааны эмчилгээтэй 5 хэвтэн эмчлүүлэгч (нэг нь хятад иргэн)-ийг Монгол Улсын бүртгэлд оруулж, улмаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамруулах;
3. СЭМҮТ-ийн нийт орны 44.3 хувийг эзлэн тус байгууллагад байнга байрлаж буй сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэц нийгмийн сэргээн засах урт хугацааны



эмчилгээ (эмийн биш), байнгын асаргаа шаардлагатай 244 эмчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэж, тус эмнэлгийн байгууллагын орны эргэлтийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах;

4. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй 42 эмчлүүлэгчийн хоол, хүнс болон ажилтнуудын нормын хувцасны зардлын санхүүжилтийг шийдвэрлэх;
5. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт албадан эмчлүүлж буй сэтгэцийн байдал нь тогтворжсон, засрал сайжрал авсан, цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэж шинжээчийн дүгнэлт гарсан 5 иргэнийг хууль ёсны төлөөлөгч, ар гэрт нь хүлээлгэж өгөх асуудлыг шийдвэрлэх;
6. ЭХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.” гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭХ, ЭХХШтХ, ШШГтХ, холбогдох захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй байна. Түүнчлэн Зөрчлийн тухай болон ЭХ-д заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн этгээдийн сэтгэцийн байдал нь тогтвортой, засрал сайжралын байдалд орсноор цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн шинжээчийн дүгнэлт, хяналтын прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг арга хэмжээг зогсоосон ч хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл эцэг эх, төрөл садан нь асран хамгаалалтдаа авахаас татгалзсаны улмаас албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй асуудлыг шийдвэрлэх;
7. Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шинжлүүлэгчийг албадан эмчлүүлэгчидтэй хамтад нь байрлуулж буй асуудлыг шийдвэрлэх.

## 2.6 УЛААНБААТАР ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 032 ДУГААР АНГИЙН ЦЭРГИЙН САХИЛГЫН БАЙРАНД ХИЙСЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Саатуулах байранд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилттэй танилцах, эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор хоёр удаа ажилласан.<sup>146</sup>



Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд холбогдох 8 албан тушаалтан, алба хаагчидтай ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлага хийж, орчин, ахуй нөхцөлтэй танилцахад дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

### Саатуулах байрны эрх зүйн орчин, нөхцөл байдал

Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын тэргүүн зөвлөх Ш.Нямдоржийн “Зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 1/6221 дугаартай албан бичгээр уг Саатуулах байранд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгожээ.

Саатуулах байрны үйл ажиллагаанд дагаж мөрддөг эрх зүйн голлох баримт, бичиг болох “Сахилгын шийтгэл эдлүүлэхээр сахилгын хорих байранд тусгаарлан саатуулах журам”-ыг Прокурорын байгууллага 2022 онд хүчингүй болгосон тухай танилцуулсан бөгөөд энэхүү нөхцөл байдлаас үзэхэд тус байгууллага нь мөрдлөг болгох эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиггүйгээр цэргийн алба хаагчийг тусгаарлан саатуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна гэж дүгнэсэн.

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-т заасан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн дагуу Зэвсэгт хүчний жанжин штабын Хуулийн хэлтэст боловсруулсан Сахилгын тусгаарлан саатуулах байрны ажиллах журмын төсөлтэй танилцан уг төсөл нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж буй эсэхэд санал боловсруулан Гишүүний “Журмын төсөлд санал хүргүүлэх тухай” 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 08/364 дугаартай албан бичгээр холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

<sup>146</sup> ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх “01” дугаартай удирдамж

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Саатуулах байранд 2019-2024 онд саатуулагдсан цэргийн алба хаагчийн мэдээллийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 26

№	Он	Саатуулагдсан цэргийн алба хаагчийн тоо	Анги
1	2019 он	9	ЗХ-ний 032-р ангиас-7 /ахлагч-2, хугацаат цэргийн алба хаагч-5/ ЗХ-ний 311-р ангиас-1 /ахлагч/ ЗХ-ний 013-р ангиас-1 /хугацаат цэргийн алба хаагч/
2	2020 он	2	ЗХ-ний 032-р ангиас-1 /хугацаат цэргийн алба хаагч/ ЗХ-ний 142-р ангиас-1 /ахлагч/
3	2021 он	Байхгүй	
4	2022 он	1	ЗХ-ний 015-р ангиас-1 /хугацаат цэргийн алба хаагч/
5	2023 он	10	ЗХ-ний 032-р ангиас-9 /хугацаат цэргийн алба хаагч/ ЗХ-ний 150-р ангиас-1 /цэргийн гэрээт алба хаагч/
6	2024 он	1	ЗХ-ний 314-р ангиас-1 /ахлагч/
		<b>Нийт</b>	<b>23</b>

### **Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал**

1. ЭШУС үндэсний ажиллагаанаас Саатуулах байранд 2023 онд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд Монгол Улсын ХЭҮКТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3-т зааснаар Гишүүн бүрэн эрхийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж “Саатуулагдсан цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн үзлэгийн бүртгэл”, “Дамжин өнгөрүүлэх буудалд ирсэн цэргийн алба хаагчдын үзлэгийн бүртгэл”, “Саатуулах байрны жижүүрийн амин үзүүлэлтийн бүртгэл”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл”-ийн дэвтрийн загвар боловсруулсан хэдий ч Саатуулах байрны эмчийн албан өрөөнд Албан тушаалын тодорхойлолт болон ажлын байрны чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн болоод холбогдох бусад чиглэлийн баримт бичиг, удирдамж, заавар байхгүй байна;



2. Эмчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх наад захын багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл байхгүй байх бөгөөд өөрийн хувийн чагнуур,

цусан дахь хүчил төрөгч хэмжигч зэргийг зарим үед ажлын байрандаа авчирч ашиглаж байгаа тухай танилцуулсан;

- Түүнчлэн эмчийн өрөөнд байгаа ихэнх эм, эмийн бэлдмэлийн болон зарим эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан байдалтай байна. Тухайлбал шилэн савтай, “Новокаин” гэх бичигтэй тариа мэт шингэний хүчинтэй хугацаа 2023 оны 02 дугаар сард, “Адреналин” гэх бичигтэй тариа мэт шингэний хүчинтэй хугацаа 2023 онд, “Дибазол” гэх бичигтэй тариа мэт шингэний хүчинтэй хугацаа 2024 оны 06 дугаар сард, “Дологонын ханд”, “Бамбайн ханд” нэртэй эмийн бэлдмэлийн хүчинтэй хугацаа 2024 оны 03 дугаар сард тус тус дууссан байсныг урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үеэр баримтжуулсан;



- Саатуулах байрны үйл ажиллагаанд зориулсан тусгайлсан төсөвгүй, Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн төсөвт Саатуулах байрны алба хаагчдын цалин хөлсний зардал болон байрны урсгал зардал тусгагддаг талаар тус ангийн захирагч танилцуулсан бөгөөд төсвийн хуваарилалт, зарцуулалтыг танилцуулахаас татгалзсан.



### **Саатуулах байрны барилгын орчин нөхцөлтэй холбоотой тогтоогдсон нөхцөл байдал**

1. Саатуулах байрны барилга нь 1984 онд баригдсан насжилт өндөртэй барилга бөгөөд агааржуулалтын систем ажилладаггүй, цонхнууд цантаж мөстсөн, таазанд заадас үүссэн, дусаал гоождог, хана их хэмжээгээр мөөгөнцөртсөн, шавардлага ховхорч унасан, хана болон шалны хүрээ хооронд завсар заадас үүссэн, нурж болзошгүй, саатуулагдсан цэргийн алба хаагчид болон тус байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал үүссэн;



2. Өрөөнүүдийн чийгшил 65-72 хувь, гэрэлтүүлэг 144 т, тус байранд хөтлөгдсөн Температурын дэвтэрт 2024 оны байрны температурыг 13-19 хэмийн хэлбэлзэлтэйгээр өдөр бүр тэмдэглэсэн байх хэдий ч дулааны үзүүлэлтийг дулаан хэмжигч төхөөрөмжөөр хэмжиж үзэхэд 14,5-15 хэм буюу зохих шаардлагыг хангахгүй үзүүлэлттэй, эмэгтэй цэргийн алба хаагчийг саатуулах өрөөний гэрлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, анивчсан байдалтай бөгөөд нэг хүнд ноогдох талбайн хэмжээ зохих шаардлагыг хангаагүй буюу 1,4 метр квадрат талбайтай гурван өрөө байх ба бүх орны гудас, дэвсгэр, дэр, бусад эд зүйлс эрүүл ахуйн шаардлагыг илтэд хангахгүй, бохир байна.

### **Саатуулах байрны алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлтэй холбоотой тогтоогдсон нөхцөл байдал**

1. Алба хаагчид, ялангуяа харуул хамгаалалтын ээлжид ажиллаж буй алба хаагчид эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй, хөгцтэй, мөөгөнцөртэй, агааржуулалтгүй, онцгой эхүүн хурц үнэртэй, илтэд хүнд нөхцөлтэй орчинд 24 цагаар жижүүрлэн ажилладаг;



2. Алба хаагчдыг ажлаа тараад гэртээ харихад "...танаас ямар муухай үнэр үнэртээд байгаа юм бэ..." гэж үр хүүхэд, гэр бүлийн гишүүд нь байнга хэлдэг, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангахгүй энэхүү нөхцөл байдлаас үүдэн нийт алба хаагчдын толгой өвдөж, хамар битүүрэн найтаалгадаг бол зарим алба хаагчдын биед харшлын тууралт гарч, халуурдаг тухай ажлын хэсэгт танилцуулсан. Ээлжийн дарга болон бусад алба хаагч нар энэхүү нөхцөл байдлын талаар байгууллагын удирдлагад танилцуулсаар ирсэн хэдий ч өнөөг хүртэл дорвитой арга хэмжээ авагдаагүй байна;
3. Түүнчлэн ээлжийн алба хаагч нар 24/48 цагаар ажиллаж байгаа гэж танилцуулснаас үзэхэд тус Саатуулах байрны алба хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байж болзошгүй байна;

*...Саатуулах байрны удирдлага, алба хаагч нар Саатуулах байранд үйлчлэх хууль тогтоомж, журмын талаар мэдээлэлгүй, эрх зүйн баримт бичгийн бүрдүүлбэргүй бөгөөд мөрдлөг болгох эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиггүйгээр цэргийн алба хаагчийг тусгаарлан саатуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна...*

*...Саатуулах байрны барилга нь 1984 онд баригдсан насжилт өндөртэй барилга бөгөөд агааржуулалтын систем ажилладаггүй, цонхнууд цантаж мөстсөн, таазанд заадас үүссэн, дусаал гоождог, хана их хэмжээгээр мөөгөнцөртсөн, шавардлага ховхорч унасан, хана болон шалны хүрээ хооронд завсар заадас үүссэн, нурж болзошгүй, саатуулагдсан цэргийн алба хаагчид болон тус байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал үүсжээ...*

*...Эмчийн өрөөнд байгаа ихэнх эм, эмийн бэлдмэлийн болон зарим эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан байна...*

*Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах  
Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Саатуулах байранд  
хийсэн Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр  
тогтоогдсон нөхцөл байдлаас*

### **ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмж**

Аливаа хэлбэрээр саатуулагдсан хүмүүсийн заяагдсан нэр хүндийг хүндэтгэх, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хангах, хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байхыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан байдаг.

Тухайлбал НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлд "Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ" гэж заасан.


НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 43/073 дугаар тогтоолоор баталсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-ын 1 дүгээр зарчимд "Аливаа нэг хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгөө энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндээ хүндэтгүүлэх эрх эдлэх ёстой", 4 дүгээр зарчимд "Аливаа хэлбэрээр



саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрхийг хөндсөн бүх арга хэмжээнүүд хийгээд аливаа хэлбэрээр саатуулах болон хорих ажиллагаа нь шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын тогтоолоор хийгдэх бөгөөд тэдгээрийн үр нөлөөтэй хяналтад байх ёстой”, 6 дугаар зарчимд “Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэж шүүх буюу хэрцгий хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэж болохгүй” гэж заасан.

Түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг; Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйл, Алагчилахгүй байх тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцын 2 дугаар зүйлд хөдөлмөрлөх, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах эрхүүдийг тус тус баталгаажуулсан.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 11 дүгээр зүйлд “Оролцогч улсууд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор түүний харьяа нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсээс мэдүүлэг авахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгсэл, түүнчлэн тэднийг ханган харгалзах, тэдэнтэй харьцах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд шат дараалсан хяналт тавина” гэж заасан.



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах...”, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр

хангагдах, ..., амрах” гэж хуульчилсан байдаг.

Иймд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйл болон Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайханд нарт зөвлөмж хүргүүлсэн.147 148

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогтод хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт 40.0 хувьтай буюу “хэрэгжилт хангалтгүй” гэж үнэлэгдсэн тул холбогдох албан

147 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайханд хүргүүлсэн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08/03 дугаартай зөвлөмж

148 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогтод хүргүүлсэн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/02 дугаартай зөвлөмж

тушаалтнуудтай уулзалт хийж, тодруулга, мэдээлэл авч хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлээгүй заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсон, хэрэгжүүлэх арга зам, ойлголтыг дахин зөвлөсөн.

Зөвлөмжийн хэрэгжилтийг нэмэлтээр авч дахин үнэлэн, тогтоогдсон зөрчлүүдийг арилгах хүртэл харилцан холбоотой ажиллаж биелэлтийг хангуулснаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогтод хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт 94.0 хувьтай үнэлэгдэн, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн ерөнхий хувь 82.0 хувьтай үнэлэгдсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Сахилгын тусгаарлан саатуулах байрны эрх зүйн орчин, нөхцөл байдлыг сайжруулах ажлын хүрээнд Монгол Улсын ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/31, А/74 дүгээр хамтарсан тушаалаар “Сахилгын тусгаарлан саатуулах байрны ажиллах журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус журамд саатуулагдсан цэргийн алба хаагчийг хүлээн авч бүртгэх, түүний эрүүл ахуй, ахуй хангалт, байрны нөхцөл, бусадтай уулзах, түр гаргах суллах, саатуулах байрны үйл ажиллагаанд тавих хяналтын талаар тусгасан. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд мөрдөх 13 баримт бичгийг шинэчлэхээр төслийг боловсруулсан;
2. ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, Цэргийн албаны хэлтсийн албан тушаалтнууд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд шалган туслах ажлыг тус тус явуулж, холбогдох албан тушаалтнуудад цаашид авч хэрэгжүүлэх, сайжруулах ажлын талаар үүрэг, зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавьж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын төлөвлөгөөнд 18, ангийн төлөвлөгөөнд 21 арга хэмжээг тус тус тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
3. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад баримт бичгийн санг бүрдүүлсэн;
4. Сахилгын тусгаарлан саатуулах байранд саатуулагдсан алба хаагчдын мэдээллийг бүртгэлжүүлэн, цахим болон цаасан суурьтай мэдээллийн сан үүсгэсэн;
5. Сахилгын тусгаарлан саатуулах байранд мөрдөгдөх хууль тогтоомж, журмын талаар хууль, эрх зүйн хичээлийн 20 цагийн хөтөлбөр боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, цэргийн цагдаагийн ротын хуулийн офицеруудтай хамтран ажиллаж долоо хоногт 12 цагийн сургалтад Сахилгын тусгаарлан саатуулах байрны бие бүрэлдэхүүнийг хамруулж байна. ЗХЖШ-аас Жендэрийн Үндэсний хороо, ХЭҮК-той хамтран ажиллаж Зэвсэгт хүчний жендэр хариуцсан албан тушаалтнуудын арга зүйн цугларалтыг 2025 оны 02 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Жендэрийн бодлогын төлөвлөлт ба тэгш

оролцоог хангах нь” сэдэвт сургалтад 80 цэргийн алба хаагчийг хамруулж нэгтгэл, анги, салбартаа жөндөрийн эрх тэгш байдлыг хангах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулж нэгдсэн ойлголтод хүрсэн;

6. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, ЭШУС чиглэлийн мэдээллийн самбаруудын эхийг бэлтгэн хэвлүүлж, цэргийн цагдаагийн ротын Саатуулах байр, дамжин өнгөрүүлэх буудлын байранд байршуулсан. Хүний эрх, эрх чөлөөг хангах болон Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой материалуудыг бүрдүүлж, хууль, эрх зүйн мэдээллийн булан байгуулсан;
7. ХтХ тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Сахилгын тусгаарлан саатуулах байрны алба хаагчдын ээлжийн жижүүрийн хуваарийг 24, 72 цагаар зохион байгуулсан;
8. Сахилгын тусгаарлан саатуулах байрны бүх өрөөний шүүгээ, сандал, ор дэрний хоёр ээлжийн цагаан хэрэглэл, гудас, орны бүтээлэг, нүүр, гарын алчуур, улавчийг шинэчилсэн. Чийгшил болон дулаан хэмжигч 3 ширхэг төхөөрөмж байршуулсан бөгөөд үзүүлэлтийг өдөр бүр хэмжин хянаж, бүртгэж байна. Байрны дулаан алдалтыг багасгаж, +18°C-ын хэмээс дээш үзүүлэлттэй байх боломжийг бүрдүүлсэн. Эмэгтэй цэргийн алба хаагчийг саатуулах өрөөний гэрлийг сольж, гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангасан;
9. ЗХЖШ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч, хошууч Ш.Ундармаагийн 2025 оны 6/147 дугаартай дүгнэлтэд Сахилгын тусгаарлан саатуулах байрыг цаашид Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНБД 13-04-03/-ын дагуу их засвар хийх шаардлагатай гэж дүгнэгдсэн. Энэ хүрээнд Сахилгын тусгаарлан саатуулах байрны засварт шаардагдах 111,356,374 сая төгрөгийн бараа материалын тооцоонд ЗХЖШ-ын дарга цохолт хийсэн бөгөөд Материал техникийн газрын даргад хүргүүлэн асуудлыг иж бүрнээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна;



Эмнэлгийн үзлэг, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, эм, ороох боох материалын тооцоог хийж, ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст хүргүүлэн 17 нэр төрлийн 140,000 төгрөгийн эм, тариа, 8 нэр төрлийн 2,100,000 төгрөгийн багаж, 6 нэр төрлийн 45,000 төгрөгийн ороох боох материал, нийт 31 нэр, төрлийн 2,285,000 төгрөгийн өртөг бүхий зүйлсийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус ангийн эрүүл мэндийн төвд хүлээж авсан. Сахилгын тусгаарлан саатуулах байранд “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний жагсаалт” боловсруулан, ангийн захирагчаар батлуулсан. Ашиглалтын хугацаа дууссан эм, ороох боох материалуудыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалаар баталсан MNS-6655-2017 стандартын дагуу “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу устгалд оруулсан. Эмчийн ажлын байрны чиг, үүрэгтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлсэн.

Хүснэгт 27

№	Зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан	Огноо, дугаар	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
<b>2022 онд</b>				
1	Батлан хамгаалахын сайд	2025.02.07, 08/02	7	94%
2	Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч	2025.02.13, 08/03	7	70%
<b>Ерөнхий хувь</b>				<b>82.0%</b>

### ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Саатуулах байранд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх нэг удаагийн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас 2024 он, 2025 оны нэгдүгээр улиралд нийт хоёр удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 8 албан тушаалтан, алба хаагчтай ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлага хийж, орчин, ахуй нөхцөлтэй танилцсан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/02 дугаартай зөвлөмжийг Монгол Улсын Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08/03 дугаартай зөвлөмжийг Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайхан нарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 “Хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах,” гэж заасан бүрэн эрхийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан тушаалаар батлах “Сахилгын тусгаарлан саатуулах байрны ажиллах журам”-ын төсөлд тусгах саналыг боловсруулан хүргүүлсэн.149

Зөвлөмжийн биелэлтийг Зэвсэгт хүчний жанжин штабын Нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ж.Өсөхбаярын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 02/703, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 101 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн бөгөөд зөвлөмжүүдийн биелэлтийн ерөнхий хувь 82.0 хувьтай үнэлэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

1. Сахилгын тусгаарлан саатуулах байрны эрх зүйн орчин, нөхцөл байдлыг сайжруулах ажлын хүрээнд Монгол Улсын ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/31, А/74 дүгээр хамтарсан тушаалаар “Сахилгын тусгаарлан саатуулах байрны ажиллах журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус журамд саатуулагдсан цэргийн алба хаагчийг хүлээн авч бүртгэх, түүний эрүүл ахуй, ахуй хангалт, байрны нөхцөл, бусадтай уулзах, түр гаргах суллах, саатуулах байрны үйл ажиллагаанд тавих хяналтын талаар тусгасан. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд мөрдөх 13 баримт бичгийг шинэчлэхээр төслийг боловсруулсан;
2. ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, Цэргийн албаны хэлтсийн албан тушаалтнууд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд шалган туслах ажлыг тус тус явуулж, холбогдох албан тушаалтнуудад цаашид авч хэрэгжүүлэх, сайжруулах ажлын талаар үүрэг, зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавьж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын төлөвлөгөөнд 18, ангийн төлөвлөгөөнд 21 арга хэмжээг тус тус тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
3. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад баримт бичгийн санг бүрдүүлсэн;
4. Сахилгын тусгаарлан саатуулах байранд саатуулагдсан алба хаагчдын мэдээллийг бүртгэлжүүлэн, цахим болон цаасан суурьтай мэдээллийн сан үүсгэсэн;

149 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний “Журмын төсөлд санал хүргүүлэх тухай” 2025 оны 08/364 дугаартай албан бичиг.

5. Сахилгын тусгаарлан саатуулах байранд мөрдөгдөх хууль тогтоомж, журмын талаар хууль, эрх зүйн хичээлийн 20 цагийн хөтөлбөр боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, цэргийн цагдаагийн ротын хуулийн офицеруудтай хамтран ажиллаж долоо хоногт 12 цагийн сургалтад Сахилгын тусгаарлан саатуулах байрны бие бүрэлдэхүүнийг хамруулж байна. ЗХЖШ-аас Жендэрийн Үндэсний хороо, ХЭҮК-той хамтран ажиллаж Зэвсэгт хүчний жендэр хариуцсан албан тушаалтнуудын арга зүйн цугларалтыг 2025 оны 02 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Жендэрийн бодлогын төлөвлөлт ба тэгш оролцоог хангах нь” сэдэвт сургалтад 80 цэргийн алба хаагчийг хамруулж нэгтгэл, анги, салбартаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулж нэгдсэн ойлголтод хүрсэн;
6. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, ЭШУС чиглэлийн мэдээллийн самбаруудын эхийг бэлтгэн хэвлүүлж, цэргийн цагдаагийн ротын Саатуулах байр, дамжин өнгөрүүлэх буудлын байранд байршуулсан. Хүний эрх, эрх чөлөөг хангах болон Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой материалуудыг бүрдүүлж, хууль, эрх зүйн мэдээллийн булан байгуулсан;
7. ХтХ тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Сахилгын тусгаарлан саатуулах байрны алба хаагчдын ээлжийн жижүүрийн хуваарийг 24, 72 цагаар зохион байгуулсан;
8. Сахилгын тусгаарлан саатуулах байрны бүх өрөөний шүүгээ, сандал, ор дэрний хоёр ээлжийн цагаан хэрэглэл, гудас, орны бүтээлэг, нүүр, гарын алчуур, улавчийг шинэчилсэн. Чийгшил болон дулаан хэмжигч 3 ширхэг төхөөрөмж байршуулсан бөгөөд үзүүлэлтийг өдөр бүр хэмжин хянаж, бүртгэж байна. Байрны дулаан алдалтыг багасгаж, +18°C-ын хэмээс дээш үзүүлэлттэй байх боломжийг бүрдүүлсэн. Эмэгтэй цэргийн алба хаагчийг саатуулах өрөөний гэрлийг сольж, гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангасан;
9. ЗХЖШ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч, хошууч Ш.Ундармаагийн 2025 оны 6/147 дугаартай дүгнэлтэд Сахилгын тусгаарлан саатуулах байрыг цаашид Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНБД 13-04-03/-ын дагуу их засвар хийх шаардлагатай гэж дүгнэгдсэн. Энэ хүрээнд Сахилгын тусгаарлан саатуулах байрны засварт шаардагдах 111,356,374 сая төгрөгийн бараа материалын тооцоонд ЗХЖШ-ын дарга цохолт хийсэн бөгөөд Материал техникийн газрын даргад хүргүүлэн асуудлыг иж бүрнээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна;

Эмнэлгийн үзлэг, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, эм, ороох боох материалын тооцоог хийж, ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтэст хүргүүлэн 17 нэр төрлийн 140,000 төгрөгийн эм, тариа, 8 нэр төрлийн 2,100,000 төгрөгийн багаж, 6 нэр төрлийн 45,000 төгрөгийн ороох боох материал, нийт 31 нэр, төрлийн 2,285,000 төгрөгийн өртөг бүхий зүйлсийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус ангийн эрүүл мэндийн төвд хүлээж авсан.



Сахилгын тусгаарлан саатуулах байранд “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний жагсаалт” боловсруулан, ангийн захирагчаар батлуулсан. Ашиглалтын хугацаа дууссан эм, ороох боох материалуудыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалаар баталсан MNS-6655-2017 стандартын дагуу “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу устгалд оруулсан. Эмчийн ажлын байрны чиг, үүрэгтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлсэн.





## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

### 3.1 ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ

Монгол Улсад ЭШУС чиглэлээр дагнасан механизм байгуулагдан ажилласан туршлага ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдахаас өмнөх хугацаанд байгаагүй бөгөөд энэ чиглэлийн гарын авлага, сурах бичиг, бусад материал байгаагүй тул ЭШУС үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас эхлэн эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ, бусад Оролцогч улсын УСҮБ-ын мэдээллийн санг бүрдүүлж, Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааг тэдэнд таниулан сурталчлах, цаашид хамтран ажиллах зорилгыг эрэлхийлэн ажилласнаар 2023 оны хоёрдугаар хагаст өмнөх хугацаанд тогтоосон харилцаа холбоо, хамтын ажиллагааны яриа хэлцлүүд ажил хэрэг болж, ОУБ-уудтай хамтран ажиллаж, бусад улсын УСҮБ-тай харилцан туршлага солилцож, албан хаагчдыг чадавхыг бэхжүүлэх сургалт, бусад арга хэмжээнд хамруулах үйл ажиллагааг эхлүүлсэн.

НҮБ-ын ЭШУС Дэд хорооны төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн хоёр дахь удаагийн айлчлалын хүрээнд ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсиқ, Мартин Зинклер, ХЭДКГ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга, Армен Авестиан, ХЭДКГ-ын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт нар Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдад Эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч чадавхжуулсан.



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакландыг 2024 оны 09 дүгээр сард Монгол Улсад урин ирүүлж, ЭШУС үндэсний ажиллагааны нийт албан хаагч нар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт”, “Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг үр дүнтэй явуулах нь” сургалтад хамрагдаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг авсан.



Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэний нийгмийн байгууллагаас зохион байгуулсан “Эрх чөлөөгөө хасуулсан газруудад гомдол мэдээлэл хүлээн авах механизм” сэдэвт хэлэлцүүлэг, Ази-Номхон далайн форум болон Женев дэх ЭШУС нийгэмлэг Олон улсын байгууллага хамтран 2024 оны 06 дугаар сард Тайландын Бангкок хотноо зохион байгуулсан “Хүний эрхийн үндэсний байгууллага ба ЭШУС” сэдэвт уулзалт, семинарт ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл тус тус оролцож, туршлага судалсан.

Түүнчлэн ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг тохиолдуулан Дэлхийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын холбоо /GANHRI/-оос эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй алхмуудыг судлах зорилгоор зохион байгуулагдсан цахим уулзалтын эхний цуврал болох “Эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт уулзалтад оролцсон. Тус арга хэмжээнд дэлхийн 112 улсын ХЭҮБ болон УСҮБ-ууд оролцсон бөгөөд төлөөлөгчид ЭШУС-д авч хэрэгжүүлж буй үр дүнтэй арга зүйгээ танилцуулж харилцан туршлага солилцсон.

ОУБ-уудтай хамтын ажиллагааны хүрээнд албан хаагчдаа чадавхжуулах сургалтад цахимаар болон биечлэн оролцуулж байна. “Жайка” олон улсын байгууллагын зохион байгуулсан “Жендерт суурилсан хүчирхийллийг устгах нь” сэдэвт мэдлэг бүтээх сургалтад ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөл хамрагдав. Мөн Ази-Номхон далайн Форум болон Женев дэх “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” хоёр байгууллагын хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт, 4 бүлэг цахим сургалтад манай албан хаагч хамрагдаж, уг сургалтаас олж авсан мэдлэг, мэдээлэл дээр үндэслэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулсныг бид хяналт шинжилгээний үеэр явуулдаг сургалтын арга хэмжээндээ хэрэглэж байна.



Мөн харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх зорилгоор Польш, Хорват, Словени улсуудын УСҮБ-тай хамтын ажиллагаа өрнүүлж байна. Хамтын ажиллагааны эхлэл болгож Бүгд Найрамдах Словени Улсын УСҮБ-ын ЭШУС тэргүүн туршлагыг судлан ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид 2024 оны 03 дугаар сард тус улсад ажилласан.

Тус улсын Хүний эрхийн Омбудсмeны орлогч дарга, УСҮБ-ын тэргүүн Иван Селих болон бусад албан тушаалтнууд 2025 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсад хариу айлчлалаар хүрэлцэн ирж, ЭШУС үндэсний ажиллагааны ажлын арга барил, туршлагатай танилцах бөгөөд энэхүү айлчлал нь Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй ахиц дэвшил, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга зүй, баримталж буй бодлогын талаар Нэмэлт протоколын Оролцогч улсуудын Европын бүс нутгийн УСҮБ-ууд туршлага судлах эхний алхам болж байна.

Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссар, УСҮБ-ын тэргүүний зүгээс Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан өөрийн улсдаа хүрэлцэн ирж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар харилцан туршлага, мэдлэг мэдээлэл солилцохыг санал болгож, албан ёсны урилгыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ирүүлсэн.

Ийнхүү өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь НҮБ-ын гэрээний хороод, ОУБ, бусад улсын УСҮБ-тай идэвхтэй харилцаа холбоо тогтоон, хамтран ажиллаж эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд шаардагдах аливаа стандартад нийцүүлэн, арга зүй, мэдлэг, ур чадварыг эзэмшихэд чиглэн ажилласан бөгөөд НҮБ-ын ЭШУС Дэд хорооны төлөөлөгчид, ЭШУС нийгэмлэг Олон улсын байгууллагын зөвлөхүүдийн Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдад өгсөн сургалт, мэргэжил арга зүй, чиглэл, ХЭҮБ-ууд болон УСҮБ-уудын үр дүнтэй урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага, өмнө нь энэ чиглэлийн сургалтад хамрагдагсдын өгсөн санал, зөвлөмж, олон улсын гарын авлага, зөвлөмжийг ЭШУС сургалтын хөтөлбөр, агуулга, зохион байгуулалтад тусган боловсруулж, сургалтуудыг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу тусгайлан болон аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр орхин гарч явах боломжгүй газруудад хийсэн урьдчилан





ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагч нар тайлант хугацаанд нийт 38 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж 5,912 төрийн албан хаагч нар, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, ЕБС-ийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн оюутан, суралцагч, сонсогч нар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сэдэвт

---

150 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн сургалтын албаны дарга О.Алтангэрэл нарын хамтран баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангахад анхаарах зарим асуудал” сургалтын хөтөлбөр.

151 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн доктор Б.Энхболд, ЦЕГ-ын тэргүүн дэд дарга, бригадын генерал Ц.Ням-Очир нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтын хөтөлбөр.

152 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Багахангай, Налайх дүүргийн Шүүхийн тамгын газрын дарга Б.Мөнхбат нарын хамтран баталсан “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сургалтын хөтөлбөр.

153 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Баянхонгор аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Амарсанаа нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сургалтын хөтөлбөр.

154 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Орхон аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх П.Батболд нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сургалтын хөтөлбөр.

155 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалтын хөтөлбөр.

156 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Чинбат нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх” сэдэвт сургалтын хөтөлбөр.

157 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Төв аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх М.Буяннэмэх нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт арга хэмжээний хөтөлбөр.

158 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Цогтбаяр нарын хамтран баталсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал Говь-Алтай аймагт” сэдэвт хэлэлцүүлгийн хөтөлбөр.

159 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Баянгол дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Мөнх-Од нарын хамтран баталсан “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сургалтын хөтөлбөр.

160 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Я.Цэлмэн, Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Э.Энхбат нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх” сэдэвт сургалтын хөтөлбөр.

сургалтыг цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллагын алба хаагч нар, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд нийт 2,632 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 70 сургагч багшийг бэлтгэн, гэрчилгээ гардуулсан.



ГУРАВДУГААР  
БҮЛЭГ

Тус сургалтад “ЭШУС нийгэмлэг” ОУБ-ын ахлах зөвлөх Бен Бакланд “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Мендезийн зарчмуудын танилцуулга” сэдвээр сургалт явуулж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн “Монгол Улсын хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдэж байж болзошгүй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжид хийсэн дүн шинжилгээ”-г танилцуулсан.



Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон “ЭШУС нийгэмлэг” Олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан сургагч багш бэлтгэх дараагийн сургалтыг “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдвээр танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, ШШГЕГ-ын дарга, Хорих ял эдлүүлэх, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадын дарга, ШШГЕГ-ын дэргэдэх зөвлөл,

Улаанбаатар хотын бүсийн болон орон нутаг дахь хорих анги, байгууллагын удирдлага, албан тушаалтнууд, сургалт хариуцсан алба хаагч нар нийт 500 орчим алба хаагчийг танхимын болон цахим хэлбэрээр хамруулсан. Үүнээс ШШГ байгууллагын 81 удирдах албан тушаалтныг танхимын хэлбэрээр сурган сургагч багшаар бэлтгэж, гэрчилгээ олгосноор тайлант хугацаанд 151 сургагч багшийг, ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд нийт 224 сургагч багшийг бэлтгэлээ.



Тус сургалтад “ЭШУС нийгэмлэг” ОУБ-ын ахлах зөвлөх Бен Бакланд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хорих ял эдлүүлэх ажиллагаанд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмыг нийцүүлэх нь”, “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдвээр сургалт явуулж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн “Монгол Улсын ШШГ байгууллагын алба хаагчдын үйлдэж байж болзошгүй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжид хийсэн дүн шинжилгээ”-г танилцуулсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтад 2023 онд Прокурорын байгууллагаас 7, Тагнуулын ерөнхий газраас 1, Авлигатай тэмцэх газраас 1, Боловсролын ерөнхий газраас 1, Цагдаагийн байгууллагаас 19, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 11 алба хаагч, Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 ажилтан, Дотоод хэргийн их сургууль, бусад их, дээд сургуулийн 8 эрдэмтэн багш, судлаач нар болон бусад албан тушаалтан, албан хаагчдыг хамруулан сургагч багшаар бэлтгэн гэрчилгээ олгосон.



2024 онд зохион байгуулсан “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт 2024 онд



зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын 4, Шүүхийн сахилгын хорооны 1, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1, Хүний эрхийн Үндэсний Комиссын 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны 1, Улсын ерөнхий прокурорын газрын 2, Авлигатай тэмцэх газрын 2 албан тушаалтан, алба хаагч нар, Тагнуулын ерөнхий газрын 1 алба хаагч, Цагдаагийн байгууллагын 38, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 82 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 2 багш, Монголын криминологийн холбооны 3, Монголын өмгөөлөгчдийн холбооны 1 төлөөлөл, бусад албан тушаалтан, алба хаагчдыг тус тус хамруулан сургагч багшаар бэлтгэн гэрчилгээ гардуулсан.



Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн сургагч багш нарыг мэдээллээр хангах, идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим орчинд групп үүсгэсэн, сургагч багш нарыг ЭШУС чиглэлийн мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

ЭШУС хэлтсийн даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Тайлан ирүүлэх тухай” 08/1218 дугаартай албан бичгийг УЕПГ, НПГ, АТГ, ЦЕГ, ШШГЕГ, БЕГ, ДХИС-д тус тус хүргүүлсэн бөгөөд АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасаньямын “Хариу хүргүүлэх тухай” 03/15193, БЕГ-ын дарга Т.Ням-Очирын “Тайлан хүргүүлэх тухай” 01/4239, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваагийн 5/258, ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Нэргүйн 05/2339, ДХИС-ийн тэргүүн дэд захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатарын 02/1676 дугаартай албан бичгээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан

гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг дэмжих, хамгаалах хүний эрхийн сургагч багш нарын 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг ЭШУС үндэсний ажиллагаанд тус тус ирүүлсэн бол сургагч багшаар бэлтгэгдсэн ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтнууд эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээг цахим шуудангаар ирүүлсэн.



Сургагч багш нар эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээр 117 удаагийн сургалт явуулж нийт 26,728 хүнийг хамруулснаар тайлант хугацаанд нийт 155 удаагийн сургалтад 32,640 шүүх, прокурорын байгууллагын, хууль сахиулах болон ШШГ байгууллагын алба хаагч нар, зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүн, төрийн бусад албан хаагч нар (дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, ЕБС-ийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл г.м.), оюутан, суралцагчид, иргэд, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг ЭШУС сургалтад хамруулсан байна.

Цагдаагийн байгууллагаас бэлтгэгдсэн сургагч багш нар тайлант хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийт 80 удаагийн сургалтыг зохион байгуулж 24,769 төрийн албан хаагч нар, иргэдийг хамруулсан нь бусад сургагч багш нарын ирүүлсэн тайлан мэдээтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 28

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 (1-3 сар)	ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд нийт
1	Зохион байгуулсан ЭШУС сургалт, хэлэлцүүлэг	31	37	151	4	223
2	Бэлтгэгдсэн сургагч багш	-	73	151	-	224
3	ЭШУС сургалтад оролцсон хүний тоо	3,357	4,858	32,640	226	41,081

ЭШУС үндэсний ажиллагаанаас тайлант хугацаанд буюу 2024 он, 2025 оны нэгдүгээр улиралд зохион байгуулсан ЭШУС сургалт, хэлэлцүүлгийн мэдээллийг хүснэгтээр харууллаа.

2024 оны 03 дугаар сар	Завхан аймгийн Прокурорын газартай хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сургалт, хэлэлцүүлэгт “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, зөрчил, анхаарах асуудлууд” сэдвээр сургалт явуулж Завхан аймгийн прокурорууд, Цагдаагийн газрын дарга нар, алба хаагчид, ШШГ газрын дарга нар, алба хаагчид, ХЭҮК-ын төлөөллийг хамруулсан
2024 оны 04 дүгээр сар	Шүүхийн сахилгын хорооны гишүүд, захиргааны албан хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сургалт явуулсан
	Нийслэлийн цагдаагийн удирдах газрын эрүүлжүүлэх, саатуулах төвд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулж алба хаагчдыг хамруулсан
2024 оны 05 дугаар сар	Увс аймгийн Прокурорын газартай хамтран “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж Увс аймгийн прокурорууд, Цагдаагийн газрын дарга нар, алба хаагчид, ШШГ газрын дарга нар, алба хаагчид, ХЭҮК-ын төлөөллийг хамруулсан
2024 оны 06 дугаар сар	Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөрт зориулсан ээлжит хэлэлцүүлгийг “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдвийн дор зохион байгуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг арилгах, нөхөн төлбөрийн асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд өмгөөлөгчдийн оролцоо”, “Шүүхээс хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг бүрэн эдлүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвүүдийн хүрээнд илтгэл танилцуулан, хэлэлцүүлсэн
	СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн эмч, эрүүл мэндийн ажилтнууд, тус клиникт үүрэг гүйцэтгэж буй ШШГ байгууллагын алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол” сэдвээр сургалт явуулсан
	Өвөрхангай аймаг дахь ШШГ газрын удирдлага, алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	Баянхонгор аймаг дахь ШШГ газрын удирдлага, алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	Говь-Алтай аймаг дахь дахь ШШГ газрын удирдлага, алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	Архангай аймаг дахь дахь ШШГ газрын удирдлага, алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	ШШГЕГ-ын Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь 423 дугаар хорих ангийн алба хаагчдад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан



2024 оны 07 дугаар сар	ШШГЕГ-ын Орхон аймаг дахь 437 дугаар хорих ангийн алба хаагчдад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	ШШГЕГ-ын Булган аймаг дахь 439 дүгээр хаалттай хорих ангийн удирдлага, алба хаагч нарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
	Хөвсгөл аймаг дахь ШШГ газрын Цагдан хорих байрны алба хаагчдад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга” сэдвээр сургалт явуулсан
2024 оны 09 дүгээр сар	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтран “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сургагч багш бэлтгэх сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд нийт 2,100 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 70 сургагч багш бэлтгэн гэрчилгээ олгосон
	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтран “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, ШШГ байгууллагын удирдлага, алба хаагч нар 532 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 81 сургагч багшийг бэлтгэн гэрчилгээ гардуулсан
	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар, Ховд аймаг дахь ШШГ газартай хамтран “Төрийн албанд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Ховд аймагт зохион байгуулж, тус аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Прокурор, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаа, Бүсийн шүүх шинжилгээний төв, ШШГ байгууллага, Зэвсэгт хүчний дугаар ангийн алба хаагчдыг хамруулсан бөгөөд төрийн албан хаагчдаас хүний эрхийн чиглэлээр санал асуулга авч харилцан ярилцаж, санал солилцсон
	ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн алба хаагчдад “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмууд, НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд, тэдгээрийг хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд хангаж ажиллах нь” сэдвээр сургалт зохион байгуулав
2024 оны 10 дугаар сар	ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба, Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн мөрдөгч нарт “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулсан
	СХД-ийн Прокурорын газар, Цагдаагийн хэлтсийн алба хаагч нарт “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалт зохион байгуулсан

	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор О.Алтангэрэл нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангахад анхаарах зарим асуудал” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын нийт прокуроруудыг хамруулав</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Багахангай, Налайх дүүргийн Шүүхийн тамгын газрын дарга Б.Мөнхбат нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалт зохион байгуулж тус дүүргүүдийн нийт прокурор, цагдаагийн алба хаагчдыг хамруулав</p>
	<p>“Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаарх Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулахтай холбогдуулан, мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг угтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмуудын хэрэгжилт, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлсэн</p>
2024 оны 11 дүгээр сар	<p>Тээврийн прокурорын газрын албан хаагчдад “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянгол дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Мөнх-Од нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж прокурор, хууль сахиулах чиг үүргийн алба хаагчдыг хамруулсан</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Төв аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх М.Буяннэмэх нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт өдөрлөг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээний хүрээнд “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сургалтад</p> <p>Тус аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид, аймгийн Прокурорын газрын прокурорууд, ХЭҮК-ын тус аймаг дахь ажилтан, аймгийн Цагдаагийн газрын мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнууд, ШШГ газрын алба хаагч нарыг танхимаар, ШШГЕГ-ын харьяа 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 417 дугаар нээлттэй хорих ангийн алба хаагч нар болон холбогдох бусад албан тушаалтнуудыг хамруулсан</p>

	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Орхон аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх П.Батболд нарын хамтран баталсан “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сургалтад ЭШУС үндэсний ажиллагаанаас “Харилцаа ба сэтгэл хөдлөл” сэдвээр явуулж тус аймгийн шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид, ХЭҮК-ын ажилтныг хамруулсан</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ү.Содномцог нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сургалтыг зохион байгуулж тус дүүрэг дэх шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын алба хаагчид болон төрийн албан хаагчдыг хамруулсан</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Цогтбаяр нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал Говь-Алтай аймагт” хэлэлцүүлэг зохион байгуулж, ЭШУС үндэсний ажиллагаанаас “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр сургалт явуулан, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Н.Мэндбаяр “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” сэдвээр, Монголын өмгөөлөгчдийн холбооны Салбар зөвлөлийн дарга, өмгөөлөгч Ж.Дорждэрэм “Орон нутаг дахь эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал” сэдвээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, дэд хурандаа Г.Ганбат “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” сэдвээр, Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, нөхцөл байдал” сэдвээр, Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Г.Мөнхтулга “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар”, Б.Золжаргал, ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн орон нутаг дахь төлөв байдал” сэдвээр тус тус мэдээлэл танилцуулсан.</p> <p>Тус арга хэмжээнд аймгийн Прокурорын газар, ХЭҮК-ын тус аймаг дахь төлөөлөл, Шүүх, Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл, Цагдаагийн газар, ШШГ, газар, Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтэс, Шүүх шинжилгээний хэлтэс, Гаалийн хороо, Хилийн цэргийн 0214 дүгээр анги (цахим хэлбэрээр), Зэвсэгт хүчний 341 дүгээр анги, Дотоодын цэрэг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Салбар зөвлөл зэрэг байгууллагуудыг хамруулсан</p>
	<p>ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Баянхонгор аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Амарсанаа нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт сургалт зохион байгуулж тус аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, ШШГ газар, Тагнуулын хэлтэс, Байгаль орчны газрын албан хаагчдыг хамруулсан</p>

	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Чинбат нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалт зохион байгуулж Чингэлтэй дүүргийн бүх шатны прокурорууд, Засаг Даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид, дүүрэг дэх Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтсийн төлөөллийг танхимаар, дүүргийн 24 хорооны ажилтан, албан хаагчид болон дүүрэг дэх Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтсийн мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнуудыг цахим хэлбэрээр хамруулсан
	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Сүхбаатар дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Э.Энхбат нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалт зохион байгуулж тус дүүрэг дэх шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг хамруулсан
2025 оны 01 дүгээр сар	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт явуулсан
	ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн алба хаагчдад “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмууд, НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд, тэдгээрийг хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд хангаж ажиллах нь” сэдвээр сургалт зохион байгуулав
2025 оны 02 дугаар сар	Өнөр бүл хүүхдийн төвийн багш, ажилтнуудад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт явуулсан
	ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны алба хаагчдад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт явуулсан

Эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөх НҮБ-ын гэрээ, конвенц, Олон улсын хүний эрхийн баримт бичиг, үндэсний хууль тогтоомжийг эмхэтгэх, хэвлэх, түгээхтэй холбоотой төсөл боловсруулан, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллагад хүргүүлсэн.

**ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалтын сэдэв:**

- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны танилцуулга”;
- “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах асуудал”;
- “Олон улсын гэрээ конвенцод тусгагдсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх”;
- “Эрүү шүүлтийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколын хэрэгжилтийн зарим асуудал”; “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан

гадуурхалтаас ангид байх хүний эрх, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид тусгагдсан нь”;

- “Мэдүүлэг, ярилцлага авах Мендезийн зарчим”;
- “Харилцаа ба сэтгэл хөдлөл”;
- “Хуульчийн мэргэжлийн хариуцлага”;
- “Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт”;
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн”;
- “Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, түр саатуулах байранд хүний эрхийг хангах асуудал”;
- “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, зөрчил, анхаарах асуудлууд”;
- “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд”;
- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах зарим асуудал”;
- “Тайлбар, мэдүүлэг авах ажиллагаанд хүний эрх зөрчихөөс урьдчилан сэргийлэх, Төрийн албанд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нь”;
- “Төрийн албан хаагч эрүү шүүлтээс ангид байх эрхээ эдлэх нь”;
- “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”;
- “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмууд, НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд, тэдгээрийг хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд хангаж ажиллах нь”;
- “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”;
- “НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх”;
- “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал”.

## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөрт зориулсан ээлжит хэлэлцүүлгийг “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдвийн дор 2024 оны 06 дугаар сард зохион байгуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн төлөөлөл 30 хүнийг оролцуулан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг арилгах, нөхөн төлбөрийн асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд өмгөөлөгчдийн оролцоо”, “Шүүхээс хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг бүрэн эдлүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвүүдийн хүрээнд илтгэл танилцуулан, хэлэлцүүлсэн;



2. “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаарх УИХ-ын хяналтын сонсгол зохион байгуулахтай холбогдуулан, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг угтан ЭШУС үндэсний ажиллагаанаас Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмуудын хэрэгжилт, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлсэн.





“Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаарх УИХ-ын хяналтын сонсголд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид 2024 оны 07 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд тус тус оролцсон.



ЭШУС үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан дээр дурдсан хэлэлцүүлгээс дараах уриалга, санал, дүгнэлт гарсан бөгөөд уриалга, санал, дүгнэлтийг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 08/1758 дугаартай албан бичгээр УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд, УИХ-ын гишүүн П.Сайнзориг, УИХ-ын Ж.Баярмаа, НҮБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Тапан Мишра, ХЗДХЯ-ны ТНБД Н.Мягмар, УЕП-ын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа нарт тус тус хүргүүлсэн.

## ГАРСАН УРИАЛГА, САНАЛ ДҮГНЭЛТ

### **Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар:**

1. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон Монгол Улсын хуульд заасны дагуу ЭШУС үндэсний ажиллагааны бие даасан байдлыг илүү сайжруулах нь зүйтэй. ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулж буй Монгол Улсын ХЭҮКТХ-ийн зорилт, хэм хэмжээ нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээгээр зорилгод хүрсэн байдал 50 хувь, практикт нийцэн хэрэгжиж буй байдал 22,7 хувьтай байна гэж дүгнэгдсэн. Тиймээс энэ асуудлыг УИХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэж ажиллана;



2. Цагдаагийн байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах хүсэлт гаргагчдаас авах мэргэшлийн шалгалтад хүний эрхийн талаарх асуултуудыг оруулах. Үүний дотор эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх асуултыг заавал оруулдаг байх, сурах бичгүүдэд мөн дээр дурдсан агуулгыг тусган, хэрэгжүүлэх;

**Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл:**

3. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг таслан зогсоох зохицуулалт бүхий Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг тусгах болон шүүхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой бие даасан хуулийн төсөл боловсруулахаар төлөвлөн, холбогдох судалгааг хийж байна;

4. Бидний хэлэлцэж буй энэхүү сэдэв нь хүн бүхэнтэй холбоотой сэдэв. Тиймээс НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг угтсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт энэхүү хэлэлцүүлгийг нэг удаагийн ээлжит нэгэн арга хэмжээ гэж хүлээж авалгүй Монгол хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдахын төлөө тус тусын чиг үүргийн ажил үүрэгт ахиц дэвшил гаргахыг уриалж байна;





## **Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд:**

5. Улсын Их Хурлын даргын санаачлан хэрэгжүүлж буй “Гурван төгөлдөршил”-д юуны түрүүнд хүн төвтэй нийгэм гэсэн үзэл санааг эрхэмлэж байна. Хууль тогтооход хүмүүнлэг, иргэнлэг байх зарчмыг хууль тогтоох үйл ажиллагаанд эрхэмлэхийг зорьж байна. Хүний эрхийн дэд хороо нь хууль зүйн хүрээнд ямар манлайлал, шинэчлэл хийж болохоор байна тэр бүгдийг хийнэ, хүний эрхийн төлөөх үйл хэрэгт манлайлан, төр, олон нийттэй хамтран хүмүүнлэг иргэний, ардчилсан нийгмийг цогцлооход онол талаасаа хуулийн нийцэл, практик талаасаа хамтран ажиллагааг бэхжүүлж Та бүхэнтэй хамтран ажиллахад бэлэн байна;

## **НҮБ-ын Монгол Улс дахь суурин зохицуулагч Тапан Мишра:**

6. ЭШУС-д тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд бидний хамтын ажиллагаа нэн чухал. Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүлээн зөвшөөрөх, Конвенцын үзэл санаа, зарчим, төрийн хүлээх үүрэг хариуцлагыг цаашид өндөрт өргөх;

7. Эрүүдэн шүүхийг бүхэлд нь хориглох шаардлагатай бөгөөд энэ зарчмаас ямар нэгэн байдлаар ухарч гажих нь хүний эрхийн болон шударга ёсны зарчмаас ухарч байгаа хэрэг юм;

8. Энэхүү цогц хандлагыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газарт хандан ЭШУС дэд хорооноос ирүүлсэн Зөвлөмжүүдийг хэрэгжүүлж эрүү шүүлтийг үндсээр нь таслан зогсоох шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалж байна;

## **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас:**

9. Улсын Их Хурлаас “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим



арга хэмжээний тухай” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх. Үүнд:

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:**


а/Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

б/эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

10. Улсын Их Хурлаас ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх. Үүнд:

а/Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;

б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг



конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх;

11. Улсын Их Хурлын ХЗБХ-ны даргын “Хамтран ажиллах тухай” 2024 оны УИХ-13/3931 дугаартай албан бичгийн дагуу эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөр дэх хүний эрх, түүний дотор эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулгад дүн шинжилгээ хийх;

12. Үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх;

### **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс:**

*Бодлогын түвшинд:*

13. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах тогтолцооны чадавхыг бэхжүүлэх;

14. Эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох бие даасан хууль батлах (гэр бүлийн гишүүд);

15. Мөрдөн байцаалтын шатанд гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож, нээлттэй хэлэлцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

16. Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллах орчин нөхцөл, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

*Үүрэг хүлээгч талууд:*

17. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

18. Дэлхий дахинд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах асуудал хувьсан өөрчлөгдөж байгаатай холбогдуулан холбогдох албан тушаалтнууд, алба хаагчдын мэдлэг хандлагыг өөрчлөх, сайжруулах асуудал;

19. Мэдүүлэг авах, мөрдөн шалгах ажиллагааг зориулалтын өрөө тасалгаанд явуулж хэвших;

20. Мэргэжлийн байх, нотолгоонд суурилах, сэтгэл зүйн бэлтгэлтэй байх;

21. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар мөрдөгч, прокурор мэдэгдэл бичиж хэвших;

22. Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг нэвтрүүлэх- эрүү шүүлтийн хохирогч;

23. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан, шүүхээр шийдвэрлэгдээгүй, эрүүгийн хариуцлага хүлээсэн гэх байдлаар эрүү шүүлтэд өртсөн асуудлаа шийдвэрлүүлж чадахгүй байгаа тохиолдол байна;

24. Жишээ: Эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлттэй тэмцэх Нийгэмд үйлчлэх ТББ Комисст хандаж гомдол мэдээлэл, удаа дараа гаргаж байгаа (47 хохирогч, ҮАБЗ, УИХ, ЗГ);

25. Гурван шатны шүүхээр шийдсэн гэдэг хариултаар ямар ч ажиллагаа хийх боломжгүй болсон. Олон нийтийн итгэл суларч, нийгэм талцалд хуваагдаж байна;

26. Ажлын хэсэг байгуулж, хохирсон иргэдийн гомдлын дагуу хэргийг дахин хянах;

### **Авлигатай тэмцэх газар:**

27. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах замаар “Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэсэн заалтыг хасах;

28. Хууль батлахын өмнө судалгаа, шинжилгээ хийж хэвших. ЭХ-ийн Тусгай ангийн Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгосон

- гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж;
- эрүүдэн шүүж;

- цус, эд, эрхтнийг авах зорилгоор; гэж хуульчлан Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 21.12 дугаар зүйл, Эрүү шүүлт тулгах, 15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэх мэтээр эрүүгийн хуульд тодорхой заасан гэмт хэргийн шинжийг давхардуулсан тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;

29. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, хэргийг шалгаж буй мөрдөгчийг дарамтлах, хуульд заагаагүй зөвшөөрөл шаарддаг нөхцөл байдлыг зохицуулах. ЭХХШТХ, ШШГТХ-ийн хуулийн 196 дугаар зүйл. Хорих ангид нэвтрэх хэсэгт өөрчлөлт оруулах;

30. Прокурорын шатанд өршөөл үзүүлэх тухай хууль, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон, Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрүүдийг цахим санд бүртгэж ил тод болгох, цагдаагийн ял шийтгэл бүртгэх санд оруулах, нэгдсэн тоо мэдээлэл, судалгаа хийх нөхцөл бүрдүүлэх;

31. Ял шийтгэл оногдуулах зорилгоор нотлох баримт хуурамчаар үйлддэг факт нь Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох эсэх;

32. ЭХ-ийн 21.1 дүгээр зүйл “Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах” гэмт хэргийн үрэгдүүлэх шинжийг хуульчлах. Хуульд санаатайгаар устгасан гэх субъектив шинж хуульчилснаар нотлох баримт, хавтаст хэрэг үрэгдүүлсэн үйлдэлд хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн;



33. Хайнга хандах гэмт хэргийн шинжид "...улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол" гэснээс мөнгөөр илэрхийлэх боломжгүй хор уршиг учраад байгаа тохиолдлуудыг гэмт хэрэгт тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн тул гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах;

34. ЭХ-ийн Тусгай ангийн 21.14 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэргийн шинжид зорилго буюу субъектив хэм хэмжээг тодорхойлсноор хийдэл үүссэн. Бусдад болон өөртөө давуу байдал бий болгосон, мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулсан, илт хууль бус шийдвэр гаргасан бол хариуцлага хүлээлгэх шаардлагатай. Гаргасан шийдвэртээ эзэн нь байж, хариуцлага хүлээгүй болохоор дур зорго нэмэгдэж илтэд хууль бус шийдвэр гаргадаг. Тухайн хууль бус шийдвэр дээд шатанд залруулах үед эд мөрийн баримт шилжих, гэмт хэрэг үйлдсэн хүмүүс Монгол улсаас гарч явах, зугтах нөхцөл байдал үүсдэг. Жишээлбэл, цагдан хоригдож байсан хугацаанд нь гарсан 4 хэргийг хүлээлгэсэн. 2 үйлдэл дээр мөрдөгч санал гаргасан бол прокурор 2 үйлдэл дээр өөрийн санаачилгаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан гэх жишээ гарсан. Мөн битүүмжлэх шаардлагатай хөрөнгийг битүүмжлээгүй, цагдан хорих байрнаас яллагдагчийг түр авч, нэг хохирогчид нь хохирол төлүүлэх арга хэмжээ авч нэг этгээдэд давуу байдал олгосон (тухайн мөнгийг шилжүүлсэн сүүлчийн хохирогч мөнгөө авах хүсэлт гаргасан хэдий ч өөр хохирогчийн хохирол барагдуулсан тохиолдол гарсан);

35. Хөрөнгийн менежментийн хууль шаардлагатай. Хөрөнгө үрэгдэх, битүүмжилсэн хөрөнгө үнэ цэнээ алдах, аж ахуйн нэгж дампуурах эрсдэлээс зайлсхийх, Гадаад улсад үйлдэгдсэн хөрөнгө мөнгө угаагдсан бол хураан авах, хуваалцах, мөрдөн шалгах ажиллагааны зардал гаргуулах нөхцөл бүрдэнэ;

36. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой харилцааг зохицуулж өгөх. Үүнд:

- Гэрч, хохирогч, бусад оролцогч нарыг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад дуудан ирүүлэх эрхийг мөрдөгчид олгох;

- Таньж олуулах ажиллагааг заавал ижил төстэй 3 доошгүй хүн эд зүйлээс олуулах зохицуулалтай зэрэгцүүлэн тухайн нөхцөл байдалд таньж олох ажиллагааг хийх боломж бүрдүүлэх. Ирэх хүмүүсийг, адилхан хүнийг олоод төөрөгдөлд оруулах уу, эрүү шүүлт тулгах үед байсан алба хаагч нараас таньж олуулах уу гэсэн нөхцөл байдал үүсдэг. Зургаар таниулах нөхцөл байдлыг хуульчлах;

37. ЭХХШТХ-д зааснаар Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэдэг. Үрэгдүүлсэн завшсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага байхгүй тул эрүүгийн хуулийн 21.10 дугаар зүйл. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэсэгт өөрчлөлт оруулах. Тухайн заалтад зөвхөн хадгалах, хамгаалах үүрэг бүхий ажилтан, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр хуульчлан хийдэл үүссэн;

38. Дайчлан баривчлах, гэмт хэрэгт сэрдэгдсэн хүнийг хэргийн газраас, эсхүл баривчлан авсан газраас хуулийн байгууллагад хүргэх (хэргийн газраас зугтаад өөр аймгаас баригдсан, оргон зайлж яваад баригдсан, хэргийн газар дээрээ

баригдсан сэжиглэгдсэн хүнийг хууль сахиулах байгууллагад хүргэх), суманд зөрчил гаргасан хүний үйлдлийг таслан зогсоох эрх зүйн орчин бүрдүүлэх;

39. Хэргийн оролцогч өөрөө мэдүүлгээ бичиж өгдөг. Тухайн мэдүүлгийг нотлох баримтаар тооцдог, цахим тоног төхөөрөмж ашиглан зайнаас (өөр газар улсад байгаа хүнээс мэдүүлэг авах нөхцөл бүрдүүлэх);

40. Өршөөл үзүүлэх хууль, хөөн хэлэлцэх хугацаа дуусаж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн хүмүүс хууль сахиулах байгууллагад ажиллах боломж нөхцөлийг хязгаарлах. Иргэн Д.Энхбатыг эрүүдэн шүүсэн, н.Чимгээ, н.Содномдаржаа нар эрүү шүүлтэд өртсөн гэх жишээг санах;

41. Мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэгт ач холбогдол өгөхөөс татгалзаж шинжилгээний байгууллага, шинжилгээний төрөл нэмэгдүүлэх (үнэр шинжлэх г.м.);

42. Эрүү шүүлтийн сандал худалдан авсан тохиолдол байсан. Иймд худалдан авалтыг анхаарах;

### **Цагдаагийн ерөнхий газар:**

43. Улсын хэмжээнд нийт эрүүлжүүлэх, саатуулах байрыг MNS6423:2019 Монгол Улсын стандартын дагуу 30-90 хоног бичлэг хадгалах багтаамж бүхий IP телекамераар бүрэн тоноглох, MNS5527:2019 стандартын дагуу агааржуулалтын төхөөрөмжийг суурилуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээний өрөөтэй болгож бүрэн тохижуулах;

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар:**

44. Мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх эмнэлгийг бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Таширын аманд 300 орны багтаамж, хүчин чадал бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баянхонгор аймагт 100 ор бүхий согтуурах мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төв барих ажлыг эрчимжүүлэх;

45. ШШГТХ-ийн 299 дүгээр зүйлийн 299.5-д “Энэ хуулийн 169.1-д зааснаас бусад тохиолдолд захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж заасны дагуу хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төсөвт тусган, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааг хэвийн явуулахад аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хэмжээнд жилд дунджаар 1 тэрбум төгрөгийн зардлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх;

46. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс ШШГ байгууллага хэрэгжүүлэхээр тусгагдсан. жилд 3,000-4,000 орчим хүн хамрагдах тооцоолол гарсан. Эхний ээлжид 2025 оны 1 дүгээр улиралд 1500-2000 ширхэг цахим бугуйвч худалдан авч, нөөцийг бүрдүүлсэн байх;

47. Ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан ялтныг олж тогтоосон даруйд прокурорын зөвшөөрлөөр саатуулах” зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуульд оруулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтан, этгээдийг прокурорын зөвшөөрлөөр саатуулах зохицуулалтыг шинээр тусгуулах /Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавьж ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад ялтан, этгээд нь ял эдлэхээс оргон зайлах явдал гардаг/;

48. Нэг эмчлүүлэгчид ногдох эмчилгээний зардлыг нэмэгдүүлэх /Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг “Албадан эмчлэх эмнэлгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд уг зардалд тухайн хүнд илэрсэн бусад өвчнийг эмчлэх”-т гэж заасан;

49. Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/105, 138 дугаар хамтарсан тушаалаар баталсан жишиг нормативд зааснаар 1 сард дунджаар 208.300 төгрөгийн эмчилгээ байх ёстой боловч өнөөдрийн байдлаар батлагдсан төсвийн дагуу 1 эмчлүүлэгчид сардаа дунджаар 38.883 төгрөгийн эмчилгээ хийгдэж, зарим эмчлүүлэгч архины хордлого ихтэйгээс гадна тухайн хүнд илэрсэн бусад өвчнийг эмчлэх эмчилгээний зардал хангалтгүй, эмчлүүлэгчдийн тоо нэмэгдэхээр эмийн зардал хүрэлцэхгүй хүндрэл үүсэж дараа сарын эмийн зардлаас урьдчилан хэрэглэж улмаар санхүүгийн өр төлбөр үүсэх эрсдэл үүсдэг;

50. Асран хамгаалагч нь хүлээн авахаас татгалзсан тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн бусад клиникт шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх;

### **Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв:**

51. Эрүү болон зөрчлийн хэргээр албадан эмчлүүлэгчдэд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэх;

52. Уг журамд нэг ээлжид 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр оруулах (2 харуул хамгаалалтын ажилтан, 1 дүрс бичлэгийн ажилтан);

53. Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шинжлүүлэгчийг албадан эмчлүүлэгчдээс тусад нь байлгахгаар холбогдох хууль, журамд тусгах;

54. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх явцад сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгч бүрийн хууль ёсны, төлөөлөгчийг иргэний шүүхээс урьдчилан тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж, албадан эмчилгээ зогссон үед ах дүү, харгалзан дэмжигч нь эргээд ар гэртээ гарган авч асран хамгаалдаг болгох эрх зүйн заалтыг оруулах;

55. Шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх, сунгах, зогсоох, мөн эмчлэгдсэн боловч ар гэрийн зүгээс хүлээн авахаас татгалзсан хүнийг нийгэмд гаргах талаарх эрх зүйн орчныг тодорхой болгох буюу иргэний болон эрүүгийн хуульд энэ талаар тусгах;

56. Хуульд заасан төрлөөр буюу үйлдсэн гэмт хэргийнх нь ангиллаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх өрөө тасалгаа өрөө тасалгаа бүхий Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийг Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албатай хамтран өргөтгөн байгуулах;

### **ТББ, иргэдийн төлөөлөл:**

57. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж буй байгууллагын бие дааж шийдвэр гаргах эрх мэдлийг сэргээх;

58. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд прокурорын байгууллага зөвхөн хяналт тавьж ажиллах, прокурор, шүүгчийн шийдвэр үйл ажиллагаанд хууль зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүний эрхийн үндэсний комисс хянан шийдвэрлэх боломжийг хуульчлах;

59. Хэргийн оролцогч хууль зүйн болон бусад туслалцаа авах эрх, эрх чөлөөг чөлөөлөх. Тодруулбал өмгөөллийн харилцааг төрөөс хараат бус байдлаар шийдвэрлэх;

60. Шүүх бүрэлдэхүүнд төрөөс хараат бус ард түмний төлөөллийг шүүхийн сонгодог тогтолцоот жишгээр оролцуулдаг болох;

61. Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын бодит оролцоог хуульчлан дэмжих;

62. Эрүү шүүлттэй тэмцэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах;

63. Төрийн тусгай албаны төрийн албан хаагчдын хууль зөрчсөн үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллүүдийг нэгтгэн, цуглуулахад дайчлах;

64. Эрүү шүүлт, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх нийгмийн хүсэл, сонирхлыг идэвхжүүлэхэд оролцуулах;

65. Төрийн тусгай албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавихад оролцуулах;

66. Одоогийн олон нийтийн зөвлөлийн хэлбэрээр хэлбэрийн төдий иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог эрс шинэчлэх г.м.;

67. ХЭҮК-оос эрх нь зөрчигдсөн иргэдийн гомдлыг үндэслэн хүн тус бүр дээр тусгайлсан шалгалт явуулах, хүний эрхийн зөрчил гарсан талаар дүгнэлт гаргах;

68. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, ХЭҮК, УЕПГ, ХЗДХЯ, Шүүхийн сахилгын хороо, Монголын өмгөөлөгчдийн холбоо болон бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хохирсон иргэдийн гомдлын дагуу хэргийг дахин хянан үзэж, хүний эрхийн болон эрх зүйн алдаа, зөрчил гарсан эсэх талаар дүгнэлт гаргах;

69. Монгол Улсын Үндсэн Хуулиар хүлээсэн Төрийн үүргийг хэрэгжүүлж, хэлмэгдэж хохирсон нь нийгэмд нэгэнт ил болсон иргэдийн зөрчигдсөн эрхийг аль тохирох арга хэлбэрээр яаралтай сэргээн тогтоох арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай байгааг харгалзан тэдний нэр төрийг сэргээж, хохирлыг барагдуулах.

## ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ХҮРЭЭНД

ЭШУС үндэсний ажиллагаа нь Улсын Их Хурлын ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатарын “Хамтран ажиллах тухай” 2024 оны УИХ-13/3931 дугаартай албан бичгээр ирүүлсэн хамтран ажиллах хүсэлтийн дагуу Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т заасныг үндэслэн эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын хүний эрхийн хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийн, үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Энэ хүрээнд ЭШУС хэлтсийн даргын “Хамтран ажиллах тухай” 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ТГ-08/1238 дугаартай албан бичгийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар нарт тус тус хүргүүлсэн.

Уг албан бичгийн хариуг Боловсролын яамны Дээд боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболдын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 4/952, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэлийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2/628, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатарын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/1694 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн.

Түүнчлэн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Мэдээлэл хүсэх тухай” 08/1569 дугаартай албан бичгийг ТАЗ-ийн дарга Л.Цэдэвсүрэнд хүргүүлэн холбогдох мэдээлэл ирүүлэхийг хүссэн бөгөөд уг албан бичгийн хариуг ТАЗ-ийн гишүүн Б.Пүрэвдагвын 10 дугаар сарын 24-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 03/2219 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагууд болох Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль, Дотоод хэргийн их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Монгол Улсын эрдмийн их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Монгол Улсын их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, “Орхон” их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сити их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, Шихихутуг их сургууль нийт 13 боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.

## ЭРХ ЗҮЙЧ, ХУУЛЬ САХИУЛАГЧИД, ХУУЛЬЧДЫГ БЭЛТГЭДЭГ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ХИЧЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Боловсролын яамны Дээд боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболдын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 4/952, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэлийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2/628, ДХИС-ийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатарын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/1694 дугаартай албан бичгээр Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрүүд дэх хүний эрх, хүний эрхийн боловсролтой холбоотой мэдээллийг “хичээлийн нэр”, “агуулга”, “төлөвлөгөө”, “сурах бичгүүд”, “үнэлгээ”, “арга зүй”, “хэрэглэгдэхүүн”, “багц цаг тооцохтой холбоотой мэдээлэл” “мөрдөж буй эрх зүйн холбогдох баримт бичиг” гэсэн үзүүлэлтийн дагуу нэгтгэн ирүүлсэн.

ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон ДХИС-иас тус тус ирүүлсэн мэдээллийн агуулга ижил байна.

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөр дэх хүний эрхийн хичээлийн агуулга

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын дээр дурдсан 13 байгууллагын сургалтын хөтөлбөрүүд дэх хүний эрхийн хичээлийн агуулгад дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдалтай байна.

Хүснэгт 30

№	Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллага	Сургалтын хөтөлбөрт ЭШУС болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээрх агуулга тусгагдсан эсэх	Сургалтын хөтөлбөрт ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээрх агуулга тусгагдсан эсэх	Сургалтын хөтөлбөрт хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний механизмуудын талаарх агуулга тусгагдсан эсэх
1	Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль	Үгүй	Үгүй	Тусгагдсан
2	Дотоод хэргийн их сургууль	Тодорхойгүй	Тусгагдсан	Тодорхойгүй
3	“Их засаг” олон улсын их сургууль	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
4	Монгол Улсын эрдмийн их сургууль	Үгүй	Үгүй	Тусгагдсан



5	Монгол Улсын боловсролын их сургууль	Үгүй	Үгүй	Үгүй
6	Монгол Улсын их сургууль	Үгүй	Үгүй	Тусгагдсан
7	Олон улсын “Улаанбаатар” их сургууль	Тусгагдсан	Тусгагдсан	Тусгагдсан
8	“Орхон” их сургууль	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	“Отгонтэнгэр” их сургууль	-	-	-
10	Санхүү, эдийн засгийн их сургууль	Үгүй	Үгүй	Тусгагдсан
11	“Сити” их сургууль	Үгүй	Үгүй	Үгүй
12	“Улаанбаатар эрдэм” их сургууль	Үгүй	Үгүй	Үгүй
13	“Шихихутуг” их сургууль	Үгүй	Тусгагдсан	Тусгагдсан
	НИЙТ	1 /7,6 хувь/	3 /23 хувь/	6 /46,1 хувь/

### Үнэлгээ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/144 дүгээр тушаалаар баталсан “Дээд боловсролын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам”-ыг баримтлан суралцагчдын мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлдэг.

Мөн бүтээлч ажил (багаар ажиллах, эсээ бичих, бодлого, хүний эрхтэй холбоотой асуудлаар судалгаа, бие даалт, эргэцүүлэл), тест, ирц, идэвхийг харгалзан үнэлэхээс гадна үнэлгээний рубрик арга зэргийг ашигладаг.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд “Хичээлийн хөтөлбөр, агуулгад хүний эрхийн өөрийн үнэлгээ хийх аргачлал”-ыг боловсруулан, албажуулж хүний эрхийн хичээлүүд болон өөр бусад хичээлүүдийн хөтөлбөрт үнэлгээ хийсэн.

Үнэлгээний үр дүнд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт суралцахуйн үр дүнгийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж бүх шатны хөтөлбөрүүдэд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Сургалтын хөтөлбөрийн зорилгод: Хүний эрх, эрхэм чанарыг дээдлэн, хамгаалдаг мэргэжилтэн (хууль сахиулагч)-г бэлтгэхэд чиглэсэн байх агуулгыг заавал тусгасан. Жишээлбэл, хүний эрхийг дээдлэх, хамгаалах мэдлэг, чадвар, хандлагатай хууль сахиулагчийг төлөвшүүлэх г.м.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнд:

Мэдлэг: Хүний эрхийн ойлголт, мөн чанарын талаар, үндэсний болон олон улсын стандартын зохих түвшний мэдлэгийг эзэмшүүлэх.

Чадвар: Мэргэжлийн үйл ажиллагааг хүний эрхийн зарчмууд, олон улсын болон дотоодын хэм хэмжээнд нийцүүлэх, ялгаварлан гадуурхалтгүй, хүний эрхийн зөрчлөөс ангид байдлаар зохион байгуулах, оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа тогтоох, зөрчилдөөнийг шийдвэрлэх, хурцадмал байдлыг арилгах арга барил, чадварыг эзэмшүүлэх.

Хандлага: Хүний эрх, эрхэм чанар, олон талт ялгаатай байдлыг хүндэтгэх, жендерийн мэдрэмжтэй, хэрэгцээг хүндэтгэх, хууль сахиулагчийн баримтлах ёс зүйн зарчим, өөрийн үйл ажиллагаандаа хариуцлага хүлээх мэргэжлийн байх хандлагыг төлөвшүүлэх зэргээр тодорхойлсон байна.

## Арга зүй

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагууд дараах хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд дараах арга зүйг ашиглаж байна. Үүнд:

1. Дэвшилтэт оролцооны аргууд, бүтээлч сэтгэлгээний аргууд, кейс буюу тохиолдол шинжлэх аргууд;

2. Хичээлийн хөтөлбөрт заагдсан сэдвүүдээс хамааран CLOs хамаарал харилцан адилгүй байдлаар төлөвлөгддөг бөгөөд аль болох тухайн хичээлийн зорилго, хүрэх үр дүнгээс хамааран сургалтын аливаа арга, арга зүйг багш сонгон хэрэглэдэг. Нийтлэг байдлаар суралцагчид олгох мэдлэг, чадвар, хандлагыг дараах байдлаар тодорхойлж хэрэгжүүлдэг:

- Шинэ мэдлэг олгох, суралцагчдад хүний эрхийн хүрээнд зайлшгүй мэдвэл зохих мэдээлэл, мэдлэгийг эзэмшүүлэхэд чиглэсэн, хичээлийн агуулга нь шалтгаант холбоо, зүй тогтлыг тайлбарласан, асуудалд суурилсан, бодит жишээнд суурилсан сорилтыг агуулж бодох, санал солилцох, баталгаажуулах үе шат, агуулгатай арга зүйгээр шинэ мэдлэг олгох лекцийн хичээлийг зохион байгуулан мэдлэг олгох;
- Хэлэлцүүлгийн, сонсож үзэх, хамтран ажиллах, өөрөө гүйцэтгэх, бусдад заах аргуудыг ашиглан суралцагчид мэдлэг бүтээх, бататгахад чухал нөлөөтэй аргуудыг ашиглах. Тухайлбал, “Хөрвүүлсэн сургалтын арга зүй”, “Зураглал боловсруулах арга зүй”, “Үр дүнтэй, сэдэлжүүлэлтэй арга зүй” гэх мэт аргуудыг сургалтад өргөн ашиглаж чадвар олгох;
- Суралцагчдад «Сэтгэл хөдлөлийн оюун ухааны арга», “Бүтцийн торон арга зүй”, “Үйл явцад чиглэсэн сургалтын арга зүй” гэх мэт сургалтын идэвхтэй аргуудаар хандлагыг төлөвшүүлэхээр ашигладаг;

3. Сургалтыг XXI зууны иргэний эзэмшсэн байх шаардлагатай чадамжууд болон тухайн мэргэжлийн орчин үеийн онол, эмпирик мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэгдэх бөгөөд суралцахуй төвтэй, бихевиорист, когнитивист, конструктивист сургахуйн онол, арга зүйд тулгуурлан явуулдаг. Тухайн хичээлийн онцлог, суралцахуйн зорилт нийцүүлэн идэвхтэй сургалтын аргууд болох кейсд суурилсан арга, сорилтод суурилсан арга, асуудалд суурилсан арга, төсөлд суурилсан арга, шийдэлд суурилсан сургалт, туршилтад суурилсан арга, сумуляцид суурилсан аргуудаас сонгон сургалтыг явуулах. Харин хичээлийг хүргэх хэлбэр нь лекц, тонгоруу анги, багаар хамтран ажиллах, багт суурилсан

сургалт, эвлүүлэг, бие биедээ заах, “Бод+Хосол+Хуваалц”, хэлэлцүүлэг мэтгэлцээнийг зохистойгоор хослуулан ашигладаг;

4. Эрх зүйн баримт бичгүүдэд задлан шинжилгээ, тохиолдлын шинжилгээ хийх арга зүй;

5. Идэвхтэй лекц (active lecture) буюу суралцагчийн сонсох, харах, мэдрэх гэх мэт мэдрэхүй дээр нь тулгуурлаж лекцийн агуулгыг товч үзүүлэн материал бэлтгэх (power point ашиглан богино хэмжээний бичлэг, зураг, бүдүүвч, хүснэгт ашиглах хэлбэрээр явуулах); Хамтын ажиллагаатай багийн сургалт (collaborative team learning) буюу суралцагчид тусгай ажил, олон төрлийн даалгаврыг тодорхой хугацаанд гүйцэтгэхийн тулд жижиг багаар ажиллах. Бие даалт буюу суралцагчид холбогдох асуудлыг шийдвэрлэхийн тулд бие дааж судалгаа явуулах, дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;

6. Оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, төсөлд суурилсан, идэвхтэй арга хэлбэрийг хослуулах;

7. Нөхцөлд суурилсан сургалт Case Based Learning (CBL);

Асуудалд суурилсан сургалт Problem Based Learning (PBL);

Сорилтод суурилсан сургалт Challenge Based Learning (CBL);

Төсөлд суурилсан сургалт Project Based Learning;

Зориулагдсан орчинд суурилсан сургалт Studio Based Learning;

Туршилтад суурилсан сургалт Experiential Learning;

Тоглоом ба симуляци хийх сургалт Gamification & Simulations;

Түүхт суурилсан сургалт Scenario/Story Based Learning.

8. Харилцан ярилцах, харьцуулалт хийж багаар ажиллах, дүрд тоглох, өртөөний арга;

9. Асуудалд суурилсан сургалт, сорилтод суурилсан сургалт, Кейсд суурилсан сургалтын оролцооны аргууд;

10. Хичээлийн онолын мэдлэг болон шаардлагатай эх сурвалжуудыг ашиглаж суурь мэдлэгийг дэлгэрэнгүй байдлаар олгон, оюутнуудын идэвх санаачилгыг тодруулан гаргаж ирэх, мэдлэгээ бататгах боломжийг олгон семинарын хичээлүүд дээр практик судалгаа, хууль хэрэглээ зэрэг байдлаар харилцан уялдаж ажиллах.

### Хэрэглэгдэхүүн

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудад хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаандаа хичээлийн хөтөлбөр, хичээлийн лекц, хичээлийн хөтөлбөр, агуулгад хүний эрхийн өөрийн үнэлгээ хийх аргачлал, хүний эрхийн сургагч багшийн нөөц, анги танхим, номын сан, ном сурах бичиг, эрх зүйн баримт бичиг, багшийн бэлтгэсэн presentation, проектор, компьютер, самбар, шохой, мэдээллийн эх сурвалжууд /контент, видео бичлэг/, кейс, үзүүлэн, тараах материал зэрэг хэрэглэгдэхүүнийг ашиглаж байна.

## Сурах бичиг

Сурах бичиг нь боловсролын чанарт нөлөөлөх нэг хүчин зүйл бөгөөд мэдлэгийг тээгч төдийгүй нийгмийн үнэт зүйлс, хэм хэмжээ, зан байдлын загварыг дамжуулах замаар хүний нийгэмшилд шууд ба шууд бусаар үүрэг гүйцэтгэдэг суралцахуйн хэрэгсэл юм.161

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын хүний эрхийн хичээлд ашиглаж буй сурах бичгүүдийг “Хавсралт 2” -оос үзнэ үү.

## Багц цаг

Хүснэгт 31

№	Боловсролын сургалтын байгууллага	Хүний эрхийн хичээлийн агуулга	Багц цагийн мэдээлэл
1	Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй хичээлээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал, түүний үзэл баримтлал агуулгын хүрээнд судална	10 цаг
		Эрх зүйн үндэс хичээлээр Бие хүний эрх зүйн байдал Хүний эрх, эрх чөлөө, түүний ангилал, Хүний эрхийн баталгаа, Хүний эрхийг хангах үндэсний механизм агуулгын хүрээнд судална	1 кр
		Хүний эрх, эрх чөлөө хичээлээр Хүний эрхийн тухай ойлголт, үүслийн тухай онол, үзэл баримтлалууд, түүхэн хөгжил, Хүний эрхийн үзэл санааны хөгжлийн өрнийн болон дорнын сэтгэлгээ, түүний үе шат, Хүний эрхийн ангилал, зарчим, хязгаарлалт, үүргийн тухай, Хүний эрхийн зөрчил, түүнийг тогтоох, НҮБ-тэй холбогдох байгууллагууд, хүний эрхийг хангах, хамгаалах механизм, Хүний эрхийг хамгаалах Үндэсний механизм, Хүний эрхийн үндэсний Монгол Улс дахь байгууллага, Монгол улсын ХЭҮК-ыг агуулгын хүрээнд судалдаг	2 кр
		Эрх зүйн философи хичээлээр Хүн ба байгалийн хууль, Хүсэл зориг ба ашиг сонирхол, Ашиг сонирхол ба хүний эрх, эрх чөлөө, Хүний эрх, эрх чөлөө ба эрх зүй, Эрх чөлөө ба тэгш байдал, Тэгш байдал ба шударга ёс, Шударга ёс ба эрх зүй агуулгын хүрээнд судалдаг	6 цаг
		Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй хичээлээр Бие хүний эрх зүйн байдал Хүний эрх, эрх чөлөө, түүний ангилал, Хүний эрхийн баталгаа, Хүний эрхийг хангах үндэсний механизм агуулгын хүрээнд судална	6 цаг
		Олон улсын нийтийн эрх зүй хичээлээр Хүний эрхийн тухай ойлголт, баримт бичиг, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүмүүнлэгийн эрх зүй агуулгын хүрээнд судална	6 цаг

161 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, УБ, 2024 он, 133 дахь тал.

2	Дотоод хэргийн их сургууль	11 хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 2 багц цагийн агуулгаар сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь мэдлэг олгох багцад сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамаарч заавал болон сонгон суралцахаар, мөн Цагдаа судлал хөтөлбөрт дээрх хичээлээс гадна “Эрүүгийн процесс ба хүний эрх”, “Хүний эрхийг цагдаагийн байгууллага хангах нь” тус бүр 2 багц цагийн хичээл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ба хүний эрх” 2 багц цаг, Эрх зүй магистрын “Хүний эрхийн орчин үеийн чиг хандлага” 3 багц цагийн мэргэжлийн хичээлийг тусгаж хэрэгжүүлж байна	-
3	“Их засаг” олон улсын их сургууль	Хүний эрх	2 кр
4	Монгол Улсын эрдмийн их сургууль	Хүний эрхийн тухай ойлголт, үзэл баримтлал, хүний эрхийн зөрчил, түүнийг тогтоох олон улсын туршлага, хүний эрхийг хамгаалах үндэсний механизм, хүний эрхийг хамгаалах олон улсын туршлага, үзэл баримтлал орчин үеийн чиг хандлага	2 кр
5	Монгол Улсын боловсролын их сургууль	“Орчин үеийн боловсролын үзэл баримтлал” хичээл: боловсрол эзэмших эрх, тэгш хүртээмжтэй боловсрол эзэмших	2 кр
6	Монгол Улсын их сургууль	<p>Хүний эрхэм чанар (human dignity), хүний эрхийн философи, онол, түүхэн хөгжил, ангилал, ач холбогдол, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хамгаалагдсан хүний эрхүүдтэй танилцаж, хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизмын талаар ойлголттой болно. Түүнчлэн хувийн эрх, улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, бүлгийн эрхийг тус бүрийн онол, түүх, онцлог, Монголын болон олон улсын жишээ, тодорхой тохиолдол, харьцуулалтад тулгуурлан нарийвчлан судална. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар: Хүний эрх хичээлийг судалснаар оюутан дараах сэдвүүдээр мэдлэг эзэмшинэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрхэм чанар ба хүний эрхийн ойлголт, философи, ангилал, түүх, ач холбогдол;</li> <li>- Хүний эрхийг хамгаалах механизм (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, хүний эрхийг хамгаалах олон улсын механизм)</li> <li>- Хувийн эрх (тэгш эрх ба амьд явах эрх, халдашгүй, чөлөөтэй байх эрх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, хувийн амьдрал ба хувийн нууц халдашгүй байх эрх, өмчлөх эрх ба нөхөх олговор авах эрх, зорчих, оршин суух газраа сонгох эрх, шударга шүүхээр шүүлгэх зэрэг);</li> <li>- Улс төрийн эрх (өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, сонгох, сонгогдох эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх зэрэг);</li> </ul>	3 кр

		<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засаг, нийгэм, соёлын эрх (амрах, зав чөлөөтэй байх эрх, нийгмийн хангамж эдлэх эрх, сурч боловсрох эрх зэрэг);</li> <li>- Бүлгийн эрх (бэлгийн цөөнх, дүрвэгсэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд); Энэ хичээлийг судалснаар оюутан дараах чадварыг эзэмшинэ:</li> <li>- Хүний эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн болон олон улсын гэрээний заалтыг тайлбарлах,</li> <li>- Тодорхой тохиолдолд хүний эрх зөрчигдсөн эсэхэд анализ хийх (фактын болон хууль зүйн анализ хийх)</li> <li>- Үндсэн эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эх сурвалжийг тодорхойлох, судалгаа хийх</li> <li>- Зөрчигдсөн эрхээ хамгаалуулах зорилгоор шүүхэд гомдол гаргаж сурах;</li> <li>- Зөрчигдсөн эрхээ үндэсний хэмжээнд хамгаалах бүх аргыг хэрэглэсний дараа олон улсын хэмжээнд хэрхэн хамгаалуулж, гомдол гаргаж сурах,</li> <li>- Өөрийн болон бусад хүмүүсийн хүний эрхэм чанар хүндлэх, хүний эрхийг хамгаалах хандлага, дадлыг төлөвшүүлэх. Хичээлээр хүний эрхийн үндэс, түүхэн хөгжил, хүний эрхийн Европын болон олон улсын эрх зүйн эх сурвалж, хүний эрхийг хамгаалах Европын (бүс нутгийн) болон олон улсын эрх зүйн тогтолцоо, тэдгээрийн онцлог ба уялдаа холбоо, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх Европын эрх зүйн болон олон улсын эрх зүйн зохицуулалт болон эдгээр эрхийн хэрэгжилтийг судална</li> </ul>	
7	Олон улсын “Улаанбаатар” их сургууль	<p>Хүний эрхийн онол, зарчим;</p> <p>Нийгмийн бүлгүүдийн эрх;</p> <p>Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм;</p> <p>Хүний эрхийн зөрчил;</p> <p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа ба хүний эрх;</p> <p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүний эрх;</p> <p>Хүний эрх ба жендэр;</p> <p>Хүүхдийн эрх;</p> <p>Монгол Улсын Үндсэн хууль ба хүний эрх;</p> <p>Хүний эрхэд суурилсан хандлага;</p> <p>Үл ялгаварлан гадуурхах;</p> <p>Анти семитизм, анархизм ба хүний эрх;</p>	-



		<p>Эрүү шүүлт тулгах болон хэрцгий, хүмүүнлэг бусаар хандаж харьцах, нэр төрийг нь доромжлох, шийтгэх;</p> <p>Цөөнхийн эрх;</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх;</p> <p>Боловсролын байгууллага дахь хүний эрх;</p> <p>Сэтгүүл зүй ба хүний эрх;</p> <p>Жендэрийн тэгш эрхийн асуудал;</p> <p>Хэвлэн нийтлэх болон мэдэх эрх;</p> <p>Шударга шүүхээр шүүлгэх эрх;</p> <p>Хорих байгууллага дахь хүний эрх;</p> <p>Ажлын байран дахь хүний эрх;</p> <p>Цахим орчин дахь хүний эрх</p>	
8	"Орхон" их сургууль	<p>Хүний эрхийн боловсрол, сургалтыг УИХ, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын хууль, БШУ-ны сайдын тушаалд нийцүүлэн зохион байгуулж байна. Орхон их сургуулийн Эрх зүйн тэнхим тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө хүний эрхийн холбогдолтой сургалт зохион байгуулах, хүний эрхийн талаарх холбогдох байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, үр дүнг нь тухайн хичээлийн жилийн ажлын тайланд тайлагнадаг</p>	-
9	"Отгонтэнгэр" их сургууль	-	-
10	Санхүү, эдийн засгийн их сургууль	<p>Хүний эрхийн тухай ойлголт, хүний эрхийн үүслийн тухай онол, үзэл баримтлалууд, түүхэн хөгжил, хүний эрхийн үзэл санааны хөгжлийн өрнийн болон дорнын сэтгэлгээ, түүний үе шат, хүний эрхийн ангилал, зарчим, хязгаарлалт, үүргийн тухай, хүний эрхийн зөрчил, түүнийг тогтоох, НҮБ-тэй холбогдох байгууллагууд, хүний эрхийг хангах, хамгаалах механизм, хүний эрхийг хамгаалах Үндэсний механизм, Хүний эрхийн Үндэсний Монгол Улс дахь байгууллага, Монгол улсын ХЭҮК</p>	2 кр

11	“Сити” их сургууль	<p>Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр хүний эрхийг хөхүүлэн дэмжих асуудал бол сайн засаглалын чухал чанар хэмээн үзэж тусгасан заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн шинжлэх ухааны нэг гол мэргэшүүлэх шинжлэх ухаан болох Хүний эрх судлал хичээлийн онолын мэдлэгийг оюутнуудад олгох юм. Оюутнууд тус онолын мэдлэг дээр тулгуурлан хүний эрх, эрх чөлөө буюу хүний эрх түүний үүсэл хөгжил зүй тогтол цаашдын чиг хандлагаас гадна суурь зарчим зэргийн уялдаа холбоог задлан шинжилж нэгтгэн дүгнэх чадварыг эзэмшүүлэхэд хичээлийн гол агуулга, зорилго оршино. Хүний эрх хичээлээр эрх зүйн тогтолцоонд хүний эрхийн эзлэх байр суурь, учир холбогдол, хүний эрхийн ойлголт үзэл баримтлал, олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, төрөөс хүний эрхийг хамгаалах арга, хүний эрхийн зөрчил, түүний гаралт, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын байгууллага, түүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг танин мэдэж, хүний эрхийн талаар өндөр мэдлэг, хүний эрхийг хангах, хамгаалах арга, механизмыг ашиглах чадвар, хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэх хандлага бүхий цогц чадамжийг оюутанд эзэмшүүлэхэд оршино. Уг зорилгыг биелүүлэхэд дараах зорилтуудыг тавьсан болно. Үүнд:</p> <p>Монгол Улсад хүний эрхийн хангаж ирсэн түүхэн уламжлалыг ойлгох;</p> <p>Хүний эрхий онолын болон үзэл сурталтын ялгамжтай чанар, түүнд хууль зүйн шинжлэх ухааны үүднээс дүн шинжилгээ хийхэд дадлагажих;</p> <p>Үйл явдал, мэдээлэл лавлагаа баримт бичгийн үндсэн дээр өөрийн үзэл бодлыг илэрхийлэх арга зүйг эзэмших;</p> <p>Хүний эрхийг дээдлэх, эрхээ хамгаалах, хадгалах, үнэ цэнийг нь танин мэдэх;</p> <p>Хүний эрхийн түгээмэл үзэл санааг Монголын амьдрал ахуйд зөв зохистой хэрэглэх, танин мэдэх</p>	2 кр
12	“Улаанбаатар эрдэм” их сургууль	<p>Хүний эрх хичээл нь хууль, эрх зүйн мэргэжлээр суралцаж буй оюутнуудад мэргэжлийн болон мэргэшүүлэх бусад хичээлийн судлах зүйл, судалгааны үндэслэлийг тавьж байгаагаараа хууль зүйн дээд боловсролын орчин үеийн хоёр дахь цагаан толгой болно</p>	2 кр

13	“Шихихутуг” их сургууль	<p>Хүний эрх, түүний мөн чанар, ангилал;          Хүний эрхийн зарчим, агуулга;          Хүний эрхэд суурилсан хандлага, төлөвшилт;          Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм;          Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм;          Хүний эрхийн зөрчил, шалгах ажиллагаа;          Хүний эрхийн хязгаарлалт, үр дагавар;          Жендэр ба хүний эрх, үүсэх үр дагавар;          Соёлын олон талт байдал ба хүний эрх;          Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх;          Үзэн ядалтаас ангид байх эрх, хэрэгжилт;          Хөгжил ба хүний эрх, хөгжлийн хандлага зэрэг агуулгыг багтаасан</p>	2 кр
----	-------------------------	---	------

Хүний эрхийн хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай байсан тул Гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Хамтран ажиллах тухай” 08/1877 дугаартай албан бичгийг Боловсролын сайд П.Наранбаярт хүргүүлсэн бөгөөд уг албан бичигт хүний эрхийн хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай байгааг дурдаад эрх зүйч, хууль сахиулагч, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөрүүд (Боловсролын ерөнхий хуулийн 3.1.13. “сургалтын хөтөлбөр” гэж суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичгийг;) болон хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнүүд (лекц, семинарын хичээлийн сэдэв тус бүрээр бичсэн агуулга), хичээл тус бүрийн агуулгын дэлгэрэнгүй тэмдэглэлийг сургууль тус бүрээр гарган ирүүлэх тухай тодорхой бичиж хүргүүлсэн.

Албан бичгийн хариуг Боловсролын сайд П.Наранбаярын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/13 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Боловсролын яамнаас Гишүүний 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Хамтран ажиллах тухай” 08/1877 дугаартай албан бичигт заасан мэдээллийг үзүүлэлт тус бүрээр задлан өмнө тайлангаар хүргүүлсэн хуульч, хууль сахиулагчдыг бэлтгэдэг дээд боловсролын сургалтын 13 байгууллагад хүргүүлж, хүний эрх, хүний эрхийн боловсролтой холбоотой хичээлийн хөтөлбөр, агуулга, төлөвлөгөө, сурах бичиг, үнэлгээ зэрэг 13 үзүүлэлтийн дагуу ирүүлсэн сургалтын материал, мэдээллийг нэгтгэн хүргүүлж буйгаа дурдаад, дээд боловсролын сургалтын 7 байгууллагаас ирүүлсэн материалуудыг нотолгоо болгон хавсарган ирүүлсэн байна.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай” 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаартай тушаалыг албан бичигт хавсарган ирүүлжээ.

Боловсролын сайд П.Наранбаярын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/13 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл нь 2024 онд ирүүлсэн эрх зүйч,

хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын 13 байгууллагын сургалтын хөтөлбөрүүд дэх хүний эрх, хүний эрхийн боловсролтой холбоотой агуулга, үнэлгээ, арга зүй, хэрэглэгдэхүүн, сурах бичгүүд, багц цаг тооцохтой холбоотой мэдээлэлтэй ижил бөгөөд дээр дурдсан үзүүлэлтүүдэд зөвхөн “хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө”-ний үзүүлэлтийг нэмж, нэгтгэн ирүүлсэн.

Өөрөөр хэлбэл эрх зүйч, хууль сахиулагч, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөрүүд, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнүүд (лекц, семинарын хичээлийн сэдэв тус бүрээр бичсэн агуулга), хичээл тус бүрийн агуулгын дэлгэрэнгүй тэмдэглэлийг сургууль тус бүрээр гарган ирүүлээгүй байна.

Харин ДХИС-ийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатарын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/14 дугаартай албан бичгээр тус сургуулийн бакалаврын түвшний бүх хөтөлбөрт заавал судлахаар тусган хэрэгжүүлж буй “Хүний эрх, жендэр” хичээлийн хөтөлбөрийг цахим шуудангаар тусгайлан ирүүлсэн.

Монгол Улсын ТАЗ-ийн дарга Л.Цэдэвсүрэнд “Мэдээлэл хүсэх тухай” 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 08/1569 дугаартай албан бичгийг хүргүүлж төрийн албан хаагчдын нийт хэдэн албан тушаалын тодорхойлолт байдаг талаарх мэдээлэл болон тэдгээрээс хэдэн төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод “Эрх зүйч” мэргэжилтэй байх шаардлага тавигдсан талаарх мэдээлэл ирүүлэхийг хүссэн.

Уг албан бичгийн хариуг ТАЗ-ийн гишүүн Б.Пүрэвдагвын “Хариу хүргүүлэх тухай” 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 03/2219 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд албан бичигт “Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д “Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.” гэж заасны дагуу 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 27,166 албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгоод байна...”. “Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын “мэргэжил”-ийн шаардлагын судалгаанаас үзэхэд “Эрх зүй” мэргэжил нь удирдах албан тушаалын 241 албан тушаалын тодорхойлолтод, гүйцэтгэх албан тушаалын 1,050 албан тушаалын тодорхойлолтод тус тус тусгагдсан болно” гэжээ.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагууд болох Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль, ДХИС, Их засаг олон улсын их сургууль, Монгол Улсын эрдмийн их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Монгол Улсын их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, “Орхон” их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сити их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, Шихихутуг их сургууль нийт 13 боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу

хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдлыг тодруулан гаргахын тулд харьцуулан судаллаа.

Боловсролын яамны Дээд боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболдын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 4/952 дугаартай албан бичгээр эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын 13 байгууллагын сургалтын хөтөлбөрүүд дэх хүний эрх, хүний эрхийн боловсролтой холбоотой мэдээллийг “хичээлийн нэр”, “агуулга”, “төлөвлөгөө”, “сурах бичгүүд”, “үнэлгээ”, “арга зүй”, “хэрэглэгдэхүүн”, “багц цаг тооцохтой холбоотой мэдээлэл” “мөрдөж буй эрх зүйн холбогдох баримт бичиг” гэсэн үзүүлэлтийн дагуу нэгтгэн ирүүлсэн боловч харилцан адилгүй байдлаар томъёологдсон мэдээлэл ирүүлжээ.

Тухайлбал, Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль, Монгол Улсын их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, Сити их сургууль, Шихихутуг их сургуулийн хүний эрхийн хичээл тус бүрийн нэр, сэдвийг тодорхой тоочин бичиж ирүүлсэн бол зарим сургуулийн сургалтын хөтөлбөр дэх хүний эрхийн хичээлийн нэр, сэдвүүд тодорхой бус, өөрөөр хэлбэл хүний эрхийн хичээлүүдийн ерөнхий агуулгыг дурдсан байна.

Боловсролын сайд П.Наранбаярын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/13 дугаартай албан бичгээр эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын 8 байгууллагын сургалтын хөтөлбөрүүд дэх хүний эрх, хүний эрхийн боловсролтой холбоотой мэдээллийг “хөтөлбөрийн нэр”, “хөтөлбөрийн төлөвлөгөө”, “хөтөлбөрийн хүний эрхийн боловсролтой холбоотой агуулга”, “тухайн хөтөлбөр дэх хичээлийн тоо”, “хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө”, “сурах бичгүүд”, “үнэлгээ”, “арга зүй”, “хэрэглэгдэхүүн”, “багц цаг тооцохтой холбоотой мэдээлэл” “мөрдөж буй эрх зүйн холбогдох баримт бичгүүд” гэсэн үзүүлэлтүүдийн дагуу нэгтгэн ирүүлсэн бөгөөд Монгол Улсын боловсролын их сургуулийн Сургалтын хөтөлбөрийг, Их засаг их сургуулийн “Хүний эрх” хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, сургалтын явцын төлөвлөгөөг хавсралтаар ирүүлснээс үзэхэд ЭШУС үндэсний ажиллагаанаас хүргүүлсэн албан бичигт заасан шаардлагатай мэдээллийг бүрэн ирүүлээгүй байна.

ДХИС-ийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатарын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/14 дугаартай албан бичгээр тус сургуулийн бакалаврын түвшний бүх хөтөлбөрт заавал судлахаар тусган хэрэгжүүлж буй “Хүний эрх, жендэр” хичээлийн хөтөлбөрийг цахим шуудангаар тусгайлан ирүүлсэн.

ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэлийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2/628 дугаартай албан бичгээр ДХИС нь 11 хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 2 багц цагийн агуулгаар сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь мэдлэг олгох багцад сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамаарч заавал болон сонгон суралцахаар, мөн Цагдаа судлал хөтөлбөрт дээрх хичээлээс гадна “Эрүүгийн процесс ба хүний эрх”, “Хүний эрхийг цагдаагийн байгууллага хангах нь” тус бүр 2 багц цагийн хичээл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ба хүний эрх” 2 багц цаг, Эрх зүй магистрын “Хүний эрхийн орчин үеийн чиг хандлага” 3 багц цагийн

мэргэжлийн хичээлийг тусгаж хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг ирүүлсэн. Мөн ДХИС-ийн хэрэгжүүлж буй бүх шатны хөтөлбөрт төлөвлөгддөг хүний эрхийн хичээлийн сэдвүүдийг тодорхой бичиж ирүүлжээ.

Боловсролын ерөнхий хууль (БЕХ)-ийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтад бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсролын талаар агуулга тусгахыг хуульчилсан<sup>162</sup> байх ч эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөний талаар нэгдсэн цогц мэдлэг олгох, хандлага төлөвшүүлэх, ур чадвар, дадал эзэмшүүлэхтэй холбоотой бодлого, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагаа хангалтгүй байж болзошгүй дүр зураг илэрч байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээрх агуулга эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын зөвхөн 1 байгууллагын (Олон улсын Улаанбаатар их сургууль) сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд нийт сургалтын хөтөлбөр дэх агуулгын 7,6 хувийг эзэлж байгаа үзүүлэлттэй байна.

Ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээрх агуулга боловсролын сургалтын 3 байгууллагын (ДХИС, Олон улсын Улаанбаатар их сургууль, Шихихутуг их сургууль) сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд нийт сургалтын хөтөлбөр дэх агуулгын 23 хувийг эзэлж байна.

Хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний механизмуудын талаарх агуулга нийт 6 боловсролын сургалтын байгууллагын (Боловсрол, соёл, эрх зүйн дээд сургууль, Монгол Улсын эрдмийн их сургууль, Монгол Улсын их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Шихихутуг их сургууль) сургалтын хөтөлбөрт буюу нийт сургалтын хөтөлбөрийн 46,1 хувьд тусгагдсан байгаа хэдий ч ЭШУС үндэсний механизмын талаарх агуулга тусгагдсан эсэх нь тодорхойгүй байна.

БЕХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтад бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсролын талаар агуулга тусгахыг хуульчилсан.<sup>163</sup>

Сургалтын хөтөлбөр нь суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичиг бөгөөд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, хандлага, ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэх эх суурь болдог тул тэдгээр суралцагчдын боловсролын чанарын үзүүлэлтэд анхаарал хандуулж цаашид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн боловсролыг эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын

<sup>162</sup> Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалт

<sup>163</sup> Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалт.



хөтөлбөрийн агуулгад нэгдсэн, цогц байдлаар, тусгайлан оруулж, тодорхой ахиц дэвшил гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын ТАЗ-өөс ирүүлсэн мэдээлэлд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 27,166 албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон ба “Эрх зүй” мэргэжил нь удирдах албан тушаалын 241 албан тушаалын тодорхойлолтод, гүйцэтгэх албан тушаалын 1,050 албан тушаалын тодорхойлолтод тус тус тусгагдсан байна.

БШУЯ-ны Дээд боловсролын хичээлийн жилийн тайланд дурдсанаар 2023-2024 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлд дүн шинжилгээ хийхэд 39,691 суралцагч бизнес, удирдлага, эрх зүйн чиглэлээр, 17,231 суралцагч боловсролын, 11,127 нь хүмүүнлэг, соёл, урлагийн, 9,757 нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн, 3,648 нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, 7,835 нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, 18,821 нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээх чиглэлээр, 2,347 нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй, 26,207 нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 7,228 нь үйлчилгээ, бусад чиглэлээр 1,423 суралцагч суралцаж байна. 164 гэснээс үзэхэд боловсролын сургалтын байгууллагуудад эрх зүйн чиглэлээр бусад мэргэжилтэй харьцуулахад харьцангуй олон суралцагч суралцаж байна.

БЕХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтад суралцагч нь бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх 165 талаар зохицуулсан.

Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 10 дугаар зүйлд “Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, мэдүүлэг авах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нэгдэн орсноор “эрүү шүүлт тулгах” үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон, холбогдох хуулиудад зүйлчлэн тусгах үүрэг хүлээсний дагуу 2002, 2015, 2017 онуудад Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-иудыг тус тус шинэчлэн найруулж баталсан. Ингэснээр зөвхөн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын төдийгүй төрийн бүх албан хаагч нар иргэнээс аливаа тайлбар мэдүүлэг авахдаа өөрөө эсвэл гуравдагч этгээдийн оролцоотойгоор албадах, хүч хэрэглэх, сэтгэл санааны хохирол учруулах, дарамт шаналгаа үүсгэх үйлдэл гаргаснаар эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект болох боломжтой болсон.

Иймд Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулж, эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон

164 БШУЯ-ны Дээд боловсролын хичээлийн жилийн тайлан, 2023-2024, УБ, 2024 он.

165 Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт, 2023 он.

харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай гэж дүгнэлээ.

ЭШУС хамгийн үр дүнтэй арга зам нь эрүү шүүлтийг хориглох болон мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тухай олон улсын гэрээ, конвенц, баримт бичгийн талаарх хуульч, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дадлыг эзэмшүүлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүндэтгэх, зөрчихгүй байх хандлагыг төлөвшүүлэх, үйл ажиллагааны үндсэн зарчим болгох явдал юм. Энэ нь сургалтын үйл ажиллагаагаар биеллээ олох асуудал юм. Иймд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 10 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж хүний эрхийн чиглэлээр дараах агуулга бүхий сургалтын тусгайлсан хөтөлбөр боловсруулах нь зүйтэй. Үүнд:

- ЭШУС болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө;
- б/ Тайлбар, мэдүүлэг авахдаа хүч хэрэглэх, тулгах, сэтгэл санаагаар дарамтлах, эрүүдэн шүүх арга ашиглахыг хориглосон агуулга бүхий НҮБ-ын “Мирандагийн анхааруулга” зарчим;
- в/ “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” (Мендезийн зарчмууд).

Түүнчлэн цаашид ЭШУС болон эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхтэй холбоотой сургалтын төлөвлөгөөг үнэлэх, хяналт тавих чиг үүргийг ЭШУС үндэсний ажиллагаа хариуцах, сургагч багш нарыг мэргэшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, цагдаагийн байгууллага болон ШШГ байгууллагад ажиллах хүсэлт гаргагчдаас мэргэшлийн шалгалт авахдаа холбогдох дүрэм, журамд заасны дагуу цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад анх ажиллах иргэнд тавигдах шаардлага, албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг шалгахын зэрэгцээ эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөний талаар, хүнээс тайлбар, мэдүүлэг авахдаа хүч хэрэглэх, тулгах, сэтгэл санаагаар дарамтлах, эрүүдэн шүүх арга ашиглахыг хориглосон агуулга бүхий НҮБ-ын “Мирандагийн анхааруулга” зарчим, “Мендезийн зарчмууд”-ын талаарх мэдлэг, ур чадвар, хандлагын түвшнийг тогтоох шаардлагатай.



## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НИЙГЭМЛЭГ (АРТ) ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

Швейцарын Холбооны Улсын Женев хотноо НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр нэгдсэн чуулганаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх гишүүн орнуудын Засгийн газрын тайланг хэлэлцсэн.

**gogo** Мэдээ ▾ GoGo булалт ▾ Урж ▾ Хэв мэлг ▾ English 🔍

### Монголын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг "Үлгэр жишээ" гэж үнэлжээ



Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг" Олон улсын байгууллагатай Улаанбаатар хотноо дэлгэс хэлэлцлийн турш хамтын ажиллагааг үргэлжлүүлжээ.

Энэ удаа эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хяналт шинжилгээний арга барилд анхаарах асуудлыг ойлгох, тогтоох зорилгоор эмэгтэйдүүдийн хөрш ахид хамтарсан хяналт шинжилгээ хийж, хоёр байгууллага нрэх онд хамтран ажиллахаар боллоо.

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Ази-Тойвог дэвдэйн бусад байгууллагдан үндэсний ажиллагаанд нэг болжээ. Бус нутгайгаар ЭШУС үндэсний ажиллагааны бусад аригт зарлажүүлэн ХОУБ-уудын днд байсан Эрүүдэн шүүлийн эсрэг конвенцын Мамонт гишүүдийн харагдан осорван байгаагүй бус нутгайн бусад Орлолцж-уудуудын үндэсний ажиллагааг "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг" ээс тодорлов.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Орлолцогч улс нь конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан-илтгэлээ тус конвенцод нэгдэн орсноос хойш 1 жилийн дотор, түүнээс хойш 4 жил тутам НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлдэг бөгөөд конвенцын хэрэгжилт, Хорооноос өмнө өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаар ээлжит чуулганаар хэлэлцдэг.

Тус чуулганы үеэр Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөгчид НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дарга, гишүүд болон Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүдтэй уулзаж,

мэдээлэл солилцсон. Түүнчлэн Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаатай уулзаж, санал солилцсон.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо болон НҮБ-ын ЭШУС Дэд хороо, Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгч нар Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа богино хугацаанд чадавхжиж, үр дүнтэй ажиллаж байгааг онцлон тэмдэглээд, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу тус Үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв санхүү, хүний нөөц, хараат бус бие даасан байдлыг хангах талаар шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай байгааг дурдсан. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Монгол Улсын хэлэлцүүлгийн мөрөөр дүгнэлт, зөвлөмжөө энэ оны 11 дүгээр сарын 22-ны өдөр нийтэд танилцуулсан.



ЭШУС үндэсний ажиллагааны төлөөлөгчид Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг (АРТ) олон улсын байгууллагад айлчилж, хоёр талын уулзалт хийсэн. Уулзалтад тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Николь Хогг, Хяналт шинжилгээний ахлах

зөвлөх Бен Бакланд, Бүсийн төслийн менежер Нид Сатжипонан нар байлцсан бөгөөд уулзалтаар Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны өнөөгийн байдлыг ярилцаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дүгнэж, цаашид хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр, эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн талаарх сургалтын хөтөлбөр боловсруулахад хамтран ажиллах талаар санал солилцож, олон улсын зөвлөх ажиллуулах талаар хэлэлцэн тохирсон.





## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга зам нь эрүү шүүлтийг хориглох болон мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тухай олон улсын гэрээ, конвенц, баримт бичгийн талаарх төрийн албан хаагч нар, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ур чадвар, дадал эзэмшүүлэх, эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хүндэтгэх, зөрчихгүй байх хандлагыг төлөвшүүлэх, үйл ажиллагааны үндсэн зарчим болгох явдал юм. Энэ нь сургалтын үйл ажиллагаагаар биеллээ олох асуудал билээ.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны төлөөлөгчид, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагын зөвлөхүүдийн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдад өгсөн сургалт, мэргэжил арга зүй, чиглэл, Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын үр дүнтэй урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага, өмнө нь энэ чиглэлийн сургалтад хамрагдагсдын өгсөн санал, зөвлөмжийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр, агуулга, зохион байгуулалтад тусган боловсруулж, сургалтуудыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх суудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу тусгайлан болон аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр орхин гарч явах боломжгүй газруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний ажлын хүрээнд зохион байгуулсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд нийт 223 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 41,081, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 155 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 32,640 төрийн албан хаагч нар, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн оюутан, суралцагч, сонсогч нар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн 73 сургагч багшийг 2023 онд бэлтгэн гэрчилгээ олгосон бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх

нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тус тус зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд нийт 2,632 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 151 сургагч багшийг бэлтгэн гэрчилгээ гардуулснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд нийт 224 сургагч багшийг бэлтгэсэн.

Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах ажлыг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тус байгууллагаас олон улсын зөвлөх ажиллуулах талаар хэлэлцэн тохиролцсон.

Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг чадавхжуулах, нийт хүн амын дундах эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн төслийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай сангийн санхүүжилтээр 2025-2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Уг төслийг хэрэгжүүлснээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид, төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдлэг, хүний эрхэд суурилсан арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд чухал ахиц дэвшил гарах билээ.

## САНАЛ

1. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах



### 3.2 ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРТАЛЧИЛГАА

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн Долоодугаар бүлгийн 33 дугаар зүйлийн 33.1.2. “Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах”, 33.1.3. “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах”, 33.1.4. “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах”,<sup>166</sup> гэж заасан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр<sup>167</sup>-ийг тус тус батлан мөрдүүлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 3.1-т Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх, 3.2-т Иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны үр дүнтэй түншлэлийг бэхжүүлэх<sup>168</sup> гэж заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийг иргэд болон төрийн албан тушаалтнуудад тайлбарлан таниулах чиг үүргийг баримтлан, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа.

#### НЭГ.СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хуулиар хүлээсэн чиг үүрэг, асуудал эрхэлсэн гишүүний баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг удиртгал болгон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөлтийг шат дараатай төлөвлөн, зохион байгуулалтыг хангаж, хэрэгжилт үр дүнг тооцож ажиллав. Энэ хүрээнд Эрүү шүүлтийн хор аюулыг олон нийтэд түгээх дараах таван үндсэн чиглэлийг тодорхойлов.

1. Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд олон нийтийн сүлжээгээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл, тогтмол хүргэж ажиллах;
2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-т заасан “бүх газарт” урт болон богино хугацаагаар байрлаж байгаа хүнд болон тухайн газар өөрийн чиг үүргийн хүрээнд

<sup>166</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл


<sup>167</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, 2024

<sup>168</sup> “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2023

албан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчдад нөлөөллийн ажлыг зохион байгуулах;


3. Олон нийт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамран ажиллах;
4. Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах хүрээнд олон сурталчилгааны хэрэглэгдэхүүн бүтээх;
5. Улсын Их хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээнээс өгсөн зөвлөмжийн хүрээнд баталсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх төлөвлөгөө”-ний дагуу ажиллах.

## ХОЁР.ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ БОЛОН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, ТОГТМОЛ ХҮРГЭЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД




Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээллийг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар тогтмол, түргэн шуурхай дамжуулан хүргэсэн ба зурагт хуудас, контентыг тухай бүр давтамжтайгаар хүргэж ажиллав.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк хуудсыг 2023 оны 2 сарын 15-ны өдрөөс ажиллуулж эхэлсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 52 мянга 966 дагагчтай болоод байна .



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фэйсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсанд эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар мэдлэг ойлголт, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон бусад арга хэмжээний талаар контент (бичлэг, reels, story, poster хэлбэрээр) нийт 311 удаагийн мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээв. Тухайлбал:



- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаарх мэдээлэл 148 удаа;

- Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээлэл, зурагт хуудас хэлбэрээр 55 удаа;

- Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх 1-75 минут хүртэлх хугацаатай бичлэг хэлбэрээр 40 удаа;

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны ярилцлагыг 30 удаа;

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх



хяналт шинжилгээний талаарх болон бусад үйл ажиллагааны талаар reels хэлбэрээр 20 удаа;

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах сонгон шалгаруулалтын зар 7 удаа;

Нийт 211 удаагийн мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээн ажиллалаа. Энэ нь ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны үйл ажиллагааны тайлант хугацаанд нийтэлсэн мэдээ, мэдээллээс 45 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024 онд нийтэлсэн мэдээллийн тоо 2023 оны мөн үеэс 45 хувиар өсөж, хандалт 91.7 хувиар өссөн байна. “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар хүргэсэн мэдээлэл йдавхардсан тоогоор урт, богино хугацаагаар 628.5 мянган хүнд шууд хүрсэн нь 2023 оны мөн үеэс 67.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан ЭШУС нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 2.1 дэх хэсэг “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд хийсэн хяналт шинжилгээний мэдээллийг 22 удаа хүргэж ажиллав.

МУХЭҮКтХ-уулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах чиг үүргийн хүрээнд ЦЕГ-ын харьяа байгууллага, ШШГЕГ болон түүний харьяа нээлттэй, хаалттай хорих анги, СЭМҮТ, төрийн бус байгууллагын урилгаар нийт зохион байгуулсан мэдээлэл хүргэсэн мэдээг 18 удаа олон нийтэд түгээж ажиллав.

Хүснэгт 32

№	Сургалт хийсэн байгууллага, албан хаагчид	Сургалт хийсэн албан тушаалтан	Сургалтын тоо
1	ШШГЕГ-ын Хорихоос өөр ял эдлүүлэх албаны алба хаагчид	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
2	“Өнөр бүл” төвийн албан хаагчид	ЭШУС хэлтсийн ахлах мэргэжилтэн	1 удаа

3	Говь-Алтай аймаг дахь хууль сахиулах байгууллагын нийт алба хаагчдад	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
4	Баянзүрх дүүргийн төрийн албан хаагчдад	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
5	Баянхонгор аймаг дахь төрийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид	ЭШУС хэлтсийн референт	2 удаа
6	Төв аймаг дахь төрийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид	ЭШУС хэлтсийн референт	1 удаа
7	Налайх дүүрэг дэх төрийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
8	Улсын Ерөнхий Прокурорын газрын Сургалт, судалгааны хүрээлэн, Нийслэл, орон нутгийн прокурорруудад	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
9	ШШГЕГ-ын харьяа 407 дугаар хаалттай, нээлттэй ангийн алба хаагчдад	ЭШУСХ-ийн референт	2 удаа
10	Ховд аймаг дахь аймгийн төрийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
11	Орхон аймаг дахь ШШГГ-ын харьяа 437 дугаар хаалттай, нээлттэй ангийн алба хаагчдад	ЭШУС хэлтсийн референт	1 удаа
12	Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй насанд хүрээгүй хүмүүст	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
13	ШШГЕГ-ын харьяа 423 дугаар хаалттай, нээлттэй ангийн алба хаагчдад	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
14	Өвөрхангай аймаг дахь ШШГГ-ын алба хаагчид	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
15	Ахмад настны үндэсний төвийн албан хаагч, үйлчлүүлэгчдэд	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1 удаа
16	Төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлд	ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	1





Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг гарсан үр дүн цаашид хамтрах ажиллах зорилго зорилтын талаарх мэдээллийг 25 удаа түгээж ажилласан.

 **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаа** ...  
November 12, 2024 · 🌐

👍👍👍 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн тухай Монгол Улсын гурав да... See more



GOGO.MN **Монгол Улсын эрүү шүүлтийн асуудлыг НҮБ хэлэлцэж байна** Call now  
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэ...

Үүнээс цахим орчинд хамгийн өндөр хандалтыг ЭШЭК-ын хэрэгжилтийн тухай Монгол Улсын гурав дахь удаагийн тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр хуралдаанаар хэлэлцэж байна” гэх мэдээлэл авчээ.

*“Швейцарын Холбооны Улсын Женев хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр нэгдсэн чуулганаар ЭШЭК-ын хэрэгжилтийн талаарх гишүүн орнуудын Засгийн газрын тайлангуудаа танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нар 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын ЭШЭК-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг үнэлэх хэлэлцүүлэг болж, Монгол Улс энэхүү конвенцын гурав дахь удаагийн илтгэлээ танилцууллаа.169*

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээллийг зурагт хуудас хэлбэрээр 45 удаа олон нийтэд түгээн ажиллав.

169 “Монгол Улсын гурав дахь удаагийн тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр хуралдаанаар хэлэлцэж байна” мэдээний хэсгээс



Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдлэгт зориулсан “Конвенцыг кодольтё” цуврал зурагт хуудсыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 36 зүйл заалтаар тус бүрээр 36 зурагт хуудсыг бэлтгэн нийтлэв.




ГУРАВДУГААР  
БҮЛЭГ

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пакт, ЭШЭК болон түүний Нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын ХЭҮКтХ, Жагсаал, Цуглаан хийх журмын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг гэрээ, конвенц, хуулиудаар нийт 15 удаагийн зурагт хуудсыг бэлтгэн олон нийтэд түгээн ажиллав.

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх 1-75 минут хүртэлх хугацаатайгаар бичлэг хэлбэрээр 20 удаа түгээн ажилласан. Мөн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн тухай мэдээллийг агуулсан дараах контентыг бүтээж тогтмол давтамжтайгаар түгээн ажиллалаа. Тухайлбал:

- “Яагаад ЭШЭК, түүний Нэмэлт протоколд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ёстой вэ?”
- “Яагаад ЭШУС асуудлыг хуульчлан баталсан бэ?”, “Яагаад ХЭҮК, ЭШУС үндэсний ажиллагаа хоёр чиг үүрэг тусдаа байдаг вэ?”
- “Яагаад ЭШУС үндэсний ажиллагааны төсөв санхүү, хүний нөөцийн хувьд хараат бус, бие даасан байх ёстой вэ?”
- “Яагаад хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийж байгаа вэ?”
- “Яагаад ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай вэ?”
- “Яагаад ЭШЭК-ын Нэмэлт протоколд нэгдэн орж, хараат бус байгууллагыг байгуулах болсон бэ?”
- “ЭШЭК-д дотоодын хуулийг нийцүүлэх ёстой. эрүү шүүлт тулгах, хүчээр мэдүүлэг авах асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэх вэ?”

- “Яагаад эрүү шүүлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх төрийн бодлого чухал вэ?”
- “Яагаад иргэний нийгмийн байгууллагууд хараат бус ЭШУС үндэсний ажиллагааг дэмжиж байгаа вэ?”
- “ЭШУС үндэсний ажиллагаа 2 жил”
- “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц - 40 жил”
- “2014 оны 12 дугаар сарын 11-ний энэ өдөр”
- “ЭШУС үндэсний ажиллагаа-2024 онд” зэрэг нийт 13 контентыг бүтээсэн байна.



Мөн эрүү шүүлтийн хораяул, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх “Эрүү шүүлтгүй Монгол төлөө” сэдэвт цуврал анимешныг бүтээж олон нийтийн сүлжээгээр болон хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” түгээж ажиллав.

Үүнээс “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагааны 2 жил” контент хамгийн өндөр буюу 43.100 үзэлтийн хандалт авчээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны ярилцлагын талаарх мэдээ, мэдээлэл гарсан үр дүнгийн талаар 20 удаа олон нийтэд түгээн ажиллав. Тухайлбал:

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэнгийн оролцсон “Монгол” телевизийн “Хар хайрцаг” нэвтрүүлэг;
- “Эрүүдэн шүүхийн эсрэг нийгэмлэг” олон улсын байгууллагын хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакландын оролцсон Монголын үндэсний олон нийтийн телевизийн “MNB World” сувгийн “Sightline” нэвтрүүлэг;
- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Улсын Ерөнхий Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, ХЗДХЯ, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагчийн газартай хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улс дахь НҮБ-ын суурин зохицуулагч Тапан Мишран, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга А.Энх-Эрдэнэ, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын Ерөнхий Прокурорын туслах прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, АТГ-ын Эрүү шүүлт тулгах, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга эрхэлсэн комиссар Ч.Жаргалбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа П.Очбадрах, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа А.Намсаманд, ШШГЕГ-ын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа П.Оростогоо, СЭМҮТ-ийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Н.Оюунчимэг, “Иргэдийн шударга шүүх” төрийн бус байгууллагын дарга Х.Бат-Ялалт, “Эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Д.Энхбат нарын ярилцлага, илтгэлийг бүрэн эхээр нь цахим хуудсаар дамжуулан түгээв.



УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын илтгэл хамгийн өндөр буюу 21.5 мянган үзэлтийн хандалт аваад байна.

1.НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон Монгол Улсын хуульд заасны дагуу ЭШУС үндэсний ажиллагааны бие даасан байдлыг илүү сайжруулах нь зүйтэй. ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулж буй Монгол Улсын ХЭҮКтХ-ийн зорилт, хэм хэмжээ нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээгээр зорилгод хүрсэн байдал 50 хувь, практикт нийцэн хэрэгжиж буй байдал 22,7 хувьтай байна гэж дүгнэгдсэн. Тиймээс энэ асуудлыг УИХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэж ажиллана.

2.Цагдаагийн байгууллага болон ШШГБ-д ажиллах хүсэлт гаргагчдаас авах мэргэшлийн шалгалтад хүний эрхийн талаарх асуултуудыг оруулах. Үүний дотор эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх асуултыг заавал оруулдаг байх, сурах бичгүүдэд мөн дээр дурдсан агуулгыг тусган, хэрэгжүүлэх гэсэн байна.<sup>170</sup>

“ЭШУС үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн”<sup>171</sup> 2.1 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний ажиллагааны хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийн олон нийтэд хүртээмжтэй хүргэх хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 12-ноос эхлэн 1 минут 30 секунд хүртэлх “Reels”-ийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж эхэлсэн.



170 Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын илтгэлээс гарсан санал дүгнэлтээс

171 “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”, 2024



Энэ хүрээнд Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудад хийсэн хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл гарсан үр дүнгийн талаар 20 удаа reels хэлбэрээр олон нийтэд түгээн ажилласан байна. Үүнээс:

*“УИХ-ын дарга Дашзэвэгийн Амарбаясгалангийн УИХ-ын Намрын чуулганыг хааж хэлсэн үгнээс нэртэй “reel” хамгийн их буюу 14 мянган хандалтыг аваад байна.*

Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 60 гаруй ажлын хэсэг давхардсан тоогоор 90 гаруй удаа хуралдсан байна. Эдгээр ажлын хэсгүүд өнөөдөр эрх зүйн шийдэл нь хүлээгдэж байгаа болон цаг үеийн шаардлагад нийцүүлэн зохицуулалтыг зайлшгүй боловсронгуй болгох шаардлагатай асуудлаар байгуулагдан ажиллаж байна. Тухайлбал, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгэм, эдийн засгийн олон асуудлыг хөндөж байгаа юм. Энэ чуулганаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар”-ыг батлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах, үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх зэрэг 17 чиглэлээр хяналт шалгалтын ажил хэрэгжүүллээ. Энэ хүрээнд Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хяналтын сонсголыг 37 төрийн байгууллага, 87 иргэн, хуулийн этгээд, 2 ажиглагчийг оролцуулан зохион байгууллаа.”<sup>172</sup>

Түүнчлэн “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-2”-ын хүрээнд 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байгаа “reels” хос бичгийн хадмалтай түгээн ажиллаж байна.

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.3.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах гэж заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах бүхий сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд хүргэж ажилласан.

Тухайлбал ном, гарын авлага, сурталчилгааны хэрэглэгдэхүүн боловсруулах, түүний хэвлэхтэй холбоотой хуулийн этгээдийг оролцуулах санал бүхий “Ажлын сонгон шалгаруулалтын зар”-ыг 7 удаа олон нийтэд нийтэлсэн байна.

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар таниулсан 321 удаагийн телевиз, сайт, сонины дүрстэй болон хэвлэмэл ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн байна. Тухайлбал:

<sup>172</sup> УИХ-ын дарга Дашзэвэгийн Амарбаясгалангийн УИХ-ын Намрын чуулганыг хааж хэлсэн үгнээс нэртэй “reel”-ийн хэсгээс

- ЭШУС сэргийлэх үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг 77 хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 211 удаа мэдээлэв;



- Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээллийг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны 70 удаагийн ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээв;



- Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх сонины ярилцлагыг 5 удаа нийтэлсэн.





Энэ нь ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны мөн үеэс нийтэлсэн мэдээ, мэдээллийн дүнгээр 50.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс 2024 онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 213 удаа олон нийтэд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээллийг хүргэсэн бол энэ нь 2023 оны мөн үеэс 63.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэсэн мэдээллийг багцалж тооцвол 73 цагийг зарцуулан ажилласан байна.

ЭШУС үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 136 удаа мэдээлэв.

Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах хүрээнд төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран иргэд, албан тушаалтны оролцоог хангасан 5 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан. Тус мэдээллийг давхардсан 77 мэдээллийн байгууллага сурвалжлан ажиллажээ. Тухайлбал:

- Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээг хэвлэл мэдээллийн 10 байгууллага;
- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, “Эрүүдэн шүүхийн эсрэг нийгэмлэг” олон улсын байгууллагатай хамтран “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сэдэвт сургалтыг хэвлэл мэдээллийн 11 байгууллага;
- Ховд аймаг дахь ШШГ газартай хамтран ховд аймгийн төрийн албан хаагчдад “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 байгууллага;
- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, УЕПГ, АТГ, ХЗДХЯ, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагчийн газартай хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 21 байгууллага сурвалжилж, МРА агентлаг, Eagle телевиз, Өрөг.мн мэдээллийн сайт.;
- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо» уулзалт, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 18 байгууллага сурвалжилж, МРА агентлаг шууд дамжуулж иргэдэд олон нийтэд түгээсэн байна.

Мөн Улсын Их Хурлаас зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”-ийн талаарх хяналтын

сонголд оролцсон асуудлаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн хэвлэл мэдээллийн 14 байгууллагад мэдээлэл өгсөн байна.

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдээлэлтэй холбоотой ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны 70 удаагийн ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээв.



Түүнчлэн ЭШУС сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон нэгжийн албан хаагчид телевиз, сайтын ярилцлагын буланд тогтмол оролцон ажиллав. Тухайлбал:

- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Өрөг.мн, Товч.мн, Зөгий.мн, Зариг.мн, News.мн, Монголын мэдээ, Тэнгэр тв, ТВ9, Монгол телевизийн “Тодруулга” ярилцлагад, Ийгл телевизийн “Зочны цаг”, Ховд телевизийн “Өдрийн зочин”, Монгол телевизийн “Хар хайрцаг” нэвтрүүлэг зэрэг давхардсан тоогоор 68 удаа
- ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Төв, Хонгор телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт 2 удаа



Үүнээс хамгийн өндөр хандалтыг Монгол телевизийн “Хар хайрцаг” нэвтрүүлэг 53,100 хандалт авсан байна.

Мөн “Мэдэх эрх” подкастаар дамжуулан шинэлэг хэлбэрээр ярилцлагыг буланг эхлүүлээд байна.

Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар сонинд 5 удаа ярилцлага өгсөн. Үүнд: ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Монголын үнэн сонины 2024 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн “042” дугаарт “Оюун санаа, хүний эрхийн хувьд нийгэм одоо л солигдож байна”, Өдрийн сонины 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “031” дугаарт “Хүн бүр бие биетэйгээ ахан дүүсийн сэтгэлээр ханд”, ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Өдрийн сонины “032” дугаарт “Хүнийг гэмт хэрэг хүлээлгэх яллах, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох зорилгоор цахим орчныг ашиглах нь эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр” гарчигтай ярилцлага өгсөн.

### **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 ДУГААР ЗҮЙЛИЙН 33.1.1-Т ЗААСАН “БҮХ ГАЗАРТ” УРТ БОЛОН БОГИНО ХУГАЦААГААР БАЙРЛАЖ БАЙГАА ХҮМҮҮСТ БОЛОН ТУХАЙН ГАЗАР АЛБАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА АЛБАН ХААГЧДАД НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД**

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу үндэсний ажиллагааны баг хамт олон тайлант хугацаанд нийт 178 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажиллав. Энэ хүрээнд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуух сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллав.

- “Эрүү шүүлтээс ангид байх эрх”,
- “Хүний эрхийн тухай ойлголт, хүний эрхийн үзэл баримтлал”,
- “Тайлбар, мэдүүлэг”, “ШШГ байгууллагын алба хаагчдын үйлдэж болзошгүй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинж”,
- “Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдэж болзошгүй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинж”,
- “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилт”,



- “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангах зарим асуудал” зэрэг сэдэв болно.

Тайлант хугацаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн мэдлэг ойлголт өгөх нийт 155 удаагийн сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

“Эрүү шүүлтгүй Монгол төлөө” сэдэвт цуврал анимешн, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх мэдээллийг агуулсан нугалбар болон зурагт хуудас, контент (бичлэг, reels, story хэлбэрээр) аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газруудын хүлээлгийн өрөөний дэлгэц, албан хаагчдын цахим хаяг, дотоод сургалт, шугамын радио зэрэг боломжит бүхий хэлбэрээр түгээж ажиллав.







“Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн билл”-ийн хэвлэлийн эхийг бэлтгэн, олон нийтэд түгээхэд бэлэн болсон байна.

Биллд Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пакт, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц Хүүхдийн эрхийн тухай конвенцын бүх зүйл заалтыг багтаан боловсруулагдсан болно.

## ДӨРӨВ.ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ТОГТМОЛ ХАМРАН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, иргэд болон төрийн албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллах хүрээнд “Монголын Үнэн” сонинтой хамтран ажиллах гэрээ 173 байгуулж “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонин буланг тогтмол ажиллуулж байна.



“Эрүү шүүлтгүй Монголын төлөө” булангаар дамжуулан олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хамтарч ажиллах зэрэг шат дараатай арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна. Гэрээний хугацаа 2026 оны 02 сарын 28-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

Мөн “Монголын Үнэн” сонинтой хамтран ажиллах хүрээнд:

- 2025 оны 01 дүгээр сарыг 17-ны өдрийн “002” дугаарт “Зэрэгцээ ертөнцөд гацагсад”;
- 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн “008” дугаарт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо”

173 “Монголын үнэн” сонинтой хамтран ажиллах ХЭҮК/2025/12 тоот гэрээ





- 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “009” дугаарт “Асрамжийн газрыг ахмад настны амьдран суух диваажин болгох хүсэл” зэрэг тусгай сурвалжилгыг бэлтгэн уншигчдад хүргээд байна.

Монголын Үндэсний Олон Нийтийн Радиотой хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хүрээнд “Мэдэх эрх” 10 удаагийн подкастыг эхний дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэж эхлэв. Эхний дугаарын зочноор “Өнөр бүл” хүүхдийн төвийн ерөнхий захирал, үйлчилгээний гавьяат ажилтан М.Өлзийчимэг зочноор оролцлоо. 174 “Мэдэх эрх” подкаст 2025 оны 05 дугаар сар хүртэл үргэлжилнэ.




“Мэдэх эрх” подкастыг МҮОНР-гийн эфирээр нэг удаагийн дугаарыг 3-аас доошгүй удаа, MNB.mn сайтаар болон MNB, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар давхардсан тоогоор 250-300 мянган хүнд хүргэхээр зорилго тавин ажиллаж байна.

174 МҮОНРТ-эй хамтран ажиллах ХЗҮК/2025/31 тоот гэрээ

Тус подкастын зочдоор:

- Б.Эрдэнэболд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга
- Д.Цогтбаатар УИХ-ын гишүүн, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга;
- О.Номинчимэг УИХ-ын гишүүн, УИХ-ын гишүүн;
- О.Мөнхбаатар Улсын Ерөнхий Прокурорын туслах прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга;
- Б.Аззаяа АТГ-ын тэргүүн дэд дарга, шадар комиссар;
- Б.Намсаманд ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд хорих ял эдлүүлэх албаны дарга;
- П.Очбадрах ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа;
- Г.Анхболд СЭМҮТ-ийн захирал;
- Д.Энхбат “Эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлтэй тэмцэх үндэсний холбоо” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал зэрэг зочдыг оролцуулахаар төлөвлөж байна болно.

Монголын сайтын холбоотой хамтран ажиллах санамж бичгийн 175 хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”-ны фейсбүүк хуудсаар олон нийт, албан хаагчдад дамжуулан хүргэж буй бүх мэдээ, мэдээллийг давхар Time.mn, Dorgio.mn, News.mn зэрэг мэдээллийн 10 сайтаар 2025 оны 12 дугаар сарын 31 хүртэл түгээн ажиллана.



175 Монголын сайтын холбоотой хамтран ажиллах 2024/05 тоот санамж бичиг

## ТАВ.ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОР АЮУЛЫГ ТАНИУЛАХ, ОЛОН СУРТАЛЧИЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, ГАРЫН АВЛАГА БҮТЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлж ажиллаад байна. Тухайлбал:

- ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны буюу хоёрдугаар тайланг монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлсэн. Уг тайлангийн монгол, англи хэл дээрх хувилбарыг тус тус хэвлүүлэх зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд түгээн, сонгон шалгаруулалтыг зарлаж, 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр “Испро Плас” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ЭШУС үндэсний ажиллагааны 2023 оны тайланг нийт 500 хувь хэвлүүлэн, холбогдох олон улсын байгууллага, төрийн албан тушаалтан, иргэдэд хүргүүлсэн;
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол Монгол Улсын хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор зөвлөх үйлчилгээний зарыг оло н нийтэд түгээн, сонгон шалгаруулалтыг зарлаж, судлаач Я.Нямсүрэнтэй 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол Монгол Улсын хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх” судалгааны тайланг бүтээж олон нийтийн хүртээл болгосон;
- “Монгол Улсын хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон асрамж халамжийн үйлчилгээ явуулдаг байгууллагууд дахь ялгаварлан гадуурхах хүний эрхийн зөрчлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ”-г хэвлэн нийтэлж олон нийтийн хүртээл болгосон.;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх зорилгоор зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд түгээн, сонгон шалгаруулалтыг зарлаж, судлаач Б.Батзоригтой 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа” судалгааны тайланг бүтээж олон нийтийн хүртээл болгосон.;

Эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах зорилгоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас “Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн билл”-ын эхийг бэлтгэн, хэвлэн нийтлэв.;

•



- Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг сурталчлах, урьдчилан сэргийлэх, түүний хор аюулыг төрийн албан тушаалтан, иргэд, олон нийтэд таниулах анимешн бүтээх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зарлаж иргэн Г.Идэрсайхантай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Монгол Ардын үлгэрийг шинэчлэн бүтээж байна.;



ГУРАВДУГААР  
БҮЛЭГ

- ЭШУС үндэсний ажиллагааны танилцуулга нугалбар хуудсыг 5,000 хувь хэвлүүлэн олон нийтэд түгээн давтамжтайгаар хэвлэж түгээж байна.

“Эрүүдэн шүүхч нар ямарч тохилолз хариугаа хүртдэг...”  
Greg Isterburg

БИДНИЙ ТУХАЙ

Холбоо Барих  
Утас: 1976-11-327136  
Email: nmpm@nhrcm.gov.mn

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА

ЭРҮҮ ШҮҮЛТЭҮЙ МОНГОЛЫН ТӨЛӨӨ...

- Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 25 заалт тус бүрд “АРТ” зурагт хуудас бүтээх, зурагт хуудсыг ашиглан календарь хэвлэх сонгон шалгаруулалтыг зарлаж “Испро Плас” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

## **ЗУРГАА. “ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ, ХҮНЛЭГ БУС ХАРЬЦАА, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХИЙН ТАЛААР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ОЛОН НИЙТЭД СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХИЙХ” ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

Улсын Их Хурлын Тамгын газраас Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн хяналт шинжилгээний танилцуулгаар өгсөн зөвлөмжийн мөрөөр эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх төлөвлөгөө батлуулан ажилласан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлын чанар, хүртээмж, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого бүхий арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэхээр дэд хөтөлбөр, төлөвлөгөө мөн батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав. Үүнд:

- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр” (2 бүлэг, 16 заалттай)
- Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтарсан “Хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гүйцэтгэх ажлын төлөвлөгөө” (16 заалттай)

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрт туссан ажлуудаас дурдвал:

- Цахим сүлжээ ашиглан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийг таниулах хүрээнд сурталчилгаа явуулах;
- МҮОНРТ-той хамтран подкаст бэлтгэн түгээх;
- “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц”-ын талаарх мэдээлэл агуулсан телевизийн контент бэлтгэн нэвтрүүлэх;
- Цагдаагийн газруудын эрүүлжүүлэх, саатуулах байранд “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийг таниулсан гарын авлага, сургалтын материал, мэдээллийн самбар байршуулах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр, хорих ангид “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийг таниулсан гарын авлага, сургалтын материал, мэдээллийн самбар байршуулах;
- “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх”-ийг таниулсан сурталчилгааны хэрэглэгдэхүүн хэвлэх (бал, цагалбар, зурагт хуудас, тэмдэглэлийн дэвтэр);
- “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонины буланг тогтмол ажиллуулах



- “Эрүүдэн шүүхээс ангид байх эрх”-ийн билл хэвлэн, нийтлэх ;

Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 6 ажил, хэрэгжих шатандаа 2 ажил байна.

Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг олон нийтэд сурталчлах, сургалт

## ДОЛОО.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Төрийн байгууллагууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах эх сурвалж болгон ашиглах боломжгүй байгааг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн тайлант хугацаанд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоож ажиллалаа.



Энэ хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 08/450 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд хандсан “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан”-д Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг бүртгэж авах хүсэлтийг тавьж, Хууль

зүй, дотоод хэргийн сайдаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайдад 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/1307 тоот албан бичгээр хандаад байна.

Ингэснээр Төрийн байгууллагууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах найдвартай эх сурвалж ашиглах боломж бүрдэж байна.



## НАЙМ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРТАЛЧИЛГААНЫ СТАТИСТИК ТОО МЭДЭЭ:

Хүснэгт 33

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2023 он	2024 он	Өсөлт
1	Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэд олон нийтэд цахим сүлжээгээр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажиллах	90 мэдээ, мэдээлэл	311 мэдээ, мэдээлэл	145 %
2	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны цахим хуудасны дагагч	Фейсбүүк дагагч 51,000 Твиттер байхгүй	Фейсбүүк дагагч 53,000 Твиттер дагагч 2 мянга	Дагагчийн өсөлт тус бүр 2 мянга
3	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар түгээсэн контентыг хандалт (хамгийн их хандалтаар)	Постерын хамгийн их хандалт 18,000  Бичлэгээс хамгийн их хандалт 45,800	Постерын хамгийн их хандалт 36,000  Бичлэгээс хамгийн их хандалт 51,200	2 дахин  10 %
4	Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар таниулсан телевиз, сайт, сонины дүрстэй болон хэвлэмэл ярилцлага	136 удаа	321 удаа	163,8 %
5	Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд мэдээлсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо	36 хэвлэл мэдээллийн хэрэгсэл	77 хэвлэл мэдээллийн хэрэгсэл	2 дахин
6	Reels	0	20	20 дахин
7	Эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх урт хугацааны бичлэг	5 удаа	20 удаа	4 дахин
8	Нугалбар хуудас	2000 ш	5000 ш	2,5 дахин
9	Сурталчилгааны хэрэглэгдэхүүн	2 судалгаа, гарын авлага	4 судалгаа, гарын авлага	2 дахин
10	ЭШУС үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг	37	155	

## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас хуулиар хүлээсэн чиг үргийн хүрээнд тайлант хугацаанд олон нийтэд, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан болон иргэдэд тогтмол мэдээлэх төлөвлөгөөг баталж, 5 үндсэн ажлыг удиртгал болгон ажиллаж, энэ хүрээнд олон нийтэд мэдээлсэн нийт мэдээллийн тоон үзүүлэлтийг 2023 оны тайлант хугацааны үзүүлэлттэй харьцуулахад 45 хувиар, хандалт 91.7 хувиар тус тус өсжээ.

ЭШУС үндэсний ажиллагааны сурталчилгааны хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт өсөн ажлын үзүүлэлт тус тус өссөн дүнтэй байна.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк дэх цахим хуудас, “NPM-Mongolia” твиттер хуудаст Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаарх мэдээлэл 211 удаа, зурагт хуудас хэлбэрээр 55 удаа, урт болон богино хугацаатай видео бичлэг 40 удаа, урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны ярилцлагыг 30 удаа, үйл ажиллагааны талаар reels хэлбэрээр 20 удаа тайлант хугацаанд түгээж, тайлант хугацаанд давхардсан тоогоор 628,000 хүнд шууд хүрч, хандалтын хувь 2023 оны мөн үеэс 67,2 хувиар өсчээ.

Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах хүрээнд Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээг хэвлэл мэдээллийн 10 байгууллага, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, “Эрүүдэн шүүхийн эсрэг нийгэмлэг” олон улсын байгууллагатай хамтран “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сэдэвт сургалтыг хэвлэл мэдээллийн 11 байгууллага, Ховд аймаг дахь ШШГ газартай хамтран ховд аймгийн төрийн албан хаагчдад “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 байгууллага, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, УЕПГ, АТГ, ХЗДХЯ, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагчийн газартай хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 21 байгууллага сурвалжилж, МРА агентлаг, Eagle телевиз, Өрөг.мн мэдээллийн сайт, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо» уулзалт, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 18 байгууллага сурвалжилж, МРА агентлаг шууд дамжуулжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 136 удаагийн мэдээллийг хүргэж ажиллажээ. Тухайлбал:

- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Өрөг.мн, Товч.мн, Зөгий.мн, Зариг.мн, News.мн, “Монголын мэдээ”, Тэнгэр телевиз, ТВ9 телевиз,

Монгол телевизийн “Тодруулга” ярилцлагад, Тэнгэр телевизийн “De facto” нэвтрүүлэг, Ийгл телевизийн “Зочны цаг”, Ховд телевизийн “Өдрийн зочин”, Монгол телевизийн “Хар хайрцаг” нэвтрүүлэгт

- ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Төв, Хонгор телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт
- УИХ-аас болон ЭШУС үндэсний ажиллагаа зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, хурлын үеэр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн 63 хэвлэл мэдээллийн байгууллагад давхардсан тоогоор 122 удаа ярилцлага өгч ажиллалаа.

Мөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн “Монголын үнэн” сонины 2024 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн “042” дугаарт “Оюун санаа, хүний эрхийн хувьд нийгэм одоо л солигдож байна”, Өдрийн сонины 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “031” дугаарт “Хүн бүр бие биетэйгээ ахан дүүсийн сэтгэлээр ханд”, ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Өдрийн сонины “032” дугаарт “Хүнийг гэмт хэрэг хүлээлгэх яллах, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох зорилгоор цахим орчныг ашиглах нь эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр” гарчигтай ярилцлага өгсөн байна.

Тайлант хугацаанд эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх нийт 172 цагийн мэдээ, мэдээллийг түгээж ажиллажээ.

ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, иргэд болон төрийн албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллах хүрээнд “Монголын Үнэн” сонин, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Монголын сайтын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонины булан “Мэдэх эрх” подкаст, бэлтгэн тогтмол хүргэж ажиллаж байна.

“Эрүү шүүлтгүй Монголын төлөө” булангаар дамжуулан олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хамтарч ажиллах зэрэг шат дараатай арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна. Гэрээний хугацаа 2026 оны 02 сарын 28-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

“Мэдэх эрх” 10 удаагийн подкаст 2025 оны 03 дугаар сарын 08-наас 05 дугаар сар 25 хүртэл хүртэл үргэлжилж, МҮОНР-гийн эфирээр нэг удаагийн дугаарыг 3-аас доошгүй удаа, MNB.mn сайтаар болон MNB, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар давхардсан тоогоор 250-300 мянган хүнд хүргэхээр зорилго тавин ажиллаж байна.

ЭШУС үндэсний ажиллагаанаас төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн урилгаар 18 удаа 176, 57 удаагийн хяналт шинжилгээний үеэр 153 удаагийн танхимын болон цахим сургалтаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулжээ. Хяналт шинжилгээний үеэр ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс Цагдаа, ШШГ байгууллага, СЭМҮТ-ийн 1,200 алба хаагчдаас авсан асуумжаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар таны ойлголт? гэх асуултад 95 хувь “Сайн” гэж, эрүү шүүлтийн талаарх мэдээллийн хаанаас авсан бэ? гэх асуултад “ЭШУС

үндэсний ажиллагаанаас” гэж хариулсан нь сургалт, нөлөөллийн ажлын үр дүнг гарч байгааг шууд харуулж байна.

Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах хүрээнд цуврал анимейшн, нугалбар хуудас, мэдээллийн самбар, зурагт хуудас, цаглавар зэрэг олон төрлийн сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг бүтээв.

Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийн доромжлон харьцаж шийтгэх тухай ойлголтыг агуулсан хүүхдэд зориулсан анимейшныг бүтээж хүүхдийн асрамж халамжийн байгууллагад байгаа хүүхдүүдэд эрүү шүүлтийн хор аюулыг ойлгуулах боломжтой болж байна.

Нугалбар хуудас, мэдээллийн самбарын загварыг боловсруулж ШШГ байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байрнуудын эргэлт уулзалтын танхим, хүлээлгийн өрөө, хоригдлын амьдралын бүс, СЭМҮТ-д байршууллаа.

Анимейшн, контент бүтээл зэрэг сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг хүүхдийн асрамж халамжийн байгууллага, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан газруудын хүлээлгийн өрөө, эргэлт уулзалтын танхимын дэлгэцээр, албан хаагчдын цахим хаяг, дотоод сургалт, шугамын радио зэрэг бүхий л боломжит хувилбарыг ашиглан тасралтгүй түгээснээр өөрийн хүслээр гарч явах боломжгүй газарт байгаа иргэд, албан хаагчдын эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт нэмэгдэж байгаа нь тэдгээр иргэд, албан хаагчдаас авдаг асуумж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан ирүүлж буй өргөдөл, гомдлын агуулга, тоо бүртгэлээс харагдаж байна.

Мэдээллийн самбарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг ахмад настны болон хүүхдийн асрамж, халамжийн бүх байгууллагад үе шаттайгаар байршуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг зорьж байна.

Төрийн байгууллагууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах эх сурвалж болгон ашиглах боломжгүй байгааг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн тайлант хугацаанд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоосон.

Энэ асуудлыг арилгуулахын тулд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан"-д Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг бүртгэж авах талаар 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 08/450 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд хандсан Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайдад 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/1307 тоот албан бичгээр хандаад байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэснээр дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд

эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлыг дан ганц ЭШУС үндэсний ажиллагаа бус бусад төрийн болон төрийн бус байгууллага баталгаат эх сурвалж болгон ашиглах боломжтой

Иргэдэд эрүү шүүлтийн хор аюулын таниулахад ЭШУС үндэсний ажиллагааны явц, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан иргэд, олон нийтэд түгээх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд мэдээ, мэдээллийн хугацааг 1 минут 30 секундэд багтаан бэлтгэх нь илүү олон хүнд хүрч өндөр хандалт авдаг болох нь ажиглагдсан.

Иймд цахим орчинд хамгийн их хандалт авдаг аргыг ашиглаж “reels” бүтээж эхэлсэн бөгөөд “УИХ-ын дарга Дашзэвэгийн Амарбаясгалангийн УИХ-ын Намрын чуулганыг хааж хэлсэн үгнээс” нэртэй reel 24 цагийн хугацаанд хамгийн их буюу 14,000 хандалтыг авсан байна.

### САНАЛ

1. Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар иргэдэд болон төрийн албан хаагчдад таниулах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн бүх байгууллагад үүрэг болгох;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлах, Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар иргэдэд болон төрийн албан хаагчдад таниулах” ажлыг тусгах;







## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 4.1 НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр дэлхий даяар эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх ажлыг илүү үр дүнтэй болгох зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц<sup>177</sup> (цаашид “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц” гэх)-ийг баталсан. Сүүлийн 40 жилийн хугацаанд энэхүү түүхэн баримт бичиг нь эрүү шүүлтийн эсрэг дэлхий нийтийн тэмцэл, шударга ёсны төлөөх тэмцэл, хохирогчдод нөхөн төлбөр олгохын үндэс суурь болсоор иржээ.

Хүн төрөлхтөн, тэр дундаа Европын улс орон 1700-аад оны үеэс эрүүдэн шүүх явдлыг хуулиар хориглож ирсэн бол дэлхийн 2 дугаар дайны үед дайны оролцогч талуудын үйлдсэн харгислал илчлэгдсэнээр олон улсын хүний эрхийн эрх зүйд эрүү шүүлтийн эсрэг нэгдсэн арга хэрэгслүүд бий болж, хэрэгжиж эхэлсэн түүхтэй.

НҮБ-ын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1949 оны Женевийн конвенцууд, ялангуяа Дайнд олзлогдогсодтой харьцах тухай конвенц, Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай конвенцуудад эрүүдэн шүүх болон түүнтэй адилтгах хүнлэг бус харьцахыг хориглосон тухай анхны хариу арга хэмжээнүүд тусгагджээ. Улмаар 1966 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт батлагдаж, тус гэрээнд нэгдэн орсон бүх улс орон эрүүдэн шүүхийг хориглох үүрэг хүлээх болов.

Эрүүдэн шүүхийг эсэргүүцсэн олон улсад өрнөсөн энэхүү уур амьсгалаас улбаалж, НҮБ шинэ, шийдвэртэй арга хэмжээ авах кампанит ажил хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Ерөнхий Ассамблей эрүүдэн шүүхийг хязгаарлах, эцэст нь таслан зогсоох зорилготой хэд хэдэн баримт бичгийг баталсан юм. Эдгээрээс хамгийн чухал нь эрүүдэн шүүхийг хориглох олон улсын баримт бичгийн үндсийг тавьсан 1975 оны Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс бүх хүнийг хамгаалах тухай тунхаглал билээ.

Үүний дараа 1978 онд Хууль сахиулах байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг батлав. Эрх чөлөөгөө хасуулсан хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахад эрүүл мэндийн ажилтнууд, ялангуяа эмч нарын гүйцэтгэх үүрэгтэй холбоотой Эмнэлгийн ёс зүйн зарчмуудыг 1982 онд, аливаа хэлбэрээр баривчлагдсан болон хорих ял эдэлж байгаа бүх хүнийг хамгаалах зарчмуудын багцыг 1988 онд тус тус батлав.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц 1984 онд батлагдсанаар эрүү шүүлттэй тэмцэх дэлхий нийтийн хамтын хүчин чармайлт оргил үедээ иржээ. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдах 1980-аад он нь хүйтэн дайны хурцадмал байдал,

<sup>177</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

колоницлолоос ангижирсан үндэстнүүдийн бие даасан байдлын төлөөх тэмцэл, геополитикийн хөтөлбөрийг тодорхойлж байсан үе юм.

Конвенцод нэгдэн орсон улс орнууд эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцахыг туйлын хориглох, цаашлаад эрүү шүүлт тулгасан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүдэн шүүх болон түүнтэй адилтгах зүй бус харьцсан гэх гомдлыг шалгах, эрүүдэн шүүсэн этгээдийг яллах, хохирогчдын хохирлыг барагдуулах үүрэг хүлээсэн байдаг.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 174 улс нэгдэн орсон хэдий ч дэлхийн улс орнуудын дөрөвний гуравт нь эрүүдэн шүүх явдал үйлдэгдсээр буй тухай мэдээлэл бий.

Иймд НҮБ-ын гэрээний байгууллагууд эрүүдэн шүүх явдалтай хийж буй тэмцлээ хоёр дахин нэмэгдүүлэхийг Оролцогч улсуудын Засгийн газар, ХЭҮБ-ууд, УСҮБ, хяналт, тайлагналын механизмууд болон бусад оролцогч талуудад уриалж байгаа билээ.

## НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ОН ДАРААЛАЛ

Хүснэгт 34

1984 он	НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар батлав
1987 он	Эхний 20 улс Конвенцод нэгдэн орсноор 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэв
2000 он	Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг соёрхон батлах тухай хуулийг 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталснаар нэгдэн оров
2002 он	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг батлав
2006 он	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд эхний 20 улс нэгдэн орсноор 2006 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэв
2014 он	Монгол Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлав
2020 он	Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын ХЭҮКтХ-ийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгав
2022 он	Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны олон талт төлөөлөл оролцсон Комиссын олонхын саналаар 7 үе шатын турш үргэлжилсэн сонсголын сонгон шалгаруулалтаар хууль зүйн ухааны доктор Ядамжавын Цэлмэн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их хурлын 29 дүгээр тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд томилогдов

Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг соёрхон батлах тухай хуулийг 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталснаар нэгдэн оржээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын

гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасны дагуу хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн эрх зүйн зохицуулалт дотоодын хууль, тогтоомж болон нэгдэн орсон энэхүү конвенцын дагуу зохицуулагдаж байна.

## **МОНГОЛ УЛС ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦОД НЭГДЭЖ ОРСНООР ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ОРУУЛСАН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД**

Хүний эрхийг хязгаарлах, хүнийг нэгжих, баривчлах үндэслэл журам, түүнд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэж, нийгмийн хэв журмыг сахих зарчмыг мөрдүүлэх чиглэлээр нарийвчилсан зохицуулалт хийх зорилгоор:

### Шинэчлэн боловсруулсан, нэмэлт өөрчлөлт оруулж баталсан:

- Эрүүгийн хууль /2002/
- Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль/2008-02-01/
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль
- ИХШХШТХ
- Иргэний хууль
- Шүүхийн тухай хууль
- Прокурорын байгууллагын тухай хууль
- ШШГТХ
- Өмгөөллийн тухай хууль
- ГБХТТХ

### Шинээр боловсруулсан:

- 2000 он – Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль.

Энэ хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаараа буюу хамтарч хуульд заасны дагуу ХЭҮК-т гомдол гаргах эрхтэй болсон.

- 2002 он – Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

Уг хууль батлагдсанаар Засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, дур зоргоор аашлах явдлаас хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг нь сэргээн тогтоох, эрх зүйн шударга дэг журмыг дэмжих эрх зүйн үндэс бүрэлдэв.

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нэгдэж орсноор хууль, эрх зүйн орчинд оруулсан нэмэлт өөрчлөлт:

- 2020 он – Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль.

Хуульд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг болон түүнд туслах нэгжийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэ бүлэгт тусган баталснаар Нэмэлт протоколд нэгдэж орсноос хойш 8 жилийн дараа буюу 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр асуудал эрхэлсэн гишүүнийг УИХ-аас томилж, ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдсан.

## **НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИЛТГЭЛҮҮД**

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Оролцогч улс нь энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээний тухай илтгэлээ конвенцод нэгдэн орсноос хойш нэг жилийн дотор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламлан Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлдэг.

Түүнээс хойш Оролцогч улс нь шинээр авсан арга хэмжээний талаарх нэмэлт илтгэлийг дөрвөн жилд нэг удаа НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлэх тайлагналын тогтолцоотой.

Уг тайлагналын тогтолцооны дагуу Монгол Улсын Засгийн газар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх гурван удаагийн илтгэлийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тайлагнаж, дагаж мөрдөх гурван удаагийн зөвлөмжийг хорооны зүгээс хүлээн авч, хэрэгжилтийг хангаж байна.

## **НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН I ИЛТГЭЛ (2009 ОН):**

Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх анхдугаар илтгэлээ 2009 онд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тавьсан. Улмаар илтгэлийг хэлэлцээд Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 2010 оны 11 дүгээр сарын 5, 8-ны өдрийн 976 дахь хурлаар баталсан зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын I илтгэл нь конвенцын 1-16 дугаар зүйлээр хүлээсэн үүргүүдийн тус бүрийн 2000-2007 оны хэрэгжилтийг агуулсан. Тухайлбал:

### **Конвенцын 1 дүгээр зүйлийн хэрэгжилт (“эрүүдэн шүүх” гэмт хэргийн тодорхойлолт):**

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж,
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10.4-т “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжил болохгүй” гэж,

- ЭХ-ийн 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар илүү дэлгэрэнгүй тусгасан. Энэ хэргийн улмаас хүний бие махбодод хүндэвтэр, хүнд гэмтэл, их хэмжээний хохирол учирсан бол хүнд гэмт хэрэгт тооцож ял оноох эрх зүйн орчин бий болсон.

### **Конвенцын 2 дугаар зүйлийн хэрэгжилт (урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээ авах)**

Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүдэн шүүх аливаа үйлдлийг гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх, гарсан нөхцөлд хариуцлага тооцох, түүнийг арилгах, засаж залруулах талаар хуулиудад тусгайлан заасан. Тухайлбал:

- ЭХ-ийн 7 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” гэж,
- ШШГТХ-д (2007 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хууль) “ялтан ял эдлүүлэх байгууллагын зүгээс хүнлэг харьцахыг шаардах, хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй” гэж тусгасан.

### **ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН I ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД (2010 ОН)**

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 2010 оны 11 дүгээр сарын 5,8-ны өдрүүдийн 963, 964 дэх хуралдаанаараа Монгол Улсын анхдугаар илтгэлийг хэлэлцээд дараах зөвлөмжийг батлан, манай улсын Засгийн газарт ирүүлсэн.

#### **Эерэг тал:**

- Хүний эрхийг илүү сайн хамгаалахын тулд хууль тогтоомжоо байнга шинэтгэж буй хүчин чармайлт
- Хүний эрхийг илүү сайн хамгаалахын тулд шинэ бодлого баримталж, авч хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүд

#### **Анхаарал хандуулах гол асуудлууд буюу зөвлөмж (нийт 21 зөвлөмж)-өөс:**

- Конвенцын 1 дүгээр зүйлтэй нийцсэн тодорхойлолт Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй байна. Оролцогч улс нь эрүүгийн хууль тогтоомждоо “эрүүдэн шүүх”-ийн тодорхойлолтыг тусгах хэрэгтэй.
- Конвенцын 4 дүгээр зүйлд нийцүүлэн эрүүдэн шүүх гэмт хэргийг эрүү шүүлт тулгахаас салгах, гэмт хэргийн хүнд хөнгөнөөс хамаарч ял ноогдуулах талаар хууль тогтоомждоо тусгах.
- ХЭҮК-ийн 2008 оны 07 дугаар сарын 01-ний онц байдлын үеэр хүний эрх зөрчигдөөгүй гэж гаргасан харамсалтай мэдэгдэл дээр үндэслэн шүүх байгууллага эрүүдэн шүүх, зүй бус үйлдлийн талаар ирсэн гомдлуудыг хэрэгсэхгүй болгосон ба хүч хэрэглэн авсан мэдүүлгийг сүүлд сэжигтний эсрэг шүүхэд ашигласан байна.
- Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа баривчлах байруудад системтэй, гэнэтийн шалгалт хийх, эрүүдэн шүүхтэй холбоотой өргөдөл гомдлыг авч үзэх зэрэг эрхийг ХЭҮК-д олгох шаардлагатай.



- Эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг Монгол Улсын шүүх өнөөг хүртэл нотлох баримт болгож байна. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч “сэжигтнийг яллахдаа мэдүүлэгт хэт найддаг шүүхийн тогтолцоо нь “эрүүдэн шүүх, зүй бус үйлдлийн эрсдэлийг бодит болгож байна” гэжээ.

## **ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН II ИЛТГЭЛ (2014 ОН)**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын II илтгэл нь Конвенцын 1-16 дугаар зүйлээр хүлээсэн үүргүүдийн тус бүрийн 2010-2014 оны хэрэгжилтийг агуулсан. Тухайлбал:

### **Конвенцын 12 дугаар зүйл (Эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах):**

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн дагуу эрүү шүүлт тулгах гэмт хэргийг Цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаагч шалгахаар болсон. Энэ төрлийн гэмт хэргийн холбогдогчоор 2007-2012 онуудад шүүгч 25, прокурор 26, мөрдөн байцаагч 115, хэрэг бүртгэгч 108, цагдаагийн байгууллагын бусад ажилтан 1094, тагнуулын байгууллагын 39 ажилтан холбогджээ.
- ХЭҮК нь 2013 онд хорих анги, цагдан хорих байгууллагад хоригдож байгаа 289 хүнээс гомдол хүлээн авсан. Эрүүдэн шүүх, нэр төрийг нь доромжлон харьцаж байгаа талаар гомдлууд улам бүр өсөн нэмэгдэж байгаа тул хорих ангиудад байнгын шалгалт хийж, сургалт зохион байгуулдаг болсон.
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

## **ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН II ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД /2016 ОН/**

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 2016 оны 08 дугаар сарын 2, 3-ны өдрүүдийн 1,443, 1,445 дахь хуралдаанаараа Монгол Улсын хоёр дахь илтгэлийг хэлэлцээд дараах зөвлөмжийг манай улсын Засгийн газарт ирүүлсэн.

### **Зерэг тал**

- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг соёрхон баталсан.
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцыг соёрхон баталсан.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталсан.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан.
- 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн ЭХХШТХ-д “Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг энэ хуульд заасан журмаар нотлох баримтаар тооцохгүй” гэж найруулсан.

### **Анхаарал хандуулах гол асуудлууд буюу зөвлөмж (нийт 39 зөвлөмж)-өөс:**

- Монгол Улсын ХЭҮК-ын бүрэн эрхийг өргөтгөж, түүний дотор Конвенцын Нэмэлт протоколын дагуу ЭШУС үндэсний ажиллагаа болгон тодорхойлсон хуулийн төслийг анхааралдаа авах, Комиссын төсөв жил бүр буурч, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц байж болзошгүй байна.
- Монгол Улсын ХЭҮК-ын шинэчилсэн хуулийн дагуу цагдаагийн байгууллага, түүний ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, одоогийн эрх мэдэл, түүний дотор урьдчилан сэргийлэх механизм болох чадавхыг бэхжүүлэх, конвенц, түүний Нэмэлт протокол, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны “Удирдамж”-ийг бүрэн дагаж мөрдөх ёстой.

### **ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН III ИЛТГЭЛ (2020)**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын III илтгэл нь Конвенцын 1-16 дугаар зүйлээр хүлээсэн үүргүүдийн тус бүрийн 2017-2020 оны хэрэгжилтийг 416 зүйлээр тайлагнасан. Тухайлбал:

#### **Хүний эрхийн үндэсний байгууллага, үндэсний урьдчилан сэргийлэх механизм:**

- ХЭҮКТХ-ийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан. Хуульд ЭШУС үндэсний ажиллагааг бий болгох талаар тусгасан.
- ЭШУС үндэсний ажиллагааг бий болгож, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаа явуулах гишүүн болон нэгжийн чиг үүргийг хуульд тусгасан. Тус нэгжид удирдах 1 ажилтан буюу гишүүнээс гадна гүйцэтгэх 7 албан хаагч, үйлчлэх 3 ажилтны орон тоог баталсан байна.
- ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй ажиллуулахтай холбоотой зардлыг 339,134,850 төгрөгийг 2021 оны улсын төсөвт тусгасан. Иймд санхүүгийн хувьд үйл ажиллагаа явуулах нөхцөл хангагдсан болно.

### **ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН III ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД МОНГОЛ УЛСАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД (2024 ОН)**

НҮБ-ын Гэрээний хороодын тайлагналын механизмын дагуу Монгол Улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн гурав дахь илтгэлийг Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр хуралдаанаар хэлэлцлээ.

Хуралдаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх төв, Дэлхийн худалдааны байгууллага болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс болон ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ болон иргэний нийгмийн төлөөлөгчид биечлэн оролцов.

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Оролцогч улсын илтгэлийн хэлэлцүүлгийн явцад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор байгуулагдсан Үндэсний урьдчилан сэргийлэх механизм буюу Монгол Улсын тухайд ЭШУС үндэсний ажиллагаа, ХЭҮК болон ТББ-ын төлөөлөлтэй хаалттай уулзалт хийж, ажиглалт зөвлөмж гаргах явцад өөрсдийн санал, дүгнэлтийг Хороодын гишүүдэд танилцуулах эрхийг олгосон байдаг.

Энэ хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид, НҮБ-ын ЭШУС Дэд хорооны дарга, гишүүдтэй албан ёсны уулзалт хийж, Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй хүчин чармайлтын талаар санал солилцов.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны гишүүдийн зүгээс “Монгол Улс ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалсан.

ЭШУС үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгохыг удаа дараа сануулсаар ирсэн бөгөөд энэ удаад ч дахин сануулж байгаагаа уламжлав.

Монгол Улсын илтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулан уг хуралдаанд оролцсон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын дарга, төлөөлөгчид “Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсийн УСҮБ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч ХЭҮБ-ууд болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын бүс нутгийн бусад Оролцогч улсууддаа “үлгэр жишээ” болж буйг онцолж, олон улсын түвшинд мэдээлсэн билээ.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа ажиглалт, дүгнэлтийг баталсан.

Эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах гэмт хэргийг мөрдөн шалгах тусгай алба байгуулах тухай хуулийн төслийг Монгол Улс 2025 онд өргөн мэдүүлэх үүрэг хүлээж буйг тус хороо тэмдэглэсэн ч сүүлийн хэлэлцүүлгээс хойш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч байгаад санаа зовниж байгаа болон АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс, ЦЕГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй, мөрдөн шалгах ажиллагаа үр дүнгүй, эрүүдэн шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол өндөр байгаад тус хороо санаа зовнисоор байгаа тухай уг ажиглалт, дүгнэлтэд дурдсан байна.

Түүнчлэн төрийн албан хаагч, тэр дундаа эрүүдэн шүүх, зүй бус харьцсан хэрэг үйлдсэн хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг мөрдөн шалгах бие даасан механизмыг бий болгох тухай хуулийг эцэслэн боловсруулж, хэрэг мөрдөн шалгах этгээд нь гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдтэй байгууллагын болон шат шатны түвшинд ямарваа харилцаа тогтоохгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийг Монгол Улсад анхааруулсан.

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь ажиглалтдаа Монгол Улс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж байгааг онцлон тэмдэглээд, ТЕГ болон АТГ-аас олон тооны баривчилгааг прокурорын зөвшөөрлөөр шүүхийн шийдвэргүйгээр хийсэн хэвээр байна гэсэн мэдээлэлд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна. Эдгээр нэн даруй баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг сайжруулах талаар Монгол Улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг Хороо анхааралдаа авч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудаас онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн (баривчлах) хэргээс бусад тохиолдолд баривчлах ажиллагааг явуулахын тулд шүүхийн байгууллагаас гаргасан баривчлах шийдвэр авахыг шаардахыг Монгол Улсад анхааруулсан байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Монгол Улсын ХЭҮКтХ-ийг 2020 онд шинэчлэн найруулж ЭШУС үндэсний ажиллагааг байгуулсан, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан.

Гэвч ЭШУС үндэсний ажиллагааны бүрэн эрхтэй холбоотой дараах асуудалд Монгол Улсын Засгийн газрын анхаарлыг хандуулсан. Үүнд:

- Үндэсний ажиллагааны бүрэн эрхэд хамаарах үйл ажиллагаа, тухайлбал, Оролцогч улсын газарзүйн байрлал, сорилтуудын нөхцөлд хяналт шинжилгээ хийхэд хүний нөөц нь хязгаарлагдмал, төрөл бүрийн мэргэжилтнээс бүрдээгүй, албан хаагчид нь чиг үүргээ бие даан хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ойлгомжтой бөгөөд тодорхой чиг үүргийн дархлаа байхгүй байна;
- ХЭҮК-ын нэгдсэн төсөвт ЭШУС үндэсний ажиллагааны төсвийн тусдаа зориулалт байхгүй, төсвийн бие даасан байдал байхгүй байна;
- Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын тайлбар нь тус ЭШУС үндэсний ажиллагааг зөвхөн уг жагсаалтаар хязгаарлагдсан эрх чөлөөгөө хасуулах газруудад нэвтрэх боломжийг олгосон байна.

Улмаар ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхийн тулд:

- (а) санхүүгийн болон хүний нөөцөөр хангах, тэр дундаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дагуу эрх чөлөөгөө хасуулсан бүх газарт үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжилтнүүд зэрэг мэргэшсэн олон талт хүний нөөцөөр хангах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархлааг хуулиар тогтоох;
- (б) ХЭҮК-ын төсвөөс ЭШУС үндэсний ажиллагааны төсвийн бие даасан байдлыг хангах;
- (в) ХЭҮКтХ-ийн 33.1.1 дэх хэсэг, түүний тайлбарт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлд заасны дагуу болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ерөнхий тайлбарын 1-д тусгаснаар эрх чөлөөгөө хасуулсан газрын иж бүрэн жагсаалтыг багтааж, нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газарт өгсөн.

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 34.1.7-д заасны дагуу, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны урьдчилсан ажиглалт, дүгнэлтийн 51-д тусгасныг үндэс болгон Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Монгол Улсын ээлжит гурав дахь илтгэлийн ажиглалт, дүгнэлтийн албан бус орчуулгыг бүрэн эхээр нь нийтэлж, Монгол Улсын төрийн байгууллагууд, иргэдэд хүргэж байна. (Хавсралт 2, 3-аас танилцана уу)

## НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРООНЫ АЙЛЧЛАЛ

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд 2025 эхний сарын байдлаар 94 улс нэгдэн ороод байна. Нэмэлт протоколын Орлоцогч улсууд нь хүний эрх чөлөөг хасах, эсхүл өөрийн дураар орхин гарч явах боломжгүй бүх газарт урьдчилан мэдэгдэлгүй, гэнэтийн байдлаар саадгүй нэвтрэхийг НҮБ-ын ЭШУС Дэд хороонд зөвшөөрөх үүргийг хүлээдэг.

Дэд хороо нь Нэмэлт протоколд Орлоцогч улсуудад айлчлах, зөвлөмж өгөх замаар эрх чөлөөгөө хасуулсан, эсхүл өөрийн дураар орхин гарч явах боломжгүй газар буй хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн өөрийн зөвлөмж, ажиглалтаа Орлоцогч улсын Засгийн газарт, шаардлагатай тохиолдолд УСҮБ-д нууцлал бүхий тайлангаар дамжуулан хүргэдэг.

ЭШУС Дэд хороо нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын хүрээнд олгогдсон бүрэн эрхийн дагуу Монгол Улсад хийх анхдугаар айлчлалаа 2017 оны 09 дүгээр сарын 11-20-ны өдрүүдэд хийв.

Дэд хорооны гишүүн Малколм Д.Эванс айлчлалын бүрэлдэхүүнийг ахалж, Сатябхоошун Гупт Дома, Мария Дэфинис-Гояанофик, Коста Митровик, Маргарет Остэрфэлд, Виктор Захария нарын Дэд хорооны гишүүд болон НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын ажлын албаны хүний эрхийн асуудал хариуцсан гурван ажилтан, НҮБ-ын Аюулгүй байдлын асуудал хариуцсан хоёр ажилтан,

дөрвөн орчуулагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж, цагдаагийн хэлтсүүд, хорих ангиуд, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг, эрүүл мэндийн, сэтгэцийн, цэргийн сахилгын байруудтай газар дээр нь танилцсан бол Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагууд, төрийн албан хаагчид, Монгол Улсад үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ХЭҮК, Иргэний нийгмийн байгууллагуудын гишүүдтэй уулзалт хийсэн ба айлчлалын ажиглалт, зөвлөмжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Засгийн газарт хүргүүлсэн.

### **НҮБ-ЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРООНЫ МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН ХОЁР ДАХЬ АЙЛЧЛАЛ**



ДӨРӨВДҮГЭЭР  
БҮЛЭГ

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 11(б)-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Дэд хороо нь Оролцогч улсын УСҮБ-д (Монгол Улсын тухайд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”) зөвлөх айлчлал хийдэг бөгөөд энэ айлчлалаараа УСҮБ болон Оролцогч улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй ажиллах техникийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, чадавхжуулах, практик үйл ажиллагаа явуулах замаар бүрэн эрхийг дэмжих, чадавхыг бэхжүүлэхийг зорьж ажилладаг.





ЭШУС Дэд хороо нь зөвлөх айлчлалын хүрээнд тухайн Оролцогч улсын УСҮБ-ын чиг үүргээ хэрэгжүүлж буй хууль эрх зүйн болон практик орчинд анхаарлаа хандуулах, холбогдох үндэсний байгууллага, иргэний нийгэмтэй шууд харилцаж, тэдгээрийн явуулж буй үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцах уулзалтууд өрнөдөг бөгөөд УСҮБ-тай хамтран хүний эрх чөлөөг хасах газруудад хийх хяналт шинжилгээ ч багтдаг.

Хяналт шинжилгээний зорилго нь УСҮБ-ыг чадавхжуулахад зөвлөн туслах, улмаар эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцахаас хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэхэд оршино. Тиймээс ч ЭШУС Дэд хорооны зөвлөх айлчлал нь тухайн нөхцөл байдалд тулгуурласан онцлогтой байдаг бөгөөд УСҮБ-ын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой.

ЭШУС Дэд хороо нь зөвлөн туслах чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсад хийх хоёр дахь айлчлалаа 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд Дэд хорооны гишүүн Элина Штайнерт (айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн), Ника Кварачелиа, Аника Томсик, Мартин Зинклер, түүнчлэн Дэд хорооны Нарийн бичгийн даргын газрын хүний эрхийн хоёр ажилтан нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн, Дэд хорооны гишүүн Элина Штайнерт “Долоон жилийн өмнөх Дэд хорооны айлчлалаас хойш Монгол Улсын Засгийн газар нь ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулсан нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чухал алхам болжээ. Энэ удаагийн айлчлалаар Монгол Улсын Засгийн газар Дэд хорооны өмнөх айлчлалаас гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх, шинэхэн байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд түлхүү анхаарах болно” хэмээн энэхүү айлчлалын зорилгыг тодорхойлсон.

ЭШУС Дэд хорооны Монгол Улсад хийх айлчлалын ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажиллах хөтөлбөрийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн эхний хагаст ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчидтай уулзаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилтийг зохицуулах хууль эрх зүйн орчин, практик хэрэгжилт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын хэрэгжилтийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл солилцсон бол хоёрдугаар хагаст ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд, стратегийн төлөвлөлт, хяналт шинжилгээний төрөл, зорилго, тайлан, зөвлөмж боловсруулах, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох байгууллагатай үргэлжилсэн яриа хэлэлцээ өрнүүлэх арга барил, зорилго, үр дүн, үндэсний хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, олон нийт, төрийн албан хаагчдад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдлэг мэдээлэл олгох сургалт, нөлөөллийн



арга хэмжээ зэрэг урьдчилан сэргийлэх бусад үйл ажиллагаа, Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад хийх хяналт шинжилгээ хүрээнд сэдэвчилсэн сургалтыг албан хаагчдад явуулав.

Хөтөлбөрийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр СЭМҮТ болон “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар, 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай 427 дугаар хорих анги, Баривчлах төвд хамтарсан хяналт шинжилгээ хийсэн.



Хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ нь эрх чөлөөгөө хасуулсан иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдалд ажиглалт хийх зорилготой боловч, нөгөөтээгүүр ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдын урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхэд шаардагдах ур чадвар, тухайлбал, ярилцлага хийх, газар дээр нь очиж танилцах явц, эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсаныг нотлох аливаа шинж тэмдгийг тодорхойлох, эрсдэлийг тогтоох ажлын арга зүйг боловсруулах, тухайн байгууллагад тулгарч буй бэрхшээл, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан нь нийгмийн эмзэг хэсэгт хэрхэн нөлөөлж буй байдлыг цогцоор тодорхойлох, ганцаарчилсан ярилцлага, уулзалт хийхтэй холбоотой арга барилд ажиглалт хийх, улмаар албан хаагчдын ур чадварт дүгнэлт хийж, Зөвлөмж өгөхөд чиглэгдсэн.



Айлчлалын төгсгөлд ЭШУС Дэд хорооны гишүүд Монгол Улсын ХЭҮК-ын дарга, гишүүд, Тамгын газрын дарга болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчидтай дүгнэх уулзалт хийв.

Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нэгдэн орсноор хүлээсэн үүргийнхээ дагуу ЭШУС үндэсний ажиллагааг байгуулж,

амжилттай ажиллуулж байгаад сэтгэл дүүрэн байгаагаа Дэд хорооны зүгээс уг уулзалтаар илэрхийлж, “Байгуулагдаад удаагүй ч үндэсний ажиллагааны албан хаагчдын ур чадвар олон улсын хүний эрхийн стандартад нийцэж чадавхажсан байгааг хамтран ажилласан эдгээр өдрүүдэд олж харлаа” хэмээгээд, ЭШУС үндэсний ажиллагааны үндэс суурь тэр хэрээр бат бөх болсныг онцолсон.



Айлчлалын тэргүүн, Дэд хорооны гишүүн, хатагтай Элина Штайнерт “ХЭҮК-ын дэргэд ЭШУС үндэсний ажиллагааг байгуулсан хэдий ч Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчмуудын дагуу ЭШУС үндэсний ажиллагааны бүрэн эрхийг хуулиар нэг мөр хүлээн зөвшөөрөх, төсөв, хүний нөөц, үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг ямар түвшинд хангах ёстойг уулзалт хийсэн Монгол Улсын төрийн байгууллагуудын албан тушаалтнуудад тухай бүр сануулж, зөвлөж явлаа. Дэд хорооны бүрэлдэхүүн Монгол Улсад ажиллах энэ цаг үед ХЭҮКтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар эрчимтэй яриа хэлэлцээр өрнөж, УИХ-ын ХЗБХ-оор хэлэлцэгдэж байгаатай давхцаж байна. Дэд хороо нь НҮБ-ын дүрмээр Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Нэмэлт протоколд тайлбар хийх эрхтэй бөгөөд Дэд хорооны хараат бус нийт 25 гишүүн санал нэгтгэйгээр Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаанаас ирүүлсэн хуулийн төслийн тухайд өгөх санал, зөвлөмжөө НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын Тамгын газраар дамжуулан албан захидлаар хүргүүлсэн. ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн шинэчлэлийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцүүлэх нь чухал бөгөөд ямар ч тохиолдолд ухарсан шийдвэр гаргаж болохгүй” хэмээгээд Монгол Улс нь Нэмэлт протоколын Оролцогч улс болохынхоо хувьд хүлээсэн үүргээ тууштай, үр дүнтэй хэрэгжүүлэхийг уриалсан.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо айлчлалын тайлан, зөвлөмждөө дараах асуудлыг анхаарч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт тусгасан. Үүнд:

- “ХЭҮКтХ-д зааснаар ЭШУС үндэсний ажиллагааг хууль эрх зүйн үүднээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх тухайд өндөр түвшний хэмжээнд бие даасан, тусдаа, шинэ бүтэц гэж үзэх ёстой. Хуульд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүнд туслах нэгжид хамаарах бүрэн эрхийг хуульчилсан боловч Нэмэлт протоколын 18, 20 дугаар зүйл, тухайлбал ганцаарчилсан ярилцлага хийх, ганцаарчилсан ярилцлагын үеэр олж авсан мэдээллийн нууцлалыг хангах зэрэг гол асуудлыг тусгаагүй” байгаад анхаарал хандуулах;

- ЭШУС үндэсний ажиллагаа нь Монгол Улсад эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцах явдал гарахад нөлөөлж буй хууль тогтоомж, бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээнээс үүдэлтэй, бүтцийн болон тогтолцооны шалтгааныг илрүүлэхэд анхаарч, эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, шаардлагатай хууль тогтоомж, бодлогод санал, дүгнэлт өгөх, бодит хэрэгжилтийн талаар бүх түвшний эрх баригчидтай урт хугацааны бүтээлч яриа хэлэлцээ хийх замаар урьдчилан сэргийлэх бүрэн эрхээ нэг мөр хэрэгжүүлэх нэн чухал. Иймд ЭШУС үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй холбоотой аливаа будилааныг арилгахын тулд шаардлагатай бол хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авах;
- ЭШУС үндэсний ажиллагаа нь хүний эрх чөлөөг хассан болон хассан байж болзошгүй бүх газарт очиж, хяналт шинжилгээ хийх, эрүү шүүлт тулгахтай холбоотой өргөн хүрээний асуудлаар сургалт, сурталчилгаа хийх зэрэг урьдчилан сэргийлэх бүрэн эрхээсээ гадна НҮБ-ын гэрээний байгууллагуудын зөвлөмжийг дагаж мөрдөхөд чиглэсэн үйл ажиллагаанууд, дэлхий нийтийн анхаарал татсан асуудлаар дотоодын, бүс нутгийн, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, Нэмэлт протоколоор байгуулагдсан УСҮБ-ын туршлагаас суралцаж, албан хаагчдаа тогтмол чадавхжуулах;
- ХЭҮКТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж, ЭШУС үндэсний ажиллагааны бие даасан байдал, түүний ажилтнууд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс бусад ХЭҮК-ын ажилтан, гишүүдээс хараат бус байдлыг хангах;
- ЭШУС үндэсний ажиллагаа нь ямар эх үүсвэр шаардагдах (төсвийн бүрдүүлэлт) болон тэр төсвийг хэрхэн зарцуулах (төсвийн зарцуулалт) шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой. ЭШУС үндэсний ажиллагааны төсвийг цагариган тойргоор хязгаарлан<sup>178</sup>, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтыг зөвхөн үндэсний ажиллагаа хариуцах ёстой. ЭШУС үндэсний ажиллагаа нь ажлын төлөвлөгөө, дүгнэлт, зөвлөмжийн хувьд үйл ажиллагааны бие даасан байдалтай байх ба шаардлагатай бол Дэд хороотой шууд, нууцлалтай харилцах;
- ХЭҮКТХ-ийг Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл, ЭШУС Дэд хорооны 1 тоот Ерөнхий тайлбарт<sup>179</sup> бүрэн нийцүүлж нэмэлт өөрчлөлт оруулж, Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлд<sup>180</sup> заасан эрх чөлөөгөө хасуулсан бүх газар, түүний дотор бүх цэргийн ангид очиж, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх бүрэн эрхийг ЭШУС үндэсний ажиллагаанд олгохыг Засгийн газарт уриалсан.

ЭШУС Дэд хорооны гишүүд айлчлалын хөтөлбөрийн хүрээнд хийсэн хамтарсан хяналт шинжилгээний ЭШУС үндэсний ажиллагааны ажлын арга барилд өгч буй ажиглалт, зөвлөмжөө танилцуулсан.

<sup>178</sup> CAT/OP/SWE/1, at para 142 (g); see also CAT/OP/12/5 at para 32

<sup>179</sup> CAT/OP/GC/1: General comment No. 1 (2024) on article 4 of the Optional Protocol (places of deprivation of liberty) | OHCHR

<sup>180</sup> CAT/OP/12/5 para 24; see also CAT/OP/GC/1.

Дэд хорооны гишүүд “ЭШУС үндэсний ажиллагаа урам зоригтойгоор ажиллаж байгааг хамтарсан хяналт шинжилгээний хоёр өдөрт харлаа. Үндэсний ажиллагааны чиг үүргээ хэрэгжүүлэх арга зүй, хандлагыг үнэлж байна, тухайлбал, үйл ажиллагааныхаа стратегийг боловсруулахын тулд Монгол Улсад эрх чөлөөг хасах ямар төрлийн газрууд, хаана байрладаг талаар судалгаа хийсэн. Цаашилбал, хяналт шинжилгээ бүрийн чиг үүргийг тодорхойлсон удирдамж боловсруулж, хяналт шинжилгээний гишүүн болгоны үүрэг, айлчлалын арга хэлбэрээ тухай бүрээр боловсруулж, ажиллаж буй байгууллагадаа хяналт шинжилгээний зорилгоо тайлбарладаг нь, хяналт шинжилгээ хийхийн өмнө асуумж, ярилцлага авах бэлтгэлээ сайтар базааж, айлчлалын хүлээгдэж буй үр дагаврын талаар стратегийн төсөөлөлтэй болдог нь олон улсад сайн туршлага болохуйц арга барил аж. Ийм санал асуулга нь хяналт шинжилгээний үеэр чухал мэдээллийг системтэйгээр цуглуулж, айлчлалын тайлан, зөвлөмжид тусган, дүн шинжилгээ хийх, харьцуулах боломжийг хангахад тустай арга хэрэгсэл болсон байна” хэмээн дүгнэсэн.

СЭМҮТ болон “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар, ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай 427 дугаар хорих анги, Баривчлах төвд хийсэн хамтарсан хяналт шинжилгээний ажиглалтад ЭШУС үндэсний ажиллагааны ажлын арга барилд анхаарах асуудлуудыг ч мөн дурдсан бөгөөд тухайлбал “Аливаа эмнэлгийн хэсэг/нэгжид хяналт шинжилгээ хийх нь үргэлж нэн тэргүүний асуудал байх ёстой бөгөөд очсон байгууллагын салбар, хэлтсүүдийн үйл ажиллагааг цогцоор ойлгоход хангалттай цагийг хуваарилдаг нь сайшаалтай. Харин ЭШУС үндэсний ажиллагааны хүний нөөцийн бүрдүүлэлтэд эрүүл мэндийн мэргэжилтэн байхгүй байгаа нь анхаарууштай, эмнэлгийн байгууллагад хийх хяналт шинжилгээнд эрүүл мэндийн мэргэжилтний идэвхтэй оролцоо чухал юм. Үндэсний ажиллагаа нь Дэд хорооноос 181 боловсруулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон Нелсон Манделагийн дүрмийн 24-35, Бангкокийн дүрмийн 5-18 дүрмийн дагуу шинэчлэгдсэн Станбулын протоколыг ашиглах”-ыг зөвлөсөн.

НҮБ-ын ЭШУС Дэд хорооны төлөөлөгчид Монгол Улсад хийсэн Зөвлөх айлчлалын тайландаа “Монгол Улсад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хоёрхон жилийн өмнөөс бий болж, ажиллаж эхэлсэн. Харьцангуй богино хугацаа, бүрэн эрхийнхээ хүрээнд тулгамдаж буй сорилтуудыг үл харгалзан бүрэн эрх, үйл ажиллагаагаа урам зоригтойгоор гүйцэтгэж, цаашид суралцах, хөгжүүлэхэд бэлэн байна. Дэд хороо нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны урам зоригийг сайшааж байгаа ба арга барил, тэргүүлэх чиглэлүүдийг ярилцаж, сайжруулах боломжтойг онцолж байна. Чухам ийм л зорилготойгоор хамтарсан уулзалт, хуралдаанууд болж, санал, санаачилгаа элэгсэг, бүтээлч байдлаар танилцуулж, хэлэлцэж, судалсан. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ЭШУС үндэсний ажиллагаа болон Дэд хорооны хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, энэхүү чухал ажлын хүрээнд мэдээлэл, санал солилцох боломжийг байнга бүрдүүлэх нь чухал юм” хэмээн дүгнэжээ.



Монгол Улс нь Эрүү шүүлт тулгах явдлаас үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэхийн тулд нөхөн сэргээх арга барилыг сонгож, эргэлт хийх хэрэгтэй гэж НҮБ-ын шинжээчид дүгнэв<sup>182</sup>

ЖЕНЕВ ХОТ (2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр) – НҮБ-ын шинжээчид Монгол Улсад хоёр дахь айлчлалаа хийсний дараа тус улс нь хүний эрх чөлөөг хязгаарладаг бүх газруудад одоогоор үйлчилж байгаа ял оноох шинж чанар бүхий арга барилаа үндсээр нь өөрчлөх шаардлагатай байна гэж мэдэгдлээ. Мөн, Монгол Улсад эрүү шүүлт тулгах явдалд хяналт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий хараат бус нэгж нь эрүү шүүлт тулгах гэмт хэргээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж байгааг цаашид улам баталгаажуулж, бэхжүүлэх шаардлагатай байна гэж үзэв.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд Монгол Улсын хорих анги, Баривчлах төв, байр, Цагдаагийн түр саатуулах, албадан эрүүлжүүлэх байр, СЭМҮТ, ахмад настны асрамжийн газар, хүүхдийн асрамжийн төвүүдэд тус тус урьдчилан мэдэгдэлгүй очиж, нөхцөл байдалтай танилцлаа.

Монгол Улс нь ЭШУС үндэсний ажиллагааг томилон байгуулж, 2017 онд Дэд хорооны анхны айлчлалын дараа уламжилсан Зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн ч цаашид сайжруулах шаардлагатай зүйлс байгааг энэхүү айлчлалын бүрэлдэхүүн цохон тэмдэглэжээ.

Дэд хорооны айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн, хатагтай Элина Штайнерт нь “Монгол Улсын эрх бүхий байгууллагуудын авч хэрэгжүүлсэн эерэг арга хэмжээнүүдийг тус улсын бүхий л хорих ангиудад ажиглагдаж байгаа хорих ял оноон шийтгэх, залхаан цээрлүүлэх тогтолцоо нь бараантуулж байна. Тиймээс эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүст нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх зорилгыг эн тэргүүнд тавих хэрэгтэй. Энэ нь эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдлаас үр дүнтэй хамгаалах баталгааны нэгэн хэсэг билээ” хэмээн дүгнэв.

Тэр бээр “Монгол Улсын эрх бүхий байгууллагууд эл өөрчлөлтийг тогтолцооны түвшинд хийхийн тулд шинээр байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагаатай нягт хамтран ажиллах нь зүйтэй” гэж тэмдэглэв.

Айлчлалын 12 өдрийн хугацаанд Дэд хорооны гишүүд хорих ял эдэлж буй болон эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, тусгай байгууллагуудын алба хаагч нартай ганцаарчилсан, нууцлал бүхий уулзалтууд зохион байгууллаа. Түүнчлэн, Засгийн газрын төлөөлөл, ХЭҮК болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид, Иргэний нийгмийн төлөөлөл, НҮБ-ын агентлагуудтай уулзалт зохион байгуулав.

Дэд хорооны гишүүд ЭШУС үндэсний ажиллагааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт зохион байгуулж, хамтарсан хяналт шинжилгээ хийлээ.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдлыг хангах нь тус механизмын урьдчилан сэргийлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эн тэргүүний шаардагдах зүйл мөн бөгөөд ЭШУС үндэсний ажиллагааг үргэлжлүүлэн бэхжүүлэхийг хичээнгүйлэн зөвлөж байна” хэмээн Монгол Улсын Засгийн газарт хандсан мэдээлэлдээ айлчлалын тэргүүн, хатагтай Штайнерт илэрхийлэв.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын 16 дугаар зүйлийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь Монгол Улсын Засгийн газарт эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхтэй холбогдох дүгнэлт, зөвлөмжүүдийг агуулсан нууцлал бүхий тайланг хүргүүлэх болно. Дэд хорооны зүгээс 2017 оны ажлын айлчлалын дараа тус тайланг олон нийтэд нээлттэй болгосны мөн адил энэ жилийн тайланг олон нийтийн хүртээл болгохыг Монгол Улсын Засгийн газарт уриалж байна.

НҮБ-ын Гэрээний хороодын Хэвлэлийн мэдээллээс

<sup>182</sup> Mongolia: Paradigm shift towards rehabilitative approach needed for effective torture prevention, UN experts find | OHCHR



## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЭШУС үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зарчмыг баримтлан, ХЭҮКтХ болон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, НҮБ-ын ЭШУС Дэд хороо, Дэд хорооны Ази-Номхон далайн бүсийг хариуцсан гишүүд, илтгэгчидтэй тогтмол харилцаатай байж, олон улсын чанартай уулзалт, хэлэлцүүлэг, арга хэмжээнд цахимаар болон биечлэн идэвхийлэн оролцож, олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг, тэр дундаа эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэх, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар гаргах нэгдсэн тунхаг, уриалгыг дэмжих, Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хэрэгжилтийг олон улсад таниулан сурталчлах бодлогыг баримталдаг.

## ЭРҮҮ ШҮҮЛТТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮРЭЭНД

ЭШУС үндэсний ажиллагаа нь “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-тай 2023 оноос харилцаа холбоо тогтоон, “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд”-ыг Монгол Улсад нутагшуулах, хууль эрх зүйн хэрэглээнд нэвтрүүлэх, төрийн байгууллагын албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшихэд сургалт, нөлөөллийн ажил хамтран хэрэгжүүлэх, ЭШУС үндэсний ажиллагааг үр дүнтэй явуулахад албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, эрүү шүүлтийн хор аюулыг таниулах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гарын авлага, хэвлэмэл болон хэвлэмэл бус материал, ном товхимол боловсруулах, хэвлэх ажилд техник, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлийн хүрээнд хамтран ажиллаж байна.



Тус байгууллагыг Швейцар улсын иргэн, хүний эрхийн зүтгэлтэн, банкир Жан Жак Готье “Эрүүдэн шүүлтийн эсрэг Швейцарын хороо” нэртэйгээр 1977 онд байгуулжээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай Европын конвенц 1987 онд батлагдсанаар тус байгууллага нь олон улсын түвшинд үйл ажиллагаагаа тэлж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авахад улс орнуудын Засгийн газар, УСҮБ, ХЭҮБ-ууд болон иргэний нийгмийг дэмжин ажиллаж эхэлсэн.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд НҮБ-ын “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” буюу Мендезийн зарчмуудыг нэг мөр нэвтрүүлэх нь цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж буй болон албадан саатуулагдсан иргэдийн эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүндэтгэн ажиллах ажлын арга барилыг хэвшүүлэх чухал арга хэрэгсэл тул “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-тай явуулж буй хамтын ажиллагааны чиглэлээ энэ асуудал руу хандуулж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэхэд сургалт, нөлөөллийн ажлыг 2024 оноос үе шаттайгаар хамтран хэрэгжүүлж байна.

Хамтын ажиллагааны эхний шат 2024 оны 09 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд ЭШУС үндэсний ажиллагаа, Цагдаагийн байгууллага, ШШГ байгууллагын алба хаагчдыг чадавхжуулахад чиглэн хэрэгжлээ.

Арга хэмжээний эхний өдөр ЭШУС үндэсний ажиллагааны хяналт шинжилгээний арга барил, урьдчилан сэргийлэх сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг чадавхжуулахад чиглэгдэж, “ЭШУС нийгэмлэг”-ийн хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд 3 сэдвийн хүрээнд сургалт явуулсан бөгөөд уг сургалтын үр дүнг бататгах зорилгоор ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид арга хэмжээний гурав дахь өдөр хамтарсан хяналт шинжилгээ хийж, хяналт шинжилгээний ажиглалт, дүгнэлт, зөвлөмжийг ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдад өгөв.



Арга хэмжээний хоёр дахь өдөр Монгол Улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд “Мендезийн зарчмууд”-ыг нэвтрүүлэх сэдэвт чиглэж, уг арга хэмжээг Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-той хамтран зохион байгууллаа.

Тухайн өдрийн арга хэмжээнд УИХ-ын ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн Ж.Баярмаа болон ХЗДХЯ, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо, УЕПГ, АТГ, ЦЕГ, ШШГЕГ, ХЭҮК, СЭМҮТ, ДХИС-ийн холбогдох албан тушаалтан, төлөөлөл болон 21 аймаг, Нийслэлийн прокурор, цагдаагийн алба хаагч, хэрэг бүртгэгч болон ЭШУС үндэсний ажиллагааны сургалтаар бэлтгэгдсэн “Хүний эрхийн сургагч багш” зэрэг нийт 2,000 гаруй хүн цахим, танхимаар хамрагдав.



Арга хэмжээний үеэр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн Монгол Улсын Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдэж буй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжид хийсэн дүн шинжилгээг танилцуулж, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын ахлах зөвлөх Монгол Улсын хууль сахиулах байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх арга зүйг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, “Мендезийн зарчмууд”-ын танилцуулга, хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулахад дараагийн алхмуудыг тодорхойлоход чиглэсэн 3 сэдвийн хүрээнд 3 цагийн сургалтын цагдаагийн алба хаагчдад явуулсан.



Арга хэмжээний сүүлийн өдрийн үйл ажиллагаа нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хорих ял эдлүүлэх ажиллагаанд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмыг нийцүүлэх нь” сэдвийн дор зохион байгуулагдсан бөгөөд ШШГЕГ-ын дарга, хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, шийдвэр гүйцэтгэх албадын дарга, ШШГЕГ-ын дэргэдэх зөвлөл, Улаанбаатар хотын бүсийн болон 21 аймаг дахь хорих анги, байгууллагын удирдлага, албан тушаалтнууд болон сургалт хариуцсан алба хаагчид зэрэг нийт 500 гаруй хүн цахим, танхимаар хамрагдсан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн Монгол Улсын ШШГБ-ын алба хаагчдын үйлдэж буй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжид хийсэн дүн шинжилгээг танилцуулсан бол “Эрүү шүүлтээс урьдчилан

сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын ахлах зөвлөх Бен Бакланд ШШГ, хорих ял эдлүүлэх ажиллагаанд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмыг нийцүүлэх сэдвээр сургалт зохион байгууллаа.



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”-тэй хамтран хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн арга хэмжээний хоёр дахь үе шат 2025 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд явагдана.



Уг арга хэмжээ нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны цагдаагийн албадан саатуулах ажиллагаанд хяналт тавихтай холбоотой чадавхыг бэхжүүлэх, ЭШУС үндэсний ажиллагаа болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, Үндэсний оролцогч талуудтай “Мендезийн зарчмууд”-ыг хэрэгжүүлэх Үндэсний зураглалын төслийг боловсруулах гэсэн үндсэн 3 зорилтын хүрээнд зохион байгуулагдах болно.

ДӨРӨВДҮГЭЭР  
БҮЛЭГ



## Mongolia: A new monitoring body focuses on risky practices and women in detention

The APT and Mongolia's National Preventive Mechanism (NPM) began an ambitious first year of cooperation by focusing on safeguards in the first hours of police custody and the NPM's visit methods during a week of joint activities in Ulaan Baatar.

Bringing together law enforcement and prison officers from around the country allowed us to take the first steps towards implementing the [Méndez Principles on Effective Interviewing](#) - a set of global standards on police interviews and safeguards, named after torture survivor and former

### МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА НЬ АЛЬ ХЭДИЙНЭЭ АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД “ҮЛГЭР ЖИШЭЭ” БАЙГУУЛЛАГА БОЛЖЭЭ

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ болон Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Улаанбаатар хотноо долоо хоногийн турш үргэлжилсэн хамтын ажиллагааны хүрээнд Цагдаагийн байгууллагад саатуулагдсан эхний цагийн хамгаалалт, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга барилд анхаарлаа хандуулснаар хамтын ажиллагааны эхний жилээ амбицтай эхлүүлээ.

Улс орны өнцөг булан бүрээс хууль сахиулах болон хорих ангийн алба хаагчдыг нэгтгэсэн нь эрүү шүүлтэд өртөж, даван туулж байсан эрүү шүүлтийн эсрэг тусгай илтгэгч асан, профессор Хуан Мендезийн боловсруулж, нэрээр нь нэрлэгдсэн цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх, хамгаалалтын арга хэмжээний талаарх дэлхийн стандартыг бүрдүүлсэн “Мендезийн зарчмууд”-ыг хэрэгжүүлэх эхний алхмыг хийх боломжийг бидэнд олгосон юм.

Мөн ЭШУС үндэсний ажиллагааны хяналт шинжилгээний арга барилд анхаарах асуудлыг олж тогтоох зорилгоор эмэгтэйчүүдийн хорих ангид хамтарсан хяналт шинжилгээ хийсэн бөгөөд улам сайжруулах чиглэлээр хоёр байгууллага ирэх онд хамтран ажиллах болно.

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсэд байгуулагдсан цөөн үндэсний ажиллагаануудын нэг боловч, бүс нутгийнхаа ЭШУС үндэсний ажиллагааны бүрэн эрхийг хэрэгжүүлэгч ХЭҮБ-уудын дунд болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг хараахан соёрхон батлаагүй бүс нутгийн улсууддаа аль хэдийнээ “үлгэр жишээ” болжээ.

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны өмнө тулгарч буй сорилтуудын нэг нь тус улсын өргөн уудам газарзүйн байршил юм. Алслагдсан бүс нутгуудад эрх чөлөөгөө хасуулсан газруудад зочлоход хүндрэлтэй байдаг бөгөөд өртөг өндөр тусдаг аж. Мөн алслагдсан бүс нутагт гэнэтийн хяналт шинжилгээ хийхээр тухайн нутагт хөл тавьсан даруйд ЭШУС үндэсний

ажиллагааны айлчлалын талаарх мэдээлэл тархдаг нь асуудал үүсгэж байна.

ЭШУС үндэсний ажиллагаа нь үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмуудыг Монгол хэлнээ орчуулах, түүнчлэн түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудлууд дээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна. Эрх баригчид энэ төрлийн практик арга барилыг ихэд сонирхож байгааг манай нэгдсэн зөвлөгөөнд 2000 гаруй цагдаагийн алба хаагч оролцсон явдал харуулж байна.

Гэр бүлийнхэндээ мэдэгдэх нь цагдаад саатуулагдсан эхний цагийн хамгийн чухал хамгаалалтуудын нэг юм. Олон улс оронд энэ явц хамгийн хялбар хэрэгждэг. Учир нь өмгөөлөгч авахаас ялгаатай нь гэр бүлийнхэндээ мэдэгдэх нь маш бага зардалтай байдаг. Гэсэн хэдий ч Монголын алслагдсан бүс нутагт энэ нь үнэндээ хамгийн хэцүү асуудал аж. Олон малчин өрх гар утасны сүлжээ ордоггүй газар амьдардаг бөгөөд садан төрлийнх нь хэн нэг нь баривчлагдах аваас тэднийгээ олох, холбоо тогтоох нь ихээхэн бэрхшээлтэй байдаг байна.

Мэдүүлэг авах бүх өрөөнд хяналтын камер нэвтрүүлэх ажил үргэлжилж байна. Олон улсад тулгарч байсны адил, бичлэг хийлгэхийг хүсээгүй цагдаа нар эхэн үедээ эсэргүүцдэг байжээ. Гэхдээ энэ байдал өөрчлөгдөж байна. Цагдаагийн алба хаагчид энэ нь өөрсдийнх нь хувьд хамгаалалт болж байгааг, тэднийг хэлмэгдэхээс сэргийлэхийн зэрэгцээ баривчлагдсан хүмүүсийн эрхийг хамгаалахад давхар тусалж байгааг олж харж байна.

Олон цагдаагийн хэлтэс нөөцийн дутагдлаас болж хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй нүүр тулгардаг аж. Тухайлбал, өрөөний дутагдлаас болж алба хаагчдын ажлын өрөөнд болон бусад хүмүүсийн дэргэд мэдүүлэг авах ажиллагаа явагдаж байна.

Монгол Улсын тухайд эрх чөлөөгөө хасуулсан эмэгтэйчүүд гэр бүлээсээ хол байршилд хуваарилагддаг нь асар том сорилт ажээ. Тус улсад эмэгтэйчүүдийн хорих анги нэг л байдаг тул ихэнх хорих ял эдэлж буй эмэгтэй гэрээсээ хол хоригддог. Энэ зураг дээр ЭШУС үндэсний ажиллагаа эдгээр болон бусад асуудлаар хорих ангийн удирдлагуудтай ярилцаж байна.

Нийслэл дэх замын хөдөлгөөний хэт ачаалал нь өмгөөлөгчөөр түргэн шуурхай хангагдахад асуудал үүсгэдэг аж. Өмгөөлөгчтэй байгаад, түргэн шуурхай холбогдсон ч замын түгжрэлээс болоод цагдаагийн хэлтэст ирэхдээ олон цаг зарцуулдаг байна.

ЭШУС үндэсний ажиллагаа нь бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа шинэхэн үндэсний ажиллагааныхаа хувьд арга зүйгээ сайжруулахад анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгтэй хамтран эмэгтэйчүүдийн хорих ангид хяналт шинжилгээ явууллаа.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн арга хэмжээний эхний үе шатын хэрэгжилтийн талаарх мэдээллээ цахим хуудастаа нийтэлжээ<sup>183</sup>



## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай сан нь Оролцогч улсуудын УСҮБ-ыг дэмжих үндсэн зорилгоор байгуулагдсан бөгөөд тус сангийн стратегийн чиглэл, бодлогод нийцсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх төслийг, тэр дундаа НҮБ-ын ЭШУС Дэд хорооны айлчлалын дараа тухайн Оролцогч улсад хандан гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслийг санхүүжүүлэх бодлогыг баримталдаг.

ЭШУС Дэд хороо нь Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлалынхаа мөрөөр манай улсын Засгийн газарт ажиглалт, зөвлөмжөө хүргүүлсэн бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын хэрэгжилтийн тухайд дараах арга хэмжээг тусгасан байв. Үүнд:

"19. УСҮБ байгуулагдсан тохиолдолд бодитоор оршин байгаа эсхүл илэрхий ашиг сонирхлын зөрчлөөс татгалзан чиг үүргээ хэрэгжүүлэх ёстой. УСҮБ-ын бүх гишүүд нь ярилцлага хийх, газар дээр нь очиж танилцах процесс, эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсаныг нотлох аливаа шинж тэмдгийг тодорхойлох, эрсдэлийг тогтоох ур чадварыг эзэмших, ажлын арга зүйг боловсруулах, тухайн байгууллагад тулгарч байгаа бэрхшээл, хүний эрх, эрх чөлөөг нь хязгаарласан нь нийгмийн эмзэг хэсэгт хэрхэн нөлөөлж байгаа байдлыг цогцоор тодорхойлох, уулзалт хийхтэй холбоотой арга зүйг эзэмшүүлэх сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

20. УСҮБ байгуулагдсан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагуудтай яриа хэлэлцээ хийх процессыг үргэлжлүүлэх, эрх чөлөөг нь хязгаарласан хүний байгаа нөхцөл байдлыг сайжруулах, зүй бус харьцааг өөрчлөх, эрүү шүүлт тулгаж буй байдал, хууль бусаар шийтгэл оногдуулж байгаагаас урьдчилан сэргийлэх зорилгоор уг яриа хэлэлцээрийг үр дүнд хүргэх, тус механизмд хамаарал бүхий зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ёстой.

22. Бие даасан, үр дүнтэй УСҮБ-ыг бий болгохдоо Дэд хорооноос гаргасан "Удирдамж"-д агуулагдах дараах элементүүдийг эрх бүхий байгууллагад анхаарахыг зөвлөж байна. Үүнд:

(с) УСҮБ-ын гишүүд нь бие даасан, хараат бус байхын зэрэгцээ мэргэжлийн мэдлэг тэр дундаа эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон өөрийн үүргийг үр дүнтэй гүйцэтгэх шаардлагатай бусад мэргэшсэн мэдлэг, чадварыг эзэмшсэн байх шаардлагатай;

(h) Бусад байгууллагууд болон олон нийтийн зүгээс УСҮБ-ыг эрүү шүүлтийн эсрэг голлох үүрэг гүйцэтгэдэг байгууллага мөн гэсэн ойлголттой байх ёстой. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд урьдчилан сэргийлэх механизмд олгож байгаа бүрэн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ талаар сурталчлах нь ач холбогдолтой гэдгийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос онцлон сануулж байгаа бөгөөд УСҮБ-ыг тус улсын системд байгаа эрүү шүүлтээс хамгаалах гол бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай."184

184 Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс. Хоёрдугаар боть. 437, 438 дугаар тал

ЭШУС үндэсний ажиллагаа нь уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг чадавхжуулах, нийт хүн амын дундах эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлэх нь” төсөл боловсруулан, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр илгээсэн нь Тусгай сангийн шалгуур үзүүлэлтэд нийцэн, төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн тухай албан мэдэгдлийг Тусгай сангийн нарийн бичгийн даргын зүгээс Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд ирүүлсэн бөгөөд уг төсөл 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаанд хэрэгжинэ.

Төслийн хэрэгжилтийн үр дүнд ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчдад зориулсан өөрөө суралцах цахим платформ бүтээгдэж, хэрэглээ тогтмолжсоноор албан хаагчид хөндлөнгийн оролцоогүйгээр ур чадвараа байнга дээшлүүлэх боломжтой болно.

Монгол Улсын төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчдад хүний эрх, тэр дундаа эрүү шүүлтээс ангид байх эрхийн боловсрол олгох, уг эрхийг хангаж ажиллах хандлагыг төлөвшүүлэх өөрөө суралцах цахим платформ бүтээгдэж, хэрэглээ тогтмолжсоноор төрийн албан хаагчид хүний эрхийн мэдлэгээ тэлж, хүний эрхэд суурилсан хандлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хөндлөнгийн оролцоогүйгээр хэвшүүлэх боломжтой болно.

Хөдөлгөөнт дүрс бүхий сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн болон бусад хэвлэмэл сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг төслийн хүрээнд бүтээснээр ЭШУС үндэсний ажиллагаа нь олон нийтийн мэдлэгийг тогтмол дээшлүүлэх сургалт, сурталчилгааны нөөц хэрэгсэлтэй болсон байна.

#SafeInCustody хөдөлгөөнд иргэд, төрийн эрх мэдэлтнүүд, байгууллагуудыг нэгтгэснээр хүний эрх чөлөөг хязгаарлах төрийн аливаа үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчихгүй байхад олон нийтийн хяналт сайжрах болно.

## **ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦСОН БАЙДАЛ**

Ази-Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллага, Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны сүлжээг бий болгох, бүс нутгийн урьдчилан сэргийлэх байгууллагууд харилцан туршлага солилцох семинарт оролцов

Монгол, Казахстан, Мальдив, Шинэ Зеланд, Шри-Ланка, Филиппин, Тайланд улсын ХЭҮБ болон УСҮБ-ын төлөөлөгчид Тайланд улсын Бангкок хотноо 2024 оны 06 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд хуран цуглаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд гаргаж буй амжилт, тэргүүн туршлагаасаа хуваалцан, өмнөө тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг даван туулж буй арга замаас харилцан хуваалцав.

Уг арга хэмжээнд ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс оролцож, ЭШУС үндэсний ажиллагааны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд баримталж буй бодлого, цөөн хүний нөөцөөр хэрхэн өргөн уудам нутагт тархан байршсан 843 байршилд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт нөлөөллийн ажлыг

хийж гүйцэтгэж буй туршлага, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа хэрхэн сулруулалгүй үргэлжлүүлэн, тулгарч буй сорилт бэрхшээлүүдээ шийдвэрлэж буй арга барилын талаар бусад улсын төлөөлөгчдөд танилцуулав.



Уулзалт арга хэмжээний дүнд Ази-Номхон далайн бүс нутгийн ЭШУС үндэсний ажиллагааны сүлжээ байгуулагдсан бөгөөд энэ нь ХЭҮБ-уудын Дэлхийн Холбооноос 2023 оны 11 дүгээр сард баталсан Киев-Копенхагены тунхаглалын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгыг дэмжсэн том алхам болсон.

ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс Ази-Номхон далайн бүс нутгийн ЭШУС үндэсний ажиллагааны сүлжээ байгуулахад идэвхийлэн оролцож, “Эрүү шүүлтгүй дэлхийн хамтын ажиллагаа” уриа дор үр дүнтэй хамтран ажиллах баримт бичигт гарын үсэг зуран нэгдэх тухай түүний гаргасан санаачилгыг бусад орны оролцогчид дэмжин, нэгдсэн билээ.

“Эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, Нэмэлт протоколыг хэрэгжүүлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх нь” сэдэвт 6 цуврал олон улсын цахим хурал<sup>185</sup>

**Цуврал цахим хурал №1:** “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх Үндэсний Байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь”

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг тохиолдуулан ХЭҮБ-уудын Дэлхийн Холбооноос эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй алхмуудыг судлах зорилгоор цуврал цахим уулзалт зохион байгуулж байна. Түүний эхний цуврал “Эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдвээр 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, 112 улсын оролцогчдыг хамрууллаа.

Уг цуврал цахим уулзалт нь 2023 оны 11 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд Дани улсын Копенхаген хотноо зохион байгуулагдсан ХЭҮБ-уудын олон улсын 14 дүгээр бага хурлын үр дүнг бататгаж, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцахаас урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах хүрээнд Оролцогч улсуудын УСҮБ болон ХЭҮБ-уудын хийж гүйцэтгэх олон талт арга хэмжээг тодорхойлсон Киев-Копенхагены тунхаглалын хэрэгжилтийг улам бататгах, ХЭҮБ-ууд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцахаас урьдчилан сэргийлэхэд хүчин чармайлтаа бэхжүүлэхэд чиглэсэн юм.

<sup>185</sup> [Preventing torture: Webinar series to strengthen NHRIs, share good practice - GANHRI](#)

Энэ удаагийн цахим уулзалтад дэлхийн өнцөг булан бүрээс оролцсон төлөөлөгчид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хэрэгжүүлж буй үр дүнтэй арга зүйгээсээ харилцан туршлага солилцсон ба Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны төлөөллийн зүгээс олон улсын экспертүүдийн хамтын ажиллагааны үр дүнд урьдчилан сэргийлэх арга барилаа богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд зорин ажиллаж байгаагаа оролцогчдод танилцуулсан бол уг цахим уулзалтыг хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Николь Хогг болон хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд нар Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны чадавх, үйл ажиллагаа Ази-Номхон далайн бүсийн хэмжээнд тэргүүлэх зэрэгт хүрснийг онцолсон.



**Цуврал цахим хурал №2:** “НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойд: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэлхийн хүчин чармайлтад гаргаж буй Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын санаачилга”

Энэ удаагийн цахим хурал нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 40 жилийн ойг тохиолдуулан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хариуцлагыг дээшлүүлэх, дэлхийн даяар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн ХЭҮБ-уудын хүчин чармайлт, санаачилгыг тодотгох зорилготой 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж, 112 улсын төлөөлөл оролцсон.

ХЭҮБ-уудын цагдан хорих байруудад тавих хяналт, тогтолцооны эрсдэлт хүчин зүйлс, Оролцогч улсуудын хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийн тулд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг

хороонд тайлагнах үйл ажиллагаа, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд эрх зүйн болон институтийн шинэчлэлийг дэмжих сэдвүүдийн хүрээнд ХЭҮБ-ын төлөөлөгчид өөрсдийн туршлага дээр үндэслэн хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн тайлан ба Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжийн хэрэгжилтийг үр дүнтэй хангахад Иргэний нийгмийн түншлэл чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолсон.

**Цуврал цахим хурал №3:** “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан эмзэг бүлгүүдийг хамгаалахад Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудад тулгарч буй бэрхшээл, стратеги”

Гурав дахь цахим хурал “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан эмзэг бүлгүүдийг хамгаалахад Хүний эрхийн байгууллагуудад тулгарч буй бэрхшээл, стратеги” сэдвийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдаж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын Оролцогч улсын 155 төлөөлөл оролцож цагдан хоригдсон, хорих ял эдэлж буй эмэгтэйчүүд, тэр дундаа нярай хүүхэдтэй эхчүүдийн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцахаас ангид байх эрхийг хангах, хамгаалах, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд авч хэрэгжүүлж буй арга зам, тэргүүн туршлага, саад бэрхшээлээ хуваалцлаа.

Цахим хурлын үеэр “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын зүгээс “Хорих ангиуд дахь эмэгтэйчүүд” судалгааны үр дүнгийн товч танилцуулгыг хийсэн. Уг судалгааг бэлтгэхэд Ази-Номхон далай, Африк, Европ болон Латин америкийн 46 улсын УСҮБ оролцжээ. Тайлангийн үр дүнд:

- Эдгээр улсын хорих ял эдэлж байгаа иргэдийн 78,000 нь эмэгтэй хоригдол байна;
- Эдгээр улсад хорих ял эдлүүлэх ажиллагаа явуулж байгаа 5 хорих анги тутмын 1 нь эмэгтэйчүүдэд зориулагдсан;
- Нийт хоригдлын 5 хувь нь эмэгтэй;
- Цагдан хоригдож байгаа 3 хүн тутмын 1 нь эмэгтэй;
- Хорих ангийн 3 алба хаагч тутамд 1 эмэгтэй хоригдол оногдож байна гэх статистик гарсан байна.

“Эмэгтэйчүүдэд хорих ял оноох явдал ихэссэн, зарим улсад эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн шийтгэл хэрэглэх нь нэмэгдсэн ч, саад бэрхшээл мэдэгдэхүйц их хэмжээтэй хэвээр байна. Цагдан хорих байруудад эмэгтэйчүүдэд нүцгэн биеийн үзлэг хийж байгаа нь, ганцаарчлан тусгаарлах аргыг өргөн хэрэглэж байгаа нь хувь хүний төрөлхөөс заяасан нэр төртэй байх үнэлэмжийг бууруулж, улмаар эмзэг нөхцөлд байгаа эмэгтэйчүүдэд онцгой хохирол учруулж буй бөгөөд үүний шалтгаан нь эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд чиглэсэн зохистой эрх зүйн зохицуулалт, хамгаалалт дутмаг байгаатай холбоотой” хэмээн тайланг боловсруулсан ажлын хэсэг дүгнэжээ.

Судалгаанд хамрагдсан эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн дунд сэтгэцийн эрүүл мэндэд нь эрсдэлт нөхцөл байдал тулгарсан тохиолдол өндөр хувь эзэлжээ. Эмнэлгийн байгууллагын хүний нөөцийн хомсдол, хүйсийн онцлогт тохирсон

эмнэлгийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, эрүүл ахуй хангалтгүй зэрэг асуудлууд ч мөн илэрсэн байна.

Судалгаанд хамруулсан улс орнуудад нийт 700 гаруй жирэмсэн эмэгтэй хорих ял эдэлж байгаа нь, нярай хүүхэд эхчүүд хорих ял эдэлж байгаа нь, хоригдож буй ЛГБТ эмэгтэйчүүдийг хүлээн зөвшөөрөх асуудал хорих ангиудад сул байгаа нь, цагаач, хууль бус шилжин суурьшигч эмэгтэйчүүдийн тоо өндөр байгаа нь хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийг эрсдэлт ангилалд оруулах шалтгаан болж байгааг судалгааны баг тогтоожээ. Улмаар эдгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн улс орнууд хууль эрх зүйн шинэчлэл хийх хэрэгцээг гаргаж ирсэн ба дараах асуудлыг тусгахыг зөвлөсөн. Үүнд:

- Эрүүгийн хэргийн зүйлчлэлийг сулруулах
- Хорихоос өөр төрлийн шийтгэл оноох аргыг түлхүү хэрэглэх
- Хүйсийн эмзэг байдалд нийцсэн хорих ял эдлүүлэх ажиллагааны бодлого боловсруулах
- Олон улсын холбогдох стандартыг дотооддоо нэвтрүүлэх
- Хууль эрх зүйн орчин, баримтлах бодлогодоо Бангкокийн дүрэм болон бусад хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан НҮБ-ын болон олон улсын гэрээ конвенц, дүрэм журмыг тусгах, хэрэгжүүлэх (тухайлбал, нүцгэн биеийн болон эмзэг эрхтний үзлэг хийхийг хориглох; жирэмсэн эмэгтэйчүүдэд хорих ял хэрэглэхийг хориглох)

**НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” Олон улсын байгууллагын төлөөлөлтэй олон талт уулзалт хийв**

Швейцарын Холбооны Улсын Женев хотноо НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр нэгдсэн чуулганаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх гишүүн орнуудын Засгийн газрын тайлангуудыг хэлэлцсэн.

Тус чуулганы үеэр Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн болон ЭШУС хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дарга, гишүүд болон Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүдтэй уулзлаа.





НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид нь “Байгуулагдаад удаагүй ч Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа богино хугацаанд чадавхжиж, үр дүнтэй ажиллаж байгаа”-г цохон тэмдэглээд, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу Үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв, санхүү, хүний нөөц, хараат бус бие даасан байдлыг хангах талаар шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатайг дурдав.



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Николь Хогг нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо байрлах төв байрандаа Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Я.Цэлмэн, ЭШУС хэлтсийн дарга, хууль зүйн ухааны доктор Ш.Үнэнтөгс нарыг хүлээн авч уулзлаа.



Уулзалтаар ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй хоёр байгууллагын арга хэмжээг дүгнэж, цаашид “Бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн сургалтын хөтөлбөр” боловсруулахад хамтран ажиллах талаар санал солилцож, ирэх жилүүдэд эдгээр төсөл, хөтөлбөрүүдийг эхлүүлэх, олон улсын зөвлөх ажиллуулах талаар тохиролцсон.

Мөн Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсэд байгуулагдсан цөөхөн үндэсний ажиллагааны нэг боловч, бүс нутагтаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд “үлгэж жишээ” болж байгааг тус ОУБ онцлов.

## ДҮГНЭЛТ

ЭШУС үндэсний ажиллагаа нь байгуулагдсан 2022 оны 06 дугаар сараас 2024 оны 02 дугаар сарыг хүртэл Нэмэлт протоколын Оролцогч улсуудын УСҮБ-уудын дунд “отгон”-д тооцогдож ирсэн хэдий ч энэ богино хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд гаргаж буй хүчин чармайлтаа зогсолтгүй урагшлуулах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга барилаа олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн чадавхжуулах, цаашлаад бүс нутгийн үндэсний байгууллагуудынхаа дунд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд баримталж буй стратеги, ахиц дэвшил, ур чадвараараа “үлгэр жишээ” болохыг эрмэлзэн ажиллаж байна.

НҮБ-ын ЭШУС Дэд хороо нь Оролцогч улсуудын УСҮБ-ын үйл ажиллагаанд баримтлах “Удирдамж”186-ийг 2012 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан. Уг удирдамжид “Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага нь үйл ажиллагааны үр нөлөөгөө бэхжүүлэх, туршлага солилцох үүднээс бусад орны Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудтай холбоо тогтоож, хамтран ажиллах”-ыг зөвлөсөн.

ЭШУС үндэсний ажиллагаа нь байгуулагдсан эхний жилдээ буюу 2022 онд эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ, бусад Оролцогч улсын УСҮБ-ын мэдээллийн санг бүрдүүлж, түүний дагуу Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааг таниулах, сурталчлах, хамтран ажиллах зорилгыг эрэлхийлэн ажилласан бол 2023 оны хоёрдугаар хагаст өмнөх хугацаанд тогтоосон харилцаа холбоо, хамтын ажиллагааны яриа хэлцэл нь ажил хэрэг болох шатанд шилжиж, ОУБ-уудтай хамтран ажиллах, бусад улсын УСҮБ-тай харилцан туршлага солилцох, албан хаагчдын чадавх бэхжүүлэх сургалт, арга хэмжээнд оролцох арга хэмжээ улбаалан хэрэгжсэн.

Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дагнасан механизм ажилласан туршлага ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдахаас өмнөх жилүүдэд байгаагүй, энэ дагуух гарын авлага, сурах бичиг, зөвлөмж, удирдамж зэрэг хэрэглээнд аль хэдийнээ нэвтэрч, “хөрсөн дээр бууж” чанаржсан сургалтын хэрэглэгдэхүүн бий болоогүй учир өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж, олон улсын гарын авлага, зөвлөмж, удирдамж дээр үндэслэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж, богино хугацаанд албан хаагчдаа олон улсын хүний эрхийн хяналт шинжилгээний стандартад нийцүүлэн чадавхжуулсаар ирлээ.

Түүнчлэн олон улсын байгууллагуудтай өрнүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд албан хаагчдаа чадавхжуулах сургалтад цахимаар болон биечлэн оролцуулж байна. “Жайка” олон улсын байгууллагын зохион байгуулсан “Жендерт суурилсан хүчирхийллийг устгах нь” сэдэвт мэдлэг бүтээх сургалт, Ази-Номхон далайн нийгэмлэг болон Швейцарын холбооны улсын Женев хотноо төвтэй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-уудын хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт, 4 бүлэг цахим сургалтад тус тус хамрагдсан үндэсний ажиллагааны албан хаагчид сургалтаас олж авсан мэдлэг, мэдээлэл дээрээ үндэслэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулан, хяналт шинжилгээний үеэр явуулдаг сургалт, нөлөөллийн арга хэмжээндээ хэрэглэж байна<sup>187</sup>.

Харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх зорилгоор Польш, Хорват, Словени улсуудын УСҮБ-тай хамтын ажиллагаа өрнүүлж байна. Хамтын ажиллагааны эхлэл болгож 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Словени Улсын УСҮБ-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд гаргаж буй тэргүүн туршлага судлах зорилгоор тус улсын нийслэл Любляна хотод ажиллав<sup>188</sup>.

Словени улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 1993 оны 07 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орж, 2007 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Нэмэлт протоколыг соёрхон баталж, УСҮБ-ыг Хүний эрхийн Омбудсменд нэмэлт бүрэн эрх олгох замаар 2008 онд байгуулсан.

Хоёр улсын урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэлдэхүүн тус тусын үйл ажиллагааны танилцуулга, мэдээллийг харилцан хуваалцсан бөгөөд Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид нь өөрийн албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ хяналт шинжилгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, хүний эрх, эрх чөлөөг хуулийн дагуу хязгаарласан газруудад ажиллаж байгаа нь өндөр ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэх шаардсан болохыг тус улсын УСҮБ-ын тэргүүн Иван Селих онцолж байлаа.

Туршлага судлах хүрээнд Словени улсын “Копер” эрэгтэйчүүдийн хорих анги, Пиран хотын Цагдаагийн хэлтэс, “Дом Лукавчи” нийгмийн халамж, үйлчилгээний төв болон “Верзей” хүүхэд, өсвөр үеийнхний сургалтын төвд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний явцад ажиглалт хийн, Монгол Улсын эрх чөлөөг хязгаарласан газрууд үйл ажиллагаа, ЭШУС үндэсний ажиллагааны урьдчилан

<sup>187</sup> Байгууллага тус бүртэй хийж буй ажлын талаарх тайлантай Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023 оны тайлан.

<sup>188</sup> Туршлага судлах айлчлалын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023 оны тайлан.

сэргийлэх хяналт шинжилгээний арга зүйд тусган хэрэгжүүлбэл зохих шинэлэг арга барил, туршлагатай танилцсан бөгөөд хоригдлууд нэгнээ, алба хаагчид хоригдлыг ялгаварлан гадуурхах, нэр хүндийг нь доромжлон харьцах нөхцөлийг бүрдүүлдэг арга барилыг халж, хорих өрөөнүүдийн үүдэнд хоригдлын хувийн мэдээллийг байршуулахдаа зөвхөн код, тоо ашиглах, хоригдол хорих ангийн алба хаагчдад харьцахдаа шийтгэгдсэн ялаа дурдахгүй байх зэрэг арга хэлбэрт шилжих зөвлөмжийг ШШГЕГ-ын даргад хүргүүлэн, Монгол Улсын нийт хорих ангийн хэмжээнд нутагшуулах туршилтыг хэрэгжүүлж эхэлсэн.

Тус улсын Хүний эрхийн Омбудсмeны орлогч дарга, УСҮБ-ын тэргүүн Иван Селих болон албан хаагчид 2025 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсад хариу айлчлалаар хүрэлцэн ирж, ЭШУС үндэсний ажиллагааны ажлын арга барил, туршлагатай танилцах бөгөөд энэхүү айлчлал нь Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй ахиц дэвшил, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга зүй, баримталж буй бодлогын талаар Нэмэлт протоколын Оролцогч улсуудын Европын бүс нутгийн УСҮБ-ууд туршлага судлах эхний алхам болж байна.

Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссар, УСҮБ-ын тэргүүний зүгээс Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан өөрийн улсдаа хүрэлцэн ирж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар харилцан туршлага, мэдлэг мэдээлэл солилцохыг санал болгож, албан ёсны урилгыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ирүүлсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн уг урилгыг хүндэтгэн хүлээн авч, улмаар хоёр тал хамтран туршлага судлах айлчлалын тов, хөтөлбөрийг баталж, шаардлагатай бэлтгэл ажлыг хангасан боловч ХЭҮК-ын Тамгын газрын зүгээс туршлага судлах айлчлалд зарцуулах төсвийг олгохгүй байх шийдвэрийг гаргаснаар туршлага судлах хөтөлбөр товлосон хугацаандаа хэрэгжээгүй.

Өмнөх 2023 онд тулгарсан санхүүгийн саад дахин учрахгүй бол хоёр талын хамтран боловсруулсан туршлага судлах айлчлалын хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх болно.

ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд баримталсан бодлого оновчтой байж, амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл нь 2024 оны онцлох үйл явдлууд юм.

Тухайлбал, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь 2024 онд албан ёсны айлчлал хийх Оролцогч улсыг товллохдоо Монгол Улсыг сонгосон нь нэг талаас ЭШУС үндэсний ажиллагаа Дэд хороотой байнгын холбоотой байж, урьдчилан сэргийлэх техник, арга зүйн зөвлөгөө, туслалцаа авахыг эрмэлзэж, хүсэлтээ уламжилсантай холбоотой.

ЭШУС Дэд хороо нь зөвлөн туслах чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсад хийх хоёр дахь айлчлалаа 2024 оны 05 дугаар сарын 05-16-ны өдрүүдэд Дэд хорооны гишүүн Элина Штайнерт (айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн), Ника Кварачелиа, Аника Томсик, Мартин Зинклер, түүнчлэн Дэд хорооны Нарийн бичгийн даргын газрын хүний эрхийн хоёр ажилтан нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Айлчлалын бүрэлдэхүүний тэргүүн, Дэд хорооны гишүүн Элина Штайнерт “Долоон жилийн өмнөх Дэд хорооны айлчлалаас хойш Монгол Улсын Засгийн газар нь ЭШУС үндэсний ажиллагаагаа байгуулсан нь эрүү шүүлтээс урьдчилан



сэргийлэх чухал алхам болжээ. Энэ удаагийн айлчлалаар Монгол Улсын Засгийн газар Дэд хорооны өмнөх айлчлалаас гаргасан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх, шинэхэн байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд түлхүү анхаарах болно” хэмээн энэхүү айлчлалын зорилгыг тодорхойлсон.

Дэд хорооны гишүүд айлчлалын хоёр өдрийн турш ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран хяналт шинжилгээ хийхдээ үндэсний ажиллагааны албан хаагчдын хорих анги, цагдан хорих байр, сэтгэцийн эрүүл мэндийн болон асрамж халамжийн байгууллагад хийдэг хяналт шинжилгээний арга барилын бүхий л явцыг, тухайлбал тухайн байгууламжид нэвтрэн орохоос эхлэн, удирдлагын багтай яриа хэлэлцээр өрнүүлэх, эрх чөлөөгөө хасуулсан иргэдтэй ярилцах, асуумж судалгаа авах, орчны ажиглалт, хэмжилт хийж буй байдлыг ажиглах, шаардлагатай үед газар дээр нь зөвлөгөө, зааварчилгаа өгөх байдлаар ажилласан бөгөөд хяналт шинжилгээний бүрийн төгсгөлд ЭШУС үндэсний ажиллагаанд урьдчилсан ажиглалт, дүгнэлтээ танилцуулж байсан нь үндэсний ажиллагааны албан хаагчид хяналт шинжилгээ хийх арга барилдаа хөндлөнгийн ажиглагчдын дүгнэлтийг тусгах, ажлын арга барилаа засаж, сайжруулах, улам чадавхжихад чухал нөлөө үзүүлсэн.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Монгол Улсад хийсэн айлчлалын бүрэлдэхүүн уг айлчлалын талаарх мэдээллийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр олон нийтэд зориулан хэвлэн нийтэлсэн<sup>189</sup>.

Уг мэдээлэлд “... Монгол Улсын эрүү шүүлт тулгах явдалд хяналт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий хараат бус нэгж нь эрүү шүүлт тулгах гэмт хэргээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж байгааг цаашид улам баталгаажуулж, бэхжүүлэх шаардлагатай” хэмээсэн нь ЭШУС үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга барил олон улсын стандартад нийцэн, үр дүнтэй явагдаж буйг хүлээн зөвшөөрсөн явдал юм.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулганаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын III илтгэлийг хэлэлцэн, Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн дүгнэлт, зөвлөмждөө<sup>190</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026)-г батлан, хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь Монгол Улсад эрүү шүүлтээс ангид байх хүний эрх хангагдах, хамгаалагдах, энэ эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чухал алхам болсныг онцолсон нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд баримталж буй ЭШУС үндэсний ажиллагааны бодлогыг үнэлж байгаа чухал алхам болсон.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ нь ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй үе шатлал бүхий арга хэмжээний талаар албан ёсны цахим хуудастаа нийтлэхдээ “Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь хэдий байгуулагдаад удаагүй ч аль хэдийнэ бүс нутгийнхаа УСҮБ, ХЭҮБ-дын дунд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх “үлгэр жишээ” болжээ”<sup>191</sup> хэмээн дүгнэсэн.

<sup>189</sup> [Mongolia: Paradigm shift towards rehabilitative approach needed for effective torture prevention, UN experts find | OHCHR](#)

<sup>190</sup> [CAT/C/MNG/CO/3](#)

<sup>191</sup> [Mongolia: A new monitoring body focuses on risky practices and women in detention | APT](#)

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэхэд гаргаж буй хүчин чармайлт, албан хаагчдын ур чадвар олон улсын хүний эрхийн стандартад нийцэн чадавхжиж буй талаар НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүдийн Монгол Улсад хийсэн хоёрдахь албан айлчлалын тэргүүн, Дэд хорооны гишүүн, Дэд хорооны УСҮБ-уудыг хариуцсан дэд дарга, хатагтай Элина Штайнерт нь айлчлалын дүгнэх уулзалт болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулганы үеэр дурдсан.

Олон улсын түвшинд ийнхүү танигдан, хүлээн зөвшөөрөгдөх хүртлээ Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа нь НҮБ-ын гэрээний хороод, ОУБ, бусад улсын УСҮБ-тай идэвхтэй харилцаа холбоотой байж, хамтын ажиллагааг эрэлхийлэн, ажил хэрэг болгон хэрэгжүүлж, эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга зүй, мэдлэг, ур чадвараа олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн, чадавхжуулах хүчин чармайлтаа зогсолтгүй хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд энэхүү хүчин чармайлтыг НҮБ-ын гэрээний хороод, олон улсын байгууллагууд онцлон анхаарч, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэх, Монгол Улсын иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хэрэгжилтэд ахиц дэвшил гаргахад хамтран ажиллах, дэмжин туслах ажлыг бодлогын түвшиндээ авч хэрэгжүүлж байгааг энд онцлох нь зүйтэй.

Тухайлбал, ЭШУС үндэсний ажиллагаа нь “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг чадавхжуулах, нийт хүн амын дундах эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлэх нь” төсөл боловсруулан, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд илгээсэн нь холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцэн, дэмжигдсэн бөгөөд төсөл 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаанд хэрэгжсэнээр ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагч, болон төрийн байгууллагын алба хаагчдад зориулсан өөрөө суралцах цахим платформ бүтээгдэж, хэрэглээ тогтмолжсоноор албан хаагчид хөндлөнгийн оролцоогүйгээр ур чадвараа байнга дээшлүүлэх боломж нээгдэж, хэрэглээ тогтмолжсоноор төрийн албан хаагчид хүний эрхийн мэдлэгээ тэлж, хүний эрхэд суурилсан хандлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хөндлөнгийн оролцоогүйгээр хэвшүүлэх нөхцөл бүрдэх болно.

Хөдөлгөөнт дүрс бүхий сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн болон бусад хэвлэмэл сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг төслийн хүрээнд бүтээснээр ЭШУС үндэсний ажиллагаа нь олон нийтийн мэдлэгийг тогтмол дээшлүүлэх сургалт, сурталчилгааны нөөц хэрэгсэлтэй болсон байна.

#SafeInCustody хөдөлгөөнд иргэд, төрийн эрх мэдэлтнүүд, байгууллагуудыг нэгтгэснээр хүний эрх чөлөөг хязгаарлах төрийн аливаа үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчихгүй байхад олон нийтийн хяналт сайжрах болно.



## САНАЛ

Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолууд батлагдаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах;

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын III илтгэлийг хэлэлцээд, Засгийн газарт ирүүлсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Монгол Улсын Хүний эрхийг хангах Үндэсний II хөтөлбөрт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын III илтгэлийг хэлэлцээд, Засгийн газарт ирүүлсэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Зөвлөмжид дурдсан хүний хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах.

## 4.2 ИРГЭНИЙ НИЙГМИЙН БОЛОН АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрөөс хараат бус, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх статус нь УСҮБ-аас урьтаж эрүү шүүлтийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл Иргэний нийгмийн байгууллагуудад түрүүлж хүрдэг практик бий. Энэ ч утгаараа иргэний нийгэм нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг учир НҮБ-ын гэрээний хороод, ОУБ-уудын зүгээс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа Иргэний нийгмийн байгууллагын уг онцлогтой хоршуулан хэрэгжүүлэхийг зөвлөдөг<sup>192</sup>.

ЭШУС үндэсний ажиллагаа нь өмнөх жилүүдэд “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” ТББ, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо, “Шогч бийр” шог зураачдын холбоо зэрэг Иргэний нийгмийн байгууллагуудтай тухайлсан арга хэмжээний хүрээнд зөвхөн хоёр байгууллагын хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн бол 2024 онд энэхүү хамтралын хүчийг улам зузаатгаж, олон талт хамтын ажиллагааны хэлбэрт шилжин ажиллаж эхлээд байна.



ЭШУС үндэсний ажиллагаа нь иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагууд, тухайлбал “Монголын ЛГБТ Төв”, “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” зэрэг ТББ-ын удирдлагуудтай 2024 оны турш зохион байгуулсан.

Эдгээр уулзалтын дүнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Иргэний нийгмийн байгууллагууд төрийн бодлого боловсруулах үйл явцад оролцохоос илүүтэй, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихад оролцох л боломжтой байгаад анхаарал хандуулж, ХЭҮКтХ-ийн 33.1.3, 34.1.7-д заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-уудын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хамтран хэрэгжүүлэх ажлын саналуудыг тусган “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг боловсруулан баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<sup>192</sup> “НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Монгол Улсад хийсэн хоёр дахь айлчлалын тайлан, зөвлөмж”, 31 дэх зүйл



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ний оролцогч талууд нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах, хамтран ажиллах зорилгоор дараах ажлуудыг хамтран хэрэгжүүлж байна. Үүнд:

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд 8 ажил:

- ◇ “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо” уулзалт - хэлэлцүүлэг зохион байгуулах
  - “Монгол Улс дахь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах
  - “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдэвт радио подкаст хийж, сонсогчдод эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай ойлголт, мэдээлэл хүргэх
  - “Хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах нь” сэдэвт төслийн санал боловсруулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүргүүлэх
  - Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд иргэдийн дунд #SafeInCustody чөлөөт микрофон ажиллуулж, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг тодорхойлох, ойлголт мэдлэг өгөх
  - #SafeInCustody сэдэвт зурагт хуудас, тараах хуудас бүтээх уралдаан зохион байгуулах

- Хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд #SafeInCustody сэдэвт мэтгэлцээн зохион байгуулах
  - “Эрүү шүүлтэд өртөхөөс өөрийгөө хамгаалах нь” сэдэвт сургалт зохион байгуулах
- ◇ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх зорилтын хүрээнд 3 ажил:
- Улаанбаатарын Тунхаглалд Монгол Улсын холбогдох төрийн байгууллагуудыг нэгтгэх
  - Монгол Улс дахь эрүү шүүлт тулгах гэмт хэргийн/үйлдлийн хэв маягийн судалгаа хийх
  - Эрүү шүүлтийн хохирогчдыг нөхөн сэргээх, нөхөн олговор авахтай холбоотой өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн өнөөгийн төлөв байдал, хууль эрх зүйн орчны үнэлгээ, цаашид шийдвэрлэх асуудлыг тодорхойлох судалгаа хийх.

**Хамтын ажиллагааны хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт – хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг - Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт – хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.



УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан энэхүү хэлэлцүүлэгт хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл болох Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлтэй тэмцэх үндэсний холбоо, “Иргэдийн шударга шүүх” ТББ, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл, ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хороо, Монголын Хуульчдын холбоо, Монголын

Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологичдын холбоо, “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” байгууллагуудын төлөөлөл оролцож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжин оролцохоо илэрхийлж, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.



Мөн уг уулзалтаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн бүрэн эрхийн хүрээнд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн Монгол Улсын 3 дахь илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дүгнэлт, зөвлөмж”-ийг Иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулсан.

Уулзалтаар Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцээд, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол, УИХ-ын ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн байдалд Иргэний нийгмийн өгч буй дүгнэлт, саналыг нэгтгэн, Монгол Улсын Засгийн газарт хандан Уриалга193 хүргүүлэх ажлын эхлэлийг тавилаа.



Түүнчлэн олон улсад өрнөж байгаа эрүүдэн шүүх, зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх нь хамтын үүрэг хариуцлага болохыг сануулж, бүх нийтээр нэгдсэн цагт хүний эрхийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна гэх үзэл баримтлалыг түгээж буй #SafeInCustody хөдөлгөөнийг Монгол Улсад нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажлын эхлэл болгож, “#Sa-



felnCustody – Улаанбаатарын тунхаглал"-ын төслийг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” уулзалт-хэлэлцүүлгийн үеэр зохион байгуулагч, оролцогч талууд хамтран боловсруулсан ба #SafeInCustody хөдөлгөөн нь Монгол Улсад албан ёсоор “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр” буюу 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр өрнөж эхлэх болно.

Шигтгээ 1

Уриалгын төслийг дэмжиж байна. Монгол Улсын Засгийн газар ажлаа эрчимжүүлэх шаардлагатай байгаа учир Иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн Эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг нь сануулж, анхаарлын төвд оруулах оролдлого гэж энэхүү Уриалгыг ойлгож болно.

Уриалгын төслийг хэлэлцэх үеэр “Иргэдийн шударга шүүх” ТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалтын хэлсэн үгнээс

Шигтгээ 2

ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдсанаар эрүү шүүлтийн хохирогчдын тухай асуудал олны анхааралд өртсөн. Тийм учраас миний бие Монгол Улсад эрүү шүүлтээс ангид байх хүний эрх хангагдахад ахиц, дэвшил гарахад түлхэц өгөх болов уу гэсэн найдвар тээн энэхүү Уриалгад нэгдэж байна. Өнгөрсөн алдаан дээрээ дүгнэлт хийж, алдаагаа засах арга хэмжээ авч байж аливаа зүйл хөгжил дэвшилд хүрдэг. Алдаагаа яриад л найрсаад байвал хөгжил дэвшилд хүрэхгүй.

Уриалгын төслийг хэлэлцэх үеэр “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”-ны гишүүн Б.Батзоригийн хэлсэн үгнээс

**Хамтын ажиллагааны хүрээнд “Хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах нь” төслийн саналыг Тусгай санд хүргүүлээ**

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-д “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах зорилгын хүрээнд цогц үйл ажиллагаа явуулахад чиглэсэн төслийн саналыг хүргүүлэх ажил багтсан.

Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт, мэдлэг, эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаарх судалгаа Монгол Улсад өмнө хийгдэж байгаагүй аж. Харин ЭШУС үндэсний ажиллагаа нь ашгийн бус байгууллагуудтай хамтран Эрүү шүүлтээс ангид байх эрхийн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар хэд хэдэн судалгааг эхлүүлээд байгаа бөгөөд үүнд “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-ыг татан оролцуулж, иргэдийн эрүү



шүүлтээс ангид байх эрхийн ойлголт, мэдлэгийн төлөв байдалд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 4 бүсийг хамруулсан судалгаа хийх саналыг тавьсан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийг хянах үйл ажиллагааны хүрээнд хийсэн “Ази тив дэх бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийллийн төлөв байдлын судалгаа194”-ны илэрцэд Монгол Улсын иргэн, нэгэн трансжендер эмэгтэй архины эмчилгээнд хамрагдахаар СЭМҮТ-д хандахад түүнтэй харьцаж, уулзсан анхны эмчийн дуу хоолой нь захирангуй, дээрэнгүй, өөрийнхөө санаа бодлыг тулгаж, буруутган, зэмлэж, сэтгэл санаагаар шаналган зовоосон тохиолдол бүртгэгдсэн байна.

Өөр нэг тохиолдол: нэгэн трансжендер эрэгтэй бусдад зодуулж, хутгалуулж, хамрынхаа дундуур хутгаар сийчүүлж, хүнд гэмтэл авч, хохирсон байхад тухайн гомдол дээр ажиллаж байсан цагдаагийн алба хаагч мөрдөн шалгах ажиллагаа хийлгүй, “тэдгээр хүмүүст арга хэмжээ аваад явуулчихсан. Санаа зоволтгүй, тайван байж болно» хэмээн хохирогчийг явуулсан байв. Түүнчлэн буруутай этгээдийг шүүх хурал болох талаар хохирогч ямар ч мэдээлэл аваагүй тул хуралд оролцоогүй, өөрийг нь хохироосон буруутай этгээд ямар шийтгэл хүлээсэн эсэх нь хохирогчид тодорхойгүй үлджээ.

Төрийн нэрийн өмнөөс иргэнтэй харьцаж, хууль сахиулах тэргүүн эгнээний төрийн алба хаагч бол цагдаагийн алба хаагч юм. Иргэний эрүүл мэндийг сахин хамгаалах төрийн үүргийг хэрэгжүүлдэг, иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тэргүүн эгнээний байгууллага нь төрийн харьяаны нэгдсэн эмнэлэг, яаралтай тусламжийн тасаг, бусад төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд билээ. Харин Төрийн нэрийн өмнөөс иргэнд хийсэн гэм буруутай үйлдэлд нь ял, шийтгэл оноодог эцсийн шатны байгууллага нь Шүүх эрх мэдлийн байгууллага.

Иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын судалгааг хийхдээ эмнэлэг, цагдаа, шүүхийн байгууллагын алба хаагчдыг хамруулан эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн ойлголт, мэдлэгийг тодорхойлсноор төрийн нэрийн өмнөөс иргэнтэй анхлан уулзаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж, хууль сахиулж, төрийн нэрийн өмнөөс гэм буруутай үйлдэлд ял оноодог шүүх байгууллагын үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангаж ажиллах төлөвшлийг бий болгоход сургалт, нөлөөллийн арга хэмжээ явуулах нь оновчтой хэлбэр үндэслэл тогтоогдох учиртай.

ЭШУС үндэсний ажиллагаа болон “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ хамтран “Хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах нь” төслийг боловсруулж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн. Төсөл дэмжигдсэнээр:

- Монгол Улсын иргэд, тэр дундаа нийгмийн эрсдэлт бүлэгт хамаарах иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн тухай ойлголт, мэдлэгийн төлөв байдлыг тодорхойлох 4 бүсийн судалгаа хийх;

194 [Gender-based-Torture-in-Asia.pdf](#)

- “Судалгааны үр дүнд үндэслэн зорилтот бүлгийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн боловсрол олгох нөлөөллийн ажил өрнүүлэх;
- “Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын Цагдаа, эмнэлэг, шүүх байгууллагуудын алба хаагчдад эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхэд суурилсан ажлын арга барилыг төлөвшүүлэх нөлөөллийн ажил өрнүүлэх зорилтуудын хүрээнд 2026 оны турш хэрэгжих юм.

### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх ажилд ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй хамтран ажиллах хүрээнд**

ЭШУС үндэсний ажиллагаа нь ХЭҮКтХ-ийн 33.1.3-т заасан “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийн хүрээнд 2024 онд 1 судалгаа, дүн шинжилгээний ажил, 1 сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлыг 1 судлаачдын баг, ашгийн бус 1 хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлсэн бол 2025 онд 2 судалгааны ажлыг хараат бус 2 шинжээчдийн багаар гүйцэтгүүлж байна. Тухайлбал:

2024 онд:

“ХЭҮКтХ-ийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ”-г Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан судлаачдын багтай ХЭҮК(2024)12 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан гүйцэтгүүлсэн. Уг судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ, хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой байлаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, НҮБ-ын хараат бус шинжээчдийн зөвлөмжийн биелэлтийг хангах, ЭШУС үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн доктор, профессор, Монгол Улсын Гавьяат хуульч П.Оюунчимэгтэй ХЭҮК/2024/21 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага боловсруулах ажлуудыг гүйцэтгүүлсэн. Уг “Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын тухай ойлголт, уг конвенцын дагуу Монгол Улсын дотоодын хууль тогтоомжуудад оруулсан хууль эрх зүйн зохицуулалт болон олон улсын түвшинд эрүү шүүлттэй тэмцэж буй туршлага, хохирогч хамгаалал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны

чиг үүрэг, бүрэн эрхийн талаар хууль сахиулах байгууллагын ажилтнуудад нэгдсэн мэдлэг, мэдээлэл өгөхөд чиглэгдсэн.

## 2025 ОНД:

Монголын Криминологийн холбооны судлаачдын багтай ХЭҮК/2025/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологийн (суурь судалгаа) судалгаа хийх” ажлыг гүйцэтгүүлээ. Гэрээний дагуу “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” дэд сэдвийн хүрээнд судалгаа хийгдэв.

ЭШУС үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн «Эрүү шүүлт тулгах, нотлох баримт хуурамчаар үйлдэх гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох» болон «Авлига-хүний эрхийн зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах» зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, улмаар хэрэгжилтийг хангахаар АТГ-ын санхүүжилтээр “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн криминологийн шинж” сэдэвт судалгааны ажлыг хараат бус судлаачдыг багаар хийж гүйцэтгүүлэх гэж байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж эхэлснээр НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажсан эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай ойлголт олон нийтэд эрчимтэй түгээж, иргэд эрүү шүүлтээс ангид байх эрхийг нь хангаж ажиллахыг төрийн байгууллагын алба хаагчдаас шаардах чадвар тэр хэрээр нэмэгдсэний илрэл нь эрүү шүүлттэй тэмцэх, хүний эрхийг төрийн албан хаагчдын хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах, иргэний эрхээ хамгаалах чадварыг нэмэгдүүлэх, түүнчлэн эрүү шүүлтийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага, холбоод нийгэмд бүрэлдэн бий болсон явдал юм.

ЭШУС үндэсний ажиллагаа нь өмнөх жилүүдэд “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” ТББ, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо, “Шогч бийр” шог зураачдын холбоо зэрэг Иргэний нийгмийн байгууллагуудтай тухайлсан арга хэмжээний хүрээнд зөвхөн хоёр байгууллагын хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн бол 2024 онд энэхүү хамтралын хүчийг улам зузаатгаж, эрүү шүүлттэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах, иргэний эрхээ хамгаалах чадварыг нэмэгдүүлэхэд идэвхтэй явуулж байгаа ТББ-уудтай олон талт хамтын ажиллагааны хэлбэрт шилжин ажиллаж байна.

ЭШУС үндэсний ажиллагаа нь иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Иргэний нийгмийн байгууллагууд, тухайлбал “Монголын ЛГБТ Төв”, “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”,

“Сэтгэлзүйн мэдрэмж” зэрэг ТББ-ын удирдлагуудтай 2024 оны турш зохион байгуулсан.

Эдгээр уулзалтын дүнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Иргэний нийгмийн байгууллагууд төрийн бодлого боловсруулах үйл явцад оролцохоос илүүтэй, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихад оролцох л боломжтой байгаад анхаарал хандуулж, ХЭҮКтХ-ийн 33.1.3, 34.1.7-д заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-уудын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хамтран хэрэгжүүлэх ажлын саналуудыг тусган “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг боловсруулан баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт – хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Иргэдийн шударга шүүх” ТББ, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл, ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хороо, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологийн холбоо, “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” байгууллагуудын төлөөлөл оролцож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжин оролцохоо илэрхийлж, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.

Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцээд, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар УИХ-ын ХЗБХ-д танилцуулах хугацаа даруй 2 жил 6 сараар удааширсан, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол, УИХ-ын ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн тайланг ХЗБХ-д танилцуулах хугацаа 2025 оны хаврын ээлжит чуулган явагдаж буй эдгээр өдрүүдэд тохиож байгаа боловч танилцуулагдаагүй хэвээр байгаад уулзалт-хэлэлцүүлэгт оролцсон Иргэний нийгмийн байгууллагууд шүүмжлэлтэй хандаж, Монгол Улсын Засгийн газар иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлээр дээрх тогтоолуудаар даалгасан арга хэмжээ бүрийг даруй авч хэрэгжүүлэхийг

уриалж, Монгол Улсын Засгийн газарт Уриалга195 гаргасан ба ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны үйл ажиллагааны тайлангаар дамжуулан Засгийн газарт хүргүүлж байна.

Олон улсад өрнөж байгаа эрүүдэн шүүх, зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх нь хамтын үүрэг хариуцлага болохыг сануулж, бүх нийтээр нэгдсэн цагт хүний эрхийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна гэх үзэл баримтлалыг түгээж буй #SafeInCustody хөдөлгөөнийг Монгол Улсад нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажлын эхлэл болгож, “#SafeInCustody – Улаанбаатарын тунхаглал”-ын төслийг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” уулзалт-хэлэлцүүлгийн үеэр зохион байгуулагч, оролцогч талууд хамтран боловсруулсан ба #SafeInCustody хөдөлгөөн нь Монгол Улсад албан ёсоор “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр” буюу 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр өрнөж эхлэх болно.

“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-д “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах зорилгын хүрээнд цогц үйл ажиллагаа явуулахад чиглэсэн төслийн саналыг хүргүүлэх ажил багтсан.

Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт, мэдлэг, эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаарх судалгаа Монгол Улсад өмнө хийгдэж байгаагүй учир санхүүжүүлэгч байгууллагын дэмжлэгээр иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн ойлголт, мэдлэгийн төлөв байдалд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 4 бүсийг хамруулсан судалгаа хийх, судалгааны үр дүнд үндэслэн зорилтот бүлгийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн боловсрол олгох нөлөөллийн ажил өрнүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон эмнэлгийн байгууллагуудын алба хаагчдад эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхэд суурилсан ажлын арга барилыг төлөвшүүлэх нөлөөллийн ажил өрнүүлэх төслийг “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран 2026 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүргүүлсэн.

ЭШУС үндэсний ажиллагаа нь ХЭҮКТХ-ийн 33.1.3-т заасан “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийн хүрээнд 2024 онд “ХЭҮКТХ-ийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ” сэдвээр 1 судалгаа, дүн шинжилгээний ажил, “Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага боловсруулах ажлуудыг 1 судлаачдын баг, ашгийн бус 1 хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлсэн

бол 2025 онд хараат бус судлаачдын багаар “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” дэд сэдвүүдийн хүрээнд цогц судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

“ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ” судалгааны ажил нь хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид ЭШУС үндэсний ажиллагааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой байв.

“Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын тухай ойлголт, уг конвенцын дагуу Монгол Улсын дотоодын хууль тогтоомжуудад оруулсан хууль эрх зүйн зохицуулалт болон олон улсын түвшинд эрүү шүүлттэй тэмцэж буй туршлага, хохирогч хамгаалал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг, бүрэн эрхийн талаар хууль сахиулах байгууллагын ажилтнуудад нэгдсэн мэдлэг, мэдээлэл өгөхөд чиглэгдсэн бол Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нөхцөлдүүлж буй шалтгаан нөхцөлд хийсэн криминологийн судалгаа нь эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх Монгол Улсын нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг зөв бүрдүүлэхэд чухал судалгааны баримт бичиг болсон.

ЭШУС үндэсний ажиллагаа нь Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхлээд буй энэхүү “хамтрал” нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй байх ёстой, үр дүнтэй, цогц үйл ажиллагааны бүрэлдэхүүн юм. Учир нь Иргэний нийгмийн байгууллагууд бол иргэдийн төлөөлөл. Тэд иргэдийн хэрэгцээг байнга тодорхойлж, үүссэн хэрэгцээнд шуурхай хариу үйлдэл үзүүлдэг.

ЭШУС үндэсний ажиллагаа нь 2024 оноос иргэний нийгмийн, ашгийн бус байгууллагатай явуулж ирсэн хамтын ажиллагааны арга барилдаа дүгнэлт хийж, илүү үр дүнтэй байх “олон талт оролцогчдын хамтын ажиллагаа”-ны хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд цаашид ч эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх төрийн үйл хэрэг иргэдэд илүү ойртож, иргэдийн эрх, эрх чөлөө, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн нөхцөл байдал, эрхээ эдлэх хэрэгцээ шаардлагыг үнэн зөв тодорхойлж, бодит үр дүнд хүрэхийн төлөө ЭШУС үндэсний ажиллагаа болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны оролцооны хүрээгээ улам тэлэн ажиллахыг зорьж байна.



## **“ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО” УУЛЗАЛТ-ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРГАСАН САНАЛ**

- ЭШУС үндэсний ажиллагааны зохион байгуулсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт-хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн газарт уламжлахаар санал нэгдэн гаргасан “Монгол Улсын иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай” Уриалгыг биелүүлэх;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үйлдсэн, өдөөн турхирсан нь тогтоогдож, шүүхээр ял шийтгэл оноосон төрийн эрх мэдэлтэн, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хамтран оролцсон бүхий л этгээд, албан тушаалтныг насан туршид нь төрийн албанд томилохгүй байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Үйлдэгдсэн нь нэгэнт тогтоогдсон эрүү шүүлт тулгах гэмт хэргүүдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, ингэснээр төрийн албан хаагч, эрх мэдэлтэй этгээд эрүү шүүлт тулгах үйлдэл давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- Төрийн албан хаагч хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө эрүү шүүлтэд өртсөн нь нэгэнт тогтоогдсон тохиолдлуудыг Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хүний эрхийг хамгаалах агуулгад “баримт” болгон тусгадаг байх;
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит хэлэлцүүлэг (UPR) болон бусад зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангаж, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийг хангах тухай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
-





## ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

**НЭГ.** ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар нийт 169 өргөдөл, гомдол мэдээллийг ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж ирүүлсэн. Үүнээс тайлант хугацаанд нийт 92 өргөдөл, гомдол мэдээлэл ирүүлсэн байна.

ХЭҮКТХ-ийн 34.1.6-д эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх гэж заасан. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандаж иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 169 гомдол мэдээллийг хүлээн авч танилцан аливаа хэлбэрээр эрх нь зөрчигдсөн иргэнтэй биечлэн уулзаж эрх зүйн туслалцаа үзүүлсэн 76, зарим санал хүсэлтийг эрх бүхий албан тушаалтнаар даруй шийдвэрлүүлэн, гомдлыг шалган шийдвэрлүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хуулийн хугацаанд албан бичгээр 93 гомдлыг шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллав.

ШШГЕГ-ын харьяа нээлттэй болон хаалттай хорих ангиудад хорих ял эдэлж байгаа ялтан, цагдан хоригдогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нараас эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх нь зөрчигдсөн асуудлаар "Биечлэн уулзах хүсэлт" гаргасан 76 хүсэлт ирсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Биечлэн уулзах хүсэлт гаргасан иргэдтэй ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн өөрийн биеэр болон ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагч нар тухайн иргэдийн байгаа газарт хүрэлцэн очиж биечлэн уулзаж эрх зүйн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ газар дээр нь шийдвэрлэх боломжтой гомдол, хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэж, зарим тохиолдолд цахим хэлбэрээр уулзаж ажиллав. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй иргэдээс гаргасан биечлэн уулзах хүсэлт болон бичгээр ирүүлсэн гомдол, мэдээлэлд дараах эрхийн зөрчлүүд голчлон яригдаж, бичигддэг болно. Үүнд:

- Шударга шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах тухай;
- Хорих ангийн удирдлага, алба хаагчдын зүгээс эрүү шүүлт тулгаж байгаа тухай;
- Хэл амаар доромжлон харьцаж, сэтгэл санааны дарамтад ял эдэлж буй тухай;
- Хийгээгүй хэрэгт холбогдуулан ял шийтгэсэн тухай;
- Хорих ангийн дотоод журам 196 зөрчигдөж байгаа тухай;
- Хорих ангийн орчин нөхцөл, хоол хүнс, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа тухай;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах тухай;
- Тэтгэвэр тэтгэмжээ авч чадахгүй байгаа;
- Хоригдолд шагналын хоног олгохдоо шударга бус хандаж байгаа тухай;

- Бусад хоригдолд дарамтлуулан зодуулсан тухай;
- Магадланд оруулахгүй байгаа тухай;
- Хууль сахиулах байгууллагын алба хаагч эрүү шүүлт тулгасан тухай;

ШШГ хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, Цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийхдээ тус байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтан, хорих ангид хорих ял эдэлж байгаа, цагдан хоригдсон, баривчлагдсан, саатуулагдсан хүмүүстэй ярилцлага хийх, түүврийн аргаар асуумж бөглүүлэх зэргээр тэдэнд тулгарсан зөрчигдсөн эрхийн талаар мэдээллийг авч газар дээр нь шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж ажиллав. Тухайлбал:

- Хоригдогч Ж-ээс гаргасан хүсэлтийн дагуу Цагдан хорих ангийн дэд дарга, дэд хурандаа Б.Амгаланбаатартай биечлэн уулзаж, эмч нарын зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу хоригдогч Ж-г “Мөнгөн гүүр” эмнэлэгт ходоодны дурангийн шинжилгээнд оруулахаар шийдвэрлүүлэв.
- Хүмүүжигч Д.А нь өвдөгний үений яс ургалт оноштойгоор хэвтрийн дэглэм сахидаг бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, “Бриллиант эмнэлэгт” шинжилгээнд хамруулах нөхцөлийг бүрдүүлэн өгч, тус эмнэлэгт өвдөгний үений “MRI” зураг авхуулав.

## ХОЁР. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ, ХАРЬАЛАН ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БАЙДАЛ

ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж 2022-2025 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг харьяалан шийдвэрлүүлэхээр АТГ-т 30, УЕПГ-т 23, ШШГЕГ болон харьяа ШШГ байгууллагуудад 23, Цагдаагийн байгууллагад 3, холбогдох бусад байгууллагад тус тус шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээллийг авч нэгтгэн, хэрэгжилтийг тооцож ажиллав.

2022 оны байдлаар:

Хүснэгт 35

Өргөдөл, гомдлыг шилжүүлсэн байгууллага		2022
<b>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа</b>	Биечлэн уулзсан, гомдол гаргагчид хариу өгсөн	8
	Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газрууд	1
	Авлигатай тэмцэх газар	1
	Гомдлыг түр хаасан	1
<b>Нийт</b>		<b>11</b>

2023 оны байдлаар:

Хүснэгт 36

<b>Өргөдөл, гомдлыг шилжүүлсэн байгууллага</b>		<b>2023</b>
<b>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа</b>	Биечлэн уулзсан, гомдол гаргагчид хариу өгсөн	26
	ШШГЕГ, харъя ШШГ байгууллагууд	8
	Улсын ерөнхий прокурор, харъя прокурорын газрууд	8
	Авлигатай тэмцэх газар	12
	Шүүхийн сахилгын хороо	1
	Цагдаагийн ерөнхий газар	2
	Ижил утгатай гомдлыг ГХШХ-т нэгтгэн шалгуулахаар нэгтгэсэн	2
<b>Нийт</b>		<b>59</b>

2024 оны байдлаар:

Хүснэгт 37

<b>Өргөдөл, гомдлыг шилжүүлсэн байгууллага</b>		<b>2024</b>
<b>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа</b>	Биечлэн уулзсан, гомдол гаргагчид хариу өгсөн	36
	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллагууд	17
	Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газрууд	15
	Авлигатай тэмцэх газар	19
	Хууль зүй, Дотоод хэргийн яам	4
	Өмгөөлөгчдийн холбоо	1
	Шүүхийн сахилгын хороо	1
	Ерөнхийлөгчийн тамгын газар	1
	Шүүхийн сахилгын хороо	1
	Монголын хүүхдийн сан төлөөлөгчийн газар	1
	Цагдаагийн ерөнхий газар	1
	ХЭҮК-ын ГХШХ-т гомдолд нэгтгэх	1
	Талархал илэрхийлсэн	1
<b>Нийт</b>		<b>99</b>



Тайлант хугацаанд буюу 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар:

Хүснэгт 38

<b>Өргөдөл, гомдлыг шилжүүлсэн байгууллага</b>		<b>2024-2025</b>
<b>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа</b>	Биечлэн уулзсан, гомдол гаргагчид хариу өгсөн	32
	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллагууд	14
	Улсын ерөнхий прокурор, харьяа прокурорын газрууд	16
	Авлигатай тэмцэх газар	15
	Хууль зүй, Дотоод хэргийн яам	4
	Өмгөөлөгчдийн холбоо	1
	Шүүхийн сахилгын хороо	1
	Ерөнхийлөгчийн тамгын газар	1
	Шүүхийн сахилгын хороо	1
	Монголын хүүхдийн сан төлөөлөгчийн газар	1
	Цагдаагийн ерөнхий газар	1
	Төрийн албаны зөвлөлд	1
	ХЭҮК-ын ГХШХ-т гомдолд нэгтгэх	1
	Талархал илэрхийлсэн	1
	Бусад	2
<b>Нийт</b>		92

## ГУРАВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ЭРХИЙН ТӨРӨЛ

ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг зөрчигдсөн эрхийн агуулгаар нь ангилбал:

Хүснэгт 39

№		Эрхийн төрөл	Өргөдөл гомдлын тоо		
			2022	2023	2024
1	Халдашгүй чөлөөтэй байх эрх	Хорих ангийн алба хаагч эрүү шүүлт тулгасан	1	8	7
		Прокурорын алба хаагч эрүү шүүлт тулгасан	1	6	5
		ШШГ байгууллагын алба хаагч эрүү шүүлт тулгасан	1	6	6
		Цагдаагийн алба хаагч эрүү шүүлт тулгасан	1	-	12
		Бусад (хорих ангийн нөхцөл гэх мэт)		2	1
2	Шударга шүүхээр шүүлгэх эрх	Хууль зүйн туслалцаа авах	3	8	20
		Хилс хэрэгт холбогдсон	1	4	1
		Нотлох баримт шалгуулах, прокурор шүүхэд нэхэмжлэх гаргах	1	9	17
3	Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх	Үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, холбогдсон зүйл ангиар ялгаварлан гадуурхагдсан		4	3
4	Бусад	Биечлэн уулзаж хууль зүйн зөвлөгөө авах	2	12	27
5	Нийт		11	59	99

## ДӨРӨВ. ЭРҮҮ ШҮҮЛТ, ХҮНЛЭГ БУС ХАРЬЦАА, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДСӨН ТАЛААРХ ОНЦЛОХ ТОХИОЛДЛУУД

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад хорих ял эдэлж байгаа хоригдол, хоригдогч нараас ирүүлсэн гомдол дийлэнх хувийг эзэлдэг. Тухайлбал:

300 гаруй хүнийг бүгдийг явган суулгаад 13:30 минутын орчим баахан багтай зэвсэглэсэн хүмүүс орж ирэн харц доошоо, гараа шилэндээ ав гэж муухай дуугаар чанга бархирч гарыг нь шилэн хүзүүнд салаавчлуулан цахилгаан бороохойгоор цохиулах, өшиглөх, 2 гар нь ардаа гавтай байхад шууд гаваас нь чирээд бохир угаадас асгадаг газар дахин өшиглөх....., хоригдлууд сууж байхад алба хаагч нар хүмүүс зааж өгч тэр хүмүүсийг чирч гаргаж ирээд гарыг нь ард нь гавлаад бүх хувцсыг тайлаад галуун цуваагаар тойруулж алхуулан 3-4 цаг зодож тамлаж байсан...

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Э.Б-ийн гомдлоос

Энэ хорих ангид ирээд шүүгчийн захирамжийн дагуу ялын хугацаагаа бодуулах гэж удаа дараа хүсэлт гаргасан боловч хүлээж авахгүй, гомдлоо гаргахгүй юу хулгайч минь амжилтад хүрэхгүй шүү, чиний захирамж хамаагүй бид нар мэдэж байна гээд прокурортой уулзуулдаггүй.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Б.Э-ийн гомдлоос

Тус хорих ангийн ерөнхий жижүүр Д-д гомдолтой байна, ... энэ хүн харилцааны доголдолтой хэл амаар доромжилж, хулгайчаа, ялтаан гэж дандаа хашхирч байдаг, намайг "нохой хийдэг" гэж байнга доромжилдог, би хорих ялыг сэтгэл зүйн дарамттай эдэлж байна.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Ц.Э-ийн гомдлоос

Ангийн дарга ерөөндөө дуудаж " Чи ар гэрээрээ гомдол гаргуулаад ямар овоо байна, би бол шоронд орохгүй, буруу шийдвэр гаргалаа гээд сахилгын шийтгэл авна биз. Харин чи бол миний доор энэ хориход байгаа шүү, заргалдаад явлаа гэхэд ялих ялихгүй юмаар нээнтэглээд чи юу ч олж долоохгүй шүү. Заргалдаад явахыг чинь харна аа" гэх зэргээр заналхийлж, сэтгэл санааны дарамтад оруулсан.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Н.Б-ийн эхнэр О.У-ийн гомдлоос

Ангийн эмнэлгийн албанд үзүүлэхээс айдаг болсон. Сувилагч а/а Б нь элдэв бусаар харааж зүхэж доромжилж, гарт таарсан юмаараа хоригдлуудыг дарамталдаг. Тухайлбал энэ алба хаагчтай холбоотойгоор түүнд зодуулж дарамтлуулсан нэлээдгүй хоригдлуудын дарамтад өртсөн тухай гомдол байна.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол М.С-ийн гомдлоос

Сувилагч а/а Б нь хоригдол Т-г хэл амаар доромжилж харааж зүхэж зодсон. Энэ асуудал ээлжийн даргын өрөөнд болсон...

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Г.Т-ийн гомдлоос

Хоригдол О-г эмчилгээ хийлгэж дусал залгаж сандал дээр суулгачихаад цохиж өшиглөсөн...

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол М.О-ийн гомдлоос

Хоригдол Б-г номхон зогсоож байгаад цээж рүү нь хэд хэдэн удаа цохиж, хөлр үү нь өшиглөсөн, удалгүй модоор цохиж мод нь хугарсан.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол Ж.Б-ийн гомдлоос

Хоригдол З-г ээлжийн даргын өрөөнд хэл амаар доромжилж бороохойгоор зодож, бороохойгоо бие рүү нь шидсэн. Мөн халуун ус дотор нэг хоригдлыг өшиглөж зодсон.

ШШГЕГ-ын ... дугаар хорих ангид ял эдэлж байгаа хоригдол М.З-ийн гомдлоос

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан ирүүлж байгаа дээрх төрлийн өргөдөл, гомдолтой холбоотойгоор ШШГЕГ болон салбар, нэгжүүдийн дарга, удирдлагад хүргүүлсэн зөвлөмж бүрд холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, сахилга, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаарх алба хаагчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, сургалт, мэргэжил арга зүй удирдлагаар хангах талаар тогтмол чиглэл өгч ажиллаж байна.

Мөн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хариуг тухай бүр авч, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах зөрчил, дутагдал гаргасан алба хаагч нарт хариуцлага тооцуулах тухай саналыг хүргүүлсэн.

Цаашид ШШГ байгууллага, удирдлага, алба хаагчид Үндсэн хууль, НҮБ-ын холбогдох гэрээ конвенцоор олгогдсон хүний хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг үл хүндэтгэж, үл хангаж, цаашилбал, Монгол Улсын хүний эрхийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгааг илтгэж буй тул энэ асуудлыг жил бүр бууруулах, таслан зогсооход онцгойлон анхаарч ажиллаж байна.

## ТАВ. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР, АВСАН АРГА ХЭМЖЭЭ

ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж ирүүлсэн гомдол мэдээллээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллахын зэрэгцээ түүний дагуу ямар арга хэмжээ авсан талаар эргэж мэдээллийг авах, эргэж мэдэгдээгүй албан газруудад дахин албан бичиг хүргүүлэн шийдвэрлэлтийн мэдээллийг авч, үр дүнг тооцож ажиллав.

Хүснэгт 40

№	Албан байгууллага	Шилжүүлсэн Гомдлын тоо	Хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлсэн гомдлын тоо	Шийдвэрлэлтийн хувь
<b>2022 онд</b>				
1	Авлигатай тэмцэх газар	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
2	УЕПГ, харъя прокурорын газар	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
3	Бусад	8	Биечлэн уулзсан	100%
<b>2023 онд</b>				
4	Авлигатай тэмцэх газар	10	Албан бичгээр хариу ирүүлээгүй 3	70.0%
5	УЕПГ, харъя прокурорын газар	7	Хариу ирүүлээгүй 3	57.0%
6	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	6	Албан бичгээр хариу ирүүлээгүй 4	30.0%
7	Цагдаагийн байгууллага	3	Албан бичгээр хариу ирүүлээгүй	0%
8	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн	100%
9	Бусад	32	Бусад байдлаар	100%
<b>2024 онд</b>				
10	Авлигатай тэмцэх газар	19	Албан бичгээр хариу ирүүлсэн 19	100%
11	УЕПГ, харъя прокурорын газар	15	Албан бичгээр хариу ирүүлсэн 15	100%

<b>12</b>	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	17	Албан бичгээр хариу ирүүлсэн 17,	100%
<b>13</b>	Цагдаагийн байгууллага	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
<b>14</b>	Хууль зүйн яам	3	Хариу ирүүлээгүй 3,	0%
<b>15</b>	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
<b>16</b>	Шүүхийн ерөнхий зөвлөл	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
<b>17</b>	Ерөнхийлөгчийн тамгын газар	1	Уучлалт үзүүлж шийдвэрлэсэн, албан бичгээр хариу ирүүлээгүй	0%
<b>18</b>	Өмгөөлөгчдийн холбоо	1	Хариу ирүүлээгүй 1	0%
<b>19</b>	Бусад	40	Бусад байдлаар	100%

Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх нь зөрчигдсөн талаар нийт 169 гомдол мэдээллийг хүлээн авсан тоон мэдээллийг харьцуулан үзвэл:

Хүснэгт 41

№	Ирсэн албан бичиг	2022	2023	2024	Нийт
1		11	59	99	169



## ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны хүрээнд 2022-2025 онд эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн хэрэгжилт 98.5 хувьтай байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг тухайн байгууллагаас тухай бүр болон шаардлагатай тохиолдолд нэгтгэсэн байдлаар ирүүлж хэвшжээ.

Шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлж байгаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан иргэдээс эрүү шүүлтэд өртсөн тухай зөрчигдсөн эрхийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар болон холбогдох харьяа газруудад шилжүүлэн шийдвэрлүүлэхээр хүргүүлдэг боловч тус гомдлыг хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэж байгаа нь 90.0 хувийг эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, цагдан хорих байранд байгаа хүнээс биечлэн уулзах хүсэлт гаргасан гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх хүрээнд ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүний зөвшөөрлөөр цахим уулзалтыг зохион байгуулж хэвшсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүнийг бусадтай утсаар болон цахимаар уулзахад албан хаагчийн биечилсэн хяналт тавих журмыг баримтлан ажилладаг ч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хүрээнд гишүүн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн албан хаагчид цахимаар уулзахдаа алба хаагчийн биечилсэн хяналтыг буулгаж, цахимаар уулзаж байгаа хүнийг чанга яригч ашиглахгүй заавал чихэвч зүүж яриулахыг тухайн байгууллага, алба хаагчдаас шаардаж уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн боломжит бүх аппликейшн (facebook, skype, google meet, vider) ашиглан, уулзалтад оролцогчийн зөвшөөрлийг үндэслэн дуу, дүрсний бичлэг хийж хадгалж, санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх цахим уулзалтын орчин нөхцөлийг бүрдүүлж чадлаа.

## САНАЛ

1. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд буюу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын мөрдөн шалгах хэлтсийн албан хаагчид нь харилцан бие биеэ шалгаж байгаа нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үр дүнтэй шалган шийдвэрлэх, эрүү шүүлтийн далд, нуугдмал хэлбэрүүдийг илрүүлж, хариуцлага тооцох боломжийг бүрдүүлж чадахгүй байгаа асуудлыг хууль эрх зүйн хүрээнд цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.



**N P M**  
**MONGOLIA**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠨᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠡᠷᠬᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠨᠳᠦᠰᠨᠢ ᠬᠣᠮᠢᠰᠰ ᠶ᠋ᠢᠨ  
ᠡᠷᠦᠭᠦ ᠰᠦᠭᠦᠯᠲᠡᠭᠦᠰ ᠤᠷᠦᠳᠴᠢᠯᠠᠨ ᠰᠡᠷᠭᠢᠶᠢᠯᠡᠬᠦ ᠠᠰᠤᠭᠤᠳᠠᠯ  
ᠡᠷᠬᠡᠯᠤᠰᠡᠨ ᠭᠢᠰᠢᠭᠦᠨᠢ ᠶ᠋ᠢᠨ 2022-2024 ᠣᠨᠳᠤ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠣᠬᠤ  
ᠪᠠᠶᠢᠭᠦᠭᠦᠯᠯᠠᠭ᠎ᠠ, ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠠᠠᠯᠲᠠᠨᠳᠤ ᠬᠦᠷᠭᠦᠭᠦᠯᠰᠡᠨ  
ᠵᠥᠪᠯᠥᠮᠵᠢᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠤ, ᠤᠷ ᠳᠦᠨ, ᠠᠬᠢᠴᠤ ᠳᠡᠪᠰᠢᠯᠲᠤ”ᠲ

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ  
ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ 2022-2024 ОНД ХОЛБОГДОХ  
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛСЭН  
ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ”Т



# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ 2022-2024 ОНД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, АХИЦ ДЭВШИЛ”

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаа нь ийнхүү байгуулагдсан цагаас хойш Монгол Улсын нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүргүүлэн ажилладаг.

Тус бүрэн эрхийн хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний нийт 497 заалт бүхий 50 зөвлөмжийг албажуулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнээс тайлант хугацаанд 141 заалт бүхий 14 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

## Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2022-2024 онд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үеэр тогтоогдсон эрүү шүүлт гарч болзошгүй аливаа нөхцөл байдлыг бодлогын хүрээнд шийдвэрлэх, хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулах холбогдох төрийн байгууллагын шийдвэрийг гаргуулах хүрээнд Засгийн газар, Яам, түүний харьяа байгууллагад нийт 9 удаагийн зөвлөмж хүргүүлсэн байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг эрхийн хэрэгжилт хамгийн ихээр зөрчигддөг газар буюу ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад хамгийн их буюу 24 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн хяналт шинжилгээний танилцуулгад зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж ажиллах талаар зөвлөсөн.

Энэ хүрээнд Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний “Аргачлал батлах тухай” 197 2024 оны А/03 дугаар тушаалыг баталсан.

Тус аргачлалаар зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүн шинжилгээ хийж ажилласан ба шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилтийн үнэлгээтэй танилцуулж “Үнэлгээг хүлээн зөвшөөрсөн” тэмдэглэлд гарын үсэг зуруулан авч архив үүсгэж хэвшсэн.

197 “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаал.



Зөвлөмжийг хүлээн авсан байгууллагаар нь ангилж үзэхэд:

Хүснэгт 42

№	Зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага	2022	2023	2024	Нийт
1	Засгийн газар, яам агентлаг түүний харьяа байгууллага	4	2	3	9
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3	15	7	25
3	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1	-	1 (1 хууль ёсны шаардлага 198 өгсөн)	3
4	Ахмад настны үндэсний төв	1	-	-	1
5	Хүүхдийн асрамжийн төв			1	1
6	Цагдаагийн байгууллага	1	2	3	6
7	Прокурорын байгууллагад	-	1	-	1

Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

Хүснэгт 43

№	Зөвлөмжийн хэрэгжилт	2022	2023	2024	Нийт
1	Бүрэн хэрэгжсэн	2	14	5	21
2	Хэрэгжих шатанд	5	4	9	18
3	Хэрэгжилт хангалтгүй	3	2	1	6
4	Хэрэгжээгүй	-	-	-	-

Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний жил бүрийн хэрэгжилтийн хувь өссөн дүнтэй харьцуулагдаж байна.


Хүснэгт 44

№		2022	2023	2024	2025 I улирал	Нийт
1	Зөвлөмжийн хэрэгжилт хувь	72.0%	86.0%	80.0%	-	80.0%
2		10 зөвлөмж	20 зөвлөмж	15 зөвлөмж	5 зөвлөмж	50 зөвлөмж
3		70 заалт	224 заалт	154 заалт	49 заалт	497 заалт

198 ХЭҮК-ын тухай хуулийн 40.3-т Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.







(Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ)

Энэ нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар 199 зүйлээр баталгаажуулсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байгааг илтгэж байна.

Хүснэгт 45

№	Зөвлөмжийн заалтын агуулга	2022	2023	2024	Нийт
1	Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах эрхийн хүрээнд	7	28	21	56
2	Хэрцгий хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хүрээнд	7	69	24	100
3	Албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хүрээнд	11	16	10	37
4	Албан хаагчдын эрүү шүүлтээс ангид байх эрхийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд	1	37	17	55
5	Хорих ял эдлүүлэх, нийгэмшүүлэх ажлыг хүртээмжтэй зохион байгуулах болон орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд	3	22	28	53
6	Алба хаагч, эмч, эмнэлгийн ажилтан, хоригдол, асруулагчдын эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хүрээнд	2	11	9	22
7	Алба хаагч, эмч, эмнэлгийн ажилтан, хоригдол, асруулагчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах эрхийн хүрээнд	5	9	6	20

199 ХЭҮК-ын тухай хуулийн 35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж.

8	СЭМҮТ болон халамжийн байгууллагуудад байрлан асрамж халамжийн үйлчилгээнд хамрагчдын эрхийн хүрээнд	5	-	6	11
9	Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх болон бусад зохион байгуулалтын арга хэмжээтэй холбоотой асуудлаар	6	23	10	39
10	Засгийн газар, яам агентлаг, холбогдох төрийн байгууллагад тодорхой эрхүүдийн хүрээнд хүргүүлсэн зөвлөмж	20	8	20	48
11	Гэмт хэрэг зөрчлийн гомдол мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар	3	1	5	9

### ТАЙЛАНТ ХУГАЦААНД

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зүгээс тайлант хугацаанд буюу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дараах зөвлөмжүүдийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллажээ.

Хүснэгт 46

№	Зөвлөмж хүргүүлсэн байгууллага	Огноо дугаар	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
1	Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Энхбаярт	2024.05.31 08/07	8	61.0%
2	ЦЕГ-ын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбатад	2024.06.10 08/08	6	83.0%
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга хурандаа Б.Нандинболорт	2024.10.18 08/09	19	78.0%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга хурандаа Б.Нандинболорт	2024.10.18 08/10	13	74.0%
5	Өнөр бүл хүүхдийн төвийн ерөнхий захирал М.Өлзийчимэгт	2024.11.27 08/11	12	91.0%
6	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд Л.Энх-Амгаланд	2024.11.27 08/12	8	73.0%
7	Баянгол дүүргийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Алтанхуягт	2024.12.04 08/13	6	93.0%
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дарга, хурандаа Б.Тамирт	2024.12.20 08/14	8	91.0%
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 437 дугаар нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Р.Ууганбаярт	2024.12.27 08/15	12	80.0%

10	СЭМҮТ-ийн захирал Г.Анхболдод	2025.02.07 08/01	10	79.0%
11	Улсын Их хурлын гишүүн, батлан хамгаалахын сайд С.Бямбацогтод	2025.02.07 08/02	7	40.0%
12	Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах зөвсөгт хүчний 032дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайханд	2025.02.13 08/03	7	70.0%
13	Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд	2025.03.10 08/04	11	Хариу ирүүлэх хугацаа болоогүй байна
14	Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболдод	2025.03.21 08/05	14	Хариу ирүүлэх хугацаа болоогүй байна
<b>Нийт</b>			141	76.0%

Хүснэгт 47

<b>Амаар өгсөн зөвлөмж<sup>200</sup></b>				
1	Эрүүл мэндийн яамны харьяа СЭМҮТ-ийн захирал В.Баярмаа	2024.05.08	5	100%

ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс 2022 оноос 2025 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар 493 заалт бүхий 50 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллажээ.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн 2022-2024 оны хэрэгжилтийг нэгдсэн байдлаар дүгнэж үзэхэд 80.0 хувь хэрэгжсэн гэж үнэлэв.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмын үндсэн зорилго ач холбогдол нь эрүүдэн шүүсэн хэргийг баримтжуулах, тухайн байгууллагыг буруутгахад чиглэдэггүй ба Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хуулиар<sup>201</sup> хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх нэг чухал хэсэг нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж юм.

Аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газрын үйл ажиллагааг задлан

<sup>200</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

<sup>201</sup> ХЭҮК-ын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг

шинжлэх, эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судалж эрүү шүүлт, зүй бус харьцаа үүсэх эрсдэлийг багасгах, урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтгүй орчныг бий болгох, сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

Зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд Хэрцгий хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах эрхийн зөрчлийг арилгах, таслан зогсоох, цаашид ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Гэсэн хэдий ч хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, халдашгүй байх эрх, зорилтот бүлгийн эрх зөрчсөн асуудлаарх хяналт шинжилгээгээр илэрсэн нөхцөл байдал давтагдан гарсаар байгаад холбогдох төрийн байгууллагын удирдлага, нийт ажил олгогч, ажилтнуудад сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, дотоод хяналт шалгалтыг давтамжтай хийж байх зайлшгүй шаардлага үүсэж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35.4-т Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана гэж заасан байдаг.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй албан хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авч ажиллах талаар санал хүргүүлж ажилласан. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг он тус бүрээр нь тайлагнан ажилласан.

Мөн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын мөрөөр тодорхой ахиц дэвшил гарч, асуудлыг шийдвэрлэж, зарим үр дүнд хүрч зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд таслан зогсоогдсон, арилсан, шийдвэрлэгдсэн, хууль дүрэм журамд өөрчлөлт орсон асуудлуудын танилцуулгыг бүлэг тус бүрд тайланд нарийн тусгаж оруулсан болно.

Зөвлөмжид тусгасан аливаа хөрөнгө, санхүүтэй холбоотойгоор шийдвэрлэх асуудлууд тухайлбал шинээр барилга барих, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, урсгал засвар хийх, ажилчдын цалин хөлс урамшуулал олгох, хөдөлмөрлөх орчин, нөхцөлийг сайжруулах зэрэг асуудлыг төлөвлөгөөндөө оруулах, хуралдаанаар, хэлэлцэх, төсвийн төсөлд санал өгөх, эрх бүхий байгууллагад уламжлах байдлаар үе шаттайгаар шийдвэрлүүлэх боломжтойг анхаарч үнэлэхдээ үр дүнг хэрэгжих шатандаа байгаа нөхцөл байдлыг харгалзан үнэлэв.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай төсөв, хөрөнгийг тухайн байгууллага жил бүрийн төсөвтөө тусган батлуулах, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүний эрхэд суурилсан төсвийг дэмжих хууль эрх зүйн зохицуулалтыг анхаарах нь зүйтэй байна.



**N P M**  
**MONGOLIA**

ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠯᠠᠭᠤᠨ

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**





## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024 оны тайланг тухайн жилд хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд боловсруулсан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас хойших хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг харьцуулан, цаашид анхаарах асуудлыг дүгнэн боловсруулж, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөө бодитой хангагдахад чиглэгдсэн саналуудыг тодорхойллоо.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь 2022 онд 4, 2023 онд 5, 2024 онд 6 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд 10,172 километр замыг туулж, 57 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш (2022-2024 он, 2025 оны нэгдүгээр улирал) 38,596 километр замыг туулж, нийт 128 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад 10, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад 5, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх албаны төв, орон нутгийн байгууллагуудад 16, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа салбар, нэгжүүдэд 22, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 3, Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Сахилгын байранд 1 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад 10, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад 11, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх албаны төв, орон нутгийн байгууллагуудад 57, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа салбар, нэгжүүдэд 43, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 5, Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Сахилгын байранд 2 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажиллажээ.

Тайлант хугацаанд эрх чөлөөгөө хязгаарлуулсан 415 иргэн, 311 төрийн албан хаагчтай, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 1,334 иргэн, 215 төрийн албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 1,623 иргэн, 311 төрийн албан хаагчаас, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд 1,549 иргэн, 1,465 төрийн албан хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар асуумж авч, нэгтгэн дүгнэсэн бөгөөд тодорхой асуудлуудыг шийдвэрлэх талаарх гишүүний зөвлөмжийн үндэслэлүүдийн нэг гол эх сурвалж болгож ирсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн урьдчилан сэргийлэх зарим хяналт шинжилгээг явуулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсик, Мартин Зинклер, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Армен Авестисиан, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд нартай хамтран ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг авсан.

Хамтын ажиллагааны хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдын хорих анги, цагдан хорих байр, сэтгэцийн эрүүл мэндийн төв болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний бүхий л үйл явц, тухайлбал тухайн байгууламжид нэвтрэн орохоос эхлэн удирдлагын багтай хийсэн уулзалт ярилцлага, эрх чөлөөгөө хасуулсан иргэдтэй хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, асуумж судалгаа авах үйл явц, орчин, ахуй нөхцөлийн ажиглалт, хэмжилт хийж буй байдал зэргийг шууд ажиглаж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь зөвлөн тусалж ажилласан нь **үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааг манай улсад бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болж байна.**

Урьдчилан сэргийлэх хамтарсан хяналт шинжилгээний төгсгөлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагын Хяналт шинжилгээний ахлах зөвлөх Бен Бакланд нар Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчидтай уулзалт хийж урьдчилсан ажиглалт, дүгнэлтээ танилцуулсан нь **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид хяналт шинжилгээ хийх арга барилдаа хөндлөнгийн ажиглагчдын дүгнэлтийг тусгах, шаардлагатай үр чадваруудыг нэмэгдүүлж, илүү чадавхжихад чухал нөлөө үзүүлсэн.**

Уулзалтаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц,

түүний Нэмэлт протоколд нэгдэн орсноор хүлээсэн үүргийнхээ дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулж, амжилттай ажиллуулж байгаад сэтгэгдэл өндөр байгаагаа илэрхийлж, “Байгуулагдаад удаагүй ч үндэсний ажиллагааны албан хаагчдын ур чадвар олон улсын хүний эрхийн стандартад нийцэж чадавхажсан байгааг хамтран ажилласан эдгээр өдрүүдэд олж харлаа” хэмээн айлчлалын тэргүүн, Дэд хорооны гишүүн Элина Штайнерт онцлон, цаашдын үйл ажиллагаанд улам их амжилт хүслээ.

Улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТЭД: “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) байгуулагдаад удаагүй ч, стратеги төлөвлөгөөгөө батлан, богино хугацаанд чадавхижж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Ази-Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ахиц гаргасан” гэж онцлон дүгнэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай тайланд тэмдэглэсэн байна.<sup>202</sup>

Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллага нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй үе шатлал бүхий арга хэмжээнийхээ талаар албан ёсны цахим хуудастаа нийтлэхдээ “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь хэдий байгуулагдаад удаагүй ч аль хэдийнээ бүс нутгийнхаа Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага, Хүний эрхийн үндэсний байгууллагуудын дунд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх “үлгэр жишээ болжээ” хэмээн үнэлсэн.<sup>203</sup>

Харилцан туршлага судлах, чадавх бэхжүүлэх зорилгоор Словени, Польш, Хорват зэрэг улсуудын Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлж, эхлэл болгож Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төлөөлөл Бүгд Найрамдах Словени Улсын Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тэргүүн туршлагыг судлах зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд тус улсад ажилласан.

Тус улсын Хүний эрхийн Омбудсмены орлогч дарга, Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын тэргүүн Иван Селих болон албан хаагчид 2025 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсад хариу айлчлалаар хүрэлцэн ирж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны ажлын арга барил, туршлагатай танилцах бөгөөд энэхүү айлчлал нь Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй ахиц дэвшил, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний арга зүй, баримталж буй бодлогын талаар Нэмэлт протоколын Оролцогч улсуудын Европын бүс нутгийн Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагууд туршлага судлах эхний алхам болж байна.

202 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх. [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en).

203 <https://www.apt.ch/news/mongolia-new-monitoring-body-focuses-risky-practices-and-women-detention>

Түүнчлэн Бүгд Найрамдах Польш Улсын Хүний эрхийн Комиссар, Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын тэргүүн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хандан өөрийн улсдаа хүрэлцэн ирж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар харилцан туршлага, мэдлэг мэдээлэл солилцохыг санал болгож, албан ёсны урилгыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ирүүлсэн боловч манай механизмын санхүүгийн боломжгүйгээс 2025 оны 06 дугаар сарыг хүртэл 2 жил хойшуулаад байгаа нь харамсалтай. Хэдийгээр ХЭҮКтХ-д "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна." гэж заасан боловч бодит байдал дээр хэрэгжихгүй байгааг НҮБ-ын ЭШЭДХ-ны гишүүдийн тайлан, зөвлөмжид тусгажээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "...Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана." гэх заалтыг удирдлага болгон хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах зорилгоор урьдчилан сэргийлэх зарим хяналт шинжилгээг Прокурорын байгууллагатай хамтран явуулсан нь анх удаа хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хамтарсан шинэ ажил боллоо.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний нийт 50 зөвлөмж, тайлант хугацаанд 14 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, зөвлөмж тус бүрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшлийг тооцон ажилласан бөгөөд 2022-2025 онд хүргүүлсэн нийт зөвлөмжийн биелэлтийн ерөнхий хувь 80.0 хувьтай үнэлэгдсэн нь төрийн ба төрийн бус байгууллага, албан тушаалтнууд эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангахад идэвх, чармайлт гаргаж байгааг илтгэж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлснээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн урьд өмнө нь илэрч байгаагүй зөрчил, дутагдлууд, нөхцөл байдлыг илрүүлж, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэн, дахин гарахаас урьдчилан сэргийлж, зөвлөн тусалж, хамтран ажиллаж ирлээ.

**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудал:**

Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр:

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд хүүхдийн асрамж, халамжийн нийт 9 байгууллагад 10 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "...Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана." заалтыг удирдлага болгон хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах зорилгоор зарим хяналт шинжилгээг Прокурорын байгууллагатай хамтран явуулсан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, баримт бичигтэй танилцах, шаардлагатай бол хуулбарлан авах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, залуучууд, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагч нараас асуумж авах, уулзалт, ярилцлага хийх болон Олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглоогүй бусад арга, аргачлалаар явуулж нийт 89 хүүхэд, залуус болон 63 төрийн албан хаагчдаас асуумж авч, 57 хүүхэд, залуус, 33 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийж, 4 хүүхэдтэй "Дуусаагүй өгүүлбэрийн арга" сэтгэл зүйн тестээр ажилласан нь гишүүний зөвлөмжийг хүргүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх үндэслэл болоод байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлууд, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, цаашид эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/11 дугаар зөвлөмжийг Өнөр бүл хүүхдийн төвийн захирал М.Өлзийчимэгт, 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 08/12 дугаар зөвлөмжийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд тус тус хүргүүлсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний "Аргачлал батлах тухай" 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 82.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдийн хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх хангагдах дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

- Оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3-18 насны 100 хүүхэд, 18-34 насны 200 залуусыг хүлээн авах хүчин чадалтай 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй асрамж, халамжийн газрын барилгыг Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт барьж





байгуулахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны багцын хөрөнгө оруулалтын төсөвт тусган баталсан. Барилгын ажлыг 2025 онд эхлүүлэх бөгөөд энэ хүрээнд шаардлагатай 5,980.6 тэрбум төгрөгийг төсөвт суулгасан.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл боломжийг сайжруулахад оюуны болон сэтгэцийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төрөлжсөн асрамж, халамжийн газрын барилгыг яаралтай барьж байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатай.

- Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцан, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах ажлыг Прокурорын байгууллагатай хамтран хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжтэй таван зөрчлийг илрүүлэн, харьяаллын дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газар болон Баянзүрх дүүргийн Цагдаагийн газарт тус тус шилжүүлсэн.
- “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017” стандартыг шинэчлэн батлахаар төслийг боловсруулсан бөгөөд төсөлд “Хөгжлийн бэрхшээлтэй гурван хүүхэд тутамд нэг багш/нийгмийн ажилтан байна.” заалт болон холбогдох бусад заалтыг тусгасан. Өнөр бүл хүүхдийн төвийн төсөв 2024 онд 5,198.5 төгрөг байсныг 2025 онд 5,549.5 төгрөг болгож нэмэгдүүлсэн.
- Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт Финлянд Улсын “Eduten”, Англи Улсын “Person” платформыг тус тус ашиглан сургалт явуулж байгаатай холбоотойгоор хүүхдүүдийг ухаалаг утсаар хангах хэрэгцээ, шаардлага тулгардаг бөгөөд асрамж, халамжийн байгууллагад амьдардаг хүүхдүүд ухаалаг утасгүйгээс дээр дурдсан хөтөлбөрүүдэд зарим үед хамрагдах боломжгүй болох, гэрийн даалгавраа хийж чадахгүй байх зэрэг асуудал тулгамдаж, хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх, цаашлаад үе тэнгийнхний дунд ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хуваарь батлах тухай” 2024 оны А/134 дүгээр тушаалаар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт албан хэрэгцээнд зориулан хуваарилсан таблетаас хэмнэлт үүсгэж, Өнөр бүл хүүхдийн төвд амьдардаг Eduten цахим хичээл хийх суралцагчид болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежид суралцаж байгаа оюутнуудад Doogee брэндийн T20 ultra загварын 30 ширхэг таблет, 31 ширхэг гар утсыг хүлээлгэн өгсөн бөгөөд хүүхдүүд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хичээлийн хэрэгцээнд ашиглаж байна.

Хүүхдийн асрамж, халамжийн бусад байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүд сурч боловсрох эрх дээр дурдсан шалтгааны улмаас зөрчигдөх, үе тэнгийнхний дунд ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлж холбогдох арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Зөвлөмжийн мөрөөр хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын хүний нөөцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа үндэслэл, шалтгааныг тогтоосон бөгөөд цаашид хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын багш, ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа шалтгааныг илүү нарийвчлан судалж, бодлогын түвшинд сайжруулах арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг салбар хариуцсан төрийн захиргааны байгууллагаас анхаарах нь зүйтэй.
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.6-д заасан тэтгэмжид хамрагдах шаардлагатай хүүхдүүдийн баримт, бичгийг бүрдүүлэн харьяа дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна.
- “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газартай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” нөлөөллийн аян, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээ, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Найз байя” аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулсан нь олон нийтэд тодорхой хэмжээнд нөлөөлж, эерэг үзүүлэлтүүдийг бий болгожээ.
- Асрамж, халамжийн байгууллагад хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын эрхийг хангах, хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах ажлыг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, салбарын нийт ажилтан, албан хаагчдын дунд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна.
- Өнөр бүл хүүхдийн төвийн дэргэдэх “Бөхөг”, “Хараацай” зусланг засварлах хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар зөвшөөрөл авах хүсэлт хүргүүлж, Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2024/00-635 тоот Архитектур төлөвлөлтийн даалгаврыг хүлээж авсан. Мөн “Ленд тест” ХХК-тай гэрээ байгуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвийн баталгаажуулсан барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтийг хийж гүйцэтгүүлсэн. “Функцион форм арч” ХХК-тай гэрээ байгуулан хүүхдийн зуслангийн хуучин барилгыг буулгах ажлын зураг төсвийг боловсруулж, зураг төслийн ажлыг хүлээлцэх, экспертээр батлуулах шатанд ажиллаж байна. “Жаргалант хийц” ХХК-тай гэрээ байгуулан барилгын ажлын зураг төсөв, эскиз зураг гүйцэтгүүлэхээр ажиллаж байна. Зуслангийн цахилгаан шугам сүлжээний техникийн нөхцөлийг өөрчлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэхээр баримт бичгийн бүрдлийг боловсруулсан бөгөөд 2025 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн саналд “Хараацай” зусланг шинэчлэх зураг, төсөв боловсруулах саналыг тусган Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж буйг мэдэгдсэн. Дээрх асуудлуудыг нэг мөр



шийдвэрлэснээр хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох зэрэг олон эрхийн хэрэгжилтэд эергээр нөлөөлнө.

- Хөдөлмөрийн дотоод журамд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, сэтгэл зүйн болон бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх, дарамт үзүүлсэн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээг Өнөр бүл хүүхдийн төв нарийвчлан тусгаж батлан, мөрдөж байна.
- Өнөр бүл хүүхдийн төвийн “Бие даан амьдрах төв”-д амьдарч буй хүүхдүүдийн амьдралын бүс дэх аюулгүй байдал, тохижилтыг сайжруулж орон сууцуудын тагтанд хаалт хийлгэсэн нь болзошгүй эрсдэлээс зохих хэмжээнд урьдчилан сэргийлсэн үйл ажиллагаа болсон.



Хүүхдийн эрхийн чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал болон Олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоо, үйлчилгээг шинэчлэн сайжруулах ажлыг эрчимжүүлснээр ахиц дэвшил гарч байгаа ч хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн байгууллагуудын үйлчилгээний чанар, нөхцөл байдал өөр хоорондоо харилцан адилгүй байгаад цаашид анхаарал хандуулж, төрөөс холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал, хүүхдийн асрамж, халамжийн зарим байгууллагад хүүхдийн амьдрах өрөө, гал тогоо, ариун цэврийн өрөө зэрэг бүхий л орчин стандартын шаардлагыг илтэд хангахгүй бохир, эмх цэгцгүй, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдалт харилцан адилгүй, мөн Монгол Улсын Засгийн газрын “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 121 дүгээр тогтоолын хэрэгжилт зарим төвд хангалтгүй, зарим байгууллагын гадна болон дотоод орчин, тоглоомын талбай камерын хяналтгүй байгаа бол зарим байгууллагад хүүхдийн унтлагын өрөөнд камерын хяналттай, хүүхдүүдэд гар утас хэрэглэхийг огт зөвшөөрдөггүй, зарим байгууллага хоолны дээжийг шинжлүүлдэггүй зэргийг дурдаж болно.



Мөн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 Монгол Улсын стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтөд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын барилга, байгууламж, орчинд тавих шаардлагад дулаан, чийгшил, гэрэлтүүлгийн стандартыг тусгаж өгөх шаардлагатай.



Хүүхдийн асрамж, халамжийн зарим байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд христийн шашны талаар мэдээлэл танилцуулга хийдэг, дагалдагч бэлтгэх сургалтад хүчээр хамруулдаг байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон. Түүнчлэн зарим төвд “Pingo” гэх аппликейшнийг ашиглаж хүүхдүүдийн интернэт орчны хэрэглээ, аюулгүй байдлыг хянаж байгаа ч хүүхдүүдийн гар утсанд хадгалж буй зураг, захидал харилцааг шалгаж байгаа нь хүүхдийн хувийн мэдээлэл, нууцтай байх эрхэд халдаж байж болзошгүй байна.



Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдээс гаргасан хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалттай холбоотой хүний эрхийн зөрчлийн гомдол, мэдээллийн бүртгэлийг байгууллага бүр хөтөлдөггүй, хүний эрхийн зөрчлийн гомдол, мэдээллийг тухай бүр зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулдаггүй нь анхаарах асуудал мөн.



Бүтэн өнчин хүүхдүүдийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.3, 12.1.4, 13.1.1, 13.2.1, 13.5.2, 13.5.3, 13.5.6, 13.6-д заасан тэтгэмжүүд, сургалтын төлбөрийн

буцалтгүй тусламжид хамруулахад Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ын 3.1.6, 3.2.3-т заасан бүрдүүлэх материалд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, эцэг, эхийн нас барсны гэрчилгээ, лавлагаа шаардагддаг бөгөөд эдгээр баримт бичгийг бүрдүүлэхэд туйлын хүндрэлтэй байдгаас Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.2-т заасан 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн нэг удаа авах мөнгөн тэтгэмж буюу онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжид хүүхэд, залуус хамрагдаж чадахгүй байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “бүтэн өнчин хүүхэд”-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгон тусгасан, мөн эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яаралтай хэлэлцэх шаардлагатай.



Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэн өгөхөд хүүхдийн эд хөрөнгө өмчлөлийн асуудал орхигддог бөгөөд хүүхэд асрамж, халамжийн байгууллагад амьдарч байх хугацаанд хашаа, байшин, гэр зэрэг гэр бүлийнх нь өмч хөрөнгийг төрөл, садан нь өөрийн хэрэгцээнд ашигладаг. Хүүхдийн эцэг, эх нас барсан тохиолдолд өмчийг мөн л төрөл, садан захиран зарцуулдаг. Харьяа орон нутгийн Засаг дарга болон Хамтарсан баг хүүхдийн өмчлөлийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргадаггүй. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “бүтэн өнчин хүүхэд”-ийн тодорхойлолтод багтаж байгаа хүүхдийг нийгмийн халамжийн тэтгэмжид цаг тухайд нь хамруулахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, мөн эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан шүүхийн шийдвэрт хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах, хүүхэд өмч хөрөнгө өвлөж авах, захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор учирч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх нэг алхам болно.



Эрсдэлт нөхцөлөөс хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад ирж байгаа хүүхдүүдийн хувийн хэрэгт тухайн хүүхдийн боловсролд хамрагдалтын талаар үнэн зөв, бодитой мэдээллийг тэмдэглэдэггүйгээс үүдэн хүүхдийг үргэлжлүүлэн боловсролд хамруулахад бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, хувийн хэрэгт тэмдэглэгдсэн тухайн хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан, сургууль завсардаагүй гэх мэдээлэлд үндэслэн Насан туршийн боловсролын төв хүүхдийг хүлээж авдаггүй бөгөөд ерөнхий боловсролын сургуульд анги дэвшүүлэн суралцуулахаар шийдвэрлэдэг боловч хүүхэд сургалтын хөтөлбөрийг гүйцэхгүйгээс улбаалж үе тэнгийнхнээсээ ичих, сургуульд явах, сурах сонирхолгүй болох зэрэг хүндрэл учирдаг байна. Иймд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын зүгээс тухайн хүүхдийн хичээлийн хоцрогдлыг арилгах чиглэлээр ажиллах шаардлага тулгардаг бөгөөд үүнд ихээхэн хугацаа, хүч хөдөлмөр шаардагдаж байна.



Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэхээр очиход ар гэрийн орчин, нөхцөл эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангахгүй, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлтэй, хүүхдэд ээлгүй байх нь элбэг тохиолдож байна. Сүүлийн үед хүүхдээ гэр бүлдээ эргэн нэгтгэж авах хүсэлтэй хүн цөөрсөн бөгөөд эцэг,



эхчүүдтэй ажиллах, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх төлөвлөгөө, хамтарсан багаас үзүүлэх мэргэжлийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай.

Түүнчлэн насанд хүрч асрамж, халамжийн байгууллагаас гарч буй хүүхэд, залууст нийтлэгээр тулгардаг орон байрны асуудалд анхаарч тэдгээр хүүхдүүдийг орон гэртэй болоход төрөөс тодорхой дэмжлэг үзүүлдэг бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээнд хамрагддаг, их, дээд сургуульд суралцаж байгаа болон мэргэжил олгох сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс төлөх эсэх асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага тулгамджээ.

Хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн үйл ажиллагааны бодлого, тогтолцоо нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (18 дугаар зүйл)-д нийцэж байгаа эсэхэд болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг гэр бүлээс нь тусгаарлан байрлуулж асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээний уламжлалт арга, өнөөгийн тогтолцооны үр дүн, хөгжил дэвшилд дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний онцлох үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудал:**

*Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр:*

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад тайлант хугацаанд 5 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн бөгөөд нийт 22 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнээс асуумж авч ганцаарчилсан ярилцлага хийн, 14 эмч, ажилтнаас асуумж авч, 15 эмч, ажилтантай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын “Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээ”-гээр зөвлөмж болгосны дагуу урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон тэдний амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцахын зэрэгцээ өмнө нь хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өмнө хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшилтэй танилцсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхарт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/04, Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/03, Төв аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Ч.Алтанхуягт 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/01, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/05, Монгол Улсын

Их хурал, Засгийн газрын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн 08/06, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн 08/17 дугаартай зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлэхэд 93.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд асрамжийн газрын үйлчилгээнд хамрагдаж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх хангагдах дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

✚ 1. Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулж ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөгжих, эрүүл, идэвхтэй амьдрах, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх боломжтой байх, үл ялгаварлах зарчмыг хуульчлан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зохицуулалтыг тусган баталсан. Үүнд:

- ✚ • Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ гэж ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн ахмад настныг төрөлжсөн асрамжийн, гэрээр, асралт гэр бүлээр, өдрөөр, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг төрийн байгууллага иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан, эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ”;
- ✚ • Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.10-т “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан болон сум, тосгон, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх”;
- ✚ • Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.13-т “ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах”.

2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхэд дагаж мөрдөгддөг нийт таван журмыг шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж байна. Үүнд:

- ✚ • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”;
- ✚ • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”;
- ✚ • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаал;



- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны үнэлгээ хийх журам”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны А/191 дүгээр тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам”.



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас Ахмад настны үндэсний төвд 2022 онд анхлан хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалж эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг авахаар Төв аймгийн Батсүмбэр сум хүртэл ус, намаг бүхий бартаат 8 орчим километр замыг нэг цаг гаруй хугацаанд туулах үед хүний амь нас эндэж болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг тогтоосон бөгөөд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангах хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг холбогдох салбарын сайд нарт хүргүүлснээр Төв аймгийн Батсүмбэр сумаас Ахмад настны үндэсний төв хүртэлх 7,7 километр замыг хатуу хучилттай болгох ажлыг улсын төсвийн нийт 13,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2026 онд багтаан гүйцэтгэхээр шийдвэрлэгдсэн бөгөөд засмал зам тавих нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Будаан толгой” хэмээх газарт зохион байгуулагдсан. 2025 оны төсөвт 4,6 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд замын шороон далан барих ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер шалгаруулалт зохион байгуулах, үнэлгээний хороо байгуулах зэрэг үйл ажиллагаанд их хугацаа зарцуулдагас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгсэл, эмийн зардлын норм, норматив батлах тухай” 2023 оны А/130 дугаар тушаалаар баталсан холбогдох зардлыг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газруудад жилийн эхэн үеэр олгох боломжгүй байна. Энэхүү нөхцөл байдал нь асрамжийн үйлчилгээ үзүүлдэг зарим байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдахад хүндрэл бэрхшээл үүсгэдэг тул холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.



**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудал:**

*Цагдаагийн байгууллагад эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр:*

ЭШУС үндэсний ажиллагаа тайлант хугацаанд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр болон Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр, Өвөрхангай аймгийн сум дундын Цагдаагийн хэлтэс, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын

сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр гэсэн нийт 16 байршилд ажиллаж, хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, албадан эрүүлжүүлэгдсэн, түр саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан 609 иргэн болон 131 цагдаагийн алба хаагчаас асуумжийн аргаар эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар судалгаа авч, 43 иргэн, цагдаагийн 27 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийв.

ЦЕГ-ын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын албаны харьяанд төв, орон нутгийн нийт 35 Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байр хамаардаг боловч Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа зогсоосон байдалтай байна. ЭШУС үндэсний ажиллагаа нь 2022-2025 оны 03 дугаар сарыг хүртэл үйл ажиллагаагаа зогсоосноос бусад 34 байршлын 31-д хуулийн дагуу иргэний эрх чөлөөг хязгаарлан, албадан эрүүлжүүлэх, саатуулах, түүнчлэн Зөрчлийн тухай, ЭХХШТХ-ийн дагуу оногдуулсан баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээг эдлүүлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх хэрхэн хангагдан хэрэгжиж буй байдал, эдгээр эрх зөрчигдөж байж болзошгүй шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Хуулийн дагуу иргэний эрх чөлөөг хязгаарлах, албадан эрүүлжүүлэх, саатуулах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эдлүүлэх ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийг арилгуулж, сайжруулахаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 08/01 дугаартай Зөвлөмжийг Төв аймаг дахь Цагдаагийн газрын даргад, 2023 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 08/01 дугаартай Зөвлөмжийг ЦЕГ-н даргад, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 08/13 дугаартай Зөвлөмжийг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн даргад, 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай Зөвлөмжийг ЦЕГ-ын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргад, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08/13 дугаартай Зөвлөмжийг Баянгол дүүргийн Цагдаагийн газрын даргад тус тус хүргүүлсэн.

Эдгээр Зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны дотооддоо мөрддөг Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох аргачлал 204-ын дагуу үнэлэхэд 83,0 хувийн гүйцэтгэлтэй тооцогдсон.

Төв аймгийн Цагдаагийн газарт хяналт шинжилгээгээр ажиллахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч шалгахдаа иргэнээс гаргасан гомдол, мэдээллийн тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулаагүй, тэмдэглэлийн үлдэх хувийг иргэнд өгөөгүй, эцсийн шийдвэрлэлтийн талаар иргэнд хариу бичгээр мэдэгдээгүй, өөрийн үйл ажиллагааны тухай илтгэх хуудасны хамт шилжүүлээгүй, мэдээллийн санд шивэлт хийгээгүй, бүртгэлийн нэгдсэн дугаар аваагүй зэрэг холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэл тогтоогдож, улмаар зөрчлийг арилгах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрдөж ажиллах, удирдлагын



204 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 тоот тушаалаар баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлтийг үнэлэх аргачлал”

хяналт, зохион байгуулалтыг бүрэн хангаж ажиллах тухай 4 заалт бүхий 2022 оны 08/01 дугаартай Зөвлөмжийг хүргүүлж, заалт тухай бүрийн биелэлтийг хангуулсан.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд хийсэн хяналт шинжилгээгээр иргэдийг албадан эрүүлжүүлэхдээ хүйтэн, цементэн шалан дээр хөл нүцгэн 24 цагийн турш байлгадаг байдал тогтоогдож байв. Энэ нь олон улсын хүний эрхийн эрх зүйд бие махбодын эсрэг үйлдэж буй эрүү шүүлтийн нэг хэлбэр гэж тооцогддог үйлдэл тул хүний эрхийн зөрчлийг арилгах, цаашид давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх 2023 оны 08/13 дугаартай 5 заалт бүхий Зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулснаар тус цагдаагийн хэлтэст саатуулагдсан иргэдийг байршуулахдаа углааш хэрэглүүлдэг болсон, баривчлах шийтгэл эдлүүлэх өрөөнд нэмэлт цонх бий болгож, MNS 5527:2019 стандартын шаардлагад нийцүүлэн орчин нөхцөлөө сайжруулсан, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаар иргэний мэдэх болон мэдээлэл авах эрхийг хангахад анхаарч, сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг эрүүлжүүлэх, саатуулах байрны сургалтын өрөөнд байршуулж, саатуулагдсан иргэдэд мэдээлэл өгч ажилладаг болсон.



НЦУГ-ын газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Баянзүрх, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар, хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд ажиллаж, тогтоогдсон эрхийн зөрчлийг арилгах, иргэнийг хуулийн дагуу саатуулах нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тусгасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08/08 дугаартай Зөвлөмжийг ЦЕГ-ын дэд дарга бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын даргад хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон.

НЦУГ-ын Эрүүлжүүлэх, саатуулах төв болон Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байрууд нь эмчийн үзлэгийн өрөөгүй байсан нь эрүүлжүүлэгдэж буй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд эрсдэл учруулахуйц нөхцөлийг бүрдүүлсэн байв.

Иргэний эрүүл мэндэд эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үйлчилгээг “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5527:2019” стандартын шаардлагад нийцүүлэх, цагдаагийн алба хаагч хүний эрхийг зөрчих, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 08/08 тоот зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд Эрүүлжүүлэх, саатуулах төв, Сонгинохайрхан дүүргийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь яаралтай тусламж үзүүлэх, эмчийн үзлэгийн өрөөг тус тус бий болгож, эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан иргэний эрүүл мэндийг сахин хамгаалахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, тариа, туслах материалаар хангагдсан, Эрүүлжүүлэх, саатуулах төв, байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхаас, алба хаагчид иргэдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энгэрийн камер ашиглалтыг тогтмолжуулж, энгэрийн камерын бичлэгийн сан үүсгэн ажилладаг болсон.



Нийслэлийн хэмжээний Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байруудад алба хааж буй цагдаа, жижүүр эмч, цагдаа жолооч зэрэг архи,



согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, холбогдох магадлалтай, энэ хэрээр хуулиар үл хязгаарлагдах эрхээ хамгаалуулах, шаардах чадвар нь суларсан иргэдтэй төрийн нэрийн өмнөөс анхлан уулзаж, эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлдэг алба хаагчдад иргэдтэй хуулийн дагуу харьцаж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, холбогдох хууль, тогтоомж, журмыг баримтлан, сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байхад хэлтсүүдийн удирдлагын зүгээс өдөр бүр зааварчилгаа, зөвлөмж өгч хэвшсэн, эрүүлжүүлэх, саатуулах орчин нөхцөлийг стандартад нийцүүлж байгаа зэрэг ахиц дэвшил гарч байна.



Хяналт шинжилгээний хүрээнд ажилласан нийт Цагдаагийн хэлтэс ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдээлэл олгох сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг угтах үйлчилгээний орчин, Эрүүлжүүлэх, саатуулах байранд байршуулж хэвшсэн нь иргэдийн хуулиар үл хязгаарлагдах эрхийнхээ талаар мэдлэг, мэдээлэл авах чухал эх сурвалж болж байгаа нь эдгээр байршлуудад хийсэн хяналт шинжилгээний үеэр албадан саатуулагдсан, эрүүлжүүлэгдэж буй иргэдээс авсан асуумжийн хүний эрхийн зөрчлийн тухайд өгсөн хариултын илэрцээр тогтоогдсон.

ЭШУС үндэсний ажиллагаа 2024 оноос Зөвлөмжийн хэрэгжилт нь “хангалтгүй” гэж үнэлэгдсэн байгууллагын удирдлагуудтай үргэлжилсэн яриа хэлэлцээр өрнүүлж, зөвлөмжийн биелэлтийн талаарх тодруулга, мэдээлэл авах, хангалтгүй, эсхүл ерөөс хэрэгжүүлээгүй зөвлөмжийн заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсох, цаашид хэрэгжүүлэх арга замыг дахин зөвлөх зэрэг тухайн зөрчил арилах нөхцөл бүрдэх хүртэл харилцан холбоотой ажилласнаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийн хэрэгжилтийг нэг мөр хангагдахад ахиц дэвшил гарч байна.

Цагдаагийн байгууллагын тухайд 2024 оны 12 дугаар сарын 04-ний 08/13 дугаартай Зөвлөмжийн хэрэгжилт 45 хувьтай “хангалтгүй” гэж үнэлэгдсэн тул Баянгол дүүргийн Цагдаагийн газрын удирдлагатай уулзаж, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийг цагдаагийн алба хаагч албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад санаатай болон санамсаргүйгээр үйлдэхгүй байх бүхий л боломжит арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгч, хэрэгжилтийг нөхөн гүйцэтгүүлснээр 08/13 дугаартай Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт 93 хувийн гүйцэтгэлтэй хангагдсан.



Зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авсны дүнд Баянгол дүүргийн Цагдаагийн газар нь нэг, хоёрдугаар хэлтсийн алба хаагчдын болон мэдүүлэг авах өрөөнд 26, нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчдын өрөөнд 34 камерыг суурилуулсан, мэдүүлэг авах өрөө тус бүрд байрлах камерын дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бичлэгийг 30-аас дээш хоног хадгалдаг болсон, нийт 7 өрөөнд хөдөлгөөн мэдрэгчтэй, мэдүүлэг авах ажиллагаанд оролцогчийн царайг ойроос харах боломжтой камераар тоногдсон, хяналтын прокурор, хэргийн оролцогчдод цахимаар харилцах боломжийг бүрдүүлсэн зэрэг нь хэрэг бүртгэл, мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Цагдаагийн байгууллагын Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааг “Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага MNS 5527:2019”-д бүрэн нийцүүлэх нь эрүүлжүүлэх үйлчилгээний явцад иргэний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлийг бууруулах, хүний эрхийн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэх тул ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг Цагдаагийн байгууллагын холбогдох удирдлага, албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтийг нэг бүрчлэн тооцон ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах ажиллагааг уг стандартад нийцүүлэн явуулахгүй байгаа байдал нь албадан эрүүлжүүлэгдэж буй иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх зөрчигдөх, цаашлаад амь нас хохирох шалтгаан болж байгаа нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон.



Цагдаагийн байгууллагад эрүүлжүүлэгдэж байсан нийт 21 иргэн сүүлийн таван жилийн хугацаанд Нийслэл болон орон нутаг дахь Эрүүлжүүлэх, саатуулах байранд нас барсан тохиолдол бүртгэгдсэнээс 2022-2024 онд 10 иргэн амь нас хохирсон тохиолдлуудад албан шалгалт явуулахад 5 тохиолдолд Эрүүлжүүлэх байранд баримтлах стандарт зөрчигдсэнөөс үүдэлтэй нь тогтоогдож, холбогдох албан тушаалтнуудад Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийг үндэслэн сахилгын шийтгэл оногдуулсан байна.

ЭШУС үндэсний ажиллагааны ажлын хэсэг Баянхонгор аймгийн Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд хяналт шинжилгээгээр ажиллах үедээ албадан эрүүлжүүлэгдэж байсан иргэн нас барсан тохиолдлыг баримт бичигтэй танилцах явцад олж мэдсэн. Эрүүлжүүлэх, саатуулах байрны удирдлагын зүгээс Ажлын хэсгийнхэнд өгсөн мэдээллээр “иргэний зүрх зогссон” гэсэн урьдчилсан дүгнэлттэй байсан ба энэ нь Эрүүлжүүлэх, саатуулах байрны нэг хүнд оногдох талбайн хэмжээ MNS 5527:2019 стандартад нийцээгүй, үүнээс үүдэлтэй халуун бүгчим, агааргүй орчин нөхцөлд тухайн иргэний эрүүл мэнд, амь насанд эрсдэл учирсан байж болзошгүй байв.



Иргэний амь нас хохирсон уг тохиолдолд албаны шалгалт явуулж, улмаар Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/115 дугаар тушаалаар тус газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга, тасгийн эрүүлжүүлэх саатуулах байр хариуцсан дарга, эмч зэрэг албан тушаалтнуудад сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу “хууль бусаар баривчлах”, 14.1 дүгээр зүйл буюу “ялгаварлан гадуурхах”, 21.12 дугаар зүйл буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэргүүдийн тухай гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаар УЕПГ, ШЕЗ-өөс ЭШУС үндэсний ажиллагаанд ирүүлсэн мэдээгээр 2017 оны сүүлийн хагас жил, 2018-2022 онд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэж, 471 хүн тэдгээрт шалгагдсанаас 359 гомдол, мэдээлэлд буюу 93,2 хувьд нь цагдаагийн алба хаагч холбогдсон бол 2023 онд 87 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 82 нь зөвхөн “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжтэй байсан ба тэдгээрт нийт 16 цагдаагийн алба хаагч холбогдон шалгагдсан.



ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь цагдаагийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа Эрүүгийн хуулийн Тусгай ангид зүйлчилсэн “хууль бусаар

баривчлах”, “ялгаварлан гадуурхах”, “эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ЦЕГ-ын өмнөх болоод одоогийн удирдлага, төв, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн дарга, удирдлагуудад хүргүүлсэн Зөвлөмжүүдэд удаа дараа тусгаж, Цагдаагийн байгууллагад хийх хяналт шинжилгээ, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг арга хэмжээ бүрд үр дүнд суурилсан оновчтой, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удаа дараа зөвлөн сануулсаар ирсэн.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн цагдаагийн алба хаагч энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөсөөр байтал хэрэгжилтийг үр дүнтэй хангаж ажиллаагүйн улмаас чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэнд эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцсан гэх гомдол, мэдээлэлд Булган аймгийн Сайхан сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад С, У нар, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын цагдаагийн алба хаагч О нар 2023 онд, Говь-Алтай аймгийн Бигэр сумын хэсгийн төлөөлөгч Б, Баянхонгор аймгийн Эрүүгийн цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, Баянгол, Сүхбаатар дүүргүүдийн Цагдаагийн хэлтсийн нэр бүхий алба хаагчид 2024 онд холбогдон шалгагдсан, тодорхой тохиолдлуудын гэмт хэргийн чанартай болох нь тогтоогдож, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, мөн хуулийн Тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээсэн нь эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх талаар бүхий төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар өгсөн гишүүний зөвлөмжийг бүрэн биелүүлж чадаагүй гэж дүгнэж, буруутай холбогдох албан тушаалтнуудыг тогтоож, өөгшүүлэн, хаацайлахгүйгээр хариуцлага тооцох шаардлагатай байгааг анхааруулж байна.

Цагдаагийн байгууллагын орон нутгийн газар, хэлтсийн алба хаагчид эдгээр гэмт хэрэгт илүүтэй холбогдсон байгаа нь ЦЕГ-ын орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаа дахь хяналт, хариуцлагын тогтолцоо сул байгааг шууд харуулна.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4-т заасан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана” гэх бүрэн эрхийн хүрээнд “эрүү шүүлт тулгах”, “хууль бусаар баривчлах”, “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт цагдаагийн алба хаагч холбогдохоос урьдчилан сэргийлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйн улмаас алба хаагч эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдон, эрүүгийн хариуцлага хүлээсэн Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын холбогдох удирдлагад хариуцлага тооцох, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх саналыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 08/485 тоот “Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” албан бичгээр ЦЕГ-ын даргад хүргүүлсэн.

ЭШУС үндэсний ажиллагаа нь 2022 оны 08 дугаар сараас 2025 оны 03 дугаар сарыг хүртэлх хугацаанд Цагдаагийн байгууллагын төв, орон нутгийн



Эрүүлжүүлэх, саатуулах байр, баривчлах байруудад хийсэн хяналт шинжилгээний хүрээнд хуулийн дагуу эрх чөлөөгөө хасуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, албадан эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан, шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан 1,180 иргэн болон 451 цагдаагийн алба хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар асуумж авсан.

Энэ хугацаанд авсан асуумж нь тухайн байршлуудад ЭШУС үндэсний ажиллагааны хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөл, цагдаагийн алба хаагчдын үйлдэж буй эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийг тодорхойлох мэдээллийн бааз суурь болсон.

Асуумжийн илэрцэд дүн шинжилгээ хийснээр Цагдаагийн байгууллагын нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтэд ялангуяа ахлагч бүрэлдэхүүний иргэнтэй харьцах үйл ажиллагаанд тодорхой зорилгогүйгээр, ажлын хэвшмэл арга барил хэлбэрээр хайхрамжгүй үйлдэгддэг, бие махбодод шарх сорви үлдээдэггүй ч удаан үргэлжилдэг, хэзээ ч бүрэн эдгэдэггүй сэтгэцийн гэмтэл учруулдаг, хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор доромжилсон, хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоох шинжтэй хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж, ялгаварлан гадуурхах зөрчил тогтоогдсон.



Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хэрэгжилтэд хэрэг хүлээлгэх зорилгоор бие махбод, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох шинжтэй “эрүү шүүлт тулгах” үйлдэлд тооцогдох зөрчил хэвшин, уламжлагдан үйлдэгдэж байгааг тогтоосон.



Төрийн албан хаагч нь аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүстэй харьцах үйл ажиллагаа явуулахдаа хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдэл гаргасан бол уг үйлдлийг “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн нэгэн адил үзэх, мөн түүнээс урьдчилан сэргийлэх тухай Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 16 дугаар зүйлд заасан.

Асуумжид оролцсон 451 алба хаагчдын 70 хувь буюу 317 нь гэмт хэрэг, зөрчилд шалгагдаж буй хүнтэй хэрхэн харьцах, ярилцах талаар сургалтад хамрагддаг гэж хариулсан. Тэдгээрийн 299 нь эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн талаар сургалтад хамрагдсан гэсэн байв. Асуумжид хамрагдсан цагдаагийн алба хаагчдын 66 хувь нь иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон гэх боловч урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн хэв шинжийн төлөв байдал нь цагдаагийн байгууллагын сургалт, тэр дундаа ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтын агуулга, сургалтаас олж авсан мэдлэг, мэдээллийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллаж буй эсэхэд тавьдаг удирдлагын хяналт, хариуцлагын тогтолцоо шууд холбоотойг харуулж байна.



ЦЕГ-ын дарга болон бусад газар, хэлтсийн удирдлагад хүргүүлсэн Зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний тайланд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангаж ажиллах хүрээнд олон тооны сургалт, нөлөөллийн ажлыг алба хаагчдад явуулсан гэх мэдээлэл



тогтмол агуулагддаг боловч 2022-2025 3 дугаар сар хүртэлх хугацаанд асуумжид оролцсон эрх чөлөөгөө хасуулсан 1180 хүний 48,7 хувь буюу 574 нь эрүү шүүлтээс ангид байх эрх нь хэрхэн зөрчигдсэн, цагдаагийн алба хаагчид өөртэй нь хэрхэн хүнлэг бус, хэрцгий хандсан талаар бичсэн байгаа нь Цагдаагийн байгууллагын сургалт, нөлөөллийн ажил оновчтой бус байгаатай холбоотой.



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчил үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл нь нэг талаас алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, боловсролын түвшинтэй салшгүй холбоотой байгаа нь ийнхүү тогтоогдож байх тул хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхэд суурилсан үр дүнтэй ярилцлага хийх “Мендезийн зарчмууд”-ыг нутагшуулах, эрүүлжүүлэх, саатуулах ажиллагааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх, цагдаагийн бүхий л үйл ажиллагаанд НҮБ-ын “Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-ыг мөрдлөг болгон хэвшүүлэхэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг Цагдаагийн байгууллага болон ОУБ-тай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байна.



Тухайлбал, НҮБ-ын “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд” (Мендезийн зарчмууд)-ыг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд нутагшуулах хүрээнд Швейцарын холбооны улсын Женев хотноо төвтэй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ, ЦЕГ-тай хамтран 3 үе шат бүхий сургалт-хэлэлцүүлгийг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба Нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран “Хүний эрхийг хангах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 онд хийж гүйцэтгэж ажлын төлөвлөгөө”-г батлан хамтран ажиллаж байна.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссаруудын газар нь Хүний эрхийн билл, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон бусад хүний эрхийн бичиг баримтууд, Хууль сахиулах байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны хүч хэрэглэх, галт зэвсэг ашиглах үндсэн зарчим, Аливаа хэлбэрээр баривчлагдсан болон хорих ял эдэлж байгаа бүх хүнийг хамгаалах зарчмын багц зэрэг хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд баримтлах олон улсын дүрэм, журмуудыг эх сурвалжаа болгон НҮБ-ын гишүүн улс болгон эрх зүйн тогтолцооноосоо үл хамааран дагаж мөрдөх ёстой “Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт”-ыг 2004 онд баталсан ба түүнд цагдаагийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хүний эрхийн стандартуудыг тогтоосон. Тухайлбал:

Хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд:

- “Хууль сахиулахын албан хаагчид нь олон улсын хүний стандартуудыг мэдэх, хэрэглэх үүрэг хүлээнэ” гэж;

Хууль сахиулах ажиллагаа ба ёс зүйн зарчмын хүрээнд:

- “Хууль сахиулах байгууллагын албан тушаалтан нь хуулиар хүлээсэн үүргээ цаг ямагт чандлан биелүүлж, олон нийтэд үйлчилж, хууль бус үйлдлээс хүн бүрийг хамгаалж, чиг үүргээр хүлээсэн өндөр хариуцлагыг баримтлан ажиллана”; “Хууль сахиулах байгууллага нь хүний нэр төрийг хүндэтгэж, хамгаалж, бүх хүний эрхийг хангаж, хамгаална”; “Цагдаагийн

байгууллагын бүхий л үйл ажиллагаа нь хууль ёсны, зайлшгүй байх ёстой ба ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байх, хүмүүнлэг байх зарчмуудыг хүндэтгэх ёстой” гэж;

#### Хууль сахиулах ажиллагаа ба ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хүрээнд:

“Хуулийн өмнө хүн бүр адил тэгш бөгөөд ялгаварлан гадуурхагдахгүйгээр хуулиар тэгш хамгаалагдах эрхтэй”; “Цагдаагийн байгууллага нь нийгмийг хамгаалах, иргэдэд үйлчлэхдээ үндэс угсаа, хүйс, шашин шүтлэг, хэл, арьсны өнгө, улс төрийн үзэл бодол, хөрөнгө чинээ, гэр бүлийн байдал болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж;

#### Цагдаагийн байгууллагын тайлбар, мэдүүлэг авах ажиллагааны хүрээнд:

- “Хүн бүр өөрийнхөө аюулгүй байдлыг хангуулах эрхтэй”; “Хүн бүр шударга шүүхээр шүүлгэх эрхтэй”; “Шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл хүн бүр гэм буруугүйд тооцогдоно”; “Мэдүүлэг өгч буй иргэний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй”; “Сэжигтэн, гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа бие махбодын болон сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглоно”; “Эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлохыг туйлын хориглоно”; “Хохирогч болон гэрчид хүнлэг, анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй”; “Хэнийг ч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг албадах ёсгүй” гэж;

#### Баривчлах ажиллагааны хүрээнд:

- “Хэнийг ч дур мэдэн баривчлах, цагдан хорихыг хориглоно”; “Баривчлагдсан хэн бүхэнд баривчлагдах болсон шалтгааныг тэр даруйд мэдэгдэнэ”; “Баривчлагдсан, цагдан хоригдсон бүх хүн өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгчтэйгөө уулзаж, харилцах хангалттай боломжоор хангагдана” гэж;

#### Цагдан хорих ажиллагааны хүрээнд:

- “Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг ёсоор хандаж, төрөлхийн нэр төрд нь хүндэтгэлтэй хандана”; “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хүн бүр шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдоно”; “Цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэх, аливаа хэлбэрээр хүчирхийлэх, заналхийлэхийг хориглоно”; “Цагдан хоригдсон этгээдийн эрүүл мэндийг сахин хамгаалахад шаардлагатай зориулалтын байранд байлгаж, зохих хоол хүнс, ус, орон байр, хувцас, эмнэлгийн үйлчилгээ, дасгал хөдөлгөөн хийх боломж, хувийн ариун цэврийн хэрэглэлээр хангана”; “Цагдан хоригдсон этгээдийн шашин шүтлэг, ёс суртахууны итгэл үнэмшлийг хүндэтгэнэ”; “Цагдан хоригдсон хүний нөхцөл байдлыг ашиглан түүнийг хэргээ хүлээхийг албадах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөд хүргэхийг хориглоно”; Сахилга, дэг журмыг сахиулах арга хэмжээ нь гагцхүү хууль, журамд нийцсэн байх бөгөөд аюулгүй байлгахад шаардлагатай хэм хэмжээнээс хэтрэх ёсгүй, хүнлэг бус байж болохгүй” гэж тус тус заасан.

Монгол Улсын Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг



хэрэгжүүлэхдээ хүний эрхэд суурилсан, олон улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд баримтлах стандартад нийцсэн бодлогыг баримтлах, үүний тулд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хангаж ажиллахад дагаж мөрдөх олон улсын конвенц, стандарт, журмуудын талаарх мэдлэг, боловсролыг байнга дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг чанаржуулах, үр дүнг баталгаажуулахын тулд хариуцлагын тогтолцоог бий болгох, энэ зорилгын үүднээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь НҮБ-ын "Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах олон улсын хүний эрхийн стандарт"-д нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, хууль эрх зүйн зохицуулалтаар шаардлагатай нийцлийг хангах, Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн бэлтгэл сургалтын төрөлд хүний эрхийн тухай суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг тусгах, Цагдаагийн алба хаагчдын ур чадварын үнэлгээнд хүний эрхийн мэдлэгийн үзүүлэлтийг тусгах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудал:**

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр:*








Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 22, 2022-2024 онуудад 43 салбар, нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийн ажиллав.

Тайлант хугацаанд 150 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 19 алба хаагчтай ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийж, 894 эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэн, 50 алба хаагчаас асуумж авсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхдээ тухайн байршилд буй эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрд хүрч, ганцаарчлан ярилцаж, нууцлал бүхий асуумж авдаг бөгөөд 2022 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд 4,500 хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон иргэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 707 алба хаагчийг хамруулсан.

1. ШШГ ажиллагаанд алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг тогтоож, түүнд үндэслэн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.
2. ШШГ байгууллагуудад хүний эрхийн суурь ойлголт, эрүү шүүлт тулгах, хэрцгий хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа дадал болгон ажиллах, ёс зүйн хэм хэмжээний заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг системийн хэмжээнд зохион байгуулав.



3. ШШГ ажиллагааны явцад гарч буй алба хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн төлөв байдал зэргийг харгалзан судалгаанд суурилсан сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулан төвлөрсөн байдлаар алба хаагчдад сургалт явуулахаар ШШГ байгууллагын нийт харьяа газруудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулав. 
4. ШШГ ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон НҮБ-ын гэрээ, конвенцууд, олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалуудыг нэн тэргүүнд үзэж, чанд мөрдөн ажиллахыг эрхэм зорилго болгон хэвшүүлэв. 
5. Хорих өрөөний гадна хэсэгт хоригдогчийн цээж зураг бүхий хувийн мэдээлэлтэй танилцуулга байсныг өөрчлөн, зөвхөн тухайн хорих өрөөнд байх хоригдогчийн тоог илэрхийлсэн хуудастай болгон өөрчлүүлсэн. 
6. Алба хаагч болон хоригдолд хүний эрхийн талаар мэдээ, мэдээлэл олгох зорилгоор Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх талаарх сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг шалган нэвтрүүлэх байр, хоригдлын байр, хорих өрөөнүүд, түр болон удаан хугацааны эргэлт, уулзалтын байр мэдүүлэг авах хэсгийн орчинд байршуулсан. 
7. Хоригдлыг гэр бүлийнхэнтэйгээ харьцах чин сэтгэлийн харьцааг нэмэгдүүлэх зорилгоор түр уулзалтын хэсгийн хатуулаг чанартай хуванцар хаалтын доод хэсгийг авсан ба цаашид бусад нээлттэй дэглэмийн хорих ангиудад дээрх аргыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах өөрчлөлтийн ажлыг эхлүүлсэн. Цаашид тус арга хэмжээг ШШГ байгууллагын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад бүрэн хэрэгжүүлж дуусгахад анхаарч урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол хамтран ажиллана. 
8. Хоригдлуудын зан төлөв, эрсдэлийн төрөлд тохирсон арга зүйг боловсруулан хорих ангийн сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд ашиглах ажлыг шинээр эхлүүлэв. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилт хорих ангиуд, цагдан хорих байр, төвүүдэд хангагдахгүй байгаагийн нэг илрэл бол эдгээр эрхийн зөрчил нь байгууллагын дотоод журамд тусгагдан дагаж мөрдөгдөх үйл ажиллагаа болтлоо хэлбэржин оршиж байгаатай холбоотой. Тиймээс ШШГ байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмуудад өөрчлөлт оруулах замаар засаж сайжруулах шат дараалсан арга хэмжээ авахад санал өгч ажиллана. 
9. Хоригдол, хоригдогсдыг хорих анги байгууллагын эмч нарын үзлэгээс гадна 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тухайн орон нутгийн нэгдсэн эмнэлгийн эмч нарын үзлэгт бүрэн хамруулсан. Энэ хүрээнд хорих ял эдэлж байгаа хүмүүс, хорих байгууллагын алба хаагчдад зориулсан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний шинэ арга хэрэгсэл, нөлөөллийн арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, хоригдлын хувийн байдал, сэтгэл зүйн онцлогийг судлан хорих газруудад бий болдог сөрөг үзэгдлүүдийг таслан зогсоход чиглэж ажиллах шаардлагатай. 

10. Хорих ангийн хоригдлын байр, хорих өрөөг бүдгэрүүлэгчтэй унтраалган зохицуулалттай гэрэлтүүлгээр сольж, харуул хамгаалалтын хяналтад ашиглаж болох туршилтын ажлыг хорих ангиудад эхлүүлсэн. ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс тус ажлыг ШШГ байгууллагын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад бүрэн хэрэгжүүлж дуусгахад анхаарч ажиллана.



11. ШШГЕГ-ын зардал 2024 оны төсөв болон тодотголтой харьцуулахад 6 дахин өссөн нь системийн хэмжээнд сүүлийн жилүүдэд хорих ангийн нөхцөл байдалд ЭШУС зүгээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг тогтмол хийж, хүний эрх зөрчигдөж байгааг тухай зөвлөж ажилласантай шууд холбоотой.



12. Хөдөлмөр эрхлэх заалт бүхий хоригдлыг ажлын байраар хангах хувь хэмжээг 2025 онд өсгөх зорилгоор хорих ангийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхээр төлөвлөж 527.4 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусган шийдвэрлүүлсэн. Цаашид хорих байгууллагын зүгээс хоригдолд хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах, бололцоо нөхцөлөөр хангахад анхаарч ажиллаж буйд тогтмол хяналт шинжилгээг хийж ажиллана.



13. Хөдөлмөрт хамрагдаагүй хоригдлуудад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар цаг үеийн байдлаар яриа таниулга хийх, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, хөдөлгөөнт дасгал хийлгэх зэргээр хоригдлын цагийг зөв зохистой ашиглах нөлөөллийн ажлыг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний өгсөн зөвлөмжийн хүрээнд тогтмол хэрэгжүүлэн ажилладаг болоод байна.



14. ШШГ 407 дугаар нээлттэй, хаалттай эмэгтэйчүүдийн хорих анги нь улсын хэмжээнд ганцхан байдаг учир бүх аймаг, сумдаас хорих ялтай иргэд ирдэг. Ар гэр амьдралын бололцоо, нутаг орны алслагдмал байдлаас шалтгаалан тэр бүр эргэлт авах бололцоогүй хоригдлууд их учир эмэгтэй хоригдлуудад зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэглэл гэх мэт зүйлд тодорхой хэмжээний мөнгө төсөвлөдөг байх, ШШГ 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид дөнгөж төрсөн, нярай хүүхэдтэй эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нөхцөл, боломжийг судлах хэрэгцээ үүссэн байна.



15. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна гэж тусгагдсан<sup>205</sup>. Тус ажлын хүрээнд хийгдэх хууль, эрх зүйн шинэчлэлтэд Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын үндсэн зарчмыг харгалзан үзэх нь зүйтэй.

205 4.1.1.8. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна.



16. ШШГ байгууллагын алба хаагчдын эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол гарсан тохиолдолд заавал шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял завшуулахгүй байх сургалтын хөтөлбөр, дотоод журам, хяналтын тогтолцоог бий болгох, тодорхой хугацаанд мэргэшлийн шалгалт давтамжтайгаар явуулдаг байх шаардлагатай байна. ✕
17. Хэдийгээр хийсэн гэмт үйлдэл, гэм хорынхоо уршгаар ял эдэлж буй ч тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх арга хэмжээг тогтмол авах, суллагдсаны дараа ажил, хөдөлмөр эрхэлж нийгэмд хурдан дасан зохицох нөхцөл бололцоог бий болгох асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай. ✕
18. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Долоо. "Амар тайван, аюулгүй нийгэм" зорилтын 7.3.2. дахь хэсэгт "Хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ" гэж заасан тул тус заалтын хэрэгжилтийг мөрдлөг болгож хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй байна. ✕
19. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдсон иргэний эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангуулахад мөн ШШГ ажиллагаа нь хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүлтэг, бэлгийн боловсрол болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хэрэгжих ёстойг, бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хандах, нэр төрийг нь доромжилж харьцахыг хорих анги хорих ангийн алба хаагчдад хориглосон байдлыг сахин мөрдүүлэхэд ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс хийж хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтээс үзэхэд бодит ахиц дэвшил гарсан байна. +

**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудал:**

*Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр:*

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд нийт 5 удаа, тайлант хугацаанд 3 удаа ээлжит урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн бөгөөд нэг удаад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн а), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсиқ, Мартин Зинклер, Хүний эрхийн дээд комиссарын газрын Нарийн бичгийн дарга нарын

газрын дарга, Армен Авестиан, Хүний эрхийн дээд комиссарын газрын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ явуулсан. Тайлант хугацаанд явуулсан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, асуумж ярилцлагад оролцох боломжтой гэж үзсэн 19 эмчлүүлэгч, 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийн, 9 эмчлүүлэгч, 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчаас асуумж авсан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн хүргүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн ерөнхий хувь 81.0 гэж үнэлэгдсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:



1. Төвийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/57 дугаар тушаалаар “Хяналтын камерын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам” батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн;



2. Нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулж тус байгууллагад байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг ар гэр нь авч зарцуулж Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хуулийн заалт зөрчигдөн нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулж байж болзошгүй зөрчлийг таслан зогсоох, сэтгэцийн эмгэгтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг өөрсдийнх нь хэрэгцээт зүйлсэд зориулан зарцуулах боломж, нөхцөлийг сайжруулан ажиллаж тодорхой үр дүнд хүрсээр байна;



3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор нийт ажилчдын санал асуулгаар төвийн дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн;



4. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн эргэлтийн өрөөг тус клиникийн орох хэсэгт шинээр зохион байгуулж, вакум хаалт бүхий өрөө бий болгон, уг эргэлтийн өрөөний тав тухыг бүрдүүлж буйдан, ширээ, ар гэр, асран хамгаалагчид мэдээлэл өгөх мэдээллийн самбар зэргийг байршуулсан;



5. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн эмчлүүлэгчийн “Идэвхжүүлэх өрөө”-ний хана, таазанд засвар хийж, эмчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүлсэн;



6. “Асрамжийн гэр төв”-ийн хашаанд хуримтлагдсан барилгын засварын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, дулааны улиралд зүлэгжүүлж, мод тарихаар бэлтгэл ажлыг хангаж байна;

7. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн ажилчдын хувцас солих өрөөнд бүрэн засвар хийж, эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувцас солих өрөөг тус тус бий болгон тохижуулсан;
8. Улсын Их Хурлаас 2013 онд батлан, хэрэгжүүлж буй Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхтэй холбоотой дараах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үүнд:
  - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд байнга байрлан эмчлүүлж буй сэтгэцийн эмгэгтэй иргэд (2025 оны 03 дугаар сарын байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд нийт орны 50 орчим хувийг эзлэн байнга байрлан эмчлүүлж буй 244 иргэн байгаа бөгөөд энэ тоо жил тутамд өсөж байна)-д зориулсан асрамжийн үйлчилгээг бий болгох асуудал;
  - Хүн амд, ялангуяа ерөнхий боловсролын болон их дээд сургууль, коллежид суралцагчдад эрүүл мэндийн мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх асуудал;
  - Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, үндэсний хөтөлбөрүүдийг сурталчлах нийслэлд болон орон нутагт нийгэм хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээ үзүүлэх төсөв санхүүжилтийн асуудал;
  - Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд ачааллыг багасгах, төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах асуудал;
  - Эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлал, албан тушаалын ангилал, зэрэглэлийг ажлын ачаалал, гүйцэтгэл, хариуцлага, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл, онцлогтой уялдуулан тогтоох, хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэх асуудал;
  - Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалттай холбоотой асуудал.



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжид тусгагдсан дараах асуудалд анхаарч холбогдох арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.” гэж заасан боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй асуудал;
2. Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан эмчлүүлэгчдийг хамт эмчилж байгаа, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн этгээдийн сэтгэцийн байдал нь тогтвортой, засрал сайжралын байдалд орсноор



цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн шинжээчийн дүгнэлт, хяналтын прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг арга хэмжээг зогсоосон ч хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, эсхүл эцэг эх, төрөл садан нь асран хамгаалалтдаа авахаас татгалзсаны улмаас албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй асуудал;



3. Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шинжлүүлэгчийг албадан эмчлүүлэгчидтэй хамтад нь байрлуулж буй асуудал;

4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А240/А369 хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих” журмын 4.8-д “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” заалтыг хэрэгжүүлэх асуудал. Өөрөөр хэлбэл **асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа хүлээлгэж өгөх байгууллага байхгүй байгаа асуудал.**



**Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшил:**

*Саатуулагдсан цэргийн алба хаагчдын эрхийг хамгаалах чиглэлээр:*

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Сахилгын тусгаарлан саатуулах байранд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх нэг удаагийн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш хоёр удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж ажилласан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 8 албан тушаалтан, алба хаагчтай ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлага хийж, орчин, ахуй нөхцөлтэй танилцсан.

Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/02 дугаартай зөвлөмжийг Монгол Улсын Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08/03 дугаартай зөвлөмжийг Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Э.Билэгсайхан нарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 “Хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах,” гэж заасан бүрэн эрхийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын хамтарсан тушаалаар батлах “Сахилгын

тусгаарлан саатуулах байрны ажиллах журам"-ын төсөлд тусгах саналыг боловсруулан хүргүүлсэн.206

Зөвлөмжийн биелэлтийг Зэвсэгт хүчний жанжин штабын Нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ж.Өсөхбаярын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 02/703, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 101 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн бөгөөд зөвлөмжүүдийн биелэлтийн ерөнхий хувь 82.0 хувьтай үнэлэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Олон улсын гэрээгээр баталгаажсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дараах үр дүнд хүрч, ахиц дэвшлийг гаргасан гэж дүгнэж байна. Үүнд:

1. Сахилгын тусгаарлан саатуулах байрны эрх зүйн орчин, нөхцөл байдлыг сайжруулах ажлын хүрээнд Монгол Улсын ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/31, А/74 дүгээр хамтарсан тушаалаар "Сахилгын тусгаарлан саатуулах байрны ажиллах журам"-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус журамд саатуулагдсан цэргийн алба хаагчийг хүлээн авч бүртгэх, түүний эрүүл ахуй, ахуй хангалт, байрны нөхцөл, бусадтай уулзах, түр гаргах суллах, саатуулах байрны үйл ажиллагаанд тавих хяналтын талаар тусгасан. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд мөрдөх 13 баримт бичгийг шинэчлэхээр төслийг боловсруулсан;
2. ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, Цэргийн албаны хэлтсийн албан тушаалтнууд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаанд шалган туслах ажлыг тус тус явуулж, холбогдох албан тушаалтнуудад цаашид авч хэрэгжүүлэх, сайжруулах ажлын талаар үүрэг, зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавьж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын төлөвлөгөөнд 18, ангийн төлөвлөгөөнд 21 арга хэмжээг тус тус тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
3. Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад баримт бичгийн санг бүрдүүлсэн;
4. Сахилгын тусгаарлан саатуулах байранд саатуулагдсан алба хаагчдын мэдээллийг бүртгэлжүүлэн, цахим болон цаасан суурьтай мэдээллийн сан үүсгэсэн;
5. Сахилгын тусгаарлан саатуулах байранд мөрдөгдөх хууль тогтоомж, журмын талаар хууль, эрх зүйн хичээлийн 20 цагийн хөтөлбөр боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, цэргийн цагдаагийн ротын хуулийн офицеруудтай хамтран ажиллаж долоо хоногт 12 цагийн сургалтад Сахилгын тусгаарлан саатуулах байрны бие бүрэлдэхүүнийг хамруулж байна. ЗХЖШ-аас Жендэрийн Үндэсний хороо,



206 ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний "Журмын төсөлд санал хүргүүлэх тухай" 2025 оны 08/364 дугаартай албан бичиг.

ХЭҮК-той хамтран ажиллаж Зэвсэгт хүчний жендэр хариуцсан албан тушаалтнуудын арга зүйн цугларалтыг 2025 оны 02 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Жендэрийн бодлогын төлөвлөлт ба тэгш оролцоог хангах нь” сэдэвт сургалтад 80 цэргийн алба хаагчийг хамруулж нэгтгэл, анги, салбартаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулж нэгдсэн ойлголтод хүрсэн;

6. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллийн самбаруудын эхийг бэлтгэн хэвлүүлж, цэргийн цагдаагийн ротын Саатуулах байр, дамжин өнгөрүүлэх буудлын байранд байршуулсан. Хүний эрх, эрх чөлөөг хангах болон Сахилгын тусгаарлан саатуулах байрны үйл ажиллагаатай холбоотой материалуудыг бүрдүүлж, хууль, эрх зүйн мэдээллийн булан байгуулсан;
7. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Сахилгын тусгаарлан саатуулах байрны алба хаагчдын ээлжийн жижүүрийн хуваарийг 24, 72 цагаар зохион байгуулсан;
8. Сахилгын тусгаарлан саатуулах байрны бүх өрөөний шүүгээ, сандал, ор дэрний хоёр ээлжийн цагаан хэрэглэл, гудас, орны бүтээлэг, нүүр, гарын алчуур, улавчийг шинэчилсэн. Чийгшил болон дулаан хэмжигч 3 ширхэг төхөөрөмж байршуулсан бөгөөд үзүүлэлтийг өдөр бүр хэмжин хянаж, бүртгэж байна. Байрны дулаан алдалтыг багасгаж, +18°C-ын хэмээс дээш үзүүлэлттэй байх боломжийг бүрдүүлсэн. Эмэгтэй цэргийн алба хаагчийг саатуулах өрөөний гэрлийг сольж, гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангасан;
9. Зэвсэгт хүчний жанжин штабын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Барилга техникийн хяналтын улсын байцаагч, хошууч Ш.Ундармаагийн 2025 оны 6/147 дугаартай дүгнэлтэд Сахилгын тусгаарлан саатуулах байрыг цаашид Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНБД 13-04-03/-ын дагуу их засвар хийх шаардлагатай гэж дүгнэгдсэн. Энэ хүрээнд Сахилгын тусгаарлан саатуулах байрны засварт шаардагдах 111,356,374 сая төгрөгийн бараа материалын тооцоонд Зэвсэгт хүчний жанжин штабын дарга цохолт хийсэн бөгөөд Материал техникийн газрын даргад хүргүүлэн асуудлыг иж бүрнээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна;

Эмнэлгийн үзлэг, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, эм, ороох боох материалын тооцоог хийж, Зэвсэгт хүчний жанжин штабын Эрүүл мэндийн хэлтэст хүргүүлэн 17 нэр төрлийн 140,000 төгрөгийн эм, тариа, 8 нэр төрлийн 2,100,000 төгрөгийн багаж, 6 нэр төрлийн 45,000 төгрөгийн ороох боох материал, нийт 31 нэр, төрлийн 2,285,000 төгрөгийн өртөг бүхий зүйлсийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус ангийн эрүүл мэндийн төвд хүлээж авсан. Сахилгын тусгаарлан саатуулах байранд “Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний жагсаалт” боловсруулан, ангийн захирагчаар батлуулсан. Ашиглалтын хугацаа дууссан эм, ороох боох материалуудыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалаар баталсан MNS-6655-2017 стандартын дагуу “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу устгалд оруулсан. Эмчийн ажлын байрны чиг, үүрэгтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлсэн.



## **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын үйл ажиллагааны үр дүн, ахиц дэвшил:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, Олон улсын байгууллагууд, бусад улсын Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудтай идэвхтэй харилцаа холбоо тогтоон, хамтран ажиллаж эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд шаардагдах аливаа стандартад нийцүүлэн, арга зүй, мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшихэд чиглэн ажилласан бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны төлөөлөгчид, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагын зөвлөхүүдийн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчдад өгсөн сургалт, мэргэжил арга зүй, чиглэл, Хүний эрхийн үндэсний байгууллагууд болон Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын үр дүнтэй урьдчилан сэргийлэх тэргүүн туршлага, өмнө нь энэ чиглэлийн сургалтад хамрагдагсдын өгсөн санал, зөвлөмж, олон улсын гарын авлага, зөвлөмжийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр, агуулга, зохион байгуулалтад тусган боловсруулж, сургалтуудыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу тусгайлан болон аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл тухайн хүн өөрийн хүсэлтээр орхин гарч явах боломжгүй газруудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний ажлын хүрээнд зохион байгуулсан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 155 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 32,640, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш нийт 223 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 41,081, төрийн албан хаагч нар, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн оюутан, суралцагч, сонсогч нар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангахад анхаарах зарим асуудал” сургалтын хөтөлбөрийг УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор О.Алтангэрэлтэй хамтран баталж, сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулан орон нутаг, нийслэл, дүүрэг, сумдад ажиллаж байгаа нийт прокуроруудыг хамруулсан нь ЭШУС сургалтын онцлох ажлуудын нэг боллоо.

Завхан, Говь-Алтай, Увс, Баянхонгор, Орхон, Төв аймаг болон нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Прокурорын газрууд болон Тээврийн Прокурорын газар, Багахангай, Налайх дүүргийн Шүүхийн Тамгын газартай хамтран “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сургалтыг тус тус зохион байгуулж шүүх эрх мэдлийн, хууль сахиулах, ШШГ байгууллагын алба хаагч нар, төрийн бусад албан хаагч нарыг хамруулсан нь төрийн албан хаагчдын ойлголтыг нэг мөр болгох ач холбогдолтой байв.



Завхан аймгийн Прокурорын газартай хамтран “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан тус арга хэмжээнд ЭШУС үндэсний ажиллагаанаас “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, зөрчил, анхаарах асуудлууд” сэдвээр сургалт явуулсан бол Авлигатай тэмцэх газраас “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, мөрдөн шалгах ажиллагаа”, Хүний эрхийн Үндэсний Комиссын тус аймаг дахь төлөөлөл “Завхан аймаг дахь хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал”, аймгийн Прокурорын газраас “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик”, “Ял эдлүүлэх ажиллагаанд ялтан, хоригдогч этгээдийн эрхийг хангахад анхаарах зарим асуудал” сэдвээр тус тус мэдээлэл танилцуулан хэлэлцүүлсэн.



ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Говь-Алтай аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Цогтбаяр нарын хамтран баталсан хөтөлбөрийн дагуу “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал Говь-Алтай аймагт” хэлэлцүүлгийг Говь-Алтай аймагт зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд ЭШУС үндэсний ажиллагаанаас “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр сургалт явуулсан. Аймгийн Цагдаагийн газраас “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” сэдвээр, Монголын өмгөөлөгчдийн холбооны Салбар зөвлөлөөс “Орон нутаг дахь эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн төлөв байдал” сэдвээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ” сэдвээр, Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, нөхцөл байдал” сэдвээр, Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар”, ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн орон нутаг дахь төлөв байдал” сэдвээр тус тус мэдээлэл танилцуулсан.



Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөрт зориулсан ээлжит хэлэлцүүлгийг “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сэдвийн дор 2024 оны 06 дугаар сард зохион байгуулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг арилгах, нөхөн төлбөрийн асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд өмгөөлөгчдийн оролцоо”, “Шүүхээс хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанаас өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг хасаж тооцон, хорих ялыг бүрэн эдлүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвүүдийн хүрээнд илтгэл танилцуулан, хэлэлцүүлсэн.



“Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”- ийн талаарх УИХ-ын хяналтын сонсгол зохион байгуулахтай

холбогдуулан, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 40 жилийн ойг угтан ЭШУС үндэсний ажиллагаанаас Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын суурь зарчмуудын хэрэгжилт, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлсэн.

“Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт”- ийн талаарх УИХ-ын хяналтын сонсголд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид 2024 оны 07 дугаар сарын 30, 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд тус тус оролцсон.



ЭШУС үндэсний ажиллагаанаас зохион байгуулсан дээр дурдсан хэлэлцүүлгээс гарсан уриалга, санал, дүгнэлтийг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 08/1758 дугаартай албан бичгээр УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд, УИХ-ын гишүүн П.Сайнзориг, УИХ-ын Ж.Баярмаа, НҮБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч Тапан Мишра, ХЗДХЯ-ны ТНБД Н.Мягмар, УЕП-ын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа нарт тус тус хүргүүлсэн.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн 73 сургагч багшийг 2023 онд бэлтгэн гэрчилгээ олгосон бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тус тус зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд нийт 2,632 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 151 сургагч багшийг бэлтгэн гэрчилгээ гардуулснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд нийт 224 сургагч багшийг бэлтгэсэн.



Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтад 2023 онд Прокурорын байгууллагаас 7, Тагнуулын

ерөнхий газраас 1, Авлигатай тэмцэх газраас 1, Боловсролын ерөнхий газраас 1, Цагдаагийн байгууллагаас 19, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 11 алба хаагч, Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 ажилтан, Дотоод хэргийн их сургууль, бусад их, дээд сургуулийн 8 эрдэмтэн багш, судлаач нар болон бусад албан тушаалтан, албан хаагчдыг хамруулан сургагч багшаар бэлтгэн гэрчилгээ олгосон.

“Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдвээр 2024 онд зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын 4, Шүүхийн сахилгын хорооны 1, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 1, Хүний эрхийн Үндэсний Комиссын 1, Хууль зүй, дотоод хэргийн яамны 1, Улсын ерөнхий прокурорын газрын 2, Авлигатай тэмцэх газрын 2 албан тушаалтан, алба хаагч нар, Тагнуулын ерөнхий газрын 1 алба хаагч, Цагдаагийн байгууллагын 38, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 82 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 2 багш, Монголын криминологийн холбооны 3, Монголын өмгөөлөгчдийн холбооны 1 төлөөлөл, бусад албан тушаалтан, алба хаагчдыг тус тус хамруулан сургагч багшаар бэлтгэн гэрчилгээ гардуулсан бөгөөд сургагч багш нарыг мэргэжил, арга зүйн удирдлага, мэдээ, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

Сургагч багш нар эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн чиглэлээр тайлант хугацаанд 117 удаагийн сургалт явуулж 26,728 шүүх, прокурорын байгууллага, хууль сахиулах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нар, зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүн, төрийн бусад албан хаагч нар буюу дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл, оюутан, суралцагчид, иргэдийг хамруулжээ.

Үүнээс Цагдаагийн байгууллагаас бэлтгэгдсэн сургагч багш нар тайлант хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийт 80 удаагийн сургалтыг зохион байгуулж 24,769 төрийн албан хаагч нар, иргэдийг хамруулсан нь бусад сургагч багш нарын ирүүлсэн тайлан мэдээтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн

хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулж, эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцоор баталгаажсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтад суралцагч нь бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх 207 талаар зохицуулсан.

Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 10 дугаар зүйлд “Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, мэдүүлэг авах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана” гэж заасан.

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нэгдэн орсноор “эрүү шүүлт тулгах” үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон, холбогдох хуулиудад зүйлчлэн тусгах үүрэг хүлээсний дагуу 2002, 2015, 2017 онуудад Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг тус тус шинэчлэн найруулж баталсан. Ингэснээр зөвхөн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын төдийгүй төрийн бүх албан хаагч нар иргэнээс аливаа тайлбар мэдүүлэг авахдаа өөрөө эсвэл гуравдагч этгээдийн оролцоотойгоор албадах, хүч хэрэглэх, сэтгэл санааны хохирол учруулах, дарамт шаналгаа үүсгэх үйлдэл гаргаснаар эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект болох боломжтой болсон.

Хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах хүрээнд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлтэй төрийн албан хаагчдын нийт хэдэн албан тушаалын тодорхойлолт байдаг, тэдгээрээс хэдэн төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод “Эрх зүйч” мэргэжилтэй байх шаардлага тавигддаг талаар судалгаа хийж хамтран ажилласан бөгөөд Төрийн албаны зөвлөлөөс өссөн дүнгээр нийт 27,166 албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон ба “Эрх зүй” мэргэжил нь удирдах албан тушаалын 241 албан тушаалын тодорхойлолтод, гүйцэтгэх албан тушаалын 1,050 албан тушаалын тодорхойлолтод тус тус тусгагдсан байна.

Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцоор баталгаажуулсан хэнийг ч аливаа

207 Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт, 2023 он.



хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулж эхэлсэн бөгөөд холбогдох яам, их дээд сургуулийн төлөөллүүдийг багтаасан ажлын хэсэг гарган, хэлэлцэн баталж, боловсролын салбарт нэг мөр мөрдөх шаардлагатай байна.



Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг чадавхжуулах, нийт хүн амын дундах эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн төслийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хугацаанд хэрэгжүүлэх гэж байна.

Уг төслийг хэрэгжүүлснээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид, төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдлэг, хүний эрхэд суурилсан арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд чухал ахиц дэвшил гарна.

### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлын үр дүн, ахиц дэвшил:**



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас хуулиар хүлээсэн чиг үргийн хүрээнд тайлант хугацаанд олон нийтэд, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан болон иргэдэд тогтмол мэдээлэх төлөвлөгөөг баталж, 5 үндсэн ажлыг удиртгал болгон ажиллаж, энэ хүрээнд олон нийтэд мэдээлсэн нийт мэдээллийн тоон үзүүлэлтийг 2023 оны тайлант хугацааны үзүүлэлттэй харьцуулахад 45 хувиар, хандалт 91.7 хувиар тус тус өсжээ.

ЭШУС үндэсний ажиллагааны сурталчилгааны хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт есөн ажлын үзүүлэлт тус тус өссөн дүнтэй байна.



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк дэх цахим хуудас, “NPM-Mongolia” твиттер хуудаст Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаанаас зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний талаарх мэдээлэл 211 удаа, зурагт хуудас хэлбэрээр 55 удаа, урт болон богино хугацаатай видео бичлэг 40 удаа, урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны ярилцлагыг 30 удаа, үйл ажиллагааны талаар reels хэлбэрээр 20 удаа тайлант хугацаанд түгээж, тайлант хугацаанд давхардсан тоогоор 628,000 хүнд шууд хүрч, хандалтын хувь 2023 оны мөн үеэс 67,2 хувиар өсжээ.

Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах хүрээнд Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдрийг тохиолдуулан 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээг хэвлэл мэдээллийн 10 байгууллага, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, “Эрүүдэн шүүхийн эсрэг нийгэмлэг” олон улсын байгууллагатай хамтран “Мөрдөн



шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх Мендезийн зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь” сэдэвт сургалтыг хэвлэл мэдээллийн 11 байгууллага, Ховд аймаг дахь ШШГ газартай хамтран ховд аймгийн төрийн албан хаагчдад “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг орон нутгийн хэвлэл мэдээллийн 3 байгууллага, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, УЕПГ, АТГ, ХЗДХЯ, НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагчийн газартай хамтран зохион байгуулсан “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 21 байгууллага сурвалжилж, МРА агентлаг, Eagle телевиз, Өрөг.мн мэдээллийн сайт, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоо» уулзалт, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн 18 байгууллага сурвалжилж, МРА агентлаг шууд дамжуулжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 136 удаагийн мэдээллийг хүргэж ажиллажээ. Тухайлбал:

- ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Өрөг.мн, Товч.мн, Зөгий.мн, Зариг.мн, News.мн, “Монголын мэдээ”, Тэнгэр телевиз, ТВ9 телевиз, Монгол телевизийн “Тодруулга” ярилцлагад, Тэнгэр телевизийн “De facto” нэвтрүүлэг, Ийгл телевизийн “Зочны цаг”, Ховд телевизийн “Өдрийн зочин”, Монгол телевизийн “Хар хайрцаг” нэвтрүүлэгт
- ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Төв, Хонгор телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт
- УИХ-аас болон ЭШУС үндэсний ажиллагаа зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, хурлын үеэр ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн 63 хэвлэл мэдээллийн байгууллагад давхардсан тоогоор 122 удаа ярилцлага өгч ажиллалаа.

Мөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн “Монголын үнэн” сонины 2024 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн “042” дугаарт “Оюун санаа, хүний эрхийн хувьд нийгэм одоо л солигдож байна”, Өдрийн сонины 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “031” дугаарт “Хүн бүр бие биетэйгээ ахан дүүсийн сэтгэлээр ханд”, ЭШУС хэлтсийн референт Г.Дэлгэрбаяр Өдрийн сонины “032” дугаарт “Хүнийг гэмт хэрэг хүлээлгэх яллах, сэтгэл санааг нь хүчтэй шаналган зовоох зорилгоор цахим орчныг ашиглах нь эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр” гарчигтай ярилцлага өгсөн байна.

Тайлант хугацаанд эрүү шүүлтийн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх нийт 172 цагийн мэдээ, мэдээллийг түгээж ажиллажээ.

ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулж, иргэд болон төрийн албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллах хүрээнд “Монголын Үнэн” сонин, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Монголын сайтын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонины булан “Мэдэх эрх” подкаст, бэлтгэн тогтмол хүргэж ажиллаж байна.

“Эрүү шүүлтгүй Монголын төлөө” булангаар дамжуулан олон нийтэд эрүү шүүлтгүйн хор аюулыг тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд хамтарч ажиллах зэрэг шат дараатай арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллаж байна. Гэрээний хугацаа 2026 оны 02 сарын 28-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

“Мэдэх эрх” 10 удаагийн подкаст 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс 05 дугаар сар 25-ны өдрийг хүртэл үргэлжилж, МҮОНР-гийн эфирээр нэг удаагийн дугаарыг 3-аас доошгүй удаа, MNB.mn сайтаар болон MNB, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны фейсбүүк хуудсаар давхардсан тоогоор 250-300 мянган хүнд хүргэхээр зорилго тавин ажиллаж байна.

ЭШУС үндэсний ажиллагаанаас төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн урилгаар 18 удаа 208, 57 удаагийн хяналт шинжилгээний үеэр 153 удаагийн танхимын болон цахим сургалтаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулжээ. Хяналт шинжилгээний үеэр ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс Цагдаа, ШШГБ, СЭМҮТ-ийн 1200 алба хаагчдаас авсан асуумжаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар таны ойлголт? гэх асуурад 95 хувь “Сайн” гэж, эрүү шүүлтгүйн талаарх мэдээллийн хаанаас авсан бэ? гэх асуурад “ЭШУС үндэсний ажиллагаанаас” гэж хариулсан нь сургалт, нөлөөллийн ажлын үр дүнг гарч байгааг шууд харуулж байна.



Олон нийтэд эрүү шүүлтгүйн хор аюулыг тайлбарлан таниулах хүрээнд цуврал анимейшн, нугалбар хуудас, мэдээллийн самбар, зурагт хуудас, цаглавар зэрэг олон төрлийн сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг бүтээв.

Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийн доромжлон харьцаж шийтгэх тухай ойлголтыг агуулсан хүүхдэд зориулсан анимейшныг бүтээж хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад байгаа хүүхдүүдэд эрүү шүүлтгүйн хор аюулыг ойлгуулах боломжтой болж байна.



Нугалбар хуудас, мэдээллийн самбарын загварыг боловсруулж ШШГ байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байрнуудын эргэлт уулзалтын танхим, хүлээлгийн өрөө, хоригдлын амьдралын бүс, СЭМҮТ-д байршууллаа.



Анимейшн, контент бүтээл зэрэг сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг хүүхдийн асрамж халамжийн байгууллага, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан газруудын хүлээлгийн өрөө, эргэлт уулзалтын танхимын дэлгэцээр, албан хаагчдын цахим хаяг, дотоод сургалт, шугамын радио зэрэг бүхий л боломжит хувилбарыг ашиглан тасралтгүй түгээснээр өөрийн хүслээр гарч явах боломжгүй газарт байгаа иргэд, албан хаагчдын эрүү шүүлтгүйн хор аюул, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт нэмэгдэж байгаа нь тэдгээр иргэд, албан хаагчдаас авдаг асуумж, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хандан ирүүлж буй өргөдөл, гомдлын агуулга, тоо бүртгэлээс харагдаж байна.

Мэдээллийн самбарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг ахмад настны болон хүүхдийн асрамж, халамжийн бүх байгууллагад үе шаттайгаар байршуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг зорьж байна.

Төрийн байгууллагууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах эх сурвалж болгон ашиглах боломжгүй байгааг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн тайлант хугацаанд хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоосон.

Энэ асуудлыг арилгуулахын тулд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнээс Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан"-д Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг бүртгэж авах талаар 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 08/450 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлд хандсан Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайдад 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/1307 тоот албан бичгээр хандаад байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколыг “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэснээр дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хууль хэрэглээнд ашиглах, хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй, аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан “бүх газарт” болон олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах ажлын дан ганц ЭШУС үндэсний ажиллагаа бус бусад төрийн болон төрийн бус байгууллага баталгаат эх сурвалж болгон ашиглах боломжтой.

Иргэдэд эрүү шүүлтийн хор аюулын таниулахад ЭШУС үндэсний ажиллагааны явц, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан иргэд, олон нийтэд түгээх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд мэдээ, мэдээллийн хугацааг 1 минут 30 секундэд багтаан бэлтгэх нь илүү олон хүнд хүрч өндөр хандалт авдаг болох нь ажиглагдсан.

Иймд цахим орчинд хамгийн их хандалт авдаг аргыг ашиглаж “reels” бүтээж эхэлсэн бөгөөд “УИХ-ын дарга Дашзэвэгийн Амарбаясгалангийн УИХ-ын Намрын чуулганыг хааж хэлсэн үгнээс” нэртэй reel 24 цагийн хугацаанд хамгийн их буюу 14,000 хандалтыг авсан байна.



Цаашид төрийн болон хувийн мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран бүхий л хэлбэрээр бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх бодит шаардлага тулгарсан.

**Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн, ахиц дэвшил:**

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн эхний 2,5 жилийн хугацаанд эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэхэд дагаж мөрдөх олон улсын хүний эрхийн стандарт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад хурдан хугацаанд нийцэж, бусад улсын Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагуудын аль хэдийнээ эзэмшсэн үр чадвар, туршлагыг хуримтлуулахад чиглэн ажиллав.

Шинэ тутам байгуулагдсан үндэсний ажиллагаа болохынхоо хувьд эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийн нөхцөл байдлыг тогтолцооны түвшинд илрүүлэх, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, нөлөөллийн ажлыг үр дүнтэй явуулах олон улсад шалгарсан арга зүйд суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн тулд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ болон бусад Оролцогч улсын Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагатай зөвлөн туслах, харилцан суралцах, хамтран ажиллах бодлогыг энэ хугацаанд баримталж ирлээ.

Ийнхүү Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд баримталсан бодлого оновчтой байж, амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл нь 2024 оны онцлох үйл явдлууд юм.

Тухайлбал, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь 2024 онд албан ёсны айлчлалаар ажиллах Оролцогч улсыг товлохдоо Монгол Улсыг сонгосон нь нэг талаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагаа Дэд хороотой байнгын холбоотой байж, урьдчилан сэргийлэх техник, арга зүйн зөвлөгөө, туслалцаа авахыг эрмэлзэж, хүсэлтээ уламжилсан явдалтай холбоотой билээ.

Уг айлчлалын зорилгын нэг чиглэл нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагааны албан хаагчдын урьдчилан сэргийлэх арга зүйг чадавхжуулахад оршиж байсан бөгөөд айлчлалын эхний өдрийг үндэсний ажиллагааны хяналт шинжилгээ явуулдаг арга барилтай нарийвчлан танилцах, улмаар хяналт шинжилгээ явуулах олон улсын стандартад нийцүүлэн үр дүнтэй явуулах арга зүйн зөвлөгөө, сургалтыг албан хаагчдад явуулав.

Дэд хорооны гишүүд айлчлалын хоёр өдрийн турш Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагаатай хамтран хяналт шинжилгээ хийхдээ үндэсний ажиллагааны албан хаагчдын хорих анги, цагдан хорих байр, сэтгэцийн эрүүл мэндийн болон асрамж халамжийн байгууллагад хийдэг хяналт шинжилгээний арга барилын бүхий л явцыг, тухайлбал тухайн байгууламжид нэвтрэн орохоос эхлэн, удирдлагын багтай яриа хэлэлцээр өрнүүлэх, эрх чөлөөгөө хасуулсан иргэдтэй ярилцах, асуумж судалгаа авах, орчны ажиглалт, хэмжилт хийж буй байдлыг ажиглах, шаардлагатай үед газар дээр нь зөвлөгөө, зааварчилгаа өгөх байдлаар ажилласан бөгөөд хяналт шинжилгээний төгсгөлд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд урьдчилсан ажиглалт, дүгнэлтээ танилцуулж байсан нь үндэсний ажиллагааны албан хаагчид хяналт шинжилгээ хийх арга барилдаа хөндлөнгийн ажиглагчдын дүгнэлтийг тусгах, дутагдаж буй, засаж, сайжруулах үр чадваруудаа засаж, сайжруулах, улам чадавхжихад чухал нөлөө үзүүлсэн юм.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Монгол Улсад хийсэн айлчлалын бүрэлдэхүүн уг айлчлалын талаарх мэдээллийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр олон нийтэд зориулан хэвлэн нийтэлсэн.

Уг мэдээлэлд “... Монгол Улсын эрүү шүүлт тулгах явдалд хяналт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий хараат бус нэгж нь эрүү шүүлт тулгах гэмт хэргээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж байгааг цаашид улам баталгаажуулж, бэхжүүлэх

шаардлагатай” хэмээсэн нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга барил олон улсын стандартад нийцэн, үр дүнтэй явагдаж буйг хүлээн зөвшөөрсөн явдал юм.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулганаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын III илтгэлийг хэлэлцэн, Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн дүгнэлт, зөвлөмждөө Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026)-г батлан, хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь Монгол Улсад эрүү шүүлтээс ангид байх хүний эрх хангагдах, хамгаалагдах, энэ эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чухал алхам болсныг онцолсон нь Монгол Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд баримталж буй бодлогыг үнэлж байгаа чухал алхам болсон билээ.



Түүнчлэн, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай хамтран хэрэгжүүлж буй үе шатлал бүхий арга хэмжээнийхээ талаар албан ёсны цахим хуудастаа нийтлэхдээ “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үндэсний ажиллагаа нь хэдий байгуулагдаад удаагүй ч аль хэдийнээ бүс нутгийнхаа Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага, Хүний эрхийн үндэсний байгууллагуудын дунд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх “үлгэр жишээ” болжээ” хэмээн үнэлсэн.



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг чадавхжуулах, нийт хүн амын дундах эрүү шүүлтээс ангид байх эрх, хүний эрхийн тухай боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн төслийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хугацаанд хэрэгжүүлэх гэж байна.



Уг төслийг хэрэгжүүлснээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид, төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мэдлэг, хүний эрхэд суурилсан арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд чухал ахиц дэвшил гарах билээ.

### **Иргэний нийгмийн болон ашгийн төлөө бус төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны үр дүн, ахиц дэвшил:**

Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаа байгуулагдаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж эхэлснээр НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажсан эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн тухай ойлголт олон нийтэд эрчимтэй түгээж, иргэд эрүү шүүлтээс ангид байх эрхийг нь хангаж ажиллахыг төрийн байгууллагын алба хаагчдаас шаардах чадвар тэр хэрээр нэмэгдсэний илрэл нь эрүү шүүлттэй тэмцэх, хүний эрхийг төрийн албан хаагчдын хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах, иргэний эрхээ хамгаалах чадварыг нэмэгдүүлэх, түүнчлэн эрүү шүүлтийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага, холбоод нийгэмд бүрэлдэн бий болсон явдал юм.

ЭШУС үндэсний ажиллагаа нь өмнөх жилүүдэд “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” ТББ, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо, “Шогч бийр” шог зураачдын холбоо зэрэг Иргэний нийгмийн байгууллагуудтай тухайлсан арга хэмжээний хүрээнд зөвхөн хоёр байгууллагын хамтын ажиллагааг хэрэгжүүлж ирсэн бол 2024 онд энэхүү хамтралын хүчийг улам зузаатгаж, эрүү шүүлттэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах, иргэний эрхээ хамгаалах чадварыг нэмэгдүүлэхэд идэвхтэй явуулж байгаа ТББ-уудтай олон талт хамтын ажиллагааны хэлбэрт шилжин ажиллаж байна.



ЭШУС үндэсний ажиллагаа нь иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох уулзалтуудыг Иргэний нийгмийн байгууллагууд, тухайлбал “Монголын ЛГБТ Төв”, “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” зэрэг ТББ-ын удирдлагуудтай 2024 оны турш зохион байгуулсан.



Эдгээр уулзалтын дүнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Иргэний нийгмийн байгууллагууд төрийн бодлого боловсруулах үйл явцад оролцохоос илүүтэй, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихад оролцох л боломжтой байгаад анхаарал хандуулж, ХЭҮКтХ-ийн 33.1.3, 34.1.7-д заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн хүрээнд “Иргэдийн шударга шүүх”, “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо”, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-уудын зүгээс ирүүлсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд хамтран хэрэгжүүлэх ажлын саналуудыг тусган “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-ыг боловсруулан баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хэн бүгдийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалах, дэмжих, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх, хүний эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтран ажиллахаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” сэдэвт уулзалт-хэлэлцүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.



УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт “Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлтэй тэмцэх үндэсний холбоо”, “Иргэдийн шударга шүүх” ТББ, “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл, ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хороо, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологийн холбоо, “Эмнести Интернэшнл” ОУБ, “Монголын ЛГБТ Төв” байгууллагуудын төлөөлөл оролцож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжин оролцохоо илэрхийлж, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.

Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцээд, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй



байх эрхийг хамгаалах чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар УИХ-ын ХЗБХ-д танилцуулах хугацаа даруй 2 жил 6 сараар удааширсан, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол, УИХ-ын ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн тайланг ХЗБХ-д танилцуулах хугацаа 2025 оны хаврын ээлжит чуулган явагдаж буй эдгээр өдрүүдэд тохиож байгаа боловч танилцуулагдаагүй хэвээр байгаад уулзалт-хэлэлцүүлэгт оролцсон Иргэний нийгмийн байгууллагууд шүүмжлэлтэй хандаж, Монгол Улсын Засгийн газар иргэний эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах чиглэлээр дээрх тогтоолуудаар даалгасан арга хэмжээ бүрийг даруй авч хэрэгжүүлэхийг уриалж, Монгол Улсын Засгийн газарт Уриалга209 гаргасан ба ЭШУС үндэсний ажиллагааны 2025 оны үйл ажиллагааны тайлангаар дамжуулан Засгийн газарт хүргүүлж байна.



Олон улсад өрнөж байгаа эрүүдэн шүүх, зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх нь хамтын үүрэг хариуцлага болохыг сануулж, бүх нийтээр нэгдсэн цагт хүний эрхийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна гэх үзэл баримтлалыг түгээж буй #SafeInCustody хөдөлгөөнийг Монгол Улсад нэвтрүүлэн хэрэгжүүлэх ажлын эхлэл болгож, “#SafeInCustody-Улаанбаатарын тунхаглал”-ын төслийг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн оролцоо” уулзалт-хэлэлцүүлгийн үеэр зохион байгуулагч, оролцогч талууд хамтран боловсруулсан ба #SafeInCustody хөдөлгөөн нь Монгол Улсад албан ёсоор “Эрүү шүүлтийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх олон улсын өдөр” буюу 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр өрнөж эхлэх болно.



“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 2025”-д “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүний эрх, эрх чөлөө, эрүү шүүлтээс ангид байх эрхийн тухай бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн харилцаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд Иргэний нийгмийн оролцоог хангах зорилгын хүрээнд цогц үйл ажиллагаа явуулахад чиглэсэн төслийн саналыг хүргүүлэх ажил багтсан.

Иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх ойлголт, мэдлэг, эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаарх судалгаа Монгол Улсад өмнө хийгдэж байгаагүй учир санхүүжүүлэгч байгууллагын дэмжлэгээр иргэдийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн ойлголт, мэдлэгийн төлөв байдалд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 4 бүсийг хамруулсан судалгаа хийх, судалгааны үр дүнд үндэслэн зорилтот бүлгийн эрүү шүүлтээс ангид байх эрхийн боловсрол олгох нөлөөллийн ажил өрнүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон эмнэлгийн байгууллагуудын алба хаагчдад эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхэд суурилсан ажлын арга барилыг төлөвшүүлэх нөлөөллийн ажил өрнүүлэх төслийг “Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ-тай хамтран 2026 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын Тусгай санд хүргүүлсэн.





ЭШУС үндэсний ажиллагаа нь ХЭҮКтХ-ийн 33.1.3-т заасан “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийн хүрээнд 2024 онд “ХЭҮКтХ-ийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ” сэдвээр 1 судалгаа, дүн шинжилгээний ажил, “Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага боловсруулах ажлуудыг 1 судлаачдын баг, ашгийн бус 1 хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлсэн бол 2025 онд хараат бус судлаачдын багаар “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологи судалгаа”, “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөл”, “Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” дэд сэдвүүдийн хүрээнд цогц судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

“ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх, хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт хийх дүн шинжилгээ” судалгааны ажил нь хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид ЭШУС үндэсний ажиллагааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой байв.

“Эрүү шүүлт тулгах явдалтай тэмцэх үндсэн асуудал болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны үйл ажиллагаа” сургалтын хөтөлбөр, “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал” сургалтын гарын авлага нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын тухай ойлголт, уг конвенцын дагуу Монгол Улсын дотоодын хууль тогтоомжуудад оруулсан хууль эрх зүйн зохицуулалт болон олон улсын түвшинд эрүү шүүлттэй тэмцэж буй туршлага, хохирогч хамгаалал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг, бүрэн эрхийн талаар хууль сахиулах байгууллагын ажилтнуудад нэгдсэн мэдлэг, мэдээлэл өгөхөд чиглэгдсэн бол Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нөхцөлдүүлж буй шалтгаан нөхцөлд хийсэн криминологийн судалгаа нь эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх Монгол Улсын нэгдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг зөв бүрдүүлэхэд чухал судалгааны баримт бичиг болсон.



ЭШУС үндэсний ажиллагаа нь Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхлээд буй энэхүү “хамтрал” нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй байх ёстой, үр дүнтэй, цогц үйл ажиллагааны бүрэлдэхүүн юм. Учир нь Иргэний нийгмийн байгууллагууд бол иргэдийн төлөөлөл. Тэд иргэдийн хэрэгцээг байнга тодорхойлж, үүссэн хэрэгцээнд шуурхай хариу үйлдэл үзүүлдэг.

Энэ ч үүднээс ЭШУС үндэсний ажиллагаа нь 2024 оноос иргэний нийгмийн, ашгийн бус байгууллагатай явуулж ирсэн хамтын ажиллагааны арга барилдаа дүгнэлт хийж, илүү үр дүнтэй байх “олон талт оролцогчдын хамтын ажиллагаа”-ны хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд цаашид ч эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх төрийн үйл хэрэг иргэдэд илүү ойртож, иргэдийн эрх, эрх чөлөө, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн нөхцөл байдал, эрхээ эдлэх хэрэгцээ шаардлагыг үнэн зөв тодорхойлж, бодит үр дүнд хүрэхийн төлөө ЭШУС үндэсний ажиллагаа болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны оролцооны хүрээгээ улам тэлэн ажиллахыг зорьж байна.

### **Эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсэн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үр дүн, ахиц дэвшил:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны хүрээнд 2022 онд 11, 2023 онд 59, 2024 онд 99, 2025 оны эхний улиралд 17, нийт 186 гомдол, мэдээлэл ирүүлснийг харьяаллын дагуу шилжүүлэн шалгуулсан. Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсэн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэлт 98.5 хувьтай байна.



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс холбогдох байгууллага албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг тухайн байгууллагаас тухай бүр болон шаардлагатай тохиолдолд нэгтгэсэн байдлаар авч хэвшсэн.



Шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлж байгаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан иргэдээс эрүү шүүлтэд өртсөн тухай зөрчигдсэн эрхийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар болон холбогдох харьяа газруудад шилжүүлэн шийдвэрлүүлэхээр хүргүүлдэг боловч тус гомдлыг хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэж байгаа нь 90.0 хувийг эзэлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, цагдан хорих байранд байгаа хүнээс биечлэн уулзах хүсэлт гаргасан гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх хүрээнд ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүний зөвшөөрлөөр цахим уулзалтыг зохион байгуулж хэвшсэн.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүнийг бусадтай утсаар болон цахимаар уулзахад албан хаагчийн биечилсэн хяналт тавих журмыг баримтлан ажилладаг ч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хүрээнд гишүүн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны албан хаагчид цахимаар уулзахдаа алба хаагчдын биечилсэн хяналтыг буулгаж, цахимаар уулзаж байгаа хүнийг чанга яригч ашиглахгүй заавал чихэвч зүүж яриулахыг тухайн байгууллага, алба хаагчдаас шаардаж уулзалтыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн боломжит бүх аппликейшнүүд (facebook, skype, google meet, viber)-ыг ашиглан, уулзалтад оролцогчийн зөвшөөрөлд үндэслэн дуу, дүрсний бичлэг хийн хадгалж, санал, хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх цахим уулзалтын орчин нөхцөлийг бүрдүүлж чадсан.



### **Улсын Их Хурал, Засгийн газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан тогтоол, шийдвэр, анхаарах асуудал:**

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 2024 оны 5 дугаар сард хараат бус шинжээчдийн багийн гүйцэтгэсэн судалгааны дүн болон УИХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолд заасны дагуу УИХ-ын удирдлагуудаас өгсөн чиглэлийн хүрээнд

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулсан харилцааг боловсронгуй болгохоор Монгол Улсын ХЭҮКтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, чуулганаар хэлэлцүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан боловсруулж, (2024.04.26) Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлж, Хаврын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэж, эхний хэлэлцүүлэгт шилжүүлж шийдвэрлэсэн.

Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн байнгын хорооны гишүүд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан, бусад үйл ажиллагаатай танилцан, ач холбогдол өгч, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар болон ЗГ, ХЗБХ-ны хуралдаануудаар хэлэлцээд:

- 1. Улсын Их Хурлын** 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” **35 дугаар тогтоол;**
- 2. Улсын Их Хурлын** 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол;
- 3. Улсын Их Хурлын** 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” **114 дүгээр тогтоол;**
- 4. Улсын Их Хурлын** Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” **09 дүгээр тогтоол;**
- 5. Улсын Их Хурлын** 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлах тухай” **21 дүгээр тогтоол** (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй Засгийн газрын бүх түвшинд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн);
- 6. Улсын Их Хурлын** 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө»-г батлах тухай” **42 дугаар тогтоол** (Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилтын 5.3-т: “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан);

7. **Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар.** (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр тогтоол, шийдвэрүүд батлагдсан нь төр, засгаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлсэн томоохон арга хэмжээ болсон.



**1. Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх;
- Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

**2. УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох"-ыг Засгийн газарт даалгасан.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний

нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

- Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно.” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

### **3. Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийх чиглэлээр:

- Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хороонд даалгасан<sup>210</sup>.

### **4. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор ЭШУС асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар:

- Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

<sup>210</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу хийсэн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ” хийлгэсэн. Судалгаагаар ХЭҮКХ-ийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, үл ойлгогдох байдал үүсгэхүйц байгаа нь тогтоогдсон. Хараат бус судлаачдын багийн тайлан. 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>



**5. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй Засгийн газрын бүх түвшинд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй Засгийн газрын бүх түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.1.10 дугаар заалтад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа аливаа хязгаарлалтгүйгээр, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдах чухал баталгаа болсон.

**6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар.**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй Засгийн газрын бүх түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр тогтоол нь Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан ЭШУС үйл ажиллагааг бэхжүүлэхэд болон эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлсэн томоохон бодлогын арга хэмжээ болсон. Онцлон тэмдэглэхэд тус тогтоолууд хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, замын зургийг тодорхойлоход чухал түлхэц үзүүлсэн.

**Нэгдсэн Үндэстний Байгууллага, Хүний эрхийн гэрээний хороодоос Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмж, Дүгнэлт, анхаарах асуудал**

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 50 дугаар чуулганы хуралдаан болон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны хуралдааны 54 дүгээр хуралдаанаас “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу Монгол Улс ЭШУС үндэстний механизмыг бие даасан, хараат бус байдлаар бий болгох арга хэмжээ авах” НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан удаа дараагийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах талаар Монгол Улсад өгөх зөвлөмж”-үүдийг баталсан.

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хорооны 2016 оны 08 дугаар сарын 2,3-ны өдрийн 1443, 1445 дахь хуралдаанаар Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэлийг CAT/C/MNG/2 хэлэлцээд, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 1453 дахь хуралдаанаар баталсан зөвлөмж (2016),
2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн CAT/OP/MNG/1 «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017),
3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 54 дэх хуралдаанаар хэлэлцэн баталсан A/HRC/54/51/Add.2 Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг хэлэлцэн баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэстний механизмыг бие даасан, хараат бусаар байгуулах талаарх зөвлөмж.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээний хороодын тайлагналын механизмын дагуу Монгол Улсын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал болон өмнөх зөвлөмжүүдийн биелэлтийн гурав дахь илтгэлийг Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 81 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн.

Хуралдаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Женев дэх төв, Дэлхийн худалдааны байгууллага болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа, Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар болон ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ болон иргэний нийгмийн төлөөлөгчид биечлэн оролцсон.

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Оролцогч улсын илтгэлийн хэлэлцүүлгийн явцад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор байгуулагдсан Үндэстний урьдчилан сэргийлэх механизм буюу Монгол Улсын тухайд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэстний ажиллагаа болон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хаалттай уулзалт хийж, ажиглалт, зөвлөмж гаргах явцад өөрсдийн санал, дүгнэлтийг Хороодын гишүүдэд танилцуулах эрхийг олгодог.

Энэ хүрээнд Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны дарга, гишүүд, Монгол Улсыг хариуцсан тусгай илтгэгчид, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны дарга, гишүүдтэй Монгол Улсын эрүү шүүлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд гаргаж буй хүчин чармайлтын талаар хоёр талын албан ёсны уулзалт хийв.



Мөн энэ үеэр НҮБ-ын **Тусгай сангаас Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чадавхыг бэхжүүлэх талаар хүргүүлсэн төсөл шалгарч, санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн**<sup>211</sup>.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын **Эрүүдэн шүүхийн эсрэг хороо** нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд 2157, 2160 дугаар хуралдаанаараа Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа **CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг** баталсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтэд: **“Монгол Улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголын УИХ, Засгийн газарт уриалж, Зөвлөмж ирүүлсэн.**<sup>212</sup>



Түүнчлэн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгохыг удаа дараа сануулсаар ирсэн бөгөөд энэ удаад ч дахин сануулж байгаагаа уламжлав.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь **Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026 он) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан байна.**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх **Дэд хорооноос** Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн **CAT/OT/MNG/RPNP/R-I** зөвлөмж гаргасан.

211 “Strengthening the NPM of Mongolia, improving public education on the right to be free from torture and human rights”. Granted by the Special Fund of the Optional Protocol to the UN Convention against Torture to be implemented in 2025.05.01 – 2026.04.01.

212 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтийг баталсан. CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх. [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FFUL%2FMNG%2F32846&Lang=en).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12-ны 2157 дугаар хуралдаанд Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос танилцуулсан.

Улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн **CAT/OT/MNG/RPNPM/R-I дүгнэлт** гаргаж, ирүүлсэн. Үүнд:



- Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдан ажиллаж байгаа богино хугацаанд үр дүнтэй ажиллаж, Ази-Номхон далайн бүс нутагтаа тэргүүлэх байр суурьтай ажиллаж байна.
- Монгол Улсын илтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулан уг хуралдаанд оролцсон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АПТ) - Олон улсын байгууллагын дарга, төлөөлөгчид **“Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсийн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын бүс нутгийн бусад Оролцогч улсууддаа “үлгэр жишээ” болж буйг онцолж,** мандатынхаа дагуу олон улсын түвшинд энэ тухай мэдээлсэн байна<sup>213</sup>.



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

**Нэг.** Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байна<sup>214</sup>. Нэмэлт протоколын үзэл санаа, зохицуулалтыг хоёрдмол утга, өөр өөр байдлаар тайлбарлахгүйгээр нэг мөр хэрэгжилтийг хангах нь чухал байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг

<sup>213</sup> Mongolia's NPM is one of only a small number in the Asia Pacific but it is already benefiting from the experiences of other NHRIs in the region with an NPM mandate, as well as acting as an example for those states in the region who are yet to ratify the Optional Protocol to the Convention against Torture. <https://www.apt.ch/news/mongolia-new-monitoring-body-focuses-risky-practices-and-women-detention>

<sup>214</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан тул эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийн эрх зүйн зохицуулалт дотоодын холбогдох хууль тогтоомж болон нэгдэн орсон энэхүү конвенцын дагуу зохицуулагдана. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг ойлгоно” гэж өөр өөр чиг үүрэг бүхий, хараат бус механизм байхаар тодорхойлсон.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол нь Оролцогч улсууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан байдлыг бүхэлд нь баталгаажуулж, хараат бус ажилтнуудаас бүрдүүлэх, баталгаажуулахыг шаарддаг (Нэмэлт протоколын 18 дугаар зүйл. 1 дүгээр хэсэг). Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдалд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан, хуулийн этгээдээс хараат бус байх (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг) шаардлагатай.

Тус механизмын бие даасан байдал нь хууль болон конвенциор зохицуулагдсан. Энэ нь:

- Бүрэн эрх,
- Хүний нөөцийн хараат бус байдал,
- Үйл ажиллагааны хараат бус байдал,
- Санхүүгийн хараат бус байдлыг багтаадаг.

Энэ талаар **Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний хороодоос Монгол Улсад удаа дараа дүгнэлт гарган, зөвлөмж өгч ирсэн бөгөөд эдгээр зөвлөмж, Нэмэлт протоколын үзэл санааг даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.**



1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтэд: “...Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх талаар өмнө өгсөн зөвлөмжүүд болон энэ удаагийн зөвлөмжийн дагуу шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг УИХ, Засгийн газарт уриалж, Зөвлөмж ирүүлсэн”<sup>215</sup>.

2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн CAT/OT/MNG/RPNP-M/R-I зөвлөмжид: “Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар арга хэмжээ авах талаар зөвлөмж гаргасан.

3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2021 оны 50 дугаар чуулганы хуралдаан болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны хуралдааны 54 дүгээр хуралдаанаас “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу Монгол Улс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бие даасан, хараат бус байдлаар бий болгох арга хэмжээ авах” НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс

<sup>215</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн зөвлөмжүүд <https://mongolia.un.org/mn/98613https://legalinfo.mn/mn/detail?lawid=16959903470441>

гаргасан удаа дараагийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах талаар Монгол Улсад өгөх зөвлөмж"-үүдийг баталсан.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хорооны 2016 оны 08 дугаар сарын 2,3-ны өдрийн 1443, 1445 дахь хуралдаанаар Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэлийг CAT/C/MNG/2 хэлэлцээд, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 1453 дахь хуралдаанаар баталсан зөвлөмж (2016),
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн CAT/OP/MNG/1 «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017),
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 54 дэх хуралдаанаар хэлэлцэн баталсан A/HRC/54/51/Add.2 Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг хэлэлцэн баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бие даасан, хараат бус байдлаар байгуулах талаарх зөвлөмж.

Энэ талаар Монгол Улсын Их Хурал болон Олон улсын парламентын холбооны хамтран (2025.03.20) зохион байгуулсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан, хэлэлцүүлэг (UPR-Universal Periodic Review)-ийн үйл явц дахь Монгол Улсын Их Хурлын оролцоо, гишүүн орнуудаас хүлээн авсан зөвлөмжүүдийн хэрэгжилт, тэдгээрийг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог хангах тухай уулзалт-хэлэлцүүлгийн үеэр тусгайлан хөндөгдсөн<sup>216</sup>.

**Хоёр.** Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хараат бус байхыг шаарддаг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан байдлыг хангах хамгийн чухал үзүүлэлт нь -нэг талаас төрийн асар өргөн эрх мэдэл бүхий институтууд, -нөгөө талаас эрүүгийн гэмт хэрэгтэн, бүлэглэлүүдтэй шууд тулгардаг тул бие даасан, хараат бус байдлыг нь нэн тэргүүнд хангаж, эрсдлийг хааж ажиллах зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13 дугаар зүйл, Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлүүдэд дурдсан ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид болон эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангахыг шаарддаг.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 21 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэг “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан ямарваа шийтгэл ногдуулахыг тушаах, эдлүүлэх, зөвшөөрөх, хүлээн тэвчих ёсгүй бөгөөд тухайн хувь хүн, байгууллагыг ямарваа бусад байдлаар хавчих ёсгүй”, “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын цуглуулсан нууц мэдээллийг ил тод болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг тухайн хүний шууд илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй” гэсэн

<sup>216</sup> Хүний эрхийн төлөв байдлын үнэлгээний талаарх цахим уулзалт-хэлэлцүүлэг. <https://www.parliament.mn/nh/74289/>



заалтуудаар эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангахыг Оролцогч улсуудад үүрэг болгосон<sup>217</sup>.

**Гурав.** Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан заалтуудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийлгэхийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд даалгасан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар хараат бус судлаачдын багийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй, ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэж байна.



Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр байдлыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулсан 22 заалтаар үнэлбэл зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна<sup>218</sup>.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол батлагдсан<sup>219</sup>.

Тус тогтоолоор:

- Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны

<sup>217</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протокол <https://legalinfo.mn/mn/detail/1156>

<sup>218</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ”. Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан хараат бус судлаачдын баг. 5 хууль зүйн докторууд багт ажилласан. ХЭҮК., 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>

<sup>219</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140487382221>

54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох”;

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар даалгасан.

Иймд Монгол Улсын Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолд заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газраас эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

**Дөрөв.** Түүнчлэн хууль хэрэглээний явцад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдалд халдах, санхүү, хүний нөөц, үйл ажиллагааны байдалд саад учруулж, гадаадад харилцах албан хэрэг захидал харилцааг задлах, нөлөөлөх, гэнэтийн ажиллагаагаар хяналт шинжилгээ хийх удирдамжийн нууцлал алдагдах, эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн иргэдийн мэдээллийн нууцыг задруулах, хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах эрхийг хангах бололцоогүй байна<sup>220</sup>.

Тухайлбал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргаас хуулиар олгогдоогүй, өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах бүрэн эрх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдалд халдаж, Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний өмнөөс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүдэд 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр албаны цахим хаягаас албан захидал явуулсан асуудал гарсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд, нарийн бичгийн даргаас уг захидлыг ЭШУСАЭ гишүүнд ирүүлж, албан ёсоор ямар учиртай болохыг асуусан. ХЭҮК-ын ТГ-ын даргын илгээсэн захидалд: “ХЭҮК-ын хүрээнд ЭШУС үндэсний ажиллагааг байгуулсан одоогийн хууль дахин хэлэлцэгдэж байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Саяхан манай хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг сөрөг хүчний дарга өргөн барьсан. ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний голлон нөлөөлсөн энэхүү хуулийн төсөл нь Нэмэлт протоколын дагуу байгуулагдсан байгууллагын үүргийг өөрчилж, өргөтгөсөн эрх мэдэл бүхий тусдаа Омбудсмeны газрыг байгуулахад чиглэжээ. Та бүхний айлчлал болон удахгүй болох манай бүх нийтийн сонгуультай холбогдуулан өөрчлөлт оруулах тухай тэдгээр саналыг шийдвэрлэх цаг нь ирж байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн цаад сэдэл нь нийтийн эрх ашиг гэхээсээ илүү хувийн ашиг сонирхлоос шалтгаалж байгаа бөгөөд энэ нь манай үндэсний

<sup>220</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайлан. 222 дахь хуудас. D-Parliament.mn

бодлого болон танайх шиг олон улсын байгууллагуудын ойлголтод нөлөөлж болзошгүй буруу тайлбар хийх эрсдэлтэй гэсэн болгоомжлол байна.” гэж дурджээ.

Энэ нь Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нараас УИХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоол221, хараат бус шинжээчдийн багийн гүйцэтгэсэн судалгаа222-ны дүн, Монгол Улсын Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол223-д тус тус заасны дагуу НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцүүлэн эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх талаар хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд санаачлан боловсруулсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн мэдүүлж, 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлж224 байсан үед явуулсан захидал болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт: “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно”, мөн энэ зүйлийн 31.3 дахь хэсэгт: “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж хуульчилсан зохицуулалтыг нэн даруй хангах шаардлагатай.

Нөгөөтээгүүр Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13 дугаар зүйл, Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлд заасан ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчид болон эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах асуудлаар хуульд тусгагдаагүй нь дээр дурдсан эрсдэл үүсгэж байгаа гэж дүгнэж байна.

221 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17047938712721>

222 Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ”. Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан хараат бус судлаачдын баг. 5 хууль зүйн докторууд багт ажилласан. ХЭҮК., 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>

223 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140487382221>

224 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлэв. 2024-04-26 <https://www.parliament.mn/nm/62341/>





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНААС ӨГЧ БУЙ САНАЛ

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй болгох;
2. Эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох.
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд зориуд саад учруулах үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох.
4. Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлгүүдэд буй “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн, эрүүгийн хуулийн нэг бүлэг болгож эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх;
6. Нотлох баримтыг эрүү шүүлт тулгаж, хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж цуглуулж, бэхжүүлж, шалгаж, үнэлсэн нь тогтоогдсоныг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэлд тооцох;
7. Эрүү шүүлтийн хохирогчийн хохирол, хор уршгийг төр эхлэн барагдуулж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
8. Монгол Улсын Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах;
9. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагуудад орон тооны бус зөвлөл байгуулах, үндэсний хөтөлбөр боловсруулах;







**N P M**  
MONGOLIA

ᠠᠨᠠᠨᠢᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ  
ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ  
ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ  
ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠨᠢ

**ХАВСРАЛТ**



# ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮ ШҮҮЛТТЭЙ ТЭМЦЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

ХАВСРАЛТ 1

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ УРИАЛГА

*Монгол Улсын иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай*

Монгол Улсад хүний эрхийг нийтээрээ хүндэтгэж, хамгаалж, биелүүлдэг, цагдан хоригдсон, саатуулагдсан, хорих ял эдэлж буй, эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр эрүү шүүлтээс ангид байх нийгмийг цогцлооход хүч нэгтгэн, хувь нэмрээ оруулахаар Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа болон Иргэний нийгмийн байгууллагууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө - 2025”-ын хүрээнд хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.1.10 дугаар заалтад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа аливаа хязгаарлалтгүйгээр, хэзээд эдлэх ёстой эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдах чухал баталгаа болсон.

Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22, 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022, 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолууд батлагдаж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын Засгийн газарт даалгасныг эргэн сануулж, дараах Уриалгыг хүргүүлж байна. Үүнд:

### **1. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоол:**

4/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

б/Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

## **2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоол:**

8/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

а/Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

9/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

## **3. “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонголыг явуулсантай холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дугаар тогтоол.**

Төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдан, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ “Бүх хүнтэй заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцах”; “Яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ялгаварлан гадуурхаж болохгүй”; “Хэнийг ч эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж болохгүй” гэх хүний эрхийг хангах суурь үзэл баримтлалыг мөрдлөг болгож, Монгол Улсын Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолоор хүлээсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр авах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт УРИАЛЖ байна.

Эрүү шүүлтийн хохирогчид бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирлоо барагдуулах, гэмтлийн эмчилгээ, нөхөн сэргээх бусад хэлбэрийг оролцуулан шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрхээ эдлэх цогц хөтөлбөр бий болгож, тухайн хөтөлбөрийг үр дүнтэй ажиллуулахын тулд хангалттай нөөцийг хуваарилахыг Монгол Улсын Засгийн газарт УРИАЛЖ байна.

Эрүү шүүлтийн хохирогчдыг олж тогтоох, эрүү шүүлтийн улмаас үүссэн бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирлыг бодитоор, шударга үнэлж, мөнгөн болон мөнгөн бус нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бий болгохыг Монгол Улсын Засгийн газарт УРИАЛЖ байна.

Өөрийгөө хамгаалах чадвар сул эмзэг бүлгийнхэн, тэр дундаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэзээд үл хязгаарлагдах эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах бодлогыг холбогдох яам, агентлагийн түвшинд хэрэгжүүлэхийг УРИАЛЖ байна.

Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолуудаар даалгасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх болон хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан хугацаанд багтаан хэрэгжүүлж ажилладаг байхад Засгийн газарт УРИАЛЖ байна.

### **УРИАЛГАД НЭГДСЭН:**

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа

Эрүүдэн шүүх, хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо

“Иргэдийн Шударга шүүх” Төрийн бус байгууллага

“Сэтгэлзүйн мэдрэмж” Төрийн бус байгууллага

ХЭҮК-ын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөл

Монголын Хуульчдын холбоо

Монголын Өмгөөлөгчдийн холбоо


Монголын Криминологичдын холбоо

ЛГБТ төв





**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН “МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 23 ДАХЬ ИЛТГЭЛ, ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 37 ДУГААР ТОГТООЛ**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 02-ны өдөр      Дугаар 37      Төрийн ордон, Улаанбаатар хот

**ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ  
ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

**8/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:**

а/шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

**9/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:**

а/Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;

б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх.

Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.





**УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2024 ОНЫ 12 ДУГААР  
САРЫН 18-НЫ ӨДРИЙН “ЭРҮҮДЭН ШҮҮЛТ ТУЛГАХ, ХҮНЛЭГ БУС, ХЭРЦГИЙ  
ХАНДАХААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ” АСУУДЛААР  
ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБОГДСОН МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ХЯНАЛТЫН СОНСГОЛЫГ ЯВУУЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 09 ДҮГЭЭР ТОГТООЛ**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**“Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид  
байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг  
хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг  
явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасгай:

**1/Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:**

а. эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг НҮБ-ын “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-д нийцүүлэн боловсронгуй болгох, эрүүгийн хариуцлагыг чангатгах талаарх саналыг бэлтгэн Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

б. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

в. эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бүрдүүлж, чадавхыг бэхжүүлэх талаарх санал, дүгнэлт боловсруулан Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах;

г. гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрхийн хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг гадаад улс орнуудтай байгуулах, Монгол Улсын иргэд олноор амьдарч байгаа улс орны хувьд иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр Засгийн газраас бодлогын арга хэмжээ авах талаарх холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай

хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Авлигын эсрэг хууль зэрэг процессын хууль, тогтоомжуудад холбогдох судалгааг хийж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналтын механизмыг сайжруулах талаар санал боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд ирүүлэх;

е.эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчид учирсан гэмтлийг тогтоох анхдагч шинжилгээг шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийдэг байх талаарх зохицуулалтыг Шүүх шинжилгээний тухай хуульд тусган боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ё.эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг шүүх шинжилгээний үйлчилгээний хураамж, зардлаас чөлөөлөх талаарх зохицуулалтыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд тусган боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

## **2/Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр:**

а.цагдан хорих, хорих ангийн орчин нөхцөл, албадан эмчилгээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг сайжруулах;

б.эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийн хор уршиг, урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, үүрэг хүлээсэн байгууллага бүр орчин үеийн чиг хандлагад нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

в.Эрүүдэн шүүхийн конвенцын орчуулга, агуулга, нэр томъёог нэг мөр болгох, улмаар 2015 оны Эрүүгийн хуулийн "эрүү шүүлт тулгах" гэмт хэргийн шинжийг тодорхой болгох;

г.шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газраас бодлогын арга хэмжээ авч ажиллах;

д.албан үүргээ гүйцэтгэх явцдаа иргэдийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн албан тушаалтны талаарх мэдээллийн сан үүсгэх замаар ажил, албан тушаалд томилогдоход зайлшгүй харгалзан үзэх нөхцөл байхаар Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээг чангатгах;

е.эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх криминолги судалгаа болон энэ төрлийн гомдол шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл байдлын талаа хөндлөнгийн судалгааны байгууллагаар суурь судалгаа хийлгэх;

ё.цэргийн албан дахь дүрмийн бус харьцааны үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, цэргийн номлол, үзэл баримтлалыг хүний хөгжилтэй уялдуулан шинэчлэх, цэргийн ангид үйлчилж буй дүрэм журмыг хүний эрхийн зарчимд нийцүүлэх, дүрмийн бус харьцааны хэлбэрүүдийг уг үндсээр нь таслан зогсоох, цэргийн иргэний хяналтыг сайжруулах талаарх дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргаж, суурь болон зорилтот түвшнээр ангилж, хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон холбогдох бодлогын баримт бичгийг

төсөл боловсруулж Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

ж улс төрийн болон бусад ашиг сонирхлын үүднээс эрүүгийн хилс хэрэгт хэлмэгдсэн талаар тодорхой баримт бүхий өргөдөл, гомдол гаргаж буй иргэдийн хүсэлтийг шалгах, нягтлах, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаарх санал, дүгнэлтийг бэлтгэн Улсын Их Хурлын 2025 оны Хаврын чуулганы хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулах.

2. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны даргаар ахлуулан байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дахь хэсэгт заасан ажлын хэсгийн зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааг Улсын Их Хурлын даргын 2024 оны 112 дугаар захирамжаар байгуулагдсан "Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах талаар холбогдох хууль тогтоомжийг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн зорилт, чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахыг тус ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Хүний эрхийн дэд хорооны дарга (С.Эрдэнэболд) нарт даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, Улсын Их Хурлын 2025 оны Намрын чуулганы хугацаанд багтаан тогтоолын хэрэгжилттэй танилцах хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

5. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.ЦОГТБААТАР



# УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ БАТЛАХ ТУХАЙ” 21 ДҮГЭЭР ТОГТООЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 21

Төрийн ордон, Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөнгөлтийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүндийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилгот түвшин"-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр баталсантай холбогдуулан дарваж арга хэмжээг өвч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар / Л.Оюун-Эрдэнэ-г дэвлэсүгай.
3. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөрдөг, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх;
4. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дөрвүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдрддэг, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;
6. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжлтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан тухайн оны зорилгот түвшнийг хангахад чиглүүлэх.
8. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаатай уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд харилдан тайлагнадаг байгууллагын дарга нэрт үүрэг болгосүгай.
9. Энэ тогтоолыг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 42

Төрийн ордон, Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дах хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
  2. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байнгын, дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо (Ж.Бат-Эрдэнэ)-нд даалгасугай.
  3. Эрхлэх асуудлынаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах бүх үе шатанд Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг шалгуур болгон хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахад дүн шинжилгээ хийн үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодод үүрэг болгосугай.
  4. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга (Б.Баасандорж)-д даалгасугай.
1. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусуулах.
  2. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил тутам мониторинг, хоёр жил тутамд үр нөлөөний үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо (Ж.Бат-Эрдэнэ)-нд танилцуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДАМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 42

Төрийн ордон, Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратегийн зорилго 5. Монгол Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлнэ.

### Стратегийн зорилт:

5.1. Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, парламентын боловсрол олгох, сурталчилсан тангуйнаад нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэмжлэгт арга, хэрэгсэл ашиглах.

5.2. Монгол Улсын Их Хурлын гадаад харилцаа, парламент, бүс нутгийн ба олон улсын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

**5.3. Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.**

5.4. Дэмжлэгт, шинэ үеийн парламентын хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадвартай, өндөр бүтээмжтэй ажлын албант бэхжүүлнэ.

# ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮ ШҮҮЛТТЭЙ ТЭМЦЭХТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

ХАВСРАЛТ 9

НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН III ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД ЗАСГИЙН ГАЗАРТ ИРҮҮЛСЭН НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХОРООНЫ ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ (англи хэлээр)

 Committee against Torture

United Nations

CAT/C/MNG/CO/3\*



Convention against Torture  
and Other Cruel, Inhuman  
or Degrading Treatment  
or Punishment

Distr.: General

11 December 2024

Original: English

Concluding observations on the third periodic report of Mongolia<sup>225\*\*</sup>

1. The Committee considered the third periodic report of Mongolia<sup>226</sup> at its 2157th and 2160th meetings,<sup>227</sup> held on 12 and 13 November 2024, and adopted the present concluding observations at its 2168th meeting, held on 20 November 2024.

## A. Introduction

2. The Committee expresses its appreciation to the State party for accepting the simplified reporting procedure and submitting its periodic report thereunder, as this improves the cooperation between the State party and the Committee and focuses the examination of the report and the dialogue with the delegation.

3. The Committee welcomes the constructive dialogue held with the State party's delegation and the oral replies and written information provided in response to the concerns raised by the Committee.

## B. Positive aspects

4. The Committee also welcomes the State party's initiatives to revise and introduce legislation in areas of relevance to the Convention:

(a) The adoption of the Law on the Establishment of Courts, which provides for the establishment of the court of first instance for family and children's affairs in the area of the capital, Ulaanbaatar, in 2024;

(b) The adoption of the Law on Child Protection, which prohibits corporal

<sup>225</sup> \*Reissued for technical reasons on 16 December 2024.

<sup>\*\*</sup>Adopted by the Committee at its eighty-first session (28 October–22 November 2024).

<sup>226</sup> CAT/C/MNG/3.

<sup>227</sup> See CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160.



punishment and other degrading treatment of children by parents, custodians and other persons in family and social environments, in 2024;

(c) The reform of the Criminal Procedure Law, which eliminates the provision regulating “indefinite arrest”, and introduces a requirement to provide a detailed explanation of the reason for the suspect’s immediate arrest, the judge’s approval, and the refusal of approval in unjustified cases, in 2024;

(d) The adoption of the Law on Amendments to the Criminal Procedure Law, introducing alternatives to detention, in 2024;

(e) The revision of the Law on the National Human Rights Commission of Mongolia, which provides for the establishment of the national preventive mechanism, in 2020;

(f) The revision of the Law on Combating Domestic Violence, which criminalizes domestic violence, in 2016.

5. The Committee commends the State party’s initiatives to modify its policies and procedures in order to afford greater protection to human rights and to apply the Convention, in particular:

(a) The adoption of the Mental Health Comprehensive Action Plan (2024–2027);

(b) The adoption of the Action Plan for the Protection of Human Rights in Business Activities, Prevention of Human Rights Violations and Restoration of Violated Rights (2023–2027);

(c) The adoption of the Strategic Action Plan of the Unit for the Prevention of Torture (2023–2026);

(d) The establishment of the Domestic Violence Division by order A/301 of the Director General of the National Police Agency, in 2019;

(e) The establishment of a Unified Domestic Violence Database, which was integrated into the police call and registration system, in 2018.

### **C. Principal subjects of concern and recommendations**

#### **Pending follow-up issues from the previous reporting cycle**

6. In its previous concluding observations,<sup>228</sup> the Committee requested the State party to provide information on the measures that it had taken in follow-up to the recommendations on the following issues: respect for fundamental legal safeguards<sup>229</sup> and impunity for acts of torture.<sup>230</sup> Noting that a reply concerning the information sought by the Committee was provided on 27 May 2018,<sup>231</sup> and with reference to the letter dated 23 October 2018 from the Committee’s rapporteur for follow-up to concluding observations<sup>232</sup> as well as to the information contained in its third periodic report, the Commit-

<sup>228</sup> CAT/C/MNG/CO/2, para. 41.

<sup>229</sup> *Ibid.*, para. 12 (a)–(d).

<sup>230</sup> *Ibid.*, para. 16 (a)–(d).

<sup>231</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1.

<sup>232</sup> See [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FEUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2FEUL%2FMNG%2F32846&Lang=en).

tee considers that these recommendations have been only partially implemented. The outstanding issues addressed in the previous concluding observations are covered in paragraphs 9, 10, 15 and 16 of the present document.

### **Definition of torture**

7. While noting the revision of article 21.12 of the Criminal Code in 2017, aimed at criminalizing torture as a separate offence, the Committee is concerned that the definition of torture is still not fully in line with article 1 of the Convention, although it appreciates the information provided by the representatives of the State party during the dialogue on a new proposed revision of the crime of torture, which is pending approval. In this connection, the Committee notes the following shortcomings contained in article 21.12 currently in force. First, this provision does not specifically refer to acts of torture committed for the purpose of intimidating or coercing the victim or a third party; second, it does not include acts of torture committed at the instigation of or with the consent or acquiescence of a public official or a person other than a public official acting in an official capacity; third, the criminal responsibility of superior officers who are aware or should have been aware of acts of torture or ill-treatment committed by their subordinates, but failed to take the appropriate action to prevent them, is absent as well; fourth, it does not cover complicity in torture or attempts to commit torture; and fifth, perpetrators of acts of torture can be subject to sentences of a fine or to imprisonment from one to five years, which are penalties that are not commensurate with the grave nature of the crime. Moreover, the Committee is concerned that the Criminal Code does not explicitly exclude the application of an amnesty and a statute of limitations for the crime of torture, except when life imprisonment is imposed for the commission of the crime under specific aggravating circumstances of criminal liability under article 1.10 of the Criminal Code (arts. 1 and 4).

**8. The State party should amend article 21.12 of the Criminal Code to ensure that all forms of torture, as defined in article 1 of the Convention, are prohibited, including acts of torture committed for the purpose of intimidating or coercing the victim or a third party and acts of torture inflicted by or at the instigation of or with the consent or acquiescence of any public official or any other person acting in an official capacity. The State party's legislation should also clearly provide for the criminal responsibility of superior officers who are aware or should have been aware of acts of torture or ill-treatment committed by their subordinates but failed to take the appropriate action to prevent them. It should clearly provide for criminal liability for any act constituting complicity or participation in the commission of torture and attempts to commit torture, in accordance with article 4 (1) of the Convention. The Committee recommends that the State party ensure that the offence of torture is punishable by appropriate penalties which take into account its grave nature, in accordance with article 4 (2) of the Convention. Lastly, the Committee recommends that the State party adopt the necessary legislative measures to ensure that no acts of torture are subject to an amnesty and a statute of limitations.**

### **Fundamental legal safeguards**

9. With reference to its previous concluding observations,<sup>233</sup> as well as the assessment made by the Committee's Rapporteur for follow-up to concluding observations, the Committee notes the efforts of the State party to further strengthen proce-

<sup>233</sup> CAT/C/MNG/CO/2, paras. 11 and 12.

dural legal safeguards and to revise the Criminal Procedure Law in this respect in 2024. However, it remains concerned at reports indicating the following shortcomings:

(a) A high number of arrests are still carried out with the consent of the prosecutor without a court order (known as arrests without delay), in particular by the General Intelligence Agency and the Anti-Corruption Agency, although the Committee takes note of the measures taken and envisaged to enhance judicial oversight of these immediate detentions, as explained by the delegation;

(b) Reported delays in ensuring the right of access to a lawyer and challenges in providing adequate legal aid, notably in remote areas, despite the State party's efforts to improve the legal aid system. In addition, lawyers are allegedly prevented from accessing the full case file of their clients, although the Committee notes the delegation's statement to the contrary;

(c) The Criminal Procedure Code allows for a delay of up to six hours in notifying a relative or legal representative of detainees (art. 31.6 (5)), including in the case of children (art. 18.6 (4));

(d) Questioning of persons summoned as witnesses by the police takes place outside the official interrogation rooms, although the Committee notes the delegation's assertion that this practice has now been eliminated; according to reports, self-incriminating statements or forced testimonies are frequently obtained during these interviews, without the presence of a lawyer, and they often lead to immediate arrest;

(e) Not all interrogations are properly recorded, and where they are, the recordings are not adequately protected and retained for a reasonable period of time; and not all interview and interrogation rooms are equipped with video and audio recording equipment, particularly in remote areas, although the Committee appreciates the information provided by the State party that 849 interrogation rooms have already been equipped;

(f) The length of police custody still sometimes exceeds the legal limit of 48 hours; the period of stay in sobering up facilities of up to 24 hours is often not counted against the 48-hour limit in the event of transfer to police custody (art. 2).

#### **10. The Committee urges the State party:**

**(a) To take all necessary measures to require law enforcement officials to obtain an arrest warrant issued by a judicial authority in order to conduct an arrest, except in cases of flagrante delicto;**

**(b) To ensure that all persons deprived of their liberty are in practice afforded all fundamental legal safeguards from the very outset of their deprivation of liberty, including persons brought to the police station for informal questioning or testimony, in particular unimpeded access to an independent lawyer of their choice or, if necessary, free legal aid of adequate quality in accordance with international standards, including during the initial questioning or interrogation;**

**(c) To amend article 31.6 (5) and article 18.6 (4) of the Criminal Procedure Code to guarantee the right of arrested persons to notify a relative or another person of their choice, of their detention, immediately after apprehension;**

**(d) To continue its efforts to equip all interrogation rooms in all parts of**

the country with video and audio recording equipment, and to guarantee the right to have the questioning in custody, as well as interviews and witness statement-taking, systematically recorded, with mandatory instructions for the storage of such recordings in secure facilities for a reasonable period of time; and to ensure that recordings are reviewed to identify and investigate torture and other breaches of standards, and that they be made available to defendants and their counsels, prosecutors and other supervisory bodies, and that they may be used as evidence in court;

(e) To ensure that protection measures are in place against making self-incriminating or coerced statements by persons who have been interrogated as witnesses and that courts examine the circumstances in which such statements were made and, where a claim of coerced confession is made, stay proceedings until the claim has been thoroughly investigated;

(f) To ensure that the maximum period of police custody does not exceed 48 hours and that any period of de facto deprivation of liberty, including during a stay in a sobering up facility, is counted against the 48-hour period in the case of arrest;

(g) To provide the Committee, in its next periodic report, with information on the number of complaints received regarding the failure to respect fundamental legal safeguards, and on the outcome of such complaints, including disciplinary measures taken against officials who failed to afford fundamental legal safeguards.

#### **Pretrial detention**

11. While noting the amendments adopted by the State party to improve the legal framework governing pretrial detention during the reporting period, including the limitation of the maximum period of pretrial detention to 12 months, or to 18 months in the case of more serious indictable offences, the Committee is concerned at reports that such detention routinely exceeds the legal limits due to the excessive length of judicial proceedings. In this connection, it notes the State party's explanation of its budget investments made to strengthen the judiciary in 2025, which might contribute to addressing the length of judicial proceedings and pretrial detention periods. The Committee also remains concerned about the excessive use of pretrial detention by the judicial authorities during the reporting period, although it appreciates the information provided by the State party about a decrease in the number of pretrial detainees in the past year due to the imposition of alternative measures to detention, such as travel bans. It also notes the introduction of technical devices as an alternative to detention, planned for 2025 (arts. 2 and 14).

**12. The State party should ensure that the provisions on pretrial detention are respected and that such detention is resorted to only in exceptional circumstances and for a limited period, taking into account the principles of necessity and proportionality. It should also intensify efforts to address the prolonged periods of detention due to the excessive length of judicial proceedings, and whenever feasible, make more use of alternatives to pretrial detention, such as electronic monitoring, travel bans, house arrest and bail, in accordance with the United Nations Standard Minimum Rules for Non-custodial Measures (the Tokyo Rules) and the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Noncustodial Measures for Women Offenders (the Bangkok Rules).**

## National preventive mechanism

13. The Committee welcomes the designation of the National Preventive Mechanism Unit within the national human rights institution, the National Human Rights Commission of Mongolia, in 2022. However, it observes with concern the following shortcomings: first, the limited human resources available to carry out activities related to the mechanism's mandate, including the monitoring visits, while acknowledging the geographical conditions and challenges that exist in the State party, the absence of a multidisciplinary composition of its staff, and the lack of clear and explicit functional immunity of its members, which is necessary for the independent exercise of its functions; second, the absence of a separate budget line within the overall budget of the National Human Rights Commission and the lack of budgetary autonomy; and third, a commentary provided on article 33.1.1 of the Law on the National Human Rights Commission, which grants the mechanism access to only a restrictive list of places of deprivation of liberty (art. 2).

**14. The State party should strengthen the capacity of the national preventive mechanism, by: (a) providing it with the financial and human resources, including qualified multidisciplinary personnel, such as medical professionals, psychologists, social workers and other relevant experts, to carry out its work effectively in all types of places of deprivation of liberty, in accordance with the requirements of the Optional Protocol to the Convention, and establishing in law the immunity of the members of the mechanism as is necessary for the independent exercise of their functions; (b) ensuring its budgetary autonomy from the National Human Rights Commission; and (c) amending article 33.1.1 of the Law on the National Human Rights Commission and its comment note, so as to include a comprehensive list of places of deprivation of liberty, in accordance with article 4 of the Optional Protocol to the Convention and general comment No. 1 (2024) of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment.**

## Ineffective investigation of acts of torture and ill-treatment

15. With reference to its previous concluding observations<sup>234</sup> and to the assessment made by the Committee's Rapporteur for follow-up to concluding observations, the Committee remains concerned about the following:

(a) The delays in the establishment of an independent body to investigate complaints of torture and ill-treatment made by persons deprived of their liberty, while noting the State party's commitment to submit the draft law on the establishment of a special investigation unit in 2025. In the meantime, the Committee remains concerned about the potential conflict of interest and ineffectiveness of investigations into allegations of torture and ill-treatment carried out by the Investigation Division of the Anti-Corruption Agency and the Investigative Division of the General Police Department;

(b) Numerous allegations received of torture or ill-treatment committed by law enforcement officials, a high rate of dismissal of torture cases as time-barred, a low percentage of prosecutions, and the imposition of fines rather than appropriate sentences in several convictions;

(c) Information about intimidation and other invasive measures against relatives and legal representatives of victims during the criminal proceedings (arts. 12, 13 and 15).

<sup>234</sup> CAT/C/MNG/CO/2, paras. 15 and 16.

## 16. The Committee urges the State party:

(a) To finalize the law establishing an independent mechanism to investigate acts of torture and ill-treatment committed by public officials, in particular law enforcement officials, and to ensure that there is no institutional or hierarchical relationship between the body's investigators and the alleged perpetrators of such acts; and to strengthen efforts to ensure that acts of torture and ill-treatment are promptly, impartially and effectively investigated by this independent body, whenever there are reasonable grounds to believe that an act of torture or ill-treatment has been committed, and that the alleged perpetrators are duly tried and, if found guilty, punished in a manner commensurate with the gravity of their acts. The Committee notes the commitment made by the State party at its latest universal periodic review in this regard;<sup>235</sup>

(b) To ensure that the authorities open an *ex officio* investigation whenever there are reasonable grounds to believe that an act of torture or ill-treatment has been committed, and that in cases of alleged torture or ill-treatment, the alleged perpetrators are immediately suspended from their duties for the duration of the investigation, in particular where there is a risk that they would otherwise be in a position to repeat the alleged act, to commit reprisals against the alleged victim and their relatives or to obstruct the investigation;

(c) To take all appropriate measures to prevent acts of intimidation and reprisals against alleged victims and their legal representatives and relatives;

(d) To compile and publish relevant comprehensive disaggregated statistical information on all complaints and reports of torture and ill-treatment received, including information on whether such complaints have led to investigations and, if so, by which authority, whether the investigations have resulted in disciplinary action or criminal prosecution, the nature of the penalties imposed in the event of convictions, and whether the victims have obtained redress.

### Evidence obtained through the use of torture and ill-treatment

17. While noting article 16.12 of the Code of Criminal Procedure which provides for the inadmissibility of testimony obtained through the use of torture and ill-treatment, the Committee is concerned that the prohibition contained in this article is focused narrowly on testimonies rather than on any evidence or information derived from statements obtained through torture and ill-treatment, and is concerned at reports that this prohibition is not always respected in practice (art. 15).

18. The State party should amend article 16.2 of the Code of Criminal Procedure to ensure that any evidence or information derived from statements obtained through torture or ill-treatment is not admissible as evidence in law and in practice. The State party should also continue to improve, and provide, mandatory training for law enforcement and intelligence personnel on the provisions of the Convention, in particular on the absolute prohibition of torture and ill-treatment, and on non-coercive interrogation and investigation techniques, including the Principles on Effective Interviewing for Investigations and Information Gathering (the Méndez Principles), introduce advanced investigative tools and establish a system for the collection of

<sup>235</sup> A/HRC/46/9, paras. 116.4 and 116.50–116.56, read in conjunction with A/HRC/46/9/Add.1, para. 3.



**forensic evidence, in order to strengthen the shift from a confession-based to an evidence-based system.**

### **Complaints mechanisms in places of deprivation of liberty**

19. While noting the installation of complaint boxes in prisons and detention facilities, which are regularly checked by the prosecutors during their visits, the Committee is concerned at reports received that many persons deprived of their liberty are unaware that they can lodge complaints of torture or ill-treatment or are reluctant to do so due to fear of reprisals or intimidation. The Committee notes the information provided in the State party's report that detainees can lodge their complaints through the administration of the detention facility, which raises concerns about the protection of their confidentiality (arts. 2, 12, 13 and 16).

**20. The State party should take steps to strengthen the existing complaints mechanisms by ensuring that victims of torture and ill-treatment in all places of deprivation of liberty have effective, confidential and unhindered access to them, and information about these mechanisms should be transparent and widely disseminated; and neither the guards nor the officers of the facility should play any role in the collection or transmission of complaints. The State party should ensure that complainants are protected from any intimidation or reprisals as a result of their complaints.**

### **Conditions of detention**

21. While appreciating the measures taken by the State party to introduce alternatives to detention and noting its efforts to build pretrial detention facilities and to improve the material conditions in prisons, the Committee observes with concern reports received concerning:

(a) Poor and unhygienic conditions, as well as inadequate sanitary facilities, which persist in several prisons and remand centres, and persisting deficiencies in the material conditions, such as poor sanitation facilities and ventilation in police stations and sobering up facilities; the Committee also notes the information provided by the State party about the national standard of living space, which can be as low as 2 square metres per detainee;

(b) Inadequate healthcare services, including the lack of psychosocial services, and insufficient support provided to detainees with psychosocial disabilities, as well as inadequate access to reproductive health services for female detainees due to the lack of healthcare staff and of the necessary medical equipment. In this regard, the Committee acknowledges the efforts made by the State party to modernize 22 per cent of medical equipment during the reporting period;

(c) Deaths in custody due to illness, with contributing factors such as delays in the detection of illness and inadequate training of medical personnel in this regard;

(d) The lack of reasonable accommodation provided for persons with physical disabilities in prisons, and the remote location of the women's prison facility located in Ulaanbaatar, which constitutes an obstacle to family visits from remote regions;

(e) The overly punitive and disciplinary approach, as well as insufficient rehabilitation, resocialization and reintegration programmes and meaningful activities

in places of deprivation of liberty, as noted by the Subcommittee on Prevention of Torture<sup>236</sup> (arts. 2, 11 and 16).

## **22. The State party should:**

**(a) Improve existing prison facilities and material conditions to bring them into line with the United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners (the Nelson Mandela Rules) and take steps to ensure minimum international standards of living space for each detainee;**

**(b) Make greater use of non-custodial measures, such as parole and early release, in accordance with the United Nations Standard Minimum Rules for Non-custodial Measures (the Tokyo Rules) and the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (the Bangkok Rules);**

**(c) Adopt specific measures to provide individualized reasonable accommodation and accessibility in prisons to persons with disabilities;**

**(d) Take steps to ensure that women prisoners have adequate opportunities to maintain relations with their families, in particular where they have minor children, by taking the necessary measures to enable such visits and to increase inmates' contact with the outside world, including by allowing them to make frequent telephone calls;**

**(e) Strengthen its efforts to ensure that sufficient resources, including appropriate medical staff, are allocated to provide prisoners with adequate healthcare, in particular mental healthcare and reproductive healthcare, and redouble its efforts to improve the necessary medical equipment;**

**(f) Conduct an evaluation of the punitive and retributive approach in the criminal justice system and introduce the necessary changes to move from a punitive model to one of rehabilitation and reintegration of persons deprived of their liberty as part of effective efforts to protect them from torture and cruel, inhuman or degrading treatment, by providing rehabilitation and reintegration programmes, including meaningful activities, vocational training and education.**

### **Disciplinary sanctions for persons deprived of liberty**

23. The Committee is concerned that, under articles 227.1.1 and 228.1 of the Law on the Enforcement of Court Decisions, the right to meet or make phone calls can be restricted for up to three months as a disciplinary measure and solitary confinement can be imposed for up to 30 days, and in exceptional cases for up to 60 days for male prisoners, as a disciplinary sanction, accompanied by excessive and punitive restrictions (arts. 2, 11 and 16).

**24. The State party should bring articles 227.1.1 and 228.1 of the Law on the Enforcement of Court Decisions and the practice of disciplinary sanctions, in particular the prohibition of family contact and solitary confinement, into line with international standards, in particular rules 43 to 46 of the Nelson Mandela Rules. In this context, disciplinary sanctions or restrictive measures should not include the prohibition of**

<sup>236</sup> See <https://www.ohchr.org/en/press-releases/2024/05/mongolia-paradigm-shift-towards-rehabilitative-approach-needed-effective>.

**family contact, except when imposed for a limited period of time and when strictly required for the maintenance of security and order, and solitary confinement should be imposed only in exceptional cases as a last resort, for the shortest possible period of time (not exceeding 15 days) and subject to independent review, and only with the authorization of a competent official and under the daily supervision of a healthcare professional.**

### **Special closed unit**

25. While noting the commutation of all death sentences to long-term imprisonment following the abolition of the death penalty, the Committee is concerned about the special restrictive regime imposed on persons serving their sentences, including life imprisonment, in the special closed unit (Prison No. 405), and their isolation in prolonged solitary confinement, the practice of handcuffing and shackling them outside their cells, the extremely limited contact with other inmates as well as with the outside world, and the lack of access to work and adequate rehabilitation programmes. Moreover, the Committee observes with concern that inmates with intellectual or psychosocial disabilities who, as explained by the delegation are not in a stable condition, can be placed in solitary confinement for a period of time as a protective measure in this facility (arts. 2, 4, 11–14 and 16).

**26. The State party should develop appropriate measures to review the detention regime in the special closed unit (Prison No. 405), including for prisoners serving long sentences, and bring it into line with international human rights standards, such as the Nelson Mandela Rules, notably rule 43 (1) (b). In this regard, it should ensure that prisoners serving long sentences have access to a regime of organized and purposeful out-of-cell activities, with a view to preventing the deterioration of their mental faculties and social abilities, and take measures to integrate them into the general prison population. The Committee would like to draw the State party's attention to rule 45 (2) of the Nelson Mandela Rules, which prohibits the use of solitary confinement in the case of prisoners with intellectual or psychosocial disabilities if their condition would be exacerbated by such measures.**

### **Juvenile justice**

27. The Committee takes note of the State party's efforts to improve the situation of children in conflict with the law, including through legislative measures and capacitybuilding activities for judges, among others. However, it regrets the slow progress in establishing a comprehensive juvenile justice system since the previous periodic review. Furthermore, the Committee notes with concern the situation of children detained in general pretrial detention facilities, where they do not have access to adequate educational and recreational activities, which is not the case for convicted child offenders. It is also concerned about inadequate material conditions for the accommodation of children in conflict with the law in the Special Training and Education Centre in Ulaanbaatar. Lastly, the Committee regrets the absence of comprehensive information on the non-custodial alternatives to detention applied in practice to child offenders (arts. 2, 11 and 16).

**28. The State party should strengthen its efforts to bring its juvenile justice system fully into line with the relevant international standards. In particular, the State party should promote alternatives to detention and ensure that detention is used as a**

measure of last resort and for the shortest possible period of time and is regularly reviewed with a view to its withdrawal, in accordance with the United Nations Standard Minimum Rules for the Administration of Juvenile Justice (the Beijing Rules). Furthermore, the State party should:

(a) Proceed without delay with establishing the specialized juvenile court and its procedures, provide it with adequate human, technical and financial resources, appoint specialized judges for children and ensure that such specialized judges receive appropriate and continuous training;

(b) Improve access to education, rehabilitation and social reintegration programmes for children detained in pretrial detention facilities and ensure that the staff are appropriately trained;

(c) Take measures to improve, as a matter of urgency, the living conditions in centres of deprivation of liberty for children and adolescents in terms of sanitation and hygiene.

### **Persons with disabilities**

29. While welcoming the adoption of the Mental Health Comprehensive Action Plan (2024–2027), the Committee is concerned at the inadequate allocation of resources for its implementation. It also observes with concern the involuntary hospitalization of persons with disabilities on the basis of impairment. The Committee further observes with concern the lack of community-based services for persons with psychosocial disabilities, resulting in their subsequent long-term hospitalization in the National Centre for Mental Health, often without their informed consent. Furthermore, the information on the situation of forensic patients held in the closed acute psychiatric ward, their prolonged isolation, and the lack of staff and support services, as well as the reported lack of access to effective complaints mechanisms in psychiatric institutions, are matters of concern (arts. 2, 11, 13 and 16).

**30. The Committee recommends that the State party allocate sufficient resources for the effective implementation of the Mental Health Comprehensive Action Plan (2024–2027), intensify its efforts to avoid involuntary admissions to closed institutions on the basis of impairment and develop a policy of deinstitutionalization in the form of alternative and community-based support services and other forms of outpatient care programmes throughout the territory of the State party. It should also adopt measures to improve the situation of forensic patients held in closed wards, including by investing in staff reinforcement, non-custodial measures and community-based services, and establish an effective, independent, confidential and accessible complaints mechanism for persons with disabilities in psychiatric institutions.**

### **Redress**

31. The Committee takes note of the revision of the Law on the Government Special Fund in 2019, which provides for the right to seek compensation for acts of torture, and of the regulations adopted in this regard. The Committee observes, however, that no victim of torture has yet been compensated under this law, and only a few recognized survivors of torture have managed to obtain monetary compensation from the convicted perpetrators, as stated by the delegation. The Committee is concerned at reports that the above-mentioned law lacks clear procedures for calculating damages and ensuring fair and adequate compensation, and that it does not cover non-pecuniary damages

and survivors have to resort to other legal means for this purpose. The Committee takes note of the adoption of the Forensic Law in 2022, under which 668 victims of crimes have so far received compensation for psychological and moral damage, but regrets to observe that no court order has yet been issued in this regard for torture victims, although, according to the State party's statistics, four torture survivors have their claims pending. The Committee regrets that there are no ongoing comprehensive reparation programmes for victims of torture and ill-treatment available in the State party. The Committee draws the attention of the State party to its general comment No. 3 (2012) on the implementation of article 14, in which it elaborated on the nature and scope of the obligations of States parties under the Convention to provide full redress to victims of torture (art. 14).

**32. The Committee recommends that the State party take steps to establish comprehensive reparation programmes, under which victims of torture obtain redress and have an enforceable right to fair and adequate compensation, including the means for rehabilitation as fully as possible, including trauma treatment and other forms of rehabilitation, for victims of torture and ill-treatment, and that it allocate adequate resources to ensure the effective functioning of such programmes. In addition, the State party should take further steps to establish clear procedures for identifying victims of torture and awarding of adequate and fair pecuniary and non-pecuniary compensation for physical and mental suffering as a result of torture.**

#### **Non-refoulement**

33. While noting that article 1.7 (3) of the Criminal Code prohibits the extradition of foreign nationals or stateless persons for the purpose of investigation or punishment of an offence where there is a risk of torture or the imposition of death penalty, the Committee remains concerned that several bilateral and multilateral agreements concluded by the State party, including those signed with Belarus and Kazakhstan in 2018 and 2019 respectively, contain broadly worded provisions which do not seem to specifically cover instances related to sufficient grounds to consider a risk of torture. Furthermore, the Committee notes with concern that the State party has not acceded to the international conventions on the rights of refugees and stateless persons, and that its domestic legislation, the Constitution and the Law on the Legal Status of Foreign Citizens do not provide a sufficient framework for a national asylum determination procedure that allows for a thorough individual assessment of whether there is a substantial risk that the applicant would be subjected to torture in the country of destination. While noting the statistics provided by the State party on the expulsion of 1,360 foreign nationals between 2020 and 2024, the Committee regrets the absence of statistics on asylum applications received and refugee status granted during the period under review, the reportedly low rate of refugee recognition in the State party and the lack of a registration database of migrants and stateless persons (arts. 2, 3 and 16).

**34. The State party should ensure that no one may be expelled, returned or extradited to another State where there are substantial grounds for believing that he or she would run a personal and foreseeable risk of being subjected to torture. In particular, the State party should take all necessary steps to bring its bilateral and multilateral agreements on extradition into conformity with the principle of nonrefoulement. The State party should further take all legislative steps to establish comprehensive national asylum legislation and procedures that provide effective protection to asy-**

**lum-seekers and refugees against refoulement to a State where there are substantial grounds for believing that they would be in danger of being subjected to torture or ill-treatment, in accordance with article 3 of the Convention. The State party should consider acceding to the 1951 Convention relating to the Status of Refugees and its 1967 Protocol, the 1954 Convention relating to the Status of Stateless Persons and the 1961 Convention on the Reduction of Statelessness.**

#### **Protection of human rights defenders**

35. While noting the adoption of the Law on the Legal Status of Human Rights Defenders in 2021, the Committee is concerned about its inadequate implementation in practice, as well as about several problematic legal provisions and vague and broad wording contained in the law, as identified by the Working Group on Arbitrary Detention during its visit in 2022,<sup>237</sup> which might hamper the work of human rights defenders and expose them to criminalization for their activities (arts. 2 and 16).

**36. The State party should adopt effective measures to amend vaguely and broadly worded legal provisions of the Law on the Legal Status of Human Rights Defenders in order to ensure that they are not misused to criminalize the work of human rights defenders.**

#### **Gender-based violence, including domestic violence**

37. The Committee notes the increase in the number of one-stop service centres and shelters for victims of domestic and sexual violence, the establishment of the hotline and the capacity-building activities carried out to combat domestic violence, as well as the criminalization of marital rape in the Law on Combating Domestic Violence. However, the Committee remains concerned at the insufficient resources allocated for the effective implementation of this law and at the low number of prosecutions and convictions compared to the high estimated number of cases of domestic violence, while acknowledging the initial steps taken by the State party to establish the specialized courts in this area. In addition, it notes with concern the inadequacy of support services for victims, including medical and legal services and shelters, particularly in rural areas, although it acknowledges the ongoing efforts to address these shortcomings (arts. 2, 12–14 and 16).

**38. The State party should strengthen measures to prevent domestic and sexual violence and ensure that mechanisms are in place to encourage victims of sexual and gender-based violence to come forward, that all allegations of violence are promptly, thoroughly and effectively investigated, that perpetrators are held accountable, and that victims obtain adequate redress and have access to adequate medical and psychosocial support. It should further continue its efforts to establish the specialized courts to deal with cases of gender-based violence, including domestic violence and marital rape, and ensure that survivors and/or their families are protected and have access to medical and legal services, redress and rehabilitation, including adequate compensation, and to adequately funded shelters throughout the country.**

#### **Trafficking in persons**

39. While acknowledging the State party's ongoing efforts to combat trafficking in persons, the Committee remains concerned that the phenomenon is still prevalent, no-

<sup>237</sup> A/HRC/54/51/Add.2, paras. 23–25.



tably child trafficking and trafficking for the purpose of sexual and labour exploitation. The Committee is also concerned about the limited number of cases investigated and prosecuted, the reported shortcomings in the detection of victims, particularly among migrants and in rural communities, the alleged revictimization throughout the identification process, and the insufficient training provided to all officials who might detect signs of trafficking, including in the labour market, although it takes note of various capacity-building initiatives carried out for police officers, doctors and social workers. Furthermore, the Committee is concerned about the insufficient resources allocated to the multidisciplinary task force for identifying, protecting and assisting victims of trafficking, and about the lack of comprehensive support services available to all victims of trafficking, including access to shelters (arts. 2, 12–14 and 16).

**40. The State party should continue adopting measures to combat and prevent all forms of trafficking in persons, and ensure that such cases are thoroughly investigated, that suspected perpetrators are prosecuted and, if convicted, sentenced to appropriate penalties, and that victims obtain full redress, including adequate compensation and rehabilitation. The State party should strengthen its efforts to encourage the reporting of cases by raising awareness of the risks of trafficking among the general population and by training judges, law enforcement officials, immigration and border control officers, labour inspectors and social workers in the early detection and identification of victims of trafficking and their referral to appropriate psychosocial and legal services. The State party should further ensure the allocation of sufficient resources for the implementation of prevention, protection and victim assistance programmes, including for the multidisciplinary task force, and access to shelters throughout the territory.**

#### **Violence and abuse against individuals on the basis of their actual or perceived sexual orientation or gender identity**

41. The Committee notes with concern violence and abuse against individuals on the basis of their actual or perceived sexual orientation or gender identity, and the negative attitudes towards these individuals by health professionals when they receive treatment and by the police when they report violent incidents, as well as the lack of effective investigations into such cases (arts. 2 and 16).

**42. The State party should take effective measures to prevent violence based on actual or perceived sexual orientation or gender identity, and ensure that all acts of violence are promptly, effectively and impartially investigated and prosecuted, that perpetrators are brought to justice and that victims are provided with redress.**

#### **Corporal punishment of children**

43. While welcoming the significant legislative steps taken by the State party to prohibit and combat corporal punishment of children in all settings, the Committee is concerned at the reports documenting a high rate of violent disciplinary practices against children that persist in the country (art. 16).

**44. The State party should take all necessary measures to prevent corporal punishment of children, including by ensuring that these acts are investigated, that perpetrators are brought to justice and that victims are granted redress, and redouble its efforts to conduct awareness-raising and educational campaigns for the general**

**public to inform them about the prohibition of the use of corporal punishment against children and the consequences of such punishment.**

### **Abuses in the military**

45. The Committee is concerned at the reported increase in cases of discrimination, torture and ill-treatment, including beatings, of conscripts in the armed forces and at the lack of effective monitoring of military units (arts. 2 and 16).

**46. The State party should ensure effective investigations into all allegations of acts of torture and ill-treatment of personnel in the army, prosecute and punish those responsible with appropriate penalties, and provide victims and their families with redress, and adopt all necessary measures aimed at preventing these acts, including through monitoring of the military units by independent bodies, such as the national preventive mechanism.**

### **Training**

47. While acknowledging the human rights training activities offered to law enforcement and prison officers, lawyers, judges and health professionals, the Committee is concerned about the reported shortcomings in medical evaluations in cases of torture and ill-treatment due to the lack of knowledge and training provided to medical professionals to detect signs and sequelae of physical or psychological torture (art. 10).

**48. The State party should continue to develop and implement mandatory initial and in-service training programmes for all relevant persons, including law enforcement officers, judicial officials and prison staff, and in particular medical professionals, so that they are properly trained to identify cases of torture and ill-treatment, in accordance with the Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (Istanbul Protocol), as revised. The State party should also take measures to define the obligation for doctors working in the criminal justice system to assess and detect possible signs of torture and ill-treatment as part of the medical service provided.**

### **Follow-up procedure**

49. The Committee requests the State party to provide, by 22 November 2025, information on follow-up to the Committee's recommendations on the definition of torture, fundamental legal safeguards, and ineffective investigation of acts of torture and ill-treatment (see paras. 8, 10 (a) and (d) and 16 (a) above). In that context, the State party is invited to inform the Committee about its plans for implementing, within the coming reporting period, some or all of the remaining recommendations in the concluding observations.

### **Other issues**

50. The Committee encourages the State party to consider making the declaration under articles 21 and 22 of the Convention recognizing the competence of the Committee to receive and consider inter-State communications and communications from or on behalf of individuals subject to its jurisdiction who claim to be victims of a violation by the State party of the provisions of the Convention.

51. The State party is requested to widely disseminate the report submitted to the Committee and the present concluding observations, in appropriate languages,

through official websites, the media and non-governmental organizations and to inform the Committee about its dissemination activities.

52. The Committee requests the State party to submit its next periodic report, which will be its fourth, by 22 November 2028. For that purpose, and in view of the fact that the State party has agreed to report to the Committee under the simplified reporting procedure, the Committee will, in due course, transmit to the State party a list of issues prior to reporting. The State party's replies to that list of issues will constitute its fourth periodic report under article 19 of the Convention.

НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН III ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭЭД ЗАСГИЙН ГАЗАРТ ИРҮҮЛСЭН  
НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ХОРООНЫ ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ (албан бус  
орчуулга, монгол хэлээр)

United Nations

CAT/C/MNG/CO3\*



Convention against Torture  
and Other Cruel, Inhuman  
or Degrading Treatment  
or Punishment

Distr.: General  
11 December 2024

Original: English

## Эрүүдэн шүүхийн эсрэг хороо

### Монгол Улсын ээлжит гурав дахь илтгэлийн ажиглалт, дүгнэлт\*

1. Хороо нь 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд хуралдсан Монгол Улсын<sup>238</sup> ээлжит гурав дахь илтгэлийг 2157, 2160 дугаар хуралдаанаараа<sup>239</sup> хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа энэхүү урьдчилсан ажиглалт, дүгнэлтийг баталлаа.

#### А. Оршил

2. Оролцогч улс болон Хорооны хамтын ажиллагааг сайжруулах, тайланг судлах, төлөөлөгчидтэй яриа хэлцэл хийхэд зориулсан хялбаршуулсан журмыг хүлээн авч, түүний дагуу тогтмол тайлангаа ирүүлж байгаад нь Оролцогч улсад талархаж буйгаа Хороо илэрхийлж байна.

3. Оролцогч улсын төлөөлөгчидтэй хийсэн ажил хэрэгч яриа хэлэлцээ болон Хорооноос дэвшүүлсэн асуудалд аман хариулт, бичгээр ирүүлсэн мэдээллийг Хороо сайшааж байна.

#### Б. Эерэг талууд

4. Хороо нь конвенцод хамаарах салбарын хууль, тогтоомжийг шинэчлэн боловсруулж нэвтрүүлэх талаар гаргаж буй Оролцогч улсын санаачилгыг мөн сайшааж байна.

(а) Нийслэл Улаанбаатар хотод гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх байгуулахаар тусгасан Шүүх байгуулах тухай хуулийг 2024 онд батлах;

<sup>238</sup> \* Хорооны наян нэгдүгээр чуулганаар (2024 оны 10 дугаар сарын 28-аас 11 дүгээр сарын 22) баталсан. CAT/C/MNG/3.

<sup>239</sup> CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх

(б) Эцэг эх, харгалзан хамгаалагч болон бусад этгээдийн зүгээс хүүхдэд бие махбодын шийтгэл үзүүлэх, нэр төрийг нь доромжлохыг хориглосон Хүүхэд хамгааллын тухай хуулийг 2024 онд батлах;

(в) 2024 онд батлах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл “хугацаагүй баривчлах” заалтыг хүчингүй болгож, сэжигтнийг нэн даруй баривчлах, шүүгчийн зөвшөөрөл авах, үндэслэлгүй тохиолд зөвшөөрөл авахаас татгалзах үндэслэлийг нарийвчлан тайлбарлах шаардлагыг тусгасан;

(г) 2024 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, хорихоос өөр төрлийн ялыг нэвтрүүлэх;

(д) Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгохоор заасан Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг 2020 онд шинэчлэн найруулсан;

(е) Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцсон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 онд шинэчлэн найруулсан.

5. Оролцогч улсын хүний эрхийг илүү хамгаалах, конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, журамдаа өөрчлөлт оруулах санаачилгыг Хороо сайшааж байна, тухайлбал:

(а) Сэтгэцийн эрүүл мэндийн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө (2024-2027) батлагдсан;

(б) Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай (2023-2027);

(в) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026) батлагдсан;

(г) Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/301 дүгээр тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийг байгуулсан;

(д) 2018 онд цагдаагийн дуудлага, бүртгэлийн системд Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн нэгдсэн сан (eGBV) бий болсон.

### **С. Анхаарал хандуулах асуудал, зөвлөмжүүд**

#### **Өмнөх тайлангийн мөчлөгийн хүлээгдэж буй асуудлууд**

6. Хороо өмнөх дүгнэлтийнхээ<sup>240</sup> үеэр иргэний хууль эрх зүйн үндсэн баталгааг хүндэтгэх<sup>241</sup>, эрүү шүүлт тулгасан үйлдлийг ял шийтгэлгүй орхигдуулахгүй байх<sup>242</sup> асуудлаарх зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээнийхээ талаар мэдээлэл өгөхийг Оролцогч улсаас хүссэн. Хорооноос хүссэн мэдээллийн талаарх 2018 оны 5 дугаар сарын 27-ны<sup>243</sup> өдөр ирүүлсэн хариу, мөн тус хорооны илтгэгчийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ажиглалт, дүгнэлтийн мөрөөр ирүүлсэн албан бичиг<sup>244</sup>, түүнчлэн ээлжит гурав дахь удаагийн

<sup>240</sup> CAT/C/MNG/CO/2, para. 41

<sup>241</sup> Ibid., para. 12 (a)–(d).

<sup>242</sup> Ibid., para. 16 (a)–(d).

<sup>243</sup> CAT/C/MNG/CO/2/Add.1.

<sup>244</sup> [https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2F-](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2F-)

тайланд тусгагдсан мэдээллээс дүгнэн эдгээр зөвлөмжийг зөвхөн хэсэгчлэн хэрэгжүүлсэн гэж Хороо үзэж байна. Өмнөх ажиглалт, дүгнэлтэд дурдсан шийдэгдээгүй асуудлуудыг энэхүү баримт бичгийн 9, 10, 15, 16-р зүйлд тусгасан болно.

### **Эрүү шүүлтийн тодорхойлолт**

7. Хэдийгээр Оролцогч улсын төлөөлөгчид эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг шинэчлэх явц болон хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа тухай өгсөн мэдээлэлд талархаж байгаа боловч, 2017 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 21.12 дугаар заалтад эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг гэж үзэхийг зорьсон боловч энэ гэмт хэргийн тодорхойлолт нь Конвенцын 1 дүгээр зүйлд бүрэн нийцэхгүй хэвээр байгаад Хороо санаа зовниж байна. Үүнтэй холбогдуулан Хорооноос одоогийн мөрдөж байгаа 21.12 дугаар заалтын дараах дутагдалтай талуудыг анхааруулж байна: нэгдүгээрт, энэ заалт нь хохирогч болон гуравдагч этгээдийг айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор үйлдсэн эрүү шүүлт тулгах үйлдлийг тусгайлан заагаагүй; хоёрдугаарт, төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад этгээдийн өдөөн хатгалга, ил, далд зөвшөөрлөөр үйлдсэн эрүү шүүлт тулгах үйлдлүүдийг хамааруулаагүй; гуравдугаарт, доод шатны албан тушаалтнууд нь эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцсан үйлдлийг мэдсэн эсвэл мэдэж байх ёстой байсан ч урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ аваагүй дээд шатны албан тушаалтнуудад эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй; дөрөвдүгээрт, эрүү шүүлт тулгахыг завдах, эрүү шүүлт тулгахад хамтран оролцох үйлдлийг хамааруулаагүй; тавдугаарт, эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж болох бөгөөд энэ нь гэмт хэргийн хүнд байдалд үл нийцэх ял юм. Түүгээр ч зогсохгүй Эрүүгийн хуулийн 1.10 (1 ба 4-р зүйл)-ын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх тодорхой хүндрүүлэх нөхцөл байдалд бүх насаар нь хорих ял оногдуулахаас бусад тохиолдолд эрүү шүүлт тулгасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэх, хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд шууд үгүйсгээгүйд тус хороо санаа зовж байна.

**8. Оролцогч улс Эрүүгийн хуулийн 21.12-т өөрчлөлт оруулж, Конвенцын 1 дүгээр зүйлд заасан эрүү шүүлтийн бүх хэлбэр, тэр дундаа хохирогчийг, эсхүл гуравдагч этгээдийг айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдсэн эрүү шүүлт тулгах бүх үйлдлийг хориглох хэрэгтэй. Оролцогч улсын хууль тогтоомжид доод албан тушаалтнуудынхаа үйлдсэн эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан үйлдлүүдийг мэдэж байсан буюу мэдэж байх ёстой байсан ч түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ аваагүй дээд албан тушаалтнуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгах ёстой. Хууль нь Конвенцын 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүү шүүлт тулгахыг завдсан, эрүү шүүлт тулгахад хамтран оролцсон аливаа үйлдэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхой зааж өгөх ёстой. Конвенцын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүнд мөн чанарыг харгалзан зохих шийтгэл оногдуулахыг Оролцогч улсад баталгаажуулахыг Хороо зөвлөж байна. Эцэст нь, эрүү шүүлтийн аливаа үйлдлийг өршөөлд хамруулахгүй, хөөн хэлэлцэх хугацааг баталгаажуулахын**



**тулд шаардлагатай хууль тогтоомжийн арга хэмжээг авахыг Хорооноос зөвлөж байна.**

### **Хууль эрх зүйн үндсэн хамгаалалтууд**

9. Хороо нь өмнөх дүгнэлтүүд, түүнчлэн ажиглалт дүгнэлтийн 245 мөрөөр хийсэн Хорооны илтгэгчийн хийсэн үнэлгээг харгалзан, Оролцогч улс процессын эрх зүйн хамгаалалтыг цаашид бэхжүүлэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2024 онд шинэчлэн найруулах талаар хүчин чармайлт гаргаж байгааг онцолж байна. Гэсэн хэдий ч дараах дутагдалтай талууд тайланд тусгагдсан байгаад санаа зовж байна.

(а) Хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагаанд шүүхийн хяналтыг сайжруулахад авсан болон авахаар төлөвлөсөн арга хэмжээний талаар төлөөлөгчид тайлбарласныг Хороо анхааралдаа авсан, хэдий тийм ч прокурорын зөвшөөрлөөр, шүүхийн шийдвэргүйгээр (хойшлуулшгүйгээр баривчлах гэж нэрлэдэг) ялангуяа Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар маш олон баривчлах ажиллагаа явуулсан хэвээр байгааг дурдаж байна.

(б) Оролцогч улсаас хууль зүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгох талаар хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч өмгөөлөгч авах эрхийг хангах ажил удааширч, зохих хууль зүйн туслалцаа үзүүлэх, ялангуяа алслагдсан бүс нутагт хүндрэлтэй байгаа талаар мэдээлсэн. Нэмж дурдахад, төлөөлөгчдийн мэдээлэлд эсрэгээр тэмдэглэгдсэн байгаа боловч өмгөөлөгчид үйлчлүүлэгчдийнхээ хэргийн бүрэн материалтай танилцах эрхгүй байна;

(в) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд баривчлагдсан этгээдийн төрөл садан, хууль ёсны төлөөлөгчдөө мэдэгдэхийг, түүнчлэн хүүхдийн тухайд мөн адил (18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг) зургаан цаг хүртэл хойшлуулахыг зөвшөөрдөг (31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг);

(г) Цагдаагийн байгууллагаас гэрчээр дуудагдсан хүмүүсээс мэдүүлэг авах ажиллагааг албан ёсны мэдүүлэг авах өрөөнөөс гадуур явуулж байгаа хэдий ч энэ үйлдлийг одоо устсан гэж төлөөлөгчид Хороонд мэдээлсэн; Тайланд дурдсанаар эдгээр ярилцлагын үеэр өөрийнх нь эсрэг эсвэл өмгөөлөгчийн оролцоогүйгээр албадан мэдүүлэг авах нь элбэг бөгөөд ихэнхдээ шууд баривчлахад хүргэдэг;

(е) Бүх мэдүүлгийг зохих ёсоор бүртгэдэггүй, хаана байгаа нь мэдэгдэхгүй, бичлэгүүдийг зохих ёсоор хамгаалж, зохих хугацаанд хадгалаагүй; Оролцогч улсаас 849 мэдүүлэг авах өрөөг аль хэдийн тохижуулсан гэж өгсөн мэдээллийг Хороо өндрөөр үнэлж байгаа хэдий ч ярилцлага, мэдүүлгийн бүх өрөө, ялангуяа алслагдсан бүс нутагт дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжөөр хангагдаагүй байна;

(е) Цагдан хорих хугацаа зарим үед хуулиар тогтоосон 48 цагаас хэтэрдэг; Цагдан хорих байранд шилжүүлсэн тохиолдолд 24 цаг хүртэл хугацаагаар эрүүлжүүлэх байранд байх хугацааг ихэвчлэн 48 цагийн хязгаарт тооцдоггүй (2 дугаар зүйл).

### **10. Хороо оролцогч улсаас дараах зүйлийг хийхийг уриалж байна:**

**(а) гэмт хэргийн газарт баривчлагдсанаас бусад тохиолдолд баривчлах ажиллагааг явуулахын тулд шүүхийн байгууллагаас гаргасан баривчлах**

245 CAT/C/MNG/CO/2, paras. 11-12.

шийдвэрийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудаас шаардах бүх арга хэмжээг авах;

(б) Албан бусаар асуугдах, мэдүүлэг өгөхөөр цагдаагийн газарт дуудагдсан хүмүүсийг оролцуулан эрх чөлөөгөө хасуулсан бүх хүмүүст эрх чөлөөгөө хасуулсан эхний мөчөөс эхлэн хууль эрх зүйн бүх үндсэн баталгааг бодитоор хангаж, ялангуяа өөрийн сонголтоор хараат бус өмгөөлөгчтэй уулзах боломжоор хангах, шаардлагатай бол олон улсын стандартын дагуу зохих чанарын хууль зүйн туслалцаа, түүний дотор анхны мэдүүлгийн үед үнэ төлбөргүй үзүүлэх;

(в) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар баривчлагдсан этгээд нэн даруй баривчлагдсан тухайгаа төрөл садан болон бусад хүнд мэдэгдэх эрхийг баталгаажуулах;

(г) Улс орны өнцөг булан бүрд байгаа мэдүүлгийн бүх өрөөг дуу-дүрсний бичлэгийн хэрэгслээр тоноглох хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, цагдан хорих газарт мэдүүлэг өгөх, ярилцлага, гэрчийн мэдүүлгийн үед системтэй бичлэг хийх эрхийг баталгаажуулах, ийм бичлэгийг зааварчилгааны дагуу найдвартай байгууламжид зохих хугацаанд хадгалах; эрүү шүүлт болон бусад хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг илрүүлэх, шалгах зорилгоор бичлэгийг хянах эрхийг шүүгдэгч болон тэдгээрийн өмгөөлөгч, прокурор, хяналтын бусад байгууллагад нээлттэй байлгах, шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах боломжийг бүрдүүлэх;

(д) Гэрчээр мэдүүлэг өгч хүмүүс өөрийгөө буруутгах, албадан мэдүүлэг өгөхөөс хамгаалах арга хэмжээ авч, шүүх ийм мэдүүлэг өгсөн нөхцөл байдлыг шалгаж, хэрэг тулган хүлээлгэсэн тухай нэхэмжлэл гаргасан тохиолдолд нэхэмжлэлийг сайтар шалгаж дуустал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;

(е) Цагдаагийн албадан саатуулах дээд хугацааг 48 цагаас хэтрүүлэхгүй байх, баривчлагдсан тохиолдолд эрүүлжүүлэх байранд байх зэрэг эрх чөлөөг нь бодитоор хассан хугацааг 48 цагт тооцох;

(ж) Хууль эрх зүйн үндсэн баталгааг хангаагүй талаар хүлээн авсан гомдлын тоо, уг гомдлын үр дагавар, тэр дундаа эрх зүйн үндсэн баталгааг хангаагүй албан тушаалтанд авсан сахилгын арга хэмжээний талаарх мэдээллийг Хороонд хүргүүлэх ээлжит тайландаа тусгах.

### **Урьдчилан хорих**

11. Оролцогч улс тайлант хугацаанд урьдчилан хорих эрх зүйн орчныг боловсронгуй болгосон гээд, тухайлбал баривчлах ялын дээд хязгаарыг 12 сар, яллах боломжтой хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 18 сар хүртэл хугацаагаар хязгаарласан нэмэлт, өөрчлөлт оруулсан болохыг тэмдэглэхийн хамт шүүх ажиллагаа хэт уртассаны улмаас ийнхүү цагдан хорих нь хуульд заасан хэмжээнээс байнга давж байна гэсэн мэдээлэлд Хороо санаа зовниж байна. Хороо нь үүнтэй холбогдуулан 2025 онд шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтын талаар өгсөн Оролцогч улсын тайлбарыг чухалд авч үзэж байгаа ба энэ нь шүүх хуралдааны үргэлжлэх хугацаа болон урьдчилан хорих хугацааг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах боломжтой юм.

12. Оролцогч улс урьдчилан баривчлах тухай заалтыг даган мөрдөж, зайлшгүй болон пропорциональ байх зарчмыг харгалзан ийм баривчлах ажиллагааг зөвхөн онцгой нөхцөл байдал, хязгаарлагдмал хугацаагаар хэрэглэхийг баталгаажуулах ёстой. Мөн шүүх хуралдаан хэт уртассаны улмаас цагдан хорих хугацааг сунгадаг байдлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлж, боломжтой бол НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм), НҮБ-ын Эмэгтэй хоригдлуудтай харьцах, гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах дүрэм (Бангкокийн дүрэм)-ийн дагуу урьдчилан хорихоос өөр төрлийн цахим хяналт, зорчих эрхийг хасах, гэрийн хорио, батлан даалтад гаргах зэрэг урьдчилан хорихоос өөр хувилбаруудыг илүү ашиглах хэрэгтэй.

#### **Үндэсний урьдчилан сэргийлэх механизм**

13. Хороо нь Хүний эрхийн үндэсний байгууллага болох Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын нэгжийг 2022 онд томилсныг сайшааж байна. Гэвч дараах дутагдалтай талуудыг анхааруулж байна: нэгдүгээрт, үндэсний ажиллагааны бүрэн эрхэд хамаарах үйл ажиллагаа, тухайлбал, Оролцогч улсын газарзүйн байрлал, сорилтуудын нөхцөлд хяналт шинжилгээ хийхэд хүний нөөц нь хязгаарлагдмал, төрөл бүрийн мэргэжилтнээс бүрдээгүй, албан хаагчид нь чиг үүргээ бие даан хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ойлгомжтой бөгөөд тодорхой чиг үүргийн дархлаа байхгүй; хоёрдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комиссын нэгдсэн төсөвт төсвийн тусдаа зориулалт байхгүй, төсвийн бие даасан байдал байхгүй; Гуравдугаарт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын тайлбар нь тус механизмыг зөвхөн уг жагсаалтаар хязгаарлагдсан эрх чөлөөгөө хасуулах газруудад нэвтрэх боломжийг олгосон (2 дугаар зүйл).

14. Оролцогч улс Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын чадавхыг бэхжүүлэхийн тулд дараах арга хэмжээ авах: (а) түүнийг санхүүгийн болон хүний нөөцөөр хангах, тэр дундаа Конвенцын Нэмэлт протоколын дагуу эрх чөлөөгөө хасуулсан бүх төрлийн газарт үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжилтнүүд зэрэг мэргэшсэн олон талт хүний нөөцөөр хангах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай дархлааг хуулиар тогтоох; (б) Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвөөс бие даасан байдлыг хангах; (в) Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33.1.1 дэх хэсэг, түүний тайлбарт Конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлд заасны дагуу болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ерөнхий тайлбарын 1-д246 тусгаснаар эрх чөлөөгөө хасуулсан газрын иж бүрэн жагсаалтыг багтааж, нэмэлт, өөрчлөлт оруулах.

Эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцсан хэргийн мөрдөн шалгах ажиллагаа үр дүн муутай байна

15. Хорооны өмнөх ажиглалт, дүгнэлтийн<sup>247</sup> мөрөөр хийсэн илтгэгчийн хийсэн үнэлгээг үндэслэн дараах асуудалд санаа зовж байна.

(а) Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцаанд өртсөн тухай гомдлыг шалгах бие даасан байгууллага байгуулах ажил удааширсан болон, Оролцогч улс 2025 онд тусгай мөрдөн шалгах алба байгуулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр амлаж байгааг онцолж байна. Үүний зэрэгцээ Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтсээс эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа ашиг сонирхлын зөрчилтэй, үр дүнгүй болж байгаад санаа зовниж байна;

(б) Хууль сахиулах байгууллагын ажилтнууд эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан тухай олон тооны мэдүүлэг хүлээн авсан, эрүү шүүлт тулгах хэргийг хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн хэмээн хэрэгсэхгүй болгосон, яллагдагчаар татсан хүмүүсийн эзлэх хувь бага, хэд хэдэн шийтгэл оногдуулахдаа оноовол зохих шийтгэлээс илүүтэйгээр торгох шийтгэл ногдуулсан;

(в) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн төрөл садан, хууль ёсны төлөөлөгчийг айлган сүрдүүлэх болон бусад түрэмгий арга хэмжээний тухай мэдээлэл (12, 13, 15 дугаар зүйл).

#### **16. Хороо Оролцогч улсаас дараах зүйлийг хийхийг уриалж байна:**

(а) Төрийн албан тушаалтан, ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан үйлдлийг мөрдөн шалгах бие даасан механизмыг бий болгох хуулийг эцэслэн боловсруулж, тус байгууллагын мөрдөгч болон гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй этгээдүүдийн хооронд зохион байгуулалт, шаталсан харилцаагүй байх байдлыг хангах; эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан гэж үзэх үндэслэлтэй, гэмт хэрэг хийсэн гэж сэжиглэгдэж буй этгээдийг нэн даруй, шударга, үр дүнтэйгээр бие даасан байгууллага мөрдөн шалгах, гэм буруутай нь тогтоогдвол гэмт хэргийн хүнд байдалд тохирсон шийтгэл ногдуулах. Оролцогч улс энэ талаар хамгийн сүүлд Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит хэлэлцүүлгийн үеэр өгсөн амлалтыг Хороо цохон дурдаж байна<sup>248</sup>;

(б) Эрүү шүүлт тулгасан, зүй бусаар харьцсан гэж үзэх үндэслэлтэй, мөн эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцсан гэж сэжиглэгдсэн үйлдлээ давтан хийх, хохирогч болон түүний төрөл төрөгсдийг хэлмэгдүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах эрсдэлтэй тохиолдолд сэжигтнийг мөрдөн байцаалтын явцад нэн даруй үүрэгт ажлаас нь түдгэлзүүлэх; холбогдох эрх бүхий этгээдэд дотоод хяналт шалгалт явуулах эрхийг нээж өгөх;

(в) Хохирогчид болон тэдний хууль ёсны төлөөлөгч, төрөл төрөгсдийг айлган сүрдүүлэх, хэлмэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх бүхий л зохих арга хэмжээг авах;

г) Хүлээн авсан эрүү шүүлт тулгах, зүй бус харьцаатай холбоотой бүх гомдол, мэдээлэл, үүнд эдгээр гомдлыг шалгасан эсэх, шалгасан бол ямар эрх бүхий байгууллага шалгасан, мөрдөн шалгах явцад сахилгын шийтгэл

<sup>247</sup> CAT/C/MNG/CO/2, paras. 15-16.

<sup>248</sup> A/HRC/46/9, para.116.4, 116.50-56 read in conjunction with A/HRC/46/9/Add.1, para. 3.

**ногдуулсан эсэх, эсхүл эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэх, ял шийтгүүлсэн тохиолдолд оногдуулсан ялын шинж чанар, хохирогчид хохирлоо нөхөн төлсөн эсэх талаарх статистикийн цогц мэдээллийг нэгтгэн нийтлэх;**

#### **Эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцах замаар олж авсан нотлох баримт**

17. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.12-т эрүү шүүлт тулгаж, зүй бусаар харьцах замаар олж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй гэсэн заалтыг тусгахдаа энэ зүйлд заасан хориг нь эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцах замаар олж авсан аливаа нотлох баримт, мэдээлэлд бус зөвхөн мэдүүлэг өгөхөд чиглэж байгаад мөн энэ хоригийг амьдрал дээр тэр бүр дагаж мөрддөггүй гэсэн мэдээлэлд Хороо санаа зовж байна (15-р зүйл).

**18. Оролцогч улс хууль сахиулах болон тагнуулын ажилтнуудад Конвенцын заалтууд, тухайлбал эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцахыг туйлын хориглох тухай, Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд (Мендезийн зарчмууд) зэрэг албадлагын бус тайлбар мэдүүлэг, мөрдөн шалгах ажиллагааны арга барилыг үргэлжлүүлэн сайжруулж, сургах, мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэт хэрэгслүүдийг нэвтрүүлж, шүүх эмнэлгийн нотлох баримт цуглуулах тогтолцоог бий болгож, хэрэг хүлээлгэхээс нотлох баримтад суурилсан тогтолцоо руу шилжих шилжилтийг бэхжүүлэх.**

#### **Эрх чөлөөгөө хасуулсан газрууд дахь гомдол гаргах механизм**

19. Хорих анги, баривчлах байруудад прокурорууд очиж шалгаж байх гомдлын хайрцаг суурилуулж байгаа боловч эрх чөлөөгөө хасуулсан олон хүн хэлмэгдүүлэлт, айлган сүрдүүлгээс айж эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан тухай гомдол гаргахыг хүсдэггүй эсвэл мэдээгүй гэсэн мэдээлэлд Хороо санаа зовж байна. Баривчлагдсан хүмүүс цагдан хорих байрны захиргаагаар дамжуулан гомдлоо гаргаж болно гэж Оролцогч улсын тайланд тусгасан байгаа нь тэдний хувийн нууцын хамгаалалтад асуудал үүсгэж байгааг Хороо цохон тэмдэглэж байна (2, 12, 13, 16-р зүйл).

**20. Оролцогч улс эрх чөлөөгөө хасуулсан бүх газарт эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан үйлдлийн хохирогчдод үр дүнтэй, нууцлалтай, саадгүй хандах боломжийг хангах замаар гомдол гаргах механизмыг бэхжүүлэх арга хэмжээ авах ёстой, энэ талаарх мэдээллийг ил тод, өргөн хүрээнд тараах; харуул хамгаалалтын болон тухайн байгууллагын ажилтнууд гомдол цуглуулах, дамжуулахад ямар нэг үүрэг гүйцэтгэх ёсгүй, Оролцогч улс гомдол гаргагчдыг гомдол гаргасных нь төлөө аливаа хэлбэрээр айлган сүрдүүлэх, хэлмэгдүүлэхээс хамгаалах ёстой.**

#### **Цагдан хорих нөхцөл**

21. Оролцогч улсаас цагдан хорихоос өөр хувилбарыг нэвтрүүлэх талаар авч буй арга хэмжээг сайшааж, урьдчилан хорих байр барих, хорих ангиудын материаллаг нөхцөлийг сайжруулах чиглэлээр хийж буй хүчин чармайлтыг онцлохын зэрэгцээ хүлээн авсан тайланд тусгасан дараах асуудалд Хороо санаа зовниж байна.

(а) Хэд хэдэн хорих анги, цагдан хорих байрны нөхцөл байдал тааруу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ариун цэврийн байгууламж хангалтгүй, материаллаг

хангамж байнгын дутагдалтай байдаг, тухайлбал цагдаагийн газрын эрүүлжүүлэх байрны ариун цэврийн байгууламж, агааржуулалт муу; Хоригдолд ногдох талбай хоёр метр квадратаас бага байж болох үндэсний стандартын талаар Оролцогч улсаас өгсөн мэдээлэлд мөн Хороо анхаарлаа хандуулж байна;

(б) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хангалтгүй байдал, түүний дотор сэтгэлзүйн үйлчилгээний дутагдал, сэтгэц, нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудад үзүүлэх дэмжлэг хангалтгүй, түүнчлэн эрүүл мэндийн ажилтан, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж дутмаг байгаагаас хоригдож буй эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байна. Үүнтэй холбогдуулан тайлангийн хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн 22 хувийг шинэчлэх талаар Оролцогч улс хүчин чармайлт гаргасныг Хороо хүлээн зөвшөөрч байна;

(в) Өвчнийг илрүүлэх ажил удаашралтай байгаа, энэ талаар эмнэлгийн ажилтны сургалт хангалтгүй зэрэг хүчин зүйлийн улмаас цагдан хоригдож байх үедээ өвчний улмаас нас барсан;

(г) Хорих ангиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хорих өрөө дутмаг, эмэгтэйчүүдийн хорих анги Улаанбаатар хотод алслагдсан байршилд байгаа нь алслагдсан бүс нутгаас гэр бүлийнхэнтэйгээ уулзахад саад болж байна;

(д) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны тэмдэглэсэнээр<sup>249</sup>, эрх чөлөөг хязгаарласан газруудад нөхөн сэргээх, дахин нийгэмшүүлэх, дахин нэгтгэх хөтөлбөр, зорилгот үйл ажиллагаа хангалтгүй байдгаас шийтгэл, сахилгын арга хэмжээг хэтрүүлэн хэрэглэж байна (2, 11, 16-р зүйл).

## **22. Оролцогч улс нь:**

**(а) Хорих ангийн одоогийн барилга байгууламж, материаллаг нөхцөлийг НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэмд (Нельсон Манделагийн дүрэм) нийцүүлэн сайжруулж, хоригдол бүрийн амьдрах орон зайн олон улсын наад захын стандартыг хангах арга хэмжээ авах;**

**(б) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм (Токиогийн дүрэм) болон Эмэгтэй хоригдлуудтай харьцах, гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах дүрэм (Бангкокийн дүрэм)-ийн дагуу хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах, тухайлбал тэнсэн суллах, хугацаанаас нь өмнө суллах зэрэг аргыг түлхүү хэрэглэх;**

**(в) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогт тохирсон хүртээмжтэй байраар хангах тусгай арга хэмжээ авах;**

**(г) Эмэгтэй хоригдлуудыг гэр бүлийнхэнтэйгээ хангалттай харилцах боломжоор хангах, ялангуяа насанд хүрээгүй хүүхэдтэй бол уулзалт хийх шаардлагатай арга хэмжээг авч, хоригдлуудын гадаад ертөнцтэй харилцах харилцааг нэмэгдүүлэх, тэр дундаа тогтмол утсаар ярих боломжийг олгох;**

**(д) Хоригдлуудад эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд эмнэлгийн ажилтнуудыг оролцуулан хангалттай нөөц хуваарилах**

<sup>249</sup> Mongolia: Paradigm shift towards rehabilitative approach needed for effective torture prevention, UN experts find | OHCHR



ажлыг эрчимжүүлэх, ялангуяа сэтгэцийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулахад хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх;

(е) Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь шийтгэх, шийтгэлийн арга хэлбэрт үнэлгээ хийж, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцахаас үр дүнтэй хамгаалах ажлын нэг хэсэг болгон шийтгэлийн арга барилаас нийгэмшүүлэх, дахин нэгтгэх арга хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөр, түүний дотор зорилтот үйл ажиллагаа, мэргэжлийн сургалт, боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх.

#### **Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст сахилгын шийтгэл ногдуулах**

23. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227 дугаар зүйлийн 227.1.1, 228 дугаар зүйлийн 228.1-д заасны дагуу уулзалт хийх, утсаар ярих эрхийг гурван сар хүртэл хугацаагаар хязгаарлаж, сахилгын шийтгэл ногдуулах боломжтой байгаад Хороо санаа зовж байна, түүнчлэн 30 хүртэлх хоногийн хугацаанд ганцаарчлан хорих, онцгой тохиолдолд эрэгтэй хоригдлуудад 60 хүртэлх хоногийн сахилгын шийтгэл оногдуулах боломжтой байгаа нь шийтгэл, сахилгын арга хэмжээг хэтрүүлэхэд хүргэж байна.

24. Оролцогч улс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227.1.1, 228.1 дэх **заалтууд болон сахилгын шийтгэл оногдуулах ажиллагаа, тэр дундаа гэр бүлтэйгээ холбоо барихыг хориглох, ганцаарчлан хорих явдлыг олон улсын жишигт, ялангуяа Нельсон Манделагийн дүрмийн 43-46 дугаар дүрэмд нийцүүлэх нь зүйтэй. Энэ хүрээнд сахилгын шийтгэл, хязгаарлалтын арга хэмжээ нь аюулгүй байдал, дэг журмыг сахиулах зайлшгүй шаардлагатай үед хязгаарлагдмал хугацаагаар оногдуулахаас бусад тохиолдолд гэр бүлийнхэнтэй харилцахыг хориглох ёсгүй бөгөөд ганцаарчлан хорихыг зөвхөн онцгой тохиолдолд л эцсийн арга хэмжээ болгон аль болох богино хугацаанд (15 хоногоос илүүгүй) бие даасан хяналт дор, зөвхөн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр, эмнэлгийн мэргэжилтний өдөр тутмын хяналтан дор явуулна.**

#### **Тусгай хаалттай нэгж**

25. Цаазаар авах ялыг халсны дараа бүх цаазаар авах ялыг урт хугацааны хорих ялаар сольсныг сайшаахын хамт Хороо нь тусгай хаалттай ангид (405 дугаар хаалттай хорих анги) бүх насаараа хорих ял эдэлж байгаа хүмүүст тусгай хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаад, мөн хоригдлуудыг удаан хугацаанд ганцаарчлан тусгаарладаг, хорих өрөөний гадна дөнгөлдөг, бусад хоригдлууд болон гадаад ертөнцтэй харилцах харилцаа маш хязгаарлагдмал, ажил хөдөлмөр эрхлэх боломж хомс, нөхөн сэргээх хөтөлбөр хангалтгүй зэрэг байдалд Хороо санаа зовниж байна. Түүнчлэн, төлөөлөгчдийн тайлбарласнаар сэтгэл санаа нь тогтворгүй байгаа оюуны болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудыг ганцаарчлан тусгаарлах байранд хамгаалалтын арга хэмжээ болгон хэсэг хугацаанд ганцаарчлан хорьж байгаад санаа зовниж байна. (2, 4, 11-14, 16-р зүйл).

26. Оролцогч улс тусгай хаалттай хорих ангид (405-р хорих анги), түүний дотор удаан хугацаагаар ял эдэлж буй хоригдлуудын хорих дэглэмийг эргэн харж, Нельсон Манделагийн дүрэм, ялангуяа 43(1) (b) зэрэг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнтэй

**холбогдуулан хорих ял эдэлж буй хоригдлуудын сэтгэцийн чадвар, нийгмийн чадавхыг доройтуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор бүх хоригдлыг хорих ангиас гадуур зохион байгуулалттай, зорилготой үйл ажиллагаагаар хангах, нийгэмшүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй. Хороо нь Нельсон Манделагийн дүрмийн оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хоригдлуудын нөхцөл байдлыг улам дордуулж болзошгүй тохиолдолд ганцаарчлан хорихыг хориглосон 45 (2) дахь дүрмийг анхаарахыг Оролцогч улсаас хүсэж байна.**

#### **Насанд хүрээгүй хүүхдийн шүүх**

27. Оролцогч улс хууль зөрчсөн хүүхдүүдийн нөхцөл байдлыг сайжруулах, түүний дотор хууль тогтоомжийн арга хэмжээ, шүүгчдийг чадавхжуулах үйл ажиллагаа гэх мэт хүчин чармайлт гаргаж байгааг Хороо онцолж байна. Гэсэн хэдий ч өмнөх Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит хэлэлцүүлгээс хойш насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн иж бүрэн тогтолцоог бий болгох ажил удаашралтай байгаад харамсаж байна. Цаашилбал, цагдан хорих байранд байгаа хүүхдүүд хүмүүжлийн болон чөлөөт цагаар хийх үйл ажиллагаанд хамрагдах боломжгүй байгааг Хорооноос онцлон анхааруулж байна. Мөн Улаанбаатар хотын Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хууль зөрчсөн хүүхдүүдийг байрлуулах материаллаг нөхцөл хангалтгүй байгаад санаа зовниж байна. Эцэст нь, гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд хэрэглэсэн хорихоос өөр төрлийн арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байгаад Хороо харамсаж байна (2, 11, 16-р зүйл).

28. Оролцогч улс насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тогтолцоогоо олон улсын холбогдох стандартад бүрэн нийцүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлэх ёстой. Ялангуяа, Оролцогч улс цагдан хорихоос өөр хувилбаруудыг дэмжих ёстой бөгөөд цагдан хорих арга хэмжээг хамгийн богино хугацаагаар, эцсийн арга хэмжээ болгон авч, Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам (Бээжингийн журам)-ын дагуу түүнийг цуцлах үүднээс тогтмол хянаж байх ёстой. Түүнчлэн Оролцогч улс:

(а) Насанд хүрээгүй хүмүүсийн дагнасан шүүхийг байгуулж, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох, түүнийг хүний нөөц, техник, санхүүгийн хангалттай нөөцөөр хангах, хүүхдийн асуудлаар мэргэшсэн шүүгчдийг томилох, тэдгээр дагнасан шүүгчдийг хангалттай, байнгын сургалтад хамруулах ажлыг цаг алдалгүй үргэлжлүүлэх;

(б) Урьдчилан саатуулах төвд хоригдож буй хүүхдүүдийн боловсрол, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжийг сайжруулж, ажилтнуудыг зохих ёсоор сургах;

в) Цагдан хорих байранд хүүхэд, өсвөр үеийнхний хоригдох нөхцөлийг ариун цэвэр, эрүүл ахуйн талаас нь яаралтай сайжруулах арга хэмжээ авах.

#### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс**

29. Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны иж бүрэн төлөвлөгөө (2024-2027) батлагдсаныг сайшаахын хамт түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хуваарилалт хангалтгүй байгаад сэтгэл зовниж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр албадан эмнэлэгт хэвтүүлж байгаад санаа зовниж байна. Мөн сэтгэц, нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ дутмаг, улмаар

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд өөрсдөөс нь зөвшөөрөл авалгүйгээр удаан хугацаагаар хэвтүүлэн эмчилдэг болохыг тус Хороо анхааран харж байна. Нэмж дурдахад, цочмог сэтгэцийн хаалттай тасагт хоригдож буй шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникийн өвчтөнүүдийн нөхцөл байдал, тэднийг удаан хугацаанд тусгаарлах, хүний нөөц, туслах үйлчилгээний дутмаг байдал, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад гомдол гаргах үр дүнтэй механизм дутмаг байгаа зэрэгт санаа зовж байна (2-р зүйл 11, 13 ба 16).

**30. Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны иж бүрэн төлөвлөгөө (2024-2027)-ыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай нөөцийг хуваарилж, хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр хаалттай байгууллагад албадан хэвтүүлэхгүй байх хүчин чармайлтаа эрчимжүүлж, улс даяар олон нийтэд түшиглэсэн болон амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр институтийн төвлөрлийг халах бодлогыг боловсруулахыг Оролцогч улсад Хорооноос зөвлөж байна. Түүнчлэн хаалттай тасагт хоригдож буй шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникийн өвчтөнүүдийн нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авч, ажилтнуудыг чадавхжуулах, хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах, олон нийтэд түшиглэсэн үйлчилгээнд хөрөнгө оруулах, өвчтөнд зориулсан гомдлын үр дүнтэй, хараат бус, нууц, хүртээмжтэй механизмыг бий болгох шаардлагатай.**

### **Нөхөн төлбөр**

31. Эрүү шүүлт тулгасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр шаардах эрхийг баталгаажуулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг 2019 онд шинэчлэн найруулж, холбогдох журмууд батлагдсаныг Хороо онцолж байна. Гэсэн хэдий ч төлөөлөгчдийн мэдээлснээр энэ хуулийн дагуу эрүү шүүлтийн хохирогчид нөхөн төлбөр аваагүй байгаа бөгөөд цөөн тооны эрүү шүүлтийн хохирогчид л гэмт хэрэгтнүүдээс мөнгөн нөхөн төлбөр авч чадсан тухайд Хороо анхаарал хандуулж байна. Дээрх хуульд учирсан хохирлыг тооцох, шударга, зохистой нөхөн төлбөр олгох журам тодорхойгүй, эдийн бус хохирлыг барагдуулахгүй бөгөөд энэ учраас хохирогчид хуулийн өөр арга хэрэглэх шаардлагатай болдог гэсэн мэдээлэлд хороо санаа зовж байна. Шүүх шинжилгээний тухай хууль 2022 онд батлагдсанаар гэмт хэргийн улмаас хохирсон 668 хохирогч сэтгэл санаа, ёс суртахууны хохирлоо барагдуулсан боловч Оролцогч улсын статистик мэдээгээр эрүү шүүлтийн хохирогч дөрвөн хүний нэхэмжлэл хүлээгдэж байгаа боловч эрүү шүүлтийн хохирогчдод холбогдох шүүхийн шийдвэр хараахан гараагүй байна. Оролцогч улсад эрүү шүүлт тулгах, зүй бус харьцах гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх цогц хөтөлбөр хэрэгжихгүй байгаад Хороо харамсаж байна. Эрүү шүүлтийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Конвенцод Оролцогч улсуудын үүргийн мөн чанар, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлсон 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийн талаарх Ерөнхий тайлбар No3 (2012)-ыг анхааралдаа авахыг Хорооны зүгээс Оролцогч улсаас хүсэж байна.

**32. Эрүү шүүлтийн хохирогчид хохирлоо барагдуулах, аль болох бүрэн нөхөн сэргээх арга хэрэгслийг багтаасан, мөн гэмтлийн эмчилгээ, нөхөн сэргээх бусад хэлбэрийг оролцуулан шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрхээ эдлэх цогц хөтөлбөрүүдийг бий болгох, ийм хөтөлбөрүүдийг үр дүнтэй ажиллуулахын тулд хангалттай нөөцийг хуваарилахыг зөвлөж байна. Түүнчлэн, Оролцогч улс эрүү шүүлтийн хохирогчдыг олж тогтоох, эрүү шүүлтийн улмаас үүссэн бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг бодитоор, шударга үнэлж, мөнгөн**

**болон мөнгөн бус нөхөн төлбөр олгох тодорхой журмыг бий болгохын тулд цаашдын алхмуудыг хийх ёстой.**

### **Буцаан гаргахгүй байх**

33. Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт эрүү шүүлт тулгах, цаазаар авах ял оногдуулах эрсдэлтэй гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тухайн улсад гэмт хэрэгт мөрдөн шалгуулах, ял шийтгүүлэх зорилгоор шилжүүлэн өгөхийг хориглосныг цохон тэмдэглэж байгаа боловч Оролцогч улсаас Беларусь, Казахстан улстай 2018, 2019 онд тус тус гарын үсэг зурж байгуулсан хоёр болон олон талт хэд хэдэн хэлэлцээрт эрүүдэн шүүх эрсдэлийг авч үзэх хангалттай үндэслэлтэй холбоотой тохиолдлуудыг тусгайлан тусгаагүй мэт өргөн агуулгатай заалтууд агуулагдаж байгаад Хороо санаа зовж байна. Цаашилбал, Оролцогч улс нь дүрвэгсэд болон харьяалалгүй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенцид нэгдээгүй бөгөөд дотоодын хууль тогтоомж, Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиудад өргөдөл гаргагчийг зорьсон улсад эрүү шүүлтэнд өртөх ноцтой эрсдэл байгаа эсэхийг нэг бүрчлэн нарийвчлан үнэлэх боломжийг олгодог улс төрийн орогнол тодорхойлох журамд хангалттай бүрдээгүй байна. Оролцогч улсаас ирүүлсэн 2020-2024 оны хооронд 1360 гадаадын иргэнийг албадан гаргасан талаарх статистикийг үзэхэд Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит хэлэлцүүлгийн хугацаанд орогнол хүссэн өргөдөл хүлээн авсан болон дүрвэгчийн статус олгосон тухай мэдээлэл байхгүй, Оролцогч улсад дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх түвшин бага, цагаачид болон харьяалалгүй хүмүүсийн бүртгэлийн мэдээллийн сан байхгүй байгаад Хороо харамсаж байна (2, 3, 16-р зүйл).

**34. Оролцогч улс нь хэнийг ч эрүү шүүлтэд өртөх хувийн болон урьдчилан таамаглаж болох эрсдэлтэй гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол түүнийг хөөн гаргах, буцаах, өөр улсад шилжүүлэн өгөх боломжгүй гэдгийг баталгаажуулах ёстой. Ялангуяа, Оролцогч улс шилжүүлэн өгөх хоёр болон олон талт гэрээгээ буцаан шилжүүлэхгүй байх зарчимд нийцүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой. Оролцогч улс Конвенцын 3 дугаар зүйлд заасны дагуу орогнол хүсэгч болон дүрвэгсдийг эрүү шүүлтэнд өртөх эрсдэлтэй гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд тухайн улс руу буцаахаас үр дүнтэй хамгаалах тухай орогнол хүсэгч болон дүрвэгсдийн талаарх үндэсний иж бүрэн хууль тогтоомж, журмыг боловсруулах хууль эрх зүйн бүхий л арга хэмжээг авах ёстой. Оролцогч улс Дүрвэгсдийн байдлын тухай 1951 оны конвенц болон түүний 1967 оны протокол, Харьяалалгүй хүмүүсийн байдлын тухай 1954 оны конвенц, Харьяалалгүй байдлыг бууруулах тухай 1961 оны конвенцид нэгдэн орох асуудлыг авч үзэх хэрэгтэй.**

### **Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах**

35. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2021 онд батлагдсаныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хуулийн хэрэгжилт бодит байдал дээр хангалтгүй бөгөөд олон асуудалтай заалт, ойлгомжгүй, ерөнхий хэллэгээр хуульд тусгагдсан, энэ нь хүний эрх хамгаалагчдын ажиллагаанд саад учруулж, үйл ажиллагааных нь төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэж болзошгүй хэмээн 2022 онд 250 Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг онцлон тэмдэглэсэн (2 болон 16 дугаар зүйл).

[250 A/HRC/54/51/Add.2, paras. 23-25.](#)

**36. Оролцогч улс Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн тодорхой бус, өргөн агуулгатай заалтуудыг хүний эрх хамгаалагчийн үйл ажлыг гэмт хэрэгт тооцоход буруугаар ашиглахгүй байх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах үр дүнтэй арга хэмжээ авах нь зүйтэй.**

#### **Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэл**

37. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны тоог нэмэгдүүлж, шуурхай утас ажиллуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр чадавхжуулах ажлыг зохион байгуулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулиар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдог болсныг онцлон тэмдэглэж байна. Гэсэн хэдий ч энэ хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгө хуваарилагдаагүй, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо өндөр байгаатай харьцуулахад эрүүгийн хэрэг үүсгэн ял шийтгэгдсэн тоо бага байгаад Хороо санаа зовниж байгаа бөгөөд энэ ялдамд Оролцогч улс энэ чиглэлээр дагнасан шүүхүүдийг байгуулах эхний алхмуудыг авч хэрэгжүүлж байгааг хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн, хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээ, тэр дундаа эмнэлгийн болон хууль зүйн үйлчилгээ, хамгаалах байр ялангуяа хөдөө орон нутагт хангалтгүй байгаад санаа зовнихын зэрэгцээ эдгээр дутагдлыг арилгах талаар тасралтгүй хүчин чармайлт гаргаж байгааг хүлээн зөвшөөрч байна (2, 12-14, 16-р зүйл).

**38. Оролцогч улс гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чангатгаж, хүчирхийллийн талаарх бүх гомдлыг нэн даруй, сайтар, үр дүнтэй мөрдөн шалгах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчид зохих нөхөн төлбөр авах, эмнэлгийн болон сэтгэл зүйн зохих дэмжлэг авах боломжийг бүрдүүлэх үүднээс бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид өөрсдийнх нь эсрэг үйлдлийг илчлэхийг уриалах механизмыг бий болгох ёстой. Мөн цаашид жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хүрээнд дэх хүчиндэх гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулах хүчин чармайлтаа үргэлжлүүлж, хохирогчид болон/эсвэл тэдний гэр бүлийг хамгаалж, эмнэлгийн болон хууль зүйн үйлчилгээ, нөхөн сэргээлт, тэр дундаа хангалттай нөхөн олговор авах, мөн улс даяар хангалттай санхүүтэй хамгаалах байранд хамрагдах боломжоор хангах.**

#### **Хүн худалдаалах гэмт хэрэг**

39. Оролцогч улсаас хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр хийж буй хүчин чармайлтыг Хороо хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч энэ үзэгдэл, ялангуяа хүүхэд худалдаалах, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор худалдах гэмт хэрэг түгээмэл хэвээр байгаад санаа зовж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргүүдийн тоо хязгаарлагдмал, ялангуяа шилжин ирэгсэд болон хөдөө орон нутгийн иргэдийн дунд хохирогчдыг илрүүлэх ажил учир дутагдалтай, таних үйл явцын үед дахин гэмт хэрэг үйлдсэн гэх зэрэгт Хороо санаа зовж байна, түүнчлэн, цагдаа, эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах янз бүрийн санаачилгыг анхааралдаа авсан хэдий ч хүний наймааны шинж тэмдгийг илрүүлж болох бүх албан тушаалтнуудад, тэр дундаа хөдөлмөрийн зах зээлд хангалттай сургалт явуулаагүй байна. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг илрүүлэх, хамгаалах, тэдэнд туслах зорилгоор салбар дундын ажлын хэсэгт

хуваарилсан хөрөнгө хүрэлцдэггүй, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх цогц үйлчилгээ, тэр дундаа хоргодох байранд нэвтрэх боломж дутмаг байгаад санаа зовж байна (2, 12–14 ба 16).

**40. Оролцогч улс хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх бүх төрлийн арга хэмжээг үргэлжлүүлэн авч, ийм хэргийг сайтар шалгаж, гэмт этгээдүүдийг сэжигтнээр татаж, гэм буруутай нь тогтоогдвол зохих шийтгэл оногдуулж, хохирогчид хангалттай нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зэргээр бүрэн хохирлыг барагдуулах. Оролцогч улс хүн амын дунд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, шүүх, хууль сахиулах байгууллага, цагаачлалын болон хилийн хяналтын ажилтнууд, хөдөлмөрийн байцаагч, нийгмийн ажилтнуудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох, эрт илрүүлэх аргад сургах, тэднийг сэтгэл зүй, хууль зүйн зохих үйлчилгээнд шилжүүлэх замаар хэргийг тайлагнах хүчин чармайлтаа бэхжүүлэх ёстой. Оролцогч улс цаашид урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчдод туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тэр дундаа Салбар дундын ажлын хэсэгт хангалттай нөөцийг хуваарилах, мөн нутаг дэвсгэр даяар хоргодох байранд хамрагдах боломжоор хангах ёстой.**

**Бодит болон хүлээн зөвшөөрөгдсөн бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар хүчирхийлэх**

41. Бодит болон хүлээн зөвшөөрөгдсөн бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар нь хүмүүсийг хүчирхийлж, заналхийлдэг, эмчилгээ хийлгэж байх үед нь эрүүл мэндийн ажилтнууд сөрөг ханддаг, хүчирхийлэлд өртсөн тухайгаа мэдээлэх үед цагдаа нар тэдэнд сөрөг ханддаг, түүнчлэн ийм хэргүүдийг үр дүнтэй мөрдөн шалгадаггүй талаар Хороо онцгойлон тэмдэглэж байна. (2, 16-р зүйл).

**42. Оролцогч улс нь бодит буюу хүлээн зөвшөөрөгдсөн бэлгийн болон хүйсийн чиг баримжаа дээр суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авч, хүчирхийллийн бүх үйлдлийг нэн даруй, үр дүнтэй, шударгаар шалгаж, шийтгэх, гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцлага тооцох, хохирогчдод нөхөн төлбөр олгох явдлыг хангах ёстой.**

**Хүүхдийн бие махбодын шийтгэл**

43. Оролцогч улс бүх орчинд хүүхдэд бие махбодын шийтгэл оногдуулахыг хориглох, түүнтэй тэмцэх талаар хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлж буй томоохон алхмуудыг сайшааж байгаагийн зэрэгцээ тус улсад хүүхдийн эсрэг сахилгын арга хэмжээ хэрэглэх хүчирхийлэл байнга гарсаар буйг тайланд баримтжуулсан байгаад Хороо санаа зовниж байна. (16-р зүйл).

**44. Оролцогч улс эдгээр үйлдлүүдийг шалгаж, гэмт хэрэг үйлдэгчдийг шүүхэд шилжүүлж, хохирогчдод нөхөн төлбөр олгохыг баталгаажуулах зэргээр хүүхдийг бие махбодын шийтгэлээс урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авч, хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл хэрэглэхийг хориглох, түүний үр дагаврын талаар олон нийтэд сурталчлах, таниулах үйл ажиллагаа явуулах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх хэрэгтэй.**

**Цэргийн анги дахь хүчирхийлэл**



45. Зэвсэгт хүчинд үүрэг гүйцэтгэгчдийг ялгаварлан гадуурхах, эрүү шүүлт тулгах, зүй бус харьцах, тэр дундаа зодох тохиолдол ихсэж байгаа, түүнчлэн цэргийн ангиудын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавихгүй байгаа тухай мэдээлэлд Хороо санаа зовниж байна (2, 16-р зүйл).

**46. Оролцогч улс цэргийн албан хаагчдад эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан үйлдлийн талаарх бүх гомдлыг үр дүнтэй шалгаж, буруутай этгээдэд зохих шийтгэл ногдуулах, хохирогчид болон тэдний гэр бүлийнхэнд нөхөн төлбөр олгох, мөн ийм үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа зэрэг бие даасан байгууллагууд цэргийн ангиудад хяналт тавих зэргээр шаардлагатай бүх арга хэмжээг авах.**

### **Сургалт**

47. Хууль сахиулах болон хорих байгууллагын ажилтнууд, хуульч, шүүгч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүний эрхийн сургалт явуулахын ач холбогдлыг Хороо хүлээн зөвшөөрч байгаа боловч биеийн болон сэтгэл зүйн эрүү шүүлтийн шинж тэмдэг, үр дагаврыг илрүүлэх талаар эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, сургалт хангалтгүйн улмаас эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан тохиолдолд эмнэлгийн үнэлгээ дутмаг байгаад Хороо санаа зовниж байна (10-р зүйл).

**48. Оролцогч улс хууль сахиулах, шүүх, хорих ангийн алба хаагчид, ялангуяа эмнэлгийн мэргэжилтнүүд зэрэг холбогдох бүх хүмүүст зориулсан анхан шатны болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд улмаар тэднийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага (Станбулын протокол)-ын дагуу эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцсан тохиолдлыг илрүүлэх арга зүйд зохих ёсоор сургах хэрэгтэй. Оролцогч улс эрүүл мэндийн үйлчилгээнд эрүү шүүлт тулгах, зүй бусаар харьцсан байж болзошгүй шинж тэмдгийг үнэлж, илрүүлэх эрүүгийн эрх зүйн тогтолцоонд ажилладаг эмч нарын үүргийг тодорхойлох арга хэмжээ авах ёстой.**

### **Дагаж мөрдөх журам**

49. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолт, эрх зүйн үндсэн хамгаалалт, эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах тухай Хорооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2025 оны 11 дүгээр сарын 22-ны дотор уламжлахыг Хороо Оролцогч улсаас хүсэж байна (дээрх 8, 10 (а) ба (г) ба 16 (а)-г үзнэ үү). Энэ хүрээнд Оролцогч улсыг эцсийн ажиглалтад дурдсан үлдсэн зөвлөмжүүдийн заримыг эсвэл бүгдийг ирэх тайлангийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө талаар Хороонд мэдээлэхийг хүсэж байна.

### **Бусад асуудлууд**

50. Оролцогч улс Конвенцын заалтыг зөрчсөний улмаас хохирогч болсон гэж мэдэгдэж байгаа өөрийн харьяаллын хувь хүмүүсээс эсвэл тэдний нэрийн өмнөөс Оролцогч улс хоорондын мэдээллийг хүлээн авах, хэлэлцэх тухай Конвенцын 21, 22 дугаар зүйлд заасан Хорооны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл хийх асуудлыг хэлэлцэж байгаа явдлыг Хороо дэмжиж байна.

51. Оролцогч улсыг Хороонд ирүүлсэн тайлан болон эдгээр ажиглалт, дүгнэлтийг зохих хэлээр албан ёсны цахим хуудас, хэвлэл мэдээлэл, төрийн бусад байгууллагуудаар дамжуулан өргөнөөр түгээж, мэдээлэл түгээх үйл ажиллагааныхаа талаар Хороонд байнга мэдээлж байхыг уриалж байна.

52. Хороо нь 2028 оны 11 дүгээр сарын 22-ны дотор ээлжит дөрөв дэх тайлангаа ирүүлэхийг Оролцогч улсаас хүсэж байна. Оролцогч улс хялбаршуулсан тайлагнах журмын дагуу Хороонд тайлагнаж байхыг зөвшөөрсөн тул Хорооны зүгээс тайлан гаргахаас өмнө тухайн Оролцогч улсад тулгамдсан асуудлын жагсаалтыг зохих хугацаанд нь хүргүүлнэ. Оролцогч улсын эдгээр асуудлын жагсаалтад өгсөн хариулт нь Конвенцын 19 дүгээр зүйлд заасны дагуу түүний дөрөв дэх тогтмол тайлан болно.

**НҮБ-ЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-16-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН МӨРӨӨР МОНГОЛ УЛСАД ИРҮҮЛСЭН “ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНД ХАМААРАХ АЖИГЛАЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД” (албан бус орчуулга, монгол хэлээр)**

[Хоёрдугаар бүлгийг Орлоцогч улсад өгсөн Дэд хорооны тайлангаас иш татав (CAT/OP/MNG/ROSP/R.1)]

United Nations

CAT/OP/MNG/RONPM/R.1



Optional Protocol to the  
Convention against Torture  
and Other Cruel, Inhuman  
or Degrading Treatment  
or Punishment

Distr.: Restricted

1 January 2025

Original: English

English, French and Spanish only

### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа<sup>251</sup>**

1. Монгол Улс Нэмэлт протоколыг 2015 оны 02 дугаар сарын 12-нд соёрхон баталсан бөгөөд дараа жилдээ багтаан Урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаагаа томилох ёстой байсан. Дэд хорооноос 2017 онд Монгол Улсад хийсэн сүүлчийн томилолтын үеэр Урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа томилогдоогүй байсан бөгөөд түүнийг шуурхай томилох нь дараагийн гол зөвлөмж болсон юм.

2. 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-ыг Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаагаар томилсон. Үүний дараа ХЭҮК-ын дэргэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны нэгжийг (ЭШУС нэгж) байгуулж, гишүүнд ЭШУС нэгжийн ажлыг удирдан чиглүүлэх үүрэг хүлээлгэсэн. Ийнхүү Засгийн газар Дэд хорооны өмнөх айлчлалын гол зөвлөмжийг биелүүлж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг томилсон.

#### **А. Бүрэн эрх ба бүтэц**

3. Монголын Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаанд байнгын үүрэг гүйцэтгэдэг Гишүүнтэй бөгөөд ЭШУС нэгж түүнд туслан ажилладаг. Туршлагаас харахад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэн эрх

<sup>251</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ажиглалт, зөвлөмжийг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хүргэх боломжийг олгодог. Энэ дагуу тайлангийн уг хэсгийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай хуваалцах боловч Орлоцогч улс тайланг бүхэлд нь олон нийтэд ил болгох хүсэлт гаргах хүртэл нууц хэвээр байх болно.

нь Хүний эрхийн үндэсний байгууллага гэх мэт байгууллагын бүтцэд байршдаг бол одоогийн Монгол Улсын нэгэн адилаар бүтэц дотроо тусдаа нэгж болон орших нь хамгийн үр дүнтэй. Айлчлалын өмнө төлөөлөгчид УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж буй ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ерөнхий санал, дүгнэлтээ өгсөн бөгөөд үүнд Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх, түүнчлэн ХЭҮК-ын дэргэдэх ЭШУС нэгжийг хэвээр хадгалахыг зорьсон агуулга багтсан. **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэн эрхийг ХЭҮК-ын ЭШУС нэгжид өгөхөөр гаргасан шийдвэрийг эргэн санаж, Нэмэлт протоколын 18 дугаар зүйлд заасны дагуу тус нэгжийн үр дүнтэй үйл ажиллагаа, бие даасан байдлыг хангах нь зүйтэй.**

4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд эрх чөлөөгөө хасуулсан газруудад саадгүй нэвтрэхэд ноцтой асуудал гараагүйг төлөөлөгчид сайшааж байна. Гэсэн хэдий ч, ХЭҮК-ын тухай хуульд эрх чөлөөгөө хасуулсан газрын бүх байгууламжид нэвтрэхийг заасан Нэмэлт протоколын 20 дугаар зүйлийн (с) заалт бүрэн тусгагдаагүй, ялангуяа цэргийн ангийн тухайд зөвхөн цэргийн сахилгын байранд нэвтрэхийг тусгасныг тэмдэглэх нь зүйтэй. **Нэмэлт Протоколын 4, 20 (с)-д заасан болон 1 тоот Ерөнхий тайлбар (2024)-т тайлбарласны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь хууль болон практикийн хувьд эрх чөлөөгөө хасуулсан бүх газар, тэдгээрийн байгууламжид очих эрхтэй байх ёстой.**

#### **Б. Хүний нөөц ба чиг үүргийн бие даасан байдал**

5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны орон тоо 10 мэргэжилтэнтэй байхаар батлагдсан ч төсвийн хэмнэлтийн улмаас ердөө зургаахан орон тоотой ажиллаж байна. Түүгээр ч зогсохгүй ЭШУС нэгжийн хүний нөөцийн сонгон шалгаруулалтад гүйцэтгэж буй Төрийн албаны зөвлөлийн үүрэг оролцоо анхаарал татаж байгаа ба Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн тухайн нэгжийн хүний нөөцийн сонгон шалгаруулалтад хамгийн бага үүрэг гүйцэтгэж байгаа нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны бие даасан байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүний нөөцийг бүрэн бүрэлдэхүүнээр хуваарилах, ЭШУС нэгжийн хүний нөөцийг сонгоход Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үүргийг чухалчлан хангах, нэгжийн ажилтнуудыг олон талт байдлаар бүрэлдхүүлэх замаар үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг улам бэхжүүлэх ёстой.

#### **В. Санхүүжилт**

7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн жил бүр төсвийн саналаа ХЭҮК-т уламжилдаг бөгөөд Комисс нь эргээд Комиссын даргаараа дамжуулан хууль тогтоох байгууллагаас төсвийг хүлээн авсны дараа төсвийн дотоод хуваарилалт, тэр дундаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг шийдвэрлэдэг. Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг ХЭҮК-ын нэгдсэн төсвийн нэг хэсэг болгон хуваарилдаг бөгөөд Үндэсний ажиллагаанд тусад нь тусгайлан зориулсан төсөв байдаггүй.

**8. Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангаж, бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрээр түүнийг хангасан байх ёстой. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь ямар эх үүсвэр шаардагдах (төсвийн бэлтгэл) болон тэр төсвийг хэрхэн зарцуулах (төсвийн зарцуулалт) талаар шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой бөгөөд түүний төсвийг ХЭҮК-ын нийт төсвийн дотор цагираган тойрогт хамгаалсан байх ёстой.**

9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэх чиг үүргийг оновчтой тодорхойлсон байх ёстой бөгөөд үүнд эрүү шүүлт тулгах, зүй бус харьцах зөрчлийн хэв маягийг тодорхойлох, эрсдэл, түүнд нөлөөлж буй үндсэн шалтгаан, тогтолцооны асуудлуудыг илрүүлэх, нөхцөл байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийх, холбогдох оролцогч талуудад практик болон стратегийн зөвлөмж гаргахад нөлөөллийг бууруулах арга барилыг ашиглах зэрэг багтсан байх ёстой ба ингэснээр эдгээр эрсдлийг даван туулахад төрд туслах явдал юм. Оролцогч улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны урьдчилан сэргийлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадварыг хангахад шаардлагатай нөөцийг хуваарилах ёстой.

### **Г. Тайлагнах**

10. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны жилийн тайланг ХЭҮК-ын тайлангаас тусад нь УИХ-д танилцуулж байгаа нь сайшаалтай. Гэсэн хэдий ч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт нь түүний ажлын үр ашгийг хангах гол түлхүүр бөгөөд энэ нь үндэсний ажиллагааны бүрэн эрх, үйл ажиллагааг мэддэг байх ёстой бүх оролцогч талууд, ялангуяа цагдан хорих эрх бүхий байгууллага болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй өрнүүлэх хамтын ажиллагаагаар дамжин хангагддаг. Оролцогч улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны жилийн тайланг (Нэмэлт протоколын 23-р зүйл) нийтэлж, өргөнөөр түгээх ёстой бөгөөд бүх эрх бүхий байгууллага Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар үндэсний ажиллагаатай бүтээлчээр яриа хэлэлцээ хийхийг баталгаажуулах ёстой (Нэмэлт протоколын 22-р зүйл).

**НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИССЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН АСУУДЛААРХ  
ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАНФРЕД НОВАКИЙН 2005 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-09-  
НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ  
(англи хэлээр)**



THE SPECIAL RAPPORTEUR ON THE QUESTION OF TORTURE AND OTHER CRUEL, INHUMAN OR DEGRADING TREATMENT OR PUNISHMENT OF THE UNITED NATIONS COMMISSION ON HUMAN RIGHTS, MANFRED NOWAK, ISSUED THE FOLLOWING STATEMENT TODAY<sup>252</sup>

The Special Rapporteur on the question of torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment of the United Nations Commission on Human Rights, Manfred Nowak, undertook a fact-finding mission to Mongolia from 6 June to 9 June 2005, at the invitation of the Government.

Over the course of the four-day visit the Special Rapporteur met with the President, the Vice Minister for Foreign Affairs, and the Deputy Minister of Justice, among other officials. He enjoyed the full cooperation with the authorities with the exception of the administration of the Gants Hudag Pre-trial Detention Centre, Ulaanbaatar, and Zuunmod Pre-trial Detention Center. He also met with the commissioners of the National Human Rights Commission of Mongolia, representatives of non-governmental human rights organizations, as well as representatives of international organizations.

The Special Rapporteur praised the 2005 public inquiry on torture being carried out by the National Human Rights Commission, and expressed strong support for its efforts aimed at eradicating torture.

"On the other hand, despite recent efforts in Mongolia, such as legislative reform and the establishment of a unit within the Prosecutor's Office to combat abuses of law enforcement, torture persists, particularly in police stations and pre-trial detention facilities.

He was also concerned with the secrecy surrounding the application of the death penalty, especially the absence of any official data. The deplorable conditions on death row and the lack of notification of families, among other things, amount to cruel treatment, according to the Special Rapporteur. He also noted that the treatment of prisoners serving 30-year terms in isolation is inhuman. However, the 'ordinary' prison regime was found generally to be in line with international standards.

<sup>252</sup> SPECIAL RAPPORTEUR ON TORTURE ENDS VISIT TO MONGOLIA | OHCHR



The Special Rapporteur highlighted that impunity in Mongolia for violations of torture and cruel, inhuman or degrading treatment or punishment goes unimpeded because of the absence in the Criminal Code of a definition of torture in line with the Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment; the lack of effective mechanisms to receive and investigate allegations of ill-treatment; and a basic lack of awareness primarily on behalf of prosecutors, lawyers and the judiciary of the international standards relating to the prohibition of torture. Consequently, there is no recourse to compensation and rehabilitation for torture and other forms of ill-treatment.

The Special Rapporteur issued preliminary recommendations to the Government, which included that it criminalize torture in accordance with the definition contained in article 1 of the Convention against Torture, and impose appropriate penalties; investigate effectively every allegation of torture and bring the perpetrators to justice; and ratify the Optional Protocol to the Convention against Torture, entrusting the National Human Rights Commission with the task of carrying out preventive visits to all places of detention.

The Special Rapporteur expressed his appreciation to the Government, the Office of the High Commissioner for Human Rights, and the United Nations Country Team for their assistance in organizing the visit to Mongolia.

The report of his visit to Mongolia will be presented at the sixty-second session of the Commission on Human Rights.

Mr. Nowak was appointed Special Rapporteur on 1 December 2004. As Special Rapporteur, he is independent from any government and serves in his individual capacity. The Commission first decided to appoint a special rapporteur to examine questions relevant to torture in 1985. The mandate covers all countries, irrespective of whether or not a State has ratified the Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment.

Mr. Nowak has previously served as a member of the Working Group on enforced and involuntary disappearances; as the United Nations expert on missing persons in the former Yugoslavia; as the United Nations expert on legal questions on enforced disappearances, and as a judge at the Human Rights Chamber for Bosnia and Herzegovina. He is a Professor of Constitutional Law and Human Rights at the University of Vienna and the Director of the Ludwig Boltzmann Institute of Human Rights.

**НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИССЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН АСУУДЛААРХ  
ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАНФРЕД НОВАКИЙН 2005 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-09-  
НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**  
(албан бус орчуулга, монгол хэлээр)

НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИССЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН АСУУДЛААРХ ТУСГАЙ  
ИЛТГЭГЧ МАНФРЕД НОВАКИЙН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛЫН ТАЛААРХ  
МЭДЭЭЛЭЛ

НҮБ-ын Хүний эрхийн комиссын эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгч Манфред Новак Монгол Улсын Засгийн газрын урилгаар 2005 оны 06 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд Монгол Улсад баримт илрүүлэх зорилгоор ажиллалаа.

Тэрээр дөрөв хоногийн турш үргэлжилсэн уг айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Гадаад харилцааны дэд сайд, Хууль зүйн дэд сайд болон бусад албаны хүмүүстэй уулзав. Мөн Улаанбаатар хотын Ганц худаг, Зуунмод дахь урьдчилан хорих төвийн захиргааг эс тооцвол эрх баригчидтай бүрэн хамтран ажиллаж, Хүний эрхийн Үндэсний Комиссын комиссын гишүүд, хүний эрхийн төрийн бус байгууллагын төлөөлөл, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийлээ.

Тусгай илтгэгч Хүний эрхийн Үндэсний Комиссын 2005 онд зохион байгуулсан эрүү шүүлтийн талаарх олон нийтийн сонсголыг өндрөөр үнэлж, эрүү шүүлтийг таслан зогсоход чиглэсэн үйл ажиллагааг нь тууштай дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Мөн “Нөгөөтэйгүүр сүүлийн үед Монгол Улсад хууль тогтоомжийг шинэчлэх, Прокурорын дэргэд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг урвуулан ашиглахтай тэмцэх нэгж байгуулах зэрэг хүчин чармайлт гаргасаар байгаа ч эрүү шүүлт тулгах үйлдэл ялангуяа цагдаагийн газар, урьдчилан хорих ангиудад үргэлжилсээр байна” хэмээлээ.

Тэрээр цаазаар авах ялд хэрэглэж буй нууцлалд, ялангуяа албан ёсны мэдээлэл байхгүй байгаад санаа зовж байгаагаа илэрхийллээ. Тусгай илтгэгчийн хэлснээр цаазаар авах ялын хүнд нөхцөл байдал, ар гэрийнхэнд нь мэдэгдэхгүй байх зэрэг явдал нь хэрцгий харьцаж байгаа хэрэг юм. Мөн 30 жилийн хорих ял эдэлж буй хоригдлуудыг ганцаарчлан тусгаарлаж байгаа нь хүнлэг бус үйлдэл гэдгийг онцолжээ. Гэсэн хэдий ч шоронгийн «жирийн» дэглэм нь олон улсын жишигт нийцсэн гэж тэрээр ерөнхийд нь дүгнэв.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод заасан “эрүүдэн шүүх” гэсэн тодорхойлолт Эрүүгийн хуульд байхгүй байгаа тул Монгол Улсад эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэлгүй үлдэж байгааг, зүй бусаар харьцсан тухай гомдлыг хүлээн авах, шалгах үр дүнтэй механизм дутмаг, мөн эрүүдэн шүүхийг хориглохтой холбоотой олон улсын жишгийн талаар прокурор, хуульчид, шүүхийн байгууллага ойлголтоггүй

байгаа зэрэг асуудлуудыг Тусгай илтгэгч онцлон тэмдэглэв. Үүний улмаас эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан тохиолдолд нөхөн төлбөр, нөхөн сэргээх арга хэмжээ авах боломжгүй байдаг аж.

Тусгай илтгэгч Засгийн газарт урьдчилсан зөвлөмж хүргүүлсэн бөгөөд үүнд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолтын дагуу “эрүүдэн шүүх” үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж, зохих шийтгэл оногдуулах; “эрүү шүүлт тулгасан” гэх гомдлыг үр дүнтэй шалгаж, буруутай этгээдийг шүүхэд шилжүүлэх; Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг соёрхон баталж, цагдан хорих бүх газарт урьдчилан сэргийлэх ажлыг Хүний эрхийн үндэсний комисст хариуцуулахыг зөвлөв.

Тусгай илтгэгч Монгол Улсад хийх айлчлалыг зохион байгуулахад тусалсан Засгийн газар, Хүний эрхийн дээд комиссарын газар, НҮБ-ын суурин төлөөлөгчдөд талархаж буйгаа илэрхийлэв.

Түүний Монгол Улсад хийсэн айлчлалын тайлан Хүний эрхийн комиссын 62 дугаар чуулганд танилцуулагдах болно.

Ноён Новак 2004 оны 12 дугаар сарын 01-нд Тусгай илтгэгчээр томилогдсон. Тусгай илтгэгчийн хувьд тэрээр аль ч улсын Засгийн газраас хараат бус бөгөөд бие даасан байдлаар ажилладаг. Эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлыг шалгах тусгай илтгэгчийг томилох шийдвэрийг анх 1985 онд Комисс гаргаж байв. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг соёрхон баталсан эсэхээс үл хамааран түүний бүрэн эрх нь бүх улс орнуудыг хамарна.

Ноён Новак нь Хүчээр алга болгохтой тэмцэх ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байсан ба Югослав улсад сураггүй алга болсон хүмүүсийн асуудлаарх НҮБ-ын шинжээч, НҮБ-ын хүчээр алга болгохтой холбоотой хууль эрх зүйн асуудал хариуцсан шинжээч, Босни Герцеговина дахь Хүний эрхийн танхимын шүүгчээр тус тус ажиллаж байв. Тэрээр Венийн их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүй, хүний эрхийн профессор, Людвиг Больцманы нэрэмжит Хүний эрхийн хүрээлэнгийн захирал юм.

# НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХ АСУУДЛААРХ ТУСГАЙ ИЛТГЭГЧ, ДОКТОР АЛИС ЖИЛЛ ЭДВАРДС НЬ “ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ” ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГЫН ТОЙМЫГ 2024 ОНЫ НӨХЦӨЛ БАЙДЛААР ДҮГНЭЖЭЭ (англи хэлээр)

## Torture Trends and Developments: Annual Overview 2024

United Nations Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Dr Alice Jill Edwards

For full report  
click here

Summary of her report to the United Nations General Assembly 2024 (A/79/181)

The Special Rapporteur's report is in two parts. Part one is an annual overview of trends and developments, and in the second part, the Special Rapporteur presents her call for action on prohibiting, preventing and responding to sexual torture in armed conflict.

The year 2024 has seen devastating levels of torture and other outrages on human dignity in armed conflict, including:

- Evidence demonstrates that torture and other inhuman cruelty is Russian state policy in its war in Ukraine to intimidate, instil fear, punish, or extract information and confessions
- In Sudan warring parties are engaged in systematic campaigns involving arbitrary arrest, detention, and the torture and ill-treatment of civilians
- Evidence from the Hamas-led attacks in Israel on 7 October 2023 convincingly indicates that grave violations of international law took place including killings, hostage-taking, torture and sexual torture
- Credible allegations of torture, including sexual torture, and other cruel, inhuman or degrading treatment or punishment against detained Palestinians by Israeli forces were received and acted upon by the Special Rapporteur
- Despite the welcome, binding and urgent provisional measures issued by the International Court of Justice on Syria in November 2023, the Special Rapporteur continues to receive current and large-scale allegations of torture and other ill-treatment in the country

The Special Rapporteur also received communications and/or intervened on torture cases relating to conflict in Afghanistan, Azerbaijan, Burundi, Central African Republic, Chad, Colombia, Ethiopia, Guinea, India, Iraq, Ivory Coast, Kenya, Libya, Mexico, Myanmar, Nepal, Nicaragua, Nigeria, Rwanda, Sri Lanka, Syria, Uganda, and Yemen.

The Special Rapporteur is particularly concerned by the prevalence of allegations of sexual violence in conflicts, which is covered in detail in the thematic section of her report.

### Protests

The general trend towards authoritarianism in this year of elections is worrying. Recent protests have been driven by a desire for political change, by the continuing cost of living crisis and by reaction to global events. In many instances peaceful protests have been policed with excessive force or violence.

Over the past year there have been protests that resulted in violence *inter alia* in Angola, Argentina, Bangladesh, Belarus, Comoros, Congo, Georgia, Greece, Guatemala, Haiti, Iran, Israel, Jordan, Kenya, Kosovo, Madagascar, Mexico, Mozambique, Nepal, Pakistan, Papua New Guinea, Poland, Senegal, Serbia, Somalia, Spain, Sri Lanka, Türkiye and the United States.

Other notable trends include:

### Quashing political opposition through torture

- The Special Rapporteur intervened in many cases, including:
  - Alexei Navalny in Russia, whose death was a bleak day for human rights
  - the Jimmy Lai case in Hong Kong SAR, where proceedings have allegedly relied on torture-tainted evidence. Jimmy Lai has also been subjected to months of solitary confinement
  - the Julian Assange case in the United Kingdom. While the Special Rapporteur welcomes Mr. Assange's release, she encourages the United States to update their espionage and extradition laws to include safeguards for journalists and whistleblowers
- The decision of Suriname's highest court to uphold the prison sentence of former President Bouterse for torture and extrajudicial execution was welcomed
- In addition, the mandate received information on cases in Azerbaijan, Cambodia, China, Egypt, Eritrea, Laos, Palestine, Myanmar, Russia, Syria, Thailand, United Arab Emirates, Viet Nam and Zimbabwe. These represent a fraction of the States in which this repression takes place

### Hostage-diplomacy

This trend is deeply troubling and will be an ongoing focus for the mandate. The Special Rapporteur intervened on behalf of American Ryan Corbett, detained in Afghanistan.

A/79/181/Press Pack | 1

### Prison conditions

- Global prison conditions remain deeply concerning with far too many people imprisoned, for too long, in severely overcrowded facilities in all regions. The Special Rapporteur reported to the Human Rights Council on this in March ([A/HRC/55/52](#))
- Indeterminate sentences for public protection (IPP) that were introduced then disbanded in the **United Kingdom** continue to affect thousands and result in psychological torture. The new government must end this injustice
- The Supreme Court ruling in **Brazil** on the widespread violation of fundamental rights in prisons was welcome and the Special Rapporteur urges the government to swiftly draw-up the required nationwide action plan to end abuses
- She welcomes the decision of the Federal Police in **Australia** to stop using inhumane spit hoods on detainees

### Women and girls

Females remain at heightened risk of severe and gender-specific forms of torture and other ill-treatment.

- Their near total exclusion from public life in **Afghanistan** heightens the risk they face of violence
- In **Gaza**, military strikes by Israel have destroyed capacity to provide adequate medical care for mothers giving birth
- Reproductive restrictions continue in the **United States** where 14 states have criminalized abortion. The decision of the US Senate to block the federal right to contraception access was regrettable

### Death row

- Serious allegations were received about executions in **Afghanistan, Iran, Iraq, Saudi Arabia, the United States of America** and **Yemen**
- The execution of **Kenneth Eugene Smith** in **Alabama** in the **United States** with experimental nitrogen gas inhalation was a horrific development
- The reinstatement of the death penalty in **Congo**, after two decades, is a retrograde step

### Refugees

The situation for refugees and other displaced peoples is concerning. The Special Rapporteur highlights:

- The vulnerability of returnees to **Syria** to gross human rights violations, including torture and ill-treatment, which raises serious questions about the commitment of sending states to the prohibition of *refoulement*


- The Special Rapporteur is concerned about the situation of refugees in **Libya** who have allegedly been held captive and tortured
- The evacuation by **Australia** of the last refugee from the terrible conditions at the offshore processing facility in **Nauru** was short-lived, with the island now allegedly housing 100 or more asylum-seekers

### Notable legislative and judicial developments

- In December 2024 the fortieth anniversary of the Convention against Torture will be marked. This treaty is approaching universal ratification, with 174 States parties. The Special Rapporteur welcomes the accession of **Tuvalu**
- **Slovakia** and **Congo** joined the Optional Protocol to the Convention against Torture. Also notable was the establishment of a new national preventive mechanism in **Burkina Faso** and two local preventive mechanisms in **Brazil**
- The amendments to the Penal Code in **Côte d'Ivoire** to ensure acts of torture are considered as crimes in all circumstances are welcome
- At least 39 torture cases were or are being prosecuted via universal jurisdiction involving multiple offenders



A/79/181/Press Pack | 2



A79/181/Press Pack | 3

ХАВСРАЈТ



# Investigating, prosecuting and preventing wartime sexual torture, and providing rehabilitation to victims and survivors

United Nations Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, Dr Alice Jill Edwards

*Warning: The Special Rapporteur's report and the following summary contain information about sexual torture and sexual violence which may be triggering for victims and survivors*

## Introduction

Sexual torture is a profound exercise of power, leaving enduring scars that impact victims and future generations emotionally, physiologically, reproductively and socio-economically. It targets not only the direct victims but also has consequences for families, communities, and ethnic or religious groups, aiming to break their spirit and will.

The Special Rapporteur notes the alarming rise in reports of sexual torture in recent conflicts. Forty-six written contributions were received for this report, documenting allegations of torture in a wide range of countries, including *inter alia*, Afghanistan, Azerbaijan, Burundi, Central African Republic, Chad, Colombia, Côte d'Ivoire, Democratic Republic of the Congo, Ethiopia, Guinea, Iraq, Israel, Kenya, Libya, Mexico, Myanmar, Nepal, Nicaragua, Nigeria, occupied Palestinian territory, Russia, Rwanda, Sri Lanka, Sudan, Uganda, Yemen and the former Yugoslavia.

Dr Edwards' report to the General Assembly underscores the need for specialist care in recovery and calls for a reassessment of how sexual torture is perceived and addressed, noting the frequent impunity for perpetrators.

As part of her research for this report, the Special Rapporteur travelled to Dohuk and Erbil, Iraq in June 2024 and interviewed survivors of crimes committed by Islamic State in Iraq and the Levant.

## Defining Sexual Torture

Sexual torture can be any form of verbal, emotional, psychological or physical aggression that violates intimate areas. This includes forced nudity, rape and sexual assault, genital mutilation and forced pregnancies. It aims to inflict maximum humiliation and cruelty.

Women and girls, often targeted by male soldiers, suffer additional burdens such as forced pregnancies and social rejection. While men and boys are less frequent victims of sexual torture, this violence is under-reported. It is intended to emasculate and humiliate them.

Children are particularly vulnerable. Sexual torture causes severe developmental, emotional and psychological harm, with long-lasting impacts. LGBTQ+ individuals also face sexual torture, with the added risk that they may be criminalized instead of protected.

## The Special Rapporteur on Torture's Call for Action

Dr Edwards believes that states should fundamentally rethink how they tackle sexual aggression in wartime and other security situations. She argues that the legal framework for torture has significant advantages over the current approaches for combating sexual violence in conflict, especially for victims and survivors.

- **Binding legal framework**  
Conflict-related sexual violence continues to be committed relentlessly. Nearly all cases involve severe pain or suffering, which characterizes them as torture. The torture prohibition is binding on all States, offering protections that the sexual violence framework cannot. Torture is absolutely prohibited under customary international law, and superior orders are not a defence. There are no time limits on prosecutions or rehabilitation, and no one can claim immunity or amnesty. Protections for victims and witnesses are clear, and perpetrators should face the highest penalties.
- **Inclusivity of the torture framework**  
Security Council Resolution 1325 and the Women, Peace, and Security agenda acknowledges that there can be no peace without real and meaningful representation and participation of women and girls in peace processes, rebuilding and security. However, this focus on women and girls can exclude other victims of wartime sexual offences. Research shows that anyone, including civilians, soldiers, women, men, children and LGBTQ+ individuals, can be at risk of sexual torture in war. The torture framework applies to all who suffer severe pain or suffering.
- **Shame**  
There is no shame in being a victim of torture. Framing sexual violence as sexual torture redirects shame from victims to perpetrators. This helps to reduce stigma, as well as allow political, religious, and community leaders speak out more freely on behalf of survivors.

- **Consent**

Armed conflict restricts choice and autonomy, complicating consent in cases of rape, enslavement or other sexual aggression. Consent is not an element in the international crime of torture, simplifying legal proceedings for wartime sexual torture.

- **Evidence-gathering, Interviewing and Investigations**

Testimonial evidence is primary in cases of sexual violence and torture. Best practices for interviewing, documenting and investigating torture ensure that crimes are established and prosecuted, allowing victims and witnesses to fully recount their experiences.

- **Rehabilitation**

Few treaties mandate rehabilitation, but Article 14 of the Convention against Torture provides explicit rights to rehabilitation and compensation for victims.

## Special Rapporteur's observations and recommendations

### *Shifting shame and stigma to perpetrators*

Shame and stigma around sexual violence, including for children born of rape, impede recovery and justice. Survivors often face compounded trauma, intensified by community stigmatization, which leads to increased depression and anxiety.

The stigma must shift to perpetrators.

- **Torture Framework**

There is no shame in being a victim of torture, nor of sexual torture. Victims, their families and communities are not to blame. By accurately calling sexual offences torture, shame and stigma are removed from victims and placed on perpetrators.

- **Leadership**

Leaders can change societal attitudes towards victims. In **Iraq**, Yazidi leader Baba Sheikh's statement welcoming women liberated from ISIS reduced societal shame and aided healing. Faith-based organizations in Tigray, **Ethiopia**, support shunned survivors with essential services. In **Ukraine**, the Coordination Headquarters for the Treatment of Prisoners of War provides a judgment-free environment for war victims to discuss their experiences and receive rehabilitation.

- **Survivor Involvement**

Survivors must be co-creators of their rehabilitation. [The Kinshasa Declaration](#) demands that reparation programs address discriminatory taboos and that survivors should be stakeholders in designing and implementing policies. [The Bogota Declaration](#), from torture survivors in Latin America, stresses the need for victim involvement in public policy, highlighting their struggles with stigmatization and displacement.

### *Underreporting and delayed disclosure*

The Special Rapporteur notes that sexual torture in war is severely underreported, with estimates suggesting up to twenty cases remain undocumented for each case reported. Reports are typically late, complicating data collection and response efforts. Authorities should start with the assumption that sexual torture occurs in conflicts to better respond, collect evidence and assist victims, looking also for indicators like increased demand for emergency contraception and STI testing.

- **Barriers to Reporting**

War creates significant barriers to reporting sexual torture. Victims prioritize safety and survival over reporting. They may lack access to law enforcement or fear reprisal from powerful perpetrators. Monitoring bodies may be denied access. Displaced victims face legal and cultural challenges.

- **Social and Psychological Barriers**

Disclosure is hindered by trauma, stigma and the fear of reprisals. For male victims there is a fear of compromising their masculinity or, in places that criminalize same-sex relations, the fear of prosecution.

- **Confidentiality**

Survivors fear breaches of confidentiality. Confidentiality protocols and secure data management are essential to protect survivors. For example, in Ukraine victims can request security measures and legal documents avoid specific crime locations to prevent re-traumatization and stigmatization.

### *Evidence gathering*

There is often a lack of evidence in cases of sexual torture in conflict which leads to injustice.

- **Reporting and Evidence Challenges**

Areas may be inaccessible, and evidence can deteriorate over time. Perpetrators may destroy evidence by bombing or burning. Medical and forensic infrastructure may be damaged, and rape kits are often unavailable. Physical injuries may only be present in a minority of victims and may heal quickly. The identities of perpetrators may be unknown which limits the usefulness of DNA evidence.

- **Psychological Impact and Evidence Collection**

Many acts of sexual torture aim at psychological torment, such as forcing victims to witness against loved ones. [The Istanbul Protocol](#) provides guidelines for documenting psychological and physical evidence of torture. Evidence types include testimonials, physical evidence from examinations and locations, digital evidence (videos, photos, satellite imagery) and documentary evidence. Circumstantial and testimonial evidence are often sufficient to substantiate war-time crimes if this evidence is reliable and credible.

### *Interviewing survivors and witnesses*

Interviewing survivors of sexual torture requires skill, training and emotional intelligence. The quality of the interview impacts the reliability of information and the willingness of survivors to share their stories, which affects the outcome of criminal proceedings.

- **Rapport Building**  
Rapport building is crucial, and victims should describe their experiences in their own way. Interviewers must be trained to elicit sensitive information ethically and reliably, without causing further harm or security risks. Open-ended questions – as recommended by the [Istanbul Protocol](#) – allow survivors to lead the narrative and are important practices.
- **Ethical Interviewing Practices**  
Properly conducted interviews can aid in survivors' recovery, and embedding psychologists in investigation teams ensures continual assessment.
- **Addressing Gender Disparities**  
The Special Rapporteur notes disparities in interviewing men and women, with female survivors often having their experiences narrowly classified as rape or other sexual offences, rather than torture. Survivors should be allowed to share their full experiences to ensure all potential crimes are recognized.
- **Interviewer Selection and Interpreter Training**  
Whenever possible, survivors should choose the sex/gender of their interviewer, and interpreters should be trained in cultural and linguistic nuances. Recording interviews can alleviate cognitive load and provide accurate records.
- **Remote Interviewing**  
Remote interviews can be useful in conflict-affected areas but should only be conducted when necessary, with comprehensive threat and risk assessments.
- **Support and Burnout Prevention**  
Interviewers and interpreters face significant cognitive and emotional pressure, and both survivors and interviewers need breaks and support. High rates of burnout among interviewers can be mitigated through proper training and support.

#### **Most Recent Reports by Dr Alice Jill Edwards, UN Special Rapporteur on Torture**

October 2023, [Global trade in weapons, equipment and devices that are capable of inflicting torture](#), General Assembly, A/78/324

March 2024, [Current issues and good practices in prison management](#), Human Rights Council A/HRC/55/52

### *Understanding offender behaviour to strengthen prevention*

Despite international and national investments in education, training, investigations and prosecutions, wartime sexual crimes and torture continue with impunity. Accountability can have a preventive effect, but addressing the underlying causes and catalysts of sexual torture is crucial.

- **Root Causes and Magnification in Wartime**  
Sexual violence against women and girls stems from misogyny, inequality, and discrimination, perpetuated by legal, social, cultural, economic and religious systems that devalue women and establish male dominance. These drivers, which are present in civilian life, are magnified in wartime.
- **Conflict-Specific Causes**  
In conflict situations, political and economic entrenchment of difference and hatred, as well as selective targeting to foment terror and to destroy social cohesion contribute to the perpetration of torture. Sexual torture is used in political and military strategies to oppress, control, exact revenge and is mistakenly believed by some to be effective in eliciting intelligence or confessions.
- **Terrorist Policies and Rewards**  
Some terrorist entities authorize sexual violence, including sexual enslavement and child marriage, as part of their ideologies. Rape may compensate or reward troops, especially with inadequate salaries. Historical examples include “comfort women” in WWII, rape hotels in [Bosnia and Herzegovina](#), and ISIS’s sexual enslavement of Yazidi and other women, girls and boys.
- **Military Strategies and Rape Culture**  
Appalling acts may be part of State military or political strategies through explicit or implicit orders. Wartime breaks peacetime norms, with military cultures often characterized by misogyny and “rape culture.” Group mentality can lead to multiple perpetrator rape to build cohesion within units.
- **Understanding Perpetrators**  
Research shows most perpetrators are not sadists or psychopaths. Social structures, situations and psychological stressors lead “ordinary people” to become torturers. Factors include obedience to authority, training, manipulation of emotions and dehumanization of victims.
- **Importance of Understanding Offender Behaviour**  
Understanding perpetrators’ motives and incentives is crucial for eradicating torture and its sexual manifestations. This knowledge helps to prevent future torture and to ensure targeted interventions, without excusing criminal responsibility.



## Dr Alice Edwards biography

Dr Alice Edwards was appointed in July 2022 by the UN Human Rights Council to the position of UN Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman Treatment or Punishment. She took office on 1 August 2022. Dr Edwards, an established human rights lawyer and academic, is the seventh Special Rapporteur on Torture, and the first woman to fill the mandate.

As the UN's leading expert on torture, Dr Edwards is at the forefront of global efforts to combat torture. Her role includes conducting fact-finding country visits and pursuing justice for victims of state-sanctioned violence.

Between 2016 and 2021 Dr Edwards headed the Secretariat of the Convention against Torture Initiative (CTI), an initiative of the governments of Chile, Denmark, Fiji, Ghana, Indonesia and Morocco, which aimed at achieving universal ratification and implementation of the UN Convention against Torture (UNCAT).

Prior to this, Dr Edwards was the Principal Legal Coordinator and Chief of Protection Policy and Legal Advice at the UN Refugee Agency (UNHCR). She was responsible for initiating and leading the implementation of the UNHCR's Global Strategy – Beyond Detention, a blueprint for action to support governments to end the routine detention of asylum seekers through constructive dialogue, technical advice and capacity building. Dr Edwards drafted the first set of guidelines on gender-related persecution and the current guidelines on detention and alternatives to detention.

Dr Edwards has spent her twenty-five-year career working for the rights of victims of human rights violations, including in the major conflict situations of Bosnia and Herzegovina, Mozambique and Rwanda. Among her achievements is the now globally recognised doctrine that rape and sexual violence are forms of torture and persecution, meriting international refugee protection. Her book, *Violence Against Women under International Human Rights Law* has influenced policies in a number of countries. She was also responsible for initiatives in advising States on reforming domestic laws to include torture as a prosecutable offence.

*If journalists would like to interview Dr Edwards about her report to the HRC or other aspects of her work please contact:*

**Crispin Thorold, Strategic Communications Advisor**  
cthorold@gmail.com +1 (647) 980 1973

**Alessandro Marra** alessandro.marra@un.org  
HRC-sr-torture@un.org +41 22 917 2059



© Condula Trembl

### Note on the mandate of the UN Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman and Degrading Treatment or Punishment

The mandate of the Special Rapporteur covers any act or omission amounting to torture and ill-treatment under applicable international customary and treaty law. The Special Rapporteur is authorised to examine questions relating to the prohibition, prevention, investigation and redress of such abuse in all current and aspiring member States of the United Nations, regardless of their treaty obligations.

The three-year mandate, established in 1985 by a resolution of the UN Commission on Human Rights, is the UN's second oldest. Dr Alice Edwards is the first woman in the role of Special Rapporteur on Torture in its nearly four-decade history.

In fulfilling the mandate, the Special Rapporteur conducts country visits, communicates with governments concerning information and complaints about alleged cases of torture, legislations or policies that might be in breach of certain human rights. The Special Rapporteur also submits activity reports to the UN General Assembly and Human Rights Council.

The UN Special Rapporteur on Torture and Other Cruel, Inhuman and Degrading Treatment or Punishment is one of the thematic special procedures which are independent human rights experts appointed by the UN Human Rights Council.

A/79/181/Press Pack | 8

**НҮБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ  
БУСААР БҮЮУ БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХ  
АСУУДЛААРХ ТУСГАЙ ИЛТГЭГЧ, ДОКТОР АЛИС ЖИЛЛ ЭДВАРДС НЬ “ЭРҮҮ  
ШҮҮЛТ ТУЛГАХ” ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГЫН ТОЙМЫГ 2024 ОНЫ НӨХЦӨЛ  
БАЙДЛААР ДҮГНЭЖЭЭ (албан бус орчуулга, монгол хэлээр)**

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс нь “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн чиг хандлагын тоймыг 2024 оны нөхцөл байдлаар дүгнэжээ<sup>253</sup>.

**ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА: 2024 ОНЫ ТОЙМ**

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх Тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2024 оны чуулган (А/79/181)-д тавьсан илтгэлийн хураангуй

Тусгай илтгэгчийн илтгэл хоёр хэсэгтэй. Нэгдүгээр хэсэг нь чиг хандлага, хөгжлийн талаарх жилийн тойм бөгөөд хоёрдугаар хэсэгт Тусгай илтгэгч зэвсэгт мөргөлдөөн дэх бэлгийн эрүү шүүлтийг хориглох, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар өөрийн уриалгыг танилцуулав.

Зэвсэгт мөргөлдөөний үеэр эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжлох үйлдлүүд 2024 онд гамшгийн хэмжээнд хүрлээ, тухайлбал:

- ОХУ-ын Украинд хийж буй зэвсэгт мөргөлдөөнд айлган сүрдүүлэх, айдас төрүүлэх, шийтгэх, мэдээлэл, мэдүүлэг авах зорилгоор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус харгислал явуулах бодлого баримталж байгааг нотлох баримт харуулж байна.
- Суданд дайтаж буй талууд дур зоргоороо саатуулах, баривчлах, энгийн иргэдийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах зэрэг системтэй кампанит ажил явуулж байна.
- ХАМАС тэргүүтнүүдийн 2023 оны 10 дугаар сарын 07-нд Израильд явуулсан халдлагын үеэрх нотлох баримтууд нь аллага үйлдэх, барьцаалах, эрүүдэн шүүх, бэлгийн эрүү шүүлт тулгах зэрэг олон улсын хуулийг ноцтой зөрчсөн гэмт хэрэг үйлдэгдсэнийг батлан харуулж байна.
- Израилийн цэргүүд баривчлагдсан Палестинчуудын эсрэг эрүүдэн шүүлт, тэр дундаа бэлгийн эрүү шүүлт, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн тухай баттай мэдээллийг Тусгай илтгэгч хүлээн авч, шийдвэрлэсэн.
- Олон улсын шүүхээс 2023 онд гаргасан Сирийн асуудлаар яаралтай авах түр зуурын арга хэмжээний тухай шийдвэрийн дагуу арга хэмжээ

<sup>253</sup> [202410-unsrt-sexualtorture-q-a.pdf](#)

авагдсан хэдий ч тус улсад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, зүй бусаар харьцсан тухай мэдэгдлүүд Тусгай илтгэгчид ирсэн хэвээр байна.

Тусгай илтгэгч Афганистан, Азербайжан, Бурунди, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Колумби, Этиоп, Гвиней, Энэтхэг, Ирак, Зааны ясан эрэг, Кени, Ливи, Мексик, Мьянмар, Балба, Никарагуа, Нигери, Урванда, Шри-Ланка, Сири, Уганда, Йемэн зэрэг улсууд дахь зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой эрүүдэн шүүх хэргийн талаар мэдээлэл хүлээн авав.

Тусгай илтгэгч зэвсэгт мөргөлдөөн дэх бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээлэл зонхилж байгаад онцгойлон санаа зовниж байгаа бөгөөд тэрээр тухай илтгэлийнхээ сэдэвчилсэн хэсэгт дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

### **Эсэргүүцэл**

Энэ жилийн тухайд сонгууль болж буйтай холбоотой дарангуйлах ерөнхий хандлага зонхилж байгаад санаа зовоож байна. Сүүлийн үеийн эсэргүүцлийн жагсаал нь улс төрийн өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэл, амьжиргааны өртгийн үргэлжилсэн хямрал, дэлхийн үйл явдлуудад үзүүлэх хариу үйлдэл зэргээс үүдэлтэй. Ихэнх тохиолдолд тайван жагсаалыг цагдаа нар хэт их хүч хэрэглэн дарж байв.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Ангол, Аргентин, Бангладеш, Беларусь, Комор, Конго, Гүрж, Грек, Гватемал, Гаити, Иран, Израиль, Йордан, Кени, Косово, Мадагаскар, Мексик, Мозамбик, Балба, Пакистан, Шинэ Гвиней, Польш, Сенегал, Серб, Сомали, Испани, Шри-Ланка, Турк, АНУ зэрэг улсуудад зохион байгуулагдсан жагсаал цуглаан хүчирхийлэл, эмх замбараагүй байдалд хүргэв.

Бусад онцлох чиг хандлага:

*Улс төрийн сөрөг хүчнийг эрүүдэн шүүх замаар нухчин дарах*

- Тусгай илтгэгч олон хэрэгт хөндлөнгөөс оролцсон бөгөөд үүнд:
  - \* Алексей Навальный нас барсан тэр өдөр Орос улс дахь хүний эрхийн хар бараан өдрөөр тэмдэглэгдэв.
  - \* Эрүүдэн шүүж авсан нотлох баримтад тулгуурлаж хэргийг нь хянан шийдвэрлэсэн гэх Хятадын Засаг захиргааны онцгой бүс Хонкон дахь Жимми Лайгийн хэрэг. Жимми Лай хэдэн сарын турш ганцаарчлан хоригдож байсан.
  - \* Их Британи дахь Жулиан Ассанжийн хэрэг. Тусгай илтгэгч ноён Ассанжийг суллагдсаныг сайшааж байгаа ч АНУ-ыг тагнуулын болон шилжүүлэн өгөх хуульдаа сэтгүүлчид болон мэдээлэгчдийг хамгаалах арга хэмжээ багтаахыг уриалав.
- Эрүү шүүлт тулгаж, шүүхээс гадуур цаазаар авсан гэх Ерөнхийлөгч асан Бутерсегт холбогдох хэрэгт оноосон хорих ялыг хэвээр үлдээхээр Суринамын дээд шүүх шийдвэрлэв.
- Үүнээс гадна Азербайжан, Камбож, Хятад, Египет, Эритрей, Лаос, Палестин, Мьянмар, Орос, Сири, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират, Вьетнам, Зимбабве зэрэг улсад энэ төрлийн хэргийн талаар мэдээллийг



Тусгай илтгэгч хүлээн авав. Эдгээр нь хэлмэгдүүлэлт явагдаж буй улс орнуудын зөвхөн нэгээхэн хэсэг юм.

### **Барьцааны дипломат ажиллагаа**

Энэ чиг хандлага нь сэтгэл түгшээж байгаа бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд байнгын анхаарал хандуулах болно. Тусгай илтгэгч нь Афганистанд баривчлагсан Америк улсын иргэн Райн Корбеттийн өмнөөс хөндлөнгөөс оролцсон.

- Дэлхийн даяарх шоронгийн нөхцөл бүх бүс нутагт хэт олон хүн, хэт их ачаалалтай хорих байгууламжид удаан хугацаагаар хоригдож буй байдал хэвээр байна. Тусгай илтгэгч энэ талаар өнгөрсөн гуравдугаар сард Хүний эрхийн зөвлөлд мэдээлсэн (A/HRC/55/52)
- Их Британы Вант Улсад нэвтрүүлээд, дараа нь цуцалсан олон нийтийг хамгаалах тодорхой хугацаагүй ял (IPP) -ын бодлого нь олон мянган хүнд нөлөөлж, сэтгэл зүйн эрүү шүүлт учруулдаг. Шинэ Засгийн газар энэ шударга бус явдлыг таслан зогсоох ёстой.
- Бразил улсын Дээд шүүхээс гаргасан шоронд хүний үндсэн эрх маш түгээмэл зөрчигдөж буй талаарх шийдвэр нь сайшаалтай юм. Тусгай илтгэгч Засгийн газраас хүчирхийллийг таслан зогсооход шаардлагатай үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг яаралтай боловсруулахыг уриалав.
- Тэрээр саатуулагдсан иргэд рүү нулимаж, юүдэн хэрэглэж буй хүнлэг бус үйлдлийг зогсоох талаар гаргасан Австрали улсын Холбооны цагдаагийн газрын шийдвэрийг сайшааж байна.

### **Охид, эмэгтэйчүүд**

Эмэгтэйчүүд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах хүнд хэлбэрийн болон жендерт суурилсан эрүү шүүлтийн өвөрмөц хэлбэрт өртсөөр байна.

- Афганистан дахь эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралаас бараг бүхэлд нь хассан нь тэд хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Газын зурваст Израилийн цэргийн цохилтын улмаас хүүхэд төрүүлж буй эхчүүдэд зохих эмнэлгийн тусламж үзүүлэх боломжгүй болсон байна.
- АНУ-д 14 муж үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцсон нөхөн үржихүйн хязгаарлалт үргэлжлэн явагдаж байна. АНУ-ын Сенатаас жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийг ашиглах холбооны эрхийг хаах шийдвэр гаргасан нь харамсалтай.

### **Цаазын ял**

- Афганистан, Иран, Ирак, Саудын Араб, АНУ, Йемен зэрэг улсад цаазаар авах ял гүйцэтгэсэн тухай ноцтой мэдээллүүд ирсэн.
- Алабама мужид (АНУ) Кеннет Южин Смитийг азотын хийгээр амьсгалуулах туршилтын аргаар цаазалсан нь аймшигтай үйл явдал байв.
- Конгод 20 жилийн дараа цаазаар авах ялыг сэргээсэн нь ухарсан алхам юм.

## Дүрвэгсэд

- Дүрвэгсэд болон бусад шилжин суурьшигчдын нөхцөл байдал түгшүүртэй байна. Тусгай илтгэгч дараах зүйлийг онцлон тэмдэглэв.
- Сири рүү буцаж ирсэн хүмүүс эрүүдэн шүүх, зүй бус харьцах зэрэг хүний эрхийн бүдүүлэг зөрчилд өртөмтгий байгаа нь улс орнуудын буцаан шилжүүлэхийг хориглох амлалтад эргэлзээ төрүүлж байна.
- Ливид олзлогдож, эрүүдэн шүүгдэж байгаа дүрвэгсдийн байдалд Тусгай илтгэгч санаа зовж байна.
- Австрали улс нь Науру дахь дүрвэгсдийн хуарангийн аймшигт нөхцөл байдлаас болж яаралтайгаар дүрвэгчийг нүүлгэн шилжүүлсэн бөгөөд өдгөө тус арал дээр 100 ба түүнээс дээш орогнол хүсэгч байрлаж байна.

## Хууль тогтоох, шүүх эрх мэдлийн онцлох үйл явдлууд

- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын дөчин жилийн ой 2024 оны арванхоёрдугаар сард тохионо. Энэхүү гэрээнд нийт 174 орон нэгдэн ороод байгаа бөгөөд дэлхий нийтээр соёрхон батлахад тун ойртож байна. Тусгай илтгэгч Тувалу улс нэгдсэнийг сайшааж байна.
- Словак, Конго улсууд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нэгдэв. Түүнчлэн Буркина Фасо улсад ЭШУС үндэсний ажиллагаа шинээр, Бразил улсад орон нутгийн хоёр ЭШУС ажиллагаа бий болсон нь тэмдэглүүштэй.
- Кот-д'Ивуар дахь Эрүүгийн хуульд эрүүдэн шүүх үйлдлийг ямар ч нөхцөлд гэмт хэрэг гэж үзэх нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар зэхэж байна.

*Дайны үеийн бэлгийн эрүү шүүлтийг мөрдөн шалгах, ял шийтгэл хүлээлгэх, урьдчилан сэргийлэх, хохирогч болон даван туулагдсыг нөхөн сэргээх*

*НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх Тусгай илтгэгч, доктор Алис Жилл Эдвардс*

**Анхааруулга:** Тусгай илтгэгчийн тайлан болон дараах хураангуй нь хохирогч болон даван туулагдсад нөлөөлж болзошгүй бэлгийн эрүү шүүлт, бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийг агуулсан болно.

## Танилцуулга

Бэлгийн эрүү шүүлт нь хохирогчид болон хойч үеийнхний сэтгэл санаа, бие махбод, нөхөн үржихүй, нийгэм-эдийн засгийн хувьд арилшгүй ул мөр үлдээдэг эрх мэдлээ ашиглах хэрэглүүр юм. Энэ нь зөвхөн хохирогчдод төдийгүй тэдний гэр бүл, олон нийт, угсаатны болон шашны бүлгүүдийн хүсэл зориг, сэтгэл санааг эвдэх зорилготой юм.

Сүүлийн үеийн мөргөлдөөний үеэр бэлгийн эрүү шүүлтийн талаарх мэдээлэл түгшүүртэйгээр нэмэгдэж байгааг Тусгай илтгэгч тэмдэглэв. Афганистан, Азербайжан, Бурунди, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Колумби, Кот-д'Ивуар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Этиоп, Гвиней, Ирак, Израиль,

Кени, Ливи, Мексик, Мьянмар, Балба, Никарагуа, Нигери, Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Орос, Рванда, Шри-Ланка, Судан, Уганда, Йемен, хуучин Югослав зэрэг олон улс оронд үйлдэгдсэн эрүү шүүлтийг баримтжуулсан 46 материалыг энэхүү тайлангийн хүрээнд хүлээн авсан.

Доктор Эдвардс Ерөнхий Ассамблейд тавьсан илтгэлдээ нөхөн сэргээхэд нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх шаардлагатайг онцолж, бэлгийн эрүү шүүлтийн тухай ойлголт, шийдвэрлэлтийг дахин үнэлж, дүгнэхийг уриалж, энэ гэмт хэргийг үйлдэгч бүр ял шийтгэлгүй өнгөрч байгааг цохон тэмдэглэжээ.

Тусгай илтгэгч энэхүү тайлангийн судалгааны ажлынхаа хүрээнд 2024 оны 06 дугаар сард Ирак улсын Дохук, Эрбил хотод айлчилж, Иракийн Левант дахь Исламын улс бүлэглэлийн үйлдсэн гэмт хэргээс амьд үлдсэн хүмүүстэй ярилцлага хийсэн.

### **Бэлгийн эрүү шүүлтийг тодорхойлох**

Бэлгийн эрүү шүүлт нь хүний биеийн эмзэг хэсгүүдэд үзүүлж буй үг хэл, сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн болон бие махбодын түрэмгийлэл бөгөөд хамгийн ихээр гутаан доромжлох, харгислал үзүүлэх зорилгоор албадан нүцгэлэх, хүчиндэх, бэлгийн хүчирхийлэл үзүүлэх, бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, албадан жирэмслүүлэх зэрэг үйлдлүүд багтана.

Ихэнхдээ эрэгтэй цэргүүдид олзлогдсон охид, эмэгтэйчүүд өөрийн хүсэл зоригоос гадуур жирэмсэлж, үүнээсээ улбаалж нийгмийн гадуурхалтад өртөх зэргээр нэмэлт дарамтыг амсдаг. Эрэгтэйчүүд, хөвгүүд бэлгийн эрүү шүүлтэд өртөх нь бага ч энэ төрлийн хүчирхийллийн талаар мэдээлэл бага байдаг. Энэ нь тэднийг гутаан доромжлох зорилготой юм.

Хүүхдүүд ялангуяа эмзэг байдаг. Бэлгийн эрүү шүүлт нь хөгжил, сэтгэл хөдлөл, сэтгэлзүйн хувьд ноцтой хохирол учруулдаг бөгөөд урт хугацааны үр дагаварт хүргэдэг. ЛГБТК+ хүмүүс ч бас бэлгийн эрүү шүүлтэд өртөж байгаа нь тэднийг хамгаалахын оронд гэмт хэрэгт тооцох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

### **Эрүүдэн шүүлтийн асуудлаарх тусгай илтгэгч**

Улс орнууд дайн болон бусад аюулгүй байдлын үед бэлгийн түрэмгийллийг хэрхэн шийдвэрлэх талаар ул үндсээр нь эргэцүүлэн харах ёстой гэж Доктор Эдвардс үзэж байна. Эрүүдэн шүүхтэй тэмцэх эрх зүйн орчин нь ялангуяа хохирогч, даван туулагчдын тухайд зэвсэгт мөргөлдөөний үеийн бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх өнөөгийн арга барилаас илүү давуу талтай гэж тэрээр үзэж байна.

#### **• Заавал дагаж мөрдөх эрх зүйн орчин**

Зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэл тасралтгүй гарсаар байна. Бараг бүх тохиолдлууд нь эрүү шүүлтэд тооцогддог хүнд өвдөлт, зовлон шаналал учруулдаг. Бэлгийн хүчирхийллийн эсрэг эрх зүйн орчны бий болгож чаддаггүй хамгаалалтыг эрүү шүүлтийн хориг үзүүлдэг бөгөөд бүх улс оронд заавал байх ёстой эрх зүйн орчин юм. Олон улсын заншлын дагуу эрүүдэн шүүхийг туйлын хориглодог. Яллах, цагаатгахад хөөн хэлэлцэх хугацаа гэж байхгүй, хэн ч дархан эрх, өршөөлд хамрагдах эрхгүй. Хохирогч, гэрчийг хамгаалах асуудал тодорхой бөгөөд гэмт хэрэгтэн хамгийн өндөр хариуцлага хүлээх ёстой.

- **Эрүү шүүлтийн хамарсан хүрээ**

Аюулгүйн зөвлөлийн 1325 тоот тогтоол ба Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын хөтөлбөрт эмэгтэйчүүд, охидын энхтайвны үйл явц, сэргээн босголт, аюулгүй байдалд бодитой бөгөөд утга учиртай төлөөлөл, оролцоогүйгээр энх тайвныг цогцлоож чадахгүй гэдгийг онцолсон. Хэдий тийм ч охид, эмэгтэйчүүдэд чиглэж буй энэхүү бодлого дайны үеийн бэлгийн хүчирхийллийн бусад хохирогчдыг орхигдуулах магадлалтай. Энгийн иргэд, цэрэг, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүд, ЛГБТК+ нийгэмлэгийн гишүүд зэрэг хэн ч дайны үеэр бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг нь судалгаагаар тогтоогджээ. Эрүү шүүлтэд өртсөн гэх асуудал нь хүнд өвдөлт, зовлон шаналалыг амссан хэн бүхэнд хамаарна..

- **Ичгүүр**

Эрүү шүүлтийн золиос болох нь ичгүүртэй явдал биш юм. Бэлгийн хүчирхийллийг бэлгийн эрүү шүүлт гэж үзэх нь энэ ичгүүрийг хохирогч биш хүчирхийлэгч үйлдэгч эдлэхэд хүргэх учиртай. Энэ нь гутаан доромжлох үзлийг бууруулахаас гадна улс төрч, шашин, олон нийтийн удирдагчид даван туулагсдын өмнөөс илүү чөлөөтэй үг хэлэх боломжийг олгодог.

- **Зөвшөөрөх**

Зэвсэгт мөргөлдөөн нь сонголт хийх, бие даасан байдлыг хязгаарлаж, хүчин, боолчлол эсвэл бусад бэлгийн хүчирхийллийг зөвшөөрөхөд хүргэдэг. Зөвшөөрнө гэдэг ойлголт олон улсын эрүүдэн шүүх гэмт хэргийн бүрэлдэхүүн биш тул дайны үеийн бэлгийн эрүүдэн шүүх хэргийг шийдвэрлэхэд хялбар болгодог.

- **Нотлох баримт цуглуулах, ярилцлага хийх, мөрдөн шалгах**

Бэлгийн хүчирхийлэл, эрүүдэн шүүх хэргийг илрүүлэх гол зүйл нь нотлох баримт юм. Эрүү шүүлт тулгасан гэмт хэргийн мэдүүлэг авах, баримтжуулах, мөрдөн шалгах шилдэг арга барил нь уг гэмт хэргийг илрүүлж, яллах боломжийг бүрдүүлж, хохирогч, гэрчүүдэд өөрсдийн туулж мэдэрсэн зүйлийг бүрэн тайлагнаж ярих боломжийг олгодог.

- **Нөхөн сэргээлт**

Цөөн тооны олон улсын гэрээ нөхөн сэргээх үүргийг хүлээлгэсэн байдаг ч Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлд хохирогчдыг нөхөн сэргээх, нөхөн олговор олгох эрхийг тодорхой заасан байдаг.

***Тусгай илтгэгчийн ажиглалт, зөвлөмж***

***Гэмт этгээдүүд ичгүүр, доромжлолыг үүрэх ёстой***

Бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд, тэр дундаа хүчингийн улмаас эхийн хэвлийд бүрэлдэж төрсөн хүүхдүүдийн зүг ичгүүр, доромжлол ирдэг нь эдгээр хүмүүсийг нөхөн сэргээх, шударга ёс тогтооход саад учруулж байна. Хохирогчид ихэвчлэн олон нийтийн зүгээс ирэх доромжлолын улмаас хүнд гэмтэл авч, улмаар сэтгэлийн хямрал, түгшүүрт автдаг.

- **Эрүү шүүлтийн хүрээ**

Эрүүдэн шүүлт, бэлгийн эрүү шүүлтийн золиос болоход ичгүүртэй зүйл үгүй юм. Хохирогчид, тэдний гэр бүл, хамт олон ч буруугүй. Бэлгийн хүчирхийллийн

гэмт хэргийг “эрүү шүүлт” гэж үнэн зөв тодорхойлсноор бид хохирогчдод ирэх ичгүүр, доромжлолыг арилгаж, гэмт хэрэгтнүүд рүү зүглүүлдэг.

- **Манлайлал**

Хохирогчдод хандах нийгмийн хандлагыг Удирдагчид өөрчилж чадна. Ирак улсад Язидигийн удирдагч Баба Шейх нь Ирак, Сирийн Исламын улсаас чөлөөлөгдсөн эмэгтэйчүүдийг угтан авсан тухай мэдэгдэл нь нийгмийн ичгүүрийг бууруулж, нөхөн сэргэхэд нь тусалсан. Этиоп улсын Тиграй дахь шашны байгууллагууд хохирогчдод зайлшгүй шаардлагатай үйлчилгээгээр дэмжлэг үзүүлдэг. Украинд Дайны олзлогдогсодтой харьцах ажлыг зохицуулах штаб нь дайнд нэрвэгдэгсэд өөрсдийн туршлагаа ярилцаж, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэж болохуйц шүүн хэлэлцэх зорилгоос ангид орчныг бүрдүүлж өгдөг.

- **Хохирогчдын оролцоо**

Хохирогчид өөрсдийн нөхөн сэргээх явцыг хамтран бүтээгчид байх ёстой. Нөхөн сэргээх хөтөлбөрүүд нь ялгаварлан гадуурхах явдлыг хориглоход чиглэх бөгөөд бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хохирогчид өөрсдөө оролцогч тал байх ёстой хэмээн Киншасагийн тунхаглал шаарддаг. Латин Америкийн эрүү шүүлтийн хохирогчдын баталсан Боготагийн тунхаглалд хохирогчид төрийн бодлогод оролцох шаардлагатайг онцлон тэмдэглэж, тэднийг гадуурхах, гутаан доромжлолын эсрэг тэмцлийг онцлон тэмдэглэжээ.

- **Хугацаа хоцорсон, дутуу тайлагнал**

Дайны үед үйлдэгддэг бэлгийн эрүү шүүлтийн талаарх мэдээ маш дутуу тайлагнагддаг, тайлагнал мэдээлэл бүрд хорь хүртэлх тохиолдол нь баримтжуулалтгүй үлддэг гэсэн тооцоо бий талаар Тусгай илтгэгч дурдлаа. Тайлан хугацааны хувьд ихэвчлэн хоцорсон байдаг нь мэдээлэл цуглуулах, хариу арга хэмжээ авахад хүндрэл учруулдаг. Бэлгийн эрүү шүүлт нь мөргөлдөөний үед гардаг гэсэн таамаглалаас авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ улс орнуудын эрх баригчид эхлүүлэх ёстой бөгөөд илүү сайн хариу арга хэмжээ авах, нотлох баримт цуглуулах, хохирогчдод дэмжлэг үзүүлэх, түүнчлэн жирэмслэлтээс хамгаалах яаралтай тусламжийн арга хэрэгслийн хэрэгцээ нэмэгдсэн эсэх, БЗХӨ-ий шинжилгээ зэрэг үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

- **Мэдээллийн саад бэрхшээл**

Дайны нөхцөл байдал бэлгийн эрүү шүүлтийн талаар мэдээлэхэд ихээхэн бэрхшээлийг бий болгодог. Хохирогчид эрүү шүүлтэд өртсөн талаараа мэдээлэхээс илүүтэй аюулгүй байдал, эсэн мэнд амьд гарахыг л чухалчилдаг. Тэд нэг талаар хууль сахиулах байгууллагад хандах боломжгүй байх эсвэл гэмт хэрэгтнүүдийн дарангуйллаас айж буй байж болох. Хяналтын байгууллагуудад нэвтрэх эрхийг хориглож болно. Нүүлгэн шилжүүлсэн хохирогчид хууль эрх зүйн болон соёлын бэрхшээлтэй тулгардаг.

- **Нийгэм, сэтгэл зүйн саад бэрхшээл**

Авсан гэмтэл, доромжлол, хэлмэгдүүлэлтээс айх айдас зэрэг нь хохирогч болсноо илчлэн мэдээлэхэд саад болж байна. Хохирогч эрчүүдийн хувьд эр хүний мөн чанараа алдахаас эсвэл ижил хүйсийн харилцааг гэмт хэрэгт тооцдог газруудад шийтгэгдэхээс айдаг байна.

- **Нууцлал**

Амьд үлдсэн хүмүүс нууцлалыг зөрчихөөс айдаг. Амьд үлдсэн хүмүүсийг хамгаалахын тулд нууцлалын протоколууд болон аюулгүй мэдээллийн менежмент нь чухал юм. Жишээлбэл, Украинд хохирогчид дахин гэмтэх, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэхийн тулд аюулгүй байдлын арга хэмжээ авах, хууль эрх зүйн баримт бичгүүдийг авах хүсэлт гаргаж, гэмт хэргийн тодорхой байршлаас зайлсхийх боломжтой.

- **Нотлох баримт цуглуулах**

Зэвсэгт мөргөлдөөний үед бэлгийн хүчирхийлэлд өртсөн хэргийн нотлох баримт хомс байдаг нь шударга бус явдалд хүргэдэг.

- **Тайлан, нотлох баримттай холбоотой асуудал**

Тухайн газруудад нэвтрэх боломжгүй байх ба нотлох баримт нь цаг хугацааны явцад муудах магадлалтай. Гэмт этгээдүүд дэлбэлэх, шатаах замаар нотлох баримтыг устгаж болно. Эмнэлгийн болон шүүх эмнэлгийн дэд бүтэц эвдрэх, хүчингийн хохирогчид тусламж боломжгүй байдаг. Бие махбодийн гэмтэл нь зөвхөн хохирогчдын цөөхөн хэсэгт л тохиолдож болох бөгөөд хурдан эдгэрдэг. Гэмт этгээдүүдийн хэн болох нь тодорхойгүй байж болох ба энэ нь ДНХ-аар нотлоход хязгаарлалт үүсгэдэг.

- **Сэтгэлзүйн нөлөөлөл ба нотлох баримтын цуглуулах**

Бэлгийн эрүү шүүлтийн олон үйлдэл нь хохирогчийг ойр дотныхоо хүмүүсийн эсрэг албадан мэдүүлэг өгөхөд хүргэж сэтгэл зүйн хүнд дарамт үүрүүлдэг. Стамбулын протокол нь эрүүдэн шүүлтийн талаарх сэтгэл зүйн болон биет нотлох баримтыг баримтжуулах удирдамжийг өгдөг. Нотлох баримтын төрөлд мэдүүлэг, үзлэг хийх, байршлаас авсан эд мөрийн баримт, дижитал нотлох баримт (видео, гэрэл зураг, сансрын зураг) болон баримтат нотлох баримтууд орно. Нөхцөл байдлын болон гэрчийн мэдүүлгийн нотлох баримтууд нь дайны үеийн гэмт хэргийг нотлоход хангалттай байдаг.

- **Хохирогчид болон гэрчүүдээс ярилцлага авах**

Бэлгийн эрүү шүүлтийн хохирогчтой ярилцлага хийх нь ур чадвар, дадлага, зөв сэтгэл хөдлөлийн ухаан шаарддаг. Ярилцлагын чанар нь мэдээллийн найдвартай байдал, хохирогчид түүхээ хуваалцах хүсэлд нөлөөлдөг бөгөөд энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд нөлөөлдөг.

- **Харилцааны барилга**

Харилцаа холбоо тогтоох нь маш чухал бөгөөд хохирогчид туулж, мэдэрсэн зүйлээ өөрийнхөөрөө тайлбарлах учиртай. Ярилцлага хийгч нь тухайн хүнд нэмэлт хор, хохирол учруулахгүйгээр эмзэг мэдээллийг нь ёс суртахуунтай, найдвартай олж авахад сургагдсан байх ёстой. Стамбулын протоколд зөвлөсний дагуу нээлттэй орхисон асуултууд нь хохирогч өөрөө ярих зүйлээ удирдан өгүүлэх боломжийг олгодог чухал арга юм.

- **Ёс зүйн ярилцлагын практик**

Зөв явагдсан ярилцлага нь хохирогчдыг нөхөн сэргээлтэд тусалдаг бөгөөд ярилцлагын багт сэтгэл судлаачдыг оруулах нь байнгын үнэлгээг баталгаажуулдаг.



- **Хүйсийн ялгааг арилгах**

Тусгай илтгэгч эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй ярилцлага хийх явцад ялгаа байгааг тэмдэглэв. Эмэгтэй хохирогчид ихэвчлэн өөрсдийн туулж өнгөрүүлсэн тохиолдлыг эрүү шүүлт гэхээсээ илүү хүчин болон бусад төрлийн бэлгийн хүчирхийлэл гэж ойлгож байна. Бүх болзошгүй гэмт хэргийг хүлээн зөвшөөрөхийн тулд хохирогчид өөрсдийн туршлагаа бүрэн хуваалцах боломжийг олгох хэрэгтэй.

- **Ярилцагч сонгох, орчуулагчийн сургалт**

Боломжтой бол хохирогчид ярилцлага авагчийн хүйс/бэлгийн хандлагыг сонгодог байх, хэлмэрчийг соёл, хэл шинжлэлийн нюансуудад сургах хэрэгтэй. Ярилцлагын бичлэгийг хийх нь авч буй мэдээллүүдийг орхигдуулахгүй санах, үнэн зөв баримтжуулалт хийх боломжийг олгодог.

- **Зайнаас ярилцлага хийх**

Алсын зайнаас ярилцлага хийх нь мөргөлдөөнд өртсөн бүс нутагт ашигтай байж болох ч шаардлагатай үед аюул, эрсдлийн цогц үнэлгээ хийсний дараа л хийх ёстой.

- **Бие махбодийн болон оюун санааны уналтаас урьдчилан сэргийлэх, дэмжих**

Ярилцлага авагчид болон орчуулагчид нь танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн ихээхэн дарамттай тулгардаг бөгөөд хохирогч болон ярилцлага авагч хоёуланд нь завсарлага, дэмжлэг хэрэгтэй. Ярилцлага авагчдад зохих сургалт зохион байгуулж, энэхүү уналтын хэмжээг бууруулж болно.

**Урьдчилан сэргийлэх ажлыг бэхжүүлэхийн тулд гэмт хэрэгтний зан үйлийг ойлгох**

Боловсрол, сургалт, хэрэг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд оруулж буй олон улсын болон үндэсний хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн хэдий ч дайны үед үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, эрүүдэн шүүх гэмт хэргүүд шийтгэлгүй үлдсэн хэвээр байна. Хариуцлага хүлээлгэх нь урьдчилан сэргийлэх нөлөөтэй боловч бэлгийн эрүү шүүлтийн үндсэн шалтгаан, хурдасгуурыг арилгах нь хамгийн чухал юм.

- **Дайны үеийн үндсэн шалтгаан ба өсөлт**

Эмэгтэйчүүд, охидын эсрэг бэлгийн хүчирхийлэл нь эмэгтэй хүний үнэ цэнийг бууруулж, эрэгтэй хүн ноёрхлоо тогтоодог хууль эрх зүй, нийгэм, соёл, эдийн засаг, шашны тогтолцооноос үүдсэн доромжлол, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй. Эдгээр хүчин зүйлс нь дайны үед улам эрчимждэг.

- **Зөрчилдөөний өвөрмөц шалтгаанууд**

Мөргөлдөөнтэй нөхцөлд улс төр, эдийн засгийн ялгаа, үзэн ядалтыг бэхжүүлэх, түүнчлэн терроризмыг өдөөх, нийгмийн эв нэгдлийг устгах сонгомол зорилго нь эрүү шүүлт явуулахад хүргэдэг. Бэлгийн эрүү шүүлтийг дарангуйлах, хяналтдаа байлгах, өшөө авах зорилгоор улс төр, цэргийн стратегид ашигладаг

бөгөөд зарим хүмүүс тагнуулын мэдээлэл авах эсвэл хэрэг хүлээлгэхэд үр дүнтэй гэж буруугаар ойлгодог.

- **Терроризмын бодлого ба шагнал**

Зарим террорист байгууллагууд үзэл суртлынхаа нэг хэсэг болгон бэлгийн хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн боолчлол, хүүхэд гэрлэлтийг зөвшөөрдөг. Хангалтгүй цалинтай цэргүүдэд нөхөн олговор хэлбэрээр, эсвэл урамшууллын зорилгоор цэргүүдээр бэлгийн хүчирхийлэл үйлдүүлдэг. Түүхэн жишээг дурдвал дэлхийн 2 дугаар дайны үеийн «Тайтгаруулагч эмэгтэйчүүд», Босни Герцеговин дахь хүчингийн зочид буудлууд, Ирак, Сирийн Исламын улс Язиди болон бусад эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийг бэлгийн боолчлолд оруулсан зэрэг болно.

- **Цэргийн стратеги ба хүчиндэх соёл**

Аймшигт үйлдлүүд нь ил эсвэл далд тушаалаар үйлдэж буй төрийн цэргийн болон улс төрийн стратегийн нэг хэсэг байж болно. Дайны цаг нь ихэвчлэн эмэгтэйчүүдийг доромжлох, “хүчиндэх соёл” гэгчээр илэрхийлэгддэг цэргийн соёлоор энх цагийн хэм хэмжээг эвддэг. Бүлгийн сэтгэлгээ нь нэгж доторх эв нэгдлээ хангахын тулд олон хүнийг хүчингийн хэрэг үйлдэхэд хүргэдэг.

- **Гэмт этгээдүүдийг ойлгох**

Судалгаанаас харахад ихэнх гэмт хэрэгтнүүд садист эсвэл психопат биш байдаг. Нийгмийн бүтэц, нөхцөл байдал, сэтгэл зүйн дарамт нь «энгийн хүмүүсийг» хүчирхийлэгч болоход хүргэдэг. Эрх мэдэлд дуулгавартай дагах, сургах, сэтгэл хөдлөлийг нь удирдах, хохирогчдын мөн чанарыг үгүйсгэх зэрэг нь түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдэд орно.

- **Гэмт этгээдийн зан үйлийг ойлгохын ач холбогдол**

Гэмт хэрэг үйлдэгчдийн сэдэл, өдөөж буй хүчин зүйлийг ойлгох нь эрүү шүүлт, түүний бэлгийн илрэлийг арилгахад маш чухал юм. Энэхүү мэдлэг нь ирээдүйд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хариуцлага хүлээхгүйгээр зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд тусалдаг.

**Бэлгийн эрүү шүүлтээс нөхөн сэргээгдэх**

- **Бэлгийн эрүү шүүлтийн хохирогчдод иж бүрэн нөхөн төлбөр олгох**

Нөхөн төлбөр нь хүний эрхийн зөрчлийг арилгах, тэр дундаа мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн эрүү шүүлтэд өртсөн хохирогчдыг нөхөн сэргээхэд чиглэгддэг. Босни Герцеговин, Колумб, Кот-д’Ивуар, Ирак зэрэг улсууд хохирогчдод нөхөн төлбөр олгох хөтөлбөртэй байдаг ч тэдгээрт хамрагдах асуудал нь ихэвчлэн бэрхшээлтэй байдаг.

- **Нөхөн сэргээлтийн сул тал**

Нөхөн сэргээх хөтөлбөрүүд нь ихэвчлэн иргэний нийгмийн байгууллагуудад тулгуурладаг, нотлох баримтын өндөр стандарт шаарддаг, нарийн мэргэжлийн бус ерөнхий үйлчилгээ үзүүлдэг, эрэгтэй хохирогчдыг оролцуулдаггүй. Хохирогчдод үзүүлдэг эмчилгээ ихэвчлэн муу, санхүүжилт дутмаг, цаг хугацааны хязгаарлалтай, нөхөн сэргээх бүртгэлд хамрагдахад хүнд сурталтай байх зэрэг бусад саад бэрхшээл тулгардаг.

## • **Үр дүнтэй нөхөн сэргээх арга**

Судалгаанаас харахад нөхөн сэргээх үр дүнтэй дараах аргууд байна:

- Хүлээн зөвшөөрөх: Нөхөн төлбөрийн хууль нь бүх хохирогчдод хүртээмжтэйгээр нөхөн сэргээгдэх боломжийг олгох ёстой.
- Хохирогчид төвлөрсөн загвар: Нөхөн төлбөр нь хангалттай, хурдан бөгөөд бүтцийн тэгш бус байдлыг арилгах чадвартай байх ёстой. Ийм жишээнд Нигери дэх бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай комисс, Косово дахь бэлгийн хүчирхийллийн хохирогчийн статусыг хүлээн зөвшөөрөх комисс зэргийг нэрлэж болно.
- Нэргүй дэмжлэг: Дэмжлэгийн арга хэмжээ нь эрүү шүүлтийн үр дагаврыг арилгах чиглэх ба ил тод болгох шаардлагагүй.
- Тохиромжтой үйлчилгээ: Нөхөн сэргээх эмчилгээ нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг хангах, нууцлал, хамрах хүрээг хангах үүднээс олон нийтэд хүрч ажиллах, теле эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй цогц бөгөөд хувь хүнд тохирсон байх ёстой.
- Мэргэшсэн мэргэжилтнүүд: Мэргэжилтнүүд дахин гэмтэл авахаас урьдчилан сэргийлэхийн тулд мэдрэмтгий үг хэллэг ашиглан цогц тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургагдсан байх ёстой.
- Аюулгүй байдал ба нууцлал: Нөхөн сэргээлтийн орчин нь нууцлалын байдлыг хангасан байх ёстой.
- Бэлгийн эрүү шүүлтийн хохирогч хүүхдүүд: Хүчингийн гэмт хэргийн улмаас төрсөн хүүхдүүд үндсэн эрхээ баталгаажуулахын тулд төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, иргэний харьяалалтай байх шаардлагатай.

## **Зөвлөмжүүд**

### • **Хууль эрх зүй ба бодлогын хүрээнд**

- Хууль тогтоомж нь бэлгийн болон бусад эрүүдэн шүүхтэй холбоотой гэмт хэргийн хүрээг тодорхой тусгах ёстой. Гэмт хэргийн жинхэнэ цар хүрээг харуулдаг тул хуримтлагдсан яллах дүгнэлтийг зөвшөөрөх ёстой.
- Улс орнууд, цэрэг хүчний байгууллагууд эрүү шүүлт, түүний дотор бэлгийн хүчирхийллийг үл тэвчих бодлого баримтлах ёстой. Цэрэг, офицерууд сахилгын дүрмээ баталж, эрүү шүүлтийн шалтгаан, үр дагавар, түүний хоригийн талаар мэдлэгтэй байх ёстой. Эмэгтэй цэрэг, офицеруудыг олноор элсүүлэх хэрэгтэй. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийг цэргийн албанд татах ёсгүй.
- Хохирогчдод нөхөн төлбөр олгох, нөхөн сэргээх зорилгоор нөхөн төлбөрийн тухай хуулийг баталж, санхүүжүүлэх ёстой.
- Улс орнууд гэмт этгээдийн зан байдал, үндсэн шалтгаан, катализаторын талаар нэмэлт судалгаа хийх үүрэг хүлээх ёстой.

- **Хохирогчдод чиглэсэн дэмжлэг, үйлчилгээ**

- Хохирогчид зөвхөн зөвлөлддөг байх биш тэдэнд нөлөөлөх бүх бодлого, хуулийг хамтран бүтээгчид байх ёстой.
- Хохирогчдод хүндэтгэлтэй хандаж, хүлээн зөвшөөрөх ёстой. Хохирогчдыг үл хүндэтгэсэн эрх бүхий байгууллагуудын нэр дээр гомдол гаргах журам, сахилгын арга хэмжээ байх ёстой.
- Хохирогчдод үйл явцыг өөрсдөө зохицуулах ачааллыг бууруулахын тулд бүх хамгаалалт, эмнэлгийн болон хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэг цэгээс авах боломжтой болгох. Ийм үйлчилгээнд бэлгийн эрүү шүүлтэд өртсөн явдлыг тодруулах зэрэг хамаарах ёсгүй.
- Урьдчилан сэргийлэх, боловсрол, хариуцлага
- Улс төр, цэрэг, шашны болон нийгмийн зүтгэлтнүүд хохирогчдыг доромжилж байгаа асуудалд олон нийтэд мэдэгдэл хийх ёстой. Гэмт этгээдийг ичээж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж, шалгаж, яллаж, шийтгэх ёстой.
- Мөрдөн шалгах багууд бэлгийн эрүү шүүлт үйлдэгдэхэд авах хариу арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Стамбулын протоколд заасан эрүү шүүлттэй холбоотой гэмт хэрэг гэж баримтжуулах ёстой. Шүүхийн байгууллагууд холбогдох эмнэлгийн тайланг хүлээн авах ёстой. Эмнэлгийн хуулийн баг шаардлагатай шүүх шинжилгээний хэрэгсэлтэй байх ёстой бөгөөд хохирогчид урьдчилан сэргийлэх, үр хөндөлт, ХДХВ/БЗДХ-ын шинжилгээ зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц үйлчилгээнд хамрагдах боломжтой байх ёстой.
- Бэлгийн эрүү шүүлтийн хохирогч, гэрчтэй ярилцлагыг үр дүнтэй, мэдрэмжтэй явуулахын тулд ярилцлага авагч, орчуулагчдыг Мендезийн зарчим болон Мурадын дүрэмд сургаж, гэрчилгээ авсан байх ёстой. Мэдээллийн зөвшөөрөл, нууцлал, нэр нууцлалыг чанд сахих ёстой.
- Дайны гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулахад оролцдог янз бүрийн оролцогчид (олон улсын болон үндэсний) хохирогчид дахин гэмтэл авах магадлалыг багасгах, зөрчилтэй мэдэгдлийн магадлалыг бууруулахын тулд үйл ажиллагаагаа зохицуулах ёстой.

### **Доктор Алис Эдвардсын намтар**

Доктор Алис Эдвардс 2022 оны долдугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн албан тушаалд томилогдсон. Тэрээр 2022 оны 08 дугаар сарын 01-нд үүрэгт ажлаа хүлээн авчээ. Хүний эрхийн нэр хүндтэй хуульч, эрдэмтэн доктор Эдвардс нь Эрүү шүүлтийн асуудлаарх долоо дахь Тусгай илтгэгч бөгөөд бүрэн эрхээ дүүргэсэн анхны эмэгтэй юм.

Доктор Эдвардс НҮБ-ын Эрүү шүүлтийн асуудлаарх тэргүүлэх шинжээчийн

хувьд эрүү шүүлттэй тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлтын тэргүүн эгнээнд явж байна. Түүний үүрэг бол улс орнуудад баримт судлах айлчлал хийх, төрийн зөвшөөрөлтэйгөөр хүчирхийллийн хохирогчдод шударга ёсыг тогтоох явдал юм.

Доктор Эдвардс 2016-2021 оны хооронд Чили, Дани, Фижи, Гана, Индонез, Марокко улсуудын Засгийн газрын санаачилгаар НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг бүх нийтээр соёрхон батлах, хэрэгжүүлэхэд чиглэсэн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын санаачилга байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газрыг удирдаж ажиллажээ.

Үүнээс өмнө доктор Эдвардс нь НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн агентлагийн хуулийн үндсэн зохицуулагч, хамгаалалтын бодлого, хуулийн зөвлөхийн даргаар ажиллаж байв. Тэрээр НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн агентлагийн ажил хэрэгч яриа хэлэлцээ, техникийн зөвлөгөө, чадавх бэхжүүлэх замаар орогнол хүсэгчдийг тогтмол баривчлах явдлыг зогсооход засгийн газруудад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болох “Цагдан хорихоос бусад дэлхий нийтийн стратеги”-ийг санаачлан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм. Доктор Эдвардс жендертэй холбоотой мөрдлөг хавчлагын талаарх анхны удирдамж, цагдан хорих болон хорихоос өөр хувилбаруудын талаарх одоогийн удирдамжийн төслийг боловсруулсан.

Доктор Эдвардс хорин таван жилийн карьераа Босни Герцеговин, Мозамбик, Рванда зэрэг томоохон мөргөлдөөнтэй нөхцөл байдалд хүний эрхийн зөрчлийн хохирогчдын эрхийн төлөө ажилласан. Түүний ололт амжилтуудын дунд хүчингийн болон бэлгийн хүчирхийлэл нь эрүүдэн шүүх, хавчлагын нэг хэлбэр бөгөөд дүрвэгсдийг олон улсын хамгаалалтад авах ёстой гэсэн нь одоо дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн “баримтлал” болжээ. Түүний «Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл» ном нь хэд хэдэн орны бодлогод нөлөөлсөн. Тэрээр мөн эрүүдэн шүүхийг яллах гэмт хэрэгт оруулахын тулд дотоодын хууль тогтоомжийг шинэчлэх талаар улс орнуудад зөвлөгөө өгөх санаачилгыг хариуцаж байв.

### **Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаар НҮБ-ын тусгай илтгэгчийн бүрэн эрхийн тухай танилцуулга**

Тусгай илтгэгчийн бүрэн эрх нь холбогдох олон улсын заншил, гэрээний хуулийн дагуу эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахтай холбоотой аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хамарна. Тусгай илтгэгч нь НҮБ-ын одоогийн болон гишүүнээр элсэх гэж буй бүх улс орнуудад гэрээний үүргээс үл хамааран ийм хүчирхийллийг хориглох, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, арилгахтай холбоотой асуудлыг судлах эрхтэй.

НҮБ-ын Хүний эрхийн комиссын тогтоолоор 1985 онд байгуулагдсан гурван жилийн хугацаатай энэхүү мандат нь НҮБ-ын түүхэнд бий болсон хоёр дахь мандат юм. Доктор Алис Эдвардс нь 40 жилийн түүхэнд Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгчийн үүрэг гүйцэтгэсэн анхны эмэгтэй юм.

Тусгай илтгэгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс орнуудад айлчилж, эрүүдэн

шүүсэн гэх хэргийн талаарх мэдээлэл, гомдлын талаар засгийн газруудтай харилцаж, хүний зарим эрхийг зөрчиж болзошгүй хууль тогтоомж, бодлогын талаар мэдээлэл солилцдог. Тусгай илтгэгч НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон Хүний эрхийн зөвлөлд үйл ажиллагааны тайлангаа мөн хүргүүлдэг.

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх асуудлаарх Тусгай илтгэгч нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс томилогдсон хүний эрхийн бие даасан шинжээчид болох сэдэвчилсэн тусгай журмын нэг юм.



**ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЖЕНЕВ ХОТНОО ТӨВТЭЙ “ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НИЙГЭМЛЭГ” ОУБ-ЫН ЦАХИМ ХУУДАСНАА  
НИЙТЛЭГДСЭН НИЙТЛЭЛ (англи хэлээр)**



**association pour la prévention de la torture**  
**asociación para la prevención de la tortura**  
**association for the prevention of torture**

*Швейцарын Холбооны Улсын Женев хотноо төвтэй “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” ОУБ-ын цахим хуудаснаа нийтлэгдсэн нийтлэл*

**Mongolia: A new monitoring body focuses on risky practices and women in detention**

The APT and Mongolia’s National Preventive Mechanism (NPM) began an ambitious first year of cooperation by focusing on safeguards in the first hours of police custody and the NPM’s visit methods during a week of joint activities in Ulaan Baatar.

Bringing together law enforcement and prison officers from around the country allowed us to take the first steps towards implementing the Méendez Principles on Effective Interviewing - a set of global standards on police interviews and safeguards, named after torture survivor and former special rapporteur, Professor Juan Méendez.

By visiting a prison for women as well, we also helped the NPM to identify gaps in their own methodology that we can now work together to address in the year ahead.

Mongolia’s NPM is one of only a small number in the Asia Pacific but it is already benefiting from the experiences of other NHRIs in the region with an NPM mandate, as well as acting as an example for those states in the region who are yet to ratify the Optional Protocol to the Convention against Torture.

Among the challenges faced by the Mongolian NPM are the country’s vast geography. This makes it difficult and expensive to visit places of deprivation of liberty in remote regions. Conducting unannounced visits to such regions is particularly difficult, as everyone is aware of the NPM’s arrival as soon as they step off the plane.

The NPM has been working with APT to translate the Méendez Principles on Effective Interviewing into Mongolian and to understand some of the gaps in implementation. Interest among the authorities for this kind of practical approach is high, demonstrated by the more than 2,000 police officers who attended our joint workshop.

Contact with family is among the most important safeguards in the first hours of police custody. In many countries it is also the easiest to implement as, unlike access to a lawyer, it is very low cost. However, in remote regions of Mongolia, it is in fact one of the hardest. Many herder families live out of cell phone range and both finding them and

making contact can be a significant challenge, if one of their relatives is arrested.

Work is ongoing to introduce CCTV in all interrogation rooms. As in many places, in the beginning, there was resistance from the police. They didn't want to be recorded. But this perspective is shifting. The police are beginning to see that it is also a safeguard for them; that it can help to protect them against false allegations, while also upholding the rights of those they have detained.

Resourcing presents a challenge for implementation of safeguards in many police units. A lack of questioning rooms, for example, means that many interviews take place in offices and in the presence of others.

For women deprived of liberty in Mongolia, distance from their families is an enormous challenge. With only one prison for women in the country, most are held far from their homes. Here the NPM discusses these and other issues with prison authorities.

Traffic in the capital poses a problem in relation to ensuring prompt access to a lawyer. Chronic traffic jams mean that even when a lawyer is available and contacted immediately, sometimes they can take hours to arrive at the police station.

Together with the APT, the NPM conducted a visit to a detention centre for women, with a focus on improving their visiting practices and methodologies, as they work to fully implement their new mandate.

**ХОРИГДЛУУДАЙ ХАРЬЦАХ НААД ЗАХЫН ЖИШИГ ДҮРЭМ (англи хэлээр)**

United Nations

A/RES/70/175

**General Assembly**Distr.: General  
8 January 2016**Seventieth session**  
Agenda item 106**Resolution adopted by the General Assembly on 17 December 2015***[on the report of the Third Committee (A/70/490)]***70/175. United Nations Standard Minimum Rules for the  
Treatment of Prisoners (the Nelson Mandela Rules)***The General Assembly,**Guided by the principal purposes of the United Nations, as set out in the*

Preamble to the Charter of the United Nations and the Universal Declaration of Human Rights, and inspired by the determination to reaffirm faith in fundamental human rights, in the dignity and worth of the human person, without distinction of any kind, and in the equal rights of men and women and of nations large and small, to establish conditions under which justice and respect for the obligations arising from treaties and other sources of international law can be maintained and to promote social progress and better standards of life in larger freedom,

Recalling all standards and norms in crime prevention and criminal justice developed at the request of the Commission on Crime Prevention and Criminal Justice and adopted or recommended by the General Assembly, or adopted by a United Nations congress on the prevention of crime and the treatment of offenders, and recognizing that the Universal Declaration of Human Rights is a source of inspiration for the United Nations standards and norms in crime prevention and criminal justice,

Bearing in mind the long-standing concern of the United Nations for the humanization of criminal justice and the protection of human rights, and emphasizing the fundamental importance of human rights in the daily administration of criminal justice and crime prevention,

Aware that the Standard Minimum Rules for the Treatment of Prisoners have been the universally acknowledged minimum standards for the detention of prisoners and that they have been of significant value and influence, as a guide, in the development of correctional laws, policies and practices since their adoption by the First United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, in 1955,



---

Mindful that, in the Salvador Declaration on Comprehensive Strategies for

Global Challenges: Crime Prevention and Criminal Justice Systems and Their Development in a Changing World,<sup>254</sup> Member States recognized that an effective, fair, accountable and humane criminal justice system was based on the commitment to uphold the protection of human rights in the administration of justice and the prevention and control of crime, and acknowledged the value and impact of the United Nations standards and norms in crime prevention and criminal justice in designing and implementing national crime prevention and criminal justice policies, procedures and programmes,

Taking into account the progressive development of international law pertaining to the treatment of prisoners since 1955, including in international instruments such as the International Covenant on Civil and Political Rights,<sup>255</sup> the International Covenant on Economic, Social and Cultural Rights<sup>4</sup> and the Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment<sup>256</sup> and the Optional Protocol thereto,<sup>257</sup>

Recalling the United Nations standards and norms in crime prevention and criminal justice related to the treatment of prisoners and to alternatives to imprisonment adopted since 1955, in particular the procedures for the effective implementation of the Standard Minimum Rules for the Treatment of Prisoners,<sup>258</sup> the Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or

Imprisonment,<sup>259</sup> the Basic Principles for the Treatment of Prisoners,<sup>260</sup> the United Nations Standard Minimum Rules for Non-custodial Measures (the Tokyo Rules)<sup>261</sup> and the basic principles on the use of restorative justice programmes in criminal matters,<sup>262</sup>

---

<sup>254</sup> Resolution 65/230, annex.

<sup>255</sup> See resolution 2200 A (XXI), annex.

<sup>256</sup> United Nations, Treaty Series, vol. 1465, No. 24841.

<sup>257</sup> Ibid., vol. 2375, No. 24841.

<sup>258</sup> Economic and Social Council resolution 1984/47, annex.

<sup>259</sup> Resolution 43/173, annex.

<sup>260</sup> Resolution 45/111, annex.

<sup>261</sup> Resolution 45/110, annex.

<sup>262</sup> Economic and Social Council resolution 2002/12, annex.

Bearing in mind the need for vigilance with regard to the specific situation of children, juveniles and women in the administration of justice, in particular while they are deprived of their liberty, as called for in the United Nations Standard Minimum Rules for the Administration of Juvenile Justice (the Beijing Rules),<sup>263</sup> the

United Nations Guidelines for the Prevention of Juvenile Delinquency (the Riyadh Guidelines),<sup>264</sup> the United Nations Rules for the Protection of Juveniles Deprived of their Liberty<sup>265</sup> and the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (the Bangkok Rules),<sup>266</sup>

Recalling the United Nations standards and norms in crime prevention and criminal justice adopted since 1955 that provide additional guidance on the treatment of prisoners, including the Code of Conduct for Law Enforcement

---

Officials,<sup>267</sup> the Principles of Medical Ethics relevant to the role of health personnel, particularly physicians, in the protection of prisoners and detainees against torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment, <sup>268</sup> the Basic Principles on the Use of Force and Firearms by Law Enforcement Officials,<sup>269</sup> the

Principles on the Effective Investigation and Documentation of Torture and Other

Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment<sup>270</sup> and the United Nations Principles and Guidelines on Access to Legal Aid in Criminal Justice Systems,<sup>271</sup>

Aware of regional principles and standards related to the treatment of prisoners, including the Principles and Best Practices on the Protection of Persons Deprived of Liberty in the Americas, the revised European Prison Rules, the

Kampala Declaration on Prison Conditions in Africa,<sup>272</sup> the Arusha Declaration on Good Prison Practice<sup>273</sup> and the Principles and Guidelines on the Right to a Fair Trial and Legal Assistance in Africa,

Recalling its resolution 65/230 of 21 December 2010, entitled “Twelfth United Nations Congress on Crime Prevention and Criminal Justice”, in which it requested the Commission on Crime Prevention and Criminal Justice to establish an openended inter-governmental expert group to exchange information on best practices, as well as national legislation and existing international law, and on the revision of existing United Nations

---

<sup>263</sup> Resolution 40/33, annex.

<sup>264</sup> Resolution 45/112, annex.

<sup>265</sup> Resolution 45/113, annex.

<sup>266</sup> Resolution 65/229, annex.

<sup>267</sup> Resolution 34/169, annex.

<sup>268</sup> Resolution 37/194, annex.

<sup>269</sup> Eighth United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, 27 August–7 September 1990: report prepared by the Secretariat (United Nations publication, Sales No. E.91.IV.2), chap. I, sect. B.2, annex.

<sup>270</sup> Resolution 55/89, annex.

<sup>271</sup> Resolution 67/187, annex.

<sup>272</sup> Economic and Social Council resolution 1997/36, annex.

<sup>273</sup> Economic and Social Council resolution 1999/27, annex.

standard minimum rules for the treatment of prisoners so that they reflect recent advances in correctional science and best practices,

Recalling also its resolutions 67/188 of 20 December 2012, 68/190 of

18 December 2013 and 69/192 of 18 December 2014, entitled “Standard Minimum Rules for the Treatment of Prisoners”, in particular resolution 68/190, in which it took note with appreciation of the work done by the Expert Group on the Standard Minimum Rules for the Treatment of Prisoners, and resolution 69/192, in which it emphasized that efforts should be made to finalize the revision process, building on the recommendations made at the three meetings of the Expert Group and the submissions of Member States,

Mindful that, in its resolution 68/190, it took into consideration the recommendations of the Expert Group with regard to the issues and the rules of the Standard Minimum Rules that had been identified for revision in the following areas:

Respect for prisoners’ inherent dignity and value as human beings

(rules 6, para. 1; 57–59; and 60, para. 1),

Medical and health services (rules 22–26; 52; 62; and 71, para. 2),

Disciplinary action and punishment, including the role of medical staff, solitary confinement and reduction of diet (rules 27, 29, 31 and 32),

Investigation of all deaths in custody, as well as of any signs or allegations of torture or inhuman or degrading treatment or punishment of prisoners

(rule 7 and proposed rules 44 bis and 54 bis),

---

Protection and special needs of vulnerable groups deprived of their liberty, taking into consideration countries in difficult circumstances (rules 6 and 7),

The right of access to legal representation (rules 30; 35, para. 1; 37; and 93),

Complaints and independent inspection (rules 36 and 55),

The replacement of outdated terminology (rules 22–26, 62, 82 and 83 and various others),

Training of relevant staff to implement the Standard Minimum Rules

(rule 47),

Mindful also that, in its resolution 69/192, it reiterated that any changes to the Standard Minimum Rules should not lower any of the existing standards, but should reflect recent advances in correctional science and good practices so as to promote safety, security and humane conditions for prisoners,

Mindful further of the extensive consultative process culminating in the recommendations of the Expert Group, a process spanning a period of five years, consisting of technical and expert pre-consultations, meetings in Vienna, Buenos Aires and Cape Town, South Africa, and the active participation and input of Member States from all regions, assisted by representatives of the United Nations crime prevention and criminal justice programme network and other United Nations entities, including the Office of the



United Nations High Commissioner for Human Rights, the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, the United Nations Office on Drugs and Crime, intergovernmental organizations, including the International Committee of the Red Cross, specialized agencies in the United Nations system, including the World Health Organization, and non-governmental organizations and individual experts in the field of correctional science and human rights,

Recalling its resolution 69/172 of 18 December 2014, entitled “Human rights in the administration of justice”, in which it recognized the importance of the principle that, except for those lawful limitations that are demonstrably necessitated by the fact of incarceration, persons deprived of their liberty shall retain their non-derogable human rights and all other human rights and fundamental freedoms, recalled that the social rehabilitation and reintegration of persons deprived of their liberty shall be among the essential aims of the criminal justice system, ensuring, as far as possible, that offenders are able to lead a law-abiding and self-supporting life upon their return to society, and took note of, inter alia, general comment No. 21 on the humane treatment of persons deprived of their liberty, adopted by the Human Rights Committee;<sup>274</sup>

1. Expresses its gratitude and appreciation to the Government of South Africa for hosting the meeting of the Expert Group on the Standard Minimum Rules for the Treatment of Prisoners held in Cape Town, South Africa, from 2 to 5 March 2015 and for providing financial support and leadership throughout the review process, and notes with appreciation the consensus achieved on the nine thematic areas and the rules identified for revision by the Expert Group at its previous meetings;<sup>275</sup>

---

Expresses its appreciation to the Government of Argentina for hosting and financing the meeting of the Expert Group held in Buenos Aires from 11 to 13 December 2012 and to the Government of Brazil for its financial contribution to the meeting of the Expert Group held in Vienna from 25 to 28 March 2014;

Acknowledges the valuable work accomplished by the bureau of the meeting of the Expert Group held in Vienna in 2014 in preparing, with the assistance of the Secretariat, the documentation for the meeting of the Expert Group held in Cape Town in 2015, in particular the revised consolidated working paper;<sup>276</sup>

Notes that in the Doha Declaration on Integrating Crime Prevention and Criminal Justice into the Wider United Nations Agenda to Address Social and Economic Challenges and to Promote the Rule of Law at the National and International Levels, and Public Participation, adopted by the Thirteenth United Nations Congress on Crime Prevention and Criminal Justice, held in Doha from 12 to 19 April 2015,<sup>277</sup> the Thirteenth Congress welcomed the work of the Expert Group, and took note of the draft updated Standard Minimum Rules for the Treat-

---

<sup>274</sup> Official Records of the General Assembly, Forty-seventh Session, Supplement No. 40 (A/47/40), annex VI.B.

<sup>275</sup> See E/CN.15/2015/17.

<sup>276</sup> UNODC/CCPCJ/EG.6/2015/2.

<sup>277</sup> Resolution 70/174, annex. <sup>27</sup> See resolution 64/13.

ment of Prisoners, as finalized by the Expert Group at its meeting held in Cape Town in March 2015;

Adopts the proposed revision of the Standard Minimum Rules for the

Treatment of Prisoners, annexed to the present resolution, as the United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners;

Approves the recommendation of the Expert Group that the Rules should be known as “the Nelson Mandela Rules”, to honour the legacy of the late President of South Africa, Nelson Rolihlahla Mandela, who spent 27 years in prison in the course of his struggle for global human rights, equality, democracy and the promotion of a culture of peace;

Decides to extend the scope of Nelson Mandela International Day, observed each year on 18 July,<sup>27</sup> to be also utilized in order to promote humane conditions of imprisonment, to raise awareness about prisoners being a continuous part of society and to value the work of prison staff as a social service of particular importance, and to this end invites Member States, regional organizations and organizations of the United Nations system to celebrate this occasion in an appropriate manner;

Reaffirms, in the context of paragraph 5 above, the preliminary observations to the Nelson Mandela Rules, underscores the non-binding nature of the Rules, acknowledges the variety of Member States’ legal frameworks, and in that regard recognizes that Member States may adapt the application of the Rules in accordance with their domestic legal frameworks, as appropriate, bearing in mind the spirit and purposes of the Rules;

Encourages Member States to endeavour to improve conditions in detention, consistent with the Nelson Mandela Rules and all other relevant and applicable United Nations standards and norms in crime prevention and criminal justice, to continue exchanging good practices in order to identify challenges faced in implementing the Rules and to share their experiences in dealing with those challenges;

---

Invites the Commission on Crime Prevention and Criminal Justice to consider, at its upcoming sessions, reconvening the open-ended intergovernmental Expert Group on the Standard Minimum Rules for the Treatment of Prisoners for the purpose of identifying the lessons learned, the means to continue to exchange good practices and the challenges faced in the implementation of the Nelson Mandela Rules;

Encourages Member States to promote the implementation of the United

Nations Rules for the Protection of Juveniles Deprived of their Liberty<sup>14</sup> and the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (the Bangkok Rules);<sup>15</sup>

Recommends that Member States continue to endeavour to reduce prison overcrowding and, where appropriate, resort to non-custodial measures as alternatives to pretrial detention, to promote increased access to justice and legal defence mechanisms, to reinforce alternatives to imprisonment and to support rehabilitation and social reintegration programmes, in accordance with the United Nations Standard Minimum Rules for Non-custodial Measures (the Tokyo Rules);<sup>10</sup>

Notes the importance of a voluntary exchange of experiences and good practices among Member States and with relevant international entities, where appropriate, and

the provision of technical assistance to Member States, for the improved implementation of the Nelson Mandela Rules, upon their request;

Encourages Member States to consider allocating adequate human and financial resources to assist in the improvement of prison conditions and the application of the Nelson Mandela Rules;

Requests the United Nations Office on Drugs and Crime to ensure broad dissemination of the Nelson Mandela Rules, to design guidance material and to provide technical assistance and advisory services to Member States in the field of penal reform, in order to develop or strengthen penitentiary legislation, procedures, policies and practices in line with the Rules;

Commends the Commission on Crime Prevention and Criminal Justice for its continuing contributions to the improvement of the administration of justice through the development and refinement of international standards and norms in the field of crime prevention and criminal justice, and calls upon Member States to continue their efforts in this regard;

Requests the United Nations Office on Drugs and Crime to continue to promote the use and application of the United Nations standards and norms in crime prevention and criminal justice by, inter alia, providing advisory services and technical assistance to Member States, on request, including assistance in crime prevention, criminal justice and law reform, and in the organization of training for law enforcement, crime prevention and criminal justice personnel and support in the administration and management of penal and penitentiary systems, thus contributing to the upgrading of their efficiency and capabilities;

Invites Member States and other donors to provide extrabudgetary resources for the purposes described above, in accordance with the rules and procedures of the United Nations;

Affirms the important role of the United Nations crime prevention and criminal justice programme network, intergovernmental organizations and non-governmental organizations in consultative status with the Economic and Social Council in the revision process and in contributing to the dissemination, promotion and practical application of the Nelson Mandela Rules in accordance with the procedures for their effective implementation.

80th plenary meeting 17 December 2015

Annex

United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners (the Nelson Mandela Rules)

Preliminary observation 1

The following rules are not intended to describe in detail a model system of penal institutions. They seek only, on the basis of the general consensus of contemporary thought and the essential elements of the most adequate systems of today, to set out what is generally accepted as being good principles and practice in the treatment of prisoners and prison management.

#### Preliminary observation 2

In view of the great variety of legal, social, economic and geographical conditions in the world, it is evident that not all of the rules are capable of application in all places and at all times. They should, however, serve to stimulate a constant endeavour to overcome practical difficulties in the way of their application, in the knowledge that they represent, as a whole, the minimum conditions which are accepted as suitable by the United Nations.

On the other hand, the rules cover a field in which thought is constantly developing. They are not intended to preclude experiment and practices, provided these are in harmony with the principles and seek to further the purposes which derive from the text of the rules as a whole. It will always be justifiable for the central prison administration to authorize departures from the rules in this spirit.

#### Preliminary observation 3

Part I of the rules covers the general management of prisons, and is applicable to all categories of prisoners, criminal or civil, untried or convicted, including prisoners subject to “security measures” or corrective measures ordered by the judge.

Part II contains rules applicable only to the special categories dealt with in each section. Nevertheless, the rules under section A, applicable to prisoners under sentence, shall be equally applicable to categories of prisoners dealt with in sections B, C and D, provided they do not conflict with the rules governing those categories and are for their benefit.

#### Preliminary observation 4

The rules do not seek to regulate the management of institutions set aside for young persons such as juvenile detention facilities or correctional schools, but in general part I would be equally applicable in such institutions.

The category of young prisoners should include at least all young persons who come within the jurisdiction of juvenile courts. As a rule, such young persons should not be sentenced to imprisonment.

## I. Rules of general application Basic principles

### Rule 1

All prisoners shall be treated with the respect due to their inherent dignity and value as human beings. No prisoner shall be subjected to, and all prisoners shall be protected from, torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment, for which no circumstances whatsoever may be invoked as a justification. The safety and security of prisoners, staff, service providers and visitors shall be ensured at all times.

### Rule 2

The present rules shall be applied impartially. There shall be no discrimination on the grounds of race, colour, sex, language, religion, political or other opinion, national or social origin, property, birth or any other status. The religious beliefs and moral precepts of prisoners shall be respected.

In order for the principle of non-discrimination to be put into practice, prison administrations shall take account of the individual needs of prisoners, in particular the most vulnerable categories in prison settings. Measures to protect and promote the rights of prisoners with special needs are required and shall not be regarded as discriminatory.

### Rule 3

Imprisonment and other measures that result in cutting off persons from the outside world are afflictive by the very fact of taking from these persons the right of self-determination by depriving them of their liberty. Therefore the prison system shall not, except as incidental to justifiable separation or the maintenance of discipline, aggravate the suffering inherent in such a situation.

### Rule 4

The purposes of a sentence of imprisonment or similar measures deprivative of a person's liberty are primarily to protect society against crime and to reduce recidivism. Those purposes can be achieved only if the period of imprisonment is used to ensure, so far as possible, the reintegration of such persons into society upon release so that they can lead a law-abiding and self-supporting life.

To this end, prison administrations and other competent authorities should offer education, vocational training and work, as well as other forms of assistance that are appropriate and available, including those of a remedial, moral, spiritual, social and health- and sports-based nature. All such programmes, activities and services should be delivered in line with the individual treatment needs of prisoners.

### Rule 5

The prison regime should seek to minimize any differences between prison life and

life at liberty that tend to lessen the responsibility of the prisoners or the respect due to their dignity as human beings.

Prison administrations shall make all reasonable accommodation and adjustments to ensure that prisoners with physical, mental or other disabilities have full and effective access to prison life on an equitable basis.

## Prisoner file management

### Rule 6

There shall be a standardized prisoner file management system in every place where persons are imprisoned. Such a system may be an electronic database of records or a registration book with numbered and signed pages. Procedures shall be in place to ensure a secure audit trail and to prevent unauthorized access to or modification of any information contained in the system.

### Rule 7

No person shall be received in a prison without a valid commitment order. The following information shall be entered in the prisoner file management system upon admission of every prisoner:

Precise information enabling determination of his or her unique identity, respecting his or her self-perceived gender;

The reasons for his or her commitment and the responsible authority, in addition to the date, time and place of arrest;

The day and hour of his or her admission and release as well as of any transfer;

Any visible injuries and complaints about prior ill-treatment;

An inventory of his or her personal property;

The names of his or her family members, including, where applicable, his or her children, the children's ages, location and custody or guardianship status; ( g )  
Emergency contact details and information on the prisoner's next of kin.

### Rule 8

The following information shall be entered in the prisoner file management system in the course of imprisonment, where applicable:

Information related to the judicial process, including dates of court hearings and legal representation;

Initial assessment and classification reports;

Information related to behaviour and discipline;

Requests and complaints, including allegations of torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment, unless they are of a confidential nature;



Information on the imposition of disciplinary sanctions;

Information on the circumstances and causes of any injuries or death and, in the case of the latter, the destination of the remains.

#### Rule 9

All records referred to in rules 7 and 8 shall be kept confidential and made available only to those whose professional responsibilities require access to such records. Every prisoner shall be granted access to the records pertaining to him or her, subject to redactions authorized under domestic legislation, and shall be entitled to receive an official copy of such records upon his or her release.

#### Rule 10

Prisoner file management systems shall also be used to generate reliable data about trends relating to and characteristics of the prison population, including occupancy rates, in order to create a basis for evidence-based decision-making.

#### Separation of categories

#### Rule 11

The different categories of prisoners shall be kept in separate institutions or parts of institutions, taking account of their sex, age, criminal record, the legal reason for their detention and the necessities of their treatment; thus:

Men and women shall so far as possible be detained in separate institutions; in an institution which receives both men and women, the whole of the premises allocated to women shall be entirely separate;

Untried prisoners shall be kept separate from convicted prisoners;

Persons imprisoned for debt and other civil prisoners shall be kept separate from persons imprisoned by reason of a criminal offence; (d) Young prisoners shall be kept separate from adults.

#### Accommodation

#### Rule 12

Where sleeping accommodation is in individual cells or rooms, each prisoner shall occupy by night a cell or room by himself or herself. If for special reasons, such as temporary overcrowding, it becomes necessary for the central prison administration to make an exception to this rule, it is not desirable to have two prisoners in a cell or room.

Where dormitories are used, they shall be occupied by prisoners carefully selected as being suitable to associate with one another in those conditions. There shall be regular supervision by night, in keeping with the nature of the prison.

### Rule 13

All accommodation provided for the use of prisoners and in particular all sleeping accommodation shall meet all requirements of health, due regard being paid to climatic conditions and particularly to cubic content of air, minimum floor space, lighting, heating and ventilation.

### Rule 14

In all places where prisoners are required to live or work:

The windows shall be large enough to enable the prisoners to read or work by natural light and shall be so constructed that they can allow the entrance of fresh air whether or not there is artificial ventilation;

Artificial light shall be provided sufficient for the prisoners to read or work without injury to eyesight.

### Rule 15

The sanitary installations shall be adequate to enable every prisoner to comply with the needs of nature when necessary and in a clean and decent manner.

### Rule 16

Adequate bathing and shower installations shall be provided so that every prisoner can, and may be required to, have a bath or shower, at a temperature suitable to the climate, as frequently as necessary for general hygiene according to season and geographical region, but at least once a week in a temperate climate.

### Rule 17

All parts of a prison regularly used by prisoners shall be properly maintained and kept scrupulously clean at all times.

### Personal hygiene

### Rule 18

Prisoners shall be required to keep their persons clean, and to this end they shall be provided with water and with such toilet articles as are necessary for health and cleanliness.

In order that prisoners may maintain a good appearance compatible with their self-respect, facilities shall be provided for the proper care of the hair and beard, and men shall be able to shave regularly.

## Clothing and bedding

### Rule 19

Every prisoner who is not allowed to wear his or her own clothing shall be provided with an outfit of clothing suitable for the climate and adequate to keep him or her in good health. Such clothing shall in no manner be degrading or humiliating.

All clothing shall be clean and kept in proper condition. Underclothing shall be changed and washed as often as necessary for the maintenance of hygiene.

In exceptional circumstances, whenever a prisoner is removed outside the prison for an authorized purpose, he or she shall be allowed to wear his or her own clothing or other inconspicuous clothing.

### Rule 20

If prisoners are allowed to wear their own clothing, arrangements shall be made on their admission to the prison to ensure that it shall be clean and fit for use.

### Rule 21

Every prisoner shall, in accordance with local or national standards, be provided with a separate bed and with separate and sufficient bedding which shall be clean when issued, kept in good order and changed often enough to ensure its cleanliness.

## Food

### Rule 22

Every prisoner shall be provided by the prison administration at the usual hours with food of nutritional value adequate for health and strength, of wholesome quality and well prepared and served.

Drinking water shall be available to every prisoner whenever he or she needs it.

## Exercise and sport

### Rule 23

Every prisoner who is not employed in outdoor work shall have at least one hour of suitable exercise in the open air daily if the weather permits.

Young prisoners, and others of suitable age and physique, shall receive physical and recreational training during the period of exercise. To this end, space, installations and equipment should be provided.

## Health-care services

### Rule 24

The provision of health care for prisoners is a State responsibility. Prisoners should enjoy the same standards of health care that are available in the community, and should have access to necessary health-care services free of charge without discrimination on the grounds of their legal status.

Health-care services should be organized in close relationship to the general public health administration and in a way that ensures continuity of treatment and care, including for HIV, tuberculosis and other infectious diseases, as well as for drug dependence.

### Rule 25

Every prison shall have in place a health-care service tasked with evaluating, promoting, protecting and improving the physical and mental health of prisoners, paying particular attention to prisoners with special health-care needs or with health issues that hamper their rehabilitation.

The health-care service shall consist of an interdisciplinary team with sufficient qualified personnel acting in full clinical independence and shall encompass sufficient expertise in psychology and psychiatry. The services of a qualified dentist shall be available to every prisoner.

### Rule 26

The health-care service shall prepare and maintain accurate, up-to-date and confidential individual medical files on all prisoners, and all prisoners should be granted access to their files upon request. A prisoner may appoint a third party to access his or her medical file.

Medical files shall be transferred to the health-care service of the receiving institution upon transfer of a prisoner and shall be subject to medical confidentiality.

### Rule 27

All prisons shall ensure prompt access to medical attention in urgent cases. Prisoners who require specialized treatment or surgery shall be transferred to specialized institutions or to civil hospitals. Where a prison service has its own hospital facilities, they shall be adequately staffed and equipped to provide prisoners referred to them with appropriate treatment and care.

Clinical decisions may only be taken by the responsible health-care professionals and may not be overruled or ignored by non-medical prison staff.

## Rule 28

In women's prisons, there shall be special accommodation for all necessary prenatal and postnatal care and treatment. Arrangements shall be made wherever practicable for children to be born in a hospital outside the prison. If a child is born in prison, this fact shall not be mentioned in the birth certificate.

## Rule 29

A decision to allow a child to stay with his or her parent in prison shall be based on the best interests of the child concerned. Where children are allowed to remain in prison with a parent, provision shall be made for:

Internal or external childcare facilities staffed by qualified persons, where the children shall be placed when they are not in the care of their parent;

Child-specific health-care services, including health screenings upon admission and ongoing monitoring of their development by specialists.

Children in prison with a parent shall never be treated as prisoners.

## Rule 30

A physician or other qualified health-care professionals, whether or not they are required to report to the physician, shall see, talk with and examine every prisoner as soon as possible following his or her admission and thereafter as necessary. Particular attention shall be paid to:

Identifying health-care needs and taking all necessary measures for treatment;

Identifying any ill-treatment that arriving prisoners may have been subjected to prior to admission;

Identifying any signs of psychological or other stress brought on by the fact of imprisonment, including, but not limited to, the risk of suicide or self-harm and withdrawal symptoms resulting from the use of drugs, medication or alcohol; and undertaking all appropriate individualized measures or treatment;

In cases where prisoners are suspected of having contagious diseases, providing for the clinical isolation and adequate treatment of those prisoners during the infectious period;

Determining the fitness of prisoners to work, to exercise and to participate in other activities, as appropriate.

## Rule 31

The physician or, where applicable, other qualified health-care professionals shall have daily access to all sick prisoners, all prisoners who complain of physical or mental health issues or injury and any prisoner to whom their attention is specially directed. All medical examinations shall be undertaken in full confidentiality.

#### Rule 32

The relationship between the physician or other health-care professionals and the prisoners shall be governed by the same ethical and professional standards as those applicable to patients in the community, in particular:

The duty of protecting prisoners' physical and mental health and the prevention and treatment of disease on the basis of clinical grounds only;

Adherence to prisoners' autonomy with regard to their own health and informed consent in the doctor-patient relationship;

The confidentiality of medical information, unless maintaining such confidentiality would result in a real and imminent threat to the patient or to others;

An absolute prohibition on engaging, actively or passively, in acts that may constitute torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment, including medical or scientific experimentation that may be detrimental to a prisoner's health, such as the removal of a prisoner's cells, body tissues or organs.

Without prejudice to paragraph 1 (d) of this rule, prisoners may be allowed, upon their free and informed consent and in accordance with applicable law, to participate in clinical trials and other health research accessible in the community if these are expected to produce a direct and significant benefit to their health, and to donate cells, body tissues or organs to a relative.

#### Rule 33

The physician shall report to the prison director whenever he or she considers that a prisoner's physical or mental health has been or will be injuriously affected by continued imprisonment or by any condition of imprisonment.

#### Rule 34

If, in the course of examining a prisoner upon admission or providing medical care to the prisoner thereafter, health-care professionals become aware of any signs of torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment, they shall document and report such cases to the competent medical, administrative or judicial authority. Proper procedural safeguards shall be followed in order not to expose the prisoner or associated persons to foreseeable risk of harm.

#### Rule 35

The physician or competent public health body shall regularly inspect and advise the prison director on:

The quantity, quality, preparation and service of food;

The hygiene and cleanliness of the institution and the prisoners;

The sanitation, temperature, lighting and ventilation of the prison;



The suitability and cleanliness of the prisoners' clothing and bedding;

The observance of the rules concerning physical education and sports, in cases where there is no technical personnel in charge of these activities.

The prison director shall take into consideration the advice and reports provided in accordance with paragraph 1 of this rule and rule 33 and shall take immediate steps to give effect to the advice and the recommendations in the reports. If the advice or recommendations do not fall within the prison director's competence or if he or she does not concur with them, the director shall immediately submit to a higher authority his or her own report and the advice or recommendations of the physician or competent public health body.

## Restrictions, discipline and sanctions

### Rule 36

Discipline and order shall be maintained with no more restriction than is necessary to ensure safe custody, the secure operation of the prison and a well ordered community life.

### Rule 37

The following shall always be subject to authorization by law or by the regulation of the competent administrative authority: (a) Conduct constituting a disciplinary offence;

The types and duration of sanctions that may be imposed;

The authority competent to impose such sanctions;

Any form of involuntary separation from the general prison population, such as solitary confinement, isolation, segregation, special care units or restricted housing, whether as a disciplinary sanction or for the maintenance of order and security, including promulgating policies and procedures governing the use and review of, admission to and release from any form of involuntary separation.

### Rule 38

Prison administrations are encouraged to use, to the extent possible, conflict prevention, mediation or any other alternative dispute resolution mechanism to prevent disciplinary offences or to resolve conflicts.

For prisoners who are, or have been, separated, the prison administration shall take the necessary measures to alleviate the potential detrimental effects of their confinement on them and on their community following their release from prison.

### Rule 39

No prisoner shall be sanctioned except in accordance with the terms of the law or regulation referred to in rule 37 and the principles of fairness and due process. A prison-

er shall never be sanctioned twice for the same act or offence.

Prison administrations shall ensure proportionality between a disciplinary sanction and the offence for which it is established, and shall keep a proper record of all disciplinary sanctions imposed.

Before imposing disciplinary sanctions, prison administrations shall consider whether and how a prisoner's mental illness or developmental disability may have contributed to his or her conduct and the commission of the offence or act underlying the disciplinary charge. Prison administrations shall not sanction any conduct of a prisoner that is considered to be the direct result of his or her mental illness or intellectual disability.

#### Rule 40

No prisoner shall be employed, in the service of the prison, in any disciplinary capacity.

This rule shall not, however, impede the proper functioning of systems based on self-government, under which specified social, educational or sports activities or responsibilities are entrusted, under supervision, to prisoners who are formed into groups for the purposes of treatment.

#### Rule 41

Any allegation of a disciplinary offence by a prisoner shall be reported promptly to the competent authority, which shall investigate it without undue delay.

Prisoners shall be informed, without delay and in a language that they understand, of the nature of the accusations against them and shall be given adequate time and facilities for the preparation of their defence.

Prisoners shall be allowed to defend themselves in person, or through legal assistance when the interests of justice so require, particularly in cases involving serious disciplinary charges. If the prisoners do not understand or speak the language used at a disciplinary hearing, they shall be assisted by a competent interpreter free of charge.

Prisoners shall have an opportunity to seek judicial review of disciplinary sanctions imposed against them.

In the event that a breach of discipline is prosecuted as a crime, prisoners shall be entitled to all due process guarantees applicable to criminal proceedings, including unimpeded access to a legal adviser.

#### Rule 42

General living conditions addressed in these rules, including those related to light, ventilation, temperature, sanitation, nutrition, drinking water, access to open air and physical exercise, personal hygiene, health care and adequate personal space, shall apply to all prisoners without exception.

#### Rule 43

In no circumstances may restrictions or disciplinary sanctions amount to torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment. The following practices, in particular, shall be prohibited: (a) Indefinite solitary confinement;

Prolonged solitary confinement;

Placement of a prisoner in a dark or constantly lit cell;

Corporal punishment or the reduction of a prisoner's diet or drinking water;

Collective punishment.

Instruments of restraint shall never be applied as a sanction for disciplinary offences.

Disciplinary sanctions or restrictive measures shall not include the prohibition of family contact. The means of family contact may only be restricted for a limited time period and as strictly required for the maintenance of security and order.

#### Rule 44

For the purpose of these rules, solitary confinement shall refer to the confinement of prisoners for 22 hours or more a day without meaningful human contact. Prolonged solitary confinement shall refer to solitary confinement for a time period in excess of 15 consecutive days.

#### Rule 45

Solitary confinement shall be used only in exceptional cases as a last resort, for as short a time as possible and subject to independent review, and only pursuant to the authorization by a competent authority. It shall not be imposed by virtue of a prisoner's sentence.

The imposition of solitary confinement should be prohibited in the case of prisoners with mental or physical disabilities when their conditions would be exacerbated by such measures. The prohibition of the use of solitary confinement and similar measures in cases involving women and children, as referred to in other United Nations standards and norms in crime prevention and criminal justice,<sup>278</sup> continues to apply.

#### Rule 46

Health-care personnel shall not have any role in the imposition of disciplinary sanctions or other restrictive measures. They shall, however, pay particular attention to the health of prisoners held under any form of involuntary separation, including by visiting such prisoners on a daily basis and providing prompt medical assistance and treatment at the request of such prisoners or prison staff.

<sup>278</sup> See rule 67 of the United Nations Rules for the Protection of Juveniles Deprived of their Liberty (resolution 45/113, annex); and rule 22 of the United Nations Rules for the Treatment of Women Prisoners and Non-custodial Measures for Women Offenders (the Bangkok Rules) (resolution 65/229, annex).

Health-care personnel shall report to the prison director, without delay, any adverse effect of disciplinary sanctions or other restrictive measures on the physical or mental health of a prisoner subjected to such sanctions or measures and shall advise the director if they consider it necessary to terminate or alter them for physical or mental health reasons.

Health-care personnel shall have the authority to review and recommend changes to the involuntary separation of a prisoner in order to ensure that such separation does not exacerbate the medical condition or mental or physical disability of the prisoner.

#### Instruments of restraint

##### Rule 47

1. The use of chains, irons or other instruments of restraint which are inherently degrading or painful shall be prohibited.

---

2. Other instruments of restraint shall only be used when authorized by law and in the following circumstances:

As a precaution against escape during a transfer, provided that they are removed when the prisoner appears before a judicial or administrative authority;

By order of the prison director, if other methods of control fail, in order to prevent a prisoner from injuring himself or herself or others or from damaging property; in such instances, the director shall immediately alert the physician or other qualified health-care professionals and report to the higher administrative authority.

##### Rule 48

When the imposition of instruments of restraint is authorized in accordance with paragraph 2 of rule 47, the following principles shall apply:

Instruments of restraint are to be imposed only when no lesser form of control would be effective to address the risks posed by unrestricted movement;

The method of restraint shall be the least intrusive method that is necessary and reasonably available to control the prisoner's movement, based on the level and nature of the risks posed;

Instruments of restraint shall be imposed only for the time period required, and they are to be removed as soon as possible after the risks posed by unrestricted movement are no longer present.

Instruments of restraint shall never be used on women during labour, during childbirth and immediately after childbirth.

##### Rule 49

The prison administration should seek access to, and provide training in the use of,

control techniques that would obviate the need for the imposition of instruments of restraint or reduce their intrusiveness.

#### Searches of prisoners and cells

##### Rule 50

The laws and regulations governing searches of prisoners and cells shall be in accordance with obligations under international law and shall take into account international standards and norms, keeping in mind the need to ensure security in the prison. Searches shall be conducted in a manner that is respectful of the inherent human dignity and privacy of the individual being searched, as well as the principles of proportionality, legality and necessity.

##### Rule 51

Searches shall not be used to harass, intimidate or unnecessarily intrude upon a prisoner's privacy. For the purpose of accountability, the prison administration shall keep appropriate records of searches, in particular strip and body cavity searches and searches of cells, as well as the reasons for the searches, the identities of those who conducted them and any results of the searches.

##### Rule 52

Intrusive searches, including strip and body cavity searches, should be undertaken only if absolutely necessary. Prison administrations shall be encouraged to develop and use appropriate alternatives to intrusive searches. Intrusive searches shall be conducted in private and by trained staff of the same sex as the prisoner.

Body cavity searches shall be conducted only by qualified health-care professionals other than those primarily responsible for the care of the prisoner or, at a minimum, by staff appropriately trained by a medical professional in standards of hygiene, health and safety.

##### Rule 53

Prisoners shall have access to, or be allowed to keep in their possession without access by the prison administration, documents relating to their legal proceedings.

#### Information to and complaints by prisoners

##### Rule 54

Upon admission, every prisoner shall be promptly provided with written information about:

The prison law and applicable prison regulations;

His or her rights, including authorized methods of seeking information, access to

legal advice, including through legal aid schemes, and procedures for making requests or complaints;

His or her obligations, including applicable disciplinary sanctions; and

All other matters necessary to enable the prisoner to adapt himself or herself to the life of the prison.

#### Rule 55

The information referred to in rule 54 shall be available in the most commonly used languages in accordance with the needs of the prison population. If a prisoner does not understand any of those languages, interpretation assistance should be provided.

If a prisoner is illiterate, the information shall be conveyed to him or her orally. Prisoners with sensory disabilities should be provided with information in a manner appropriate to their needs.

The prison administration shall prominently display summaries of the information in common areas of the prison.

#### Rule 56

Every prisoner shall have the opportunity each day to make requests or complaints to the prison director or the prison staff member authorized to represent him or her.

It shall be possible to make requests or complaints to the inspector of prisons during his or her inspections. The prisoner shall have the opportunity to talk to the inspector or any other inspecting officer freely and in full confidentiality, without the director or other members of the staff being present.

Every prisoner shall be allowed to make a request or complaint regarding his or her treatment, without censorship as to substance, to the central prison administration and to the judicial or other competent authorities, including those vested with reviewing or remedial power.

The rights under paragraphs 1 to 3 of this rule shall extend to the legal adviser of the prisoner. In those cases where neither the prisoner nor his or her legal adviser has the possibility of exercising such rights, a member of the prisoner's family or any other person who has knowledge of the case may do so.

#### Rule 57

Every request or complaint shall be promptly dealt with and replied to without delay. If the request or complaint is rejected, or in the event of undue delay, the complainant shall be entitled to bring it before a judicial or other authority.

Safeguards shall be in place to ensure that prisoners can make requests or complaints safely and, if so requested by the complainant, in a confidential manner. A prisoner or other person mentioned in paragraph 4 of rule 56 must not be exposed to any risk of retaliation, intimidation or other negative consequences as a result of having submitted a request or complaint.



Allegations of torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment of prisoners shall be dealt with immediately and shall result in a prompt and impartial investigation conducted by an independent national authority in accordance with paragraphs 1 and 2 of rule 71.

Contact with the outside world

Rule 58

Prisoners shall be allowed, under necessary supervision, to communicate with their family and friends at regular intervals:

(a) By corresponding in writing and using, where available, telecommunication, electronic, digital and other means; and (b) By receiving visits.

Where conjugal visits are allowed, this right shall be applied without discrimination, and women prisoners shall be able to exercise this right on an equal basis with men. Procedures shall be in place and premises shall be made available to ensure fair and equal access with due regard to safety and dignity.

Rule 59

Prisoners shall be allocated, to the extent possible, to prisons close to their homes or their places of social rehabilitation.

Rule 60

Admission of visitors to the prison facility is contingent upon the visitor's consent to being searched. The visitor may withdraw his or her consent at any time, in which case the prison administration may refuse access.

Search and entry procedures for visitors shall not be degrading and shall be governed by principles at least as protective as those outlined in rules 50 to 52. Body cavity searches should be avoided and should not be applied to children.

Rule 61

Prisoners shall be provided with adequate opportunity, time and facilities to be visited by and to communicate and consult with a legal adviser of their own choice or a legal aid provider, without delay, interception or censorship and in full confidentiality, on any legal matter, in conformity with applicable domestic law. Consultations may be within sight, but not within hearing, of prison staff.

In cases in which prisoners do not speak the local language, the prison administration shall facilitate access to the services of an independent competent interpreter.

Prisoners should have access to effective legal aid.

Rule 62

Prisoners who are foreign nationals shall be allowed reasonable facilities to communicate with the diplomatic and consular representatives of the State to which they belong.

Prisoners who are nationals of States without diplomatic or consular representation in the country and refugees or stateless persons shall be allowed similar facilities to communicate with the diplomatic representative of the State which takes charge of their interests or any national or international authority whose task it is to protect such persons.

#### Rule 63

Prisoners shall be kept informed regularly of the more important items of news by the reading of newspapers, periodicals or special institutional publications, by hearing wireless transmissions, by lectures or by any similar means as authorized or controlled by the prison administration.

#### Books

#### Rule 64

Every prison shall have a library for the use of all categories of prisoners, adequately stocked with both recreational and instructional books, and prisoners shall be encouraged to make full use of it.

#### Religion

#### Rule 65

If the prison contains a sufficient number of prisoners of the same religion, a qualified representative of that religion shall be appointed or approved. If the number of prisoners justifies it and conditions permit, the arrangement should be on a full-time basis.

A qualified representative appointed or approved under paragraph 1 of this rule shall be allowed to hold regular services and to pay pastoral visits in private to prisoners of his or her religion at proper times.

Access to a qualified representative of any religion shall not be refused to any prisoner. On the other hand, if any prisoner should object to a visit of any religious representative, his or her attitude shall be fully respected.

#### Rule 66

So far as practicable, every prisoner shall be allowed to satisfy the needs of his or her religious life by attending the services provided in the prison and having in his or her possession the books of religious observance and instruction of his or her denomination.

## Retention of prisoners' property

### Rule 67

All money, valuables, clothing and other effects belonging to a prisoner which he or she is not allowed to retain under the prison regulations shall on his or her admission to the prison be placed in safe custody. An inventory thereof shall be signed by the prisoner. Steps shall be taken to keep them in good condition.

On the release of the prisoner, all such articles and money shall be returned to him or her except in so far as he or she has been authorized to spend money or send any such property out of the prison, or it has been found necessary on hygienic grounds to destroy any article of clothing. The prisoner shall sign a receipt for the articles and money returned to him or her.

Any money or effects received for a prisoner from outside shall be treated in the same way.

If a prisoner brings in any drugs or medicine, the physician or other qualified health-care professionals shall decide what use shall be made of them.

## Notifications

### Rule 68

Every prisoner shall have the right, and shall be given the ability and means, to inform immediately his or her family, or any other person designated as a contact person, about his or her imprisonment, about his or her transfer to another institution and about any serious illness or injury. The sharing of prisoners' personal information shall be subject to domestic legislation.

### Rule 69

In the event of a prisoner's death, the prison director shall at once inform the prisoner's next of kin or emergency contact. Individuals designated by a prisoner to receive his or her health information shall be notified by the director of the prisoner's serious illness, injury or transfer to a health institution. The explicit request of a prisoner not to have his or her spouse or nearest relative notified in the event of illness or injury shall be respected.

### Rule 70

The prison administration shall inform a prisoner at once of the serious illness or death of a near relative or any significant other. Whenever circumstances allow, the prisoner should be authorized to go, either under escort or alone, to the bedside of a near relative or significant other who is critically ill, or to attend the funeral of a near relative or significant other.

## Investigations

### Rule 71

Notwithstanding the initiation of an internal investigation, the prison director shall report, without delay, any custodial death, disappearance or serious injury to a judicial or other competent authority that is independent of the prison administration and mandated to conduct prompt, impartial and effective investigations into the circumstances and causes of such cases. The prison administration shall fully cooperate with that authority and ensure that all evidence is preserved.

The obligation in paragraph 1 of this rule shall equally apply whenever there are reasonable grounds to believe that an act of torture or other cruel, inhuman or degrading treatment or punishment has been committed in prison, irrespective of whether a formal complaint has been received.

Whenever there are reasonable grounds to believe that an act referred to in paragraph 2 of this rule has been committed, steps shall be taken immediately to ensure that all potentially implicated persons have no involvement in the investigation and no contact with the witnesses, the victim or the victim's family.

### Rule 72

The prison administration shall treat the body of a deceased prisoner with respect and dignity. The body of a deceased prisoner should be returned to his or her next of kin as soon as reasonably possible, at the latest upon completion of the investigation. The prison administration shall facilitate a culturally appropriate funeral if there is no other responsible party willing or able to do so and shall keep a full record of the matter.

## Removal of prisoners

### Rule 73

When prisoners are being removed to or from an institution, they shall be exposed to public view as little as possible, and proper safeguards shall be adopted to protect them from insult, curiosity and publicity in any form.

The transport of prisoners in conveyances with inadequate ventilation or light, or in any way which would subject them to unnecessary physical hardship, shall be prohibited.

The transport of prisoners shall be carried out at the expense of the prison administration and equal conditions shall apply to all of them.

## Institutional personnel

### Rule 74

The prison administration shall provide for the careful selection of every grade of the personnel, since it is on their integrity, humanity, professional capacity and personal suitability for the work that the proper administration of prisons depends.

The prison administration shall constantly seek to awaken and maintain in the minds both of the personnel and of the public the conviction that this work is a social service of great importance, and to this end all appropriate means of informing the public should be used.

To secure the foregoing ends, personnel shall be appointed on a full-time basis as professional prison staff and have civil service status with security of tenure subject only to good conduct, efficiency and physical fitness. Salaries shall be adequate to attract and retain suitable men and women; employment benefits and conditions of service shall be favourable in view of the exacting nature of the work.

#### Rule 75

All prison staff shall possess an adequate standard of education and shall be given the ability and means to carry out their duties in a professional manner.

Before entering on duty, all prison staff shall be provided with training tailored to their general and specific duties, which shall be reflective of contemporary evidence-based best practice in penal sciences. Only those candidates who successfully pass the theoretical and practical tests at the end of such training shall be allowed to enter the prison service.

The prison administration shall ensure the continuous provision of in service training courses with a view to maintaining and improving the knowledge and professional capacity of its personnel, after entering on duty and during their career.

#### Rule 76

Training referred to in paragraph 2 of rule 75 shall include, at a minimum, training on:

Relevant national legislation, regulations and policies, as well as applicable international and regional instruments, the provisions of which must guide the work and interactions of prison staff with inmates;

Rights and duties of prison staff in the exercise of their functions, including respecting the human dignity of all prisoners and the prohibition of certain conduct, in particular torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment;

Security and safety, including the concept of dynamic security, the use of force and instruments of restraint, and the management of violent offenders, with due consideration of preventive and defusing techniques, such as negotiation and mediation;

First aid, the psychosocial needs of prisoners and the corresponding dynamics in prison settings, as well as social care and assistance, including early detection of mental health issues.

Prison staff who are in charge of working with certain categories of prisoners, or who are assigned other specialized functions, shall receive training that has a corresponding focus.

#### Rule 77

All prison staff shall at all times so conduct themselves and perform their duties as to influence the prisoners for good by their example and to command their respect.

#### Rule 78

So far as possible, prison staff shall include a sufficient number of specialists such as psychiatrists, psychologists, social workers, teachers and trade instructors.

The services of social workers, teachers and trade instructors shall be secured on a permanent basis, without thereby excluding part-time or voluntary workers.

#### Rule 79

The prison director should be adequately qualified for his or her task by character, administrative ability, suitable training and experience.

The prison director shall devote his or her entire working time to official duties and shall not be appointed on a part-time basis. He or she shall reside on the premises of the prison or in its immediate vicinity.

When two or more prisons are under the authority of one director, he or she shall visit each of them at frequent intervals. A responsible resident official shall be in charge of each of these prisons.

#### Rule 80

The prison director, his or her deputy, and the majority of other prison staff shall be able to speak the language of the greatest number of prisoners, or a language understood by the greatest number of them.

Whenever necessary, the services of a competent interpreter shall be used.

#### Rule 81

In a prison for both men and women, the part of the prison set aside for women shall be under the authority of a responsible woman staff member who shall have the custody of the keys of all that part of the prison.

No male staff member shall enter the part of the prison set aside for women unless accompanied by a woman staff member.

Women prisoners shall be attended and supervised only by women staff members. This does not, however, preclude male staff members, particularly doctors and teachers, from carrying out their professional duties in prisons or parts of prisons set aside for women.



## Rule 82

Prison staff shall not, in their relations with the prisoners, use force except in self-defence or in cases of attempted escape, or active or passive physical resistance to an order based on law or regulations. Prison staff who have recourse to force must use no more than is strictly necessary and must report the incident immediately to the prison director.

Prison staff shall be given special physical training to enable them to restrain aggressive prisoners.

Except in special circumstances, prison staff performing duties which bring them into direct contact with prisoners should not be armed. Furthermore, prison staff should in no circumstances be provided with arms unless they have been trained in their use.

## Internal and external inspections

### Rule 83

There shall be a twofold system for regular inspections of prisons and penal services:

Internal or administrative inspections conducted by the central prison administration;

External inspections conducted by a body independent of the prison administration, which may include competent international or regional bodies.

In both cases, the objective of the inspections shall be to ensure that prisons are managed in accordance with existing laws, regulations, policies and procedures, with a view to bringing about the objectives of penal and corrections services, and that the rights of prisoners are protected.

### Rule 84

Inspectors shall have the authority:

To access all information on the numbers of prisoners and places and locations of detention, as well as all information relevant to the treatment of prisoners, including their records and conditions of detention;

To freely choose which prisons to visit, including by making unannounced visits at their own initiative, and which prisoners to interview;

To conduct private and fully confidential interviews with prisoners and prison staff in the course of their visits;

To make recommendations to the prison administration and other competent authorities.

External inspection teams shall be composed of qualified and experienced inspectors appointed by a competent authority and shall encompass health-care professionals. Due regard shall be given to balanced gender representation.

## Rule 85

Every inspection shall be followed by a written report to be submitted to the competent authority. Due consideration shall be given to making the reports of external inspections publicly available, excluding any personal data on prisoners unless they have given their explicit consent.

The prison administration or other competent authorities, as appropriate, shall indicate, within a reasonable time, whether they will implement the recommendations resulting from the external inspection.

## II. Rules applicable to special categories A. Prisoners under sentence

### Guiding principles

#### Rule 86

The guiding principles hereafter are intended to show the spirit in which penal institutions should be administered and the purposes at which they should aim, in accordance with the declaration made under preliminary observation 1 of these rules.

#### Rule 87

Before the completion of the sentence, it is desirable that the necessary steps be taken to ensure for the prisoner a gradual return to life in society. This aim may be achieved, depending on the case, by a pre-release regime organized in the same prison or in another appropriate institution, or by release on trial under some kind of supervision which must not be entrusted to the police but should be combined with effective social aid.

#### Rule 88

The treatment of prisoners should emphasize not their exclusion from the community but their continuing part in it. Community agencies should therefore be enlisted wherever possible to assist the prison staff in the task of social rehabilitation of the prisoners.

There should be in connection with every prison social workers charged with the duty of maintaining and improving all desirable relations of a prisoner with his or her family and with valuable social agencies. Steps should be taken to safeguard, to the maximum extent compatible with the law and the sentence, the rights relating to civil interests, social security rights and other social benefits of prisoners.

#### Rule 89

The fulfilment of these principles requires individualization of treatment and for this purpose a flexible system of classifying prisoners in groups. It is therefore desirable that such groups should be distributed in separate prisons suitable for the treatment of each group.

These prisons do not need to provide the same degree of security for every group. It is desirable to provide varying degrees of security according to the needs of different groups. Open prisons, by the very fact that they provide no physical security against escape but rely on the self-discipline of the inmates, provide the conditions most favourable to the rehabilitation of carefully selected prisoners.

It is desirable that the number of prisoners in closed prisons should not be so large that the individualization of treatment is hindered. In some countries it is considered that the population of such prisons should not exceed 500. In open prisons the population should be as small as possible.

On the other hand, it is undesirable to maintain prisons which are so small that proper facilities cannot be provided.

#### Rule 90

The duty of society does not end with a prisoner's release. There should, therefore, be governmental or private agencies capable of lending the released prisoner efficient aftercare directed towards the lessening of prejudice against him or her and towards his or her social rehabilitation.

#### Treatment

#### Rule 91

The treatment of persons sentenced to imprisonment or a similar measure shall have as its purpose, so far as the length of the sentence permits, to establish in them the will to lead law-abiding and self-supporting lives after their release and to fit them to do so. The treatment shall be such as will encourage their self-respect and develop their sense of responsibility.

#### Rule 92

To these ends, all appropriate means shall be used, including religious care in the countries where this is possible, education, vocational guidance and training, social casework, employment counselling, physical development and strengthening of moral character, in accordance with the individual needs of each prisoner, taking account of his or her social and criminal history, physical and mental capacities and aptitudes, personal temperament, the length of his or her sentence and prospects after release.

For every prisoner with a sentence of suitable length, the prison director shall receive, as soon as possible after his or her admission, full reports on all the matters referred to in paragraph 1 of this rule. Such reports shall always include a report by the physician or other qualified health-care professionals on the physical and mental condition of the prisoner.

The reports and other relevant documents shall be placed in an individual file. This file shall be kept up to date and classified in such a way that it can be consulted by the responsible personnel whenever the need arises.

## Classification and individualization

### Rule 93

The purposes of classification shall be:

To separate from others those prisoners who, by reason of their criminal records or characters, are likely to exercise a bad influence;

To divide the prisoners into classes in order to facilitate their treatment with a view to their social rehabilitation.

So far as possible, separate prisons or separate sections of a prison shall be used for the treatment of different classes of prisoners.

### Rule 94

As soon as possible after admission and after a study of the personality of each prisoner with a sentence of suitable length, a programme of treatment shall be prepared for him or her in the light of the knowledge obtained about his or her individual needs, capacities and dispositions.

## Privileges

### Rule 95

Systems of privileges appropriate for the different classes of prisoners and the different methods of treatment shall be established at every prison, in order to encourage good conduct, develop a sense of responsibility and secure the interest and cooperation of prisoners in their treatment.

## Work

### Rule 96

Sentenced prisoners shall have the opportunity to work and/or to actively participate in their rehabilitation, subject to a determination of physical and mental fitness by a physician or other qualified health-care professionals.

Sufficient work of a useful nature shall be provided to keep prisoners actively employed for a normal working day.

### Rule 97

Prison labour must not be of an afflictive nature.

Prisoners shall not be held in slavery or servitude.

No prisoner shall be required to work for the personal or private benefit of any prison staff.

#### Rule 98

So far as possible the work provided shall be such as will maintain or increase the prisoners' ability to earn an honest living after release.

Vocational training in useful trades shall be provided for prisoners able to profit thereby and especially for young prisoners.

Within the limits compatible with proper vocational selection and with the requirements of institutional administration and discipline, prisoners shall be able to choose the type of work they wish to perform.

#### Rule 99

The organization and methods of work in prisons shall resemble as closely as possible those of similar work outside of prisons, so as to prepare prisoners for the conditions of normal occupational life.

The interests of the prisoners and of their vocational training, however, must not be subordinated to the purpose of making a financial profit from an industry in the prison.

#### Rule 100

Preferably, institutional industries and farms should be operated directly by the prison administration and not by private contractors.

Where prisoners are employed in work not controlled by the prison administration, they shall always be under the supervision of prison staff. Unless the work is for other departments of the government, the full normal wages for such work shall be paid to the prison administration by the persons to whom the labour is supplied, account being taken of the output of the prisoners.

#### Rule 101

The precautions laid down to protect the safety and health of free workers shall be equally observed in prisons.

Provision shall be made to indemnify prisoners against industrial injury, including occupational disease, on terms not less favourable than those extended by law to free workers.

#### Rule 102

The maximum daily and weekly working hours of the prisoners shall be fixed by law or by administrative regulation, taking into account local rules or custom in regard to the employment of free workers.

The hours so fixed shall leave one rest day a week and sufficient time for education and other activities required as part of the treatment and rehabilitation of prisoners.

#### Rule 103

There shall be a system of equitable remuneration of the work of prisoners.

Under the system, prisoners shall be allowed to spend at least a part of their earnings on approved articles for their own use and to send a part of their earnings to their family.

The system should also provide that a part of the earnings should be set aside by the prison administration so as to constitute a savings fund to be handed over to the prisoner on his or her release.

#### Education and recreation

##### Rule 104

Provision shall be made for the further education of all prisoners capable of profiting thereby, including religious instruction in the countries where this is possible. The education of illiterate prisoners and of young prisoners shall be compulsory and special attention shall be paid to it by the prison administration.

So far as practicable, the education of prisoners shall be integrated with the educational system of the country so that after their release they may continue their education without difficulty.

##### Rule 105

Recreational and cultural activities shall be provided in all prisons for the benefit of the mental and physical health of prisoners.

#### Social relations and aftercare

##### Rule 106

Special attention shall be paid to the maintenance and improvement of such relations between a prisoner and his or her family as are desirable in the best interests of both.

##### Rule 107

From the beginning of a prisoner's sentence, consideration shall be given to his or her future after release and he or she shall be encouraged and provided assistance to maintain or establish such relations with persons or agencies outside the prison as may promote the prisoner's rehabilitation and the best interests of his or her family.

##### Rule 108

Services and agencies, governmental or otherwise, which assist released prisoners in re-establishing themselves in society shall ensure, so far as is possible and necessary,



that released prisoners are provided with appropriate documents and identification papers, have suitable homes and work to go to, are suitably and adequately clothed having regard to the climate and season and have sufficient means to reach their destination and maintain themselves in the period immediately following their release.

The approved representatives of such agencies shall have all necessary access to the prison and to prisoners and shall be taken into consultation as to the future of a prisoner from the beginning of his or her sentence.

It is desirable that the activities of such agencies shall be centralized or coordinated as far as possible in order to secure the best use of their efforts.

#### B. Prisoners with mental disabilities and/or health conditions

##### Rule 109

Persons who are found to be not criminally responsible, or who are later diagnosed with severe mental disabilities and/or health conditions, for whom staying in prison would mean an exacerbation of their condition, shall not be detained in prisons, and arrangements shall be made to transfer them to mental health facilities as soon as possible.

If necessary, other prisoners with mental disabilities and/or health conditions can be observed and treated in specialized facilities under the supervision of qualified health-care professionals.

The health-care service shall provide for the psychiatric treatment of all other prisoners who are in need of such treatment.

##### Rule 110

It is desirable that steps should be taken, by arrangement with the appropriate agencies, to ensure if necessary the continuation of psychiatric treatment after release and the provision of social-psychiatric aftercare.

#### C. Prisoners under arrest or awaiting trial

##### Rule 111

Persons arrested or imprisoned by reason of a criminal charge against them, who are detained either in police custody or in prison custody (jail) but have not yet been tried and sentenced, will be referred to as “untried prisoners” hereinafter in these rules.

Unconvicted prisoners are presumed to be innocent and shall be treated as such.

Without prejudice to legal rules for the protection of individual liberty or prescribing the procedure to be observed in respect of untried prisoners, these prisoners shall benefit from a special regime which is described in the following rules in its essential requirements only.

#### Rule 112

Untried prisoners shall be kept separate from convicted prisoners.

Young untried prisoners shall be kept separate from adults and shall in principle be detained in separate institutions.

#### Rule 113

Untried prisoners shall sleep singly in separate rooms, with the reservation of different local custom in respect of the climate.

#### Rule 114

Within the limits compatible with the good order of the institution, untried prisoners may, if they so desire, have their food procured at their own expense from the outside, either through the administration or through their family or friends. Otherwise, the administration shall provide their food.

#### Rule 115

An untried prisoner shall be allowed to wear his or her own clothing if it is clean and suitable. If he or she wears prison dress, it shall be different from that supplied to convicted prisoners.

#### Rule 116

An untried prisoner shall always be offered the opportunity to work, but shall not be required to work. If he or she chooses to work, he or she shall be paid for it.

#### Rule 117

An untried prisoner shall be allowed to procure at his or her own expense or at the expense of a third party such books, newspapers, writing material and other means of occupation as are compatible with the interests of the administration of justice and the security and good order of the institution.

#### Rule 118

An untried prisoner shall be allowed to be visited and treated by his or her own doctor or dentist if there are reasonable grounds for the application and he or she is able to pay any expenses incurred.

#### Rule 119

Every untried prisoner has the right to be promptly informed about the reasons for his or her detention and about any charges against him or her.

If an untried prisoner does not have a legal adviser of his or her own choice, he or she shall be entitled to have a legal adviser assigned to him or her by a judicial or other authority in all cases where the interests of justice so require and without payment by the untried prisoner if he or she does not have sufficient means to pay. Denial of access to a legal adviser shall be subject to independent review without delay.

#### Rule 120

The entitlements and modalities governing the access of an untried prisoner to his or her legal adviser or legal aid provider for the purpose of his or her defence shall be governed by the same principles as outlined in rule 61.

An untried prisoner shall, upon request, be provided with writing material for the preparation of documents related to his or her defence, including confidential instructions for his or her legal adviser or legal aid provider.

#### D. Civil prisoners

##### Rule 121

In countries where the law permits imprisonment for debt, or by order of a court under any other non-criminal process, persons so imprisoned shall not be subjected to any greater restriction or severity than is necessary to ensure safe custody and good order. Their treatment shall be not less favourable than that of untried prisoners, with the reservation, however, that they may possibly be required to work.

#### E. Persons arrested or detained without charge

##### Rule 122

Without prejudice to the provisions of article 9 of the International Covenant on Civil and Political Rights,<sup>29</sup> persons arrested or imprisoned without charge shall be accorded the same protection as that accorded under part I and part II, section C, of these rules. Relevant provisions of part II, section A, of these rules shall likewise be applicable where their application may be conducive to the benefit of this special group of persons in custody, provided that no measures shall be taken implying that re-education or rehabilitation is in any way appropriate to persons not convicted of any criminal offence.

---

<sup>29</sup> See resolution 2200 A (XXI), annex.

**ХОРИГДЛУУДАЙ ХАРЬЦАХ НААД ЗАХЫН ЖИШИГ ДҮРЭМ (албан бус орчуулга,  
монгол хэлээр)**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор баталсан "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм"-ийн албан бус орчуулга

United Nations

A/RES/70/175/



General Assembly

Distr.: General

8 January 2016

**Дал дахь хуралдаан**

Хэлэлцэх асуудал 106

**Ерөнхий Ассамблейн 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн тогтоол***[Гуравдугаар хорооны илтгэлийн тухай (A/70/490)]***70/175. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын  
жишиг дүрэм (Нелсон Манделлагийн дүрэм)****Ерөнхий хэрэглээний дүрэм****Үндсэн зарчим**

## Дүрэм 1

Бүх хоригдолтой заяасан нэр хүнд, мөн чанарыг эрдэнэт хүнийх нь хувьд хүндэтгэн харьцана. Бүх хоригдол эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалагдах ёстой, нэг ч хоригдлыг эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэж болохгүй бөгөөд ямар ч нөхцөл байдал энэ үйлдлийн шалтгаан болохгүй. Хоригдлууд, ажилтнууд, үйлчилгээ үзүүлэгчид, зочдын аюулгүй байдал үргэлж хангагдах ёстой.

## Дүрэм 2

1. Энэхүү дүрмийг шударгаар дагаж мөрдөнө. Яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал,

эд хөрөнгийн байдал, гарал язгуур болон бусад байдлаар хэрхэвч ялгаварлан гадуурхаж болохгүй. Хоригдлуудын шашны итгэл үнэмшил, ёс суртахууны зарчмуудыг хүндэтгэнэ.

2. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг практикт хэрэгжүүлэхийн тулд хорих ангийн захиргаа хоригдлуудын хувийн хэрэгцээ, ялангуяа хамгийн эмзэг бүлэгт хамаарах хоригдлуудын нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой. Тусгай хэрэгцээт хоригдлуудын эрхийг хамгаалах, дэмжих арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд энэ арга хэмжээ нь тэднийг ялгаварлан гадуурхсан гэж ойлгогдохооргүй байх ёстой.

### Дүрэм 3

Хорих ял болон хүмүүсийг гадаад ертөнцөөс тусгаарлах бусад арга хэмжээ нь тэдний өөрийгөө удирдах эрх чөлөөг нь хасдаг учраас хүнд дарамт үүсгэдэг. Иймд хорих анги нь үндэслэлтэй тусгаарлах, шаардлагатай сахилгын арга хэмжээ авахаас бусад нөхцөл байдлаас үүдэлтэй зовлон зүдгүүрийг улам хүндрүүлэх ёсгүй.

### Дүрэм 4

1. Хүний эрх чөлөөг хассан хорих ял, түүнтэй адилтгах арга хэмжээний зорилго нь юун түрүүнд нийгмийг гэмт хэргээс хамгаалах, дахин гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэгддэг. Үүний тулд хоригдлыг хорих ял эдлэх хугацаанд нь суллагдсаныхаа дараа нийгэмд эргэн нэгдэж, хууль тогтоомжийг даган мөрдөж, бие даан амьдрахад нь чиглүүлсэн тохиолдолд л эдгээр зорилгод хүрч чадна.

2. Үүний тулд хорих ангийн удирдлагууд болон бусад эрх бүхий байгууллагууд боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт болон хүмүүжил, ёс суртахуун, оюун санаа, нийгэм, эрүүл мэнд, спортын шинж чанартай, зохих бөгөөд боломжит бусад төрлийн тусламжийг санал болгох ёстой. Ийм бүх хөтөлбөр, үйл ажиллагаа, үйлчилгээг хоригдол болгонд тохирох байдлаар нийцүүлэн явуулах ёстой.

### Дүрэм 5

1. Хорих ангийн дэглэм нь хоригдлуудад тавих хяналтыг бууруулж, нэр төрийг нь хүндэтгэх хандлага буюу хорих анги дахь болон эрх чөлөөт амьдралын хоорондын ялгааг аль болох багасгахыг эрмэлзэх ёстой.

2. Хорих ангийн захиргаа бие махбод, сэтгэцийн болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд хорих ангийн амьдралд тэгш эрхтэйгээр бүрэн, үр дүнтэй оролцох боломжийг хангах үүднээс зохих байр, бусад зохицуулалтыг хийнэ.

## **Хоригдлуудын бүртгэлийн менежмент**

### Дүрэм 6

Хоригдол хоригдож буй газар бүр хоригдлын файлыг удирдах стандарт системтэй байх ёстой. Ийм систем нь бүртгэлийн цахим мэдээллийн сан эсвэл дугаарласан, гарын үсэг зурах хуудас бүхий дэвтэр байж болно. Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, системд агуулагдаж буй аливаа мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах, өөрчлөхөөс урьдчилан сэргийлэх журам байх ёстой.

### Дүрэм 7

Хэнийг ч хорих ял эдлүүлэх тухай хүчин төгөлдөр шийдвэргүй хорих ангид хүлээн авахыг хориглоно. Ялтан тус бүрийг хүлээн авахдаа хоригдлын бүртгэлийн удирдлагын системд дараах мэдээллийг оруулах ёстой.

а) Өөрийгөө хүлээн зөвшөөрдөг хүйсийг харгалзан түүний өвөрмөц онцлогийг тодорхойлох үнэн зөв мэдээлэл;

б) Баривчлагдсан огноо, цаг, газраас гадна түүнийг хорих болсон шалтгаан, хариуцагч байгууллага;

в) Түүнийг хүлээн авах, чөлөөлөх өдөр, цаг, шилжүүлсэн хугацаа;

г) Урьд өмнө нь зүй бусаар харьцсантай холбоотой илэрсэн гэмтэл, гомдол;

д) Хувийн эд хөрөнгийн бүртгэл;

е) Гэр бүлийн гишүүдийн нэр, тухайлбал хүүхдүүд, хүүхдийн нас, оршин суугаа газар, асран хамгаалагч, асран хамгаалагчийн статус;

г) Яаралтай холбоо барих хаяг, хоригдлын ойр дотны хүмүүсийн мэдээлэл.

#### Дүрэм 8

Хорих ял эдэлж байх хугацаанд нь хоригдлуудын бүртгэлийн менежментийн системд дараах мэдээллийг оруулах ёстой.

(а) Шүүх хуралдааны огноо, хууль ёсны төлөөлөгч зэрэг шүүх ажиллагаатай холбоотой мэдээлэл;

(б) Анхан шатны үнэлгээ, ангиллын тайлан;

(в) Зан үйл, сахилга баттай холбоотой мэдээлэл;

(д) Хэрэв нууцлалтай биш бол эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэсэн тухай мэдүүлэг, хүсэлт, гомдол;

(е) Сахилгын шийтгэл ногдуулсан тухай мэдээлэл;

(е) Аливаа бэртэл гэмтэл, нас баралтын нөхцөл байдал, шалтгааны талаарх мэдээлэл, нас барсан тохиолдолд шарил байгаа газар.

#### Дүрэм 9

Дүрэм 7, 8-д дурдсан бүх бүртгэлийг нууцалж, зөвхөн мэргэжлийн үүргээр ийм бүртгэлтэй танилцах шаардлагатай хүмүүст нээлттэй байлгах ёстой. Хоригдол бүр өөрт хамаарах бүртгэлтэй танилцах, дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсний дагуу засварлах, мөн суллагдсаныхаа дараа эдгээр тэмдэглэлийн албан ёсны хуулбарыг авах эрхтэй.

#### Дүрэм 10

Хоригдлын бүртгэлийн менежментийн системийг хоригдлуудын ерөнхий төлөв, чиг хандлага, эзлэх хувь зэрэг үзүүлэлтийн талаарх найдвартай мэдээллээр хангах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үндэс суурийг бүрдүүлэх зорилгоор мөн ашиглах ёстой.



## Ангилал

### Дүрэм 11

Янз бүрийн ангиллын хоригдлуудыг хүйс, нас, ял эдэлж байсан байдал, цагдан хорих хууль ёсны шалтгаан, тэдэнтэй харьцах онцлог байдлын шаардлага зэргийг харгалзан тусдаа байранд эсрэв тусдаа хэсэгт байрлуулна; үүнд:

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг аль болох тусад нь хорих газарт хорих; эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүлээн авдаг хорих ангид эмэгтэйчүүдэд зориулсан байр бүрэн тусдаа байх ёстой;

Шүүхээр хэрэг нь эцэслэн шийдэгдээгүй хоригдогчдыг ял шийтгүүлсэн хоригдлуудаас тусад нь байрлуулах;

Эдийн засгийн болон иргэний гэмт хэрэгтэй хоригдлыг эрүүгийн гэмт хэргийн улмаас хоригдогсдоос тусад нь байрлуулах;

Насанд хүрээгүй хоригдлуудыг насанд хүрэгчдээс тусад нь байрлуулах.

### Дүрэм 12

1. Унтлагын байр нь тусдаа камер, өрөөнд байгаа бол хоригдол бүр шөнийн цагаар нэг камер, өрөөнд дангаар нь байна. Түр зуурын ачаалал гэх мэт онцгой шалтгааны улмаас хорих ангийн төв захиргаа энэ дүрэмд үл хамаарах зүйл хийх шаардлагатай бол хоёр хоригдлыг камер, өрөөнд байлгах нь зохимжгүй юм.

2. Хэрэв дотуур байр ашиглаж байгаа бол эдгээр нөхцөлөөр бие биетэйгээ харилцахад тохиромжтой гэж сайтар сонгосон хоригдлуудыг байрлуулах ёстой. Хорих ангийн онцлогт тохируулан шөнийн цагаар байнгын хяналттай байх ёстой.

### Дүрэм 13

Хоригдлуудад зориулсан бүх орон байр, ялангуяа унтлагын өрөө нь цаг уурын нөхцөл, өрөөний багтаамж, байх ёстой хамгийн бага талбай, гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалтыг зохих ёсоор харгалзан эрүүл мэндийн бүх шаардлагыг хангасан байна.

### Дүрэм 14

Хоригдлууд амьдрах, ажиллах ёстой бүх газарт:

(а) Цонхнууд нь хоригдол байгалийн гэрэлд ном унших, ажиллах боломжтой байхуйц том хэмжээтэй байх ба хиймэл агааржуулалттай эсэхээс үл хамааран цэвэр агаар нэвтрэх боломжтой байхаар хийгдсэн байх;

(б) Хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлуудын хараанд гэмтэл учруулахгүйгээр ном уншиж, ажиллах боломжтой байх ёстой.

### Дүрэм 15

Ариун цэврийн байгууламж нь хоригдол бүрийг шаардлагатай үед жам ёсны хэрэгцээгээ хангах, цэвэр, зохистой нөхцөл байдлаар хангагдсан байх ёстой.

### Дүрэм 16

Хоригдол бүрийг цаг уурын нөхцөлд тохирсон температурт, улирал, газарзүйн бүсээс хамааран ерөнхий эрүүл ахуйн шаардлага хангасан давтамжаар,

харин сэрүүн уур амьсгалтай газар долоо хоногт ядаж нэг удаа усанд ороход тохиромжтой халуун усны төхөөрөмжөөр хангана.

#### Дүрэм 17

Хоригдлуудын тогтмол ашигладаг хорих ангийн бүх хэсгийг зохих ёсоор нь арчилж, үргэлж цэвэр байлгана.

#### **Хувийн ариун цэвэр**

#### Дүрэм 18

1. Хоригдлууд ариун цэврээ сахих ёстой бөгөөд үүний тулд эрүүл мэнд, ариун цэврээ сахихад шаардлагатай ус, ариун цэврийн хэрэгслээр хангагдана.

2. Хоригдлууд өөрсдийнхөө хүндэтгэлд нийцсэн сайхан дүр төрхийг хадгалахын тулд үс, сахлаа зохих ёсоор арчлах, эрэгтэйчүүд сахлаа тогтмол хусч байх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Хувцас, ор дэрний цагаан хэрэглэл

#### Дүрэм 19

1. Өөрийнхөө хувцсыг өмсөхийг хориглосон хоригдол бүрийг цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл мэндээ хангалттай хамгаалахад тохирох хувцсаар хангана. Ийм хувцас нь хүний нэр төрийг гутааж, доромжилсон шинжтэй байх ёсгүй.

2. Бүх хувцас цэвэр, зохих хэмжээгээр чанартай байх ёстой. Эрүүл ахуйг сахихын тулд дотуур хувцасыг шаардлагатай бол олон удаа сольж, угаадаг байх ёстой.

3. Онцгой тохиолдолд хоригдлуудыг хорих ангиас гадагш зөвшөөрөлтэй авч явахад түүнд өөрийн хувцас болон бусдад үл анзаарагдам хувцас өмсөхийг зөвшөөрөх ёстой.

#### Дүрэм 20

Хэрэв хоригдлуудад өөрсдийн хувцсыг өмсөхийг зөвшөөрвөл хорих ангид ороход нь цэвэрхэн, өмсөхөд тохиромжтой эсэхийг шалгах арга хэмжээ авах ёстой.

#### Дүрэм 21

Хоригдол бүр орон нутгийн болон үндэсний стандартын дагуу тусдаа ор, тусдаа, хүртээмжтэй, цэвэр ор дэрний цагаан хэрэгслээр хангагдах ёстой, эмх цэгцтэй, цэвэр байдлыг хадгалж ор дэрний цагаан хэрэгслийг тогтмол солино.

#### Дүрэм 22

1. Хорих ангийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдол бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалагдахад хангалттай тэжээллэг, сайн чанарын, сайтар бэлтгэж боловсруулсан хоолоор хангана.

2. Хоригдол бүр шаардлагатай үедээ ундны усаар хангагдах боломжтой байх ёстой.

## **Дасгал хөдөлгөөн**

### **Дүрэм 23**

1. Гадаа хөдөлмөр эрхлээгүй хоригдол бүр цаг агаар таатай байх өдөрт дор хаяж нэг цаг задгай агаарт тохиромжтой дасгал хөдөлгөөн хийх ёстой.

2. Залуу хоригдлууд болон ижил нас, бие бялдартай бусад хүмүүс дасгал сургуулилтын үеэр бие бялдрын болон чийрэгжүүлэх дасгалд хамрагдана. Үүний тулд байр, байгууламж, тоног төхөөрөмжөөр хангасан байх ёстой.

## **Эрүүл мэндийн үйлчилгээ**

### **Дүрэм 24**

1. Хоригдлуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг юм. Хоригдлууд нийгэмд байдаг эрүүл мэндийн стандартыг эдлэх ёстой бөгөөд эрх зүйн байдлаасаа үл хамааран ялгаварлалгүйгээр шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах ёстой.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн ерөнхий газартай нягт уялдаатай, ХДХВ, сүрьеэ болон бусад халдварт өвчин, түүнчлэн хар тамхины донтолын эсрэг эмчилгээ, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахуйц байдлаар зохион байгуулах ёстой.

### **Дүрэм 25**

1. Хорих анги бүр хоригдлын бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийг үнэлэх, дэмжих, хамгаалах, сайжруулах, эрүүл мэндийн онцгой хэрэгцээтэй, эсвэл нөхөн сэргээхэд саад болж буй эрүүл мэндийн асуудалтай хоригдлуудад онцгой анхаарал хандуулах үүрэг бүхий эрүүл мэндийн үйлчилгээтэй байна.

2. Эрүүл мэндийн үйлчилгээ нь эмнэлзүйн хувьд бүрэн бие даасан байдлаар ажилладаг, хангалттай мэргэшсэн боловсон хүчин бүхий салбар дундын багаас бүрдэх бөгөөд сэтгэл судлал, сэтгэцийн эмгэг судлалын чиглэлээр хангалттай мэргэшсэн байх ёстой. Мэргэшсэн шүдний эмчийн үйлчилгээ нь хоригдол бүрт хүртээмжтэй байх ёстой.

### **Дүрэм 26**

1. Эрүүл мэндийн алба нь бүх хоригдлуудын эрүүл мэндийн бүртгэлийг үнэн зөв, нууцлалтайгаар боловсруулж, хөтөлж, шинэчилж, хүсэлт гаргасан бүх хоригдолд бүртгэлтэйгээ танилцах боломжоор хангана. Хоригдол нь өөрийн эрүүл мэндийн бүртгэлтэй танилцах зорилгоор гуравдагч этгээдийг томилж болно.

2. Эмнэлгийн бүртгэлийг хоригдлыг шилжүүлсний дараа хүлээн авагч байгууллагын эрүүл мэндийн үйлчилгээнд шилжүүлэх бөгөөд эмнэлгийн нууцад хамаарна.

### **Дүрэм 27**

1. Бүх хорих ангиуд яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламж авах боломжийг бүрдүүлнэ. Нарийн мэргэжлийн эмчилгээ, мэс засал хийлгэх шаардлагатай хоригдлуудыг төрөлжсөн байгууллага, иргэний эмнэлэгт шилжүүлнэ. Хорих анги нь өөрийн гэсэн эмнэлгийн тоног төхөөрөмжтэй бол өөрт нь шилжүүлсэн

хоригдлуудад зохих эмчилгээ, тусламж үзүүлэхийн тулд зохих боловсон хүчин, тоног төхөөрөмжтэй байна.

2. Эмнэлзүйн шийдвэрийг зөвхөн хариуцлагатай эрүүл мэндийн мэргэжилтнүүд гаргаж болох бөгөөд эмнэлгийн бус хорих ангийн ажилтнууд үүнийг үгүйсгэж, үл тоомсорлож болохгүй.

#### Дүрэм 28

Эмэгтэйчүүдийн хорих ангид төрөхийн өмнөх болон төрсний дараах үеийн бүх шаардлагатай тусламж, эмчилгээ хийх тусгай байртай байна. Боломжтой бол нярайг хорих ангийн гаднах эмнэлэгт төрүүлэх зохицуулалт хийх хэрэгтэй. Хэрэв хүүхэд хорих ангид төрсөн бол төрсний гэрчилгээнд энэ баримтыг тусгаж болохгүй.

#### Дүрэм 29

1. Хүүхдийг эцэг, эхтэйгээ хорих ангид байлгах шийдвэр гаргахдаа тухайн хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан үзнэ. Хэрвээ хүүхдүүд эцэг эхтэйгээ хорих ангид үлдэхийг зөвшөөрсөн тохиолдолд дараах зүйлийг хангана:

(а) Эцэг эхийнхээ асрамжид байхгүй үед хүүхдүүдийг байрлуулах, мэргэшсэн ажилтан ажилладаг дотоод болон гадаад асрамжийн газрууд;

(б) Хүүхдийг хүлээж авсны дараа хийх эрүүл мэндийн үзлэг, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүүхдийн хөгжилд тавих мэргэжилтний хараа хяналт.

2. Эцэг эхтэйгээ хорих ангид хамт байрлаж байгаа хүүхдийг хэзээ ч хоригдол гэж үзэж болохгүй.

#### Дүрэм 30

Эмч болон бусад мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтнүүд эмчдээ тайлагнах шаардлагатай эсэхээс үл хамааран хоригдол бүрийг хүлээн авсны дараа болон шаардлага гарсан үед тэр даруй ярилцаж, үзлэг хийнэ. Дараах зүйлсийг онцгой анхаарна:

(а) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, эмчилгээнд шаардлагатай бүх арга хэмжээг авах;

(б) Хоригдлуудыг хүлээн авахдаа хорих ангид ирэхээсээ өмнө зүй бус харьцаанд өртсөн байж болзошгүй аливаа хүчирхийллийн ул мөр бий эсэхийг илрүүлэх;

(в) Хорих ялаас үүдэлтэй сэтгэл зүйн болон бусад стрессийн шинж тэмдэг, түүний дотор амиа хорлох, өөрийгөө гэмтээх эрсдэл, мансууруулах бодис, эм, согтууруулах ундаа хэрэглэснээс үүдэн гарах шинж тэмдгүүдийг илрүүлэх; мөн хувь хүнд тохирсон зохих арга хэмжээ авах эсхүл эмчлэх;

(г) Хоригдлууд халдварт өвчтэй гэж сэжиглэгдсэн тохиолдолд тэдгээр хоригдлуудыг халдварт өвчний үед эмнэлзүйн тусгаарлалт, зохих эмчилгээ хийх;

(д) Хоригдлуудын хөдөлмөр эрхлэх, дасгал хөдөлгөөн хийх болон бусад үйл ажиллагаанд ёсоор оролцох чадамжийг тодорхойлох.

### Дүрэм 31

Эмч эсвэл шаардлагатай бол эрүүл мэндийн бусад мэргэшсэн мэргэжилтнүүд өвчтэй бүх хоригдол, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, гэмтлийн талаар гомдол гаргасан хоригдол нэг бүр, онцгой анхаарал шаарддаг аливаа хоригдолтой өдөр бүр уулзах боломжтой байх ёстой. Эмнэлгийн бүх үзлэгийг бүрэн нууцлалтайгаар явуулна.

### Дүрэм 32

1. Эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, хоригдол хоёрын харилцааг нийгэмд байгаа өвчтөнүүдэд мөрддөг ёс зүй, мэргэжлийн хэм хэмжээгээр зохицуулна, тухайлбал:

(а) Хоригдлуудын бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, зөвхөн эмнэлзүйн шинж тэмдгүүдийн үндсэн дээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үүрэг;

(б) Эмч, өвчтөний харилцаанд хоригдлуудын бие даасан байдлын зарчмыг хүндэтгэх, тэдний эрүүл мэндийн талаарх мэдээллийг зөвшөөрлийн үндсэн дээр авах;

(в) Ийм нууцыг хадгалах нь өвчтөн болон бусад хүмүүст бодит бөгөөд шууд аюул учруулахгүй бол эмнэлгийн мэдээллийн нууцлал байх болно;

(г) Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж байж болзошгүй үйлдэл, тэр дундаа хоригдлын эд эрхтнийг авах зэрэг хоригдлын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтыг идэвхтэй болон идэвхгүй байдлаар хийхийг туйлын хориглоно.

2. Энэ дүрмийн 1 (г)-д харшлахгүйгээр хоригдлууд өөрсдийнхөө эрүүл мэндэд шууд бөгөөд чухал ач холбогдолтой гэж үзвэл эмнэлзүйн туршилт болон бусад эрүүл мэндийн судалгаанд оролцох, мөн төрөл төрөгсдөдөө эс, биеийн эд, эрхтнийг хандивлахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрч болно.

### Дүрэм 33

Эмч нь хорих ялыг үргэлжлүүлэн эдлэх, эсхүл хорих ялын аливаа нөхцөл байдал нь хоригдлын бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд хор хөнөөл учруулсан буюу учруулах болно гэж үзвэл хорих ангийн даргад мэдэгдэнэ.

### Дүрэм 34

Эмнэлгийн ажилтнууд хоригдлыг эмнэлэгт хэвтүүлэх, түүнд эмнэлгийн тусламж үзүүлэх явцад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэсэн шинж тэмдэг илэрвэл тэдгээр тохиолдлыг баримтжуулж, эмнэлгийн, захиргааны болон шүүхийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой. Хоригдлууд болон түүнтэй холбоотой хүмүүсийг урьдчилан таамаглаж болохуйц хохирол учруулахгүйн тулд зохих процессыг дагаж мөрдөх ёстой.

### Дүрэм 35

1. Эмч, эрүүл мэндийн эрх бүхий байгууллага нь хорих ангийн даргад дараах зүйлийг тогтмол шалгаж, зөвлөгөө өгнө.

- (а) Хоолны хэмжээ, чанар, бэлтгэх явц, үйлчилгээ;
- (б) Байгууламж, хоригдлуудын эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдал;
- (в) Хорих ангийн ариун цэврийн байгууламж, температур, гэрэлтүүлэг, агааржуулалт;
- (г) Хоригдлуудын хувцас, ор дэрний цагаан хэрэглэл тохиромжтой, цэвэр буй эсэх;
- д) Техник арга зүйн ажилтан байхгүй тохиолдолд биеийн тамир, спорттой холбоотой дүрэм, журам дагаж мөрдөх.

2. Хорих ангийн дарга энэ дүрмийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өгсөн зөвлөгөө, тайланг анхааралдаа авч, тайланд тусгагдсан зөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг нэн даруй авна. Зөвлөмж, зөвлөгөө нь хорих ангийн даргын бүрэн эрхэд хамаарахгүй, эсхүл түүнтэй санал нийлэхгүй байгаа бол дарга өөрийн тайлан, эмч, эрүүл мэндийн байгууллагын зөвлөгөө, зөвлөмжийг дээд байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

### **Тусгаарлах арга хэмжээ, сахилгын шийтгэл**

#### **Дүрэм 36**

Сахилга, дэг журам сахиулах ажиллагааг аюулгүй байдлыг хангах, хорих ангийн аюулгүй ажиллагаа, нийтийг дэг журамтай байлгахад шаардагдахаас илүү хязгаарлалтгүйгээр хадгална.

#### **Дүрэм 37**

Дараах зүйлс нь ямагт хууль, эсвэл эрх бүхий захиргааны байгууллагын журмаар зөвшөөрөгдсөн байх ёстой.

- (а) Сахилгын зөрчилд тооцсон зан үйл;
- (б) Ногдуулж болох шийтгэлийн төрөл, хугацаа;
- (в) Энэ төрлийн шийтгэл ногдуулах эрх бүхий байгууллага;

(г) Сахилгын шийтгэл, дэг журам, аюулгүй байдлыг хангах зорилгоор ганцаарчлан хорих, тусгаарлах, тусгай тусламж үйлчилгээний нэгж, тусгаарлах байр гэх мэт нийт хорих ангиас албадан тусгаарлах аливаа хэлбэрийн арга хэмжээг авахад чиглэсэн бодлого, журмыг хэрэглэх, албадан тусгаарлах аливаа хэлбэрийг ашиглах, хянах, хүлээн авах, гаргах.

#### **Дүрэм 38**

1. Хорих ангийн удирдлагуудыг сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг шийдвэрлэхийн тулд аль болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эвлэрүүлэн зуучлах болон маргаан шийдвэрлэх бусад механизмыг ашиглах нь зүйтэй.

2. Хорих ангийн удирдлагууд тусгаарлах арга хэмжээ авагдаж байсан хоригдлыг суллахдаа түүний өмнө тусгаарлагдаж байсан байдлын өөрт нь болон нийгэмд үзүүлж болзошгүй үр дагаврыг багасгахын тулд шаардлагатай арга хэмжээг авах ёстой.



### Дүрэм 39

1. Хуульд зааснаас болон энэхүү дүрмийн 37-д дурдсан зохицуулалт, шударга ёсны зохих зарчмаас бусад тохиолдолд ямар ч хоригдол шийтгэл хүлээх ёсгүй. Хоригдлуудыг нэг үйлдэл, гэмт хэргийн төлөө хоёр удаа шийтгэж болохгүй.

2. Хорих ангийн захиргаа нь сахилгын шийтгэл болон түүний үйлдсэн гэмт хэргийн хоорондын пропорциональ байдлыг хангаж, ногдуулсан бүх сахилгын шийтгэлийн талаар зохих бүртгэл хөтөлнө.

3. Сахилгын шийтгэл оногдуулахын өмнө хорих ангийн удирдлагууд ялтны сэтгэцийн эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй нь түүний зан авир, гэмт хэрэг үйлдэхэд хэрхэн нөлөөлсөн эсэх, эсвэл сахилгын шийтгэлийн үндсэн дээр үйлдэл хийсэн эсэхийг авч үзэх ёстой. Хорих ангийн удирдлагууд хоригдлын сэтгэцийн эмгэг, сэтгэцийн хомсдолтой шууд холбоотой гэж үзсэн аливаа зан үйлийг шийтгэх ёсгүй.

### Дүрэм 40

1. Ямар ч хоригдлыг хорих ангийн сахилгын албан тушаал эдлүүлэх албан тушаалд ажиллуулахыг хориглоно.

2. Гэсэн хэдий ч энэ дүрэм нь нийгэм, боловсролын болон спортын тодорхой үйл ажиллагааг хариуцах, эмчилгээний зорилгоор бүлэг болгон нэггэсэн хоригдлуудыг хянах зэрэг өөрийгөө удирдахад суурилсан тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах ёсгүй.

### Дүрэм 41

1. Хоригдол сахилгын гэмт хэрэг үйлдсэн тухай аливаа эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх бөгөөд түүнийг цаг алдалгүй шалгана.

2. Хоригдлуудад өөрсдөд нь тулгаж байгаа ялын мөн чанарын талаар тэдний ойлгох хэлээр, цаг алдалгүй мэдэгдэж, өмгөөллийг бэлтгэл ажилд нь хангалттай цаг хугацаа, боломжийг олгоно.

3. Шударга ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн үед, ялангуяа ноцтой сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд хоригдлууд биечлэн эсвэл өмгөөлөгчөөр дамжуулан өөрийгөө хамгаалах боломжоор хангагдах ёстой. Хэрэв хоригдлууд сахилгын шүүх хуралдаанд ашигласан хэлийг ойлгодоггүй, ярьдаггүй бол үнэ төлбөргүй, чадварлаг орчуулагчаар хангах ёстой.

4. Хоригдлууд өөрт оногдуулсан сахилгын шийтгэлийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжтой.

5. Сахилгын зөрчлийг гэмт хэрэгт тооцсон тохиолдолд ялтнуудад хуулийн зөвлөхтэй саадгүй хандах зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хамаарах бүх шатны баталгааг эдлэх эрхтэй.

### Дүрэм 42

Гэрэлтүүлэг, агааржуулалт, температур, ариун цэврийн байгууламж, хоол тэжээл, ундны ус, задгай агаарт гарах, биеийн тамирын дасгал хийх, хувийн ариун цэврийг сахих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хувийн орон зай зэрэгтэй холбоотой амьдралын ерөнхий нөхцөл нь бүх хоригдлуудад хамаарна.

#### Дүрэм 43

1. Ямар ч тохиолдолд хязгаарлалт, сахилгын шийтгэл нь эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхтэй адил байж болохгүй. Ялангуяа дараах үйлдлүүдийг хориглоно.

- (а) Хугацаагүй ганцаарчлан хорих;
- (б) удаан хугацаагаар ганцаарчлан хорих;
- (в) Хоригдлуудыг харанхуй эсвэл байнга гэрэлтэй өрөөнд байрлуулах;
- (г) Бие махбодын шийтгэл эдлүүлэх, эсвэл хоригдлын хоолны дэглэм, ундны усыг багасгах;
- (е) Хамтын шийтгэл.

2. Таслан сэргийлэх арга хэмжээг сахилгын зөрчлийн шийтгэл болгон хэзээ ч хэрэглэж болохгүй.

3. Сахилгын шийтгэл, хязгаарлах арга хэмжээнд гэр бүлийнхэнтэйгээ харилцахыг хориглохыг хориглоно. Гэр бүлийн харилцаа холбоог зөвхөн тодорхой хугацаагаар хязгаарлаж, аюулгүй байдал, дэг журмыг сахиулахын тулд хатуу шаардлагын дагуу хязгаарлаж болно.

#### Дүрэм 44

Эдгээр дүрмийн зорилгын үүднээс ганцаарчлан хорих гэж хоригдлуудыг өдөрт 22 цаг ба түүнээс дээш хугацаагаар хүнтэй харьцахгүйгээр хорихыг хэлнэ. Уртасгасан хорионд байх нь дараалсан 15 хоногоос дээш хугацаагаар ганцаарчлан хорихыг хэлнэ.

#### Дүрэм 45

1. Ганцаарчлан хорих ялыг зөвхөн онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгон, аль болох богино хугацаанд, хараат бусаар хянуулж, зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ. Ганцаарчлан хорихыг хоригдолд оноох ял хэлбэрээр оногдуулах ёсгүй.

2. Сэтгэцийн болон бие бялдрын хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын нөхцөл байдал ийм арга хэмжээ авснаар улам дорддог тохиолдолд ганцаарчлан хорихыг хориглох ёстой. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн эрх зүйн байдлын талаарх бусад стандарт, хэм хэмжээнд дурдсанчлан эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй холбоотой хэрэгт ганцаарчлан хорих болон түүнтэй адилтгах арга хэмжээ хэрэглэхийг хориглосон заалт хэвээрээ байна.

#### Дүрэм 46

1. Эрүүл мэндийн ажилтнууд сахилгын шийтгэл ногдуулах, хязгаарлах бусад арга хэмжээ авахад ямар ч үүрэг хүлээх ёсгүй. Гэсэн хэдий ч тэд албадан тусгаарлах аливаа хэлбэрээр хоригдож буй хоригдлуудын эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулж, эдгээр хоригдлуудтай өдөр бүр очиж уулзах, тэдгээр хоригдол, хорих ангийн ажилтнуудын хүсэлтээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ёстой.

2. Эрүүл мэндийн ажилтнууд ийм шийтгэл, арга хэмжээ авсан хоригдлын бие болон сэтгэцийн эрүүл мэндэд сахилгын шийтгэл болон бусад хязгаарлах арга

хэмжээний сөрөг нөлөөллийн талаар хорих ангийн даргад цаг алдалгүй мэдээлж, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаанаар түүнийг цуцлах, өөрчлөх шаардлагатай гэж үзвэл даргад мэдэгдэнэ.

3. Эрүүл мэндийн ажилтнууд хоригдлын эрүүл мэндийн байдал, сэтгэцийн болон бие махбодийн хөгжлийн бэрхшээлийг хүндрүүлэхгүй байх үүднээс хоригдлыг албадан тусгаарлах асуудлыг хянан үзэж, өөрчлөх санал гаргах эрхтэй.

### **Хязгаарлах арга хэрэгсэл**

#### **Дүрэм 47**

1. Хүний төрөлхөөс заяасан нэр төрийг доромжлох, бие маходын өвдөлт мэдрүүлдэг төмөр гав, гинж болон бусад хязгаарлах хэрэгслийг ашиглахыг хориглоно.

2. Бусад хязгаарлах арга хэрэгслийг зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн болон дараах нөхцөлд хэрэглэнэ.

(а) Шүүх болон захиргааны байгууллагад авчрах шилжүүлэн байрлуулалтын явцад оргон зайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор;

(б) Бусад аргууд үр дүнгүй бол хоригдол өөрийгөө болон бусдыг гэмтээх, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд хорих ангийн даргын тушаалаар; Ийм тохиолдолд хорих ангийн дарга нь эмч болон бусад мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд нэн даруй мэдэгдэж, дээд шатны захиргааны байгууллагад уламжилна.

#### **Дүрэм 48**

1. Дүрмийн 47 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хязгаарлах арга хэрэгсэл хэрэглэхийг зөвшөөрсөн тохиолдолд дараах зарчмыг баримтална.

(а) Хязгаарлагдмал хөдөлгөөнөөс үүсэх эрсдэлийг арилгахад багагүй хяналтын хэлбэр үр дүнтэй байх үед л хязгаарлалтын хэрэгслийг ногдуулна;

(б) Хязгаарлах арга нь учирч буй эрсдлийн түвшин, шинж чанарт үндэслэн хоригдлын хөдөлгөөнийг хянахад зайлшгүй шаардлагатай бөгөөд боломжийн хамгийн бага хөндлөнгийн арга байх ёстой;

(в) Хязгаарлалтгүй хөдөлгөөнтэй холбоотой эрсдлийг арилгахад илүү сул хяналтын хэлбэр нь үр дүнгүй тохиолдолд л хязгаарлалтын арга хэрэгслийг ашиглах ёстой;

2. Хөдөлмөр эрхлэлтийн үед, хүүхэд төрүүлэх үед болон төрсний дараа шууд хязгаарлах арга хэрэгслийг эмэгтэйчүүдэд хэзээ ч хэрэглэж болохгүй.

#### **Дүрэм 49**

Хорих ангийн захиргаа хязгаарлах арга хэмжээ авах хэрэгцээг арилгах эсвэл арга хэмжээ авахад хүргэх хөндлөнгийн оролцоог багасгах хяналтын арга техникийг ашиглах боломжийг эрэлхийлж, сургалт явуулах ёстой.

## **Хоригдол болон өрөөн доторх нэгжлэг**

### Дүрэм 50

Хоригдлууд болон хорих ангиудад нэгжлэг хийх тухай хууль, зохицуулалт нь олон улсын эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэгт нийцсэн байх бөгөөд олон улсын стандарт, хэм хэмжээг харгалзан хорих байгууллагын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх ёстой. Нэгжлэгийн ажиллагааг тухайн хүний төрөлхийн нэр хүнд, хувийн нууцыг хүндэтгэн, пропорциональ, хууль ёсны, зайлшгүй байх зарчмуудыг баримтлан явуулна.

### Дүрэм 51

Хоригдлуудыг дарамтлах, айлган сүрдүүлэх, хувийн нууцад нь шаардлагагүй халдах зорилгоор нэгжлэг хийж болохгүй. Хариуцлагатай байдлыг хангахын тулд хорих ангийн захиргаа нь нэгжлэг, тухайлбал, нүцгэн биеийн, биеийн хөндийн, амьдрах өрөөний нэгжлэг, түүнчлэн нэгжлэг хийсэн шалтгаан, нэгжлэг хийсэн албан хаагчид хэн болох, нэгжлэгийн үр дүнгийн зохих бүртгэлийг хөтлөх ёстой.

### Дүрэм 52

1. Нүцгэн биеийн болон биеийн хөндийн зэрэг интрузив нэгжлэгийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд л хийнэ. Хорих ангийн захиргаа интрузив нэгжлэгээс өөр бусад хувилбар боловсруулж ашиглахыг эрмэлзэх ёстой. Интрузив нэгжлэгийг хоригдолтой ижил хүйстний бэлтгэгдсэн ажилтнаар болон нууцаар явуулна.

2. Биеийн хөндийн үзлэгийг хоригдлыг хянах үндсэн үүрэгтэй ажилтнаас бусад зөвхөн эрүүл мэндийн мэргэшсэн мэргэжилтэн, наад зах нь эрүүл ахуй, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартын талаар зохих ёсоор бэлтгэгдсэн ажилтнууд ажилтнууд явуулна.

### Дүрэм 53

Хоригдлууд тэдний шүүх ажиллагаатай холбоотой бичиг баримттай танилцах, эсхүл хорих ангийн захиргаанд өгөхгүйгээр өөрийнхөө эзэмшилд хадгалахыг зөвшөөрөх ёстой.

## **Хоригдлуудад өгөх мэдээлэл, хоригдлын гомдол**

### Дүрэм 54

Хүлээн авсан даруйд хоригдол бүрд дараах мэдээллийг бичгээр өгнө:

(а) Хорих ангийн дүрэм журам;

(б) Мэдээлэл хайх, хууль зүйн зөвлөгөө авах эрх, түүний дотор хууль зүйн туслалцааны тогтолцоогоор дамжуулан авах эрх, хүсэлт, гомдол гаргах журам зэрэг хоригдолд хамаарах эрх;

(в) Сахилгын шийтгэл зэрэг хоригдлын үүрэг хариуцлага; болон

(г) Хорих ангийн амьдралд дасан зохицоход шаардлагатай хоригдолд хамаарах бусад бүх асуудал.

## Дүрэм 55

1. Дүрэм 54-д дурдсан мэдээллийг нийт хоригдлын хэрэгцээнд нийцүүлэн хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлээр гаргах ёстой. Хэрэв хоригдол эдгээр хэлний аль нэгийг нь ойлгохгүй байвал орчуулгын тусламж үзүүлнэ.

2. Хоригдол бичиг үсэг тайлагдаагүй бол энэ тухай түүнд амаар дамжуулна. Мэдрэхүйн бэрхшээлтэй хоригдлууд хэрэгцээнд нь тохирсон мэдээллээр хангагдах ёстой.

3. Хорих ангийн захиргаа тухайн хорих ангийн нийтийн эзэмшлийн талбайд мэдээллийн хураангуйг ил тод байрлуулна.

## Дүрэм 56

1. Хоригдол бүр хорих ангийн захирагч эсвэл түүнийг төлөөлөх эрх бүхий хорих ангийн ажилтанд өдөр бүр хүсэлт, гомдол гаргах боломжтой байх ёстой.

2. Хорих ангийн байцаагч хяналт шалгалт хийх явцад түүнд хүсэлт, гомдол гаргах боломжтой байна. Хоригдол нь байцаагч болон хянагчидтай дарга болон бусад ажилтнуудыг байлцуулахгүйгээр чөлөөтэй, бүрэн нууцлалтайгаар ярилцах боломжтой байна.

3. Хоригдол бүр өөртэй нь хэрхэн харьцаж байгаатай холбоотой хүсэлт, гомдлыг мөн чанарын хувьд цензургүйгээр хорих байгууллагын төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад, тэр дундаа хянан шийдвэрлэх, нөхөн сэргээх эрх бүхий байгууллагад гаргахыг зөвшөөрнө.

4. Энэ дүрмийн 1-3 дахь хэсэгт заасан эрх нь хоригдлын хуулийн зөвлөхөд хамаарна. Хоригдол болон түүний хуулийн зөвлөхийн аль нь ч ийм эрхийг эдлэх боломжгүй тохиолдолд түүний гэр бүлийн гишүүн болон хэргийн талаар мэддэг бусад хүн эдлэх боломжтой.

## Дүрэм 57

1. Өргөдөл, гомдол бүрийг шуурхай шийдвэрлэж, цаг алдалгүй хариу өгөх ёстой. Хүсэлт, гомдлыг хүлээн авахаас татгалзсан эсвэл үндэслэлгүйгээр хойшлуулсан тохиолдолд өргөдөл гаргагч нь шүүх болон бусад байгууллагад давж заалдах эрхтэй.

2. Хоригдлууд хүсэлт, гомдлоо аюулгүй гаргаж, гомдол гаргагчийн хүсэлтээр нууцлалтайгаар гаргах боломжийг хангах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дүрмийн 56-р зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан хоригдол болон бусад хүн хүсэлт, гомдол гаргасны үр дүнд өс хонзон авах, айлган сүрдүүлэх болон бусад сөрөг үр дагаварт өртөх ёсгүй.

3. Хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэсэн тухай гомдлыг нэн даруй шийдвэрлэж, 71 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу бие даасан үндэсний эрх бүхий байгууллага шуурхай, шударга мөрдөн байцаалт явуулна.

## Гадаад ертөнцтэй харилцах

### Дүрэм 58

1. Хоригдлууд шаардлагатай хяналт дор гэр бүл, найз нөхөдтэйгээ тогтмол харилцахыг зөвшөөрнө:

(а) Бичгээр, боломжтой бол утсан холбоо, цахим, тоон болон бусад хэрэгслийг ашиглан харилцах;

(б) Биечлэн уулзах замаар.

2. Гэрлэсэн хостойгоо уулзах тохиолдолд энэ эрхийг ялгаварлахгүйгээр хэрэглэж, эмэгтэй хоригдлууд эрчүүдтэй адил эрхээ эдлэх боломжийг олгоно. Аюулгүй байдал, нэр төрийг зохих ёсоор харгалзан шударга, тэгш хүртээмжийг хангах журам, байгууламжууд байх ёстой.

### Дүрэм 59

Хоригдлуудыг боломжийн хэрээр гэртэйгээ ойр хорих ангид, эсхүл нийгэмшүүлэх газарт байрлуулна.

### Дүрэм 60

1. Эргэлтээр очсон зочин өөрөө зөвшөөрсөн тохиолдолд нэгжлэг хийж хорих ангид нэвтрүүлнэ. Зочин хүссэн үедээ зөвшөөрлөө цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд хорих ангийн захиргаа нэвтрэхээс татгалзаж болно.

2. Зочдод нэгжлэг хийх, нэвтрүүлэх журам нь хүний нэр төрийг доромжлох шинжтэй байх ёсгүй бөгөөд 50-52 дугаар дүрмийн дагуу хамгаалалтын зарчмыг баримтална. Биеийн хөндийгөөр нэгжлэг хийхээс зайлсхийх ба хүүхдэд хэрэглэхгүй байх ёстой.

### Дүрэм 61

1. Холбогдох дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль зүйн аливаа асуудлаар цаг алдалгүй, хөндлөнгөөс оролцох, цензургүй, бүрэн нууцлалтайгаар өөрийн сонгосон хуулийн зөвлөх эсвэл хууль зүйн туслалцаа үзүүлэгчидтэй уулзаж, харилцах, зөвлөлдөх хангалттай боломж, цаг, нөхцөлөөр хоригдлуудыг хангана. Энэхүү уулзалтыг хорих ангийн ажилтнуудын нүдэн дээр хийж болох ба харин сонсох ёсгүй.

2. Хоригдлууд орон нутгийн хэлээр ярьдаггүй тохиолдолд хорих ангийн удирдлагууд бие даасан, чадварлаг орчуулагчтай байх боломжийг хангах ёстой.

3. Хоригдлууд үр дүнтэй хууль зүйн туслалцаа авах боломжтой байх ёстой.

### Дүрэм 62

1. Гадаадын иргэн хоригдлууд харьяат улсынхаа дипломат болон консулын төлөөлөгчтэй харилцах боломжоор хангагдана.

2. Тус улсад дипломат болон консулын төлөөлөгчийн газаргүй улсын харьяат хоригдлууд, түүнчлэн дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүст тэдний эрх ашгийг хамгаалдаг улсын дипломат төлөөлөгч, эсхүл эдгээр хүмүүсийг хамгаалах үүрэг хүлээсэн үндэсний болон олон улсын байгууллагатай харилцах ижил төстэй боломжийг олгох ёстой.



## Дүрэм 63

Сонин, тогтмол хэвлэл эсвэл байгууллагын тусгай хэвлэл унших, радио нэвтрүүлэг, лекц сонсох, хорих ангийн захиргаанаас зөвшөөрөгдсөн эсвэл хяналтад байдаг бусад ижил төстэй хэрэгслээр хоригдлууд хамгийн чухал мэдээний талаар тогтмол мэдээлэл авах ёстой.

### Ном

## Дүрэм 64

Хорих анги бүр бүх ангиллын хоригдлуудад зориулсан номын сантай байх ёстой бөгөөд чөлөөт цагаа өнгөрөөх, сурган хүмүүжүүлэх ном зохиолоор хангалттай хангагдсан байх, хоригдлууд үүнийг бүрэн ашиглахыг дэмжих ёстой.

### Шашин

## Дүрэм 65

1. Хорих ангид нэг шашны хангалттай тооны хоригдол байгаа бол тухайн шашны итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, баталгаажуулна. Хэрэв хоригдлуудын ихэнх үүнийг хүлээн зөвшөөрвөл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь бүтэн цагаар ажиллана.

2. Энэ дүрмийн 1 дэх хэсэгт заасны дагуу томилогдсон, эсхүл батлагдсан итгэмжлэгдсэн төлөөлөгч тогтмол үйл ажиллагаа явуулах, тохиромжтой цагт өөрийн шашны хоригдолд тусад нь шашны зан үйлдэхийг зөвшөөрнө.

3. Ямар ч хоригдолд аливаа шашны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзахыг хориглож болохгүй. Нөгөөтэйгүүр, аливаа хоригдол шашны төлөөлөгчтэй уулзахыг эсэргүүцэж байвал түүний байр суурийг бүрэн хүндэтгэх ёстой.

## Дүрэм 66

Хоригдол бүрийг хорих ангид өөрийн шашны зан үйлийн сургаал номыг хувьдаа эзэмшиж, шашны зан үйлд хамрагдах зэргээр шашны амьдралынхаа хэрэгцээг хангах боломжоор аль болох хангах ёстой.

### Хоригдлуудын эд хөрөнгийг хадгалах

## Дүрэм 67

1. Хорих ангийн дүрэм журмын дагуу хоригдлын өөртөө хадгалахыг хориглосон бүх мөнгө, үнэт зүйл, хувцас болон бусад зүйлийг хорих ангид анх ирэхэд нь аюулгүй газар хадгална. Эд зүйлсийн бүртгэлд хоригдол гарын үсэг зурсан байх ёстой. Эд зүйлсийг сайн нөхцөлд хадгалах арга хэмжээ авна.

2. Хоригдол суллагдсаны дараа түүнд мөнгө зарцуулах, ийм эд хөрөнгийг хорих ангиас гадагш гаргахыг зөвшөөрөөгүй, эсхүл эрүүл ахуйн шалтгаанаар хувцасны аль нэг хэсгийг устгах шаардлагатай гэж тогтоогдоогүй бол бүх эд зүйл, мөнгийг түүнд буцаан олгоно. Хоригдол өөрт нь буцааж өгсөн эд зүйл, мөнгө авсан баримт дээр гарын үсэг зурах ёстой.

3. Хоригдлуудад гаднаас ирсэн мөнгө, эд зүйлд ч мөн адил үйлчилнэ.

4. Хэрэв хоригдол ямар нэгэн эм, эмнэлгийн хэрэгсэл авчирвал тэдгээрийг хэрхэн хэрэглэхийг эмч эсвэл бусад мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтэн тодорхойлох ёстой.

## **Мэдэгдэл**

### Дүрэм 68

Хоригдол бүр хорих ял, өөр ангид шилжсэн, хүнд өвчин туссан, гэмтсэн тухайгаа гэр бүлийнхэн болон холбогдох этгээдээр томилогдсон бусад хүнд нэн даруй мэдэгдэх эрхтэй бөгөөд ийм боломж, хэрэгслээр хангана. Хоригдлуудын хувийн мэдээллийг хуваалцах нь дотоодын хууль тогтоомжийн дагуу явагдана.

### Дүрэм 69

Хоригдол нас барсан тохиолдолд хорих ангийн дарга энэ тухай түүний ойр дотны хүмүүс эсвэл яаралтай холбоо барих хүмүүст нэн даруй мэдэгдэнэ. Хоригдлуудын эрүүл мэндийн мэдээллийг авахаар томилсон хүмүүст ялтны хүнд өвчин, гэмтэл, эрүүл мэндийн байгууллагад шилжсэн тухай дарга мэдэгдэнэ. Хоригдол өвдөж гэмтсэн тохиолдолд эхнэр, нөхөр, ойрын хамаатан садандаа мэдэгдэхгүй байх тухай тодорхой хүсэлтийг хүндэтгэн үзнэ.

### Дүрэм 70

Хорих ангийн удирдлагууд хоригдолд ойрын хамаатан садан эсвэл бусад чухал хүнд өвчтэй, нас барсан тухай нэн даруй мэдэгдэх ёстой. Нөхцөл байдал зөвшөөрвөл хоригдол нь ганцаар эсхүл дагалдан хүний хамт хүнд өвчтэй төрөл төрөгсөд болон бусад ойр дотны хүн дээр очих, төрөл төрөгсөд болон бусад ойр дотны хүний оршуулгад оролцохыг зөвшөөрнө.

## **Хяналт шалгалтын ажиллагаа**

### Дүрэм 71

1. Дотоодын хяналт шалгалтын ажиллагаа эхэлснээс үл хамааран хорих ангийн дарга хоригдож байхдаа нас барсан, сураггүй алга болсон, хүнд гэмтсэн тохиолдолд тухайн хорих газраас хараат бус, тухайн хэргийн нөхцөл байдал, шалтгааныг шуурхай, шударга, үр дүнтэй мөрдөн шалгах эрх бүхий шүүх болон бусад эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх ёстой. Хорих ангийн удирдлагууд энэ байгууллагатай бүрэн хамтран ажиллаж, бүх нотлох баримтыг хадгалах ёстой.

2. Албан ёсны гомдол ирсэн эсэхээс үл хамааран хорих ангид эрүү шүүлт тулгасан болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн гэж үзэх үндэслэлтэй байвал энэ дүрмийн 1 дэх хэсэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.

3. Энэ дүрмийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг хийсэн гэж үзэх үндэслэлтэй байгаа тохиолдолд хэрэгт холбогдсон байж болзошгүй бүх хүмүүсийг хяналт шалгалтад оролцуулахгүй байх, гэрч, хохирогч, хохирогчийн ар гэрийнхэнтэй холбоо тогтоохгүй байх арга хэмжээг нэн даруй авна.

### Дүрэм 72

Хорих ангийн захиргаа нас барсан хоригдлын биед хүндэтгэлтэй хандаж, харьцана. Нас барсан хоригдлын цогцсыг мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа аль болох богино хугацаанд төрөл төрөгсдөд нь хүлээлгэн өгнө. Хорих ангийн захиргаа нь оршуулах ёслолыг хийх хүсэлтэй, чадвартай өөр этгээд байхгүй тохиолдолд соёлын хувьд зохицсон оршуулгын ёслолыг зохион байгуулж, явцын талаар бүрэн тэмдэглэл хөтөлнө.

## **Хоригдлыг тээвэрлэх**

### **Дүрэм 73**

1. Хоригдлуудыг аль нэг байгууллагад шилжүүлэх юм уу тэндээс гаргах үед тэднийг аль болох олон нийтийн хараанд бага өртүүлэх, доромжлол, сониуч зан, аливаа хэлбэрээр сурталчлахаас хамгаалах зохих арга хэмжээг авна.

2. Хоригдлуудыг агааржуулалт, гэрэлтүүлэг муутай тээврийн хэрэгслээр, эсхүл бие махбодод шаардлагагүй дарамт учруулах аливаа хэлбэрээр тээвэрлэхийг хориглоно.

3. Хоригдлуудыг тээвэрлэх ажлыг хорих ангийн захиргааны зардлаар гүйцэтгэж, бүгдэд нь ижил нөхцөлөөр хангана.

## **Байгууллагын хүний нөөц**

### **Дүрэм 74**

1. Хорих ангийг зөв удирдах нь хүний нөөцийн шударга байдал, хүнлэг чанар, мэргэжлийн чадвар, ажилд тохирсон эсэхээс хамаардаг тул хорих байгууллагын удирдлага нь ангилал бүрийн алба хаагчдыг анхааралтай сонгох ёстой.

2. Хорих ангийн захиргаа нь энэхүү ажил нийгмийн асар их ач холбогдолтой үйлчилгээ мөн гэсэн итгэл үнэмшлийг алба хаагчид болон олон нийтийн оюун санаанд байнга сэрээж, хадгалахыг зорьж, энэ зорилгын үүднээс олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах ёстой.

3. Дээрх зорилгын үүднээс бие бялдрын хөгжил сайтай, эерэг зан байдалтай хүнийг эдлэх эрхийн баталгаагаар хангагдсан төрийн албаны статус бүхий бүтэн цагийн алба хаагчийн ажлын байранд томилон ажиллуулна. Цалин нь аль ч хүйсийн хүний сонирхлыг татахуйц, сонирхлыг удаан хадгалахуйц байх ба ажлын нөхцөлөөс шалтгаалан олгох тэтгэмж, хүнд нөхцөлийн нэмэгдэл таатай байх ёстой.

### **Дүрэм 75**

1. Хорих ангийн бүх ажилтнууд зохих түвшний боловсролтой, үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадвар, хэрэгслээр хангагдсан байна.

2. Хорих ангийн бүх ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхийн өмнө ерөнхий болон тусгайлсан чиг үүрэгт нь тохирсон сургалтад хамрагдах бөгөөд энэ нь эрүүгийн шинжлэх ухааны орчин үеийн нотолгоонд суурилсан шилдэг туршлагыг тусгасан байх ёстой. Ийм сургалтын төгсгөлд онол, практикийн шалгалтыг амжилттай өгсөн хүн л хорих байгууллагад ажиллахыг зөвшөөрнө.

3. Хорих ангийн удирдлагууд алба хаагчдынхаа мэдлэг, мэргэжлийн чадавхыг албан тушаалд орсны дараа болон ажил амьдралынхаа туршид хадгалах, сайжруулах зорилгоор мэргэжил дээшлүүлэх сургалтыг тасралтгүй явуулах ёстой.

### **Дүрэм 76**

1. Дүрмийн 75 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан сургалтад дор хаяж дараах чиглэл сургалтыг багтаана.

(а) Хорих ангийн ажилтнуудын хоригдлуудтай ажиллах, харьцах харилцааг зохицуулах үндэсний холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, түүнчлэн олон улсын болон бүс нутгийн холбогдох баримт бичиг;

(б) Хорих ангийн ажилтны чиг үүргээ гүйцэтгэхдээ хүлээх эрх, үүрэг, үүнд бүх хоригдлуудын нэр төрийг хүндэтгэх, тодорхой зан үйл, тухайлбал эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох;

(в) Хэлэлцээр, эвлэрүүлэн зуучлах гэх мэт урьдчилан сэргийлэх, сааруулах арга техникийг зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр динамик аюулгүй байдлын үзэл баримтлал, хүч, таслан сэргийлэх арга хэрэгсэл ашиглах, хүчирхийлэл үйлдэгчдийг хянах зэрэг аюулгүй байдлын арга хэрэгсэл;

(г) Анхны тусламж, хоригдлуудын сэтгэгц-нийгмийн хэрэгцээ, хорих анги дахь холбогдох динамик, түүнчлэн нийгмийн халамж, тусламж, түүний дотор сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг эрт илрүүлэх.

2. Тодорхой ангиллын хоригдлуудтай ажиллах үүрэг хүлээсэн болон бусад мэргэшсэн чиг үүрэг хүлээсэн хорих ангийн ажилтнууд зохих төвлөрсөн сургалтад хамрагдах ёстой.

#### Дүрэм 77

Хорих ангийн ажилтнууд хоригдлуудад эерэгээр нөлөөлж, тэдэнд үлгэр дуурайл үзүүлж, хүндэтгэлийг хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэдэг байх ёстой.

#### Дүрэм 78

1. Боломжтой бол сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, багш, мэргэжлийн сургагч багш зэрэг хангалттай тооны мэргэжилтнүүдийг хорих ангийн хүний нөөцөд бүрдүүлнэ.

2. Нийгмийн ажилтан, багш, мэргэжлийн сургагч багш нарын үйлчилгээг байнга үзүүлэх ба хагас цагийн болон сайн дурын ажилчдыг ажиллуулах боломжоор хангана.

#### Дүрэм 79

1. Хорих ангийн дарга нь зан чанар, удирдлагын чадвар, дадлага туршлагаараа үүрэгт ажлаа гүйцэтгэхэд хангалттай мэргэшсэн байна.

2. Хорих ангийн дарга нь ажлын бүх цагаа албан үүргээ биелүүлэхэд зориулах ёстой бөгөөд орон тооны бусаар томилогдох боломжгүй. Тэрээр хорих ангийн байранд эсвэл түүний ойр орчимд оршин сууна.

3. Хоёр ба түүнээс дээш хорих анги нэг даргын харьяалалд байгаа бол тухайн хорих ангид ойр ойрхон очдог байх ёстой. Эдгээр хорих анги тус бүрийг тус хорих ангийн байнгын албан тушаалтан хариуцна.

#### Дүрэм 80

1. Хорих ангийн дарга, түүний орлогч болон бусад ихэнх ажилтнууд хоригдлуудын дийлэнх нь ярьдаг эсхүл дийлэнх нь ойлгодог хэлээр ярих чадвартай байх ёстой.

2. Шаардлагатай тохиолдолд чадварлаг орчуулагчийн үйлчилгээг авна.

#### Дүрэм 81

1. Эрэгтэй, эмэгтэй аль ч хорих ангид байх эмэгтэйчүүдэд зориулсан хэсэг эмэгтэй ажилтны удирдлага дор байх ба хорих ангийн тухайн хэсгийн бүх түлхүүрийг тухайн ажилтан хадгална.

2. Хорих ангийн эмэгтэйчүүдэд зориулагдсан хэсэгт эмэгтэй ажилтан дагалдуулаагүй бол эрэгтэй ажилтан орохыг хориглоно.

3. Эмэгтэй хоригдлуудад зөвхөн эмэгтэй ажилтнууд үйлчилж, хяналт тавих ёстой. Гэсэн хэдий ч энэ нь эрэгтэй ажилтан, ялангуяа эмч, багш нар хорих анги, эмэгтэйчүүдийн хэсэгт мэргэжлийн үүргээ биелүүлэхэд саад болох учиргүй.

#### Дүрэм 82

1. Хорих ангийн алба хаагчид зөвхөн өөрийгөө хамгаалах, эсхүл оргох оролдлого хийх, хууль тогтоомжид үндэслэсэн тушаалыг идэвхтэй болон идэвхгүй хэлбэрээр эсэргүүцэхээс бусад тохиолдолд хоригдлуудтай харьцахдаа хүч хэрэглэхийг хориглоно. Хүч хэрэглэж буй алба хаагчид зөвхөн зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэх бөгөөд болсон явдлын талаар хорих ангийн даргад даруй мэдэгдэх ёстой.

2. Хорих ангийн ажилтнууд түрэмгий хоригдлуудын үйлдлийг таслан зогсоохын тулд бие бялдрын тусгай бэлтгэлд хамрагдах ёстой.

3. Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд хоригдлуудтай шууд харьцах үүрэгтэй хорих ангийн ажилтнууд зэвсэглэх ёсгүй. Нэмж дурдахад хорих ангийн ажилтнуудад зэвсэг хэрэглэх талаар сургаагүй бол ямар ч тохиолдолд зэвсэг олгох ёсгүй.

### **Дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалт**

#### Дүрэм 83

1. Хорих ангийн үйлчилгээнд хийх тогтмол хяналт шалгалт нь хоёр шатлалтай байх ёстой:

(а) хорих ангийн төв захиргаанаас явуулж буй дотоод болон захиргааны хяналт шалгалт;

(б) Хөндлөнгийн хяналт шалгалтыг хорих ангийн захиргаанаас хараат бус байгууллага гүйцэтгэдэг бөгөөд үүнд олон улсын болон бүс нутгийн эрх бүхий байгууллагууд багтаж болно.

2. Аль ч тохиолдолд хяналт шалгалтын зорилго нь хорих анги, нийгэмшүүлэх албаны зорилтыг хэрэгжүүлэх, хоригдлуудын эрхийг хамгаалах зорилгоор хорих ангиудын үйл ажиллагааг одоо мөрдөж буй хууль тогтоомж, журам, бодлогын дагуу зохион байгуулж байгаа эсэхийг шалгахад оршино.

#### Дүрэм 84

1. Хянагч нар дараах эрхтэй.

(а) Хоригдлуудын тоо, хорих газар, байршлын талаарх бүх мэдээлэл, түүнчлэн хоригдлуудтай харьцахтай холбоотой бүхий л мэдээлэл, түүний дотор тэдний

бүртгэл, хорих нөхцөл зэрэгтэй танилцах;

(б) Аль хорих ангид очих, түүний дотор өөрсдийн санаачилгаар гэнэтийн айлчлал хийх, ямар хоригдолтой ярилцлага хийхээ чөлөөтэй сонгох;

(в) Хоригдлууд болон хорих ангийн ажилтнуудтай уулзах үеэр тэдэнтэй ганцаарчилсан болон бүрэн нууцлалтай ярилцлага хийх;

(г) Хорих ангийн удирдлага болон бусад эрх бүхий байгууллагад зөвлөмж гаргах.

2. Хөндлөнгийн хяналтын баг нь эрх бүхий байгууллагаас томилогдсон мэргэшсэн, туршлагатай хянагчдаас бүрдэх ба эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг оролцуулна. Жендэрийн тэнцвэртэй төлөөллийг анхаарч үзнэ.

#### Дүрэм 85

1. Хяналт шалгалт бүрийн дараа тайлан гаргаж, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлнэ. Хөндлөнгийн хяналт шалгалтын тайланг олон нийтэд ил болгохдоо хоригдлууд зөвшөөрөл өгөөгүй бол тэдний хувийн мэдээллийг оруулахгүй байхад онцгой анхаарах ёстой.

2. Хорих ангийн захиргаа болон бусад эрх бүхий байгууллага нь хөндлөнгийн хяналт шалгалтаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар боломжит хугацаанд эргэн мэдэгдэнэ.

## II. Тусгай ангилалд хамаарах дүрэм

### А. Ял эдэлж буй хоригдлууд

#### Удирдах зарчим

#### Дүрэм 86

Доор дурдсан удирдамж нь эдгээр дүрмийн 1 Ерөнхий хэрэглээний дүрэмд заасны дагуу хорих байгууллагуудыг ямар байдлаар удирдаж, ямар зорилгод чиглүүлэх ёстойг харуулах зорилготой юм.

#### Дүрэм 87

Хоригдол ялаа дуусгаж, суллагдахаас өмнө түүнийг нийгэмд аажмаар эргэн нэгдэхэд шаардлагатай арга хэмжээг авах нь зүйтэй юм. Тухайн хорих ангид эсвэл өөр зохих байгууллагад суллагдахаас өмнөх дэглэм зохион байгуулах эсхүл цагдаагийн байгууллагаас өөр бусад этгээдийн хяналт дор шүүхээс суллах замаар энэ зорилгод хүрч болох ба нийгмийн үр дүнтэй тусламжтай хослуулах хэрэгжүүлэх хэрэгтэй.

#### Дүрэм 88

1. Хоригдлуудтай харьцахдаа тэднийг олон нийтээс гадуурхах бус харин ч тэдний оролцоог чухалчлах ёстой. Тиймээс хорих ангийн ажилтнуудад хоригдлуудыг нийгэмшүүлэх ажилд нь туслах зорилгоор аль болох олон нийтийн байгууллагуудыг татан оролцуулах хэрэгтэй.

2. Хорих анги бүр хоригдлын гэр бүлийнхэнтэйгээ болон нийгмийн үнэ цэнэтэй байгууллагуудтай үүсгэх хүссэн харилцааг хадгалах, сайжруулах үүрэг хүлээсэн нийгмийн ажилтантай байх ёстой. Хоригдлуудын иргэний эрх, нийгмийн



хамгааллын эрх, нийгмийн бусад ашиг тусыг хууль тогтоомж, ялын хэмжээнд бүрэн нийцүүлэн хамгаалах арга хэмжээ авах ёстой.

#### Дүрэм 89

1. Эдгээр зарчмыг хувь хүн болгонд тохирсон байдлаар хэрэгжүүлэх, үүний тулд хоригдлуудыг бүлэгт ангилах уян хатан тогтолцоог бий болгох шаардлагатай. Иймд энэ бүлгүүдийг бүлэг тус бүрийн онцлогт тохирсон тусдаа хорих ангиудад хуваарилах нь зүйтэй.

2. Эдгээр хорих ангиуд нь бүлэг тус бүрийн аюулгүй байдлыг ижил түвшинд хангах албагүй. Бүлэг болгоных нь хэрэгцээнд нийцүүлэн янз бүрийн түвшний аюулгүй байдлыг хангах нь зүйтэй. Нээлттэй хорих ангиуд нь оргон зайлахаас сэргийлсэн бие махбодын хамгаалалт байхгүй боловч анхааралтай сонгосон хоригдлуудыг хувийн сахилга батад нь тулгуурлан нийгэмшүүлэхэд хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

3. Хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдлуудын тоо эдгээр зарчмуудыг хувь хүнд тохируулан хэрэгжүүлэхэд саад учруулахгүй байхуйц их биш байх нь зүйтэй. Зарим оронд ийм хорих ангийн хоригдлын тоо 500 хүнээс хэтрэхгүй байх ёстой гэж үздэг. Нээлттэй хорих ангиудад хоригдлын тоо аль болох цөөхөн байх ёстой.

4. Нөгөөтэйгүүр, хорих ял эдлүүлэх зохих нөхцөлийг бүрдүүлэх боломжгүй жижиг хорих ангиудыг байлгаад байх нь зохимжгүй юм.

#### Дүрэм 90

Хоригдлуудыг сулласнаар нийгмийн хариуцлага дуусахгүй. Иймд суллагдсан хоригдолд үзүүлэх эсрэг нөлөөллийг бууруулах, нийгэмд нөхөн сэргээхэд нь чиглэсэн үр дүнтэй тусламж үйлчилгээг үзүүлэх чадвартай төрийн болон хувийн байгууллагууд байх ёстой.

#### Дүрэм 91

Хорих болон түүнтэй адилтгах ялаар шийтгүүлсэн хүмүүстэй ажиллах, харьцах нь ял эдлэх хугацаанд нь тэдэнд бие даан амьдрах хүсэл зоригийг төлөвшүүлэх, суллагдсаныхаа дараа хууль дээдэлдэг байхад чиглэгдэх ёстой. Энэ нь тэдний өөрийгөө хүндэтгэх, хариуцлагатай байх мэдрэмжийг төлөвшүүлэхэд чиглэсэн байх ёстой.

#### Дүрэм 92

1. Эдгээр зорилгод хүрэхийн тулд аль болох шашны тусламж үзүүлэх, боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох, сургах, нийгмийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх, хоригдол бүрийн нийгэм, гэмт хэргийн түүх, бие бялдар, оюун санааны чадавх, чадамж, хувийн зан чанар, суллагдсаны дараах хэтийн төлөвийг харгалзан хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх, бие бялдрын хөгжил, ёс суртахууны нэмэгдүүлэх зэрэг зохих бүх арга хэрэгслийг ашиглах ёстой.

2. Хорих ангийн дарга нь тодорхой хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдол бүрд хамаарах энэ дүрмийн 1 дэх хэсэгт заасан бүх асуудлаарх мэдээллийг хоригдлыг хүлээн авсны дараа аль болох богино хугацаанд хүлээн авна. Ийм мэдээлэлд хоригдлын бие махбодын болон сэтгэцийн байдлын талаар

эмч эсвэл бусад мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтний мэдээллийг заавал агуулсан байх ёстой.

3. Мэдээлэл болон бусад холбогдох баримт бичгийг тусдаа файлд хийнэ. Энэ файлыг шинэчилж, шаардлагатай үед холбогдох ажилтнаас лавлаж болохуйц байдлаар ангилах ёстой.

### **Ангилал**

#### Дүрэм 93

1. Дараах зорилгоор ангиллыг хийнэ:

(а) Гэмт хэргийн түүх, зан чанарын улмаас муу нөлөө үзүүлж болзошгүй хоригдлуудыг бусдаас тусгаарлах;

(б) Нийгэмд нөхөн сэргээх зорилгоор хоригдлуудтай ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ангилалд хуваах.

2. Төрөл бүрийн ангиллын хоригдлуудыг аль болох тусдаа хорих анги эсвэл хорих ангийн тусдаа хэсгийг байршуулах.

#### Дүрэм 94

Хүлээн авсан даруйдаа болон зохих хугацаатай хорих ял эдэлж буй хоригдол бүрийн хувийн шинж чанарыг судалсны дараа түүний хувийн хэрэгцээ, чадвар, зан чанарын талаар олж авсан мэдээллийг харгалзан түүнд зориулсан хөтөлбөрийг бэлтгэнэ.

### **Давуу эрх**

#### Дүрэм 95

Хорих анги бүр хоригдлын төрөл бүрийн ангилалд тохирсон давуу эрхийн тогтолцоог бий болгож, тэдний зөв зан үйлийг хөхиүлэн дэмжих, хариуцлагын мэдрэмжийг төлөвшүүлэх, тэднийг эмчлэхэд тэдний ашиг сонирхол, хамтын ажиллагааг хангах үүднээс тэдэнд хандах янз бүрийн арга барилыг бий болгох ёстой.

### **Ажил**

#### Дүрэм 96

1. Ял эдэлж буй хоригдлуудад бие бялдар, оюун санааны чадавхыг нь эмч болон бусад мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтнүүд тогтоосны үндсэн дээр хөдөлмөрлөх ба/эсвэл тэднийг хүмүүжүүлэх ажилд идэвхтэй оролцох боломжийг олгоно.

2. Хоригдлуудыг ердийн ажлын өдөр идэвхтэй байлгахын тулд ашигтай шинж чанар бүхий хангалттай ажлаар хангах ёстой.

#### Дүрэм 97

1. Хорих ангийн хөдөлмөр нь зовоох шинж чанартай байж болохгүй.

2. Хоригдлуудыг боолчлол, албадлагын нөхцөлд байлгаж болохгүй.

3. Ямар ч хоригдол хорих ангийн ажилтны хувийн болон хувийн ашиг сонирхлын төлөө ажиллахыг шаардах ёсгүй.

## Дүрэм 98

1. Хоригдлын хөдөлмөр нь аль болох суллагдсаныхаа дараа шударгаар амьжиргаагаа залгуулах чадварыг хадгалах буюу нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

2. Үр шимийг нь хүртэх боломжтой мэргэжлийн сургалтад ялангуяа залуу хоригдлуудыг сургах хэрэгтэй.

3. Сонгогдсон тодорхой ажлын хүрээнд, тухайн байгууллагын удирдлага зохион байгуулалт, сахилга хариуцлагын шаардлагад нийцүүлэн хоригдлууд гүйцэтгэхийг хүсч буй ажлын төрлөө сонгох боломжтой байна.

## Дүрэм 99

1. Хорих ангиуд эрхлэх хөдөлмөрийн зохион байгуулалт, арга барил нь хорих ангиас гадуурх ижил төрлийн ажилтай аль болох адилхан байх ёстой бөгөөд ингэснээр хоригдлуудыг хөдөлмөрийн хэвийн нөхцөлд бэлтгэх ёстой.

2. Харин хоригдлуудын ашиг сонирхол, тэдний хөдөлмөр эрхлэлтийг хорих ангиас мөнгө олох зорилгод хөтлөгдх ёсгүй.

## Дүрэм 100

1. Байгууллагын үйлдвэр, аж ахуйг хувийн гэрээт гүйцэтгэгчид бус хорих ангийн удирдлагууд шууд удирддаг байх нь зүйтэй.

2. Хэрэв хоригдлууд хорих ангийн захиргаанаас хараат бус хөдөлмөр эрхэлдэг бол хорих ангийн ажилтнууд байнгын хяналтдаа байлгах ёстой. Хоригдол нь төрийн байгууллагаас өөр байгууллагад хамаарах ажил гүйцэтгэсэн бол тэдний хөдөлмөрийн хөлсийг ажлын бүтээмжийг харгалзан ажил гүйцэтгүүлсэн этгээд хорих ангийн захиргаанд бүрэн төлнө.

## Дүрэм 101

1. Чөлөөт ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хорих ангиуд адил тэгш мөрдөнө.

2. Хоригдлын үйлдвэрийн ослоос үүдэлтэй гэмтэл, тэр дундаа мэргэжлээс шалтгаалах өвчний нөхөн олговрыг хуулийн дагуу чөлөөт ажилтанд олгогдогоос багагүй нөхцлөөр барагдуулах зохицуулалтыг хийнэ.

## Дүрэм 102

1. Хоригдлуудын өдөр тутмын болон долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаарыг чөлөөт ажилчдыг ажиллуулахтай холбоотой орон нутгийн дүрэм, журмыг харгалзан хууль, захиргааны журмаар тогтооно.

2. Ингэж тогтоосон цаг нь долоо хоногт нэг өдөр амарч, боловсролын болон хоригдлуудыг нөхөн сэргээх бусад үйл ажиллагаанд хангалттай цагийг олгоно.

## Дүрэм 103

1. Хоригдлуудын хөдөлмөрийг шударгаар үнэлэх тогтолцоог бий болгох ёстой.

2. Уг тогтолцооны дагуу хоригдлууд олсон орлогынхоо тодорхой хэсгийг өөрийн хэрэгцээнд зориулан зөвшөөрөгдсөн эд зүйлд зарцуулах, гэр бүлдээ илгээх боломжоор хангагдана.

3. Мөн хорих ангийн захиргаа орлогын тодорхой хэсгийг хоригдол суллагдсаны дараа олгох нөхцөлтэйгөөр хуримтлалын сан үүсгэн, төвлөрүүлэх тогтолцоог бүрдүүлэх ёстой.

### **Боловсрол, чөлөөт цаг**

#### Дүрэм 104

1. Цаашид үргэлжлүүлэн үр шимийг нь хүртэх боломжтой хоригдол бүрд нэмэлт боловсрол олгох, шашны сургалт явуулахыг зөвшөөрсөн улс орнууд шашин номын хичээл орох зохицуулалт хийнэ. Бичиг үсэг тайлагдаагүй болон насанд хүрээгүй хоригдлуудад заавал боловсрол олгох ба хорих ангийн удирдлагууд үүнд онцгой анхаарах ёстой.

2. Хоригдлуудын боловсролыг тухайн улсын боловсролын системтэй боломжийн хэрээр уялдуулах нь зүйтэй бөгөөд ингэснээр хоригдол суллагдсаныхаа дараа аливаа бэрхшээлгүйгээр үргэлжлүүлэн суралцах боломжтой болно.

#### Дүрэм 105

Хорих анги бүр хоригдлын сэтгэцийн болон бие бялдрын эрүүл мэндэд тустай амралт, соёлын арга хэмжээг зохион байгуулна.

#### Дүрэм 106

Хоригдол болон түүний гэр бүлийн хоорондын харилцааг хоёр талын ашиг сонирхолд нийцүүлэн хадгалах, сайжруулахад онцгой анхаарал хандуулна.

#### Дүрэм 107

Хоригдол ялаа эдэлж эхэлснээс суллагдсаныхаа дараа нийгэмд эргэн нэгдэж, бусад хүн, байгууллагатай харилцах, нийгэмшин дасан зохицох, тэдний гэр бүлийн дээд ашиг сонирхлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх ёстой.

#### Дүрэм 108

1. Суллагдсан хоригдлуудыг нийгэмд дахин нийгэмшүүлэхэд нь туслах төрийн болон бусад үйлчилгээ, агентлагууд суллагдсан хоригдлуудыг зохих бичиг баримт, үнэмлэх, тохиромжтой орон гэр, ажлын байр, тухайн цаг агаар, улирлын онцлогт тохирсон хувцас хэрэгсэл, суллагдсаны дараа нэн даруй зорьсон газартаа хүрэх, өөрийгөө тэжээх хангалттай мөнгө, санхүүтэй байна.

2. Эдгээр агентлагийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь хорих анги болон хоригдлуудтай уулзах шаардлагатай бүх боломжоор хангагдсан байх бөгөөд ял эдэлж эхлэхээс нь тэдний ирээдүйн талаар зөвлөлдөх ёстой.

3. Эдгээр агентлагуудын хүчин чармайлтыг хамгийн сайн ашиглахын тулд тэдгээрийн үйл ажиллагааг аль болох төвлөрүүлэх эсвэл нэгтгэх нь зүйтэй.

### **Б. Сэтгэцийн эмгэг ба/эсвэл эрүүл мэндийн асуудалтай хоригдлууд**

#### Дүрэм 109

1. Эрүүгийн хариуцлага хүлээхгүй нь тогтоогдсон, эсхүл хожим сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн байдал хүндэрсэн нь тогтоогдсон, хорих ангид байх нь тэдний биеийн байдлыг улам хүндрүүлэхэд хүргэсэн

хүмүүсийг хорих ангид хорихгүй бөгөөд тэднийг аль болох түргэн хугацаанд сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

2. Шаардлагатай бол сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн асуудалтай хоригдлуудыг мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтний хяналт дор тусгай байгууламжид ажиглаж, эмчилж болно.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь ийм эмчилгээ шаардлагатай байгаа бусад бүх хоригдлыг сэтгэцийн эмчилгээгээр хангана.

#### Дүрэм 110

Шаардлагатай бол суллагдсаныхаа дараа сэтгэцийн эмчилгээг үргэлжлүүлэх, нийгэм-сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар холбогдох байгууллагуудтай тохиролцсоны дагуу арга хэмжээ авах нь зүйтэй.

### **В. Баривчлагдсан эсвэл шүүх хурлаа хүлээж буй хоригдогчид**

#### Дүрэм 111

1. Цагдан хорих байр, хорих ангид байгаа эрүүгийн хэргийн улмаас баривчлагдсан, хоригдсон боловч шүүх хурал явагдаагүй, хараахан шийтгэгдээгүй хүмүүсийг цаашид “ял шийтгүүлээгүй хоригдлууд” гэнэ.

2. Ял шийтгүүлээгүй хоригдлуудыг гэм буруугүйд тооцож, ийм байдлаар харьцах ёстой.

3. Хувь хүний эрх чөлөөг хамгаалах хууль эрх зүйн хэм хэмжээ болон ял шийтгүүлээгүй хоригдлуудын талаар баримтлах журмыг зөрчихгүйгээр эдгээр хоригдлуудад дор дурдсан дүрэмд заасан онцгой дэглэмийг зөвхөн үндсэн шаардлагын дагуу эдэлнэ.

#### Дүрэм 112

1. Ял шийтгээгүй хоригдлуудыг ял шийтгүүлсэн хоригдлуудаас тусад нь байрлуулна.

2. Ял шийтгүүлээгүй насанд хүрээгүй хүүхдүүдийг насанд хүрэгчдээс тусад нь байлгаж, зарчмын хувьд тусад нь хорих байгууллагад байлгадаг.

#### Дүрэм 113

Ял эдлээгүй хоригдлууд орон нутгийн цаг уурын янз бүрийн төлөв байдлыг харгалзан тусдаа өрөөнд ганцаараа унтах ёстой.

#### Дүрэм 114

Ял шийтгүүлээгүй хоригдлууд хэрэв хүсвэл байгууллагын дэг журамтай нийцүүлэн захиргаа, гэр бүл, найз нөхдөөрөө дамжуулан хоол хүнсээ гаднаас өөрийн зардлаар авч болно. Эс бөгөөс захиргаа хоол хүнсээр хангах ёстой.

#### Дүрэм 115

Ял шийтгүүлээгүй хоригдол өөрийнхөө цэвэр, тохиромжтой хувцас өмсөхийг зөвшөөрөх ёстой. Хэрэв хорих ангийн олгосон хувцас өмсөх бол тухайн хувцас ял эдэлж буй хоригдлуудынхаас өөр байх ёстой.

### Дүрэм 116

Ял шийтгүүлээгүй хоригдолд хөдөлмөрлөх боломжийг ямагт олгож байх ёстой, гэхдээ албадан хөдөлмөр эрхлүүлж болохгүй. Хэрэв хоригдол хөдөлмөр эрхлэх бол цалин олгогдсох ёстой.

### Дүрэм 117

Ял шийтгүүлээгүй хоригдол нь өөрийн зардлаар эсвэл гуравдагч этгээдийн зардлаар шүүн таслах ажиллагааны явц, хорих ангийн аюулгүй байдал, дэг журамд үл харшлах ном, сонин, бичгийн материал, бусад хэрэгслийг олж авахыг зөвшөөрнө.

### Дүрэм 118

Ял шийтгүүлээгүй хоригдолд хэрэв үндэслэлтэй бол өөрийн эмч, шүдний эмчид үзүүлж, эмчилгээ хийлгэхийг зөвшөөрнө, гарсан зардлаа төлөх боломжтой байх ёстой.

### Дүрэм 119

1. Ял шийтгүүлээгүй хоригдол бүр тэднийг цагдан хорьсон шалтгаан болон өөрт нь тулгаж байгаа ялын талаар нэн даруй мэдээлэл авах эрхтэй.

2. Хэрэв ял шийтгүүлээгүй хоригдол өөрийн сонгосон хуулийн зөвлөхгүй бол шударга ёсны ашиг сонирхолд шаардлагатай бүх тохиолдолд шүүх болон бусад эрх бүхий байгууллагаас өөрт нь хуулийн зөвлөх томилж, төлбөр төлөх хангалттай хөрөнгөгүй бол яллагдагчаас төлбөр төлөхгүйгээр ажиллуулах эрхтэй. Хуулийн зөвлөхтэй холбоо тогтоохыг хориглосон тохиолдолд хөндлөнгийн хяналтыг цаг алдалгүй хийнэ.

### Дүрэм 120

1. Ял шийтгүүлээгүй хоригдлыг өмгөөлөх зорилгоор хуулийн зөвлөх буюу хууль зүйн туслалцаа үзүүлэгчид хандах эрх, арга хэлбэрийг дүрмийн б1-д заасан зарчмаар зохицуулна.

2. Ял шийтгүүлээгүй хоригдлыг өөрийнх нь хүсэлтээр түүнийг өмгөөлөхтэй холбоотой баримт бичиг, түүний дотор хуулийн зөвлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэгчид өгөх нууц зааварчилгааг бүрдүүлэх бичгийн хэрэглэгдэхүүнээр хангана.

## **Г. Иргэний хоригдлууд**

### Дүрэм 121

Хуулиараа эдийн засгийн эсхүл шүүхийн шийдвэрээр эрүүгийн бус хэргийн улмаас хорих ял эдлүүлдэг улс орнуудад энэ үндэслэлээр хоригдсон хүмүүст аюулгүй байдал, сайн дэг журмыг хангахад шаардагдахаас давж гарсан хязгаарлалт, хатуу хориг тавих ёсгүй. Тэдэнд ял шийтгүүлээгүй хоригдлуудаас дутуугүй сайнаар хандах ёстой, гэхдээ хөдөлмөр эрхлүүлэх шаардлагатай байж болно.



## **Д. Ямар ч үндэслэлгүйгээр баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүс**

Дүрэм 122

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактийн 9 дүгээр зүйлийн заалтыг хөндөхгүйгээр ямар ч үндэслэлгүй баривчлагдсан, цагдан хоригдсон хүмүүст эдгээр дүрмийн I хэсэг ба II хэсгийн В хэсгийн дагуу олгогдсон хамгаалалтыг нэгэн адил олгоно. Энэхүү дүрмийн II хэсгийн А хэсгийн холбогдох заалтуудыг хоригдож буй эдгээр тусгай бүлэг хүмүүст хэрэглэх нь ашиг тустай байх ба эрүүгийн гэмт хэрэгт шийтгүүлээгүй хоригдлуудад дахин хүмүүжүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ явуулахгүй байх ёстой.



**ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ТОГТООХ  
КРИМИНОЛОГИЙН СУДАЛГАА**

Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГА

ГРАФИК ЖАГСААЛТ .....	3
ХҮСНЭГТ ЖАГСААЛТ .....	6
ХУРААНГУЙ.....	7
УДИРТГАЛ .....	9
Судалгааны зорилго, зорилт .....	10
Судалгааны арга зүй .....	11
ХОЁР. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛЫН ОЙЛГОЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	15
2.1. Эрүүдэн шүүх гэмт явдлын ойлголт .....	15
2.2. Эрүүдэн шүүх гэмт явдлын нөхцөл байдал.....	18
2.2.1. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ .....	18
/ Бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн/ .....	18
2.2.2. ХЭҮК-т эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандсан талаар ирүүлсэн гомдол хийсэн дүн шинжилгээ.....	22
2.2.3. Бусад гэмт хэрэг.....	25
2.3. Эрүүдэн шүүх гэмт явдлын ойлголт, мэдлэг .....	31
/шинжээчийн болон олон нийтийн төсөөлөл/ .....	31
2.4. Эрүүдэн шүүх гэмт явдлын хор уршгийн талаарх олон нийтийн төсөөлөл ...	38
2.5 Өмгөөллийн үйл ажиллагаа ба эрүүдэн шүүх гэмт явдал .....	39
ГУРАВ. ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОЛБОГДОГЧ, ХОХИРОГЧИЙН ОНЦЛОГ .....	43
3.1. Шүүгдэгчийн хувийн байдал.....	43
3.2. Хохирогчийн онцлог .....	45
ДӨРӨВ. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ .....	50
ТАВ. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ .....	55
5.1. Эрүүн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны эрх зүйн үндэс.....	55
5.2. Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх УИХ-ын үйл ажиллагаа .....	57
5.3. Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) .....	62
5.4. Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох.....	73
5.5. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн .....	74
5.6. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагаа .....	78
ДҮГНЭЛТ .....	86
ЗӨВЛӨМЖ .....	88

## ГРАФИК ЖАГСААЛТ

График 1. Насны бүлэг, хүйсээр .....	11
График 2. Боловсролын зэрэг.....	11
График 3. Өрхийн сарын дундаж орлого .....	12
График 4. Насны бүлэг, ажил эрхлэлт.....	12
График 5. Шинжээчдийн насны бүлэг, хүйс .....	12
График 6. Шинжээчдийн мэргэжил .....	13
График 7. Ажиллаж буй салбар .....	13
График 8. Эрхэлдэг ажил, албан тушаал, ажилласан жил .....	13
График 9. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг зүйлчилсэн байдал, тоогоор... 19	19
График 10. “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн он, тоогоор ... 19	19
График 11. Гэмт хэргийн үйлдлийн арга, тоогоор .....	20
График 12. Үйлдсэн гэмт хэргийн ангилал, тоогоор .....	20
График 13. Гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр, тоогоор.....	20
График 14. Гэмт хэрэг төгссөн байдал, тоогоор.....	21
График 15. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо, тоогоор .....	22
График 16. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал (2024 он), тоогоор .....	23
График 17. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл “хууль бусаар баривчлан, саатуулах .....	26
График 18. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл “ялгаварлан гадуурхах” .....	27
График 19. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйл “нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах” .....	27
График 20. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.4 дүгээр зүйл “шинжээч зориуд худал дүгнэлт гаргах” .....	28
График 21. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.5 дугаар зүйл “гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх” .....	29
График 22. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаарх ойлголтыг мэдэх байдал.....	31
График 23. Ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал хэр байгааг үнэлсэн байдал.....	32
График 24. Эрүүдэн шүүх явдал түгээмэл байна /Дүр төрх/.....	32
График 25. Эрүүдэн шүүх ойлголтын талаар Маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс Ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал хэр байгааг үнэлсэн байдал .....	32
График 26. Ажиллаж буй салбар ба амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх явдлын түгээмэл байдал.....	33
График 27. Өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөн бэ? .....	36
График 28. Ирэх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдөх вэ?.....	36

График 29. Ажиллаж буй салбар ба өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөн байдал .....	37
График 30. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс ба өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнэсэн байдал.....	37
График 31. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс ба ирэх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдөхийг төсөөлж буй байдал.....	38
График 32. Эрүүдэн шүүх явдлын хор уршгийн талаарх ойлголт.....	38
График 33. Шүүгдэгчийн нас, тоогоор .....	43
График 34. Шүүгдэгчийн боловсролын түвшин, тоогоор .....	43
График 35. Шүүгдэгчийн мэргэжил, тоогоор .....	44
График 36. Шүүгдэгчийн албан тушаалын төрөл, тоогоор.....	44
График 37. Шүүгдэгчийн цэргийн алба хаасан хугацаа, тоогоор.....	44
График 38. Шүүгдэгчийн гэр бүлийн .....	45
График 39. Шүүгдэгч хүүхэдтэй эсэх, тоогоор.....	45
График 40. Урьд нь шүүгдэгч ял шийтгэгдсэн байдал, тоогоор .....	45
График 41. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хохирогчдын онцлог, тоогоор.....	46
График 42. Үүнээс: Оногдуулсан ялыг хэрэгжүүлсэн байдал, тоогоор.....	46
График 43. Өөрөө эрүүдэн шүүх явдлын улмаас хохирсон хүмүүс.....	47
График 44. Эрүүдэн шүүх гэмт явдлын улмаас хохирсон гэх иргэдийн нас, хүйс.....	48
График 45. Эрүүдэн шүүх гэмт явдлын улмаас хохирсон гэх иргэдийн боловсрол, өрхийн дундаж орлого ..... рүүдэн шүүх талаарх ойлголт талаар 39% нь “Маш сайн мэднэ”, 23% нь “Дунд зэрэг мэднэ”, мөн 23% нь “Бага мэднэ”, 15% нь “Мэднэ” гэж хариулсан байна. ....	48
График 46. Эрүүдэн шүүх талаарх ойлголт талаарх мэдлэг.....	48
График 47. Эрүүдэн шүүх үйл явдлын үүсвэр.....	51
График 48. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар олон нийтийн мэдлэг нэмэгдэхэд нөлөөлсөн зүйлс.....	52
График 49. Эрүүдэн шүүх гэмт явдал юунаас болж үүсдэг вэ?.....	52
График 50. Ажиллаж буй салбар ба Эрүүдэн шүүх гэмт явдал юунаас болж үүсдэг вэ?.....	53
График 51. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү.....	73
График 52. Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх явдал үүсэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү.....	73
График 53. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн.....	75
График 54. Эрүүдэн шүүх гэмт явдлыг мэддэг хүмүүс ба эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн.....	75
График 55. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 9% нь Монгол Улсын хэмжээнд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн “Огт үр дүнгүй” гэж үнэлсэн хүмүүсийн дүр төрх.....	75

График 56. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа Огт үр дүнгүй гэж үзэж байгаа хүмүүсийн хувьд урьдчилан сэргийлэхийн тулд авах арга хэмжээ нэрлэсэн байдал.....	76
График 57. Монгол Улсад эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх хууль, тогтоомж урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү .....	76
График 58. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү.....	77
График 59. Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх явдал үүсэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү .....	77
График 60. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг манлайлагч.....	78
График 62. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй арга хэрэгсэл.....	80
График 63. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ зохион байгуулбал үр дүнтэй гэж та үзэж байна вэ?.....	81
График 64. Би эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох эсэх .....	82

#### ХҮСНЭГТ ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эрүүдэн шүүх ажиллагаа хэр зэрэг гарч байгаа байдал .....	37
Хүснэгт 2. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаарх шинжээчийн үнэлэмж .....	38
Хүснэгт 3. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ .....	71
Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь .....	72
Хүснэгт 5. Эрүүдэн шүүх талаар гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт ....	73
Хүснэгт 6. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар хэмжээ зохион байгуулбал үр дүнтэй гэж та үзэж байна вэ?.....	78
Хүснэгт 7. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ / Шинжээчид/.....	82
Хүснэгт 8. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд өгсөн үнэлгээ....	84



## ХУРААНГУЙ

Монгол Улсад эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох криминологийн анхны судалгааг Монголын Криминологичдын холбоо 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 3 сарын 25-ны хооронд хийлээ. Судалгааг хууль зүйн ухааны доктор /Ph.D/, профессор Б.Батзориг, хууль зүйн ухааны доктор, профессор Ш.Чулуунбат, Хууль зүйн ухааны доктор Б.Мөнх-Эрдэнэ, хууль зүйн ухааны доктор Д.Энхтөр нар хийж гүйцэтгэв.<sup>279</sup>

Судалгааны зорилго нь эрүүдэн шүүх гэмт явдлаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх илүү үр дүнтэй тусгайлсан арга замыг тодорхойлох суурь нотолгоо болохуйц мэдээллийг оролцогч талуудаас цуглуулахад оршиж байв.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) хэрэгжиж эхэлснээс хойш эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрчимжиж, тэдгээрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, иргэдийн болон шинжээчдийн судалгаанаас харахад тодорхой үр дүнд хүрсэн байна.

Энэ хугацаанд өмнө эрүүдэн шүүх явдал гэж үздэггүй байсан эрүү шүүлт тулгах шинжтэй бусад үйлдлүүдийг анхааралдаа авч, гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн түвшинд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага гарч байна.

Хэдий олны анхааралд хүрч байгаа ч, эрүүдэн шүүх гэмт явдалд хандах иргэдийн хандлага, мэдлэг нь төрийн албан хаагчдынхтай харьцуулахад бага байна. Мөн, эрүүдэн шүүхийн асуудал нь хэрэгт шалгагдаж буй сэжигтэн, яллагдагчид, төрийн үйлчилгээ авч буй бизнес эрхлэгчдээс хальж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж буй өмгөөлөгч нарын тулгамдсан асуудал болж байна.

Түүнчлэн, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс хууль бусаар халдах, ялгаварлан гадуурхалтад өртөхөд өмгөөлөгчдийн хууль зүйн болон ёс зүйн асуудалтай тулах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан, нөхцөл нь төрийн байгууллагын үйл ажиллагааны процесс, алба хаагчдын ёс зүй, төрийн үйлчилгээ авч буй иргэдтэй харилцах арга барил, мэргэжлийн үйл ажиллагааны сургалт зэрэг олон хүчин зүйлсээс бүрдэж байна.

Судалгаанаас гарсан дараах гол зөвлөмжүүд эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа төгөлдөржүүлэхэд чиглүүлэх зорилготой:

1. Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл тэр дундаа УИХ-ын үйл ажиллагааны эрчийг сулруулахгүй байх;

2. Засгийн газар, төрийн байгууллагад бий болсон тогтолцооны шинжтэй алдааг засах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) зүгээс хамтран ажиллаж буй арга барилыг эрчимжүүлэхэд төсөв хөрөнгө, бодлогын хувьд дэмжих;

<sup>279</sup> ХЭҮК/2025/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Эрүүдэн шүүх гэмт явдлын криминологийн (суурь судалгаа) судалгаа хийх” ажлыг гүйцэтгэв.

3. Эрүү шүүлтийг эрүүдэн шүүх гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийг хэмжээнд нарийвчлан судлах;

4. Сургалтаа хор уршгийн талаар, хэрхэн мэдээлэх, ямар шинж тэмдгээр таних, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах чиглэлд хандуулах. Энэ нь эрүүдэн шүүх гэмт явдалтай холбоотой гомдол, мэдээлэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирэх нь нэмэгдэж, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ явуулах ачаалал нэмэгдэх эрсдэлтэй тул хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх;

5. Өмгөөлөгчдийн мэдээлснээр баривчлагдаж хоригдсон хүмүүсийг дарамтлах, айлган сүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага, хүмүүс зарим үед хоригдогсдын гэр бүлийг заналхийлэх, хоригдогсдыг удаа дараа шилжүүлэх, эсвэл тэднийг орон байр, гэр бүлээс нь хол хорих ангид байрлуулах зэргээр хууль эрх зүйн зөвлөгөө авах, гэр бүлийнхэнтэйгээ уулзахад хэцүү төвөгтэй болгож байгаа нөхцөл одоо ч байна. Хүний эрхийн ТББ-ууд, өмгөөлөгчид эрүүдэн шүүх, хүчирхийлэлтэй холбоотой нотлох баримт цуглуулахад хүндрэл бэрхшээлтэй байдгийг мэдээлдэг. Иймд цаашид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрхийг хангах буюу түүнийг үйлчлүүлэгчийг нь эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлж хуулиар олгогдсон эрхийг нь ягштал биелүүлэгдэх тал дээр анхаарах;

6. Хууль бус тушаал, шийдвэр гаргасан удирдах албан тушаалтанд хариуцлага тооцдог тогтолцоог бүрэн ажиллуулах;

7. Эрүүгийн хууль нь хүчээр гэм буруутай гэх мэдүүлэг өгөхийг албадсан гэж буруутгагдаж буй мөрдөгч, прокурор зэрэг эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлагаас мултрах боломжийг олгож байна. Түүнчлэн сэтгэл санаагаар тарчлаан зовоосон гэх гомдлуудыг зарим тохиолдолд нотлох баримт байхгүй, эсвэл гэмтлийн зэргийг тодорхойлох боломжгүй гэх шалтгаанаар эрх бүхий байгууллага, хүмүүс хэрэгсэхгүй болгосон байгааг цаашид анхаарч хариуцлагыг гарцаагүй байх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх буюу хуулийг боловсронгуй болгохын зэрэгцээ энэ талын хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох;

8. Эрүү шүүлтийн гэмт хэрэгт хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангаруулах. Хохирогч нарын хувьд хохирлоо мөнгөн хэлбэрээр барагдуулахаас өөрөөр зохицуулдаг эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

9. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Иргэний хуулиудад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн сэтгэл ханамжийг хангах, дахин давтагдахгүй байх баталгаагаар хангах зохицуулалтыг хийх. Тухайлбал:

- Хохирогчийн нэр төрийг сэргээх тухай албан ёсны мэдэгдэл хийх
- Олон нийтийн өмнө уучлалт гуйх
- Хохирогчдын дурсгалыг хүндэтгэх
- Хүндэтгэл үзүүлэх бусад арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлдэг болоход анхаарах.

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт «Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй» гэж зааж, ийм үйлдлийг гаргасан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тогтоожээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орнууд хүний эрхийг хамгаалах чиглэлээр ахиц дэвшил гаргаж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь 1948 онд батлагдсан бөгөөд 5 дугаар зүйлд «Хэнд ч эрүү шүүлт тулган, хэрцгий, хүний ёсноос гадуур харьцаж болохгүй» гэж заасан нь эрүү шүүлтээс ангид байхыг жам ёсны эрх гэж тодорхойлдог. Монгол Улс 2000 онд энэхүү зарчмыг дэмжиж, 2015 онд нэмэлт протоколыг соёрхон баталснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүрэг хүлээсэн. Энэ нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхөд томоохон алхам болсон гэж үзнэ.

Монгол Улс болон бусад улс орнуудын хувьд амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх жам ёсны эрхийг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг юм. Хууль сахиулах байгууллагууд зөвхөн зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хуулийн дагуу албадлага хэрэглэх үүрэгтэй. Эрүүдэн шүүхийн үйлдэлд хариуцлага хүлээлгэх нь чухал бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхэд улс төрийн хүсэл эрмэлзэл хэрэгтэй. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн мэдлэг, хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлэх нь маш чухал. Гэвч Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь хүн амын суурьшил ихтэй бүсүүдэд хүртээмж багатай байна. Энэ нь иргэдийн оролцоо, хууль сахиулах байгууллагын хүчин чадал, санхүүгийн нөөцөд шалтгаалан хууль зүйн орчныг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Хүний жам ёсны эрх болох эрүү шүүлтээс ангид байх эрх нь ямар ч нөхцөл байдалд үл хязгаарлагдах онцгой эрх бөгөөд үүний эсрэг үйлдэл нь хэзээ ч зөвтгөгдөх, эсвэл эвлэрэх боломжгүй. Эрүүдэн шүүлт нь ихэвчлэн мэдээлэл олж авах, гэм бурууг хүлээлгэх, айлгах зорилгоор хэнийг ч болов санаатайгаар хүнлэг бус харьцах, тохуурхах даажигнах, доромжлох үйлдэл бөгөөд мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх, хорих ангиудад далд хэлбэрээр үйлдэгддэг нь харамсалтай.

Эрүү шүүлтийн хор уршгаас урьдчилан сэргийлэхийн тулд олон нийтийн дунд энэ талаар мэдлэг ойлголтыг түгээх, хүний эрхийн мэдрэмжийг төлөвшүүлэх нь онцгой ач холбогдолтой. Эрүү шүүлтийн сөрөг үр дагаврыг нийгэмд ойлгуулах, энэ асуудалд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь чухал байгаа билээ.

Эрүүдэн шүүгдэх, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагыг Монгол Улсын Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн холбогдох заалтаар гэмт хэрэг, зөрчил хэмээн хуульчилсан. Гэвч эдгээр үйлдэл, эс үйлдэхгүйг хуулиар гэмт хэрэг, зөрчил гэж тооцох нь Төр үүргээ бүрэн хэрэгжүүлсэн гэсэн ойлголт биш юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг. Энэхүү үүргийн биелэлтийг хангахын тулд урьдчилан сэргийлэх Үндэсний цогц

тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулах талаар хуульчилсан.

Эндээс харахад, эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд тухайн нийгмийн сөрөг үзэгдлийг зайлшгүй судалж, түүний үндсэн дээр цогц арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь зөвхөн хууль эрх зүйн орчныг сайжруулах биш, мөн нийгмийн бүх түвшинд эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, хүний эрхийн ойлголтыг эрчимжүүлэх, эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй. Судалгааны үндсэн дээр, тусгайлан зорилтот стратегийг боловсруулах замаар эрүүдэн шүүлт, хүнлэг бус хандлагаас ангид байх эрхийг бодит байдалд хүргэх боломжтой юм. Иймэрхүү цогц арга хэмжээ нь нийгмийг хамгаалах, хүний эрхийг дээдлэх замаар шударга, аюулгүй байдлыг хангах чухал алхам болно.

Эрүүдэн шүүхтэй холбоотой тусгайлан хийгдсэн судалгаа Монгол Улсын хэмжээнд ховор бөгөөд энэ чиглэлээр бүтээл, судалгааны ажил байдаг. Жишээлбэл, П. Оюунчимэг 2010 онд «Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудлууд: онол, практик» сэдвээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд энэ нь уг асуудлыг гүнзгийрүүлэн судлахад жинтэй хувь нэмэр болж байна. Мөн Дотоод хэргийн их сургуулийн Б. Энхбат 2012 онд «Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нотлох ажиллагааны онол, практикийн асуудал» сэдвээр магистрын ажил хамгаалсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг нотлох баримт цуглуулах, нотлох ажиллагааг сайжруулахад чиглэсэн судалгааны чухал алхам юм.

Эдгээр судалгаанууд нь эрүүдэн шүүлттэй холбоотой асуудлуудыг гүнзгийрүүлэн судлах, хууль эрх зүйн орчныг сайжруулахын тулд чухал ач холбогдолтой болно. Гэвч үндэсний хэмжээний урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах судалгаа хомс байгаа нь тогтолцоог сайжруулахад бэрхшээл үүсгэж болзошгүй. Иймд энэ асуудлаар бодлогын судалгааг өргөжүүлэх шаардлага байгааг онцлох нь зүйтэй.

### **Судалгааны зорилго, зорилт**

Эрүүдэн шүүх гэсэн ойлголтыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүрээнд бус Эрүүгийн болон Зөрчлийн хуульд заасан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус харьцааны нийлбэр буюу гэмт явдал гэсэн өргөн хүрээгээр судлах оролдлого хийлээ.<sup>280</sup>

Судалгааны үр дүн нь Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ нь эрүүдэн шүүх

<sup>280</sup> “Гэмт явдал гэдэг нь түүхэн цаг хугацаа, нутаг орон, хүмүүсийн үнэт зүйл, зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг өөрийн гэсэн зүй тогтолцоотой нийгмийн сөрөг үзэгдэл, үйл явцын цогц ойлголт юм” Б.Батзориг, Г.Туяа, Г.Эрдэнэбат “Криминологи /гарын авлага” УБ., 2013., 23 дахь тал.

гэмт явдалд анхаарал хандуулах, эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулахад чиглэгдсэн болно. Иймд судалгааны явцад гарсан дүн, мэдээлэл нь хүний эрхийг бодитой хамгаалах, эрх зүйн тогтолцоог сайжруулахад бодлогын шийдвэр гаргахад хэрэгтэй суурь мэдээллийг бүрдүүлэхэд туслах боломжтой юм.

**Зорилго:** Энэхүү судалгаа нь эрүүдэн гэмт шүүх явдлын төлөв байдал, шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогчийн судлал, урьдчилан сэргийлэх чиглэлээр нарийвчлан судлах, хууль эрх зүйн болон үйл ажиллагааны бодлого, тодорхой шийдвэр гаргах чиглэлийг тодорхойлоход боломжийг олгох зорилготой болно.

Судалгааны зорилгын дагуу дараах тодорхой **зорилтуудыг** дэвшүүлж байна:

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, мөн үйлдэгдсэн байдлыг дүн шинжилгээ хийх.

Монгол Улсын хэмжээнд үйлдэгддэг эрүү шүүлт тулгах хэрэгт холбогдогч болон хохирогчийн байдалд дүн шинжилгээ хийх.

Хүний эрхийн үндэсний комисст (ХЭҮК) ирүүлсэн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагаар холбогдсон гомдлуудад дүн шинжилгээ хийх.

Иргэдээс эрүүдэн шүүх явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоохоос гадна урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлаар санал асуулга авч, дүн шинжилгээ хийх.

Мөн шинжээч нараас эрүүдэн шүүх явдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх тухай санал асуулга авч, дүн шинжилгээ хийх.

Тухайн судалгаануудын үр дүнд санал, зөвлөмжийг тусгасан судалгааны тайлан боловсруулан, захиалагчдад хүлээлгэн өгөх зэрэг тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн болно.

### **Судалгааны арга зүй**


Энэхүү судалгааг 2017-2024 онд бүртгэгдсэн Эрүүдэн шүүх гэмт явдалтай холбоотой гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг (төрийн нууцтай холбоотой гэмт хэрэг хамрагдаагүй болно) болон Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-т ирсэн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагаар ирүүлсэн гомдлуудыг (2020-2024 он) дүн шинжилгээ хийх, мөн эрүүдэн шүүхтэй холбоотой олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүд, холбогдох бусад баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх аргыг ашиглан явуулсан. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны тайлан, судалгаа болон МӨХ-оос хэрэгжүүлж буй «Өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа» (Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа. 2024) судалгааны ажлын тайлан дахь мэдээллийг тэдний зөвшөөрлөөр ашигласан болно.

Судалгааны явцад санал асуулгыг холимог аргачлалаар зохион байгуулж, санамсаргүй түүврийн аргаар сонгосон Нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн иргэд, төрийн албан хаагчид болон хуулийн сургуулийн оюутнуудыг оролцуулсан. Эдгээр судалгаанд мөрдөгч, прокурор, шүүгч, хуульчдыг хамруулаагүй болно. төрийн албан хаагч болон иргэд оролцсон. Нийт 832 хүчинтэй асуулгад дүн шинжилгээ хийж үр дүнг гаргалаа. Судалгааны өгөгдлийг

SPSS программ ашиглан боловсруулж дүн шинжилгээ хийлээ.


Судалгаанд оролцогчийн хүйсийн харьцаа тэнцүү, 18-69 настай хүмүүс судалгаанд хамрагдсанаас 90% нь 45 хүртэлх насны хүмүүс байна.

График 1. Насны бүлэг, хүйсээр




Нийт судалгаанд оролцогчийн 54% нь Бакалавр, 23 % нь Бүрэн дунд, 13% нь Магистр ба түүнээс дээш, 8% нь Техник мэргэжлийн /Тусгай дунд, үлдсэн 2% нь бүрэн бус дунд боловсролтой байна.

График 2. Боловсролын зэрэг



Өрхийн сарын дундаж орлого 1 сая хүртэлх 10%, 1000001-2000000 төгрөгийн орлоготой 38%, 2000001-3000000 төгрөгийн орлоготой 32%, 3000001-5000000 төгрөгийн орлоготой 17%, таван саяас дээш орлоготой иргэд 3% эзэлж байна. 70% нь нэгээс гурван сая төгрөгийн орлоготой хүмүүс хамрагдсан байна.

График 3. Өрхийн сарын дундаж орлого




Ажиллаж буй салбарыг төрийн, хувийн гэж хоёр ангилсан 79% нь төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчид байсан үлдсэн 21 хувь нь хувийн хэвшил, оюутан, тэтгэвэрт, гэрт, хөдөлмөр эрхлээгүй хүмүүс байв.



Насны ангилалтай харьцуулах харвал төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчаар ажилладаг хүмүүсийн дунд 26-45 насныхан, хувийн а бусад салбарт ажилладаг хүмүүсийн дунд 25 хүртэлх насныхан буюу залуучууд түлхүү хамрагдсан байна.

График 4. Насны бүлэг, ажил эрхлэлт




Шинжээчийн судалгаанд оролцогчдын 53% нь 46-аас дээш настай, 47% нь 45 хүртэлх настай, хүйсийн хувьд 53% нь эрэгтэй, 47% нь эмэгтэйчүүд хамрагдсан.

График 5. Шинжээчдийн насны бүлэг, хүйс




Боловсролын зэргийг харвал 42% нь Доктор түүнээс дээш байна. Мэргэжлийн хувьд 59% нь Хууль, өмгөөлөгч, 23% нь эрх зүйч, үлдсэн 18% нь бусад мэргэжлийн ажил хийдэг судлаачид байна.

График 6. Шинжээчдийн мэргэжил



Ажиллаж буй салбарын хувьд 28% нь Хувийн хэвшилд, 22% нь Төрийн тусгай, 22% нь Төрийн захиргаа, 11% нь ШУ боловсролын салбар, 11% нь Төрийн бус байгууллага, үлдсэн 6% нь Төрийн өмчит хуулийн этгээд/компанид ажилладаг байна.

График 7. Ажиллаж буй салбар



Албан тушаалын хувьд 42% нь Удирдах, 31% нь Гүйцэтгэх, 21% нь Зөвлөх байгаа бол, ажлын туршлага нь 53% нь 20 хүртэлх жил, 47% нь 21-ээс дээш жилийн туршлагатай хүмүүс хамрагдсан байна.

График 8. Эрхэлдэг ажил, албан тушаал, ажилласан жил



## ХОЁР. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛЫН ОЙЛГОЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 2.1. Эрүүдэн шүүх гэмт явдлын ойлголт

Эрүүдэн шүүх гэмт явдлыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг” гэж ойлгох нь Авлигатай тэмцэх газрыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.4, 22.5 дугаар зүйлд заасан Хахууль авах, өгөх гэмт хэрэгтэй тэмцэх газар болгон хязгаарлахтай буй адил юм.

Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталснаар **“эрүүдэн шүүх”** болон **“хүний нэр төрийг доромжлон харьцах”, “хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрх”**-ийг олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулах суурийг тавьсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг<sup>281</sup>, түүнчлэн 2002 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг<sup>282</sup> тус тус баталсан.

Хүний нэр төрийг доромжлох нь хэрцгий, хүнлэг бусаар харьцах, шийтгэх гэсэн ойлголтоос ялгаатай. Энэ үйлдэл нь хүчтэй шаналал үүсгэх биш, харин хүнийг доромжлох, гутаах зорилгын үүднээс үйлдэгддэг. Тухайлбал, бусдын өмнө хувь хүнийг бүдүүлгээр доромжлох, хоригдсон, саатуулагдсан этгээдийг хиртэй, бохир хувцастай нь удаан хугацаанд байлгах, бие эрхтний доголдол, халдварт өвчнийх нь талаар бусдад дэлгэх, нойргүйдүүлэх, “стресс, дарамт шахалт” учруулах, бэлгийн болон нийгмийн “цөөнх” бүлэгт хамаардаг этгээдийн эмзэг мэдээллийг бусдад задруулах, хүний нүцгэн зургийг авч бэлгийн доромжлолд оруулах, бусдын дэргэд нүцгэлэх, эмзэг эрхтэнд халдах, бусдын өмнө гутаан доромжлох үйлдлүүдийг багтаан ойлгож болно. Эдгээр төрлийн арга нь хэдийгээр бие махбодод шарх сорви үлдээдэггүй ч удаан үргэлжилдэг, хэзээ ч бүрэн эдгэдэггүй сэтгэцийн гэмтэл учруулдаг.

**“Эрүүдэн шүүх”** гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.” гэж томъёолсон<sup>283</sup>.

<sup>281</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 дугаар тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг баталж, 2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр тус конвенцыг Улсын Их Хурал соёрхон баталсан. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

<sup>282</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн Тавиндолдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг баталж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

<sup>283</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

**“Хүний нэр төрийг доромжлон харьцах”** үйлдэл нь хүний нэр төрийг бодитой, ноцтойгоор гутаасан, доромжилсон шинжтэй үйлдэл, тиймээс ч оюун ухаант ямар ч хүнийг эгдүүцэхүйц хэмжээнд хүргэж, шаналган зовоодог чанартай. Европын Хүний эрхийн комиссоос “хохилогчийг бусдын өмнө бүдүүлгээр доромжлох, баривчлагдсан этгээдийг хүсэл зориг, ухамсрынх нь эсрэг үйлдэл хийхэд түлхэц өгөх”-д чиглэсэн харьцаа, шийтгэлийн хэлбэр гэж тодорхойлсон байдаг<sup>284</sup>.

**“Хэрцгий, хүнлэг бусаар харьцаж, шийтгэх”** үйлдэл нь бие махбодын болон сэтгэл санааны хувьд ноцтой өвдөлт, зовлон зүдгүүрийг үүсгэдэг, эсвэл хувь хүний нэр төрд ноцтойгоор халдсан үйлдлээс бүрдэнэ. Эрүүдэн шүүхээс ялгаатай нь эдгээр үйлдлийг тодорхой зорилгоор хийх шаардлагагүй. Хэрцгий буюу хүнлэг бус харьцах арга хэлбэрийг гэр бүлийн гишүүдэд нь сэтгэл санааны зовлон шаналал учруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсвэл эмчилгээг буруугаар ашиглах, зохисгүй нөхцөлд цагдан хорих, саатуулах зэрэг үйлдлээр жишээ болгон тайлбарлаж болно<sup>285</sup>.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.» гэж заасан байдаг. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын энэхүү тодорхойлолт нь тодорхой зорилгоор шууд ба шууд бусаар оролцсон төрийн албан хаагчийн санаатай үйлдлээр учирсан сэтгэл санаа, бие махбодын хохирол нь эрүү шүүлтийг эрх зүйн бусад зөрчлөөс ялгах гол шинж юм.

Эрүүдэн шүүх гэмт явдлыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан «Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг» гэж ойлгох нь Авлигатай тэмцэх газрыг хахууль авах, өгөх гэмт хэрэгтэй тэмцдэг газар болгон хязгаарлахтай адил юм.

Энэ хандлага нь эрүү шүүлт тулгаж буй үйлдлийг зөвхөн тодорхой хүрээнд авч үзээд, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга барил, зохицуулалтыг хэрэгжүүлэхийг үл тоомсорлоход хүргэдэг. Эрүүдэн шүүхийг зөвхөн нэг төрлийн гэмт хэрэгтэй холбон ойлгохын оронд, хүний эрхийг зөрчих аюултай илүү өргөн хүрээнд судлах нь чухал.

Иймэрхүү хандлага нь хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулахад туслах, илүү үр дүнтэй шийдэл гаргахад зайлшгүй шаардлагатай юм.

Иймд бид Эрүүдэн шүүх гэмт явдалд дараах гэмт хэргүүдийг хамруулсан бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Үүнд: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах 2.12 “эрүүдэн шүүх хүнийг алах”, 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйл. ийн 2 дахь хэсэгт

<sup>284</sup> [Torture and other forms of ill-treatment: The definitions used by the ICRC | International Committee of the Red Cross](#)

<sup>285</sup> [Torture and other forms of ill-treatment: The definitions used by the ICRC | International Committee of the Red Cross](#)

заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 2 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах, 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах, 21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, 21.4 дүгээр зүйл. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах, 21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх, 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах, 21.13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих, 21.14 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэргүүд. Эдгээр гэмт хэргүүдэд эрүүдэн шүүх бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцсан шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг агуулж байдаг. Иймд эдгээр нь эрүүдэн шүүх гэмт явдалд хамаарах эсэхийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага бий болж байна.

## **2.2. Эрүүдэн шүүх гэмт явдлын нөхцөл байдал**

### **2.2.1. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ / Бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн/**

Монгол Улсын хэмжээнд 2017 оны сүүлийн хагасаас 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 603 мянган гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч шалгажээ. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх 478 гомдол, мэдээлэл шалгагдсан нь нийт гомдол мэдээллийн 0,08%-ийг эзэлж байна. Эдгээр 478 гомдол мэдээллийн 323 буюу 67%-ийг нь прокурор мөрдөгчийн саналыг үндэслэл үзэж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн 150 буюу 31,4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээжээ. 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг, хэрэг бүртгэлтийн шатанд 196 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 163 буюу 83,2%-ийг нь хааж, 18 хэрэг буюу 9,2%-д эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 5 буюу 2,5%-ийг нь бусад хэрэгт нэгтгэж шийдвэрлэсэн 286 байна.

2023 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 буюу “хууль бусаар баривчлах”, 14.1 буюу “ялгаварлан гадуурхах”, 21.12 буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжтэй бүртгэгдсэн 87 гомдол, мэдээллийн 64 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 20 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 3 гомдол, мэдээлэлд Эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан байна. Үүнд: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу “хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэрэгт цагдаагийн алба хаагч холбогдсон 5 гомдол, мэдээлэл шалгагдсанаас 4 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл буюу “ялгаварлан

286 Монгол Улсын их хурлаас “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын дэлгэрэнгүй тэмдэглэл. 2024.11.20 өдөр.

гадуурхах” гэмт хэрэгт алба хаагч холбогдсон талаарх гомдол, мэдээлэл 2023 онд ирээгүй байна.

Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан үндэслэлийг нь аваад үзвэл 160 гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 3 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хааж шийдвэрлэсэн. Дээрх хугацаанд нийтдээ 22 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 2 хэргийг нь хэрэгсэхгүй болгосон 36 хүнд холбогдох 18 хэргийг шүүхэд шилжүүлсэн. Одоо 2 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байна. Шүүхэд шилжүүлсэн 38 хүнд холбогдох шүүхэд шилжүүлсэн 18 хэргээс 30 хүнд холбогдох 14 хэргийг эцэслэн шийдвэрлэгдсэн энэ 14 хэргийн 28 хүнийг нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 2 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгасан<sup>287</sup> байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулгаас үзэхэд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад б чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулж нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ албан хаагчид болон хорих ял эдэлж байгаа, цагдан хоригдож байгаа иргэдтэй ярилцлага, хийж асуумж авч ажилласан тухай тусгасан байна. Энэхүү ажлын тайланд, хорих ангийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхэд гардаг хүндрэл, бэрхшээлүүд байсаар байна. Тухайлбал, ажлын байрны бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт 2023 онд өссөн үзүүлэлттэй, амралтын болон баяр ёслолын үеэр амардаггүй, ажлын илүү цаг, нөхөн олговор авдаггүй байдал өндөр хувьтай хэвээр, удирдлага болон хамт ажиллагсад хоригдсон этгээдүүдийн зүгээс хэл амаар доромжлох, гүтгэх, ялгаварлан гадуурхдаг байдал буураагүй байна. Мөн ажлын ачаалал их, олон цагаар ажиллуулдаг байдал өндөр хувь эзэлжээ. Эндээс эрүүдэн шүүлтийн хохирогч нь хууль сахиулагчид өөрсдөө ч болдог гэдгийг харж болно.


Мөн дээрх тайланд 2023 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 буюу “хууль бусаар баривчлах”, 14.1 буюу “ялгаварлан гадуурхах”, 21.12 буюу “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжтэй бүртгэгдсэн 87 гомдол, мэдээллийн 64 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 20 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 3 гомдол, мэдээлэлд Эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан байна. Үүнд: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл буюу “хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэрэгт цагдаагийн алба хаагч холбогдсон 5 гомдол, мэдээлэл шалгагдсанаас 4 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл буюу “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт алба хаагч холбогдсон талаарх гомдол, мэдээлэл 2023 онд ирээгүй байна.

Шүүхээр шийдвэрлэсэн “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг авч үзвэл, Сүүлийн 20 жилийн хугацаанд 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлийн 251.1 дэх хэсэгт зааснаар шийдвэрлэсэн 2 хэрэг, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12.1 дэх хэсэгт зааснаар шийдвэрлэсэн 17 хэрэг, нийт 19 эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна. Үүнээс 18 хэрэгт ял шийтгэл оногдуулсан бол, 1 хэргийг цагаатгаж шийдвэрлэжээ.

<sup>287</sup> Мөн тэнд.




График 9. Шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг зүйлчилсэн байдал, тоогоор



Эрүү шүүлт тулгах буюу 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар анх 2016 онд Өмнөговь аймгийн сум дундын анхан шатны шүүхээр 1 хэргийг шийдвэрлэсэн байна.

График 10. “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн он, тоогоор



Шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргүүдийг үйлдлийн аргаар нь ангилан үзвэл, хэрэг хүлээлгэх, тайлбар мэдүүлэг авах зорилгоор, гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүн, цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлагдаж байсан хүнийг зодож, эрүүл мэндэд нь хохирол учруулсан 11 тохиолдол, хууль бусаар удаан хугацаанд саатуулсан 1 тохиолдол, хэл амаар доромжилсон 2 тохиолдол, цахилгаан болон резинэн бороохойгоор зодож, тарчлаасан 5 тохиолдол байна.

График 11. Гэмт хэргийн үйлдлийн арга, тоогоор




Хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэргийн хөнгөн ангилалд, 2002 оны Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар гэмт хэргийн хүндэтгэр ангилалд хамаарч байна. Үүнээс үзэхэд нийт шүүхээр шийдвэрлэсэн хэргийн 89.4 хувь нь гэмт хэргийн хөнгөн, 10.6 хувь нь хүндэтгэр ангилалд хамаарч байна.

График 12. Үйлдсэн гэмт хэргийн ангилал, тоогоор



Нийт шүүхээр шийдвэрлэсэн “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн 14 буюу 73.7 хувийг шүүгдэгч ганцаараа үйлдсэн бол, 5 буюу 26.3 хувийг бусадтай бүлэглэж үйлдсэн байна.


График 13. Гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр, тоогоор



Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрсөн үйлдэл, эс үйлдэхүй байхаар заасан. Мөн энэ төрлийн гэмт хэрэг нь дээр дурдсан үйлдлийн улмаас бусдын бие махбод, сэтгэл шанааг шаналган зовоосон үр дагавар үүссэн байхыг шаардах бөгөөд, өөрөөр хэлбэл материаллаг бүрэлдэхүүнтэй байна<sup>288</sup>. Гэмт хэрэг үйлдэх үе шатны үүднээс авч үзэхэд, 19 гэмт хэрэг буюу шүүхээр шийдвэрлэсэн хэргийн 100 хувь нь төгссөн байна.

<sup>288</sup> Гантулга, С. Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги сурах бичиг. Уб., 2024. 339 дэх тал.

График 14. Гэмт хэрэг төгссөн байдал, тоогоор



### (NPM) 2.2.2. ХЭҮК болон ЭШУСҮА-нд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандсан талаар ирүүлсэн гомдол хийсэн дүн шинжилгээ

Сүүлийн 5 жилийн хугацаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцсан гэх нийт 239 өргөдөл, хүсэлт ирүүлсэн байна. Тодруулбал, 2020 онд 47, 2021 онд 27, 2022 онд 11, 2023 онд 59, 2024 онд 95 гомдол, хүсэлт ирүүлснийг, хуульд заасан үндэслэл журмын дагуу бүртгэн авч, шийдвэрлэж, хариу өгсөн байна<sup>289</sup>.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-нд 2023, 2024 онд ирүүлсэн нийт 154 гомдол, мэдээллийн 55 нь цагдаагийн байгууллагын алба хаагчтай, 4 нь прокурорын байгууллагын алба хаагчтай, 3 нь Авлигатай тэмцэх газрын мөрдөгчтэй, 1 нь шүүгчтэй, 45 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчтай холбоотой байсан. Тус гомдол, мэдээллийг хүлээн авч, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ ажиллагаа явуулж гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байж болзошгүй 34 гомдлыг Авлигатай тэмцэх газарт, 3 гомдлыг Цагдаагийн байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн байна.

График 15. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо, тоогоор



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) -д сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2022-2024 онд бүртгэгдсэн өргөдөл биечлэн танилцаж, ирүүлсэн гомдол мэдээллийг төрлөөр нь ангилж үзэхэд, дийлэнх гомдлыг шүүх,

<sup>289</sup> ХЭҮК, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 5 жилийн хугацаанд ирүүлсэн гомдол, мэдээллийн бүртгэл.

прокурор, мөрдөгч, хорих байгууллагын ажилтан, өмгөөлөгчид харьяалуулан ирүүлжээ.

Өргөдөл, гомдлыг агуулгын хувьд ангилан үзвэл, шүүхийн байгууллагад харьяалуулан ирүүлсэн гомдлыг агуулгаар нь ангилан үзвэл, хавтаст хэргийн материалыг өөрчилсөн, цагдан хорих хугацааг хуульд заасан хугацаанд сунгаагүй, эрх зүйн байдал дордуулсан шийдвэр гаргасан, хүсэлтийг хуульд заасны дагуу шийдвэрлээгүй, хувийн өс хонзонгоор, ашиг сонирхлын зөрчилтэй шүүгч шийдвэр гаргасан, үндэслэлгүй цагдан хорьсон тухай гомдлууд дийлэнх хувийг эзэлж байна.

Прокурорын байгууллагад холбогдуулан ирүүлсэн гомдлуудыг харьцуулан үзэхэд, хэрэг прокурорын шатанд байх хугацаанд хэргийн яллагдагчийг шалтгаангүй байгууллагын үүдэнд удаан хугацаагаар суулгадаг, гэмт хэрэгтэн хэмээн хүнлэг бусаар харьцдаг, цагдан хорьсон хугацааг буруу тоолдог, хэт нэг талыг барьсан шийдвэр гаргадаг гэх агуулгатай гомдлыг дийлэнхдээ гаргасан байна.

Цагдаагийн алба хаагчдад холбогдуулан ирүүлсэн гомдлын дийлэнх хэсгийг мөрдөгчдөд холбогдуулан гаргасан гомдлууд эзэлж байх бөгөөд агуулгаар нь ангилан үзэхэд дийлэнх гомдлыг хилс хэрэг хүлээлгэсэн, зодож дарамталсан гомдол эзэлж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлсэн гомдлын дийлэнх хувийг хорих байгууллагын ажилтанд холбогдуулан гаргасан гомдол гаргажээ. Тэдгээрт хоригдолтой хүнлэг бус харьцсан, зодож, дарамталсан, үндэслэлгүй сахилгад суулгасан, ажлын хоног тооцохгүй, хууль бус шийдвэр гаргасан, хамт байгаа хоригдлуудаар дарамтлуулдаг гэсэн гомдлууд дийлэн хувийг эзэлж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний нэр дээр ирүүлсэн дээрх гомдол мэдээллийг хянан үзэж, гомдол гаргагчид хууль зүйн зөвлөгөө өгч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг харьяаллын дагуу мөрдөн шалгах байгууллагуудад шилжүүлж, бусад гомдлыг холбогдуулан гаргасан байгууллагуудын удирдлагуудад шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Тухайлбал, 2024 онд бүртгэгдсэн нийт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл эрх нь зөрчигдсэн гэх хорих ял эдэлж байгаа хоригдогч нартай биечлэн уулзаж зөвлөгөө өгсөн, хоригдогчид өөрт нь хандаж албан бичгээр хариу хүргүүлсэн 28, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад хандаж шилжүүлсэн 13, Улсын ерөнхий прокурор, харъяа прокурорын газруудад хандаж шилжүүлсэн 8, Авлигатай тэмцэх газарт хандаж шилжүүлсэн 15, бусад холбогдох газруудад хандаж шилжүүлсэн 12, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хандаж хоригдогчоос талархал илэрхийлсэн 1 хүсэлт байна.

График 16. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал (2024 он), тоогоор



Монгол Улс 2000 онд НҮБ-ын “Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах буюу шийтгэхийн эсрэг конвенц” (1984)-д нэгдэн орж, соёрхон баталсан. Мөн Монгол Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол /цаашид “Нэмэлт протокол” гэх/-ыг батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Үүний зэрэгцээ, Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн 7 дугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-н зохицуулалтыг хуульчилсан.

Мөн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзэж, ял шийтгэх оногдуулах” гэсэн заалтын дагуу эрүүдэн шүүх явдлыг бие даасан гэмт хэрэгт тооцсон байна.

Үүнээс үзэхэд, эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин тодорхой түвшинд бүрдсэн хэдий ч, эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх гэмт явдал хэмжээнд оршсоор, цаашлаад жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байгаа нь эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн сул талыг харуулж байна.

### 2.2.3. Бусад гэмт хэрэг<sup>290</sup>

Бид өмнөх хэсгүүдэд Эрүүдэн шүүх гэмт явдал Монгол Улсын Эрүүгийн хуулийн хуулийн 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах 2.12 “эрүүдэн шүүх хүнийг алах”, 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйл. ийн 2 дахь хэсэгт заасан

290 УЕП газраас Хүний эрхийн комиссын гишүүн Я.Цэлмэнд ирүүлсэн тоон мэдээллийг ашиглав.

хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 2 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах, 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах, 21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, 21.4 дүгээр зүйл. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах, 21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх, 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах, 21.13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих, 21.14 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах, гэмт хэргүүдийг тус тус харгалзан авч үзсэн.


Судалгааны ажлын хүрээнд эдгээр гэмт хэргийн криминологи шинжийг тусгайлан судлах зорилго агуулаагүй ч, бүртгэгдсэн гэмт хэргийн хүрээнд тоон мэдээллийг орууллаа. Уг тоон мэдээлэл нь ерөнхийд нь эрүүдэн гэмт явдлын асуудлыг ойлгох, тухайн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг цаашид тодорхойлох, танин мэдэх бусад гэмт хэргүүдийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах боломжтой.

Монгол Улсын хэмжээнд 2020-2024 онуудад Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүрээнд бус мөн хуулийн 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах 2.12 “эрүүдэн шүүх хүнийг алах”, 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн” гэмт хэрэг бүртгэгдээгүй.

Мөн хуулийн 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйл. ийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн” гэмт хэрэг 2022, 2024 онд тус тус 1 нийт 2 гэмт хэрэг бүртгэгдэж шүүхэд шилжсэн.




График 17. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйл «хууль бусаар баривчлан, саатуулах»



Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар баривчлах, саатуулах” гэмт хэрэг 2020-2024 онуудад нийт 25 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 5 эрүүгийн хэрэг нь шүүхэд шилжсэн байна.


График 18. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл «ялгаварлан гадуурхах»



Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлд заасан “Ялгаварлан гадуурхах” гэмт хэрэг 2020-2024 онуудад нийт 22 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 2 эрүүгийн хэрэг нь шүүхэд шилжсэн байна.


Хууль бусаар баривчлах, саатуулах, Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн дээрх статистик мэдээлэл нь цаашид эдгээр гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарал хандуулж Эрүүгийн процесс хуулийн хэрэгжилт, хүний эрхийн зөрчилтэй холбоотой нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн шинжлэн судлахад шаардлагатайг илтгэнэ.

График 19. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйл «нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах»



Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйлд заасан “Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах” гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээлэлд дурдсанаар 2020-2024 онуудад нийт 692 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 118 эрүүгийн хэрэг нь шүүхэд шилжсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад, энэ төрлийн гэмт хэргүүдийн гаралт тогтвортой нэмэгдэж буй нь анхаарал татаж байна.


График 20. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.4 дүгээр зүйл «шинжээч зориуд худал дүгнэлт гаргах»



Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.4 дүгээр зүйлд заасан «Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах» гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээлэлд дурдсанаар, 2020-2024 онуудад нийт 70 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 2 эрүүгийн хэрэг нь шүүхэд шилжсэн байгаа нь анхаарал татаж байна.

Шүүхэд шилжсэн хэрэг нь бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3 хувийг эзэлж байгаа нь шүүхэд шилжиж байгаа энэ төрлийн гэмт хэргийн тоо харьцангуй бага байгааг харуулж байна.

График 21. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.5 дугаар зүйл «гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх»



Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэрэгтэй холбоотой статистик мэдээлэлд дурдсанаар 2020-2024 онуудад нийт 77 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 66 эрүүгийн хэрэг нь шүүхэд шилжсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, 21.4 дүгээр зүйл. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах, 21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэргүүдийн статистик мэдээллээс харахад гэмт хэргийн давтамж, түвшин нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь хууль зүйн тогтолцоонд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэрэг 2020-2024 онуудад нийт 5, мөн хуулийн 21.14 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэрэг 23 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.





холбоотой асуудалд сэтгэл зүйн дарамт, айдас зэрэг сөрөг нөлөөллийг харгалзсан шинж чанартайг илтгэж байна.


Түүнчлэн, 31 хувь нь «мэдэхгүй» гэж хариулсан нь энэ асуудлын талаар илүү тодорхой ойлголт байхгүй байгааг хэлнэ. Судалгааны үр дүн нь иргэдийн дунд эрүүдэн шүүх гэмт явдлын ойлголт, тэр дундаа сэтгэл зүйн дарамтын асуудалд анхаарал хандуулах хэрэгтэйг онцлон илэрхийлж байна.

Судалгаанд хамрагдсан шинжээчдийн дунд Монгол Улсад эрүүдэн шүүх явдал хэр түгээмэл болохыг тодруулахад, 40% нь «дунд зэрэг» гэж тодорхойлсон байна. Мөн 20% нь «түгээмэл», 20% нь «бага зэрэг» гэсэн бол, 5% нь «ихээхэн түгээмэл» гэж үзсэн байна. Энэ үнэлгээ нь эрүүдэн шүүх гэмт явдалд анхаарал хандуулах хэрэгтэйг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан хуулийн сургуулийн оюутнуудын 31% нь дунд зэрэг, 23% нь мэдэхгүй/хариулаагүй, 11% нь огт байхгүй гэж хариулжээ.


Судалгаанд хамрагдсан иргэдийн ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал хэр түгээмэл болохыг тодруулахад 35% нь “Мэдэхгүй/хариулаагүй”, 29% нь “Огт байхгүй”, 16% нь Бага зэрэг, 14% нь “Дунд зэрэг”, 4% нь Түгээмэл, 2% нь Ихээхэн түгээмэл гэж үзсэн.

График 23. Ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал хэр түгээмэл байдал




Ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал Түгээмэл, Ихээхэн түгээмэл гэж хариулсан (6%) хүмүүсийн дүр төрх гаргавал дараах зураглал гарч ирж байна.

График 24. Эрүүдэн шүүх явдал түгээмэл байна /Дүр төрх/




Эрүүдэн шүүх ойлголтын талаар Маш сайн, сайн мэдэж байгаа хүмүүс ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх явдлыг байхгүй гэж үзэж байна.

График 25. Эрүүдэн шүүх ойлголтын талаар Маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс Ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал хэр байгааг үнэлсэн байдал



Харин ажиллаж, амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх гэмт явдал байдаг гэсэн ойлголт төрийн байгууллагаас бусад салбарт ажиллаж байгаа хүмүүсийн дунд илүү түгээмэл байна.

График 26. Ажиллаж буй салбар ба амьдарч буй аймаг /нийслэл/-д эрүүдэн шүүх явдлын түгээмэл байдал



Өнгөрсөн 3 жилийн хугацаанд эрүүдэн шүүх явдлын талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 1/3 нь огт сонсоогүй байна. Энэ нь эрүүдэн шүүхийн асуудал нийгэмд хэр бодитой, чухал болохыг илтгэхгүй байгаа бөгөөд мэдээллийн хомсдолтой холбоотой байж болно.

Фейсбүүк болон нийгмийн сүлжээнээс эрүүдэн шүүхтэй холбоотой мэдээллийг хамгийн ихээр авч байна. Энэ нь нийгмийн мэдээллийн платформууд нь мэдлэг, мэдээлэл цуглуулах гол эх сурвалж болж байгааг харуулж байна.

Иймд эрүүдэн шүүхийн асуудлаар олон нийтэд тогтмол мэдээлэл өгөх, энэ чиглэлээр нийгмийн сургалтыг зохион байгуулах, тэр дундаа нийгмийн сүлжээг ашиглан энэ асуудлыг олон нийтэд хүргэх нь чухал юм.

Эрүүдэн шүүх гэмт явдал ямар үйл ажиллагаанд илүү бага болон илүү түгээмэл байгааг шинжээч нар дараах байдлаар үнэлж байна.

Эрүүдэн шүүх гэмт явдал Эрүүгийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх явцад, Хорих байгууллагын ажилтан захиалгаар дарамтлахын тулд, тусгай зөвшөөрөл олгох, сунгахад, Төрийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ихэвчлэн гардаг гэж үзсэн байна. Харин Мөрдөгч хэрэг хүлээлгэх, Мөрдөгч үйл ажиллагаагаа хөнгөвчлөх, Прокурор хэрэг хүлээлгэх, Цагдан хорих байгууллагын ажилтан цээрлүүлэх, Хорих байгууллагын ажилтан дэг журам тогтоохын тулд, Төрийн удирдах албан тушаалтан ажилтнаа халах, чөлөөлөх хүсэлт гаргуулахын тулд, Төрийн албан хаагч тайлбар авах явцад, Цагдаагийн албан хаагчид жагсаал цуглааныг тараахад, Цагдаагийн албан хаагчид нийгмийн хэв журам сахиулахад, Цэргийн байр, танхимд бага зэрэг байгаа гэжээ.

Хүснэгт 1. Эрүү шүүлт тулгах үйлдэл

№	Тохирох утга	Огт байхгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Их талдаа	Маш их	Хариулаагүй	Нийт
1	Мөрдөгч хэрэг хүлээлгэх	30%	40%	15%	10%	0%	5%	100%
2	Мөрдөгч хэргийг цагаатгахад	0%	0%	20%	25%	15%	40%	100%
3	Мөрдөгч үйл ажиллагаагаа хөнгөвчлөх	0%	50%	5%	20%	0%	25%	100%
4	Прокурор хэрэг хүлээлгэх	25%	35%	10%	15%	10%	5%	100%
5	Прокурор хэргийг цагаатгахад	0%	0%	20%	25%	15%	40%	100%
6	Прокурор үйл ажиллагаагаа хөнгөвчлөх	15%	10%	30%	10%	10%	25%	100%
7	Шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд	0%	10%	15%	35%	15%	25%	100%

8	Цагдан хорих байгууллагын ажилтан цээрлүүлэх	25%	25%	20%	20%	5%	5%	100%
9	Хорих байгууллагын ажилтан дэг журам тогтоохын тулд	5%	30%	15%	20%	5%	25%	100%
10	Хорих байгууллагын ажилтан захиалгаар дарамтлахын тулд	0%	5%	20%	35%	5%	35%	100%
11	Төрийн удирдах албан тушаалтан ажилтнаа халах, чөлөөлөх хүсэлт гаргуулахын тулд	10%	45%	20%	15%	5%	5%	100%
12	тусгай зөвшөөрөл олгох, сунгахад	10%	20%	30%	30%	0%	10%	100%
13	Төрийн албан хаагч тайлбар авах явцад	5%	45%	15%	30%	0%	5%	100%
14	Төрийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд	10%	10%	25%	45%	5%	5%	100%
15	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд	25%	5%	25%	40%	0%	5%	100%
16	Цагдаагийн албан хаагчид жагсаал цуглааныг тараахад	0%	45%	30%	15%	5%	5%	100%
17	Цагдаагийн албан хаагчид нийгмийн хэв журам сахиулахад	0%	35%	35%	20%	5%	5%	100%
18	Асрамжийн газарт	0%	5%	30%	25%	25%	15%	100%
19	Орон гэргүй иргэнийг нийгэмшүүлэх түр хоноглох байранд	5%	5%	30%	20%	15%	25%	100%
20	Цэргийн байр, танхимд	5%	30%	20%	20%	0%	25%	100%

Шинжээчид Эрүү шүүлт нь улс төрийн өрсөлдөгчөө дарах арга болсон, Эрүүдэн шүүх гэмт явдал нь хууль сахиулах байгууллагаас гадна төрийн албан хаагчид иргэд, бизнес эрхлэгчдээс мэдээ сэлт авах, тайлбар авах явцад байдаг, Эрүү шүүлт тулгахгүйгээр үйл ажиллагаа явуулах талаарх сургалтын гарын авлага хангалтгүй байдаг гэдэгтэй санал нийлж байгаа бол эсрэгээрээ Төрийн байгууллагын албан хаагчид хэрэгтэй үед найдвартай тусалдаг, Төрийн байгууллагын албан хаагчидтай харилцах шаардлага гарсан үед тантай хүндэтгэлтэй харьдаг, Төрийн байгууллагын албан хаагчид хүмүүсийг хэн гэдгээс нь үл хамааран бүгдтэй тэгш харьцдаг, Төрийн байгууллагын албан хаагчид ажлаа сайн хийдэг гэдэгт итгэдэг, Төрийн байгууллагын албан хаагчид хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүйгээр харьцаж чаддаг, Төрийн байгууллагын

албан хаагчид хүмүүсийг сэтгэл санаагаар дарамтлахгүйгээр асуудлыг шударгаар шийдвэрлэж чаддаг гэдэгтэй санал нийлэхгүй байна.

Хүснэгт 2. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаарх шинжээчийн үнэлэмж

№	Тохирох утга	Санал бүрэн нийлж байна	Нийлэх талдаа	Нийлэхгүй	ОГТ нийлэхгүй	Хариулаагүй	Нийт
1	Эрүү шүүлт нь улс төрийн өрсөлдөгчөө дарах арга болсон	10%	70%	10%	10%	0%	100%
2	Төрийн байгууллагын албан хаагчид хэрэгтэй үед найдвартай тусалдаг.	5%	35%	45%	10%	5%	100%
3	Төрийн байгууллагын албан хаагчидтай харилцах шаардлага гарсан үед тантай хүндэтгэлтэй харьдаг	0%	40%	45%	10%	5%	100%
4	Төрийн байгууллагын албан хаагчид хүмүүсийг хэн гэдгээс нь үл хамааран бүгдтэй тэгш харьцдаг	0%	5%	55%	35%	5%	100%
5	Төрийн байгууллагын албан хаагчид ажлаа сайн хийдэг гэдэгт итгэдэг	20%	25%	45%	5%	5%	100%
6	Төрийн байгууллагын албан хаагчид хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүйгээр харьцаж чаддаг	0%	25%	70%	0%	5%	100%
7	Төрийн байгууллагын албан хаагчид хүмүүсийг сэтгэл санаагаар дарамтлахгүйгээр асуудлыг шударгаар шийдвэрлэж чаддаг	0%	25%	70%	0%	5%	100%
8	Эрүүдэн шүүх гэмт явдал нь хууль сахиулах байгууллагаас гадна төрийн албан хаагчид иргэд, бизнес эрхлэгчдээс мэдээ сэлт авах, тайлбар авах явцад байдаг	20%	55%	15%	5%	5%	100%
9	Эрүү шүүлт тулгахгүйгээр үйл ажиллагаа явуулах талаарх сургалтын гарын авлага хангалтгүй байдаг	35%	40%	20%	0%	5%	100%

Эрүүдэн шүүх гэмт явдал ирээдүйд ямар байх талаар ямар нэгэн төсөөлөл байхгүй байгаа ч өнгөрсөн үеийн нөхцөл байдлыг харьцуулахад нөхцөл байдал тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн гэж үзэж байна.


Өнгөрсөн жилүүдэд эрүүдэн шүүх гэмт явдлын талаар нийгмийн дунд илүүтэй мэдэгдэхүүнтэй болж, хүний эрхийн зөрчил, хууль зүйн тогтолцооны асуудлуудад ихээхэн анхаарч, олон нийт, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах болсноор, нийгмийн ухамсарт эерэг хандлагаар нөлөөлж байна.

Ирээдүйд, эрүүдэн шүүх байдал буурна гэсэн эерэг төсөөлөлтэй байгаа нь хүний эрхийг хамгаалах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, үр дүнтэй сургалт, мэдээллийг бий болгоход чиглэгдсэн олон дахин хүчин чармайлт гарснаар холбоотой гэж үзэж болох юм.

График 27. Өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?



График 28. Ирэх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдөх вэ?



Төрийн байгууллагад ажилладаг эсэхээр нь нарийвчлан харьцуулахад, өнгөрсөн хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөн эсэхийг аль аль нь тодорхой мэдэхгүй боловч төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчид «өөрчлөгдсөн» гэж үзэх нь өндөр хувьтай байна. Үүний зэрэгцээ, хувийн хэвшлийн төлөөлөл болох иргэд «өөрчлөгдөөгүй» гэсэн хандлагатай байгаа нь сонирхолтой.



Ирэх хоёр жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдөх тухайд мөн мэдэхгүй гэсэн хариулт хамгийн их байгааг онцлох нь чухал. Гэсэн хэдий ч, өөрчлөлтийн асуудлаар аль аль нь «буурна» гэсэн ижил хүлээлттэй байна.

Энэ хариултууд нь төрийн албан хаагчид болон иргэдийн дунд эрүүдэн шүүхийн асуудалд хандах хандлага, ойлголтын ялгааг харуулж байна. Төрийн байгууллагын ажилтнууд илүү тодорхой мэдээлэлтэй байж, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч байгаа бол хувийн хэвшлийн иргэд тийм ач холбогдолтой гэж хараагүй байх нь байж болох юм.

Энэхүү зөрүүтэй хандлага нь цаашид иргэдэд мэдээлэл өгөх, сургалт явуулах эрэлт байгааг илэрхийлэх бөгөөд, эрүүдэн шүүх гэмт явдалд нийгмийн анхаарлыг татах, хүний эрхийг хамгаалах чиглэлээр зөвлөмж, арга хэмжээг авах шаардлагатай байна.

График 29. Ажиллаж буй салбар ба өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөн байдал



Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар Маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүсийн хариултыг ялгаж харвал өнгөрсөн болон ирээдүйн дүгнэлт төсөөлөл ерөнхий үр дүнтэй ижил үр дүн үзүүлж байна.

График 30. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс ба өмнөх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнэсэн байдал




График 31. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүс ба ирэх хоёр жилийн хугацаанд эрүүдэн шүүх гэмт явдал хэрхэн өөрчлөгдөхийг төсөөлж буй байдал



## 2.4. Эрүүдэн шүүх гэмт явдлын хор уршгийн талаарх олон нийтийн төсөөлөл

Эрүүдэн шүүх гэмт явдлын хор уршгийг судлах нь олон талын ач холбогдолтой. Үүнд:

1. Гэмт явдал иргэдэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх: Гэмт хэрэг, түүнээс гарах үр дагавар нь нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйд учирч буй хор хөнөөл, цаашид гарах аюулыг тодорхойлох боломжийг олгодог. Энэ нь гэмт хэргийн тархалтыг ойлгож, урьдчилан сэргийлэх зорилготой эрх зүйн болон нийгмийн стратегийг боловсруулах үндэс болдог.
2. Гэмт явдалтай тэмцэх бодлого боловсруулах: Гэмт явдлын хор уршгийг судалснаар, эрх зүйн систем, хууль сахиулах байгууллагууд, нийгмийн хариуцлага зэргийг сайжруулах бодлогын шийдлүүдийг гаргах боломжтой.
3. Гэмт хэргийг илрүүлэх: Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөл, хор уршгийг ойлгох нь гэмт хэргийг илрүүлэх, түүний давтамжийг бууруулахад тусалдаг. Иймд эрүүдэн шүүхтэй холбоотой тодорхой үйлдлийг таслан зогсоох стратегийг боловсруулахад чухал ач холбогдолтой.
4. Нийгмийн ухамсрыг дээшлүүлэх: Гэмт явдлын хор уршгийг судлах нь нийгмийн хариуцлага, хүний эрхийн асуудлуудыг ойлгуулахад, уг асуудлыг уялдуулан хэлэлцэхэд хэрэглэгдэх болно. Энэ нь хүмүүсийн үнэт зүйлсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Иймд гэмт явдлын хор уршгийг судлах нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхийг хангах, хууль зүйн системийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Шинжээчдийн 35% нь олон нийт эрүүдэн шүүх явдлын хор уршгийн талаар Сайн мэднэ, 25% нь Маш сайн, 25% нь Дунд зэрэг, 15% нь Хангалтгүй мэдлэгтэй гэж дүгнэсэн.

График 32. Эрүүдэн шүүх явдлын хор уршгийн талаарх ойлголт



## 2.5 Өмгөөллийн үйл ажиллагаа ба эрүүдэн шүүх гэмт явдал

Судалгааны явцад өмгөөлөгч нартай уулзаж байхдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад эрүүдэн шүүх гэмт явдал өмгөөллийн үйл ажиллагаанд өвөрмөц байдлаар нөлөөлж буйг судлах шаардлага гарсан байна.

Энэхүү судалгаа нь өмгөөллийн үйл ажиллагааны явцад эрүүдэн шүүх явдал хэрхэн тусч, өмгөөлөгчдийн ажлын явцад ямар өнгө аяс нэмж байгаа талаар тодорхой ойлголт авахад чиглэгдэж байгаа юм. Мөн энэ нь зөвхөн хуулийн хүрээнд бус, сэтгэл зүйн, ёс зүй, хүний эрхийн асуудал зэрэг олон талын өөрчлөлтүүдийг анхааралдаа авах боломж олгож байна. Иймээс, өмгөөллийн судалгааг цаашид гүнзгийрүүлэн явуулах нь эрүүдэн шүүх гэмт явдлын зүй тогтлыг илрүүлэх, хууль зүйн тогтолцоо сайжруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

*Үйлчлүүлэгч нартай мөрдөгч уулзахдаа хэл амтай өмгөөлөгчөө солихыг далд байдлаар тулгах, өмгөөлөх үйл ажиллагаа явуулж буй өмгөөлөгчид элдвээр шахалт үзүүлэх, зарим тохиолдолд аливаа байдлаар алагчлах явдал гардаг.*

*Ийм байдал даамжирвал бид яаж үйлчлүүлэгчээ хамгаалах юм бэ?*

*Өмгөөлөгч нарын ярианаас /судалгааны баг/*

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдаанд өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байх үед албан тушаалтнуудын зүгээс үйлчлүүлэгчийн холбогдсон буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтнууд болон албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалтад өртдөг эсэхийг МӨХ-оос хэрэгжүүлж буй «Өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа» (Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа. 2024) судалгааны ажлын тайлангаас тэдний зөвшөөрлөөр түүвэрлэн иш татаж орууллаа.

Эндээс үзэхэд, эрүүдэн шүүх гэмт явдлын хэлбэрүүд нь өмгөөлөгч нарт тулгарч эхэлсэн тухай таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна. Энэ нь өмгөөллийн үйл ажиллагааны явцад албан тушаалтнуудын зүгээс дарамт, айдас, сэтгэл зүйн шахалт зэрэг сөрөг нөлөөллүүд байж болохыг харуулж байна.

Иймд өмгөөллийн мэргэжил, тэдний эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх, энэ төрлийн асуудалд илүү анхаарал хандуулах шаардлага гарах нь ойлгомжтой.

Монгол улсын Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжоор хангагдах эрхтэй гэж заасан. Ийнхүү өмгөөлөгчид ийм эрх байх боловч зарим тохиолдолд эрх бүхий байгууллагаас уулзалтын цаг хугацаа, орчин нөхцөлөөр хязгаарлалт тогтоож, уулзалтын нууцад халдах тохиолдол гарч байна.

Энэ нь өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хууль зүйн хамгаалалтын системд хүндрэл учруулах боломжтой. Уулзалтын нууцад халдсанаар, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болгодог.

*Тохиолдол: Өмгөөлөгч Т.М цагдан хорих байранд байгаа үйлчлүүлэгчтэйгээ уулзахыг хүссэн боловч Цагдан хорих 0461-р байранд өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ 14 хоногт 1 удаа уулзахад болно гэж загнаж өмгөөлөгчтэй уулзуулаагүй.*

*/эх сурвалж МӨХ/*

Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10-д хуульд заасан үндэслэл, журмын дагуу шаардлагатай баримт сэлтийг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах эрхтэй гэж заасан байдаг. Гэвч, мөрдөн шалгах зарим байгууллагад өмгөөлөгчийг дотогш нэвтрүүлэхдээ гар утас, таблет зэрэг техник хэрэгслийг хураах журмыг баталж мөрдүүлж байна.

Энэхүү байдал нь өмгөөлөгчийн эрхийг зөрчиж, хуульд заасан нотлох баримт бусад мэдээллийг бэхжүүлэх, баримтжуулах үйл ажиллагааг хязгаарлах нөхцөл байдал үүсгэж байна. Өмгөөлөгчид хэрэгт холбоотой баримтыг цуглуулах явцад техник хэрэгсэл ашиглах нь чухал бөгөөд мөрдөн шалгах байгууллагаас энэ төрлийн техник хэрэгслийг хураах нь ёс зүйн болон хууль зүйн хязгаарлалттай холбоотой асуудал болж байна.

*Тохиолдол: Өмгөөлөгч Б.Д Цагдан хорих 0461-р байранд үйлчлүүлэгчийнхээ мэдүүлэг авах ажиллагаанд оролцохдоо гар утсаа хураалгаж орсон. Ингээд мэдүүлгийн явцад өмгөөлөгч өөрийн таблет дээрээ үйлчлүүлэгчийнхээ мэдүүлгээс тэмдэглэж авах гэхэд мөрдөгч болон прокурор, цагдан хорих байрны ажилтнууд татгалзаж өмгөөлөгчийн таблетыг хурааж авсан.*

*/эх сурвалж МӨХ/*

“Өмгөөлөгчдийн гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчмууд”-ын 16 дугаар зүйлийн а-хэсэгт хуульчид чиг үүргээ гүйцэтгэх баталгааг дараах байдлаар тодорхойлсон байна:

Айлган сүрдүүлэх, саад учруулах, дарамтлах зэрэг хөндлөнгийн зохисгүй нөлөөнөөс ангид мэргэжлийн чиг үүргээ бүрэн гүйцэтгэх боломжтой байх.

Дотооддоо болон хилийн чанадад саадгүйгээр зорчиж, үйлчлүүлэгчтэйгээ зөвлөлдөх.

Мөн, Өмгөөллийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д өмгөөлөгч нь хууль зүйн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх үедээ дарамт шахалт үзүүлэх,

саад учруулах, баталгаа шаардах, заналхийлэх, бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглосон байдаг.

Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлд өмгөөлөгчийг заналхийлсэн, сүрдүүлсэн, ятгасан нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заасан ч, өмгөөллийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

*Тохиолдол: Өмгөөлөгч О.А нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтээ туслахаараа дамжуулж мөрдөгчид хүргүүлсэн. Мөрдөгч уг хүсэлтийг хүлээн авах эсэх талаар маргаан болсон. Ингээд өмгөөлөгч О.А хүсэлтээ буцаан авах, мөрдөгчид хүсэлтээ биечилж өгөхөөр цагдаагийн байгууллагад очсон. Ингээд өмнө өгсөн хүсэлтээ буцааж авах талаар мөрдөгчтэй маргаан болсон. Улмаар маргалдах явцад мөрдөгч нь өмгөөлөгчийг согтууруулах ундаа хэрэглэсэн гэх үндэслэлээр албадан саатуулж, эрүүлжүүлэх чиглэл өгч өмгөөлөгчийг саатуулах төв байранд аваачсан. Өмгөөлөгчийг саатуулах байранд тусгай багажаар шалгахад согтууруулах ундаа илрээгүй.*

*/эх сурвалж МӨХ/*

“Өмгөөлөгчдийн гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчмууд”-ын 16 дугаар зүйлийн (с) болон 17 дугаар зүйлд дараах зарчим тусгагдсан:

Мэргэжлийн үүргээ зохих ёсоор биелүүлэх үед нь, ёс зүйн дүрэм журмын хүрээнд хийсэн аливаа үйлдлийг нь төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх, захиргааны шийтгэл, эдийн засгийн болон бусад шийтгэл хүлээлгэхгүй байх.

Мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан өмгөөлөгчийн аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөлд эрх бүхий байгууллага зохих ёсоор хамгаална.

Гэвч манай улсын хууль тогтоомжид өмгөөлөгчийн мэргэжлийн үүргээ зохих ёсоор биелүүлсэнтэй холбогдуулан хариуцлага хүлээлгэхгүй байх талаар зохицуулалт одоогоор тусгагдаагүй байна. Үүний улмаас, өмгөөллийн үйл ажиллагааг явуулсан гэдгээрээ өмгөөлөгчид эрүүгийн хэрэг үүсгэх, шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдлууд гарсан байна.

*Тохиолдол: Өмгөөлөгч Б.Б эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт шалгуулах, гэрчээс дахин мэдүүлэг авахуулах хүсэлт гаргасан. Мөн гэрчүүд дахин мэдүүлэг хүсэлт илэрхийлсэн. Үүнтэй холбогдуулан өмгөөлөгч Б.Б-д Эрүүгийн хуулийн 21.1, 21.5-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бөгөөд үйлчлүүлэгчийнх нь хамт шүүхэд шилжүүлсэн.*

*/эх сурвалж МӨХ/*

“Өмгөөлөгчдийн гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчмууд”-ын 18 дугаар зүйл болон 20 дугаар зүйлд дараах зарчим тусгагдсаны дагуу:

Өмгөөлөгчийг мэргэжлийн үүргээ гүйцэтгэсний төлөө үйлчлүүлэгчтэй нь эсхүл үйлчлүүлэгчийнх нь ашиг сонирхолтой адилтгах боломжгүй.

Өмгөөлөгч нь шударга үнэний төлөө амаар эсвэл бичгээр гаргасан хүсэлт, шүүхэд болон бусад хуулийн болон захиргааны байгууллагын өмнө хэлсэн мэргэжлийн үгээс иргэний болон эрүүгийн хариуцлагаас хамгаалагдана.

Гэвч манай улсын хууль тогтоомжид өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагааны явцад гаргасан хүсэлт, хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй

байх талаар зохицуулалт одоогоор тусгагдаагүй байна. Энэ нь өмгөөлөгчдийн мэргэжлийн үүргийг гүйцэтгэхэд мөн хүндрэл учруулах боломжтой бөгөөд зарим өмгөөлөгчдийг шүүх хуралдаанд хэлсэн үгтэй холбогдуулан цагдаагийн байгууллагад гомдол гаргах, эрүүгийн хэрэг үүсгэх тохиолдлууд гарсан байна.

*Тохиолдол: Өмгөөлөгч Р.П-г давж заалдах шатны шүүх хуралдаанд хэлсэн үгтэй нь холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэж байсан.*

*/эх сурвалж МӨХ/*

“Өмгөөлөгчдийн гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчмууд”-ын 18 дугаар зүйл болон 21 дүгээр зүйлд дараах зарчим тусгагдсан:

Хуульч нь үйлчлүүлэгчдээ хууль зүйн туслалцааг үр дүнтэй үзүүлэх нөхцөл бүрдүүлэх үүднээс тэдэнд шаардлагатай мэдээлэл, файл, баримт бичгийг авч ашиглах хангалттай хугацаа олгож байх үүргийг эрх бүхий байгууллагууд хүлээнэ. Эдгээр баримт мэдээллийг ашиглах боломжийг шаардлага гаргасан даруйд олгож байвал зохино.

Өмгөөллийн тухай хууль болон процессын хуулиудад өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авагдсан нотлох баримттай танилцах эрх олгогдсон байдаг. Гэвч мөрдөн шалгах нууц ажиллагааны гэх баримтыг өмгөөлөгчид танилцуулахгүй байх тохиолдол гарч байна.

Мөн “Өмгөөлөгчдийн гүйцэтгэх үүргийн тухай НҮБ-ын үндсэн зарчмууд”-ын 18 дугаар зүйл болон 22 дугаар зүйлд дараах зарчим тусгагдсан:

Хуульч болон үйлчлүүлэгч нарын хоорондын албан ёсны харилцаа холбоо, уулзалт, зөвлөгөөнүүд нь нууц болохыг төр хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзэх ёстой.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд үйлчлүүлэгчийн нууцыг хуулиар хамгаалах зохицуулалттай байна. Гэвч өмгөөлөгчийн албан өрөө, тасалгаанд үзлэг, нэгжлэг хийх, харилцаа холбооны хэрэгслийг чагнах тохиолдлууд гарч байсан.

Өмгөөллийн тухай хуульд “Төрийн байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх, мөн үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглоно” гэж заасан байдаг.

*Төрийн байгууллагатай гэрээ байгуулахаар харилцагчтайгаа хамт төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтантай уулзахаар ороход “Өмгөөлөгч хамт байхад гэрээний нөхцөлийг талаар ярилцахгүй” гэхэд үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн байдлыг дордуулахгүйн тулд ерөөнөөс нь гардаг*

*Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас /судалгааны баг/*

*“Мөрдөгч хууль бус шаардлага тавиад дарамтлаад байна. Хүнлэг бус харьцаж байгаа учир гомдол гаргая” гэж өмгөөлөгчдөө хэлэхэд “тэгвэл асуудал илүү их хүндэрнэ. Зүгээр орхичих” гээд эрхийг минь хамгаалдаггүй.*

*ХЭҮК-д гомдол гаргасан иргэнтэй хийсэн уулзалтаас /судалгааны баг/*



Энэ даамжраад өмгөөлөгч нар харилцагч нар нь эрүүдэн шүүх явдалд өртөхөд үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн байдлыг дордуулахгүй гэсэн хандлагаас “гэм хэргийн хамтрагч, нуун дарагдуулагч” гэсэн нэр зүүхэд хүрч байна.

Энэхүү байдлуудаас харахад, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хууль бусаар халдах, тэд ялгаварлан гадуурхалтад өртөхөд өмгөөлөгч хуулийн төдийгүй ёс зүйн асуудалтай тулах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өмгөөлөгчдийн үйл ажиллагааг хамгаалах, тэдний мэргэжлийн эрх зүй, ёс зүйг хүндэтгэх зорилгоор хууль зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах нь чухал хэрэгтэй болохыг онцгойлж байна. Хууль зүйн тогтолцоог сайжруулах, хүний эрхийг хамгаалах явцад өмгөөлөгчдийн мэргэжлийн үүргийг гүйцэтгэх баталгааг хангах нь нэн шаардлагатай гэж үзэж байна.

Эцэст нь дээрх баримтуудаас дүгнэж үзэхэд, өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааны явцад бий болж болзошгүй эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй, тэдгээртэй төсөөтэй гэмт хэргүүдийн нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн судлах, мөн өмгөөлөгчдийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

## **ГУРАВ. ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОЛБОГДОГЧ, ХОХИРОГЧИЙН ОНЦЛОГ**


### **3.1. Шүүгдэгчийн хувийн байдал**

Шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох нь тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Судалгааны хүрээнд дүн шинжилгээ хийсэн 19 шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгүүлсэн хүний нийгэм-хүн ам зүйн шинжийг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн хүний нийтлэг шинжийг харьцуулан судалсан.

Шүүгдэгчийн насны байдлыг авч үзэхэд, 16-25 насны шүүгдэгчид 7 буюу 31.8 хувийг, 26-35 насны шүүгдэгчид 11 буюу 50 хувийг, харин 36-45 насны шүүгдэгчид 3 буюу 18.2 хувийг эзэлж байна.

Энэхүү мэдээлэл нь шүүгдэгчдийн насны онцлогийг илтгэхийн зэрэгцээ, гэмт хэргийн үйлдэлд өртсөн насны бүлгийн талаар тодорхой ойлголт өгч, нийгмийн асуудал, залуучуудын гэмт хэргийн эрсдэл зэргийг үнэлэхэд туслах болно. Иймд судалгааны дүнг ашиглан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг илүү сайн ойлгож, шаардлагатай арга хэмжээг авах боломжийг бүрдүүлэх болно.

График 33. Шүүгдэгчийн нас, тоогоор




Үүнээс үзвэл, ихэвчлэн 23-30 насны хүмүүс гэмт хэрэг үйлдэж байгаа бөгөөд анхаарал татахуйц зүйл нь гэмт хэрэг үйлдсэн хамгийн залуу хүн нь 22 настай, харин хамгийн ахмад нь 45 настай байна. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгчид цагдаагийн алба хаагчид байх бөгөөд судалгаанаас дүгнэхэд, энэ төрлийн гэмт хэргийг цагдаагийн албанд шинээр томилогдсон офицерууд их үйлдсэн байна.

23-30 насныхан нь биеэ барих чадвар сул, зан төлөвийн хувьд бүрэн төлөвшөөгүй бөгөөд ажлын туршлагаас хамааран харилцааны туршлага нь бага байдагтай холбон тайлбарлаж болох юм. Нас ахих тусам хүмүүсийн биеэ барих, аливаа асуудлын эрх зүйн үр дагаврыг урьдчилан тооцоолох, түүнээс зайлсхийх чадвар нэмэгддэг байна. Иймд энэ насны бүлгийн дунд илүү нарийвчилсан судалгаа хийх, тулгамдсан асуудлын талаар мэдээлэл боловсруулж, шаардлагатай сургалтууд, хөтөлбөрүүдийг бий болгох нь чухал ач холбогдолтой.

Шүүгдэгчдийн боловсролын байдлыг авч үзвэл, бүрэн дунд боловсролтой хүн 1 буюу нийт шүүгдэгчдийн 4.1 хувийг, дээд боловсролтой 23 буюу нийт шүүгдэгчдийн 95.9 хувийг тус тус эзэлж байна.


График 34. Шүүгдэгчийн боловсролын түвшин, тоогоор



Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн дийлэнх нь дээд боловсролтой хүмүүс байна. Энэ нь тухайн алба хаагчдын сургалт, мэдлэг, мэргэжлийн бэлтгэл нь ихээхэн нөлөө үзүүлж байгааг илтгэнэ. Түүнчлэн, дээд боловсролтой хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх шалтгаан, нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах нь чухал бөгөөд энэ нь хууль зүйн боловсрол, ёс зүйн хариуцлага, албан тушаалтны ёс зүйтэй холбоотой үр дагаврыг тодорхойлоход туслах болно.


Шүүгдэгчийн мэргэжлийн байдлыг авч үзвэл, 20 буюу 90.9 хувийг цагдаагийн байгууллагад ажиллаж буй эрх зүйч мэргэжилтэй байна.

График 35. Шүүгдэгчийн мэргэжил, тоогоор



Шүүгдэгчдийн 22 буюу 100 хувь нь цагдаагийн албан хаагч байна байна.

График 36. Шүүгдэгчийн албан тушаалын төрөл, тоогоор




Шүүгдэгчдийн 19-өөс 7 буюу 31.8 хувийг орон нутгийн цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, 12 буюу 54.5 хувийг эрүүгийн мөрдөгч эзэлж, үлдсэн хувийг эрүүгийн ахлах мөрдөгч, хэв журмын ахлах байцаагч, олон нийтийн цагдаа нар бүрдүүлж байна.

Эндээс үзэхэд, шинэ төгссөн хэсгийн төлөөлөгч болон эрүүгийн мөрдөгчдийн дунд гэмт хэрэг илрүүлэх зорилгоор энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх нь харьцангуй их байна. Энэ нь шинэ алба хаагчид мэргэжлийн туршлага, ёс зүйн байр сууриа бүрдүүлэх явцдаа алдаа гаргах, үндсэн зорилгоос холдож, хүний эрхийг зөрчих эрсдэлтэй байгааг илтгэдэг.

Шүүгдэгчдийн 11 буюу 61.1 хувь нь 1-5 хүртэл жил, 3 буюу 16.6 хувь нь 6-10 жил, 3 буюу 16.6 хувь нь 3-5 жил, 1 буюу 5.5 хувь нь 20-с дээш жил төрийн тусгай алба хаасан байна. (График №12) Эндээс үзэхэд, алба хаагчид цагдаагийн байгууллагад удаан жил ажиллах тусан гэмт хэрэг үйлдэх нь магадлал нь багасаж байна.

Иймд шинээр томилогдсон алба хаагчдад зориулсан сургалт, чиглүүлэлт, мэргэжлийн ёс зүй, хүний эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлага байгааг онцолж байна. Энэ нь ажлын байран дахь гэмт хэргийн давтамжийг бууруулах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

График 37. Шүүгдэгчийн цэргийн алба хаасан хугацаа, тоогоор



Шүүгдэгчдийн гэр бүлийн байдлыг авч үзэх нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход ач холбогдолтой. Судалгаанд хамрагдсан шүүгдэгчдийн 9 буюу 56.2 хувь нь гэрлэсэн, 7 буюу 43.8 хувь нь ганц бие байна. Ганц бие хүмүүсийн дотроос 7 буюу 46.5 хувь нь хүүхэдгүй, 5 буюу 33.3 хувь нь 1 хүүхэдтэй байгаа нь харагдаж байна.

Энэхүү мэдээлэл нь гэр бүлийн байдал, хүүхэд байх эсэх нь гэмт хэргийн үйлдэлд хэрхэн нөлөөлдгийг судлахад ач холбогдолтой. Гэрлэсэн шүүгдэгчдийн хувьд гэр бүлийн хариуцлага, ачаалал, мөн салалт, гэр бүл салалтаас үүдэлтэй сэтгэл зүйн дарамт зэргийг даван туулахад түлхэц болохоор байна. Хүүхэдтэй шүүгдэгчид нь томоохон хариуцлагын мэдрэмжтэй байх нь нөхцөл байдлыг улам дордуулах, гэр бүл салалт, олон хүндлэлтэй асуудлуудтай холбогдож болох юм.

График 38. Шүүгдэгчийн гэр бүлийн байдал, тоогоор






График 39. Шүүгдэгч хүүхэдтэй эсэх, тоогоор



Шүүгдэгчийн өмнө нь ял эдэлж байсан эсэхийг авч үзвэл, 23 буюу 100 хувь нь урьд ял шийтгэл эдэлж байгаагүй байна.

График 40. Урьд нь шүүгдэгч ял шийтгэгдсэн байдал, тоогоор



### 3.2. Хохирогчийн онцлог


Гэмт хэргийн хохирогчийг судлах нь олон талын ач холбогдолтой. Үүнд:

1. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох: Хохирогчийн хувийн байдал, амьдралын нөхцөл, гэр бүлийн байдал зэрэг элементүүдийг судлах нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг гүнзгий ойлгоход тусалдаг. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх стратеги боловсруулахад ач холбогдолтой мэдээлэл өгнө.
2. Тохиолдол тодорхойлох: Хохирогчийн мэдээллийг цуглуулснаар, үйлдэгдсэн гэмт хэргийн онцлог шинж, учруулсан гэм хор, хохирлыг илүү тодорхой болгох боломжтой.
3. Хохирол нөхөн төлөх арга зам: Хохирогчийн хувийн болон гэмт халдлагад өртөх үеийн нөхцөл байдлыг нарийвчлан судалснаар нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох, хохирогчдыг дэмжих тогтолцоог боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой.
4. Сэтгэл зүйн дэмжлэг: Хохирогчийн сэтгэл зүй, бие махбодын байдалд судалгаа хийх нь хохирогчдод дэмжлэг үзүүлэх, тэдний эмчлэх хэрэгцээг ойлгоход тусална. Эмчилгээ, дэмжлэгийн хөтөлбөрийг бий болгоход шаардлагатай мэдээллийг хангана.
5. Гэмт хэргийн давтамжийг бууруулах: Хохирогчдыг судлах нь нийгмийн бодлогыг сайжруулах, гэмт хэргийн давтамжийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой. Бид хохирогчдыг ойлгож, тэдний байр суурийг хүндэтгэн авч үзсэнээр, нээгдмэл эрүүдэн шүүх гэмт явдлыг тогтоох боломжтой болно.

Энэ удаагийн судалгаа нь зөвхөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргээр хязгаарлагдсан бөгөөд энэ нь судалгаа явуулсан хугацаанд тодорхой хэмжээний мэдээлэл цуглуулах, харьцуулалт хийх боломжийг олгож байна. Гэвч зөвхөн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд төвлөрсөн нь хохирогчийн нийгмийн болон бусад хүчин зүйлийг бүрэн гүйцэд ойлгох боломжгүй байж болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын онцлогийг харьцуулан үзвэл, гэмт хэрэгт сэжиглэгдсэн, цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлагдаж байсан хүмүүс байх бөгөөд дийлэнх буюу 71.4 хувийг хулгайлах гэмт хэрэг сэжиглэгдсэн хүмүүс эзэлж байна.

График 41. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хохирогчдын онцлог, тоогоор



Шүүхээр шийдвэрлэсэн “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь харьцуулан үзвэл 63.1 хувь нь орон нутагт, 36.9 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байна.

График 42. Үүнээс: Оногдуулсан ялыг хэрэгжүүлсэн байдал, тоогоор



Шүүгдэгчийн хувийн зан чанарын онцлогийг авч үзэхэд, түргэн ууртай, түрэмгий, тогтворгүй зантай хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг ихээр үйлдэж байгаа нь тодорхой байна. Тухайлбал, цагдаагийн алба хаагчид гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хэргийн оролцогчдод хүч хэрэглэх, үндэслэлгүйгээр удаан хугацаагаар саатуулах, харилцааны ноцтой зөрчил гаргах, хэл, амаар доромжлох зэрэг үйлдлүүд хийсэн байна.

Ийм үйлдлүүд нь зөвхөн хууль хэрэглэх асуудал биш, харин ёс зүйн зөрчил үйлдэхэд ч нөлөөлдөг. Түрэмгий зан чанартай хүмүүсийн хувьд, асуудлыг хүчээр шийдвэрлэх хандлага нь гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгаа нь цагдаа, мөрдөгчдийн онцлог зан чанар, стрессийн удирдлага, ёс зүйн боловсролыг төлөвшүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

ХЭҮК, болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд ирсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчид ихэвчлэн дараах төрлөөр ангилж байна:

1. Гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүн, эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч: Цагдаа, прокурорын байгууллагад холбогдуулан гаргасан гомдлын дийлэнх хэсгийг “хилс хэрэг хүлээлгэсэн, зодож дарамталсан” гэсэн утгатай өргөдөл эзэлж байна.



- Улс төрийн хэрэгт холбогдсон этгээдүүд: Бүртгэгдсэн гомдол мэдээллийн тодорхой хувийг улс төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрд нөлөө бүхий этгээдүүдэд холбогдуулан гаргасан гомдол эзэлж байна.
- Хоригдол: Хорих байгууллагуудад ял эдэлж буй хоригдлуудтай зүй бус харьцсан, өөрийн эрх мэдлийн хүрээнд дарамталсан, эрхийг хязгаарласан утгатай гомдол тодорхой хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн гомдол мэдээллийг төрлөөр нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул зэрэг байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад холбогдуулан гаргасан боловч, шүүхээр шийдвэрлэсэн хэргүүд нь ихэвчлэн цагдаагийн алба хаагчдад хамааралтай байна. Бүртгэгдсэн гомдлын агуулгаас үзэхэд, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах явдал нь төрийн байгууллагын дотоод соёл, буруу дадал, ажлын ачаалал, шахалт, тушаал биелүүлэх нэрийдлээр хүний эрхийг ноцтой зөрчдөг нөхцөл байдлаас шалтгаалан үйлдэгдэж байгаа нь тодорхой байна.

Иргэдээс авсан санал асуулгаар “Өөрөө эрүүдэн шүүх явдлын улмаас хохирсон гэж үзсэн” нийт судалгаанд оролцсон иргэдийн 2% нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд хохирч байсан гэсэн дүн гарсан. Энэ тоо бага боловч яг ямар хүмүүс эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогч болсон, мөн энэ хүмүүс эрүүдэн шүүх гэмт хэргийн талаар юу гэж үзэж байгаа нь чухал үзүүлэлт юм.

График 43. Өөрөө эрүүдэн шүүх явдлын улмаас хохирсон хүмүүс




График 44. Эрүүдэн шүүх гэмт явдлын улмаас хохирсон гэх иргэдийн нас, хүйс





График 45. Эрүүдэн шүүх гэмт явдлын улмаас хохирсон гэх иргэдийн боловсрол, өрхийн дундаж орлого



Эрүүдэн шүүх талаарх ойлголт талаар 39% нь “Маш сайн мэднэ”, 23% нь “Дунд зэрэг мэднэ”, мөн 23% нь “Бага мэднэ”, 15% нь “Мэднэ” гэж хариулсан байна.

График 46. Эрүүдэн шүүх талаарх ойлголт талаарх мэдлэг



## ДӨРӨВ. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан гэдэг нь тухайн гэмт явдалд нөлөөлж буй нийгмийн үзэгдэл, үйл явц. Үүнд: Хүмүүсийн хандлага, мэргэжлийн ёс зүйн, улс төрийн эрх мэдэл, хууль тогтоомж, урьдчилан сэргийлэх тогтолцоо гэх мэт. Эрүүдэн шүүх гэмт явдлын нөхцөл гэдэг нь тус гэмт явдалд нөлөөлж буй нөхцөл байдал буюу тодорхой орчин. Үүнд: Цагдаагийн болон төрийн байгууллагын соёл, ажиллах орчин нөхцөл, харилцаатай тааламжгүй байдал, үйл ажиллагааны загварчлал гэх мэт.

Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох нь олон талын ач холбогдолтой. Үүнд:

1. Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг ойлгох: Гэмт явдлын үндсэн шалтгаан, нөхцөлийг судлах нь гэмт хэрэг үйлдэгдэх явц, тэдгээрт нөлөөлөх нийгмийн сөрөг үзэгдлийг илрүүлэхэд тусалдаг.
2. Төлөвлөлт, стратеги боловсруулах: Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх байгууллагуудын үйл ажиллагаа, албан хаагчдын чадавхыг сайжруулахад шаардлагатай бодлого, шийдвэрүүдийг боловсруулахад тусална.

3. Нийгмийн бодлогыг сайжруулах: Гэмт явдлын шалтгаан, нөхцөлтэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ нь нийгэмд болон зорилтод бүлэгт чиглэгдсэн бодлогыг сайжруулах, эрүүдэн шүүх гэмт явдалд хандах иргэд, албан тушаалтнуудын соёлыг ойлгох
4. Хохирогчдод туслалцаа: Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход анхаарах нь хохирогчдын нөхцөл байдлыг ойлгоход тусална. Энэ нь хохирлын нөхөн төлбөр, дэмжлэг, эмчилгээний хөтөлбөрийг боловсруулж, хохирогчдыг хамгаалах. Урьдчилан сэргийлэх цогц тогтолцоог сайжруулахад боломжийг олгодог.
5. Сэтгэл зүйн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах: Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлах нь иргэдийн аюулгүй байдлын мэдрэмж, айх айдсыг багасгах шийдвэр, бодлого гаргах асуудлыг шийдвэрлэхэд тусална.

Эрүүдэн шүүх гэмт явдал юунаас болж үүсдэгийг шинжээчид дараах байдлаар үнэлж байна. Гэвч ¼ хэсэг нь ойлгомжгүй, улс төрийн шинжтэй асуулт гэсэн үндэслэлээр хариулт өгөөгүй байна.

#### **Хүчтэй нөлөөлөх шалтгаан:**

- Албан тушаалаа урвуулан ашиглах: Төрийн албан хаагчид, ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь эрх мэдлээ буруугаар ашигласнаар эрүүдэн шүүх үйлдлүүдийг хийх явдалд чухал нөлөө үзүүлж байна.
- Хуулиар гэмтэй хүмүүсийг шийтгэж чадахгүй болох: Хууль зүйн тогтолцоо сулрах, гэмт хэрэгт холбогдсон хүмүүст хариуцлага хүлээлгэж чадахгүй байх нь эрүүдэн шүүх үйлдлийг зогсоох уриалгад саад учруулж байна.


#### **Дунд зэрэг нөлөөлөх шалтгаан:**

- Иргэдийг эрхшээлдээ байлгах: Үүнтэй адил, эрүүдэн шүүхийн үйл явдлууд нь иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж, хөндлөнгийн нөлөөнөөс болдог.
- Олон нийтийн айдсыг бий болгох: Нийгэмд айдас, эмээлийг бий болгох бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэх нь эрүүдэн шүүхийн үйлдлийг зөөлрүүлдэг.
- Улс төрийн шинжтэй үйл ажиллагаа: Поп-улс төрийн зорилго, үзэл баримтлалыг дэмжих, эсэргүүцэгчдийн эсрэг хүчээр дэмжих замаар эрүүдэн шүүхийг ашиглах.
- Хүчирхийлэл буюу хүч хэрэглэх: Мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх явцад хүч хэрэглэх нь ихэвчлэн эрүүдэн шүүх рүү хөтөлдөг.

#### **Бага зэрэг нөлөөлөх шалтгаан:**

- Шударга бус зүйлтэй тэмцэх өөр арга байхгүй болох: Гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсны байгууллагын тогтолцооны алдаа, сул байдал нь эрүүдэн шүүхийн шийдвэрлэх хэлбэрийг бий болгодог.

График 47. Эрүүдэн шүүх үйл явдлын үүсвэр




Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар олон нийтийн мэдлэг нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар өнгөрсөн 3 жилийн хугацаанд дараах зүйлсийг онцолсон байна:

1. Эрүүдэн шүүх, улс төржүүлэх нь нэмэгдсэн: Энэ хугацаанд эрүүдэн шүүх явдал тойрсон асуудал нийгмийн анхаарлыг илүү татаж байгаа нь энэ талаарх олон нийтийн мэдлэгийг тэлэхэд голлох нөлөө үзүүлсэн.
2. Улсын их хурал идэвхтэй ажиллаж эхэлсэн: Хууль тогтоох байгууллага нь эрүүдэн шүүхийн асуудлыг хэлэлцүүлж, хууль эрх зүйн орчныг сайжруулахын төлөө дэмжлэг үзүүлж байгаа нь олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж байна.
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) идэвхтэй ажилласан: Энэ асуудлаар бие даасан нэгжид анхаарал хандуулах, судалгаа хийх, дүн шинжилгээ хийх зэрэг арга хэмжээнүүд нь эрх зүйн орчныг сайжруулахад түлхэц болж байгаа нь нийгмийн мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан.

Гэхдээ Засгийн газар эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх асуудлаар идэвхтэй төсөв, санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлж ажиллахгүй байгаа, бас эрүүдэн шүүх гэмт явдал нэмэгдсэн гэдэгтэй санал нийлэхгүй байгаа явдал нь анхаарал татаж буй асуудал юм. Энэ нь Засгийн газар идэвхтэй ажиллах, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн ажлаа олон нийтэд хүргэх тал дээр илүү анхаарах хэрэгтэйн илэрхийлэл байж болох юм.

График 48. Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар олон нийтийн мэдлэг нэмэгдэхэд нөлөөлсөн зүйлс



Иргэдээс авсан судалгаанд оролцогчдын 44% нь эрүүдэн шүүхийн шалтгаан болгож хүчирхийлэл буюу хүч хэрэглэх үйлдлийг нэрлэсэн байна. Мөн 38% нь улс төрийн шинжтэй үйл ажиллагаа, 37% нь албан тушаалаа урвуулан ашиглах, 27% нь иргэний эрхшээлдээ байлгах, 26% нь шударга бус зүйлтэй тэмцэх өөр арга байхгүй болсонтой холбон үзсэн байна.

Нэмж хэлэхэд, 24% нь хуулиар гэмтэй хүмүүсийг шийтгэж чадахгүй болсон, 18% нь олон нийтийн айдсыг бий болгох шалтгаанаас үүдэлтэй гэж үзжээ.

Судалгааг нас, хүйстэй харьцуулахад ялгаа ажиглагдаагүй нь сонирхолтой бөгөөд энэ нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд нийгэмд байх боловсрол, мэдээлэл, ойлголтыг илэрхийлж байгаа юм

График 49. Эрүүдэн шүүх гэмт явдал юунаас болж үүсдэг вэ?



Төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчид нь эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан болгон улс төрийн шинжтэй үйл ажиллагаа, албан тушаалаа урвуулан ашиглах, хуулиар гэмт хүмүүсийг шийтгэж чадахгүй болох болон олон нийтийн айдсыг бий болгох шалтгаануудыг дэвшүүлж байна. Энэ нь төрийн байгууллагын дотоод соёл, сахилга хариуцлагатай холбоотой бөгөөд удирдах албан тушаалтнуудын шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлага, хүний эрхийн хамгаалалттай холбоотой асуудлуудыг илэрхийлж байна.

Нөгөө талаас, бусад хүмүүс хүчирхийлэл буюу хүч хэрэглэх, мөн шударга бус зүйлтэй тэмцэх өөр арга байхгүй гэдэг шалтгааныг эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан гэж үзэж байна. Энэ нь шударга ёс, авлигатай тэмцэх тогтолцооны дутагдал, сул талаас үүдэлтэйг илтгэнэ.

График 50. Ажиллаж буй салбар ба Эрүүдэн шүүх гэмт явдал юунаас болж үүсдэг вэ?



Судалгааны дүнгээс харахад, өрхийн дундаж орлого нь эрүүдэн шүүх гэмт явдал үүсэх шалтгаантай холбоотойгоор тодорхой зүй тогтолтой байна.

1. Гурван сая хүртэлх орлоготой иргэд: Эдгээр иргэдийн хувьд “хүчирхийлэл буюу хүч хэрэглэх” нь эрүүдэн шүүхийн гол шалтгаан гэж үзэгдэж байна.
2. Гурваас таван сая хүртэлх орлоготой иргэд: Энэ бүлгийнхэн «албан тушаалаа урвуулан ашиглах» зүйлийг гол шалтгаан гэж тодорхойлсон байна. Тус бүлэгт хамаарах хүмүүс нь мэргэжлийн болон соёлын хувьд дунд давхаргад харьцангуй их байж, албан тушаалтнуудын буруу шийдвэр, алдааг илүү мэдэрсэн байдаг.
3. Таваас дээш сая төгрөгийн орлоготой иргэд: Тэдний хувьд “улс төрийн шинжтэй үйл ажиллагаа” нь эрүүдэн шүүх гэмт явдлын гол шалтгаан болж байна. Энэ нь улс төрийн удирдлага, нөлөөллөөс шалтгаалж, дээд түвшний шийдвэрийг хүлээж, улс төрийн тогтолцоонд хамаардаг.

Дээрх судалгаанаас харахад эрүүдэн шүүх явдалтай холбоотой асуудал, түүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хүсэл эрмэлзэл улс төрийн хүсэл эрмэлзэлтэй шууд холбож байна. Ямарваа гэмт явдал тогтолцооны асуудал болсон 295 тохиолдолд төрийн байгууллага, Засгийн газар дангаараа тэмцэж үр

295 НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцсан Тусгай



дүнд хүрэх магадлал бага. Гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл нь олон улсын болон үндэсний хэмжээнд хууль тогтоогчид, Засгийн газар болон нийгмийн байгууллагуудын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалахын тулд явуулж буй үе шаттай, цогц үйл ажиллагаагаа илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлийг Монгол Улс бий болгосон байна.

Монгол Улс эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулж, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах, хүний эрхийг хамгаалах үүднээс бодит, үр дүнтэй арга хэмжээг авахыг эрмэлзэж байна. Цаашид улс төрийн хүсэл эрмэлзлээ улам бэхжүүлж, нийгэмд шүүхийн хараат бус байдал, ёс зүй, шударга ёсыг хангах зорилгоор зардлыг нэмэгдүүлэх, чиглүүлэх шаардлагатай.

Энэхүү хүсэл эрмэлзэл нь Монгол Улсын хүний эрхийн хамгааллын системийг бэхжүүлэх, мэргэжлийн ёс зүйг дэмжих, хууль зүйн тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

## ТАВ. ЭРҮҮДЭН ШҮҮХ ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

### 5.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны эрх зүйн үндэс

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний хүчирхэг тогтолцооны амин чухал хэсэг бөгөөд энэ нь олон улсын болон дотоодын хүний эрхийн тогтолцоог холбох чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэхүү үйл ажиллагааны бүрэн эрх нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөлөл үзүүлэхийн зэрэгцээ, үндэсний хэмжээнд эрүү шүүлттэй холбогдох бүх оролцогчидтой харилцах, мөн олон улсын эрүү шүүлтийн эсрэг боловсруулсан үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй байдаг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор ажиллаж, хууль, эрх зүйн орчныг сайжруулах, мэргэжлийн ёс зүйг дэмжих, шийдвэрлэхэд чиглэгдсэн ил тод системийг бий болгох боломжийг Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудад олгож байна.

Иймд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээллийн солилцоог дэмжих, үр дүнтэй ажиллагааны механизмыг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай 1975 оны Тунхаглал, НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг 1984 оны конвенц, түүний Нэмэлт протокол зэрэг НҮБ-ын хүний эрхийн суурь баримт бичгүүдэд бусдыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг илтгэгч Манфред Новак 2005 онд Монголд ажилласан тайландаа "Монголд эрүү шүүлт хавтгайран байна" <http://www.oncl.org/english/Issues/torture/report05/index.htm> доромжлон харьцаж шийтгэхийг хориглож эрүү шүүлтээс ангид байх эрхийг

баталгаажуулсан. Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан.

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганаар баталсан. Монгол Улс 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсон.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, эрх зүйн зохицуулалтыг 2020 онд нэмэлт, өөрчлөлт орсноор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдах үндэс суурь тавигдсан.

УИХ-ын чуулганаар 2022 оны 06 дугаар сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилсноор Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) хэрэгжиж эхэлсэн.<sup>296</sup>

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, баталгаа болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилсан.

Үйлчлэх хүрээний хувьд аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, олон нийтэд сурталчлах, судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй хамтран ажиллах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа (NPM)-ны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ.” гэж заасан.

Хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэрийн төсөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж

<sup>296</sup> D-Parliament.mn

боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох судалгаа, санал дүгнэлт боловсруулан УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн тодорхой асуудлуудаар шийдвэр гаргажээ.

## 5.2. Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх УИХ-ын үйл ажиллагаа<sup>297</sup>

Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) -г зохицуулсан заалтуудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийлгэхийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд даалгасан.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны талаар хараат бус судлаачдын багийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэж байна.

Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаа (NPM) нь конвенцод заасан урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх газрыг хязгаарласан, хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг олгохгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь тогтоогдсон гэж дүгнэсэн.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны эрх зүйн зохицуулсан байдлыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 заалтаар үнэлбэл зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна<sup>298</sup>.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 2024 оны 5 сард хараат бус шинжээчдийн багийн гүйцэтгэсэн судалгааны дүн болон УИХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолд заасны дагуу УИХ-ын удирдлагуудаас өгсөн чиглэлийн хүрээнд

<sup>297</sup> Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны тайлангаас тоймлон оруулав.

<sup>298</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ, дүн шинжилгээ”. Академич, доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Ж.Амарсанаагаар ахлуулсан хараат бус судлаачдын баг. 5 хууль зүйн докторууд багт ажилласан. ХЭҮК., 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-г зохицуулсан харилцааг боловсронгуй болгохоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, чуулганаар хэлэлцүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачлан боловсруулж, (2024.04.26) Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлж, хаврын чуулганаар уг хуулийн төслийн хэлэлцэж, эхний хэлэлцүүлэгт шилжүүлж шийдвэрлэсэн<sup>299</sup>.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд нийцүүлэн нэмэлт оруулах, зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль болон зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тооцож байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.<sup>300</sup>

### **ХОЁР. УИХ, Засгийн газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баталсан тогтоол, шийдвэр<sup>301</sup>**

Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн байнгын хорооны гишүүд ЭШУС үндэсний ажиллагааны тайлан, бусад үйл ажиллагаатай танилцан, өндөр ач холбогдол өгч, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Засгийн газрын хуралдаан, ХЗБХ-ны хуралдаануудаар авч хэлэлцээд:

- 1. Улсын Их Хурлын** 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” **35 дугаар тогтоол;**
- 2. Улсын Их Хурлын** 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” **37 дугаар тогтоол;**
- 3. Улсын Их Хурлын** 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга

<sup>299</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэлээ. <https://www.parliament.mn/nn/62341/>

<sup>300</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл <https://d.parliament.mn>

<sup>301</sup> Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны тайлангаас тоймлон оруулав.

хэмжээний тухай “ **114 дүгээр тогтоол**;

4. **Улсын Их Хурлын** Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” **09 дүгээр тогтоол**.
5. **Улсын Их Хурлын** 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлах тухай” **21 дүгээр тогтоол** (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн)
6. **Улсын Их Хурлын** 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө»-г батлах тухай” **42 дугаар тогтоол** (Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилтын 5.3-т: “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан.)
7. **Монгол Улсын Ерөнхий сайдын** 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” **02 дугаар Албан даалгавар**. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

Эдгээр тогтоол, шийдвэрүүд батлагдсан нь төр, засгаас Эрүү шүүлтээс урьдчилан үндэсний үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлсэн томоохон арга хэмжээ болсон.

**1. УИХ-ын 2023 оны 35 дугаар тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх;
- Эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

**2. УИХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

- Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад Нэмэлт, Өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох"-ыг Засгийн газарт даалгасан.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

- Шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно." гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

### **3. Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийх чиглэлээр:

- Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын ХЗБХ болон Хүний эрхийн дэд хороонд даалгасан<sup>302</sup>.

<sup>302</sup> Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 114 дүгээр тогтоолын дагуу хийсэн "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт хийсэн үнэлгээ" хийлгэсэн. Судалгаагаар ХЭҮКХ-ийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй ЭШУС



**4. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг УИХ-ын ХЗБХ болон Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх асуудлаар:

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

**5. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг баталж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.1.10 дугаар заалтад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа аливаа хязгаарлалтгүйгээр, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхахаас ангид байх эрхийн хэрэгжилт хангагдах чухал баталгаа болсон.

**6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар.**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар Албан даалгавар. (Албан даалгаврын 4.10.2-т: “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй иргэдийн гомдол мэдээллийг шалгаж нягтлах, хэргийг сэргээх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.)

---

үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, үл ойлгогдох байдал үүсгэхүйц байгаа нь тогтоогдсон. Хараат бус судлаачдын багийн тайлан. 2024 оны 3 дугаар сарын 10 өдөр. <https://nhrcm.gov.mn/>

## Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө»-г батлах тухай” 42 дугаар тогтоол

- (Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилтын 5.3-т: “Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.” гэж заасан. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор байгуулагдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм (NPM)-ыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалахад УИХ-аас дэмжиж ажиллах чухал баримт бичиг болсон.

Эдгээр тогтоол нь Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн томоохон бодлогын арга хэмжээ болсон. Онцлон тэмдэглэхэд тус тогтоолууд хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, замын зургийг тодорхойлоход чухал түлхэц үзүүлсэн.

Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хуульд заасан чиг үүргээ богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж байгааг дүгнэсэн байна<sup>303</sup>.

Үүнээс дүгнэхэд иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүүдэн шүүлтийг таслан зогсоох чиглэлд бодитой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн. Үндсэн хууль, төрөлжсөн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр иргэдийн эрүү шүүлт болон хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрхийг баталгаажуулсан, түүнийг хангах, хамгаалах үйл ажиллагааг дэмжих бэхжүүлэхэд тодорхой ахиц гарсан байна<sup>304</sup>.

Улсын Их Хурлын “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 75 жилийн ойд зориулсан 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Хүндэтгэлийн хуралдаан, УИХ-ын 2024 оны Хаврын чуулганы нээлт, 2025 оны Хаврын чуулганы хаалтын хуралдаанд Улсын Их Хурлын дарга чуулганы хуралдааны индрээс үг хэлэхдээ: “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд тодорхой ахиц дэвшил гарч байгааг Улсын Их Хурлын удирдлагын зүгээс үнэлж, байр сууриа илэрхийлэхийн сацуу Монгол Улс Хүний эрхийн конвенц, гэрээ, пактуудаар хүлээсэн үүргээ биелүүлж, Хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын Хүний эрхийн хороо, бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизм бүрдүүлж, парламентаас манлайлж ажиллах, Гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээний заалтыг шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын гэрээний үүрэг, зөвлөмжийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд тогтмол

<sup>303</sup> Монгол Улсын Их Хурлаас “Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын дэлгэрэнгүй тэмдэглэл. 2024.11.20. “Их-Эзэн Чингис хаан” танхимд. <https://www.parliament.mn/nc/646/>

<sup>304</sup> Г.Занданшатар: Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, Эрүү шүүлтийг таслан зогсоох чиглэлд бодитой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн. Хаврын чуулганаар эрх зүй, эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн реформуудаа эцэслэн дуусгах нь та бидний эрхэм чухал зорилт байх болно. <https://www.parliament.mn/nn/52006/>

тайлагнадаг журамд шилжиж, эрүү шүүлтийн нөхцөл байдалтай холбогдуулан нээлттэй сонсголоор хянан хэлэлцэх үүрэг чиглэл өгсөн<sup>305</sup>.

### 5.3. Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)<sup>306</sup>

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нэгдэн орсон гишүүн орнуудад олон улсын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бие даасан байгууллага бүрдүүлж, хараат бусаар ажиллах боломжийг олгохыг үүрэг болгосон<sup>307</sup>. Энэ нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэх зорилготой юм.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод одоогоор 174 улс нэгдэн орсон хэдий ч дэлхийн улс орнуудын дөрөвний гуравт нь эрүүдэн шүүх явдал үйлдэгдсээр, хүн төрөлхтний хамгийн эмзэг асуудал байсаар байна<sup>308</sup>.

Монгол Улсын хувьд конвенц, дотоодын хууль тогтоомжид заасны дагуу<sup>309</sup> Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилж, албан хаагчид томилогдсоноор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Одоогоор бүрэн эрхээ хэрэгжүүлээд үйл ажиллагааны тайлант гурав дахь жилтэйгээ золгожээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь аливаа хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан, өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт нэвтэрч, гэнэтийн, тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг сурталчлах, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах гол чиг үүрэгтэй<sup>310</sup>.

Ихэнх хүмүүс эрүү шүүлтийг хорих газар, эсвэл цагдан хорих, саатуулах байранд л үйлдэгддэг хэмээн боддог. Гэтэл конвенц болон хуульд заасан «бүх газарт» гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах

305 Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нар (2023.12.12) Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нартай уулзлаа. <https://www.parliament.mn/nn/51503/>

306 Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-ны тайлангаас бусад судалгаа, шинжилгээтэй харьцуулан үзэх, тухайн ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор оруулав.

307 НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 19 дүгээр зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1156>

308 Seventeenth Annual report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment\*\* НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Арван долоо дахь тайлан. [file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20\(1\).pdf](file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20(1).pdf); [file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20\(1\).pdf](file:///C:/Users/ESHUIS-2/Downloads/G2403510%20(1).pdf)

309 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, түүнд туслах нэгжийн зохицуулалтыг хуульчилсан.

310 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр зэрэг их өргөн хүрээтэй олон объект үүнд хамаардаг.<sup>311</sup>

Тиймээс энэ механизмын урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх газар нь 21 аймаг, 330 сум, нийслэл, 9 дүүрэгт оршин байх тул маш өргөн цар хүрээтэй ажиллахыг шаардана. Ажиллах бүрэлдэхүүний хувьд зургаан албан хаагчтай. Цаг хугацааны хувьд ч ажлын 8 цагаар хязгаарлагдахгүйгээр ажиллах нэн хүнд нөхцөлтэй. Илүү цаг, нэмэгдэл цалин хөлс олгох төсөвгүй, автомашингүй<sup>312</sup>.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор баталгаажуулсан аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж байна. Өөрөөр хэлбэл тухайн этгээд өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөлтэй нийт 843 газарт, давтагдсан тоогоор жилд 144942 иргэн урт, богино ямар нэг хугацаагаар байрлаж байна. Нэн тэргүүнд Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн 37000 гаруй хүнд тогтмол хүрэлцэн очиж урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хууль, олон улсын гэрээнд зааснаар ажилладаг.

Гэнэтийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхийн тулд шөнийн цагаар ч дээр дурдсан хаалттай, маш хол тархан байрласан объектуудад гэнэт хаалга тогшоод ордог. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм нь эрүү шүүлт гарсны дараа шалгадаг биш, харин гарч болзошгүй нөхцөл байдлуудыг урьдчилан харж, тогтмол урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил явуулах замаар болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлдэг механизм юм. Мөн нөгөө талаасаа урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийхийн зэрэгцээ хууль тогтоомжид тогтолцооны хувьд өөрт нь зөрчил гаргаж болзошгүй нөхцөл байдал байна гэж үзвэл, түүнийг засаж залруулахын төлөө холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, санал дүгнэлт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилладаг.

## **Нэгдсэн Үндэстний Байгууллага, Хүний эрхийн гэрээний хороодоос ирүүлсэн зөвлөмж, тогтоол, дүгнэлт**

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Ерөнхий чуулганы 2024 оны 11

311 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг. Тайлбар: Энэ хуульд заасан «бүх газарт» гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно. <https://legalinfo.mn/mn/detail/15152>

312 Нээлттэй Нийгэм Форумас хийсэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” бие даасан институтын төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийсэн дүн шинжилгээ”. Б.Хишигсайхан, нар. Энэ чиглэлээр уг механизмын үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй судалсан. Улаанбаатар, 2022.12.10.

дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдааны CAT/C/MNG/CO/3 Ажиглалт, Дүгнэлтэд: “Монгол Улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаагаа байгуулаад удаагүй ч, богино хугацаанд чадавхжуулж, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд ахиц гаргаж байгаа”-г онцлон тэмдэглээд, цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс ангид байх хүний эрхийг хангах, хамгаалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголын УИХ, Засгийн газарт уриалж, Зөвлөмж ирүүлсэн болно<sup>313</sup>.

a. Түүнчлэн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), «Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд» (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжүүдэд нийцүүлэн боловсронгуй болгохыг удаа дараа сануулсаар ирсэн бөгөөд энэ удаад ч дахин сануулж байгаагаа уламжлав.

b. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны стратеги төлөвлөгөө (2023-2026 он) батлагдсан явдлыг Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн эерэг үзүүлэлтэд дурдсан байна.

4. НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн CAT/OT/MNG/RP-NPM/R-I зөвлөмж гаргасан.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо нь Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12-ны 2157 дугаар хуралдаанд Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаар НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос танилцуулсан.

Улмаар НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах талаар 2025 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн CAT/OT/MNG/RPNPM/R-I дүгнэлт гаргаж, ирүүлсэн.

5. Монгол Улсын илтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулан уг хуралдаанд

313 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2024 оны 11 дүгээр сарын 12, 13-ны өдрийн 2157, 2160 дугаар хуралдаанаараа “Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Засгийн газрын ээлжит гурав дахь илтгэлийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2168 дугаар хуралдаанаараа CAT/C/MNG/CO/3 ажиглалт, дүгнэлтийг баталсан. CAT/C/SR.2157 and CAT/C/SR.2160-ыг үзэх.

[https://tbinternet.ohchr.org/\\_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2F-EUL%2FMNG%2F32846&Lang=en](https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2FCAT%2F-EUL%2FMNG%2F32846&Lang=en).

оролцсон “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг” (АРТ) - Олон улсын байгууллагын дарга, төлөөлөгчид “Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Ази-Номхон далайн бүсийн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын бүс нутгийн бусад Оролцогч улсууддаа “үлгэр жишээ” болж буйг онцолж, мандатынхаа дагуу олон улсын түвшинд энэ тухай мэдээлсэн байна<sup>314</sup>.

Тухайлбал, Монголын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдан ажиллаж байгаа богино хугацаанд үр дүнтэй ажиллаж, Ази-Номхон далайн бүс нутагтаа тэргүүлэх байр суурьтай ажиллаж байна гэж дүгнэжээ.

АРТ-“Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг”, APF-Ази-Номхон далайн форум байгууллагууд хамтран санхүүжилтийг шийдвэрлэн Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхэд 2025 онд техникийн туслалцаа үзүүлэх хүрээнд Монгол Улсад 3 удаа ирж, үндэсний ажиллагааны алба хаагчид болон Монгол Улсын хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын сургагч багшаар бэлтгэх хамтарсан урт хугацааны төсөл хэрэгжиж эхлэв.<sup>315</sup>

### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ:**<sup>316</sup>

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 10,172 километр замыг туулж, 57 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжсэнээс хойших хугацаанд 38,596 километр замыг туулж нийт 128 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн байдал, эрүү шүүлтээс ангид байх эрх, эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.
- Тайлант хугацаанд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан удирдамжийн дагуу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 4 дүгээр зүйл; 14 дүгээр зүйлийн 1-ийн a), b), c), d), e) дэх заалт; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Ачлалт хүүхдүүд” ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газар, СЭМҮТ-д

314 Mongolia's NPM is one of only a small number in the Asia Pacific but it is already benefiting from the experiences of other NHRIs in the region with an NPM mandate, as well as acting as an example for those states in the region who are yet to ratify the Optional Protocol to the Convention against Torture. <https://www.apt.ch/news/mongolia-new-monitoring-body-focuses-risky-practices-and-women-detention>

315 “Strengthening the NPM of Mongolia, localizing the Mendez Principles in the law enforcement”. Granted by the Asia Pacific Forum (APF) and Association for the Prevention of Torture (APT), to be implemented in 2025.

316 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 2 дугаар бүлгээс үзнэ үү.



НҮБ-ын ЭШУС Дэд хорооны гишүүн Элина Штайнерт, Ника Кварачкелиа, Аника Томсиқ, Мартин Зинклер, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Армен Авестисиан, Хүний эрхийн Дээд комиссарын газрын Хүний эрхийн ажилтан Женнифер Крафт, Аюулгүй байдлын ажилтан Конрад де Сваф нартай хамтран аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зарим газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн.

- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг холбогдох албан тушаалтнаас тодруулга авах, шаардлагатай баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, эрх чөлөөний хэрэгжилт болон амьдарч, хөгжиж буй ахуй нөхцөлтэй танилцах, орчин нөхцөлд ажиглалт хийх, техник хэрэгсэл ашиглан баримтжуулах зэрэг аргачлалаар явуулж, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар асуумжийн аргаар судалгаа авч, ганцаарчлан ярилцсан.
- Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хүрээнд 2022-2025 онд 6,076 иргэн, 1,465 төрийн албан хаагчаас эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар олон улсын жишиг стандарт, өөрийн улсын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж судалгаа авсан бол, тайлант хугацаанд 1,623 иргэн, 311 төрийн албан хаагчаас асуумж авсан.
- ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2025 онд аливаа хэлбэрээр эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан 1,531 иргэнтэй, ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 291 хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад хэлбэрээр эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдтэй, 117 төрийн албан хаагчтай ганцаарчилсан уулзалт ярилцлага хийж зөвлөгөө өгсөн. ЭШУС хэлтсийн албан өрөөнд 7 иргэн өөрийн биеэр ирж ганцаарчлан ярилцаж, зөвлөгөө авсан нь Уулзалтын бүртгэлд тэмдэглэгджээ.

### Хүснэгт 3. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ	23	48	57	128
2	Туулсан зам (километрээр)	10,614	17,810	10,172	38,596
3	Асуумж (эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдээс)	1,650	2,803	1,623	6,076
4	Асуумж (төрийн албан хаагчдаас)	304	850	311	1,465
5	Ганцаарчилсан уулзалт ярилцлага	459	675	415	1,549

#### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж**<sup>317</sup>

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант

<sup>317</sup> ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

хугацаанд 14 зөвлөмж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний нийт 50 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, зөвлөмж тус бүрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ахиц дэвшлийг тооцон ажиллав.

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн биелэлт тайлант хугацаанд 80 хувь, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлсэн 2022 оны 06 дугаар сараас 2024 он, 2025 оны нэгдүгээр улиралд мөн 80 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн.
- Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулгад зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж ажиллах талаар зөвлөсөн. Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны А/03 дугаар тушаалаар “Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал батлах тухай” тушаал баталсан. 318
- Тус аргачлалаар зөвлөмжийн хэрэгжилтийг заалт бүрээр хувиан үнэлж, дүн шинжилгээ хийж ажилласан ба шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилтийн үнэлгээтэй танилцуулж “Үнэлгээг хүлээн зөвшөөрсөн” тэмдэглэлд гарын үсэг зуруулан, биелэлтийг хангуулан тухайн байгууллагад нь архив үүсгэж хэвшсэн. Ингэснээр зөвлөмжийн биелэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтнаас тодруулга, мэдээлэл авах, хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлээгүй ирүүлсэн зөвлөмжийн заалттай холбоотой шалтгаан нөхцөлийг сонсож тус заалтын хүрээнд өгсөн арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх ойлголт, арга замыг дахин зөвлөж хэрэгжилтийг нэмэлтээр авч үнэлж ажиллав. Зарим тохиолдолд тухайн байгууллага дээр зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр сургалт хийх, газар дээр нь очиж хэрэгжилтийг хангуулахад зөвлөн туслах зэргээр үр дүнд суурилсан, нарийвчилсан дүн шинжилгээг тухай бүр хийж ажиллав.319.
- Гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлага алдсан албан тушаалтныг хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулах, чөлөөлөх, огцруулах саналаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулж ажиллав.320
- ЭШУС үндэсний ажиллагааны зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийн сайн туршлагыг хуваалцах, өмнөх хяналт шинжилгээгээр илэрсэн зөрчил, дутагдал давтан гарах шалтгаан нөхцөлийг арилгахад онцгой анхаарч ажиллалаа.

318 “Аргачлал батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаал.

319 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

320 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

Зөвлөмжийн хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь

		2022	2023	2024	2025 I улирал	Нийт
1	<b>Зөвлөмжийн хэрэгжилт хувь</b>	74.0%	80.0%	84.0%	-	80.0%
2		10 зөвлөмж	20 зөвлөмж	15 зөвлөмж	6 зөвлөмж	51 зөвлөмж
3		70 заалт	224 заалт	154 заалт	46 заалт	494 заалт

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн жил бүрийн хэрэгжилтийн хувь өссөн дүнтэй байна.

ХЭҮКТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.4-т ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ хэрэгжүүлээгүй бол албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана гэж заасан. Хуулиар олгосон энэхүү зохицуулалтыг баримтлан саналаа эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулж ажиллав.<sup>321</sup>

#### **Эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдсөн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийн шийдвэрлэлт**<sup>322</sup>

ЭШУС үндэсний ажиллагаанд хандаж ирүүлсэн гомдол, мэдээллээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн ажиллахын зэрэгцээ түүний дагуу ямар арга хэмжээ авсан талаар эргэж мэдээллийг авах, эргэж мэдэгдээгүй албан газруудад дахин албан бичиг хүргүүлэн шийдвэрлэлтийн мэдээллийг авч, үр дүнг тооцож ажиллав.

ЭШУС үндэсний ажиллагаа гомдол шалгадаггүй, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.<sup>323</sup>

321 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 7 дугаар бүлгээс үзнэ үү.

322 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 6 дугаар бүлгээс үзнэ үү.

323 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны чиг үүрэг: <https://legalinfo.mn/mn/detail/15152>

Хүснэгт 5. Эрүүдэн шүүх талаар гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

№	Албан байгууллага	Шилжүүлсэн гомдлын тоо	Хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлсэн гомдлын тоо	Шийдвэрлэлтийн хувь
<b>2022 онд</b>				
1	АТГ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
2	УЕПГ, харьяа прокурорын газар	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
<b>2023 онд</b>				
1	АТГ	10	Албан бичгээр хариу ирүүлээгүй 3	70%
2	УЕПГ, харьяа прокурорын газар	7	Хариу ирүүлээгүй 3	57%
3	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	6	Албан бичгээр хариу ирүүлээгүй 4	30.0%
4	Цагдаагийн байгууллага	3	Албан бичгээр хариу ирүүлээгүй	0%
5	ХЗДХЯ	3	Хариу ирүүлээгүй 3	0%
6	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
7	ШЕЗ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
<b>2024 онд</b>				
5	АТГ	19	Албан бичгээр хариу ирүүлсэн 19	100%
6	УЕПГ, харьяа прокурорын газар	15	Албан бичгээр хариу ирүүлсэн 15	100%
7	ШШГЕГ, харьяа ШШГ байгууллага	17	Албан бичгээр хариу ирүүлсэн 17,	100%
8	Цагдаагийн байгууллага	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1,	100%
9	ХЗДХЯ	3	Хариу ирүүлээгүй 3	0%
10	Шүүхийн сахилгын хороо	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
11	Ерөнхийлөгчийн Тамгын газар	1	Уучлалт үзүүлж шийдвэрлэсэн	100%
12	ШЕЗ	1	Албан бичгээр хариу ирүүлсэн 1	100%
<b>Нийт</b>				96.0%

ЭШУС үндэсний ажиллагааны хүрээнд 2022-2024, 2025 оны нэгдүгээр улиралд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх зөрчигдсэн талаар нийт 169, үүнээс тайлант хугацаанд нийт 92 өргөдөл, гомдол мэдээлэл ирүүлсэн байна.

## Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт<sup>324</sup>

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс хойш нийт 223 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 41,081 хүнийг хамруулсан.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлант хугацаанд 155 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 32,640 төрийн албан хаагч нар, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллагуудын удирдлага, алба хаагч нар, холбогдох мэргэжилтнүүд, ахмад настны асрамжийн газрын болон сэтгэцийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, сэтгэл зүйч, дүүргүүдийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, ЕБС-ийн захирлууд, багш, дотуур байрны багш нар, сургалтын менежер, насан туршийн боловсролын төвийн төлөөлөл, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, их, дээд сургуулийн оюутан, суралцагч, сонсогч нар, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэдийг хамруулсан.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх хүний эрхийн 73 сургагч багшийг 2023 онд бэлтгэн гэрчилгээ олгосон бол ЭШУС үндэсний ажиллагааны тайлант хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг ОУБ-тай хамтран ажиллаж “Мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмуудыг Монгол Улсын хууль сахиулах ажиллагааны хэрэглээнд нутагшуулах нь”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц: Эрүү шүүлтийг хориглох; Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь; Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэх” сэдэвт сургалтыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тус тус зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, ШШГ байгууллага, эрдэмтэн багш нар, судлаачид, бусад албан тушаалтнууд нийт 2,632 хүнийг хамруулж, танхимын сургалтаар 151 сургагч багшийг бэлтгэн гэрчилгээ гардуулснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд нийт 224 сургагч багшийг бэлтгэсэн.
- Монгол Улсад эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын нийт 13 байгууллагын сургалтын хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, түүний дотор эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөө, түүнийг дэмжих, хамгаалах, эрүү шүүлтээс ангид байх хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн агуулга тусгагдсан эсэх өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.
- Эрх зүйч, хууль сахиулагчид, хуульчдыг бэлтгэдэг боловсролын сургалтын байгууллагуудын суралцагчдад эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийн

324 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 3 дугаар бүлгээс үзнэ үү.

нэгдсэн, тодорхой мэдлэг олгож, хандлага төлөвшүүлж, ур чадвар, дадал эзэмшүүлж, Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын холбогдох гэрээ, конвенцуудаар баталгаажуулсан хэнийг ч аливаа хэлбэрээр үл ялгаварлах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг үндэсний ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай хэмээн дүгнэж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулсан.

### **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа<sup>325</sup>**

- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024-2025 оны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийг батлан, таван үндсэн чиглэлийг тодорхойлж ажиллалаа.
- Энэ хүрээнд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” фейсбүүк, “NPM-Mongolia” твиттер хуудсаар дамжуулан 211 удаагийн хүний эрхийн талаар мэдлэг ойлголт, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ болон бусад арга хэмжээний талаар контент (бичлэг, reels, story, poster хэлбэрээр) нийт мэдээ мэдээлэл, 321 удаагийн телевиз, сайт, сонины ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжууллаа. Цахим орчинд давхардсан тоогоор урт, богино хугацаагаар 628.5 мянган хүнд шууд хүрч, хандалтын хувь 2023 оны мөн үеэс 67.2 хувиар өссөн байна.
- ЭШУС үндэсний ажиллагаанаас төлөвлөн хэрэгжүүлсэн 5 үндсэн ажлын хүрээнд олон нийтэд мэдээлсэн нийт мэдээллийн тоон үзүүлэлтийг 2023 оны тайлант хугацааны үзүүлэлттэй харьцуулахад 45 хувиар, хандалт 91.7 хувиар тус тус өссөн бөгөөд ЭШУС статистик тоон мэдээллээс харахад хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 10 ажлын үзүүлэлт бүгд өссөн үзүүлэлтэй байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг таниулах ажлын хүрээнд Монголын үндэсний радио, телевиз, Монголын Үнэн сонин, Сайтын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан “Эрүү шүүлтгүй Монголын төлөө” сонины булан, 10 удаагийн подкаст, ЭШУС мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж ажилласан нь сурталчилгаа, нөлөөллийн ажлыг нэгдсэн арга зүй, системтэйгээр зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.
- Олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах хүрээнд цуврал анимейшн, нугалбар хуудас, мэдээллийн самбар, зурагт хуудас, цаглавар зэрэг олон төрлийн сурталчилгааны хэрэглэгдэхүүнийг бүтээв.
- Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийн доромжлон харьцаж шийтгэх тухай ойлголтыг агуулсан хүүхдэд зориулсан анимейшныг бүтээж хүүхдийн асрамж халамжийн байгууллагад байгаа хүүхдүүдэд эрүү шүүлтийн хор аюулыг ойлгуулах боломжтой болсон.

325 ЭШУС үндэсний ажиллагааны 2024 оны тайлангийн 3 дугаар бүлгээс үзнэ үү.



- Нугалбар хуудас, мэдээллийн самбарын загварыг боловсруулж ШШГ байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр, эрүүлжүүлэх саатуулах, баривчлах байруудын эргэлт уулзалтын танхим, хүлээлгийн өрөө, хоригдлын амьдралын бүс, СЭМҮТ-д байршууллаа.
- ЭШУС үндэсний ажиллагааны 2022, 2023 оны төсөвт эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлах хүрээнд тодорхой төсөв хуваарилагдаагүй бол 2024 оны төсөвт сурталчилгааны зардал хуваарилагдсан нь тайлант хугацаанд эрүү шүүлтээс ангид байх хүний эрх, эрүү шүүлтийн хор аюулыг сурталчлан таниулах, сурталчилгааны хэрэглэгдэхүүн бүтээх үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргахад эерэг нөлөө үзүүлсэн.

#### 5.4. Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох

Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ Огт чадахгүй байна (30%), Дунд зэрэг (30%), Хангалттай (20%), Чадахгүй байна (15%), Хангалттай сайн (5%) гүйцэтгэж байна гэж дүгнэсэн байна.

График 51. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү



Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх гэмт явдал үүсгэх нөхцөлийг ариглах, урьдчилан сэргийлэх үүргээ “Хангалттай” гүйцэтгэж байна гэж дүгнэсэн байна.

График 52. Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх явдал үүсэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү



### 5.5. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн

Судалгаанд оролцогчдын шинжээч нарын 25% нь Эрүүдэн шүүх явдлыг төр анхааралдаа авч ажиллаж байна, 45% нь Эрүүдэн шүүх гэмт явдал гаргахгүй байх арга барил, 35% нь Төрийн албан хаагчдын ажиллах орчин, ажлын ачааллын оновчтой зохицуулахгүй бол эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарахгүй, 40% нь Хууль сахиулагч нар албан үүргээ тухайн нөхцөл байдалд хэрхэн гүйцэтгэх зааварчилгаа байдаггүй нь хууль зөрчих, хүнтэй харилцахдаа алдаа гаргах, эрүүдэн шүүхтэй холбоо зөрчил, гэмт хэрэгт холбогдоход хүргэдэг, 40% нь Эрүүдэн шүүх явдлыг олны анхаарал хүргэх талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан тогтолцоо идэвхтэй ажиллаж байна гэдэгтэй санал бүрэн нийлж байна.

Хүснэгт б. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар хэмжээ зохион байгуулбал үр дүнтэй гэж та үзэж байна вэ?

№	Тохирох утга	Санал бүрэн нийлж байна	Нийлэх талдаа	Нийлэхгүй	ОГТ нийлэхгүй	Хариу-лаагүй	Нийт
1	Эрүүдэн шүүх явдлыг төр анхааралдаа авч ажиллаж байна.	25%	50%	20%	0%	5%	100%
2	Эрүүдэн шүүх гэмт явдал гаргахгүй байх арга барил, харилцааны ур чадвар их сургуульд хангалттай заахгүй байна.	45%	35%	15%	5%	0%	100%

3	Төрийн албан хаагчдын ажиллах орчин, ажлын ачааллын оновчтой зохицуулахгүй бол эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарахгүй	35%	55%	0%	5%	5%	100%
4	Хууль сахиулагч нар албан үүргээ тухайн нөхцөл байдалд хэрхэн гүйцэтгэх зааварчилгаа байдаггүй нь хууль зөрчих, хүнтэй харилцахдаа алдаа гаргах, эрүүдэн шүүхтэй холбоо зөрчил, гэмт хэрэгт холбогдоход хүргэдэг	40%	50%	5%	0%	5%	100%
5	Эрүүдэн шүүх явдлыг олны анхаарал хүргэх талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан тогтолцоо идэвхтэй ажиллаж байна.	40%	10%	35%	10%	5%	100%

Монгол Улсын хэмжээнд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 34% нь Мэдэхгүй/Хариулаагүй байна. Үнэлгээ өгсөн хүмүүсийн үр дүнг харахад Дундаж гэж үнэлсэн байна.

Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, орлоготой харьцуулахад ерөнхий үзүүлэлттэй ижил үр дүн гарлаа.

Харин эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг эрүүдэн шүүх гэмт явдлын талаарх Маш сайн, сайн мэднэ гэж хариулсан хүмүүстэй харьцуулахад дундаж гэж үнэлсэн нь хамгийн өндөр хувийн эзэлж байна.

График 54. Эрүүдэн шүүх гэмт явдлыг мэддэг хүмүүс ба Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн




График 55. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 9% нь Монгол Улсын хэмжээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн “Огт үр дүнгүй” гэж үнэлсэн хүмүүсийн дүр төрх



Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа (NPM)-г огт үр дүнгүй гэж үзэж байгаа хүмүүсийн хувьд “Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох”, “Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах” үйл ажиллагаа явуулбал хамгийн их үр дүнтэй болно гэж үзэж байна. Харин “Соён гэгээрүүлэх ажил, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн байнга зохион байгуулах” ажил үр дүн хамгийн бага гэж үзэж байна.

График 56. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа Огт үр дүнгүй гэж үзэж байгаа хүмүүсийн хувьд урьдчилан сэргийлэхийн тулд авах арга хэмжээ нэрлэсэн байдал



Судалгаанд хамрагдсан шинжээч нар Монгол Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хууль, тогтоомж урьдчилан сэргийлэх үүргээ “Дунд зэрэг гүйцэтгэж байна” гэж дүгнэв.

График 57. Монгол улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хууль, тогтоомж урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү



Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ Огт чадахгүй байна (30%), Дунд зэрэг (30%), Хангалттай (20%), Чадахгүй байна (15%), Хангалттай сайн (5%) гүйцэтгэж байна гэж дүгнэсэн байна.

График 58. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү



Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх гэмт явдал үүсгэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүргээ “Хангалттай” гүйцэтгэж байна гэж дүгнэсэн байна.

График 59. Төрийн байгууллагууд эрүүдэн шүүх явдал үүсэх нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг үнэлнэ үү




### 5.6. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагаа

Ямарваа гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон талт үр дүнтэй хамтын ажиллагаа төрийн болон хувийн байгууллагуудын үүрэг оролцоо чухал гэдэгтэй хэн нь маргахгүй. Хэдий тийм ч тэргүүлэх байгууллагын үүрэг оролцоо хамгаас чухал.

Судалгаанд оролцогч хоёр иргэн тутмын нэг нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан нэгж, Цагдаагийн газар нь эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг манлайлах үүрэгтэйгээр оролцох ёстой гэж үзэж байна. Мөн, хамгийн бага үүрэг оролцоотой нь аж ахуйн нэгжүүд гэж дүгнэсэн нь энэ салбарт хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг харуулж байна. Оюутнуудын 60% нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан нэгж нь улсын хэмжээнд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дагнан ажилладаг байгууллага гэж үзсэн нь анхаарал татаж байна.



График 60. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг манлайлагч



Судалгаанд хамрагдсан шинжээчид эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг бүгдийг үр дүнтэй гэж үзсэн. Тэр дундаа 2/3 Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох, Эрүүдэн шүүх явдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг сайжруулах, Эрүүдэн шүүсэн талаар мэдээлэл өгсөн хүнийг сайн хамгаалдаг болох, Хууль сахиулагч, төрийн бусад албан хаагчид иргэдтэй уулзах, мэдүүлэг, тайлбар авах, мэдээ сэлт авах стандарт тодорхой болгох гэдгийг илүү үр дүнтэй гэж үзжээ.

Хүснэгт 7. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ / Шинжээчид/

	Асуулт/ Хариулт	Илүү үр дүнтэй	Үр дүнтэй	Үр дүнгүй	Огт үр дүнгүй	Хариу-лаагүй	Нийт
1	Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох	75%	15%	0%	5%	5%	100%
2	Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах	50%	35%	0%	5%	10%	100%
3	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах	40%	50%	0%	5%	5%	100%

4	Төрийн байгууллагуудыг нэгдсэн байдлаар камержуулах	10%	50%	30%	0%	10%	100%
5	Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг сайжруулах	65%	20%	15%	0%	0%	100%
6	Эрүүдэн шүүсэн талаар мэдээлэл өгсөн хүнийг сайн хамгаалдаг болох	65%	15%	10%	0%	10%	100%
7	Эрүүдэн шүүсэн хүмүүст ногдуулах шийтгэлийг чангаруулах	50%	20%	20%	5%	5%	100%
8	Соён гэгээрүүлэх ажил, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн байнга зохион байгуулах	45%	35%	15%	0%	5%	100%
9	Төрийн байгууллагын үйл ажиллагааны стандарт, зааварчилгааг тодорхой болгох	55%	25%	15%	0%	5%	100%
10	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийг төлбөртэйгөөр авах, үнэлэх тогтолцоог аймгийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх	45%	40%	5%	0%	10%	100%
11	Бусад (орлого нэмэгдүүлэх, ажилгүйдэл бууруулах, сургалт, эрх зүйн сурталчилгааг оновчтой хэлбэрээр зохион байгуулах)	50%	25%	10%	10%	5%	100%
12	Хууль сахиулагч, төрийн бусад албан хаагчид иргэдтэй уулзах, мэдүүлэг, тайлбар авах, мэдээ сэлт авах орчны стандарт тодорхой болгох	65%	20%	5%	0%	10%	100%

Судалгаанд оролцсон иргэдийн 25% нь Эрүүдэн шүүх явдлыг төр анхааралдаа авч ажиллаж байна, 45% нь Эрүүдэн шүүх гэмт явдал гаргахгүй байх арга барил, 35% нь Төрийн албан хаагчдын ажиллах орчин, ажлын ачааллын оновчтой зохицуулахгүй бол эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарахгүй, 40% нь Хууль сахиулагч нар албан үүргээ тухайн нөхцөл байдалд хэрхэн гүйцэтгэх зааварчилгаа байдаггүй нь хууль зөрчих, хүнтэй харилцахдаа алдаа гаргах, эрүүдэн шүүхтэй холбоо зөрчил, гэмт хэрэгт холбогдоход хүргэдэг, 40% нь Эрүүдэн шүүх явдлыг олны анхаарал хүргэх талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан тогтолцоо идэвхтэй ажиллаж байна гэдэгтэй санал бүрэн нийлж байна.

Хүснэгт 8. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд өгсөн үнэлгээ

№	Тохирох утга	Санал бүрэн нийлж байна	Нийлэх талдаа	Нийлэхгүй	ОГТ нийлэхгүй	Хариу-лаагүй	Нийт
1	Эрүүдэн шүүх явдлыг төр анхааралдаа авч ажиллаж байна.	25%	50%	20%	0%	5%	100%
2	Эрүүдэн шүүх гэмт явдал гаргахгүй байх арга барил, харилцааны ур чадвар их сургуульд хангалттай заахгүй байна.	45%	35%	15%	5%	0%	100%
3	Төрийн албан хаагчдын ажиллах орчин, ажлын ачааллын оновчтой зохицуулахгүй бол эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарахгүй	35%	55%	0%	5%	5%	100%
4	Хууль сахиулагч нар албан үүргээ тухайн нөхцөл байдалд хэрхэн гүйцэтгэх зааварчилгаа байдаггүй нь хууль зөрчих, хүнтэй харилцахдаа алдаа гаргах, эрүүдэн шүүхтэй холбоо зөрчил, гэмт хэрэгт холбогдоход хүргэдэг	40%	50%	5%	0%	5%	100%
5	Эрүүдэн шүүх явдлыг олны анхаарал хүргэх талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан тогтолцоо идэвхтэй ажиллаж байна.	40%	10%	35%	10%	5%	100%

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 48% нь “Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох”, 43% нь Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, 34% нь “Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг сайжруулах”, 30% нь “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах” гэсэн арга хэмжээнүүдийг хамгийн үр дүнтэй гэж нэрлэсэн бол “Иргэдээс эрүүдэн шүүж буй талаарх мэдээллийг төлбөртэй авах, үнэлэх тогтолцоог аймгийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх” гэсэн арга хэмжээг хамгийн үр дүн муутай гэж үзэж байна.


График 61. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй арга хэрэгсэл



Төрийн албан хаагч, Төрийн үйлчилгээний албан хаагчид Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд хуулийн тогтолцоог боловсронгуй болгох гэж үзэж байхад хувийн хэвшил болон бусад салбарт ажилладаг иргэд Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах нь хамгийн чухал, үр дүнтэй арга гэж үзэж байна.

Судалгаанд оролцогч хуулийн сургуулийн оюутнуудын 65% нь Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, 57% нь Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох нь эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхэд хамгийн үр дүнтэй гэж үзэж байна.

График 62. Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ зохион байгуулбал үр дүнтэй гэж та үзэж байна вэ?



Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргын нэг нь олон нийтийн дэмжлэг байдаг. Судалгаанд оролцсон иргэдийн 58% нь эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцохоор саналаа өгөв, харин 24% нь «огт оролцохгүй» гэж хариулсан байна.

Энэхүү дүнгүүд нь олон нийтийн уялдаа, оролцоо нь гэмт хэргийн эсрэг тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэж болохыг харуулж байна. Иргэдийн дэмжлэг, идэвхитэй оролцоо нь гэмт явдалтай тэмцэх, нийгэмд шударга ёс, хүний эрхийг хамгаалах, боловсролын хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжихэд чухал ач холбогдолтой.

График 63. Би эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох эсэх



“Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд огт оролцохгүй” гэж хариулсан хүмүүс шалтгаанаар оролцохоос зайлсхийж байгаа гэж үзэж болно:

1. Мэдлэг, мэдээлэл сул байдал: Эдгээр хүмүүс эрүүдэн шүүх гэмт явдал, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэлгүй, ойлголтгүй байж магадгүй.
2. Төрийн байгууллагад итгэдэггүй байдал: Тэдний дунд хууль сахиулах байгууллага, төрийн байгууллагуудын хариуцлага, үйл ажиллагаанд итгэхгүй байх хандлага байх боломжтой.
3. Сэтгэл зүйн дарамт: Эрүүдэн шүүхтэй холбоотой асуудал, хохирогчдын нөхцөл байдлын талаар бодохоос зайлсхийх, болон өөрийгөө хамгаалах зорилгоор оролцоход дургүйгээ илэрхий.
4. Хувийн хамааралгүй байдал: Надтай, надгүй төрийн ажил явна. Би нийгэмд нөлөө үзүүлж ажиллаж чадахгүй гэсэн бодол.

### ШИНЖЭЭЧДИЙН САНАЛ, ДҮГНЭЛТ

**Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж нь уг харилцааг зохицуулах, эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай зохицуулалтыг оновчтой тусгаж чадсан талаарх Таны бодол юу вэ?**

Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомж нь уг харилцааг зохицуулах, эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай зохицуулалтууд хангалттай гэж дурдсан. Гэвч судалгаанд хамрагдсан шинжээчдийн 15 хувь нь эрүү шүүлтгийг ойлголтыг зөвхөн эрүүгийн хуулийн заалтын хүрээгээр хязгаарлагддаг гэж үзэж, түүнчлэн оролцогчдын эрхийг хязгаарлаж, сэтгэл санааг хүчтэй шаналгасан байдал болон төрийн бусад байгууллагад эрүү шүүлтгийн шинжтэй гэмт хэрэг үйлдэгдэж болохыг тэмдэглэжээ.



Нэмж дурдахад, хууль баталсан ч хэрэгжүүлэх механизмыг үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах, мөн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх шаардлагатайг судлаачид онцлон тэмдэглэсэн байна.

### **Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн зохицуулалтын уялдааг үнэлнэ үү.**

Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллааны хараат бус байдлыг хангах гэж шинжээч нарын 25% нь үзэж байна.

Эрүүгийн болон эрүүгийн процесс хууль боловсронгуй бус байгаа нь эрүүдэн шүүх явдлын голлох шалтгаан болж байна гэдэгтэй шинжээч нарын 50% нь санал нийлж, 40% нь Төрийн үйл ажиллагааг процесст биш хүнд эрх мэдэл олгож байгаа нь эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх ажлын ач холбогдлыг бууруулж байна гэдэгтэй бүрэн санал нийлж байна.

### **Монгол Улсын хэмжээнд эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бие даасан хараат бус механизм 2 жилийн өмнө байгуулагдсан. Энэ нь хэр оновчтой болсон талаарх Таны санал юу вэ?**

Судалгаанд оролцсон шинжээчдийн 65 хувь нь Монгол Улсын хэмжээнд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх бие даасан, хараат бус механизм байгуулсан нь оновчтой гэж дүгнэсэн боловч энэ механизмийн үр дүн нь одоогоор төдийлөн сайн мэдрэгдэхгүй байна. Тэд практик байгууллагад үйл ажиллагаагаа явуулах, суралцах шаардлагатайг онцолсон бөгөөд уг механизмыг бэхжүүлэх, мөн мөрдөн шалгах тогтолцоог хөгжүүлэх шаардлага байгааг тэмдэглэжээ.

### **Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны сул талыг дурдана уу?**

Судалгаанд хамрагдсан шинжээч нарын 35 хувь нь эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааныг санхүүжилт, бие даасан байдал, бүтэц, орон тоо хязгаарлагдмал байдлыг сул тал гэж тэмдэглэсэн.

Хууль сахиулах, мөрдөгч, прокуроруудын мэдлэг, ур чадвар, мэдрэмжийг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах арга зам, тэдэнд хүлээлгэх хариуцлага нь тодорхойгүй байдал нь эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд саад учруулж, иргэдийн итгэлийг алдагдуулахад хүргэдэг гэдгийг мөн онцолсон байна.

Мөн, эрүүдэн шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял харьцангуй сул байснаар тэднийг өөгшүүлэхэд хүргэж болохыг судлаачид дурджээ.

Шинжээчид эрүүдэн шүүхтэй холбоотой нэр томьёо, ойлголтоо нэгтгэхгүй бол тэмцэх ёстой үзэгдэл, үйл явцыг тодорхойлох боломжгүй бөгөөд энэ нь буруу замаар явах эрсдэлтэй гэж анхааруулсан байна. Тэд Эрүүдэн шүүх, 326 эрүүдэн шүүлт тулгах, 327 эрүү шүүлт тулгах, 328 эрүү шүүлт, 329 гэх мэт нэр томьёоллыг

326 <https://legalinfo.mn/mn/detail/1289>

327 <https://www.parliament.mn/nn/63400/>

328 <https://www.parliament.mn/nn/63218/>

329 П. Оюунчимэг 2010 онд «Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудлууд: онол, практик» сэдвээр хууль зүйн ухааны

ялган тодорхойлох шаардлагатайг дурдсан. Бид судалгааны ажилдаа «эрүүдэн шүүх гэмт явдал» гэж өргөн хүрээгээр томъёолсон болно.

### **Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар мэдээлэл өгөхгүй байх шалтгаан:**

Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 60 хувь нь Монгол Улсад гэрч, хохирогч, мэдээлэгчийг хамгаалах болон нууцлах баталгаа сул байгааг тэмдэглэсэн байна. Түүнчлэн, 15 хувь нь өөрийн болон гэр бүлийн эрх ашиг нь хөндөгдөөгүй бол эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл өгөхөөс зайлсхийдэг гэж дүгнэжээ.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийн сул байдал, хуулиар гэмт хүмүүсийг шийтгэж чадахгүй байгаа нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэлийг алдагдуулж буй бөгөөд, албан хаагчдын шүүмжлэлт сэтгэлгээний дутагдал, залхуу байдал нь иргэдийн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар мэдээлэл өгөхгүй байх шалтгаан болж байж болохыг судлаачид онцолсон байна.

### **Эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын нөлөөг дээшлүүлэхийн тулд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар товч дурдана уу?**

Судалгаанд хамрагдсан шинжээчдийн 45 хувь нь эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах, сургалт, сурталчилгааны ажлыг оновчтой болгох шаардлагатайг онцолсон байна. Мөн 35 хувь нь эрүү шүүлт тулгах гэмт хэрэг болон зөрчлийг олон улсын гэрээнд зааснаар нарийвчлан хуульчилж, ял, шийтгэл завшуулахгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэх, хүлээлгэх хариуцлагыг чангаруулах шаардлагатайг дурдаж, төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах хэрэгтэй гэж үзжээ. Тухайлбал, «төрийн албан хаагчид юуг, хэрхэн хийх ёстойг мэддэг болгох, удирдлагуудын арга барилыг өөрчлөх, үйл ажиллагааны стандарт, дүрэм журам нь тодорхой байх» шаардлагатайг судлаачид тэмдэглэсэн байна.

### **Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөнд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсийг товч дурдана уу?**

Шинжээчид шударга бус хууль сахиулах байгууллага, албан хаагчид орших нөхцөл боломжийг хаах тогтолцоог бүрдээгүй, хяналт сул, хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал, мөрдөн байцаалтын муу арга барил, төсөв санхүү, хүний нөөцийн дутмаг байдал, эрх мэдэл бүхий албан тушаалтны ёс суртахуун сул байдал, алба хаагчдын ёс зүй болон хандлагыг өөрчлөх сургалт хангалтгүй, эрх мэдэл бүхий албан тушаалтны ёс суртахууныг сайжруулах, шүүмжилсэн хүмүүсийг элдвээр дарамтлахыг болиулахгүй бол ямар ч үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй онцолжээ.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) бие даасан байдлаар ажиллаж эхэлснээс хойш эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрчимжиж, тодорхой үр дүнд хүрч эхэлжээ. Энэ хугацаанд эрүүдэн шүүх явдал гэж үздэггүй байсан эрүү шүүлт тулгах шинжтэй бусад үйлдлүүдийг анхааралдаа авч, гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн түвшинд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлага гарч байна.

Эрүүдэн шүүх гэмт явдлыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан «эрүү шүүлт тулгах гэмт хэрэг» гэж ойлгох нь, Авлигатай тэмцэх газрыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22.4, 22.5 дугаар зүйлд заасан «хахууль авах, өгөх гэмт хэрэг»-тэй тэмцэх газар болгон хязгаарлахтай адил асуудал болж байна. Энэхүү хязгаарлалт нь эрүүдэн шүүх гэмт явдлыг хүчгүйдүүлж, улс төр, нийгмийн нөлөөллөөс бусад үүдсэн гэмт хэргүүдийг дорвитойгоор урьдчилан сэргийлэх боломжийг сааруулж болзошгүй юм.

Иймд бид Эрүүдэн шүүх гэмт явдалд дараах гэмт хэргүүдийг хамруулсан бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Үүнд: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах 2.12 “эрүүдэн шүүх хүнийг алах”, 11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 2.1 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйл. ийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 2 “энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн”, 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах, 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах, 21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, 21.4 дүгээр зүйл. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах, 21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх, 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах, 21.13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих, 21.14 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэргүүд. Эдгээр гэмт хэргүүдэд эрүүдэн шүүх бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцсан шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг агуулж байдаг. Цаашид эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлуудыг илүү өргөн хүрээнд, криминологийн үүднээс судалж, анхаарал хандуулж гүнзгийрүүлэн судлах шаардлага бий болж байна.

Хэдий олны анхааралд хүрч байгаа ч, эрүүдэн шүүх гэмт явдалд хандах иргэдийн хандлага, мэдлэг нь төрийн албан хаагчдынхтай харьцуулахад бага байна. Энэ нь иргэдийг үнэн зөв, бодитой мэдлэг, мэдээлэлтэй байх нь чухал ач холбогдолтойг харуулж байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь төрийн албан хаагчдад чиглэгдсэн үе шаттай сургалтын үр дүн гэж үзэж болох бөгөөд энэ нь төрийн үйлчилгээний чанар, хариуцлага, ёс зүйг сайжруулахад чиглэж байна. Гэвч энэ нь зөвхөн төрийн албан хаагчдад хамааралтай байж болохгүй. Цаашид иргэд, бизнес эрхлэгчдэд чиглэгдсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ийм сургалт нь гэмт хэргийн талаарх мэдээлэл, эрүүдэн шүүх гэмт явдал, хүний эрхийн

хамгааллын талаар олон нийтийн мэдээллийг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлага, соёлыг хэвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Судалгаанд оролцсон хүмүүсийн 54 хувь нь мөрдөгч, прокурор, шүүгч, төрийн албан хаагч хэн байх нь үл хамааран өөрийн хүссэн шийдвэрийг гаргуулахын тулд иргэнийг айлган сүрдүүлж, сэтгэл зүйн дарамтад оруулж байгаа явдлыг эрүү шүүлт тулгаж байгаа хэлбэр гэж үзэж байна. Эрүүдэн шүүх гэмт явдал нь төрийн бусад байгууллагын үйл ажиллагааны оршсоор байгааг шинжээчид болон иргэд илэрхийлж байна.

Мөн, эрүүдэн шүүхийн асуудал нь хэрэгт шалгагдаж буй сэжигтэн, яллагдагчид, төрийн үйлчилгээ авч буй бизнес эрхлэгчдээс хальж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж буй өмгөөлөгч нарын тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс хууль бусаар халдах, ялгаварлан гадуурхалтад өртөхөд өмгөөлөгчдийн хууль зүйн болон ёс зүйн асуудалтай тулах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Гэмт хэрэгт 23-30 насны, биеэ барих чадвар сул, зан төлөвийн хувьд бүрэн төлөвшөөгүй, мөн ажлын туршлагаас хамааран харилцааны туршлага нь бага хүмүүс холбогдож байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй. Энэ нь шинээр томилогдсон албан хаагчдад чиглэгдсэн сургалт оновчтой бус байж, төрийн үйл ажиллагааны стандарт, журам нь ойлгомжгүй байдалд нөлөөлдөг.

Шүүгдэгчийн хувийн зан чанарын онцлогийг авч үзэхэд, түргэн ууртай, түрэмгий, тогтворгүй зантай хүмүүс эрүүдэн шүүхийн энэ төрлийн гэмт хэргийг ихээр үйлдэж байгаа нь тодорхой байна. Түүнчлэн, шинэ төгссөн хэсгийн төлөөлөгч болон эрүүгийн мөрдөгчдийн дунд гэмт хэрэг илрүүлэх зорилгоор эрүүдэн шүүхийн үйлдлийг хийх явдал харьцангуй их байгааг тэмдэглэх нь чухал. Энэхүү байдал нь шинэ алба хаагчид мэргэжлийн туршлага, ажилдаа дадлагажих явцдаа алдаа гаргах, бусад төрийн албан хаагчдад хууль хэрэглэх чадвар, стрессийн удирдлага, ёс зүйн боловсролыг төлөвшүүлэхэд хангалттай сургалт, дэмжлэггүй байх нь хүний эрхийг зөрчих эрсдэлтэй байгааг илтгэдэг. Иймд нийтийн аюулгүй байдал, хүний эрхийн хамгааллыг хангахын тулд мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, алба хаагчдын чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эргэн харж, сайжруулах нь чухал юм. Хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх, сургалтын системийг боловсронгуй болгох нь эрүү шүүлт тулгах үйлдлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Эрүүдэн шүүх гэмт явдлын талаар олон нийтийн мэдлэг нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар өнгөрсөн 3 жилийн хугацаанд дараах зүйлсийг онцолсон байна: Үүнд:

Эрүүдэн шүүх, улс төржүүлэх нь нэмэгдсэн: Энэ хугацаанд эрүүдэн шүүхийн асуудал нийгэмд ихээхэн анхаарал татаж буй тул олон нийтийн мэдлэг нэмэгдэхэд голлох нөлөө үзүүлсэн.

Улсын их хурал идэвхтэй ажиллаж эхэлсэн: Хууль тогтоох байгууллага нь эрүүдэн шүүх асуудлыг хэлэлцүүлж, хууль эрх зүйн орчныг сайжруулахын төлөө дэмжлэг үзүүлж байгаа нь олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж байна.

Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх бие даасан нэгж идэвхтэй ажилласан: Энэ асуудлаар бие даасан нэгжид анхаарал хандуулах, судалгаа хийх, дүн шинжилгээ хийх зэрэг арга хэмжээнүүд нь эрх зүйн орчныг сайжруулахад түлхэц болж байгаа нь нийгмийн мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан.

Дээрх судалгаанаас харахад эрүүдэн шүүх явдалтай холбоотой асуудал, түүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хүсэл эрмэлзэл улс төрийн хүсэл эрмэлзэлтэй шууд холбож байна. Ямарваа гэмт явдал тогтолцооны асуудал болсон 330 тохиолдолд төрийн байгууллага, Засгийн газар дангаараа тэмцэж үр дүнд хүрэх магадлал бага. Гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл нь олон улсын болон үндэсний хэмжээнд хууль тогтоогчид, Засгийн газар болон нийгмийн байгууллагуудын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалахын тулд явуулж буй үе шаттай, цогц үйл ажиллагаагаа илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлийг Монгол Улс бий болгосон байна. Энэхүү хүсэл эрмэлзэл нь Монгол Улсын хүний эрхийн хамгааллын системийг бэхжүүлэх, мэргэжлийн ёс зүйг дэмжих, хууль зүйн тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) нь эрүүдэн шүүх гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний хүчирхэг тогтолцооны амин чухал хэсэг бөгөөд энэ нь олон улсын болон дотоодын хүний эрхийн тогтолцоог холбох чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үйл ажиллагааны бүрэн эрх нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөлөл үзүүлэхийн зэрэгцээ, үндэсний хэмжээнд эрүү шүүлттэй холбогдох бүх оролцогчидтой харилцах, мөн олон улсын эрүү шүүлтийн эсрэг боловсруулсан үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй байдаг. NPM нь эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор ажиллаж, хууль зүйн орчныг сайжруулах, мэргэжлийн ёс зүйг дэмжих, шийдвэрлэхэд чиглэгдсэн ил тод системийг бий болгох боломжийг Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудад олгож байна. Тухайлбал, NPM холбогдох бусад байгууллагад зөвлөмж хүргүүлж эрүүдэн шүүх гэмт явдлын нөхцөлийг бүрэн болон хэсэгчлэн арилгах алхам хийгдэж эхэлжээ.

Иймд NPM нь хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээллийн солилцоог дэмжих, үр дүнтэй ажиллагааны механизмыг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Ямарваа гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон талт үр дүнтэй хамтын ажиллагаа төрийн болон хувийн байгууллагуудын үүрэг оролцоо чухал гэдэгтэй хэн ч маргахгүй. Хэдий тийм ч тэргүүлэх байгууллагын үүрэг оролцоо хамгаас чухал.

Судалгаанд оролцогч хоёр иргэн тутмын нэг нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан нэгж, Цагдаагийн газар нь эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг манлайлах үүрэгтэйгээр оролцох ёстой гэж үзэж байна. Мөн, хамгийн бага үүрэг оролцоотой нь аж ахуйн нэгжүүд гэж дүгнэсэн нь энэ салбарт хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг харуулж байна. Оюутнуудын 60% нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан нэгж нь улсын хэмжээнд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дагнан ажилладаг байгууллага гэж үзсэн нь анхаарал татаж байна.

330 НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцсан Тусгай илтгэгч Манфред Новак 2005 онд Монголд ажилласан тайландаа "Монголд эрүү шүүлт хавтгайрсан байна" <http://www.ohchr.org/english/issues/torture/rapporteur/index.htm>

Судалгаанд хамрагдсан шинжээчид эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг бүгдийг үр дүнтэй гэж үзсэн. Тэр дундаа 2/3 Хуулийн тогтолцоог боловсронгуй болгох, Эрүүдэн шүүх явдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг сайжруулах, Эрүүдэн шүүсэн талаар мэдээлэл өгсөн хүнийг сайн хамгаалдаг болох, Хууль сахиулагч, төрийн бусад албан хаагчид иргэдтэй уулзах, мэдүүлэг, тайлбар авах, мэдээ сэлт авах стандарт тодорхой болгох гэдгийг илүү үр дүнтэй гэж үзжээ.

## ЗӨВЛӨМЖ

1. Эрүүдэн шүүх гэмт явдалтай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл тэр дундаа УИХ-ын үйл ажиллагааны эрчийг сулруулахгүй байх

2. Засгийн газар, төрийн байгууллагад бий болсон тогтолцооны шинжтэй алдааг засах чиглэлээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM) зүгээс хамтран ажиллаж буй арга барилыг эрчимжүүлэхэд төсөв хөрөнгө, бодлогын хувьд дэмжих.

3. Эрүү шүүлтийг эрүүдэн шүүх гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийг хэмжээнд нарийвчлан судлах

4. Сургалтаа хор уршгийн талаар, хэрхэн мэдээлэх, ямар шинж тэмдгээр таних, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах чиглэлд хандуулах. Энэ нь эрүүдэн шүүх гэмт явдалтай холбоотой гомдол, мэдээлэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (NPM)-д ирүүлэх нь нэмэгдэж, урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ явуулах ачаалал ихсэх тул хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх

5. Өмгөөлөгчдийн мэдээлснээр баривчлагдаж хоригдсон хүмүүсийг дарамтлах, айлган сүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага, хүмүүс зарим үед хоригдогсдын гэр бүлийг заналхийлэх, хоригдогсдыг удаа дараа шилжүүлэх, эсвэл тэднийг орон байр, гэр бүлээс нь хол хорих ангид байрлуулах зэргээр хууль эрх зүйн зөвлөгөө авах, гэр бүлийнхэнтэйгээ уулзахад хэцүү төвөгтэй болгож байгаа нөхцөл одоо ч байна. Хүний эрхийн ТББ-ууд, өмгөөлөгчид эрүүдэн шүүх, хүчирхийлэлтэй холбоотой нотлох баримт цуглуулахад хүндрэл бэрхшээлтэй байдгийг мэдээлдэг. Иймд цаашид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрхийг хангах буюу түүнийг үйлчлүүлэгчийг нь эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлж хуулиар олгогдсон эрхийг нь ягштал биелүүлэгдэх тал дээр анхаарах

6. Хууль бус тушаал, шийдвэр гаргасан удирдах албан тушаалтанд хариуцлага тооцдог тогтолцоог бүрэн ажиллуулах,

7. Эрүүгийн хууль нь хүчээр гэм буруутай гэх мэдүүлэг өгөхийг албадсан гэж буруутгагдаж буй мөрдөгч, прокурор зэрэг эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлагаас мултрах боломжийг олгож байна. Түүнчлэн сэтгэл санаагаар тарчлаан зовоосон гэх гомдлуудыг зарим тохиолдолд нотлох баримт байхгүй, эсвэл гэмтлийн зэргийг тодорхойлох боломжгүй гэх шалтгаанаар эрх бүхий байгууллага, хүмүүс хэрэгсэхгүй болгосон байгааг цаашид анхаарч хариуцлагыг гарцаагүй байх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх буюу хуулийг боловсронгуй болгохын зэрэгцээ энэ талын хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох.



8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүдэн шүүгдсэн гэх гомдол гаргасан болон энэ гэмт хэргийн талаарх нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тусгах;

9. Эрүү шүүлтийн гэмт хэрэгт хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангаруулах. Хохирогч нарын хувьд хохирлоо мөнгөн хэлбэрээр барагдуулахаас өөрөөр зохицуулдаг эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

10. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Иргэний хуулиудад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн сэтгэл ханамжийг хангах, дахин давтагдахгүй байх баталгаагаар хангах зохицуулалтыг хийх. Ингэхдээ:

Хохирогчийн нэр төрийг сэргээх тухай албан ёсны мэдэгдэл хийх

Олон нийтийн өмнө уучлалт гуйх

Хохирогчдын дурсгалыг хүндэтгэх

Хүндэтгэл үзүүлэх бусад арга хэмжээг багтаах зэрэг болно.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 48

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНТХ	Ахмад настны тухай хууль
АНҮТ	Ахмад настны үндэсний төв
АТГ	Авлигатай тэмцэх газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БЕХ	Боловсролын ерөнхий хууль
БЖИ	Биеийн жингийн индекс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГБтХ	Гэр бүлийн тухай хууль
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЗМ	Дэлхийн зөн Монгол
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖЭТБХтХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИТБАТГӨГШтХ	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НДЕХ	Нийгмийн даатгалын ерөнхий хууль
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НПГ	Нийслэлийн прокурорын газар
НХтХ	Нийгмийн халамжийн тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага

НЦУГ	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
ОУБ	Олон улсын байгууллага
СУХХЭАЭТХ	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль
СЭМтХ	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ТАХЁЗтХ	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх станц
УЕП	Улсын ерөнхий прокурор
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
УСҮБ	Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЦАтХ	Цагдаагийн албаны тухай хууль
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХБХЭтХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХтХ	Хөдөлмөрийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХтХ	Хүүхэд хамгааллын тухай хууль
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭтХ	Хүүхдийн эрхийн тухай хууль

ХЭҮБ	Хүний эрхийн үндэсний байгууллага
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭҮКтХ	Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСЭСК	Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ШШГтХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭШУС	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх

